



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 5 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА **2026 оны 5 дугаар сарын 08-ны өдөр, Баасан гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-11
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	13-193
<hr/>	
1.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах	13-15
2.“Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/	15-16
3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	16-85
4.“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	85-192
5.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох	192-193

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
5 дугаар сарын 08-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 79 гишүүн хүрэлцэн ирж, 62.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Алдаржавхлан, Х.Баасанжаргал, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, А.Ганбаатар, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Б.Дэлгэрсайхан, Б.Жаргалан, С.Зулпхар, М.Мандхай, Г.Очирбат, Ч.Ундром, С.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Ж.Баярмаа, Х.Ганхуяг, М.Нарантуяа-Нара, Ц.Туваан, Ө.Шижир;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Болормаа, П.Мөнхтулга, Б.Тулга, С.Цэнгүүн;

Тасалсан: Л.Оюун-Эрдэнэ;

Хоцорсон: Н.Алтанхуяг-14 минут, Д.Амарбаясгалан-1 цаг 18 минут, С.Амарсайхан-2 цаг 14 минут, Б.Батцэцэг-44 минут, Э.Батшугар-02 минут, Х.Булгантуяа-1 цаг 01 минут, Ш.Бямбасүрэн-05 минут, Д.Ганбат-45 минут, Т.Доржханд-49 минут, Б.Жавхлан-41 минут, Д.Жаргалсайхан-16 минут, Б.Заяабал-03 минут, Ц.Идэрбат-04 минут, Ч.Лодойсамбуу-05 минут, Ц.Мөнхтуяа-10 минут, З.Мэндсайхан-06 минут, Ц.Сандаг-Очир-19 минут, Р.Сэддорж-41 минут, А.Ундраа-56 минут, Н.Учрал-09 минут, Г.Уянгахишиг-09 минут, Д.Цогтбаатар-38 минут, Б.Энхбаяр-01 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 5 дугаар сарын 10-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржид Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 14 гишүүнээс 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав./10:06/

Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ нар байлцав.

С.Бямбацогт: 1.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 78
Татгалзсан: 11
Бүгд: 89

87.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

2.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 13
Бүгд: 89

85.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 34
Бүгд: 89

61.8 хувь буюу нийт гишүүний олонх дэмжээгүй тул хууль батлагдсангүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 34
Бүгд: 89

61.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

3.Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 29
Бүгд: 90

67.8 хувь буюу нийт гишүүний олонх дэмжээгүй тул хууль батлагдсангүй.

Хуулийн төслийг эцэслэн батлах саналыг Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжээгүй тул “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

4.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 83
Татгалзсан: 8
Бүгд: 91

91.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 12
Бүгд: 91

86.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 80
Татгалзсан: 11
Бүгд: 91

87.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 12
Бүгд: 91

86.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн

газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

“Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	71
Татгалзсан:	21
Бүгд:	92

77.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:22/

Уг асуудлыг 10 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Одонтуяа, Н.Ууганбаатар, А.Энхбат, Н.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх

Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албаны дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан нар тус тус танилцуулав.

Илтгэл, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Эрдэнэболд, Б.Пүрэвдорж, Б.Батбаатар, Г.Лувсанжамц, Да.Цогтбаатар, О.Номинчимэг, Д.Энхтүвшин, О.Батнайрамдал, Л.Соронзонболд, Н.Наранбаатар, Б.Мөнхсоёл нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Сангийн сайд З.Мэндсайхан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Үдийн завсарлагын цаг болсон тул үдээс өмнөх хуралдаан 3 цаг 02 минут үргэлжилж, 13 цаг 02 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 05 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 14 цаг 05 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Б.Бейсен, О.Саранчулуун, Ж.Баясгалан, Ж.Галбадрах, Ж.Батжаргал, Ц.Мөнхтуяа, Н.Алтанхуяг нарын тавьсан асуултад Монгол Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Сангийн сайд З.Мэндсайхан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 15 цаг 09 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, О.Батнайрамдал, Ц.Баатархүү, Р.Эрдэнэбүрэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт үг хэлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороод, бусад Байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

**Дөрөв. “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн
мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Н.Номтойбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, мөн хорооны Ажлын албаны дарга С.Цогтгэрэл, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Одонтуяа, Н.Ууганбаатар, А.Энхбат, Н.Энхбаяр, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал Б.Баттуяа, Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга В.Жавзан, Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Баярмагнай, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрчим

хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэбаяр, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын дэд захирал Б.Мөнхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Энхтөр, мөн яамны Хяналт шалгалт, дотоод аудитын газрын дарга Б.Хишигтогтох, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Оюунгэрэл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Ц.Мөнхзул, Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Урьболд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Даваадалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, төрийн аудитын дээд байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нар тус тус танилцуулав.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл, Төрийн аудитын дээд байгууллагын болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтүүд, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Эрдэнэболд, Б.Пүрэвдорж, Б.Батбаатар, Да.Цогтбаатар, О.Номинчимэг, Д.Бум-Очир, Д.Энхтүвшин, Г.Хосбаяр, Л.Соронзонболд, Н.Наранбаатар, Б.Мөнхсоёл, М.Ганхүлэг, Б.Бейсен, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, П.Сайнзориг, П.Батчимэг, Д.Ганмаа, Р.Эрдэнэбүрэн, Н.Алтаншагай, Г.Лувсанжамц, М.Энхцэцэг, Ж.Галбадрах, Ц.Мөнхтуяа, Х.Булгантуяа, Д.Ганбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Шадар сайд Н.Номтойбаяр, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ч.Номин, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Баярмагнай,

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, мөн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа, мөн яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Даваадалай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 18:00 цаг болсон тул өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр товлосон асуудлуудыг хэлэлцэж дуусах хүртэл хуралдааны цагийг сунгав./18:02/

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 18 цаг 20 минутаас 21 цаг 29 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Эрдэнэболд, Б.Батбаатар, О.Саранчулуун, Д.Ганбат, Р.Сэддорж нар үг хэлэв.

С.Бямбацогт: Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөл Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-т заасан шаардлага хангасан байна гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 42
Бүгд: 93
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 22 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./22:26/

2.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./22:26/

3.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./22:26/

4.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./22:26/

Уг асуудлыг 22 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. “Эйблсофт” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Үй-Цай” сургуулийн 9^б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын урилгаар Төв аймгийн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 12^а ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 61 дүгээр сургуулийн 12^б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын урилгаар Канад Улсын Бритиш Колумбын их сургуулийн багш, оюутнууд, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн урилгаар Говь-Алтай аймгийн Анагаах ухааны техникумыг 1999 онд төгссөн төгсөгчид, Монголбанкны орон нутаг дахь хэлтэс, салбаруудын захирал, нягтлан бодогчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн урилгаар Дархан-Уул аймгийн “Оюутны холбоо”-ны тэргүүлэгчид, Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн хөтөч” сургуулийн 11^г, 12^е ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын урилгаар Гэмтэл согог судлалын үндэсний төв, нийслэлийн Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, тус дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчид, нийслэлийн ерөнхий боловсролын “Хишиг” сургуулийн 12^а, 12^б ангийн багш, сурагчид, Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн оюутнууд, нийслэлийн ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн 9^б, 12^б, 12^в ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны урилгаар Төв аймгийн Лүн сумын ерөнхий боловсролын сургуулийн 12^а ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн орон” сургуулийн 12^а ангийн багш, сурагчид, нийслэлийн ерөнхий боловсролын “Эм Ай Ю” сургуулийн 9^а ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн урилгаар Их Засаг их сургуулийн багш, оюутнууд Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 11 цаг 25 минут үргэлжилж, 126 гишүүнээс 102 гишүүн хүрэлцэн ирж, 81.0 хувийн ирцтэйгээр 22 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2026 оны 5 дугаар сарын 08-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн чуулганы хуралдааны ирцийг танилцуулъя. 126 гишүүн ирэхээс 79 гишүүн буюу 62,7 хувийн ирцтэй байгаа тул Баасан гаргийн нэгдсэн хуралдаанаа эхэлснийг мэдэгдье.

Өнөөдөр төрсөн өдөр нь тохиож буй гишүүн Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Бөхчулууны Пүрэвдорж 5 сарын 10-ны өдөр төрсөн байна. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорждоо төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний илч болсон Танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрүүд мэдээлэл танилцуулъя. Хүмүүнлэгийн өдөр жил бүрийн 5 дугаар сарын 8-ны өдөр, Хөрс хамгаалах үндэсний өдөр жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоногийн бямба гарагт, Байгаль хамгаалах өдөр жил бүрийн 5 дугаар сарын 2 дахь ням гараг, Мод тарих өдөр жил бүрийн 5 дугаар сарын, 5, 10 дугаар сарын 2 дахь бямба гараг. Тэгэхээр 5 дугаар сар үндсэндээ байгаль дэлхийгээ хамгаалах, эх дэлхийгээ хайрлах, мод тарих, газар тариалан эрхлэх гээд бүхий л үйл ажиллагаа явагддаг ийм онцлогтой сар. Тийм болохоор Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2025 онд тэрбум мод тарих ийм зарлиг гаргасан байдаг. Энэ хүрээнд үр хойчдоо үлдээх хамгийн үнэтэй өв бол эх дэлхийгээ, эх орноо хайрлах мод тарьж ургуулж ургуулах бүтээлч, хүнлэг соёл юм. Тиймээс энэ бямба гарагт бүх нийтээр мод тарих өдөр тохиож байгаа. Гэр бүлээрээ мод тарьж, байгаль дэлхийгээ хайрлах үйлсэд нэгдэхийг гишүүддээ болон нийт Монгол Улсынхаа иргэддээ уриалж байна. Тарихаас гадна тарьсан модоо ургуулж, арчилж ургуулах чухал байгаа.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Аюушийн Ариунзаяа, Жамбалын Ганбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд, Бөхчулууны Пүрэвдорж, Мягмардашийн Сарнай нарын гишүүд эртэч гишүүд болжээ. Тэгээд эртэч гишүүддээ баяр хүргэе.

Зочин танилцуулъя. Эйбл Софт компанийн ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн энэ сайхан бүхнийг хүсэн ерөөе. Мэдээллийн технологи, хиймэл оюун ухааныг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байх энэ чиглэлдээ илүү их бүтээлчээр ажиллаж, илүү их өндөр амжилт гаргахыг хүсье.

Өнөөдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар дараах 5 асуудлыг хэлэлцүүлнэ. 1 дүгээрт нь хуулийн төслүүдийг эцэслэн батална нийт 7 төсөл байгаа. 2 дугаарт нь Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг үргэлжлүүлэн

хэлэлцэнэ. 3 дугаарт нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ, Засгийн газар /ЗГ/ 2026 оны 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн. 4 дүгээрт нь Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна, ЗГ 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн. 5 дугаарт нь баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно. Өнөөдөр нэлээн өндөр ачаалалтай ажиллана. Гишүүд ажил төрлөө зохицуулж, чуулганы хуралдаанд идэвхтэй оролцохыг хүсэж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хурал /УИХ/-д өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Үүний дагуу УИХ-д өргөн мэдүүлсэн хууль төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар та бүхэнд танилцуулъя.

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Бадамдоржийн Пунсалмаа нарын 13 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 7-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд.

2.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ЗГ 2026 оны 5 дугаар сарын 7-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд.

3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /ААНОАТ/-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ЗГ 2026 оны 5 дугаар сарын 7-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд.

4.Хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ЗГ 2026 оны 5 дугаар сарын 7-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд.

5.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ЗГ 2026 оны 5 дугаар сарын 7-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд тус тус хуваариллаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батална

Үндсэн хуулийн цэц /ҮХЦ/-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Мэргэжлийн нэгдсэн холбоонд эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Гадаад зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл, Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батална. Хуулийн төслүүдийн эцэслэн батлах хувилбарыг холбогдох Байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн батлагдсанд тооцогдоно гэж заасан байгаа. Чуулганы ирцэд 126 гишүүнээс 86 гишүүн ирцэд орсон байна. Бэлэн болсон 69 гишүүн байна. Бэлэн бус байгаа гишүүд ирцдээ орж, санал хураалтын бэлтгэлээ хангана уу 17 гишүүн. Баатархүү гишүүн, Батболд гишүүн, Галбадрах гишүүн, Ганбаатар гишүүн, Ганмаа гишүүн, Гантөмөр гишүүн, Ганхүлэг гишүүн, Золжаргал гишүүн, Найдалаа гишүүн, Номтойбаяр гишүүн, Одбаяр гишүүн, Пунсалмаа гишүүн, Уянга гишүүн, Чинбүрэн гишүүн, Энх-Амгалан гишүүн, Ж.Энхбаяр гэсэн гишүүд бэлтгэлээ хангана уу. Ганмаа гишүүн байгаа юм байна, орчихсон байна.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын Үй-Цай сургуулийн 9Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сурагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Эрдэм номдоо шамдан суралцаж, удахгүй анги дэвших шалгалтаа өгөх байх. Энэ шалгалтдаа сайн бэлдээрэй. Аав ээжийнхээ, багш нарынхаа үгэнд сайн орж байгаарай. Манай Даваагийн Цогтбаатар гишүүн тэнд сууж байна. Та босоод, идэвхтэй сайн гишүүн байгаа шүү тийм. Цогтбаатар гишүүн ажлаа их сайн хийдэг гишүүн шүү. Санал хураалтдаа оролцоно шүү одоо. Санал хураалт явуулна. Бүртгэлийн санал хураалт, ажлаа сайн хийдэг гэсэн чинь гараад явах гэж байна шүү дээ. Санал хураалтдаа орчхоод гарч болох байх. Бүртгэлийн санал хураалт, ирцийн санал хураалт. Санал хураалтад 89 гишүүн оролцсоноос 71 гишүүн ирцдээ орсон байна. Санал хураалтад бэлэн болсон байна. Энэ татгалзсанаар гарч байгаа санал хураалтад бэлэн болж амжаагүй гишүүдийг танхимдаа орж ирэхийг урьж байна. Сайдууд алга байна гэж байна шүү. Байна, байна. Энхбаяр сайд орж ирж байна, Бат-Амгалан сайдынх байна. Энхбаяр сайд санал хураалтдаа бэлэн болчхоорой. Санал хураалт явуулна.

ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 89 гишүүн оролцсоноос 78 гишүүн буюу 87,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 89 гишүүн оролцсоноос 76 гишүүн буюу 85,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 64 эцэслэн батлагдах ёстой доо гишүүдээ. Энэ нөгөө газрын тос боловсруулах үйлдвэртэй болох, Монгол Улс гадаадаас өндөр үнэ. Горимын санал. Ганхүлэг гишүүн горимын санал гаргаж байна.

М.Ганхүлэг: Уул нь дэмжиж дарсан юм, тэгээд төхөөрөмж ажилласангүй. Дахин санал хураалт явуулж өгөөч.

С.Бямбацогт: Ганхүлэг гишүүн энэ санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 89 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 61,8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. Энэ санал хураалт их чухал санал хураалт шүү дээ гишүүдээ. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, эрчим хүчний тусгаар тогтнолоо олж авах, дотооддоо газрын тос боловсруулах үйлдвэртэй болох, шатахуун бензинийхээ үнийг хямдруулахад дотооддоо үйлдвэртэй болох, эрчим хүч, шатахуун, нефть бүтээгдэхүүний хараат бус байдлаас гарах гээд асуудлууд байгаа шүү дээ. Санал хураалт. Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 61 гишүүн буюу 67,8 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Нийт гишүүдийн олонх дэмжсэнгүй. Болохгүй. Энэ санал дэмжигдсэнгүй.

Энэ санал дэмжигдээгүй учраас энэ хуулийн 44.2-т зааснаар хуулийн төслийг эцэслэн батлах саналыг Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжээгүй бол хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол батлагдсанд тооцно. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Хуулийн төсөл буцаах тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсгийг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай нарын 21 гишүүнээс 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг эцэслэн батлах саналыг Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжээгүй тул төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 83 гишүүн буюу 91,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 79 гишүүн буюу 86,8 саналаар энэ санал дэмжигдлээ.

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 80 гишүүн буюу 87,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 79 гишүүний 86,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Хуулийн төслүүдийг эцэслэн баталлаа. Хуулийн төслийг эцэслэн баталсан Улсын Их Хурлынхаа нийт гишүүд, ажлын хэсэгт талархлаа илэрхийлье.

Хоёр. “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/

Дараагийн асуудалдаа оръё. Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцүүлнэ. Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт

оруулах тухай асуудлаар санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо танилцуулсан.

Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье, гишүүдээ суугаарай. Гишүүд санал хураалтдаа бэлдэж, хурууны хээг уншуулаарай. Санал хураалтдаа бэлдээрэй гишүүдээ. Хурууны хээгээ уншуулаарай. Олон гишүүн 36 гишүүн хурууны хээ уншуулаагүй байна шүү гишүүдээ. Хурууны хээгээ уншуулаарай. 36 гишүүн уншуулаагүй байна.

Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос 71 гишүүн буюу 77,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг баталлаа. Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.9 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэгийг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр баталсугай.

3.Энэ тогтоолыг 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргалын урилгаар Төв аймгийн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль /ЕБС/-ийн 12А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Сургуулиа төгсөөд хүссэн мэргэжлээрээ, хүссэн сургуульдаа элсэн орж, сайн мэдлэг боловсрол эзэмшин, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулсан хариуцлагатай хуулиа дээдэлдэг иргэн болоорой. Тэгээд Монгол Улсын ирээдүй та бүхний гарт байгаа шүү. Аав ээжийнхээ үгэнд, багш нарынхаа үгэнд сайн орж байгаарай. Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ. Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу боловсруулсан Монгол Улсын.../үг тасрав/

С.Бямбацогт: Заалны микрофоныг чангалъя. Гишүүд жаахан чимээгүй аядаарай.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасны дагуу боловсруулсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг та бүхэнд танилцуулж байна. Дэлхийд тодорхойгүй байдал хамгийн тодорхой байгаа нөхцөлд 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 2029 оны төсвийн төсөөллийг боловсрууллаа. Ойрх Дорнодын хурцадмал байдлаас үүдэн дэлхий даяар газрын тосны бүтээгдэхүүн хомсдож, үнэ нь савлаж, инфляц гаарлаа. Тээвэр, худалдаа логистикийн эрсдэл өсөн нэмэгдлээ. Дэлхийн Монгол Улсад ч дэлхийн хямралын сүүдэр туссан байна. Түлш шатахууны үнэ бол бүх юмны үнэ юм. 2026 оны 3 дугаар сард инфляц 7,4 хувьд хүрч, үхэр, хонь, адуу, ямааны махны үнэ 10-аас 25 хувиар өссөн нь ахуй амьжиргаанд дарамт болж байна.

Гадаад ертөнцийг бид өөрчлөхгүй боловч өөрсдөөсөө дотоодоосоо хамаарах бүхнийг хийхийг дэлхийн нөхцөл байдал та биднээс шаардаж байна. Өөрөөр хэлбэл үнэнийг үнэнээр нь хүлээн зөвшөөрч, алдаагаа засаж залруулж, дуусдаггүй олон яриаг дуусгах цаг ирсэн байна. Сүх далайтал үхэр амар гэгчээр олсныхоо хэрээр үрсэн, төр, төсвөө данхайлган томруулсан, санхүүгийн сахилга батыг сахиулан мөрдөөгүй, түүхий эдээ түүхийгээр нь гаргадаг түүхийг өөрчлөхгүйнхээ үр дагаврыг бид амсаж байна. Нүүрсний үнэ өндөр байхад үүц нөөц болгож өсгөж үржүүлэх, үлдэцтэй, өгөөжтэй зүйлд зориулахаас илүү үрж зарж төсвөө данхайлгасны горьг амсаж байна. Хүндрэлийн үед нэг хэсэг нь улам хумьж хязгаарладаг, хүндрэлийн үед нөгөө хэсэг нь үүнийг ашиглан эдийн засгаа шинэчилдэг.

Монгол Улс иргэндээ, хувийн хэвшилдээ итгэж, итгэлцлийн үндсэн дээр эдийн засгаа чөлөөлөн шинэчлэх замыг сонгож байна. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөлд жагсаасан тоо, бичсэн зорилтуудын цуглуулга биш юм. Төсвийн хүрээ, төсөөлөл бол төр ямар хэмжээнд байх вэ, хувийн хэвшилдээ ямар орон зай чөлөөлж нээх вэ гэдэг асуултын хариулт юм. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл Монгол Улс ямар хамаарлыг яаж багасгах вэ, юунаас яагаад чөлөөлөх вэ гэдэг хөгжлийн шинэ бичиг баримт юм. Та бид эдийн засгаа зөвхөн өсгөх тухай ярихгүй. Та бид иргэндээ, хувийн хэвшилдээ ямар орон зай үлдээж чөлөөлөх вэ гэдгийг хэлэлцэх учиртай. Та бид эдийн засгийн өсөлтөө иргэндээ хаягаар нь, өрхүүддээ үүдээр нь хүртээмжтэй хүргэх тухай ухаан бодлоо уралдуулна. Эмзэг хамаарлаас эдийн засгаа чөлөөлөх, түлш, шатахууны үнийн савлагааны хүнд цохилтоос чөлөөлөх, хөдөлмөрлөж бүтээх хүслийг хүнд суртлын чөдөр тушаанаас чөлөөлөх, хөрөнгө оруулалтыг хөөж туудаг тодорхой шийдвэрүүдээс чөлөөлөх гэдэг дуусдаггүй яриаг дуусгах тооцоо төлөвлөгөө юм.

Өгүүлбэртэй бодлогын хариу. 2027 оны төсвийн хүрээ, 2028-аас 2029 оны төсвийн төсөөлөл эрх чөлөөний 4 зам 4 чөлөөлөлт чөлөөлье бодлогын үргэлжлэл юм. ЗГ Чөлөөлөлтийн гарааны сардаа асуудал шийдэл, биелэлт хэмээх арга

барилаар 12 чөлөөлөлтийг хийлээ. Амьдралд бодит шийдэл биеллээ хүлээсэн олон зуун мянган хүний ажил амьдралд шууд хамаатай чөлөөлөлт бүхэн жижиг асуудал ер биш юм. Төр нь иргэндээ, хувийн хэвшилдээ итгэж, итгэлцлийн хариуд итгэл төрж, итгэлцэл үүсэх нь жижиг биш том зах зээлд эерэг дохио өгсөн зөв шийдэл юм. Татвар, нийгмийн даатгалын өртэй компаниудын дансыг бүхэлд нь хаадаг системийг өөрчилж, 12153 татвар төлөгчийн битүүмжлэгдсэн дансыг нээж, 2021 компани 64,5 тэрбум төгрөгийн өрнөөс чөлөөлөгдлөө. Хаах биш нээх тусам итгэлцэл үүсэн бэхэждэг. Төлөвлөгөөт 7029 хяналт шалгалтыг цуцалж чөлөөллөө.

8 төрлийн 146 бизнесийг зөвшөөрөл биш зөвшөөрөл, хориглолтын цаасан хүнд суртлаас чөлөөлж, цахимаар мэдэгдэж, шууд эхэлдэг, төр дараа нь иргэндээ хаягаар нь очиж үйлчилж эхэллээ. Үүний үр дүнг ЗГ биш, татвар, шимтгэлийн өрнөөс чөлөөлөгдсөн, үйл ажиллагаагаа сэргээсэн, шинээр эхлүүлсэн олон зуун мянган компани иргэд өөрсдөө батлах болно. Эдийн засгийн судсыг хааж биш нээж, хардаж биш итгэж, цусны эргэлт эрчимжин идэвхэжнэ. Эдийн засгийн цусны эргэлт бол Монгол хүний хийх ажил, олох ашиг, төлөх татвар, хөдөлмөр бүтээл юм. 2026 оны төсвийг та бид урт удаан хугацаанд хэлэлцэн баталсан. Гэтэл эмч, багш урам хугарч, 2 цалингийн ойлгомжгүй байдалд оржээ. ЗГ чөлөөлөлтийн эхний сардаа 39841 эмч цагаан нөмрөгтөн, 91499 багш, боловсролын салбарын ажилтан, албан хаагчдадаа цалингийн ойлгомжгүй байдлаас чөлөөлж, нэгдсэн 1 системд орууллаа.

Төрийн албан хаагчдаа жилд 10-аас 20 удаа гаргадаг бүтээмжийг бууруулсан давхар тайлангаас чөлөөлж, ones only буюу нэг удаа тайлагнах зарчимд бүрэн шилжлээ. Оросын Холбооны Улс /ОХУ/-тай идэвхтэй яриа хэлцэл хийсний үр дүнд түлш шатахууны үнэ огцом өсөх, тасалдал, хомсдол нүүрлэх аюул эрсдэлээс чөлөөлөгдлөө. Ард иргэд, аж ахуйн нэгж /ААН/-үүдийн карманд түлш шатахуунд энэ онд төлөх байсан 1,8 их наяд төгрөг хэмнэн үлдээж чадлаа. Дэлхийн олон оронд үнэ нугарч өсөж, хэмнэлтийн онцгой горимд орж, урт дараалал үүссэнийг та бид гадаад мэдээнээс үзэж байна. Эдийн засгийн чөлөөлөлт, эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлт, ногоон хөгжлийн чөлөөлөлт, авлигын эсрэг засаглалын чөлөөлөлтийн хуримтлагдсан асуудлыг онилсон шийдэл гаргасан биелэлт болж эхэлсэн олон багц шийдвэрүүдийг цөөнхийг онцлон дурдлаа.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Манай улсын эдийн засаг 2025 онд 6,8 хувиар өссөн хэдий ч хөдөө аж ахуй /ХАА/ болон Оюу толгой /ОТ/-н баяжмалаас бусад салбарын өсөлт ердөө 3,6 хувь буюу эдийн засгийн бодит хүчин чадлаасаа доогуур байна. Нийслэлийн өрхийн бодит орлогын өсөлт 2,2 болж удааширч, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 3,2 хувиар буурчээ. Гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй байгаа учир цаашид эдийн засгийн потенциал хүчин чадал сулрах эрсдэл нүүрлэлээ. 2026 оны эхний улиралд нийт импорт 3 хувиар буурлаа. Эдийн засаг удааширч байгаа тул бид эдийн засгийн хүндрэл, мөчлөг сөрсөн бодлогоо хэрэгжүүлж ажиллана.

УИХ-аар хэлэлцүүлэн батлуулахаар өргөн мэдүүлж байгаа энэхүү төсвийн бодлого ч эдийн засгаа сэргээн идэвхжүүлэх, эдийн засгийн цусны эргэлтийг эрчимжүүлэх зорилготой юм. Бизнес, хөрөнгө оруулалтад тулгамдсан саад тээг хүний хийж бүтээх хүслийг хяссан чөдөр тушааг тайлж чөлөөлөх нь итгэлцэл дээр үндэслэсэн эдийн засгийн цусны эргэлтийг дэмжих бодлогын цөм байна.

УИХ-д тулгуур 3 үндэслэлтэй төсвийн хүрээний мэдэгдлийг танилцуулж байна. 1 дүгээрт энэ бодит нөхцөл байдалд суурилсан хөөсгүй төсвийн хүрээ, эдийн засгийн хүндрэл, гадаад орчны эрсдэл, импортын инфляцын шок бодитоор нүүрлэж байгааг харгалзаж тооцлоо. Тулсан бэрхийг туулж давах, мөчлөг сөрсөн, асуудал, шийдэл арга хэмжээнүүд импортыг идэвхжүүлж, худалдааны эргэлтийг сайжруулах шийдлүүдийг тусгалаа.

2 дугаарт энэ бол өсөлт, хөрөнгө оруулалтыг урамшуулсан идэвхтэй төсвийн хүрээ байх болно. Гадаад валютын нөөц 7,3 тэрбум ам.доллар-т хүрсэн амжилтаа бататгах төлөвлөгөө юм. Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулгаар 21 зэсийн орд, Эрдэнэт үйлдвэрийн 7 ордод хөрөнгө оруулалтыг татаж, эдийн засгийн бааз сууриа өргөтгөн тэлэхээр тооцлоо.

3 дугаарт энэ бол сахилга баттай төсвийн хүрээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн бүх шаардлагаар улаан шугам татсан Төсвийн хүрээ. Тэнцвэржүүлсэн тэнцлийг дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ий 1,5 хувьтай тэнцэх алдагдалд хязгаарлаж, суурь тэнцлийг ДНБ-ий 2 хувийн ашигтай байхаар төлөвлөлөө. Нэгдсэн төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хэмжээг 2027 онд 31,9 хувь, 2028 онд 30,4 хувь, 2029 онд 28,6 хувь болтол үе шаттайгаар бууруулах болно.

Эрхэм гишүүд ээ, Төсвийн зардлаа хэмнэж, орлогоо нэмэх зорилгоо хатуу баримтлан Монгол Улсын ЗГ ажиллах болно. Сарын хажуугаар сайн гэдэг бидэнд сайн мэдээ ч байна. Экспорт өссөн сайн мэдээ байна. 5 дугаар сарын 6-ны байдлаар экспорт 7,1 тэрбум ам.доллар-т хүрч өмнөх оныхоос 63 хувиар өслөө. Нүүрсний экспортын биет хэмжээ 58 хувиар өсөж, 40,5 сая тоннд, зэсийн баяжмалын биет хэмжээ 38 хувиар нэмэгдэж, 926 мянган тоннд хүрээд байна. Эрч дээр эрч нэмж, нүүрсний экспортоо 2026 онд 95 сая тонн, 2027 онд 100 сая тонн, 2028 онд 105 сая тонн, 2029 онд 110 сая тоннд хүргэх зорилтыг тавилаа. Экспортын гарц, орлогын орц болсон хилийн боомтуудаа тасралтгүй найдвартай ажиллуулна. Ханги, Бичигт, Булган боомтуудад лаборатори, ухаалаг гарцыг нэн яаралтай нэвтрүүлж, Гашуун сухайт, Шивээ Хүрэнд ажиллах цагийг уртасгах зэрэг арга хэмжээг шууд авч хэрэгжүүлж эхлээд байна. Үүний үр дүнд манай улсын эдийн засаг 2027 онд 5,8 хувиар, 2028 онд 6 хувиар, 2029 онд 6,3 хувиар өсөх төсөөлөлтэй байна.

Түүхий эд гаргадаг түүхийг өөрчлөх, түүнээс хэт хамаарлаа багасгах, байгалийн үүц нөөцтэй үнэ цэн, өртөг ашиг, нэмж боловсруулах үйлдвэрүүдийн үүдийг зоригтойгоор нээнэ. Гангийн цогцолбор, зэс боловсруулах цогцолбор, нүүрс, пиролизийн үйлдвэр, хөнгөн цагааны аж үйлдвэрийн парк зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлнэ. 15 мянган хүний хийх шинэ ажил, авах цалин шууд ажлын байр, 63 мянган шууд бус ажлын байрыг бий болгоно. Энэ тоон биш, чанарын үзүүлэлт юм. Төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалт, харилцан итгэлцэл дээр үндэслэсэн ЗГ-т нэмэлт дарамт үүсгэхгүйгээр бүтээн босгох болно. Үүний үр дүнд эдийн засаг дахь ЗГ-ын өрийн хязгаарыг бид 2027 онд 50 хувиас, 2028 онд мөн 50 хувиас, 2029 онд 45 хувиас хэтрүүлэхгүй байх хүрээгээ тогтоож байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр та бүхний гар дээр очсон баримт бичигт бид үнэнийг баримталж, алдаагаа хүлээн зөвшөөрч, төсвийн сахилга батыг сахиулан чангатгаж, санхүүгийн шинэчлэлийг өрнүүлсэн, төрийн хүнд суртлын чөдөр тушаанаас бизнес хөрөнгө

оруулалтыг чөлөөлсөн, зардлаа хэмнэж, орлогоо нэмэх зорилготой төсвийн хүрээний мэдэгдлийг танилцуулж байна. Төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн сахилга бат, бодлогын уян хатан байдлыг сайжруулах зорилготой Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан хамтад нь өргөн мэдүүлж байна. Хоорондоо шууд харилцан уялдаатай багц бодлогыг илүү өргөн хүрээнд бүрэн зураглалаар нь харж, хэлэлцэн шийдвэрлэнэ гэдэгт итгэл төгс байна.

Бид дэлхийг өөрчлөхгүй боловч өөрчлөгдөж байгаа дэлхийд Монголоо хохирол багатай авч үлдэж, эдийн засгаа хамгаалах үүрэгтэй. Иргэндээ, хувийн хэвшилдээ, баялаг бүтээгч нарынхаа хийе, бүтээе гэсэн хүсэл эрмэлзээд итгэж, итгэлээс итгэл, итгэлцэл дээр эдийн засгаа идэвхжүүлэн цусны эргэлтийг эрчимжүүлэх, ЗГ-ын үндсэн жанжин шугам үүнд орших болно. Улс төрийн эрх чөлөөг эдийн засгийн эрх чөлөөгөөр бататгаж, улс орны тусгаар тогтнолоо эдийн засгийн эрх чөлөөгөөр гагнах нь та бидний эрхэм дээд эрх ашиг юм. Бид орлого, зарлагаас илүү итгэлцлийг төлөвлөж байна. Тодорхойгүй байдалтай дэлхийд тогтвортой байдал, харилцан итгэлцлээр бат бөх оршин тогтноцгооё. Улс орныхоо хөгжил, ард түмнийхээ ахуй амьдралын төлөө бодлого шийдлээ уралдуулцгаая. Хүн бүрд илүү маргааш бүтээхийн төлөө хамтдаа хичээе. Эдийн засгийн өсөлт өрхийн үүдээр орж, иргэнийхээ хаягаар очиж, өндөр тооноос бодит чанар луу шилжихийн төлөө Монгол Улсын ЗГ ажиллах болно. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал танд баярлалаа. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 61 дүгээр сургуулийн 12Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сурагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Сургуулиа төгсөөд удахгүй сургуулиа төгсөнө, хүссэн мэргэжлээрээ хүссэн сургуульдаа орж, сайн мэдлэг, боловсрол эзэмшин эх орныхоо хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан, хариуцлагатай, хуулиа дээдэлдэг иргэн болж төлөвшөөрэй. Та бүхнийхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхныг хүсье. Манай Цэндийн Баатархүү гишүүн энд сууж байна. Хуралдаа идэвхтэй оролцдог ажил хэрэгч гишүүдийн нэг. Ажлаа сайн хийж байгаа шүү гэж манай Даваагийн Цогтбаатар гишүүн дамжуулаарай гэж байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг зөвлөлийн дарга Жамсрандоржийн Дэлгэрсайхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ж.Дэлгэрсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ гараас 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16^{5.2} дахь заалтыг үндэслэн төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлт гаргалаа. Тус дүгнэлтийг боловсруулахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагууд, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн агуулга, төсвийн бодлогын тогтвортой байдал, макро эдийн хэсгийн эрсдэлт нөхцөл байдалд тулгуурлан боловсруулсан болно. Энэ удаагийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь макро эдийн засгийн таамаглалын хувьд

олон улсын байгууллага /ОУБ/, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн таамаглалтай харьцангуй нийцтэй болсон. Төрийн оролцоог бууруулах бодлогын зөв чиглэлийг баримталж байгаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн агуулгыг хамарсан байдлын хувьд өмнөхөөс сайжирсан ахиц дэвшилтэй байна гэж Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс үзлээ. Мөн төсвийн тэнцэл, өрийн үзүүлэлтүүд нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг хангаж байна.

Гэсэн хэдий ч төсвийн тогтвортой байдал, төсвийн бодлого, зарлагын бүтэц, макро эдийн засгийн эрсдэлтэй холбоотой анхаарах асуудлууд байгааг зөвлөлийн зүгээс дурдаж байна. Үүнд 1 дүгээрт төсвийн зарлагын өндөр түвшин болон зарлагын өсөлтийг хязгаарлах бодлогыг тууштай үргэлжлүүлэх шаардлагатай байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн судалгаагаар төсвийн зарлага ДНБ-ий 27 орчим хувь байх нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд хамгийн эерэг нөлөөтэй гэж гарсан боловч 2027-гоос 29 онд энэ үзүүлэлтийг 28,6-аас 31,9 байхаар төлөвлөсөн байна. Үүний шалтгаан нь өмнөх жилүүдэд нүүрсний экспорт, түүхий эдийн үнийн өсөлтөөс бий болсон гэнэтийн тогтмол бус орлогод тулгуурлан төсвийн зарлагыг огцом тэлсэн бодлогын үр нөлөө гэж үзэж байна. Үүний улмаас 2024 онд төсвийн нийт зарлага 35,9 хувиар өссөн нь буруу алдаатай бодлого байсан. Харин 2025 онд төсвийн тодотгол хийхдээ болон 2026 оны төсөвт зарлагын өсөлтийг хязгаарласан нь зөв арга хэмжээ болсон гэж Төсвийн тогтвортой байдлын зөвлөл үзэж байна. Иймд тус бодлогыг цаашид тууштай үргэлжлүүлж, төсвийн зарлагын тэлэлтийг хязгаарлах шаардлагатай байна.

2.Макро эдийн засгийн хувьд тодорхой эрсдэлүүд байгааг анхаарах хэрэгтэй. Макро эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлс, өсөлтийн түвшин тогтворгүй байгаа нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийг бууруулахаар тодорхойлсон бодлогыг хэрэгжүүлэхэд төсвийн зарлага төдийгүй гадаад эрсдэл өндөр байгаа нь инфляцын эрсдэлийг нэмэгдүүлэх, 2025, 2026 онд хос алдагдалтай гарсан, төсвийн урсгал зардал өссөн зэрэг нь дунд хугацааны макро эдийн засгийн тогтвортой байдалд дарамт учруулж болзошгүй байгааг анхаарах нь зүйтэй.

3.Голлох эрдсийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнийн тооцоолол зах зээлийн нөхцөлөөс өндөр хэвээр байна. Хуулийн төсөлд нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг 2027 онд 127,4 ам.доллар, харин зах зээлийн үнийг 68 ам.доллар байхаар тооцжээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан олон жилийн дундаж болон олон улсын үнийн төсөөлөлд суурилсан аргачлал нь зарим тохиолдолд эрдэс бүтээгдэхүүний үнийг бодит зах зээлийн үнээс хэт зөрөөтөйд тооцох нөхцөл бүрдүүлж байгаа тул Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.3-д заасан тэнцвэржүүлсэн үнийн тооцооллыг тооцох аргачлалыг эргэн харах шаардлагатай байна.

4.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүд дутуу, буруу томъёололтой хэвээр байна. 2010-аас 25 оны хооронд Төсвийн тухай хуульд 71 удаа, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 22 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан нь эдгээр хуулиудын хоорондын уялдаа, нэгдмэл байдал болон зохицуулах чадварт сөргөөр нөлөөлж, төсвийн хүрээг, төсвөө хүрээ нь дагадаг, төсвийн тодотгол хийн орлого, зардлаа бууруулсан ч хүрээ нь хөндөгддөг нөхцөл байдал хэвээр байна.

Иймээс эдгээр хуулиудын нийцлийг харж, тодорхой өөрчлөлт оруулах, нэрлэсэн ДНБ нэгдсэн төсвийн орлого, урсгал зардал, голлох эрдсийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнэ зэрэг үзүүлэлтийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгаж байх шаардлагатай байна.

5.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах зохицуулалтыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд хангалттай тусгаагүй байна. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдээлэлд өөрчлөлт оруулах тохиолдолд хуулийн төслийг өргөн барихдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16⁶ дахь заалтыг баримталдаг боловч уг заалтыг хэрхэн баримтлах нь тодорхойгүй. Баримтлаагүй тохиолдолд ямар зохицуулалттай нь нарийвчлан тусгаадаагүй байна.

6.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй хамт өргөн мэдүүлсэн хуультай холбоотой төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн ач холбогдол буурч байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5 дахь заалтад өөрчлөлт оруулан түүний нэмэлт, өөрчлөлтийг, мөн төсвийн тодотголыг гэснийг хассанаар төсөвт тавигддаг хүрээ баталснаас хойш багадаа 3 сарын дараа төсөв батлагддаг жишиг зөвхөн төсөв батлагдах үед мөрдөгдөж төсвийн тодотголтой хамааралгүй болж болох нөхцөл байдал үүсэж байна. Ингэснээр өмнөх жилүүдийн жишгээр хүрээ нь төсвөө дагадаг, төсвийн төлөвлөлтийг сайтар хийх замаар шаардлагагүй төсвийн тодотголыг бууруулах чиглэлд хийгдэж буй алхмаас ухралт хийхэд хүрч, эрх зүйн орчны хувьд 2023 оны эрх зүйн шинэчлэлийн өмнөх нөхцөл байдал руу очих нөхцөл бүрдэж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс дээрх асуудлуудыг анхаарч, төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах бодлогыг үргэлжлүүлэх, батлагдсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахгүй байх, баримтлах тусгай шаардлагыг сулруулахгүй байхад дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн бүтэц, агуулга, төсвийн төлөвлөлт, сахилга батыг сайжруулах чиглэлд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Дэлгэрсайхан даргад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулна. Энэ зочин ямар зочид ирчихсэн байна вэ? Ажлын хэсгийн бүрэлдэхүүн танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдиннямын урилгаар Канад улсын Колумбын Их сургуулийн багш, оюутнууд болон Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшиний урилгаар Говь-Алтай аймгийн анагаах ухааны техникумын 1989 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Ажлын хэсгийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

/ТНБД/, Бат-Ирээдүйн Анар Сангийн яамны ТНБД, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Даринчулууны Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Зияханы Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга. Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн гишүүддээ хууль сануулъя. Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ЗГ-ын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн, зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй. 21.25.Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх Албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн, зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худлаа мэдээлэл өгөх, танилцуулах, УИХ-д худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. 21.31-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаанаар хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж ийм хуультайг та бүхэндээ сануулж байна.

Төсвийн хүрээний мэдэгдэл бол маш том асуудал хэлэлцэж байгаа. Тийм болохоор үнэн зөв, бодитой мэдээлэл өгч, Их Хуралд хүндэтгэлтэй хандахыг та бүхнээсээ хүсье. Илтгэл, дүгнэлттэй холбогдуулан Ерөнхий сайд, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн даргаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү? Үгүй, Дэг нь чуулган дээрээ шууд авдаг дэгтэй. Хэнээр, хэн сүүлд нь гарч байна, тасаллаа. Хамгийн сүүлийн хүн хэн байна вэ? Маш олон гишүүд асуулт асуух нь. Асуулт асууна, дараа нь үгтэй тийм ээ. Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Гадаад зээллэгийн ашиглалтын хууль эцэслэн батлах шатан дээрээ унасан. Үүнтэй холбоотойгоор энэ төсвийн хүрээний мэдэгдлийг яг энэ хэлбэрээр нь хэлэлцэх нь өөрөө утгагүй болж байна. 2024 оны намар 2025 оны төсвийн тухай хуулийг эцсийн хэлэлцүүлгийн шатад самарсан, улс төржсөн, алдагдалгүй төсөв байх ёстой гэсэн гишүүд яг энэ сая өнөөдрийн энэ хуулийг бас унагах санал өгч байгаа байхгүй юу. Та яг яа гээд байгаа юм. Алдагдалгүй төсөв байна гэдэг чинь тэгээд энэ авсан зээлүүдээ яаж ашигла гээд байгаа юм бэ? Дандаа бодлого эсэргүүцсээр байгаад, өөрсдөө тэгээд засах ямар бодлого оруулж ирсэн юм бэ? Төсвийн тогтвортой байдлын зөвлөл улсын хөгжлийн тогтворгүй байдлыг бий болгоод байгаа юм уу? Энэ авсан зээлүүдээ яаж ашиглах вэ? Газрын тосны үйлдвэр бид хийж байгаа ажлынх нь хөлсийг нь өгч чадахгүй нөхцөл байдалд хүрээд байна шүү дээ. Яах ёстой юм бэ?

Эрчим хүчний сайд нь, бүх сайдууд нь Эрдэнэбүрэний усны цахилгаан станц, Сэлбэ дээр ч гэсэн бид бондыг нь босгох зөвшөөрлийг нь өгчихсөн шүү дээ. Бондоо босгочихсон, өөр юунд ч зарцуулах боломжгүй, өдөр болгон бид энэ авсан зээлийнхээ төлбөрийг төлж байгаа. Зээлийн хүүг төлж байгаа, улам нэмэгдэж байгаа. Яах ёстой юм бэ, яа гээд байгаа юм бэ, би ердөөсөө ойлгохгүй байна. Ерөнхий сайдаа Төсвийн энэ зарлагын тэнцлийг хувь хэмжээг нь өөрчлөх талаар санаачилга гарга, Сангийн сайдаа яаж албан ёсоор тэгвэл энэ төсөвтөө оруулаад энэ гадаад зээллэгүүдээ ашиглах вэ? Бид чинь энэ төсвийн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна гэсэн ийм хязгаарыг таазыг өөрөө өөрсдөдөө тавьчихсан. Тэгээд урсгал зардлуудаа багтааж чадахгүй танаад хасаад, бүүр адаг сүүлдээ яаж байна вэ гэхлээр хөөрхий муу төрийн албан хаагчид дээрээ асуудлаа нааж үлдээж байгаа байхгүй юу.

Төрийн албан хаагчдын тэтгэврээ тогтоолгох насанд нь нэг удаа олгодог 36 сарын тэтгэмж бууруулах оролдлого оруулж ирсэн, хэвээр нь үлдээсэн. Тэгсэн ч гэсэн төсвийн 50 хувийг нь л баталсан. Яагаад вэ гэхлээр энэ хязгаартаа багтахгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд яаж цалин хөлсөө нэмэгдүүлэх юм, яаж тэтгэврээ нэмэгдүүлэх юм, урсгал зардлуудаа яах гэж байгаа юм би бүүр ердөөсөө ойлгохгүй байна. Гарц шийдэл чинь юу юм бэ, та нар ямар гарц шийдэл санал болгож байгаа юм бэ тэгвэл? Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс үүнийг асуумаар байна. Ерөнхий сайдын зүгээс албан ёсоор үүнийг оруулах боломжтой байгаад байна уу? Энэ ядаж л Эрдэнэбүрэний усны цахилгаан станц, ядаж л энэ газрын тосны боловсруулах үйлдвэр, босгочихсон нэгэнт авчихсан байгаа зээлээ яаж ашиглах вэ, Хөгжлийн банкнууд руугаа эсхүл шилжүүлэх юм уу яах вэ? Ийм л асуудал байна даа. Бүүр үнэхээрийн хэлэх үг алга.

Яагаад ингээд улс орноо мэдэж хорлоод байдаг юм уу, мэдэхгүйгээр хорлоод байдаг юм уу? Нэн ялангуяа энэ миний мэдэхийн мундаг л эдийн засагчид л гэж боддог юм шүү дээ. Тэгээд зүгээр юмыг унагааж болно, ядаж босгох өөр гарц шийдлийг нь санал болгох хэрэгтэй шүү дээ. Улс орноо ингээд хохироогоод, хорлоод байж боломгүй л санагдах юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя. Дараад нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бэлдэж байгаарай.

Н.Учрал: Эдийн засаг хэрвээ агшиж байгаа бол илүү мөчлөгийг сөрж, тодорхой алдагдал үүсгэж, үүсгэхдээ гол нь санхүүжих эх үүсвэр нь тодорхой байсан цагт мэдээж эдийн засгийг халааж идэвхжүүлнэ. Тэгэхээр бид эдийн засаг тэлж байх үед хуримтлал хийж чадаагүй, тэгээд алдагдалгүй төсөв сайн, алдагдалтай төсөв муу гэдэг ийм ойлголтоор олон удаа төсөв баталж иржээ. Тэгэхээр нөгөө олсныхоо хэрээр үрдэг шиг, өмнө нь бид чинь 33,5 их наядын орлоготой, 33,5 их наядын зарлагатай төсөв батлаад бид их сайн алдагдалгүй, сайн төсөв баталчихлаа гээд байдаг. Тэгэхээр энэ өөрөө нөгөө эдийн засгийн бодлого бол өөрөө яг мөчлөг яг сөрнө гэвэл би яг энэ цаг мөч л гэж хараад байгаа юм. Тэгэхдээ энэ бол зөвхөн нэг тийм алдагдал үүсгэснээрээ биш, гадаад зээлийн ашиглалтаа нэмэгдүүлэх ёстой. Хэрэв эх үүсвэр нь тодорхой байгаа тохиолдолд.

Давхар энэ ЗГ-ын явуулаад байгаа энэ чөлөөлье гээд байгаа бодлого чинь өөрөө эдийн засгийг идэвхжүүлэх гээд байгаа л гол бодлого. Тийм учраас энэ гадаад зээлийн ашиглалтын хуулийг энэ Алтаншагай нарын гишүүд санаачлаад, эх

үүсвэр нь бэлэн байгаа энэ гадаад зээлээ ашиглая, хурдан хугацаанд энэ төслүүдээ дуусгая гэдэг ийм зорилгоор энэ хуулийг Их Хурлаар хэлэлцүүлж, бүлгүүдээр ч шийдвэрлэсэн гэж бид ойлгож байсан. Гэхдээ яах вэ төсвийн тусгай шаардлага энэ Төсвийн тогтвортой байдлын хуулийг бид чандлан барьж байгаа. Яг энэ удаа оруулж ирсэн төсвийн хүрээ, төсвийн төсөөлөл бол Төсвийн тогтвортой байдлын хуулийн тусгай шаардлагууд хатуу барьсан. Ийм л төсвийн хүрээг оруулж ирсэн.

Тэгэхээр мэдээж төсвийн сахилга бат, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэхэд энэ Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагуудыг барих нь маш их чухал. Гэхдээ яг гадаад зээл дээр ийм асуудал үүсээд байгаа юу гэвэл үүсээд байгаа. Гэхдээ бас огт орон зайгүй болчхоогүй, гадаад зээл дээр харьцангуй орон зайнууд байгаа. 2027 онд чинь бараг 4 их наяд, 28 онд 3,8, 2029 онд дахиад 3,5 гэхээр 11,3 их наяд төгрөгийн орон зай байгаа. Тэгэхээр төсвийн энэ хүрээнийхээ дагуу Эрдэнэбүрэнгийн УЦС болон бусад төслүүдээ үргэлжлүүлээд явуулах бололцоогүй гэж хэлж болохгүй. Тэгэхээр бид хичээнэ.

Гэхдээ мэдээж нөгөө манай төсөв чинь маш ойлгомжтой болчхоод байна шүү дээ 75 хувь нь урсгал болчхоод байна. Ерөөсөө 8 их наядын хөрөнгө оруулалт чинь 4 нь нийслэлд, 1,3 нь шинэ, 1,3 нь зээл, 1,3 нь үргэлжлэл ийм л төсөв. Тэгэхээр энэ хууль чухал байлаа. Гэхдээ мэдээж ЗГ-ын зүгээс батлагдсан төсвийн хүрээндээ хууль төслөө.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Ерөнхий сайдын микрофон.

Н.Учрал: Тэгэхээр мэдээж энэ бол Их Хурлын бүрэн эрх. Төсвийн хүрээ, төсвийн төсөөллөө ЗГ өргөн мэдүүлсэн. Та бүхэн хэлэлцээд батлаад өгвөл бид энэ макро 9 тоогоо ЗГ өөрсдөө өргөн мэдүүлж, Их Хурлаар хэлэлцүүлж байна. Тэгэхээр мэдээж энэ хууль батлагдсаны дараа бид энэ хуульдаа нийцүүлээд, энэ хязгаартаа багтаагаад л ирэх оныхоо төсвийн төсөөллийг, ирэх оныхоо төсвийг оруулж ирээд явна гэдгийг хэлье.

Саяын хууль унаснаараа гадаад зээл огт ашиглахаа болих гэж байгаа гэдэг нэр биш. Газрын тос ч бай, Эрдэнэбүрэний УЦС ч бай гадаад зээлийн 2027 онд ашиглах дүн нь энэ чинь бараг 2,5 их наяд шүү дээ. Тэгээд үргэлжлээд л явна. Энэ хэмжээгээрээ хэрэгжүүлэх төслүүдээ ингээд үргэлжлүүлээд явуулна. Тэгэхдээ мэдээж сахилга бат, хариуцлагаа нэмэгдүүлээд, зарим төслүүдийг хойшлуулаад эрэмбэлэх ажлуудыг хийхээс өөр зам байхгүй.

С.Бямбацогт: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хариулъя. Дэлгэрсайхан дарга 3 дугаар микрофон индрийн.

Ж.Дэлгэрсайхан: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дүгнэлтээ өгөхдөө төсвийн бодлогын өмнөх хэрэгжилт болон Төсвийн тогтвортой байдлын хууль, эрх зүйн орчинд үзүүлэх нөлөөлөл, гадаад өрд үзүүлэх нөлөөлөл гэдэг ийм байдлаар хандаж, дүгнэлтээ өгсөн. Өмнөх төсвийн бодлогын хэт тэлэлт, алдаатай байдлаас болоод бид төсвийн хөрөнгө оруулалтын орон зайгаа, бодлогын орон зайгаа хумьсан гэдэг ийм дүгнэлтэд хүрсэн. Мөн энэ хуулийн өөрчлөлтийг хийснээр 2 төсөвтэй болох, Төсвийн тогтвортой байдлын хууль, эрх зүйн орчинд төрөг нөлөөлөх юм байна гэдэг энэ агуулгыг бид харсны улмаас яг төсвийн тогтвортой байдлыг хангуулах эрх, үүрэг бүхий төрийн Улсын Их Хурлын дэргэдэх байгууллагынхаа хувьд бидний зүгээс

шууд дэмжсэн дүгнэлт өгөх ямар ч боломжгүй байсан. Тийм учраас бид энэ дүгнэлтийг өгсөн гэдгээ хэлье. Шийдвэр гаргалтыг УИХ дээр яаж гаргахыг, яах вэ бид зөвхөн дүгнэлт шийдвэр л гаргадаг. Тэрийг УИХ хэрхэн хүлээж авч, шийдвэрээ гаргах нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал гэж хэлмээр байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Улсын Их Хурлын тэгээд бүрэн эрхийн асуудал юм бол тэгээд бидний буруу юм байна л даа. Угаасаа ч тэгээд бидний буруу л даа. Газрын тосны үйлдвэр энэ жил зээл ашиглалтаас нь бараг хэдэн төгрөг тавигдсан юм бэ мөнгө тавигдсан юм уу, тавигдаагүй юм уу? Энэ чинь энэ хууль гарчихна гэсэн найдлагаар л юу ч тавиагүй шүү дээ зарлага талдаа Сангийн яам. Тэгээд энэ жилдээ яг яая гээд байгаа юм бол? Хийсэн ажлынхаа мөнгийг нь ч өгч чадахгүй ингээд сууж байгаа шүү дээ. Энэтхэгийн ЗГ Энэтхэг талаасаа яаж байгаа билээ, бүр би лав тэгээд ичиж байна. Петрочайна нөгөө талдаа олборлох нөөцөө бууруулаад байгаа шүү дээ, энийгээ бид мэдэж байгаа байгаа даа. Үйлдвэр ашиглалтад орох хугацаа нь хойшлоод л байдаг, Петрочайна гарах хугацаа нь наашлаад л байдаг. Тэгээд яг яацгаах юм бол, энэ том агуулгаар нь харж байгаа хүн байгаа юм болов уу? Энийгээ нэг ярьчихмаар байгаад байх юм. Яах ёстой юм бол? Энэ зүгээр үг л гэж яая даа, ямар хариулт хүсэх вэ дээ угаасаа хариулт ирэхгүй юм байна, больё.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя, дараад нь Энхбаяр сайд.

Н.Учрал: Энэ Гадаад зээлийн ашиглалтын хууль батлагдаагүй учраас ЗГ төсвийн хүрээндээ энэ газрын тос ч бай, Эрдэнэбүрэнгийн УЦС энэ төслүүдийн ашиглалтыг оруулаад л явсан шүү дээ. Орсон, ороод явж байгаа. Тэрнээс хасаад биш шүү дээ. Хууль батлагдаагүй байхад бид түрүүлээд гадаад зээлийн ашиглалт орчих байх, энэ төсвийн хүрээнд байхгүй гээд явна гэж байхгүй шүү дээ. Энэ хуулиараа явж байгаа. 2,5 их наяд төгрөгийн орон зай байгаа зээлийн ашиглалт. Та бүхэн хэрвээ энэ Сэлбэ чинь нэмэгдвэл. Тэгэхээр та бүхэн хэрвээ энэ хуулийг ингээд өнөөдөр баталсангүй шүү дээ. Тэгэхээр энэ төсвийн хүрээгээ батлаад л явахад бид эндээ багтаагаад л явна. Бусад ажлууд хийгдэж байгаа. Тэр Петрочайна дээр Ж.Энхбаяр сайд ахлаад явж байна. ОТ-н хэлэлцээрийг эхэлж байна. Үгүй ээ, 5 сарын 12 дотор Риогийн хүмүүс ирэх гэж байна. Тэр болгон чинь тооцоод л бид энэ эдийн засгийн өсөлтөө нэгж хувиар тооцоод л оруулж ирж байгаа.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн тодруулъя. Нэмэлт асуулт нэг минут.

А.Ариунзаяа: Ерөнхий сайд би ЗГ-ын үйл ажиллагааг огт муулж гэдэг юм уу, огт шүүмжлэл хэлээгүй шүү дээ. Би асуудал байгааг хэлээд байгаа байхгүй юу. Энэ төсвийн хүрээ 27 оных дараа жилийнх. Би яг 26 оны энэ зарцуулалтын асуудлыг яриад байгаа байхгүй юу. 26 онд яг одоо бид энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн хийгдэж байгаа ажил дээр 26 онд буюу энэ жил өгөх ёстой мөнгөө өгч чадахгүй байгаад байгаа байхгүй юу. Эрх нь тавигдаагүй. Тэгэхээр энийгээ эсхүл төсвийн тодотголоор оруулж ирэх юм уу, орон зай байгаа юм бол, би энэ жилийг л яриад байгаа байхгүй юу. Тэгээд та энийг би ингээд ЗГ-ыг шүүмжлээд байгаа мэт битгий ойлгоорой, би ажил явуулах гээд байгааг л хэлээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ тал дээр нь хэдүүлээ анхаарч ажиллахгүй бол асуудал үүсэж байна шүү гэдгийг л хэлэх гэсэн юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Эдийн засаг, хөгжлийн сайд Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Ариунзаяа гишүүний хөндөөд байгаа асуудал их чухал асуудал. Сая хуулийн төсөл дэмжигдсэнгүй. Энэтэй холбоотойгоор гадаад зээлийн ашиглалт үндсэндээ 27 онд бид газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцынхаа төслөө л түлхүү ашиглагдаад, бусад төсөл буюу орлогод нийцсэн орон сууцын асуудлууд, эрүүл мэндийн 17 аймгийн төслүүд, шинээр баригдах цэцэрлэг, сургуулиуд, эрчим хүчний 10 аймгийн дулааны станцаас авхуулаад, төвийн бүсийн дамжуулах сүлжээнүүд, бүс нутгийн бүх авто замын төслүүд, орон нутгийн хөдөөгийн хөгжил, ногоон хөгжлийн бодлогын төслүүд, хил боомтын үйлчилгээ сайжруулах олон ийм хот байгуулалтын салбарын төслүүд үндсэндээ хэрэгжих бололцоогүй болж байна гэсэн үг. Тэгэхээр энийг уул нь батлаад, хуулийн гадна гаргаж байж бид энэ Монгол Улс 18,3 бид энэ тэрбум долларын гадаад зээлийг гэрээ зурчихсан байгаа байхгүй юу.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Бид 18,3 тэрбумын гэрээтэй, эндээ бид нөгөө эх үүсвэрийг нь амлуулсны төлөө жилд 40, 50 тэрбум төлдөг, нэн хөнгөлөлттэй сайн зээлүүд байгаад байдаг. Бид энэ сая батлагдсан хууль, эрх зүйн хүрээнд болохоор ашиглалт их бага. Нөгөө талдаа улсын төсвийн урсгал зардлыг цалин тэтгэвэртэй холбоотойгоор их хэмжээгээр огцом Их Хурал өнгөрсөн жил нэмэгдүүлсэн. Энэтэй холбоотойгоор улсын төсвийн хөрөнгө оруулалт хийх боломжоо үндсэндээ 27 оноос хязгаарлагдана. Шинэ хөрөнгө оруулалт байхгүй, дандаа хуучин хөрөнгө оруулалтуудаасаа бас таслаад, тэргүүлэх ээлжийн 2,2 их наядтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтыг л үргэлжлүүлнэ. Уул нь гадаад зээлийн энэ хуулийг батлаад, гадаад зээлийн ашиглалтаа гаргаад ирвэл энэ чинь 4 орчим их наядаар бид энэ олон салбарын хөнгөлөлттэй амлагдсан зээлээ ашиглаад явбал нөгөө та бидний амласан сонгуулийн чинь мөрийн хөтөлбөр нутаг орондоо, тойрогтоо очиж ярих ажил чинь энүүгээр.../минут дуусав/

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Монголбанкны орон нутаг дахь хэлтэс, салбарын захирлууд, нягтлан бодогчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх хариуцлагатай бөгөөд эрхэм үүргээ нэр төртэй биелүүлж, улс орны санхүүгийн тогтвортой байдлыг хангахад хувь нэмрээ оруулан ажилладаг Монголбанкныхаа нийт ажилтан албан хаагч та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажилд нь өндөр амжилтыг, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Одоо 26 оны 5 сарын 8-ны 11 цаг 4 минутад ирцэд 126-аас 100 хүн орсон байна. Яг энэ гадаад зээллэгтэй холбоотой санал хураалт дээр 90 хүн орсон, 61 хүн саналаа өгсөн, 29 хүн татгалзсан. 29 татгалзсан хүн дотор 7 хүн танхимд байгаа мөртөөсөө эсрэг санал өгсөн хүн бол Монгол Ардын нам /МАН/ болон хамтарсан ЗГ-т байгаа бүрэлдэхүүнээс өгсөн. Тэгэхээр би энд юу гэж хэлэх гэж байна гэхлээрээ жишээлбэл би дэмжиж саналаа өгсөн. Тэгэхээр юу гэж хэлэх гэж байна гэхлээрээ энийг нэг тийм сөрөг хүчин рүүгээ гацаалаа барилаа гэдэг байдлаар битгий улс төржүүлээрэй. Ерөнхий сайд энэ танхим нь бодлогоо, Энхбаяр сайд энэ бодлогоо энэ эхлээд энэ засагт байгаа кабинетдаа, Их Хурлын гишүүддээ хангалттай ойлгуулж чадаагүйн улмаас энэ хууль чинь уналаа шүү.

Ашиглагдаагүй гадаад төслийн зээлийн үлдэгдэл 12,6 их наяд төгрөгт хүрсний 53 хувь нь газрын тосны боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэний усан цахилгаан станц /УЦС/ зэрэг мега төслүүд байсан. Тэгэхээр энэ ингээд батлагдахгүй байгаа нь дахиад lost opportunity гэж хэлдэг алдагдсан боломж дахиад хойшилно гэсэн үг. Уг нь бид ингээд энэ нэг эдийн засгаа ахиулахын тулд зарим юман дээр энэ мэдээллээ сайн өгөхгүй байна. Та нар гишүүдийг битгий буруутгаад асуулт асуугаад бай л даа. Хангалттай мэдээллээ өгөхгүй, нөгөө гуя дагаж хүзүү гэдэг шиг өвсөнд боосон чулуу шиг юмнууд завсраар нь оруулж ирээд ийм л болж байна шүү дээ 1.

2 дугаарт болохоор энэ гадаа ингээд л баахан хүмүүс хөөрхий ахмадууд зогсоод л тэтгэвэр тэтгэмжийн асуудал, тэгээд багш нар ч тэр, эмч нар ч тэр нийгмийн гол ачааг нуруун дээрээ авч явж байгаа хүмүүс ингээд л зогсдог. Гал унтраах маягтай энэ асуудалд хандаад байдаг, уг нь энэ аудитад зөндөө хэлсэн Өмнө нь Учрал сайдыг Ерөнхий сайд болоход нь хэлсэн нэг зүйл байгаа шүү дээ. Нөгөө Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа төсвөө, энэ төсвийн хүрээгээ нийцүүлээч гэж. Одоо зүгээр ёс төдий, зарчмын хувьд нийцэж байна гэдэг дүгнэлт 16 жил хийгдэж ирсэн. Энэ хийгдэхгүй байгаа. Мэдээлэл сонсох нь энэ аюулгүйн зөвлөл дээр энэ бичиг баримт нь болоод яваад байгаа, дээрээс нь засаг руу шилжчихсэн гээд байх юм. Тэгэхээр яагаад энийг хэлээд байна гэхлээрээ Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшил, хүний аюулгүй байдал энэ зүйлд хамгийн нэн шаардлагатай зүйлийг бид төсөвтөө оруулах, тэгэхийн тулд энэ төсвийн хүрээ рүүгээ чиглүүлэх ёстой юм байгаа юм шүү дээ.

Тэгэхгүй болохлоор энэ чухал байсан юм та нар ойлгосонгүй, унагаачихлаа гэдэг байдлаар ингээд агсагнаад байж болохгүй. Энэ чинь бүгдээрээ л Монгол хүмүүс, бүгдээрээ л Үндсэн хууль дээр тангараг өргөсөн хүмүүс байгаа шүү дээ. Тийм учраас ЗГ энэ бодлогоо ийм учраас гэдэг тэр ... Reasonable.. гэж хэлдэг, хөдөлшгүй нотлох баримт, тэр үндэслэлүүдээ энэ хууль тогтоогч нартаа сайн ойлголцуулж, энэ талаарх зүйлүүдийг маш сайн хийдэг байх ёстой.

Тэгэхээр Ерөнхий сайдаас асуулт асууя. 2024 оны 7 сарын 9-нд байгуулагдсан Оюун-Эрдэнийн ЗГ 578 зүйл, заалттай мөрийн хөтөлбөр дэвшүүлсэн. Мэдээж энэний 70 орчим хувь нь эдийн засаг руу чиглэсэн, боомт гэсэн чиглэлтэй явж байсан. Энэ олон мега төслүүдийн тухай асуудал бол эндээс гарч ирсэн. Дараа нь Занданшатарын тэргүүлсэн ЗГ байгуулагдсан. Занданшатарын ЗГ-ын үед зарим зүйлээ буюу эрэмбийн хувьд өөрчилсөн. Оюун-Эрдэнийн ЗГ, Занданшатарын ЗГ-аас ялгаатай нь та бол ингээд чөлөөлье, эдийн засгаа идэвхжүүлье, хувийн хэвшлийг ингээд боломж олгоё гээд явж байгаа. Яг энэ зарчмын шинж чанартай, стратегийн ялгаатай зүйлүүд нь яг юу юм бэ? Энэ дээр тодорхой хэлмээр байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ урагшаагаа явахын тулд эдийн засгаа эрчимжүүлэхийн тулд алинаас нь татгалзаж байгаа юм бэ? Туулын хурдны зам гээд л сая жишээлбэл ингээд шүүхээр шийдэх ёстой гэхчлээ. Тэгэнгүүт энэ эдийн засагтаа өөрчлөлт оруулахгүйгээр өөрөөр хэлбэл бүтцийн хувьд дүнг нь өөрчлөхгүйгээр энийг урагш нь явуулъя гээд байгаа энэ үндэслэлийг та нэг тайлбарлаадхаач. Энэ аргументыг нэг сонсмоор байна. Тэгээд.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд Ням-Осорын Учрал хариулъя.

Н.Учрал: 2024 онд хамтарсан ЗГ байгуулахад ЗГ-ын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг Их Хурлаар батлуулсан. Энэ төслүүдийг эрэмбэлсэн.

Тэгээд ЗГ-ын 14 мега төслийг Занданшатар Ерөнхий сайдын үед эрэмбэлсэн. Ж.Энхбаяр сайд эрэмбэлсэн юм байна лээ. Тэгэхээр цаашдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг та бүхэн харж болно. Бид энэ жил ер нь эдийн засаг ийм агшиж байх үед тэр хувийн хэвшлээ дэмжих нь зөвхөн төсвөөс гэхээсээ илүүтэйгээр нөгөө төрийн оролцоог хумих чиглэлийн бодлогуудыг л явуулж байгаа юм. Дээрээс нь зах зээл дээр байгаа ажлын байруудыг хадгалах бодлогуудыг явуулж байгаа юм. Ажлын байр нэмэгдүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн үйлдвэрүүдийг барьж байгуулахыг нь дэмжих, тэр зөвшөөрөл, дүрэм журам, саад тээгүүдийг, гацаануудыг нь арилгах бодлогуудыг хэрэгжүүлж байгаа юм.

Яг ийм цаг үед аливаа улс орон ард түмэндээ, иргэддээ, ААН-үүддээ итгэж урагшилдаг. Тийм учраас энэ 4 чөлөөлөлтийн бодлого бол энэ рүү л чиглэж байгаа юм. Тийм учраас бид сая жилийн төлөвлөгөө дээр та бүхэн сонссон байх. Энэ гангийн үйлдвэр, зэсийн үйлдвэр, нүүрс пиролиз, тэр хөнгөн цагааны үйлдвэр гээд тодорхой хэдэн үйлдвэрүүдийг төсвөөс санхүүжүүлэхгүйгээр барьж байгуулна гэдгийг тусгаад явж байгаа. Үүнийг хийхийн тулд тэр зөвшөөрөл, дүрэм журам, саад тээгүүдийг арилгах. Жишээ нь эрчим хүчин дээр гэхэд 5 сэргээгдэх эрчим хүчний төсөл өчигдөр зарлагдлаа гэдэг шиг төсвөөс санхүүжүүлэхгүй төслүүдийгээ ингэж явуулахыг л илүүтэй гол зорилгоо болгож байгаа.

Жишээ нь гадаад зээлийн ашиглалт гэхэд та түрүүн хэлж байна 1,2 их наядар өнгөрсөн жил гадаад зээлийн ашиглалт батлагдсан. Сая би тэр дүнг нь харлаа. Жишээ нь газрын тос дээр 145, Эрдэнэбүрэн дээр 82, 3 тэрбум л гарсан байгаа байхгүй юу. Тэгэхээр ингээд энэ оны төгсгөл рүү буюу 7 сараас хойш ер нь гадаад зээлээ ашиглаж чадахгүй байдал руу орчхож байгаа юм. Сая энд нөгөө энэ хууль батлагдаагүй байсан учраас, тэгэхдээ батлагдах нөгөө эцсийн хэлэлцүүлэгт шилжсэн байсан учраас бас нэг гадаад зээлийн ашиглалтаасаа 300-г хумиад оруулаад ирсэн. Тэгээд одоо ингээд л энэ орон зайд л урагшилна. Тэгэхдээ төслүүдийг эрэмбэлсний хувьд саяын 2 төслүүдийг бид тэргүүн ээлжид хэрэгжүүлнэ гэдгийг эрэмбэлээд явж байгаа. Тэгэхээр ирэх жилийн төсөв нэлээд хумьсан, дээрээс нь урсгалыг нэмэгдүүлсэн л байхаас өөр замгүй болж байгаа. Гол нь энэ ажлын байрыг хадгалж үлдэх бодлогыг л явуулах гэж байгаа. Тийм учраас энэ татварын хуулийг өчигдөр барилаа. Энэ бол хувийн хэвшлийн, иргэдийнхээ нөгөө ажлын байрыг хадгалах зорилготой. Ирэх долоо хоногт нөгөө хөрөнгө оруулалтын дагасан хуулиудыг, Эдийн засгийн эрх чөлөөний хуультай өргөн барина.

С.Бямбацогт: Тодруулж асууя Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Ерөнхий сайдаа одоо мэдээж яах вэ ингээд хэмнэх юм байлгүй яах вэ, танах юм байна. Тэгэхдээ ер нь 2 салбарыг бид нөгөө үндсэн биш салбарын бодлого гээд яваад байгаа боловсрол, эрүүл мэнд. Яаж ч бодсон манай улс тэр Формосмостетээс гаргасан судалгааны үндсэн дээр хараад үзэхэд энэ 2 салбар дээрээ аль болохоор хэмнэлт багатай, дотор нь тэр жишээлбэл эрүүл мэндийн 26 он гэхэд 168,2 тэрбум харагдаж байна. Адаглаад л энэ дотор тэр Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төв CDC гээд олон улсын нэрлэхээр нь байж байгаа. Энэ ингээд төсөвт өөрчлөлт оруулахгүйгээр механизмыг нь өөрчлөөд, дахин инженерчилчихэд бараг 300-аас 450 тэрбум төгрөгийн алдагдсан боломжийг урьдчилан сэргийлж авч үлдэх боломжтой ийм төсөл байх жишээтэй. Тэгэхээр яг энэ шиг ингээд боловсрол, эрүүл мэндийн салбарууд дээрээ аль болохоор хасахгүй байх ёстой шүү. Энэ ерөөсөө яг ингээд аль ч ЗГ-ын үед.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчхэв үү? Үг хэлчихлээ. Энхбаяр сайд хариулчихъя Эдийн засгийн хөгжлийн сайд.

Ж.Энхбаяр: ЗГ-ын тэргүүлэх бодлого бол хүний хөгжлийн асуудал байгаа. Энэ хүрээнд эрүүл мэнд, боловсролын салбарыг 26, 27 онд жил болгон нэрэмжит болгон хэрэгжүүлж байна шүү дээ. Энэ хүрээнд чинь энэ салбарт ажиллаж байгаа албан хаагчдын цалин нэмэгдэл хамгийн өндөр сая нэмэгдлээ. Энэ салбарт хамгийн их гадаад зээлийн ашиглалт, улсын төсвийн хөрөнгө оруулалтууд чиглэж байгаа. Хүнээ хөгжүүлж байж, хүнийхээ эрүүл мэндийг хангаж байж, эдийн засгийн хөгжлийнхөө сууриа хангана гэсэн бодлогыг хэрэгжүүлж байгаа. Түрүүнд та аюулгүй байдлын асуудал хөндсөн, хамгийн сул тал бид шатахуун 100 хувь гаднаас байна, энийгээ хэрэгжүүлбэ гэлээ, сая хойшлууллаа. Эрчим хүч дутагдалтай байна, энийгээ дотоодод хангая гэлээ бас хойшлууллаа. Аюулгүй байдлын нотлох баримт чинь энэ байхгүй юу. Эрчим хүч дутаад байна, шатахуун 100 хувь хамааралтай байна. Монголд газрын тос байна, эрчим хүчний эх үүсвэрүүд байна, байгуулъя, бүтээе, гаднаас зээл олоод ирлээ, зээлээ ашиглая гэхээр энэ зээлийг ашиглуулахгүй гээд сая.../минут дуусав/

С.Бямбацогт: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Оюун-Эрдэнийн ЗГ төсвийн хүрээний мэдэгдлээ 4 удаа өөрчилж байсан юм л даа. Тэгээд энэ болгондоо төлөвлөлтгүй л байсан гэсэн үг. Тэгээд яг өнгөрсөн жил өдийд 2027 оны гадаад нийт өр 51 их наяд байна гэсэн. Гэтэл өнөө жил 57 их наяд болгоод ороод ирж байна. 6 их наядаар нэмэгдүүлээд ороод ирж байгаа. Тэгэхлээр энэ юуг илэрхийлж байна вэ гэвэл бид өр тавиад тансаглалаа, дарга нарынхаа тансаглалыг, төсвөөс идэж уудаг бүх зүйлээ бүгдийг нь хийнэ, манай хойч үе бидний тавьсан өрийг төлнө, бид сайхан амьдарч байвал хойч үе өртэй байна уу, өргүй байна уу бидэнд хамаа байхгүй гэдэг ийм л зарчим дээр энэ зүйл чинь орж ирж байна шүү дээ. Өнгөрсөн жилийнхээс 6 их наядаар нэмэгдүүлнэ гэдэг чинь юу гэсэн үг юм бэ?0 Ер нь өрөөр ингээд л бүх юмаа санхүүжүүлдэг ийм улс орон ерөөсөө хөгжихгүй.

2 дугаарт нь төсвийн зардал байна өнгөрсөн жил 34 их наядаар төлөвлөж байсан, энэ жил 36 их наяд болгоод нэмээд 2 их наядаар нэмээд оруулаад ирж байна. Энэ юуг илэрхийлж байна гэвэл та нар ингээд 9 хувиар төрийн албан хаагч нарыг хассан гээд л төсвийн зардлыг багасгасан гэж ярьж байгаа боловч 2 их наядаар нэмэгдүүлж байна гэдэг чинь юуг илэрхийлж байна гэвэл нөгөө Ерөнхийлөгчийн сонгуулиа энэ ард түмнийг худалдаж авах тэр юмнуудыгаа бүгдийг нь хийгээд ороод ирсэн гэсэн үг байхгүй юу даа. Нөгөө сахилга баттай байна гэсэн хаана байгаа юм, байхгүй л байна.

Тэгээд Дэлхийн улс орнууд ерөөсөө л төсөв, татварын бодлого гэж ярьдаг. Гэтэл манайх төсвийн бодлого гэж яриад л ганцааранг нь тусад нь оруулаад ирж байгаа юм. Өчигдөрхөн гэхэд Ерөнхий сайд татварын шинэчлэлийгээ оруулж ирнэ гээд ингээд явсан. Гэтэл ирэх жилийн төсөв дээр чинь бүхэл бүтэн 6 их наядаар энэ зардлуудыг нэмэгдүүлээд, энэнээс юу харагдаж байна вэ гэвэл ерөөсөө татварын бодлого чинь ерөөсөө явахгүй гэсэн үг байхгүй юу. Тэр чинь зүгээр аргалсан ийм шинэчлэл хийгдсэн байна гэсэн л үг байхгүй юу даа. Ийм их зардал нэмэгдэж байна гэдэг чинь. Тэгээд энэ ард иргэд, ААН-үүд энэ юм хийж байгаа хүн, бүх хүмүүс энэ татварын шинэчлэлээс чинь юм хүлээж байгаа. Яг ачир дээрээ юм байхгүй нь байна шүү дээ энэ төсөв, энэ төсвийн хүрээний мэдэгдлээс чинь эндээс харагдаж байна

шүү дээ. Дахиад л нөгөө татварын дарамттай хэвээрээ байх юм байна. Нэг жижиг сажиг нэг өөрчлөлтүүд хийсэн болох юм байна. Нэг тийм нэг хэсэг хүмүүст боломж олгоод, нөгөө хэсэг хүмүүсээ дарамталдаг тэр хэвээрээ байх юм байна. Ийм л юм харагдаж байна.

Тийм учраас энэ төсвийн хүрээний мэдэгдэл энэ их зардлууд нэмэгдүүлэх 8 их наядаар зардал нэмэгдүүлнэ гэдэг чинь юу гэсэн үг юм бэ? Одоо 2 их наядаар гадаад өрөө нэмэгдүүлээд, 2 их наядаар төсвийн зардлаа нэмэгдүүлнэ гэдэг чинь. Яаж байна гэхээр бүхэл бүтэн 6 их наядаар гадаад өрийг нэмэгдүүлж байна гэдэг чинь маш их тийм зардал гаргана, түүнийгээ өрөөр санхүүжүүлнэ гэсэн үг шүү дээ. Ингэж ард түмний нуруун дээр энэ дараа дараагийнхаа сонгуулийн, энэ сонгууль болохлоор л нэг баахан юм нэмж тавьдаг яг тэр хэвээрээ. Урьд нь би яг шүүмжилж байсан нь яг тэр хэвээрээ. Ийм л нөхцөл байдалтай байна. Энэ дээр тодорхой хариулт авъя.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Энэ төсвийн хүрээ гэдэг зүгээр хязгаар. Тэрнээс бүх зүйлийг санхүүжүүлнэ гэсэн үг биш шүү дээ. Энэ чинь зүгээр хязгаар байхгүй юу. Тэгэхээр тэрийг Пүрэвдорж гишүүн сайн мэдэж байгаа л даа. Яах вэ би нөгөө ажлаа л хийж байгаа учраас нөгөө улс төр яриад яах вэ, зүгээр ЗГ-ын өрийг 2027-гоос 2028 онд энэ Төсвийн тогтвортой байдлын хуульд зааснаар нөгөө GDP-н 50 хувь, 2029 онд 45 хувьтай тэнцэх хязгаартайгаар оруулж ирж байна. Ер нь Төсвийн тогтвортой байдлын хуулийн дээд хязгаар 60 биз дээ, 60 хувь. Тэгэхээр бид тусгай шаардлагадаа нийцүүлж байна. Энэ нөгөө дээд хязгаар нь учраас дээд хязгаар нь 50 байна, түүнээс давахгүй шүү гэж оруулж ирж байгаа. Бусад ирэх оны төсвийг энэ төсвийн хүрээнийхээ хязгаар дээрээ л багтаагаад оруулж ирнэ л гэж ойлгох ёстой. Тэрнээс биш нэг тийм өр нэмэх гээд байгаа зүйл огт биш гэдгийг хэлье.

Алдагдлын хувьд ойлгомжтой юм. Би түрүүн танд хэлсэн. Манай энэ эдийн засаг чинь маш ойлгомжтой болчихоод байна. Урсгал чинь 75 хувийг нь авч явчхаад байна. Тэгээд улсын жилийн төлөвлөгөө дээр 24 хувиас нэмж болохгүй гээд шаардлага тавьчхаад байна. Тэгээд эхлэхээр тэтгэвэр нэм гээд энэ талаас шахаад, багш, эмч нарын цалин гэхээр энэ чинь бараг ирэх жилийн төсөв дээр 1,3 биз дээ, 1,3 орчим нэмэгдэж байж энэ 50 хувь Их Хурлаас баталсан нөгөө 11 сарын 26 хувийн нэмэгдэл чинь ийм болно. Тэгэхээр нэмээд байж болох ч гэсэн энэ чинь нөгөө хязгаараа давчхаад байдаг. Тэгээд үлдсэн 8 их наяд чинь ерөөсөө л 4 нь нийслэл рүү 1,3 нь үргэлжлэл, 1,3 нь шинэ, 1,3 нь гадаад зээл байхгүй юу. Тэгээд ингээд эхэлдэг, тэгээд цалин нэмэх шаардлага байдаг, тэтгэвэр нэмэх шаардлага байдаг. Тэтгэвэр чинь энэ инфляцтай уялдуулаад индексжүүлэх дээр чинь багадаа 9 хувь нэмэх ёстой шүү дээ. Тэгэхээр энэ чинь нөгөө орон зайндаа багтдаггүй. Тэгэхээр ийм байдаг.

Тийм учраас төсвийн тэнцлийг алдагдалтай батлах дээр хэлэхэд алдагдалтай, эсвэл ашигтай байлгахаар төлөвлөхдөө эдийн засгийн тэр нөгөө мөчлөг яг хаана байна вэ гэдгээс шалтгаалж энэ алдагдал, ашгийг төлөвлөж явах нь өөрөө эдийн засгийн бодлогын хувьд зөв. Тэрнээс ингээд алдагдалгүй байвал гоё, алдагдалтай бол муу гэдэг ойлголт байхгүй. Тэгэхээр зүгээр мөчлөгийн хувьд нөгөө одоогийн бодит гүйцэтгэл нь нөгөө потенциал түвшнээсээ давсан, эсвэл дутсанаас хамааруулж тооцдог. Тэгэхээр одоогийн яг энэ манай нөхцөл байдал буюу төсвийн тэнцлийг алдагдалтай, ашигтай байлгах уу гэхээр мөчлөг муудах үе,

ийм сөрөг үе таараад байгаа юм. Тийм учраас алдагдалтай оруулж ирж байж л цаашаа бид энэ эдийн засгаа идэвхжүүлж, цусны эргэлт сайжирна л даа. Тэгээд нөгөө output гар нэрлэдэг. Тэгэхээр тэр өөрөө нөгөө яг сөрөг тал руугаа гарчихсан ийм цаг үетэй таарчхаад байгаа юм л даа. Тэгж байж энэ эдийн засаг чинь ингэж халж идэвхжихгүй бол агшаагаад байвал.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгая Ерөнхий сайд.

Н.Учрал: Агшаагаад байвал энэ улам л ингээд борц болоод л хатчихна шүү дээ. Ажлын байр ч нэмэгдэхгүй, үйлдвэр барилга байгууламж, хувийн хэвшлээ дэмжих ажил ч явагдахгүй. Тэгэхээр ийм үед харин бүүр мөчлөг сөрөх ёстой. Өнгөрсөн хугацаанд бид яадаг вэ гэхээр зөвхөн алдагдлаар амьдраад, зөвхөн алдагдал хийж тавьчхаад, тэгээд нөгөө бусад арга хэмжээнүүдийг авдаггүй байсан байхгүй юу. Одоо бол ЗГ тэр 4 чөлөөлөлтийн бодлогын хүрээнд гээд зарим зөвшөөрлүүдийг үйл ажиллагаа руу нь явуулаад, шууд цахимаар хүсэлт гаргадаг болгоод, хяналт шалгалтыг багасгаад, нөгөө компани ААН-үүдийг ажиллах нөхцөлөөр хангуулж байгаа байхгүй юу. Тийм учраас яг энэ бодлоготойгоо нийцүүлээд өчигдөр татварын хуульд тэр 8 өөрчлөлтийг, дээрээс нь мэдээлэл технологийн салбар дээр 2 өөрчлөлтийг нэмээд өргөн мэдүүлсэн. Энэ бол эдийн засгаа идэвхжүүлэх зорилготой. Тэгээд энэ хуулиа хурдан батлах хэрэгтэй. Тэгээд бид хэрэгжүүлнэ, тооцож л оруулж ирсэн.

С.Бямбацогт: Пүрэвдорж гишүүн тодруулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ахмадын тэтгэврийг сая 500 төгрөг болгохыг дэмжиж байгаа. Тэгэхдээ 2024 онд батлагдсан миний өргөн барьсан инфляцын дагуу тэтгэврийг жил болгон нэмэх тухай энэ хууль Жавхлан сайдын дэмжлэгтэйгээр төсөвт Төсвийн хуульд тусгагдаж ингэж явсан. Тэгэхээр жил болгон инфляцын дагуу нэмэгдэж байгаа. Ер нь энд ирэх жилийн төсөв юу, энэ жилийн инфляцыг 7 хувь гэж тооцож байгаа юм байна. Тийм юм байхгүй шүү. Зөвхөн мах гэхэд л бараг 80 хувиар өсчихсөн байгаа шүү дээ, 80 хувиар өсчихсөн байгаа бидний гол хэрэглээ. Тийм учраас энэ инфляцыг 7 хувиар тооцож энэ ахмадын тэтгэврийг нэмэх тухай асуудал ирэх оны төсөв дээр орж ирэхгүй шүү. Энэ дээр маш хариуцлагатай байна шүү. Энэ одоо.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгая, асуултаа дуусгачихъя. Нэмэлт нэг минут.

Б.Пүрэвдорж: Түрүүчийн жилүүдэд 6 хувиар нэмэгдүүлээд л ороод ирсэн. Яагаад гэвэл энэ жил инфляц 6 хувь байна гэж худлаа хэлээд л, дандаа 2 оронтой тоо руу орчихсон явж байгаа шүү дээ. Тэгээд ард түмнээ ингэж хуурч, ахмадуудыгаа ингэж хуурч ерөөсөө болохгүй. 10 хэдэн хувиар хамгийн багадаа инфляц байх ёстой, тэр 10 хэдэн хувиар заавал 2027 оны төсөв дээр оруулж ирэх ёстой шүү. Энэ дээр Аубакир сайд тодорхой хариуцлагатай байна шүү, ахмадуудыг хуурахгүй шүү.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Энэ үнийн өсөлтөөс иргэдээ хамгаалах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа. Нийлүүлэлтийн гаралтай инфляц бид үүн дээр авч хэрэгжүүлэх тодорхой үйлдлүүдийг хийгээд явж байгаа. Сая шатахууны үнэ, ХХАА-н салбар дахь тэр шатахууны нөгөө 10 мянган тонны нийлүүлэлтийн асуудлууд гээд тодорхой арга хэмжээнүүдийг авч байгаа. Зүгээр эрэлтийн гаралтай инфляц харьцангуй эрсдэл

бага байх. Энэ Монголбанкнаас явуулж байгаа энэ мөнгөний бодлого их хатуу байна, өр, орлогын харьцаа их хатуу байна. Ингээд явж байгаа учраас эрэлтийн гаралтай инфляц хэд юм. Пүрэвдорж гишүүн тэр ер нь тэтгэвэр дээр 10 хувь тэтгэвэр нэмэхэд манайх 300 тэрбум төгрөг шүү дээ бараг, 10 хувь шүү дээ. Тэгээд тэтгэвэр нэмэх буюу ингээд жигд нэмэхээс илүүтэйгээр итгэлцүүр шийдэх хэрэгтэй. Итгэлцүүр шийдэхэд бараг 900 тэрбум байхгүй юу. Тэгэхээр нөгөө индексжүүлэлт нэмэх хуулиа хийгээд, итгэлцүүрээ шийдээд урагшлахгүй бол бүгд жигд нэмнэ гэж шударга бус тогтолцоо.

С.Бямбацогт: 2 удаа асуучихсан. Батын Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Энэ төсвийн хүрээний мэдэгдэл маань сонгуулийн цикл рүү орчихсон байх вий гэдэг болгоомжлолыг тоонуудыг нь харахад харж байна. Тэгээд ЗГ иргэдэд амласан татварын буцаан олголтоо цуцлахдаа Олон улсын валютын сан /ОУВС/, геополитик инфляц эд нар гээд тайлбарлачхаж байгаа юм. Харин төсвөө өөрчлөх эрх авахдаа уян хатан байдал гэж нэрлэж байна. Иргэдийн халаасанд очих мөнгө болохоор эрсдэл ЗГ-ын зарцуулах эрх боломж гэж үзэж болохгүй. Иргэдийн мөнгийг хэмнэх гэж байна уу, эсвэл ЗГ-ын зарцуулах эрхийг хамгаалж байна уу гэдэг дээр энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр асуух ёстой болчихоод байгаа юм. НӨАТ-ын буцаан олголтыг нэмэгдүүлэх зохицуулалтыг хүчингүй болгохоор ингээд ороод ирсэн. Тэгсэн хэр нь төсвийн тодотголыг 3 сарын хязгаарлалтгүйгээр оруулж ирэх боломжийг энэ дээрээ, боломжоо өөрсдөдөө бий болгож байгаа юм. Энэ 2-ыг хамтад нь ингээд харахаар иргэдэд очих мөнгөө хасаад, ЗГ төсвөө дахин өөрчлөх эрхийгээ нэмэгдүүлж байгаа юм шиг харагдаж байна.

Инфляцтай тэмцэх нэрээр иргэдийн бодит орлогыг бууруулж байгаа юм биш үү. ЗГ инфляцын эсрэг бодлого нэрээр иргэдийн худалдан авах чадвараа хамгаалах бус иргэдийнхээ халаасанд очих мөнгийг төсөвт үлдээх гэдэг ийм оролдлого хийж байна гэж харагдаж байна. Яагаад зардлаа танахгүй, харин иргэдийн буцаан олголтыг цуцлаад байна вэ гэдэг асуудал дээр хариултыг авмаар байна. Төсвийн тодотголынхоо 3 сарын хамгаалалтыг авах нь тийм уян хатан байдал мөн юм уу, эсвэл төсвийн сахилга алдагдах хаалга уу гэдгээ бодмоор байна.

Бид төсвийн тогтвортой байдлыг эсэргүүцээгүй. Харин төсвийн тогтвортой байдлыг иргэдийнхээ халааснаас эхлүүлээд, ЗГ-ын зардлаас эхлүүлэхгүй байгааг л эсэргүүцэж байгаа юм. Энэ төсөл эдийн засгийн өсөлт гарна гээд тооцсон ч гэсэн иргэдийнхээ амьдрал дээр өсөлт мэдрэгдэх эсэхийг огт хариулаагүй байна. ДНБ өсөхөөр ард түмний орлого өсөх үү, эсвэл зөвхөн төсөв томрох уу гэдгээ энэ дээрээ тодорхойлж өгөөгүй байна. Эдийн засаг 5,8 хувиар өснө гэдэг тооцоолол хийсэн байна, төсөвлөсөн юм байна. Гэхдээ энэ 27 онд төсвийн 5 аравны эдийн засгийн 5,8 хувийн өсөлт маань өрхийн бодит орлогыг хэдэн хувиар өсгөж байна вэ гэдэг тоо энэ дээр ерөөсөө алга. Ядуурлын түвшин хэдээр буух юм, инфляцын түвшнээсээ давж өсөх юм уу тэр цалин нь. Инфляцыг 7 хувь гэж тооцсон байна. Тэгэхээр энэ чинь 7 хувиар иргэдийн орлого хуримтлал хорогдоно гэсэн үг. Тэгээд өрөө 57,1 их наяд буюу ДНБ-ий 50 хувьтай тэнцэхээр гээд заачихсан. Яах вэ хууль тогтоомжоороо ЗГ 60 хувь хүртэл өр тавих боломжтой. Тэгэхдээ энэ ДНБ-ээ өсгөөд байдаг, мөнгөн дүнгээрээ өр төлбөр нь өсөөд байдаг. Тэгэхээр энэ ямар орлогоор, ямар хугацаанд энэ өрийн ДНБ-д эзэлж байгаа хувь гэдэг утгаар нь биш, 57,1 их наяд төгрөг гэдэг хувь утгаар нь энийгээ ямар хугацаагаар бууруулж.../минут дуусав/

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлангийн урилгаар Дархан-Уул аймгийн Оюутны холбооны тэргүүлэгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Оюутан залуучууд та бүхэн бол Монгол Улсынхаа шийдвэр гаргах түвшинд дуу хоолойгоо хүргэж, нийгмийг өөрчлөхдөө хамгийн хүчтэй хөдөлгүүр гэдгээ санаж, шүүмжлэгч байхаасаа илүү, шийдлийг эрэлхийлэгч, идэвхгүй ажиглагч байхаасаа илүү идэвхтэй оролцогч байгаарай гэж Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Идэвхтэй байна, мундаг байна, манай Жавхлан гишүүн 3 удаа сонгогдсон, Монгол Улсын төсөв, санхүүгээр мэргэшсэн сайн гишүүдийн нэг. Тэгээд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар ажилладаг, одоо энд сууж байна. Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Батбаатар сайд нөгөө ЗГ-т ажиллаж байхад тухайн үед би энэ төсвийн хүрээг оруулж, бид хамт ажиллаж байсан. Тэгээд би яг энэ 3 сарын энэ заалт дээр нэг зүйлийг хэлье гэж бодоод байгаа юм. Тухайн үед энийг нэг удаа хэрэглэе гэж оруулж ирсэн шүү дээ. Энэ төсөв өөрөө батлагдсанаас хойш төсвийг 3 сарын дараа заавал барь гэдэг энэ ямар ч логикгүй шүү. Яагаад гэхээр ирэх оны төсөв болж байна. Зөв шүү дээ энэ бол. Одоо бариад, ирэх оны төсвийг эндээ тааруулж оруулж өгсөн энэ хязгаартай.

Тодотгол ер нь яагаад хийх шаардлага үүсдэг вэ гэхээр хэрэгцээ шаардлага гарч байгаа юм олон улсын эдийн засгийн хурцадмал байдал, эдийн засаг агшсан, инфляц энэний өссөн ч гэдэг юм уу, үнийн өсөлт их өндөр байгаа ийм үеүдэд. Тэгэхээр тухайн үед эдийн засгийн бодлогын хувьд мөчлөг сөрөх шаардлагатай байна, тодорхой арга хэмжээ авах хэрэгтэй байна, ажлын байрыг хадгалах шаардлагатай байна гээд зарим зардлаа танадаг. Тэгэхээр нөгөө орлого, зарлага аль алиныг нь бууруулаад орж ирдэг. Тийм хэрэгцээ шаардлагад нийцчихээд байхад энэ 3 сарыг хөндөхгүй гэхээр 3 сарын дараа тэр тодотгол утгагүй, учиргүй болчихож байгаа байхгүй юу. Тодотгол гэдэг тухайн цаг үетэйгээ зэрэгцээд хариу арга хэмжээ авах зорилгоор хурдан хугацаанд оруулж ирдэг ийм арга хэмжээ хийх зорилгоор. Дандаа ер нь зардлаа л бууруулж байгаа шүү дээ.

Тийм учраас бид энэ заалт бол анх батлагдахдаа тодотгол биш, ирэх оны төсөв дээр илүү барих л заалт байсан болов уу гэж бодоод байгаа юм. Энэ төсвийн хүрээнд зориулаад ирэх жилийн намрын төсөв энэ хүрээ энэ хязгаар дотор орж ирнэ, энэ frame дотор. Магадгүй юу гэдэг юм 6 сард бид юу болохыг мэдэхгүй, 7 сард юу болохыг мэдэхгүй. Зарим зардлаа танах, төслүүдээ хойшлуулах, шаардлагатай бол энэ үнийн өсөлтөөс иргэдээ хамгаалах чиглэлээр цалин хөлс нэмэх энэ тэр асуудал гарвал энэ 3 сар байна тийм учраас 9 сарыг хүлээе гэвэл энэ явахгүй юм байна лээ л дээ. Тийм учраас энэ 2 өөр ойлголт юм байна лээ. Тэгээд тухайн үед нөгөө бид чинь энэ 3 сарын заалтыг хөндөж орж ирж байсан шүү дээ. Тэгэхдээ 1 удаа хэрэглэе гэж. Тэр Батбаатар сайд энийг сайн мэднэ.

Эдийн засгийн өсөлт 2027 онд 5,8 хувь байхаар тооцож байгаа. Бид эдийн засгийн өсөлтийг тооцохдоо салбарын яамнууд энэ өсөлтөд ямар нэгж хувиар хувь нэмрээ авруулах вэ гэдгийг тооцдог. Жишээ нь нүүрсний үнэ, нүүрсний экспорт жишээ нь өмнөх муу оны үеэс нэг дунджаар дунджаар бараг 58-аас 60 хувь нэмэгдчихээд байна шүү дээ. Тэгэхээр бид ирэх жил 95 сая тоннд хүргэнэ биет хэмжээ. Тэгэхээр нүүрсний олборлолт нэмэгдэх, боомтуудын хил дамнасан төмөр замын олборлолттойгоор нүүрсний экспорт нэмэгдэх боломж байна, ОТ-н зэсийн баяжмал дахь агуулга нэмэгдэнэ, төмрийн хүдрийн олборлолт нэмэгдэнэ. Дээрээс

нь зэс болон төмрийн үнэ олон улсын зах зээл дээр өсөх хандлага сүүлийн assumption-аар харахад.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд гүйцээж хариулъя.

Н.Учрал: Тэгээд боломжууд байна ер нь таамаглалаар. Ган, зэс, нүүрс, пиролиз боловсруулах үйлдвэрүүд, уул уурхайн боловсруулах үйлдвэрүүдийг дэмжинэ. Энэ нийлүүлэлтийн гаралтай инфляцаас иргэдээ хамгаалах чиглэлээр бид энэ хэрэгжүүлж байгаа Хүнсний хувьсгал, Атрын 4 дүгээр аян, Цагаан алт хөтөлбөрүүдийг үе шаттайгаар дэмжих бодлогуудыгаа үргэлжлүүлж байна. Яг үүнтэй бид параллелийн зэрэгцүүлээд энэ гааль дээр цахимжилтыг эрчимжүүлэх, олон шат дамжлагуудыг бууруулах, хуучин зөвхөн экспорт нэмэгдүүлэх тал дээр манай Тэргүүн шадар сайдын ажлын хэсэг ажилладаг байсан. Одоо импортыг хамт авч явж байгаа. Яагаад гэхээр нөгөө төлбөрийн тэнцэл алдагдалтай байгаад байна, экспорт сайн, импорт муу байгаад байна. Тийм учраас энд байгаа саадуудыг арилгаж байж энэ нийлүүлэлтийн гаралтай инфляцыг барих бодлогоо хэрэгжүүлж явна л гэж ингэж зорьж байгаа.

С.Бямбацогт: Батбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Батбаатар: 27 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 28-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл дээрээ зүгээр нэг энэ хуулийн төсөл маань өөрөө 2 дохио бол шууд өгөөд байгаа байхгүй юу эхний ээлжид, 100 гаран хуудастай жижиг шрифттэй энэ материал орж ирээд долоо хонож байна гишүүдийн, 5 сарын 1-нд өргөн барьсан. Тэгэхээр ямар дохио өгч байна гэхээр иргэдэд очих НӨАТ-ын буцаан олголтоо нэмэгдүүлэх амлалтаасаа 3Г ухарч байна гэж.

2 дугаарт нь 3Г төсвийн тодотголоо илүү чөлөөтэй оруулах эрхийг авах гэж байна гэдэг ийм 2 дохиог гарцаагүй өгч байгаа. ОУВС болоод бусад зөвлөмжүүд гээд ухрах үндэслэлээ заачхаж байгаа юм. Тэгээд энэ ОУВС-ийн зөвлөмжөөсөө гадна өөрсдийнхөө хийсэн тооцоо хувилбар, судалгаа, иргэдийн орлогод үзүүлэх нөлөөллийн үнэлгээг УИХ-д бүрэн танилцуулахгүй юм уу 3Г?

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Энэ НӨАТ-ын буцаалтыг нэмэгдүүлэх хууль хэрвээ хэрэгжиж эхэлбэл 1,6 их наяд юм байна лээ шүү. Орлого буурна, НӨАТ-ын буцаалтыг нэмэгдүүлсэн тохиолдолд. Үүний оронд бид зах зээл дээр байгаа ажлын байруудыг хадгалж үлдэх бодлого явуулах ёстой. Тийм учраас хөдөлмөрлөж байгаа хүн бүрийг дэмжих зорилгоор энэ татварын хуулийг өргөн мэдүүлсэн. Ерөөсөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээн дээр Хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/-ыг тэглэхийе. Энэ бодитой дэмжлэг байхгүй юу. Ажлын байрыг авч хадгалах. Тэгээд ААНОАТ-ын нэг хувийг 2,5 тэрбум болгоод борлуулалтын орлогоос доош байвал гээд татварын хуулиа өөрчилчихье ч гэдэг юм уу. Ингээд ажлын байрыг хадгалж үлдэх л татварын хуулийг өөрчилж оруулсан нь бодлогын хувьд зөв юм. Тэрнээс НӨАТ-ын буцаалтыг нэмэгдүүлээ гээд 1,6 их наяд орлого буурчихвал юун цалин, тэтгэвэр нэмэх ийм л.../минут дуусав/

С.Бямбацогт: Батбаатар гишүүн тодруулж асууя нэмэлт асуулт.

Б.Батбаатар: Ерөнхий сайд ЗГ өмнө нь өгсөн амлалтаасаа ухарч байгаа, буцаж байгаа гэдгээ дөнгөж сая хариултаараа хэлчихлээ. 1,6 их наяд юм байна шүү тэр боломжгүй, тэрнийхээ оронд ийм зүйл хийе гээд. Тэгэхээр өмнө өгсөн ЗГ-ын амлалтаасаа ухарч байгаа гэдгийгээ хариулж байна гэдэгт нь зөв, бид өөр хувилбарыг санал болгох ёстой. Тэгэхдээ энийгээ бид энэ амлалт ийм учраас хийж чадахгүй байна гэдгээ илэрхийлэх ёстой. Дээр нь төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөл энэ хэлэлцэж байхад бид энэ нүүрснийхээ үнийн дүнг хэдэн сая, түрүүн 90 сая гээд хэлчих шиг боллоо. Ямар үнээр тооцож гаргасан бэ? Энэ төсвийн хүрээний мэдэгдэл энэ хүрээ хязгаар, төсөөлөл өөрчлөгдөх тэр эрсдэлүүдээ хэр тооцож үзсэн юм бэ? Бидний гол худалдан авагч урд хөршийн худалдан авалт болоод харилцааны асуудал дээр асуудал үүсвэл энэ дээр ямар.../минут дуусав/

С.Бямбацогт: Эдийн засгийн хөгжлийн сайд Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Нүүрс, зэс гээд манай гол тооцоонд авч байгаа 2 үндсэн экспортод түүхий эд байгаа. ДНБ-ий төсвийн 3 хувиас дээш хэмжээний нөлөөтэй гэж. Үнэ дэлхийн зах зээл хандлага гайгүй байгаа. Үнэ тогтоохдоо сүүлийн 20 жилийн зах зээлийн тогтож ирсэн үнэ, мөчлөг, ирэх 3 жилийн салбарын төсөөлөл, зах зээлийн хандлага гээд олон улсын байгууллагуудын хийсэн дүгнэлт эд нарыг зэрэгцүүлж үзээд, бид энэ суурь үнүүд гарч байгаа. Түрүүн та энэ өртэй холбоотой асуудал яриад байна лээ. Монгол Улсын ЗГ өнгөрсөн хугацаанд гадаадаас авсан дотоодын бүх өр зээлээ цаг хугацаанд нь бүрэн төлж барагдуулж байгаа. Ямар нэгэн хугацаа алдсан өр төлбөр байхгүй, өрийн маргаан үүсээгүй. Энэтэй холбоотойгоор ЗГ-ын зээлжих зэрэглэл өндөр түвшинд үнэлэгдэж байгааг.../минут дуусав/

С.Бямбацогт: Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуултаа асууя.

Г.Лувсанжамц: Төлөвлөж чадахгүй бол хэрэгжүүлж чадахгүй. Хагас жилийн өмнө бид 5 жилийн үндсэн чиглэлийг баталсан. Өнөөдөр хэлэлцэж байгаа төсвийн хүрээн дээр нийт 9 макро эдийн засгийн тоог бид батална. Энэний 5 нь 5 жилийн үндсэн чиглэл дээр байгаа. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгална 6,3 хувь дээр барина гэсэн боловч төсвийн хүрээн дээр 5,8 хувь, инфляцыг 6 хувьд барина гэсэн боловч 7 хувь, төсвийн алдагдлыг 30 хувь болгож бууруулна гэсэн боловч 31,9 хувь, төсвийн урсгал зардлыг бууруулна 23 хувь гэж зорилго тавьсан ч 28,4 хувь болгоод нэмээд ороод ирсэн. 5-д нь ЗГ-ын өрийг бууруулна 45 хувьд барина гэсэн боловч 50 хувь дээр бууруулна гээд хагас жилийн өмнө баталсан 5 жилийн үндсэн чиглэл дээрх зорилго, зорилтуудыгаа өөрчлөөд ороод ирж байна. Өндөр зорилго тавьж болно. Гэхдээ тэр зорилгодоо хүрэхийн төлөө хичээдэг болохоос зорилгоо ухраадаггүй. Яагаад энэ 5 тоонуудыг багасгаад ороод ирэв гэсэн эхний асуултыг Эдийн засгийн хөгжлийн яамнаас асууя.

2 дугаарт ЗГХЭГ-аас асууя. Сүүлийн жилүүдэд урсгал зардал тасралтгүй өсөөд 24 их наяд төгрөгт хүрсэн. Мэдээж хүүхдийн мөнгө, багш, эмч нарын цалинг нэмэгдүүлсэн, тэтгэврийг нэмэгдүүлсэн гэсэн зүйлүүд зөв сайн. Гэхдээ төсвийн бодлогын орон зай муудаад, төсвөө хумих боломж бага багаар жил ирэх тусам байхгүй болоод байгаа юм. Энэ урсгал зардлын өсөлтийг хязгаарлах, төрийн албаны чиг үүргийн давхардлыг арилгаж, цомхон, бүтээмжтэй төртэй болно гэж олон жил ярьж байна. Сүүлийн жил хагасын хугацаанд олон ч удаа сонсож байна. 100 ямаанд 60 ухна гэгчээр 3,5 сая хүн амд 16 яам, 20 сайд бол хэрэг байхгүй. Учрал Ерөнхий сайдын ЗГ бол дэд сайдын тоог цөөлсөн. Гэхдээ чиг үүргийн шинжилгээг

хийж байгаа, удахгүй цомхотгоно гэсэн ажлуудыг хийсэн. Энэ ажлыг Хэрэг эрхлэх газар дээр хийж байгаа болов уу гэж бодож байна. Энэ шинжилгээний үр дүнг хэзээ танилцуулах вэ, намар өргөн барих төсвөөс өмнө гүйцэтгэх засаглалыг цомхон болгож чадах юм уу, үгүй юм уу?

2 дахь асуулт. Төрийн албан хаагчид энд маш олон ажил хийж байгаа, маш олон тайлан гаргадаг, маш олон төлөвлөгөө хийдэг, ачаалал нь маш өндөр. Гэхдээ ЗГ-ын бодлого бүрэн хэрэгждэггүй. Энэ асуудлыг шийдэх чиглэлд бодитоор ямар ажлууд төлөвлөж байна вэ? Энэ явцыг танилцуулж өгөөч гэж хүсье.

Сангийн яамнаас асууя. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5-ыг 2 зүйл, заалтын өгүүлбэрийг нь хасаад ороод ирж байна л даа үгийг нь. Яг үлдсэн өгүүлбэрээр нь харвал ямар ч логикгүй харагдаад байна. Төсвийн хүрээгээ баталчхаад угаасаа 3 сарын дотор төсөв хэлэлцэнэ гэж байхгүй шүү дээ. Энэ яг ямар зорилгоор өөрчилж байгаа зүйл вэ? Төсвийн тогтвортой байдал бус, Төсвийн тогтворгүй байдлын тухай хууль болчих биш үү.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асууя. Proactive ажилламаар байна хэдүүлээ. ЗГ хөндөөд, хууль хөндөөд ороод ирдэг өр, урсгал зардлаа нэмэгдүүлнэ гээд ороод ирэхлээр дүгнэлт гаргадаг. Энийг би зөв гэж бодож байгаа. Гэхдээ одоо байгаа Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль дээр ямар өөрчлөлтүүдийг хийвэл бид энэ зүйл, заалтуудыг нь ЗГ-ын бодлого, төрийн бодлоготой уялдуулаад сайжруулах боломжтой байдаг юм бэ? Төсвийн байнгын хороон дээр би байдаггүй болохлоор мэдэхгүй байна. Энэ ажлыг Төсвийн байнгын хороон дээр хийдэг үү? Та бүхний зүгээс энэ хуулиа ингэж засъя, тэгвэл эдийн засагт үр ашигтай юм байна. Гэхдээ төсвийн бодлого зөв явна гэсэн proactive хандлага, үйл ажиллагаанууд хийж байна уу?

С.Бямбацогт: Баттөмөрийн Энхбаяр сайд эхлээд, дараад нь Сангийн сайд бэлдэж байгаарай, хариулъя.

Б.Энхбаяр: Баярлалаа. Тэгэхээр оношоо зөв тодорхойлж байж бодлого зөв гарна гэдэг Лувсанжамц гишүүний асуулттай санал нэг байна. Төрийн захиргааны энэ төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудад давхардал, орон тоо, бүтэц, чиг үүргийн давхардлын дүн шинжилгээ өмнө нь ч хийгдэж байсан, одоо ч хийгдэж байгаа. Сүүлийн 2 удаагийн ЗГ-ын хуралдаанаар яам, агентлагуудын түвшинд хийгдсэн дүн шинжилгээний дүнг танилцуулсан байгаа ЗГ-т. Энэтэй холбоотойгоор энэ дүн шинжилгээ хийдэг аргачлалд асуудал байна гэж аргачлалдаа сая өнгөрсөн ЗГ-ын хуралдаанаар өөрчлөлт оруулсан байгаа. УИХ төсөв хэлэлцэх үед энэ талаарх мэдээллүүдийг хүргүүлнэ. Бүх түвшинд ямар ч байсан орон тоонуудыг багасгах ажил яамнууд дээр нэг их том хэмнэлт гарахгүй, 100 хүрэхгүй орон тоотой, яг урсгал зардлын хувьд тэнд нэг их тийм орон тооны хэмнэлт гарахгүй. Таны хэлж байгаа дэд сайдуудын зардал тэгэхэд 1 тэрбум төгрөг хүрдэггүй.

Гэтэл Монголбанкн дээр жишээлбэл 150 орон тоог хэмнэхэд 15 тэрбумын хэмнэлт гаргалаа гээд өчигдөр Ерөнхийлөгч нь яриад сууж байгаа. Төрийн өмчийн компаниуд дээр бүх түвшинд хяналт шалгалт, тооцоо үнэлгээнүүдийг хийж байгаа. Сая уржигдрын 3 дахь өдрийн ЗГ-ын хуралдаан дээр төрийн өмчийн энэ байгууллагуудын түрээсийн асуудлыг шалгаж танилцуулсан. 2023-аас 2025 оны хугацаанд энд олон ажлын алба, үндэсний зөвлөл, хороод гэсэн ЗГ-ын үндсэн чиг үүрэгтэй давхардсан маш том бүтцүүдийг бий болгоод, хотын төвийн талбай

тойрсон маш өндөр зэрэглэлийн хувийн оффисуудыг түрээсэлсэн байдалд шалгалт хийсэн. Монгол Улсын хэмжээнд сүүлийн 3 жилийн байдлаар төрийн байгууллагуудын эзэмшлийн түрээсийн орлого 10 тэрбум төгрөгийн орлого олсон байгаа төрийн байгууллагууд. Тэгвэл хэдэн төгрөгийн байрууд түрээсэлж, төсвөөс гаргаж байна вэ гэдгийг төрийн өмчийн компаниудыг оруулж тооцож үзэхэд 55 тэрбумын түрээс, ашиглалтын зардлыг төсвөөс гаргаж байна. 5 тэрбумын орлого олоод 55 тэрбумын зардал гаргасан гэсэн үг.

Өөрөөр хэлбэл энэ төрийн гүйцэтгэх эрх мэдлийн өмчийн ашиглалттай холбоотой асуудал маш их хяналтгүй, дур зоргоороо ингэж явж иржээ. Энэ түрээстэй холбоотой журмыг цэгцлэх гэж байна, үнэ ханшийн хувьд маш харилцан зөрөөтэй. Төр өөрийнхөө өмчийг болохоор маш хямдаар түрээсэлдэг, өөрсдөө болохоор энэ хотын зэрэглэлийн хамгийн дээд тал нь метр квадрат нь 200 мянган төгрөгөөр түрээсэлж байна. Тийм учраас.../минут дуусав/

С.Бямбацогт: Мэндсайхан сайд, Загджавын Мэндсайхан сайд хариулъя Сангийн сайд.

З.Мэндсайхан: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын хуулийн 7.5-ыг өөрчлөх санал оруулж ирсэн байна гээд. Тэгэхээр энэ заалт маань юу вэ гэхээр зэрэг энэ төсвийн тогтвортой байдлын дунд, төсвийн хүрээний дунд хугацааны хүрээгээ баталснаас хойшоо бид 3 сарын дотор төсвийн ямар нэгэн тодотгол хийж болохгүй буюу тухайн харгалзах жилийн төсөвт тодотгол хийж болохгүй гэж байгаа юм. Тэгэхээр хүрээгээ баталлаа, бид 26 оныхоо төсөвт тодотгол хийхгүй гэсэн ийм л нөхцөл байдал үүсэж байгаа юм. Ер нь тодотгол ямар учиртай гэхээр одоо бид дэлхий нийтээрээ л энэ геополитикийн ойлгомжгүй байдалд тааварлашгүй ийм эдийн засгийн нөхцөл байдалд байж байна. Энэнээс үүдээд бид тодотгол хийх нөхцөл байдал үүсэж болно. Энэ хууль чинь өөрөө 6 сарын 1-ний дотор, төсвийн хүрээ маань батлагдах ёстой хуулиараа. Ингээд харвал бид 8 сар хүртэл төсвийн ямар нэгэн тодотгол хийхгүйгээр явна гэсэн үг. 9 сард бид төсвийн тухай.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя, Мэндсайхан сайд.

З.Мэндсайхан: 9 сард бид Төсвийн хуулиа өргөн барина 28 оны, 27 оны. Тэгэхээр энэ чинь хэрэв бид эдийн засгийн хувьд нөхцөл байдал хүндрээд, тодотгол хийх шаардлага үүслээ гэхэд тэр тодотгол дээр суурилж байж бид цаашдаа төлөвлөлтөө хийх ёстой. Тэгэхээр энэ боломжийг хуулиар хаагаад байгаа юм. Тэгэхээр энэ заалт дээр бид уян хатан хандахгүй бол дэлхийн эдийн засгийн чинь өөрчлөгдөж байгаа нөхцөл байдал өөрөө бидний хувьд, хурд, хурдын хувьд бид тэрэнтэй сөрөг сөрсөн эдийн засгийн арга хэмжээнүүд авахад энэ хуулийн заалтаараа бид боломжгүй болж байна гэж та ойлгож болно.

С.Бямбацогт: Эдийн засаг, хөгжлийн сайд Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Төсвийн хүрээ 9 тоо, макро эдийн засаг 9 тоо баталдгаас 5 нь Таван жилийн үндсэн чиглэлд байна. Энэ тоонууд яагаад үндсэн чиглэлээс өөрчлөгдөв гэсэн асуулт байна. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө бол хуулиараа 5 жилийг үндэслэж хийгдэж байгаа. 5 жилийн хугацаанд хийгдэж байгаа. Тэгээд төсвийн хүрээний мэдэгдэл бол дараа жилийнхээ төсвийн орлого, зарлагын тоог тодорхойлж байгаа тул өнөөдөр тохиолдоод байгаа энэ олон эрсдэлийн нөлөөллийг

нарийвчлан тусгасан. Иймээс 5 жилийн төлөвлөгөө дээр туссан тоон зарим зорилтуудаас зарим үзүүлэлтүүд нь бага гарч байгаа. Тухайлбал эдийн засгийн өсөлтийг бид 27 онд 5,8 хувь гэж зорьсон одоо оруулж ирж байгаа. Таван жилийн зорилт 6,3 хувь байгаа. Тэгээд энэ 5 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь том зорилт хэвээрээ байгаа, энэ 5 жил нэгдэж дүгнэгдэнэ. Төсвийн хүрээ бол энэ төсвийн орлогын доод.../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултыг нь, хариултаа дуусгачихъя. 5 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бол том зорилт хэвээрээ. Төсвийн хүрээний мэдэгдэл бол энэ төсвийн орлогын доод хэмжээг тооцоход ашигласан ийм хуульчлагдсан тоо. Өөрөөр хэлбэл төсвийн хүрээний мэдэгдэл дээр эрсдэлүүдийн нөлөөг тухайлан ингэж оруулж явж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Индрийн 3 дугаар микрофон.

Ж.Дэлгэрсайхан: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлтүүдээрээ дамжуулан хуультай холбоотойгоор холбоотой бүх саналуудаа байнга өгч байгаа. Жишээ нь бид төсвийн хүрээний мэдэгдлийн талаарх төсвийн төсөв дээр тооцож байгаа тэнцвэржүүлсэн үнийг тооцох талаар болон тусгай шаардлагын талаар бид ингээд 24 оныхоо ухралт руу, хийсэн өөрчлөлтийг буцаах гэх мэтийн. Жишээ нь саяын дүгнэлт дээр бид энэ өмнөх хуулийн өөрчлөлт төсвийн тусгай шаардлагуудыг болон энэ бусад хууль дээрээ өгсөн дүгнэлтүүдээ хэвээр байсаар байна гээд дүгнэлтээ бол байнга өгч байна.

Төсвийн тогтвортой байдлын хууль, төсвийн эрх зүйн орчинтой холбоотой байр сууриудаа бид илэрхийлж байна. Илэрхийлээд УИХ-д хүргүүлэх, гишүүдэд хүргүүлэх, сайт дээр байршуулах замаар байна. 3 дахь хэлбэр нь ажлын хэсэг болон бидэнд ирүүлсэн тохиолдолд санал өгөх хэлбэрээр ажиллаж байна. Цаашид илүү санаачилгатай ажиллах тийм хувилбаруудыг бодох талаараа хэлье.

С.Бямбацогт: Лувсанжамц гишүүн тодруулж асууя.

Г.Лувсанжамц: Тодорхой хариулсанд баярлалаа. 16 яам ихдээд байгаа, 10 орчим яам байхад хангалттай болов уу гэж боддог. Тэгэхлээр намар төсөв өргөн барихдаа энэ танилцуулгыг хийнэ гэсэн Энхбаяр сайдын танилцуулгыг хүлээж байя. Сангийн яамны тодорхойлолтуудыг ойлголоо. Гэхдээ одоо өөрчлөөд 7.5-аараа үлдэхлээр логикгүй болчихоод байгаа учраас бараг тэр чигт нь хассан нь зүйтэй заалт болчих юм болов уу гэж миний хувьд харагдаж байгаа юм. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд баярлалаа. Нөгөө санаачилгатай байвал хэдүүлээ урьдчилж асуудлуудыг шийдэж чадна гэдэг зүйл дээр дэмжээд ажиллахад бэлэн байгаа шүү. Тийм. Эдийн засаг, хөгжлийн яамны сайд нийгэм, эдийн засагтаа тааруулаад өөрчилж байгаа гэж байгаа. Гэхдээ миний хувьд тавьсан зорилгоосоо ухрахыг дэмжихгүй байгаа учраас энэ 5 тоог буцаагаад Таван жилийн үндсэн чиглэл дээрх зорьсон зорилго дээр нь буцааж аваачихаар зарчмын зөрүүтэй санал гаргахаар бэлдэж байгаа.

С.Бямбацогт: Үг хэллээ. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын Эрдмийн хөтөч сургуулийн 11Г, 12А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сурагч

хүүхдүүддээ энэ өдрийн мэнд хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Удахгүй сургуулиа төгсөөд, хүссэн мэргэжлээрээ, хүссэн сургуульдаа элсэн орж, сайн мэдлэг боловсрол эзэмшин эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулсан, хариуцлагатай, хуулиа дээдэлдэг сайн иргэн болоорой та бүхэн маань. Аав ээжийнхээ үгэнд сайн ороорой, багш нарынхаа үгэнд сайн ороорой. Амжилт хүсье. Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Их Хурлын даргаа уг нь Ерөнхий сайд байвал сайн байна. Тэгээд энэ ЗГ-ын гишүүд чинь энд 7, 8 сайд л байна, бусад нь алга. Тэгээд бид нэг ийм хий хоосон юм руу хашхирах гээд байх юм. Бусдыг нь дуудаад ирүүлээд суулгаад, та энэ нөгөө хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийнхэнд байнга дэг сануулаад байгаа юм. Сайд нартаа яагаад дэг сануулахгүй.../үг тасрав/

С.Бямбацогт: ЗГ-ын гишүүдийг танхимд урьж байна, Ерөнхий сайдыг танхимд урьж байна.

Да.Цогтбаатар: Би тэр үед нь асуултаа асууя.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүний асуултыг түр хойшлуулъя. Түр гарсан, орж гарах, бие засах, бас нэг орж гарах хэрэгцээ байгаа байх, тэр шаардлагаар гарсан байх гэж ойлгож байна. Гишүүд, Ерөнхий сайдыг танхимдаа урьж байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя.

О.Номинчимэг: Баярлалаа. Төсвийн хүрээний мэдэгдэлтэй танилцлаа. Тэгээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гарсан зөвлөмжийг ч гэсэн харсан. Тэгэхээр ЗГ-аас орж ирж байгаа энэ өргөн барьсан төсвийн хүрээний мэдэгдэл маань бүх төсөөллүүд нь маш өөдрөг байгаа, эдийн засгийн өсөлтийн хувьд ч гэсэн маш өөдрөг, ДНБ, инфляцын хувьд ч гэсэн бага байна гэсэн маш өөдрөг төсөөлөлтэй байгаа. Тэгээд яах вэ өөдрөг байж болно л доо, өөдрөг байх амьдралд хэрэгтэй байх. Гэхдээ төсвийн хүрээний мэдэгдэл бол нөгөө өөдрөг байх амьдралын юу биш, бид энд хариуцлагатай, зөв төлөвлөдөг, зөв урьдчилан дүн шинжилгээ хийж төлөвлөдөг, тэрнийхээ дагуу явдаг байх, сахилга баттай байх ёстой юм байгаа юм.

Бид өмнө нь ч гэсэн 2025 онд 27 оныг яаж төсөөлж байсан байна, одоо яачхаад байна гэдгийг нь ингээд харахаар та бүхэн маань түрүү жил ДНБ-ий бодит өсөлт нь 6,5 хувь байна гээд төсөөлж байсан байна. Тэгтэл одоо бол үгүй ээ яах вэ 5,8 хувь байх нь гээд төсөөлөөд ирсэн байна. Тэгтэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 5,5-аас 5,6 байх нь гээд. Инфляц ч гэсэн бас тийм. Өмнө жил та бүхэн бас маш л өөдрөг төсөөлж байсан байна. Тэгэхээр ЗГ яах вэ өөдрөг төсөөлж байгаа ямар учир шалтгаан байна гэж үзэж байгааг би асуумаар байна л даа. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал ийм байна, тийм байна гэдэг энэ танилцуулгад дүн шинжилгээ зөндөө л байна. Тэгээд энэ өөрөө энэ нөхцөл байдал чинь өөдрөг төсөөлөл байх үндэслэл болж 1 дүгээрт чадаж байгаа юм уу?

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ч гэсэн дүн шинжилгээ хийхдээ эдийн засгийн өсөлтийн ихэнх нь мал аж ахуй /МАН/-н салбар байна. Гэхдээ энэ бол 2027 онд үргэлжлэхээргүй байна шүү. Ялангуяа үйлчилгээний салбарууд чинь ерөөсөө уналтад орчихсон байна гэдэг дүгнэлтийг хийж байгаа. Тэгээд ингээд харвал үнэхээр л яг иргэдийн эсвэл жижиг, дунд үйлдвэрлэл /ЖДҮ/-лэл хамгийн их байдаг энэ үйл ажиллагаанууд сервис буюу үйлчилгээний үйл ажиллагаануудын

өсөлт маш бага байна. Энд яах вэ ЗГ-ын тэргүүн Учрал сайдын хийж байгаа Чөлөөлье санаачилга буюу бизнесийн орчныг илүү чөлөөлж, идэвхжүүлэх гэсэн энэ бол үр дүнгээ өгөх байх л даа. Тэгээд 1 дүгээрт энэ өөдрөг төсөөллийн чинь үндэслэл нь юу юм бэ л гэж асуугаад байгаа юм, юунаас энийгээ гарч ирнэ гэж бодож байгаа юм бэ? Дэлхийн нөхцөл байдал ийм байгаа үед, инфляцын чинь ч гэсэн төсөөлөл ийм өөдрөг байгаа.

2 дугаарт дагасан хууль дээр та бүхэн нөгөө НӨАТ-ын тухай хуулийг хүчингүй болгохоор орж ирсэн. Тэгээд энэ НӨАТ-ын тухай хуулийг түрүү жил төсөв дээрээ дагуулж орж ирээд яах вэ ингээд гарсан, төсөвт дарамт болно гэдэг нь ойлгож байгаа. Гэхдээ энэний араас та бүхэн иргэдэд бол бид хүлээлт үүсгэсэн байгаа. Үнэхээр амьжиргаа хэцүү байгаа, иргэдийгээ бид дэмжих татварын бодлого хэрэгтэй байгаа. 50 хувь адилхан бүгдийг нь байна гэхээсээ илүү, өмнө нь ЗГ-ын түвшинд боловсруулж байсан, Сангийн яам маань оролцож байсан, УИХ дээр ч гэсэн Хассуурийн Ганхуяг тэргүүтэй ажлын хэсэг, би ч гэсэн орж ажиллаж байсан НӨАТ-ын хууль байгаад байгаа. Яг анхан шатны хэрэглээний 600 байна уу, 800000-ын хэрэглээ болон өрхийн гишүүн болгоноор нь энийг нь НӨАТ-аас нь 100 хувь чөлөөлчихье, энэнээс цаадхыг нь үе шаттай байя гэдэг ийм шаталсан. Энэ бол яг өрхийн амьжиргаа буюу яг энэ хэрэгцээтэй байгаа амьдрал ахуйг нь дэмжих энэ бодлогод нийцэж байгаа гэж бодож байгаа байхгүй юу. Шаталсан хэлбэрээр наад захын хүнсээ авах энэ асуудалд нь НӨАТ-аас нь бүрэн чөлөөлье гэдэг. Тэгэхээр энэ бодлого та бүхний дараа дараагийн төсөв байдаг юм уу, бодлогод орж ирэх үү, эсвэл ингээд л НӨАТ-ын 50 хувийн буцаалтаа хүчингүй болгоод дуусчих уу гэдэг дээр асуумаар байна. Ийм 2 асуулт байна.

С.Бямбацогт: Ерөнхий сайд эхлээд хариулъя, дараад нь Эдийн засаг, хөгжлийн сайд бэлдэж байгаарай.

Н.Учрал: Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль хэрэгжиж эхэлбэл 1,6 их наядын орлого тасарна. Гэхдээ яг түрүүн би хэлсэн тэр потенциал түвшин, өнөөдрийн нөхцөл байдал, тэр output гар чинь өөрөө сөрөг байгаа ийм үед бид авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ зөв томъёолох хэрэгтэй. Би НӨАТ-ын буцаалт яг энэ цаг үед нэн тэргүүний асуудал гэж бодохгүй байгаа. ЗГ-ын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт ч тусаагүй асуудал. Манай ЗГ яг энэ мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэхийн тулд энэ цаг үед ажлын байрыг хадгалах тал руугаа илүү анхаарах учраас Татварын ерөнхий хууль болон бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах төслөө өргөн барьсан. Үүний үр дүнд ажлын байруудыг хадгална.

Инфляц тэгж их өөдрөг төсөөлөөгүй. Энэ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, нэг их тийм өөдрөг бол биш. Яах вэ, экспорт сайн байна, гэхдээ импорт төдийлөн сайн байхгүй байна. Тийм учраас инфляц өсөх гол эрсдэл өөрөө нийлүүлэлтээс шалтгаалж байгаа юм. Нийлүүлэлтийн гаралтай инфляц. Эрэлтийн гаралтай инфляц дээр эрсдэл харьцангуй бага. Нийлүүлэлтийн гаралтай бол инфляц өөрөө маш их эрсдэл дагуулж байгаа. Энэ юу вэ гэхээр нөгөө шатахууны үнийн өсөлт. Харин ч сая ЗГ хэд хэдэн хэлэлцээрүүдийг хийж, энэ шатахууны үнийн өсөлтийг тогтворжуулсан. Дээрээс нь шатахууны нөөц бүрдүүлэх чиглэлээр ОХУ-тай хэлцэл хийж, энэ эрсдэлийг амжилттай давлаа.

2 дугаарт гадаад валютын нөөцийг өсгөсөн байгаа энэ 7,3 тэрбум долларыг цаашдаа тогтвортой хадгалж чадсанаар валютын ханшны үнийн өсөлтөөс шалтгаалан инфляц нэмэгдэх эрсдэлийг бууруулна гэж тооцож байгаа.

Нийлүүлэлтийн гаралтай инфляц дээр хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг дэмжих зайлшгүй шаардлага бол байгаа юм хүнсний бүтээгдэхүүний. Та хэлж байна хүнсний бүтээгдэхүүн дээр ялангуяа өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнүүдийн үнэ өсөж байгаа. Тийм учраас энэ ХАА, хүнсний салбар дээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ажиллаж байгаа. Худалдааны эргэлтийг сайжруулах чиглэлээр анхаарч, энэ чөлөөт худалдааны хэлэлцээрүүдээ амилуулах чигээр дэд бүтцүүдийнхээ бүтээн байгуулалтуудыг эхэлж байна. Өмнө нь зөвхөн экспорт талдаа анхаардаг байсан бол импортод нь аль алинд нь анхаарахын тулд хил, гааль, тээвэр логистикийн асуудал дахиж гаргахгүй байх дээр анхаарч ажиллана.

Тийм учраас инфляц тийм өөдрөг төсөөлөлтэй бол биш. Сая энэ тариалалттай холбоотойгоор шатахууны асуудлыг шийдвэрлэсэн. Тэгэхээр энэ бодитой ажил болж байна. Тэр хүнсний салбарт хэрэгжиж байгаа хөтөлбөрүүд үргэлжилнэ. Ингээд төсвийн мэдээж урсгал зардлыг хэмнэх шаардлага дахин үүснэ.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Эдийн засгийг их өөдрөг тооцсон байна гэж. Өөдрөг байгаа. 27 онд 5,8 хувьд, ер нь дунд хугацаанд 6 хувийн эдийн засгийн өсөлтийг Монгол Улс хадгалахаар байна. Нөгөө нүүрсний олборлолтууд нэмэгдэж байна, гол нь нүүрсний олборлолт маань, нүүрсний чанартай, боловсруулсан нүүрсний экспортууд нэмэгдэж байна. Хил дамнасан дэд бүтцийн ажлууд хийгдэж, холболтууд үндсэндээ дуусаж, ашиглалтад орж эхэлнэ. ОТ-н зэсийн баяжмал дахь зэсийн, цэвэр зэсийн агуулгууд нэмэгдэнэ. Төмрийн хүдэр олборлолт нэмэгдэнэ, зэс болон төмрийн хүдрийн үнийн төлөв байдал өөдрөг байна. Мөн ган, зэс цэвэршүүлэх, нүүрс, пиролиз боловсруулах үйлдвэрүүд, ураны олборлолт, экспорт эхэлнэ. Хүнсний хувьсгал, Атрын 4, Цагаан алт хөтөлбөрүүд хийгдсэн, одоо үр дүнгүүд хадгалагдахаар байна. Эд нарыгаа дэмжсэн Евразийн эдийн засгийн холбоотой шинэ зах зээлийг нээх, идэвхжүүлэх ажлууд хийгдэж байна. Ингээд хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалт, хил.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Хүнд үйлдвэрүүд, энэ хил холболтын, төмөр замын гээд энэ олон ажлууд эцэслэн дуусах ер нь дөхөж байна. Эрчим хүчний салбарт Баян болон Бөөрөлжүүтийн, Сэлэнгийн гээд төслүүд, ТЭЦ 5, Тавантолгойн цахилгаан станц гээд олон төслүүд хэсэгчлэн ашиглалтад орох ажил эхлэх ийм том хүлээлттэй байна. Гадаадын хөрөнгө оруулалтаар санал болгож байгаа томоохон төсөл, хөтөлбөрийн саналууд нэлээн тодорхой байж байна. Ганц энэ эдийн засгийн өсөлтийг бид өөрсдөө тооцохоос гадна олон улс яаж тооцож байгааг байнга хардаг. ОУВС бол 2027 онд 5,3 хувьтай, Дэлхийн банк бол 5,5 хувьтай, Азийн хөгжлийн банк /АХБ/ 6 хувь орчмоор тооцсон. Манай тооцоолол 5,8 хувь байна. Тэгэхээр энэ томоохон төсөл, хөтөлбөрүүд эхэлсэн хөтөлбөрүүд үргэлжилнэ, бүтээн байгуулалтууд явна. Энэнтэй холбоотойгоор ажиллуулж, өсөлт хангагдах бүрэн бололцоотой гэдгээ хэлэхийг хүсэж байна.

С.Бямбацогт: Номинчимэг гишүүн тодруулж асууя.

О.Номинчимэг: Яах вэ ингээд энэ юун дээр олон улсын байгууллагууд ч гэсэн энийг яаж төсөөлж байна, та бүхэн маань ч гэсэн яаж төсөөлж байна гээд тоон мэдээлэл байгаа. Тэгээд энэ дээр л хамгийн өөдрөг нь манай ЗГ-ын төсөөлөл

байгаа. ЗГ, юу Тогтвортой байдлын зөвлөлөөс ч илүү өөдрөг төсөөлөлтэй байгаа л гэдгийг хэлмээр байна. Дараа жил мэдээж тоо нь гараад, гүйцэтгэл нь гараад ирэхээр бид энэ үнэн бодитой байсан уу гэдэг дээр үнэлэлт дүгнэлт хийнэ гэж бодож байна. Яах вэ ингээд харахаар бүгдээрээ л бид ярьж байгаа. Ер нь орлогын эх үүсвэрээ Энхбаяр сайд илүү уул уурхайн салбарын экспорт дээр тулгуурласан өсөлт нь энд өндөр байна гэдгийг төсөөлж байгаа юм байна. Тэгтэл макро эдийн засгийн хувьд ер нь эрсдэлтэй байгаа гэдгээ хэн хэн нь хүлээн зөвшөөрч байгаа энэ үед зарлага маань нэмэгдэж орж ирж байгаа. Зарлага маань нэмэгдэж, энэ маань зөвлөлөөс ч гэсэн илүү байна, өндөр байх ёстой гэдгээр 591 тэрбумын зөрөөтэй тоо гарч ирж байгаа юм. Тэгэхээр энэ макро эдийн засгийн эрсдэлтэй үед зарлагыг нэмэгдүүлэх.../минут дуусав/

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулья.

Ж.Энхбаяр: Урсгал зардал нэмэгдэж байгаа. Эдийн засгийн идэвхжил, ялангуяа эдийн засгийн 47 хувийг бүрдүүлж байгаа худалдаа, үйлчилгээ, ЖДҮ-ийн салбарт идэвхжил сул байгаа. Эндээс төсвийг алдагдалтай батлах, зарцуулалтаар нь дамжуулж нийт эрэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгаа дэмжих ийм мөчлөгийг сөрөх бодлого хэрэгжиж байна гэсэн үг. Эсрэгээрээ эдийн засаг идэвхтэй сайн байх үед төсвийг ашигтай батлаад, бид хуримтлал үүсгэдэг, эдийн засаг халахаас урьдчилан сэргийлж, тогтворжуулдаг. Тэгэхээр 27 оны төсвийн хүрээн дээр би төслийг 1,7 их наяд төгрөг буюу 1,5 хувийн алдагдалтайгаар төсөөллийг оруулж ирж байна. Энэ маань өөрөө бидний энэ 2027 оны 5,8 хувийн өсөлтийг хадгалах зорилгод нийцэж байгаа. Энэ төсвийн өөр юу байлаа, НӨАТ-тай холбоотой, НӨАТ-ын буцаалттай холбоотой асуудал хөндсөн. Энийг Их Хуралд бас улс төрийн шийдэл гаргахаар оруулж ирж байгаа.

С.Бямбацогт: Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын ЗГ бүтэц дотроо юу болж байгааг бараг мэдэхээргүй хэмжээнд данхайчихсан, тэр нь тэр чигтээ урсгал зардлаа хүртэл бууруулж чадахгүй байгаа зовлон энэ төсвийн хүрээний мэдэгдлээр дамжиж наашаа орж ирж байна гэж би харж байгаа юм. Төсвийн зардал чинь өсөөд байна, урсгал зардал чинь бас нэмж өсөөд байна. Ерөнхий сайд Учрал Их Хурлын дарга байхдаа бас л ЗГ-ыг яг энэ чиглэлд урсгал зардлаа бууруул, орон тоогоо тана, хэмнэ, хас гээд л явуулсан. Одоо тэнчээ очоод суучихсан, ямар ч өөрчлөлт гараагүй Төсвийн хүрээний мэдэгдэл. Бүүр эсрэгээрээ яривал энэчээнээс таныг Улсын Их Хурлын дарга байхад төсвийн байгууллагуудын орон тоог 9 хувиар хассан хасалтын үр дүн чинь яагаад энэ төсвийн төсөөлөл дээр чинь орж ирэхгүй байгаа юм бэ гэдэг хамгийн эхний асуулт?

2016 оноос хойш МАН-ын улаан намын Цагаан байрны хэдэн гишүүд маш их тансаглаж, Монгол Улсын энэ татвараар цуглаж байгаа баялгийг үрэх чиглэлд ажиллаж үзүүлсэн. Гэтэл дөнгөж сая 1 хууль батлагдаагүйн төлөө зовлонг нь Ардчилсан нам /АН/-ынхнаас нэхээд байх юм. Бид яасан юм бэ, бид хуралдаа ороод, ажлаа хийгээд сууж байна шүү дээ. Та нарын бодлогын алдааны чинь зөвхөн нэг илрэл нь мөсөн уулын орой нь энэ, энэчээ ингэж л харагдаж байгаа юм. Энийг тэр цагаан намын, цагаан байран дотроо очиж яривал уг нь дээр байх.

Тэгээд ер нь шийдэл гэж яриад байгаа юм. Уг нь жишээлэхэд Хөгжлийн банк, Төрийн банк гээд банкнуудтай. Хөгжлийн банкны зорилго бол импортыг орлох,

экспортыг дэмжих чиглэлд хуулиар олгогдсон ийм эрх, үүрэгтэй банк. Гэтэл яагаад газрын тос боловсруулах үйлдвэрийг тэр банк руугаа явуулахгүй байгаа юм бэ, Эрдэнэбүрэний УЦС-ыг яагаад тэр банк руугаа явуулахгүй байгаа юм бэ? Тэгээд тэр Хөгжлийн банк, Төрийн банкны захирлуудыг яагаад энэ чиглэлд нь шийдэл гаргаад, тэр хуулийн төслийг нь боловсруулаад ир гэж шахахгүй байгаа юм бэ? Энэ чиглэл рүүгээ ажиллуулмаар байна гэдгийг хэлье.

1,7 их наядын алдагдал гэдэг бол дахиад том алдагдал. Тэгээд нөгөө мөчлөг сөрсөн төсвийн бодлого гэж яриад 2 жил болж байна. Хаана байгаа юм бэ, ерөөсөө харагдахгүй байна гэдгийг чинь нэг асуух гэсэн юм?

Дээрээс нь Монгол Улс халамжид живсэн Монгол болчихсон. 4,8 их наядыг үрж байгаа Халамжийн сайд Аубакир сайд хэдэн хүнийг халамжаас гаргав, хэдэн хүнийг бизнес эрхэлдэг болгов, хэдэн хүнийг ажил хийдэг болгов? Яавал бид тэтгэвэр авч байгаа ахмадын тэтгэврийг 1,5 сая төгрөгийн доод хэмжээтэй болгоод, бусад халамж, тэтгэврийг бууруулах чиглэлд бодлого гаргадаг болох юм бэ? Яагаад та ажил хийхгүй, энэ чиглэлд нь ингээд таг дуугүй 2 жил суучхаж байгаа юм бэ? Өгсөн мөнгийг л үрж байна, өөр танаас халамжийг ингэж багасгах ийм гарц шийдэл байна гэж ажиллахгүй байгаа юм бэ гэдгийг асуух гэсэн юм. Ер нь энэ торгууль бичдэг нэг өвөөгийн ажил л маш сайн явж байна. Бусад бүх ажлууд, бусад бүх бизнесийнхэн, бусад бүх хувийн хэвшлийнхэн хүндрэлтэй байгаагаа л шогшроод яриад байна шүү дээ. Тэгээд ЗГ яагаад энэ чиглэлд ажиллахгүй байгаа юм бэ?

Махны үнэ нэмэгдлээ гээд хоолны газрууд хаалгаа барьж байна. Энэ чиглэл рүү гарч байгаа бодлого гэж бидэнд байна уу? Энийг л бид яримаар байна нэг талаасаа.

Нөгөө талаасаа 90 их наядын хөрөнгөтэй төрийн өмчит ААН-үүд Монгол Улсад ямар үр ашиг хүртээж байгаа юм бэ? Эрдэнэтийг хасчихъя, Тавантолгойг хасчихъя. Бусад нь яасан юм бэ? Эрдэнэс Монгол жишээлэхэд баахан дарга нарыг суулгаж байгаад л тансаглал тэнчээ маш ихээр явж байгаа юм. Тэнчээ тансаглал буурчихвал энэ төсөв рүү чинь орж ирж байгаа энэ орлого, үр дүнгүүд сайжирмаар байна гэх мэтчилнээр ЗГ бүтэц дотроо орлого, зарлага юу болж, яаж ямбалж байгаа, яаж тансаглаж байгааг харахгүйгээр зөвхөн татвар төлөгч иргэдийнхээ, бизнес эрхлэгчдийнхээ нурууг нь авна, дахиад алдагдал үйлдвэрлэнэ гэдэг ийм төсвийн хүрээг.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд. Зочин танилцуулчихъя эхлээд. Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд Ням-Осорын Учралын урилгаар Гэмтэл согог судлалын үндэсний төв, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн сувилагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Сувилагчдаа төлөөлж Төрийн ордонд зочилсон та бүхэндээ удахгүй болох сувилагчдын баярын мэндийг нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс өргөн дэвшүүлье. ДЭМБ-аас сувилагчийн мэргэжлийг дэлхий даяар үнэ цэнтэй, ховор ажил гэж зарласан. Эрхэм энэрэнгүй мэргэжилтэн, цагаан нөмрөгтөн баатрууд та бүхэндээ эрүүл энх, энэ хорвоогийн аз жаргал, сайн сайхан бүхнийг дахин хүсэн ерөөе. Манай танай тойргийн гишүүн Ерөнхий сайд болчихсон энд сууж байна. Ерөнхий сайд үг хэлье.

Н.Учрал: Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн манай сувилагчдын төлөөлөл Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байгаад

талархаж байна. Та бүхэнд ажлын амжилт хүсье. 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдын цалингийн нэмэгдэл тооцогдож эхэлсэн. ЗГ шийдвэр гаргасан, 5 дугаар сарын 13-нд эхний цалин бууна гэдгийг та бүхэнд хэлье. Тэгээд багш, эмч нарын цалин нэмсэн нь өөрөө Цогтбаатар гишүүн урсгал зардал өсгөж байгаа. 1, 2, 3 дугаар сард нөгөө гүйцэтгэл хангалттай биелээгүй. 4 дүгээр сард гүйцэтгэл биелсэн байхгүй юу.

Өнгөрсөн жил төсвийн хүрээний мэдэгдлийг би Эдийн засгийн сайд байхдаа боловсруулахад алдагдал 1 их наядаар оруулж ирсэн. Ингэж байж эдийн засгийн өсөлт саарахаас сэргийлсэн. Өнөөдөр АХБ эдийн засгийн өсөлтийг 6 хувь гэж үзэж байна, бид 5,8 гэж үзэж байна. Эдийн засгийн өсөлтийн энэ тоонд хүрэхийн тулд бид тодорхой алдагдал үүсгэж, гадаад зээлээр санхүүжүүлж, хувийн хэвшлийн ажлын байрыг хадгалж, ААН-үүдийгээ дэмжих бодлого л явуулах ёстой. Би энэ эдийн засгийн өсөлтийн тоонд хүрэх ёстой л гэж ингэж үзээд байгаа юм. Энэ эдийн засгийн өсөлтийн тоонд хүрэхийн тулд эдийн засгийг идэвхжүүлэх хэрэгтэй байна. Дан алдагдлаар, эсвэл нөгөө тендер зарлаад, худалдан авах ажиллагаа зохион байгуулаад биш юм байна лээ. Давхар жишээ нь бага орлоготой иргэдэд, жижиг, дунд ААН-үүдэд, том компаниудад, салбар салбарын сегментийн төлөөллүүдэд эдийн засгийг идэвхжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор жишээ нь нөгөө бага орлоготой иргэдээ дэмжих зорилгоор ХХОАТ-ыг хөдөлмөр хөлсний доод хэмжээнээс 100 хувьд хөнгөлчихье. Ингэснээрээ энд өөрөө нөгөө ажлын байр хадгалагдаад явах юм. Энэ алдагдал өөрөө бий болсноороо эдийн засгийн өсөлт энэ тоондоо хүрэх юм гэдэг зорилгоор л энэ алдагдлыг тооцсон юм шүү гэдгийг би танд хэлье.

Одоо би яг үнэнийг хэлэх ёстой. Төрийн ажил бол залгамж чанартай. Занданшатар Ерөнхий сайдын үед 2,3 их наядын хэмнэлтийг би цаг үеэ олсон зөв хэмнэлт байсан гэж үздэг. Гэхдээ 4 сарын гүйцэтгэлээр одоогийн байдлаар төсвийн алдагдал 1,4 их наяд гарчхаад байна. Бид батлахдаа алдагдал 1 их наядаар баталчихсан шүү дээ. 1,4 их наяд. Ийм үед хариу арга хэмжээ авахаас өөр арга зам байхгүй. Ингэж явахгүй бол ингээд бүгдийг нь агшаагаад явъя, тэгээд ингээд алдагдалгүй явъя гэвэл цалин хөлсөө нэмж чадахгүй, тэтгэврээ нэмж чадахгүй, давхар ААН-үүд амьгүй болно, үйл ажиллагаа явуулах бололцоогүй болно, гадаад зээл өгсөн байгаа ч хэрэглэж чадахаа болино. Тэгэхээр.../минут дуусав/

С.Бямбацогт: Аубакир сайд нэмж хариулъя.

Т.Аубакир: Тийм. Яах вэ халамжид живсэн улс боллоо гэж байх шиг байна л даа. Монголын төр ер нь дэлхийн улс орнуудын аль ч төр халамж шаардлагатай иргэддээ халамж үзүүлэх ёстой. Жишээлбэл таны хэлж байгаа зардал дотроосоо халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмж, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж, насны хишиг, 0-ээс 3 хүртэлх насны хүүхэд асаргааны тэтгэмж, өрх толгойлсон эх, эцэг, ихэр хүүхдийн тэтгэмж гээд эд нараас яг алийг нь хасах юм бэ? Хасах бүрэн эрх УИХ-д байдаг. Нийтдээ 2025 онд 2,4 их наяд төгрөгийн таны хэлээд байгаа халамжийг Монгол Улсад тараасан гэж үзээд байгаа юм.

Гэтэл халамжийн зардал дотор жишээлбэл хүүхдийн 100 мянган төгрөг явж байдаг. Энэ маань халамж юм уу жишээлбэл. Монгол Улсын Монголын төр бол хүн ам зүйн бодлогоо заавал аваад явах ёстой. Жишээлбэл 80 мянган хүүхэд төрдөг

байсан бол 50 мянга төрдөг болчихлоо. Олон хүүхдийн бодлогыг яаж дэмжих юм бэ жишээлбэл хүүхдийн мөнгөөр.../минут дуусав/

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Асуулт гэхээс илүү бараг үг хэлсэн нь дээр юм шиг байна. Ер нь бид улсын эдийн засаг удирдах хэрэгтэй байгаа, ур ухаан гаргаж, нарийн ухаан гаргаж, энийг яаж шийдлүүдийг гаргаж, уралдаж ийм урлах ёстой байгаа. Гэтэл одоогийн ингээд сүүлийн жилүүдийн энэ байдлуудыг харахад ер нь нэг нүүхийг салхи мэднэ, буухыг бут мэднэ гэдэг шиг урсгалаараа л явж харагдаж байна. Тэгээд болохгүй болохоороо бусад хуулиудаа эвддэг, нураадаг. Тэгээд төлөвлөх чадвар ерөөсөө сайжрахгүй байгаад байна. Тэгэхээр энэ нөгөө хуулиудаа өөрөө болохгүй бол хуулиудаа өөрчилдөг энэ байдал чинь угаасаа төлөвлөх шаардлагагүй болгочхож байгаа байхгүй юу. Жишээлбэл энэ би зүгээр хэд хэдэн жишээ авъя л даа. Сая энэ гадаад зээллэгтэй холбоотой хууль батлагдаагүй хуулийг жишээлбэл энэ дотор энэ өгсөн тайлан дээр байна л даа. Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн нөлөөгөөр Газрын тос, Эрдэнэбүрэнгийн УЦС барих төслүүдийг төсвөөс гаргаснаар ЗГ-ын гадаад өрийн орон зайг нэмэгдүүлэх шаардлага үүссэн тул Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ирүүлсэн таамаглалаас дээгүүр төсөөллөө гээд. Монгол Улс чинь хууль дээдлэх зарчим гэж байгаа, батлагдаагүй хуулийг жишээлбэл ингээд энэ хуулийн танилцуулга дээрээ үндэслээд асуудал оруулж ирж байна.

НӨАТ-ын албан татвар энэ буцаан олголтын тухай хууль 48 5-хан сарын өмнө баталсан, бүгдээрээ бас ЗГ-аас л оруулж ирээд баталсан. Гэтэл одоо ингээд болохгүй байна гээд тэгж байна. Тэгээд энийг яах вэ тайлбарлаж байгаа шалтгаан нь болохоор олон улсын нөхцөл байдал, геополитик гэж байна л даа. Энэ төсвийн хүрээний мэдэгдлийн танилцуулга дээр 8 тулгарч болзошгүй гадаад макро эрсдэлүүдийг дурдсан байна. Ойрх Дорнодын мөргөлдөөн, худалдааны дайн, Хятадын эдийн засаг, Орос Украины дайн гэх мэтчилэн. Тэгэхдээ яг төсөөлөл, энэ төсвийн хүрээний мэдэгдэл дотроо энийг ерөөсөө тусгасан юм байхгүй байгаад байна. Тухайлбал суурь тэнцлийг ДНБ-ий 2 хувь буюу түүнээс дээш ашигтай байхаар тооцоолол ийм дүрэмтэй. Тэгээд энэ дүрмийнхээ хүрээнд ямар ч орон зай байхгүйгээр яг 2 хувьд нь тулгаад. Тэгэхээр жишээлбэл орлого тодорхой хэмжээгээр 3 хувиас дээш буувал, зардлууд өсвөл энэ төсвийн хүрээний мэдэгдлийн шаардлагуудыг хангахгүй ийм нөхцөл байдал үүсэж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиудыг ер нь дандаа ингээд нөгөө тогтвортой байх ёстой юмнуудаа эвдэж, тэр хүрээндээ явах ёстой юмыг Төсвийн хүрээнийх нь хууль нь өөрөө өөрийнхөө хүрээг эвддэг. Тэгэхээр төсөв нь угаасаа Төсвийн тогтвортой байдлын тухай энэ, биш ээ төсвийн хүрээгээ зөрчихөөс бараг аргагүй шахуу иймэрхүү нөхцөл байдлууд байна. Энэ хуулийг дагалдуулаад 2 хууль өргөн барьж байгаагийн нэг нь энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн нэг чухал заалтыг оруулсан заалтыг энэ эвдэхээр ийм хуулийн төсөл оруулж ирж байна. Энийг уул нь ЗГ энэ заавал төсөвтэй энэ төсвийн хүрээний мэдэгдэлтэй хамт өргөн бариулах үндэслэл багатай учраас энийгээ татаад авчхаасай гэсэн иймэрхүү бодол байна.

Уул нь зүй нь төсвийн хүрээний мэдэгдлийг дагалдуулж яг энэ төсвийн хүрээтэй холбогдолтой асуудлуудаа оруулж ирмээр байгаа байхгүй юу. Тухайлбал энэ ЗГ-ын бүтэц, энэ урсгал зардлуудаа яаж багасгах вэ. Төсвийн тогтвортой

байдлын зөвлөлийн дүгнэлт дээр байна лээ шүү дээ. Энэ зардлууд чинь тасралтгүй нэмэгдээд байгаа учраас дорвитой ийм бодлогын шинжтэй өөрчлөлтүүд хийхгүй болохоор ингээд бусад юмнууд чинь эвдэгдээд байна гээд. Энэнтэй холбоотой жишээлбэл хуулийн төсөл дагалдуулж болохоор байсан. Энэ тэнцвэржүүлсэн үнийн төсөөлөл маань зах зээлийн үнээсээ их хол зөрөөтэй болчихоод байна шүү дээ. Тухайлбал нүүрсийг тэнцвэржүүлсэн үнэ 127,4 доллар гэж байхад зах зээлийн үнэ 68 доллар гэж байна. Жишээлбэл энд жишээлбэл тооцоолдог аргачлалаа өөрчилж болдоггүй юм уу гэх мэтчилний ингээд зүйл, заалтуудыг оруулж ирмээр байгаа байхгүй юу. Өөр дахиад нэмээд энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр.../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа дуусгачихъя. Ерөнхий сайд хариулчхаад, тэгээд нэмж асуух уу? Асуултаа асуучхаад, нэмж хариулах юм уу? Ерөнхий сайд.

Н.Учрал: Энхтүвшин гишүүний хэлж ярьж байгаа зарчим маш зөв. Бид 2 үзэл санааны хувьд яг нэг. Үнэхээр өнгөрсөн хугацаанд олсныхоо хэрээр үрсэн байна. Төсвийн сахилга бат, хариуцлага алдагдсан уу гэвэл алдагдсан. Тийм учраас энийг зөв болгох ёстой, төсвийн хүрээ дагалдуулаад таны хэлж байгаа бүх хуулиудыг оруулж ирэх логикийн хувьд болохгүй юм байна лээ. Төсвийн хүрээ өөрөө дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, дээд, доод хязгааруудыг л баталдаг. Энэ хязгаар дотроо төсвөө төлөвлөдөг. Тэгэхээр яагаад энэ хуулийг дагуулаад тэр 3 сарын заалтыг хөндөөд байна вэ гэхээр энэ олон улсын геополитикийн нөхцөл байдал, таны дурдаж байгаа эдгээр асуудлууд манайд шууд нөлөөлж байгаа. Та тэрийг ч мэдэж байгаа. Тэгэхээр энэ сорилтуудаас гарахын тулд бид энэ 3 сарыг хөндөхгүйгээр ирэх саруудад юу болохыг мэдэхгүй. Жишээ нь төсвийн алдагдал 1,4 их наяд болчихсон 4 дүгээр сард.

Ер нь энэ цөөхөн хэдэн бүтээгдэхүүнээс хамааралтай манай эдийн засаг, дээрээс нь экспорт хэрхэн, яаж савлахыг өнөөдөр бид мэдэхгүй, маргааш юу болохыг мэдэхгүй. Төсвийн тодотгол яагаад хийдэг вэ гэхээр шаардлага үүсэж байж хийдэг. Гэтэл аль 3 сарын өмнө баталсан төсвийн хүрээний хязгаар дотор заавал төсвөө барь, эсвэл 3 сар болж байж л тэр тодотголыг хийнэ гэдэг чинь энэ угаасаа анхнаасаа энэ хууль батлагдахдаа ирэх оны төсвийг өргөн мэдүүлэхдээ энэ 6 дугаар сарын 1-ний өмнө батлагдсан төсвийн хүрээ дотроо багтаагаад оруулж ир гэдэг заалт байсан болохоос, энэ бол тодотголд хамаарах заалт биш. Тухайн үед хуралдааны протоколууд дээр ч гэсэн ингэж гишүүд асууж, тийм тайлбаруудыг өгч байсан юм байна лээ.

Гэтэл яагаад өнөөдөр энэ заалтыг тодотголд хүртэл хамааралтай гээд заачихсан юм. Жишээ нь би бол ойлгож байгаа, Ерөнхий сайдын хувьд энэ 31 тендер хаагдчихсаны дараа шаардлагатай бол төсөвт тодотгол хийнэ. Тэр үеэрээ энэ урсгалуудаа танах, зардлаа бууруулах, гадаад зээлүүдийгээ эрэмбэлэх, тэр төрийн албан хаагчдыг 30 гаруй хуулиар цалин хөлсийг нь хөрөөний ир шиг янз бүрээр тогтоочихсон энэ байдлыг цэгцлэх, зарим албан хаагчдыг төрийн алба биш, нийтийн алба руу шилжүүлэх, зарим агентлагуудыг нэгтгэх, нийлүүлэх ажлуудыг тодотгол дагуулаад оруулж ирье гэж бодож байгаа. Яагаад гэхээр бид тийм зайлшгүй шаардлагатай тулгарч байгаа.

Гэтэл 5 сарын 31-ний дараа 6 сард тодотгол оруулах шаардлага үүсчихвэл 6 сарын 1-ний төсвийн хүрээ дээр чинь оруулж ирэх гэхээр 3 сараа давахгүй болчихоод

байна шүү дээ. Тэгэхээр энэ босго болж, шинэ төсөвтэй холбоотой гэж би ингэж ойлгож байгаа. Тэгэхээр ийм учраас л энэ дагаж орж ирсэн. Саяын.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд гүйцээгээд хариулчихъя.

Н.Учрал: Тэр танилцуулга дээр байгаа гээд байгаа үндэслэл бол энэ Эрдэнэбүрэний УЦС, газрын тосны үйлдвэрийн гадаад зээлийн ашиглалтыг бол төсөвт бичихгүйгээр санхүүжүүлээд явах ийм бие даасан эрх зүйн орчныг Их Хурлын гишүүд өргөн барьж хэлэлцүүлээд, эцсийн хэлэлцүүлэг рүү шилжчихсэн байсан. Тэгээд 1 зүйлийг хэлэхэд энэ удаагийн төсвийн хүрээний мэдэгдэл дээр энэ 2 төсөл хоёулаа багтчихсан байгаа. Тэрнээс биш багтаагүйгээр энэ хууль батлагдана гэж хэлээд оруулж ирээгүй биш, энэ бол оруулж ирсэн. Яах вэ тэр сая танилцуулга дээр мэдээж энэ орж ирснээрээ дахиад илүү орон зай үүсэх байх. Тийм учраас эдийн засгийн болон бусад тоонуудыг их өөдрөгөөр төсөөлсөн байна гэдэг үндэслэл бичсэн юм шиг байна гэж би Эдийн засгийн хөгжлийн яамныхныг ойлголоо. Тэрнээс биш Гадаад зээлийн ашиглалтын хууль гарсан ч, гараагүй ч энэ багтчихсан энэ төсвийн хүрээнд. Тэгэхээр ирэх оны төсөв дээр тавиад л, зээлээ ашиглаад л явна.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Би түрүүн нөгөө дутуу энэ жишээлбэл төсвийн хүрээгээ дагалдуулж сайжруулах юмнууд байгаа учраас энийгээ оруулж ирээч, дараагийн боломж байдаг бол оруулж ирээч гэдэг санаанууд, энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн энэ дүгнэлт дээр биччихсэн, өмнө нь ч бас яг түрүү жил ч гэсэн яригдаж байсан асуудлууд. Энэ 4 зүйлийг жишээлбэл төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл дээр багтаах, нэрлэсэн ДНБ, нэгдсэн төсвийн урсгал зардал, нэгдсэн төсвийн орлого, голлох эрдсийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнэ гээд энэ жишээлбэл төсвийн хүрээний мэдэгдэлд оруулах бусад хууль, эрх зүйн орчин дээр байгаа мөртөө одоо энд ордоггүй. Тэгэхээр энэ мэт хамааралтай зүйлүүдээ дагуулж оруулж ирээч гэдэг ийм юу хэлэх гэсэн юм 1-д.

2 дугаарт Нийслэлийн Монгол Улс нэгдсэн төсөвтэй. Нийслэлийг харахаар энэ улс хөгжөөд бүүр хөгжлийн манлайд хүрэх гээд байгаа юм шиг. Гэтэл улсын төсвөө харахаар ер нь тэгээд бараг өнөө маргаашаа аргацаагаад байгаа юм шиг энэ нэгдсэн төсвийн бодлого гэдэг юмаа барьж ажиллаасай гэж хэлмээр байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Ерөнхий сайд.

Н.Учрал: Энхтүвшин гишүүн түрүүн асуусан тэр тэнцвэржүүлсэн үнэ нь угаасаа хуульд заачихсан байдаг. Дээрээс нь төсвийн хүрээ, ер нь өнгөрсөн жилүүдэд төсвийн хүрээний мэдэгдлийг дагаж хууль дагаж орж ирсэн тохиолдол бараг байхгүй юм байна лээ. Энэ удаа бол энэ 3 сарыг тодотгол дээр хамаарахгүй байдлаар зохицуулахгүй бол яг үнэнийг хэлэхэд 6 сард төсвөө тодотгохоос өөр замгүй юм байна лээ гэж буюу одоо бид ажиллаж байгаа. Тэрнээс биш цаашаа явахад их хэцүү. Тийм учраас энэ 3 сар байгаа цагт их бэрхшээлтэй болно.

Гадаад зээлийн ашиглалтын хууль түрүүн Цогтбаатар гишүүн асууж байсан. Энэ Гадаад зээлийн ашиглалтын хууль батлагдвал тэр төслүүд, Хөгжлийн банкаар, Хөгжлийн банк тэр Сангийн яамны ажлыг хийх ёстой байхгүй юу. Тэгэхээр тэр

заалтыг ажлын хэсэг дээр гишүүд оруулж ирж байсан. Нэгтгээд төсвийг дагуулаад оруулаад ирж.../минут дуусав/

С.Бямбацогт: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуултаа асууя.

О.Батнайрамдал: Монгол Улсын 27 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 28-аас 29 оны төсвийн төсөөлөлд манай ДНБ-ий өсөлт 5,8-аас 6,3 байна гэж. Миний хувьд энэ боломжийн гэж харж байна. Ер нь гадаадын ОУБ-ын Монголын төсөөлөлтэй харьцуулбал 0,5-аас 1 функт л илүү байна л даа. Ер нь сүүлийн 5, 6 жил ч гэсэн яг тэгж явж ирж байсан. Гэхдээ бид ОУБ-ын хүлээлтийг дандаа давж гарсан өсөлт үзүүлсэн шүү дээ. Тэгэхээр энэ боломжийн гэж харж байгаа.

Энэ дотроо жоохон өрийн талаар яримаар байгаа юм. ЗГ-ын өр ДНБ-ий тааз нь 50-аас 45 хувь байна гэж төсөөллөө оруулж ирж байна. Тэгэхээр энийг ойлгохын тулд бид сүүлийнхээ 5 жилийн манай өрийн тааз, эсвэл гүйцэтгэл хэр байсныг харах ёстой болж таарч байгаа юм. 2021-ээс 2025 оны хооронд манай ЗГ-ын өр дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулах хэмжээ нь 55-аас, 25 оны гүйцэтгэлээр бол 35 хувь хүртлээ бууруулж бичсэн айгаа юм. Нэг ёсондоо бид 20 хувиар бууруулсан гэдэг бол их том үзүүлэлт шүү. Яг энэ үед бас ЗГ тэр дундаа Сангийн яам өрийн менежментээ ер нь аягүй сайн хийсэн шүү дээ. Тэгэхээр энэ дээр сайшаалын үг заавал хэлэх ёстой гэж ер нь бодож байна. Манай Сангийн яам энэ дээр өрийн менежмент сайн хийсэн.

Гэхдээ Монгол Улсын зээлжих зэрэглэл ер нь өр авч үзэхдээ зөвхөн ЗГ биш л дээ, ер нь макро эдийн засгийн түвшинд бид авч үзэхдээ Монгол Улсын нийт өрийн хэмжээгээр авч үзэх ёстой. Энэ цаг мөчид 21-ээс 25 оны энэ 5 жилийн цикл дээр Монгол Улсын нийт гадаад өр 33,8 тэрбум доллароос өнөөдрийн байдлаар 25 оны гүйцэтгэлээр 40,5 тэрбум болтлоо өссөн. Нэг ёсондоо 7 тэрбумаар Монгол Улсын нийт гадаад өр сүүлийн 5 жилийн хугацаанд өссөн. ЗГ-ын өр өсөөгүй, тогтмол байсан, харин ч буурсан. Төв банкны өр эсрэгээрээ нэлээн дорвитой буурсан. Свопоо бид чинь 2,6-аас 1 тэрбум болтлоо бууруулж чадсан.

Өсөлт хаана явагдсан бэ гэвэл ерөөсөө л ОТ дээр л явагдсан. ОТ-н тэр зээлийн хэт өсөлт энэ 7 тэрбумын бараг 6 тэрбум нь ОТ байгаад байгаа юм. Гэхдээ энэ нь бараг зээл гэхээсээ илүүтэйгээр зээлийн хүүгийн нэг ёсондоо хүү өсөхөөр дагаж өссөн зээлийн нийлмэл хүүгийн маш өндөр өсөлт энэ дээр явагдчихсан байгаа юм. 21 онд ОТ-н зээл ДНБ-ий 36 хувьтай байсан бол 25 оны эцсээр гүйцэтгэлээрээ 47 хувь гэж гарсан байна. Тэгэхээр энэ өрийн менежмент ЗГ дээр явагдсан шиг ОТ компани дээр явагдаж байж, Монгол Улсын нийт макро эдийн засгийн түвшинд өрийн менежмент нь зөв явна, буцаад зээлжих зэрэглэлд нь эергээр нөлөөлнө гэж харж байгаа юм. Өнөөдөр ОТ компанийг компаниар нь аваад үзвэл нийт санхүүжилтийн 86 хувь нь зээл, зээлийн хүү тооцогддог юм шүү дээ. Энэ бол ерөөсөө эрүүл бүтэц биш байхгүй юу. Тэгэхээр бидний хэлэлцээр ОТ компанийг нэг ёсондоо санхүүгийн бүтцийн хувьд илүү эрүүл, optimal тал руу оруулах гэж байгаа гэдгийг бас бид харах ёстой шүү. Зөвхөн нэг Монгол Улс ноогдол ашгаа хүлээгээд байгаа биш, энэ компани өөрөө эрүүл байна гэдэг бол Монгол Улсын нийт гадаад өрийн 50 хувь нь эрүүл байна гэсэн үг байхгүй юу.

2 дугаарт бас нэг зүйл байгаа юм л даа. ОТ компанийн ерөөсөө нийт гадаад санхүүжилт Монгол Улсад ямар эерэг нөлөө үзүүлдэг байсан бэ гэхлээрээ бүтээн байгуулалтын маш том санхүүжилт явж ирсэн. Капекс /сарех/ санхүүжилтб Энэ

капекс санхүүжилт 25 оны эцэст хүрээд ингээд дуусчихсан. Цаашаагаа капекс байхгүй. Энэ сөрөг нөлөө үзүүлнэ гэсэн үг. Энэ юугаар энийг бид орлуулж болох вэ гэхээрээ борлуулалтын орлогыг Монгол Улсад 100 хувиар дамжуулах ёстой. Өчигдөр Монголбанкны Ерөнхийлөгчийн хэлж байгаагаар ОТ-н борлуулалтын орлогын 57 хувь нь Монголоор дамжиж байна одоо. Энийг л бид 100 хувь болгоно гэдэг макро эдийн засгийн түвшинд энэ зорилтыг хангах маш өндөр ач холбогдолтой шүү гэдгийг хэлмээр байгаа юм.

С.Бямбацогт: Асуултаа гүйцээгээд асуучихъя. Тэгээд Ерөнхий сайд хариулъя.

О.Батнайрамдал: Тэгэхээр Ерөнхий сайд ОТ-н хэлэлцээр ер нь нөгөө бид энэ 5,8-аас 6,3 хувийн эдийн засгийн өсөлтөө хангах, цааш нь давуулан биелүүлэхэд ер нь энэ 50 хувь нь болох гээд байгаа юм л даа. Тэгэхээр таныг хэлэлцээр дээр амжилт гаргана гэдэгт би хувь хүнийхээ хувьд би 100 хувь итгэлтэй байгаа шүү. Монгол Улсын өгөөжийн 53 хувийг 120 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, хангаж чадна гэдэгт таныг залуу, эрч хүчтэй Ерөнхий сайдын хувьд биелүүлнэ гэдэгт 100 хувь итгэж байгаа. Тэгэхээр та энэ дээр ач холбогдол өгөөд, цаг хугацаанд нь ажиллаад өгөөсэй гэж чин сэтгэлээсээ хүсмээр байгаа юм. Харин бидний хувьд парламентын зүгээс таныг дэмжинэ. Гэхдээ нөгөө талаасаа ташуур болж, хэлэх, нэг ёсондоо урагшаа алхахад нь хүч түрж ажиллах болно.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя. ОТ-н асуудал чухал асуудал.

С.Бямбацогт: Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2025 онд 3,8 тэрбум доллар, түүний 50 хувь нь буюу шууд хөрөнгө оруулалтын 50 хувийг ОТ компани бүрдүүлж байгаа. Тийм учраас эдийн засагт өгөөжтэй төсөл. Гэхдээ энэ ОТ хэлэлцээрийн хүрээнд энэ зээлийн хүү бууруулах, менежментийн төлбөр, арбитр дээр үүсчээд байгаа маргааны асуудал, тэгээд сая таны түр хорооны тогтоолоор тодорхой үүрэг өгсөн, нөгөө Онрэтэй холбоотой хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах асуудал, бүхэлдээ Монголын ард түмэн энэ 50 хувийн өгөөжөө хүртэх энэ үүргээ биелүүлэх асуудал байгаа. Тийм учраас ЗГ дээр ОТ-н энэ ажлын, том ажлын хэсгийг Хэрэг эрхлэхийн сайдаар ахлуулаад, манай Сангийн сайд, Хууль зүйн сайд, манай Энхбаяр сайд, уул уурхай буюу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд ажиллаж байна. Хэлэлцээр 12-ноос үргэлжилнэ гэсэн хүлээлттэй байгаа. Тэгээд бидэнд тодорхой удирдамж байгаа гэж би ойлгож байгаа. Хэлэлцээр хийхэд бид удирдамжтай. Тэр удирдамж бол Батнайрамдал гишүүний ахалсан түр хорооны тогтоол. Тэр тогтоолыг барьж хэлэлцээр хийнэ. Монголын талд ашигтай байх талаар нь хэлэлцээр хийнэ.

Тийм учраас хэлэлцээр явж байх үед харин улс төрчид, эрхэм гишүүд та бүхнийг бид энийг хэт их олон нийтэд нээлттэй ярих зохимжтой биш. Хэн ч гэсэн хэнтэй ч хэлэлцээр хийхэд тактикуудаа өмнө нь түрүүлээд телевиз олон нийтийн хэвлэлээр яриад хэлэлцээр хийнэ гэж байдаггүй. Тийм учраас энэ чинь хэлэлцэх урлаг гэж бий. Тэгэхээр ЗГ ер нь хэлэлцээрт орж байна. Хэлэлцээрт орж байгаа учраас би яг хатуу баримтлах бодлогуудыг хэлээд ч гэдэг юм уу явах нь зохимжгүй. Батнайрамдал гишүүний би байр суурийг шууд Их Хурлын Түр хорооны тогтоолоор хүлээж авч байгаа. Би энэ Түр хорооны тогтоолыг биелүүлэх үүрэгтэй. Мэдээж ЗГ-ын зүгээс бүх боломжоо дайчилж, энэ дээр хичээж ажиллаж байгаа.

Тэгэхээр бүгдээрээ би Эрдэнэс ОТ дээр компани дээр нээлттэй сонгон шалгаруулалт зарласан, сонгон шалгаруулалтын тусламжтайгаар хэл устай, мэдлэг боловсролтой, чадалтай СЕО-той болох байх гэж бодож байна. ТУЗ-д нь оруулна. Ингээд дээрээс нь ОТ компани дээр, Эрдэнэс ОТ компани дээр олон улсын энэ хэлэлцээрт орох багийг сонгон шалгаруулна. Ингээд ширээний ард суугаад, яг хэлэлцээр хийх чадамжтай багаар ЗГ төлөөллөө хангая гээд таны энэ зарчмын саналыг дэмжээд хэрэгжүүлж байгаа.

С.Бямбацогт: Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

О.Батнайрамдал: Энд яг хэлэлцээрт орох ЗГ-ын төлөөллүүд байгаа учраас нэг зүйлийг хэлмээр байна. Бид яг ОТ төслийг аваад үзвэл яг энэ 16 жилийн туршид одоо яг ийм шилжилтийн үе рүү орж байгаа. ОТ компани урьд нь бүтээн байгуулалтын маш том төсөл, бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтаар дамжиж Монголын эдийн засагт нөлөөлдөг байсан. Одоо бүтээн байгуулалт дуусчихсан учраас цэвэр уул уурхайн компани болчихсон байхгүй юу. Тэгэхээр тэр борлуулалтын орлого Монголоор дамжих гэдэг буцаад бүтээн байгуулалтын тэр эерэг дуусчихсан нөлөөг буцаж авчрах маш том боломжийн шилжилт дээр бид хэлэлцээрт орж байгаа учраас энэ дээр маш хариуцлагатай байх ёстой юм. Тийм учраас Монголын 53 өгөөж энэ дээр том зургаараа маш чухал юм. Тэр борлуулалтын орлогыг 100 хувиар дамжуулна гэдэг биелэгдэшгүй зүйл ерөөсөө биш шүү. Аль түрүүнд 53 хувь нь Монголбанкны арилжаагаар дамжиж байгаа. Энийг л 100 хувь болгох ёстой, болгох үүрэгтэй. Тэгэхээр энийгээ амжилттай хийгээрэй. Эрдэнэс ОТ компанийн захирлын сонгон шалгаруулалт нээлттэй зарласанд талархалтай хандаж байгаа. Энэ дээр харин сонгон шалгаруулалт шударга../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Стратегийн орд, тэр 2007 оны Их Хурлын тогтоол, тэр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Баялгийн сан, тэр дундаа Монголын ард түмэн үр өгөөжийнхөө, өгөөжийнхөө 60 хувийг хүртэх, ер нь бие даасан нэг эрх зүйн орчныг гаргая, энэ олон жилийн дуусдаггүй яриаг дуусгая гэж ЗГ шийдэж, өчигдөр стратегийн орд эзэмшигчидтэй уулзлаа. Ирэх долоо хоногт энэ хуулийг өргөн мэдүүлье гэж бодож байна. Нэн яаралтай горимоор. Тэгээд та бид ярьдаг, нөгөө өгөөжид яг юу, юу тооцох вэ гэдгийг нэг хуульчлаад өгье. Тэгвэл бид хэлэлцээр хийхэд их амар болоод байна. Тэгэхгүй бол стратегийн орд эзэмшигч нартай ярихаар манай өгөөж чинь бараг 70 хувь хүрчихсэн шүү дээ гээд байдаг. Тэр байтугай ажлын байр нэмэгдүүлж байгааг та нар өгөөж гэж үзэх ёстой гээд ингээд байдаг. Тэгэхээр үзэх юм уу, үзэхгүй юм уу гэдгээ хуульчилж өгөөд, тэгээд цаашдаа байгуулагдах олон ирээдүйн Засгийн газруудад маш ойлгомжтой эрх зүйн орчныг бий болгож өгье л гэж бодож байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын Хишиг сургуулийн 12А, 12Б ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе. Удахгүй сургуулиа төгсөөд хүссэн мэргэжлээрээ, хүссэн их дээд сургуульдаа орж, сайн боловсрол эзэмшин эх орныхоо хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулсан, хариуцлагатай, хуулиа дээдэлдэг иргэн болж төлөвшөөрэй гэж хүсье. Аав ээж, багш

нарынхаа үгэнд сайн орж байгаарай. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Энэ долоо хоногт Монголбанкны 2025 оны тайланг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцсэн. Тэр танилцуулгаар ерөнхийдөө Монголбанк одоо үүсээд байгаа алдагдлаа 2030 он хүртэл Монгол Улсын ЗГ-ын өрийн үнэт цаасаар санхүүжүүлнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй байна гэдгээ танилцуулсан. Тэгтэл одоо би зүгээр Төсвийн хүрээний мэдэгдлийн төсөөлөл дээр болохоор энэ талаар ямар ч мэдээлэл алга байна. Тэгэхээр энийг, энэ тал дээр Ерөнхий сайд ямаршуу ажил төлөвлөж байгаа юм бэ гээд 1 дүгээр асуулт байна?

2 дугаарт болохоор энэ ЗГ-ын өрөнд болохоор төрийн өмчийн компаниудын өр ерөөсөө орохгүй байгаа шүү дээ хуулиараа тийм ээ. Тэгээд төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөл дээр төрийн өмчийн компанийн төсвийн орлогод оруулж байгаа ногдол ашиг, татварын талаарх төсөөллүүд мэдээж тусаж байгаа байх. Тэгэхээр энэ 2027, 2028-аас 29 оны төсөөлөл дээр энэ төрийн өмчийн компаниудтай холбоотой ямар томоохон өөрчлөлтүүд орсноос болж, ногдол ашгийн орлого яаж нэмэгдэх гээд байгаа юм, татвар нь яаж нэмэгдэнэ гэдэг тооцооллууд дээрээ нэг тайлбар хийгээч гээд?

3 дугаар асуулт болохоор ерөнхийдөө ингээд хараад үзэхээр өнөөдрийн манай уул уурхайн салбараас хамаарсан эдийн засаг маань ингээд тодорхой хэмжээний хүндрэлд ороод байгаа гэдэг нь харагдаж байна. Тэгээд хэрвээ үнэхээр ингээд эдийн засаг хумигдлаа гэвэл ЗГ-аас хэрэгжүүлэх хамгийн чухал 3 эдийн засгаа тэлэх 3 том төсөл маань юу юм бэ гэсэн ийм асуулт асууя?

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Би Их Хурлын дарга байхдаа Иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах арга хэмжээний тухай тогтоол баталж байхад Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/-нд үүрэг өгсөн. Соронзонболд гишүүн ажлын хэсэгт байдаг, Тэмүүлэн гишүүн ахалж байсан. Энэ хүрээндээ Монголбанкин дээр өнгөрсөн хугацаанд явуулсан сахилга батгүй, хариуцлагагүй үйлдэл хэрээс хэтэрсэн. Тийм учраас Монголбанк энэ өнгөрсөн хугацааны зах замбараагүй, сахилга батгүй үйлдэлдээ дүгнэлт хий, тийм учраас тэр алдагдлаа бууруул, ингэхгүй бол цаашаа явах замгүй боллоо гэсэн. Онолын хувьд зөв л дөө. Монголбанк ЗГ-аас санхүүжүүлээд тэр алдагдлаа бууруулах шаардлагатай, ийм саналаа хуулийн хүрээнд оруулж ирж байгаа юм шиг байгаа юм. Тухайн үед Монголбанкин дээр нөгөө орон тоо бууруулах, төсвийг нь хэмнэх, шаардлагатай арга хэмжээнүүдийг авах, ер нь бодлогын хүү дээр ч гэсэн жоохон чангарсан байгаа шүү дээ. Өр, орлого дээр ч гэсэн ингээд нэлээн хатуу бодлого явуулсан. Тэгээд яах вэ түүний үр дүн гарч байгаа богино хугацаанд.

Гэхдээ цаашаа бол яах вэ гэдэг дээр мэдээж бие даасан байгууллага учраас зөвлөх хэрэгтэй. Зүгээр тэр Монголбанкны өөрийнх нь бодлогын хувьд танилцуулсан байх гэж бодож байгаа. Нэгэнт батлагдаагүй, яг хэрэгжиж эхлээгүй ийм бодлого. Тийм учраас төсвийн хүрээнд дээр энэ асуудлыг оруулж өгөөгүй. Цаашид Монголбанк өөрөө илүү их ашигтай ажиллах замаар энэ алдагдлаа жил бүр шимэгдүүлж, бууруулж явах би шаардлагатай болов уу гэж бодож байна. Өнөөдөр ЗГ тийм санхүүжилт хийгээд явах тийм бололцоо төдийлөн байхгүй. Тэрийг үнэнээ хэлье. Өөр юу гэсэн бэ?

Эдийн засаг хумигдлаа гэвэл. Эдийн засаг агшиж байгаатай холбогдуулаад бид нөгөө энэ сая энэ төсвийн хүрээ бол зүгээр л орлого, зарлага дээд хязгаар тогтоосон. Тэгээд ерөнхийдөө нийлүүлэлтийн гаралтай инфляцыг бууруулах чиглэлээр экспорт, импортын нэмэгдүүлэх Тэргүүн Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсэг гааль, хил, боомтууд дээр арга хэмжээнүүдийг аваад явж байна. Энэ мэдээж тухайн цаг үеийн шаардлагууд. Дээрээс нь бид ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр нийтдээ 7 төслийг сая Гадаад явдлын яам дээр уулзсан уулзалтын үеэр зарласан. Төсвөөс санхүүжихгүй, сая энэ боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах ажлын байр нэмэгдүүлэх эхний төслүүдээ явуулсан. Энэ бага орлоготой иргэдийг дэмжих чиглэлээр энэ татварынхаа хуулийг барьж байна. Тэгээд ингээд энэ үед илүү ажлын байраа хадгалах тал руу, шинэ ажлын байр нэмэгдүүлэх чиглэл рүү гол бодлогуудаа оруулж байгаа. Тэгээд төсөвтэйгөө зэрэгцүүлээд шаардлагатай эрх зүйн орчнуудыг.../минут дуусав/

С.Бямбацогт: Соронзонболд гишүүн тодруулж асууя.

Л.Соронзонболд: Тийм. Тэгэхээр харин яах вэ Эдийн засгийн хөгжлийн яамнаас ер нь асуугаад байгаа юм л даа. Энэ чинь тодорхой хэмжээнд төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөл хийж байгаа улсууд чинь энэ эдийн засагтаа оролцож байгаа гол оролцогчтойгоо ярилцаж, ярих ёстой шүү дээ. Тэгж л асуугаад байхгүй юу. Төсөөлөл дээрээ хүртэл юу ч байхгүй байна гэж. Зүгээр яах вэ сая би сонсоход Хөгжлийн банкны дүрмийн санг 1 их наяд төгрөгөөр шууд нэмчихсэн байна лээ шүү дээ төрийн өмчийн компаниудтайгаа яриад л. Тэгсэн мөртөө Монголбанкныхаа алдагдлыг нэг жилд 1 их наядаар нэмье гэдэг юмаа ярьж чадахгүй байгаа нь л өөрөө буруу байна гээд байхгүй юу. Тэгээд энэ дээр Эдийн засгийн хөгжлийн яамнаас яг тодорхой хариулаач? Би сая 3 асуулт асуулаа шүү дээ.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ, Энхбаяр сайд уу, Батхүү Төрийн нарийн уу? Батхүү 4 дүгээр микрофон, Эдийн засгийн хөгжлийн яамны ТНБД.

И.Батхүү: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахдаа бид бодит секторууд дээр уул уурхайн голлох олборлогч, экспортлогч компаниуд, бусад ХАА-н салбар гээд, зам, тээврийн салбарын ААН-үүдтэй уулзаж, тоон мэдээллээ авч ажилладаг. Түрүүн таны дурдсан Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийг зохистой түвшинд хүргэж нэмэгдүүлэх асуудал бол Хөгжлийн банкны хувьцаа эзэмшигч нь ЗГ-ыг төлөөлж Эдийн засаг, хөгжлийн яам ажиллаж байгаатай холбоотой дотоод ЗГ-ын түвшинд шийдсэн асуудал байгаа.

Монголбанк маань өөрөө бие даасан хуультай. Түрүүн Ерөнхий сайдын хэлж байсан өөрсдөө үйл ажиллагааны ашигт байдлаа хангаад, төсвийн үр ашиггүй зардлаа хэмнээд явах нь зүйтэй байх гэж үзэж байгаа юм. Ер нь гол мөнгөний нийлүүлэлтийг хариуцаж байгаа, инфляцын түвшнийг хариуцаж байгаа, гадаад валютын албан нөөц, долларын, төгрөгийн ханшийг хариуцаж байгаа байгууллагын хувьд голлох шийдвэрүүд нь бие даасан байдлаар явдаг, тусдаа хуультай. Тэгэхээр бол яг тэр.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя 4 дүгээр микрофон.

И.Батхүү: Монголбанкны алдагдлыг төсвөөс санхүүжүүлнэ гэдэг асуудал бидэн дээр яригдаагүй байгаа, санал ирээгүй байгаа.

С.Бямбацогт: Тодруулж асууя Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Тэгэхээр нөгөө хүрээний мэдэгдэл, төсөөлөл дээрээ төрийн өмчийн компаниудаас орж ирэх ногдол ашиг, татвар дээр ямар томоохон өөрчлөлтүүд тооцоолсон юм бэ л гэж асуусан шүү дээ 2 дугаар асуулт? Тэрэн дээр хариулаач.

Дээрээс нь болохоор хэрвээ эдийн засаг хумигдсан тохиолдолд ямар 3 том төслийг ЗГ-аас хэрэгжүүлэх юм бэ дэс дарааллаараа? Өөрөөр хэлбэл эрэмбээрээ гэсэн үг шүү дээ. Ийм энэ 2 асуултад хариулаадхаач.

С.Бямбацогт: Батхүү дарга. Энх-Амгалан хариулах уу, хэн? Ажлын хэсэг хариулъя 4 дүгээр микрофон.

Л.Энх-Амгалан: Төрийн өмчит компани /ТӨК/-удын ноогдол ашгийн тухай асуултад хариулъя. Төсвийн хүрээний мэдэгдлийг хийхдээ гол экспортлогч гол үйлдвэрлэлд хувь нэмэр оруулдаг том ТӨК-удтай байнгын уулзалт, мэдээлэл солилцоо хийж байгаа. Ноогдол ашиг голлон Эрдэнэт болон Эрдэнэс Тавантолгойгоос төвлөрдөг. Мөн Эрдэнэс критикал майнинг, Дархан төмөрлөг гээд компаниудаас төвлөрдөг ноогдол ашгууд байгаа. Тэгэхээр нүүрсний хувьд 27 онд 100 сая тоннд хүргэнэ биет хэмжээ гэж тооцсон. Үүний 35-аас 40 сая тонн нь Эрдэнэс Тавантолгой /ЭТТ/-той холбоотой. Зэсийн хувьд нийт 600 мянга орчим тонн баяжмал Эрдэнэтээс экспортод гарна. Тэр дүнгээр ноогдол ашгийг Хуримтлалын санд төвлөрүүлэхээр тооцсон байгаа. Төсвийн хүрээ бол төсвийн хүрээнд хуримтлалын сан болон баялгийн сангийн орлогууд ордоггүй.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя, 4 дүгээр микрофон.

Л.Энх-Амгалан: Төсвийн хүрээнд төсвийн тэнцвэржүүлсэн орлогын асуудал яригддаг. Тэрнээс төсвийн нийт орлогын асуудал яригддаггүй. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого дээр баялгийн сангуудын орлогыг нэмээд нийт орлого болдог. Тэгэхээр хуулийнхаа хүрээнд бид танилцуулга дээр зөвхөн тэнцвэржүүлсэн орлогын асуудлыг ярьсан. Түүний цаана авсан экспортын төлөвлөгөөтэй уялдаад хуримтлалын сангийн орлого, ноогдол ашгийн орлогууд цаана нь тооцоолол дээр байгаа. Тэр нь намар төсөв хийх үед нарийн задаргаатайгаа, компани болгоны төвлөрүүлэх төлөвлөгөөт гээд танилцуулагддаг ийм зохицуулалттай байгаа.

С.Бямбацогт: Энхбаяр сайд нэмж хариулъя, Эдийн засгийн хөгжлийн сайд.

Ж.Энхбаяр: Эдийн засгийг идэвхжүүлэх бодлогын гол төслүүд юу вэ. 1 дүгээрт эрчим хүчний төслүүд, үндсэндээ Монгол Улсын эрчим хүчний салбар одоо дээд хүчин чадалдаа тулсан. Цаашид шинэ хэрэглээг хангах ийм бололцоогүй болж байгаа. Тиймд одоо энэ хэрэгжиж байгаа энэ Баян болон Бөөрөлжүүт, Шивээ, Эрдэнэбүрэн, Сэлэнгэ, Тавантолгой, ТЭЦ 5 гэсэн энэ багц эрчим хүчний хүчин чадлыг нэмэх төслүүд тэргүүн ээлжид явна.

Дараа нь бид түүхий эдийнхээ боловсруулалтын түвшин дээр онцгой анхаарна. Үүнд зэс боловсруулах, цэвэр зэс, ган хайлах, нүүрс баяжуулах энэ төслүүдээ дараагийн боловсруулалтын түвшнийг ахиулж, биржээр дамжуулж зах зээлд гаргах ийм бодлогыг хэрэгжүүлнэ. Дараа нь нефть боловсруулах үйлдвэр

байгаа. Нефть боловсруулах үйлдвэр бол нефть манай Монгол Улсын хамгийн султ тал байгаа нь энэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Нанзадын Наранбаатар гишүүн асуултаа асууя.

Н.Наранбаатар: Төсвийн хүрээний мэдэгдлийг одоо хүчин төгөлдөр байгаа хууль, эрх зүйн орчин дээрээ үндэслээд боловсруулсан байгаа байх. Тэгээд сая 3Г энэ татварын хуулийн өөрчлөлт өргөн барьсан. Тэгээд энэ дээр 2,2 их наяд татвар төлөгчдийн нуруун дээрээс хөнгөлнө гэхсэн. Гэтэл төсвийн орлогыг 34 их наяд гээд 27 онд, 28 онд 37, 39 гээд ингээд өсгөөд тавьсан. Тэгэхээр энэ татварынхаа эфффектийг яаж тусгасан юм бэ? Хэрвээ 2,2 их наядын хөнгөлөлт үзүүлж байгаа бол энийг яаж нөхөх юм гэдэг асуудал. Тэгсэн мөртөө нүүрсний экспортоо 100, 105, 110 гээд ингээд тавьсан. Ирэх жил, оны эхэнд хил холболтын төмөр замын ажил дуусах уу? Хэрвээ энэ чинь дуусчихвал жилдээ 30 сая гээд байгаа биз дээ? Тэгэхээр нүүрснийхээ экспортыг их л бага тавьсан юм болов уу гэсэн ийм яагаад ямар тооцоогоор 29 онд 110 сая тонн гэж тавьсан юм бэ? Одоо 90 сая гаргаж байгаа юм бол ядаж 30 саяыг нэмэхээр чинь 120 гарах ийм бололцоо байхгүй юм уу гэсэн нэг ийм асуулт байна?

Энэ инфляц чинь ер нь энэ түлш, тэгээд махны үнэтэй холбогдуулаад л нэлээн өсчихлөө. Тэгэхээр энэ ирэх жилүүдэд энэ түлшнийхээ нөөц, энэ мах, хүнснийхээ нөөцийг бүрдүүлэхэд ямар асуудлуудыг төлөвлөж байгаа юм бэ? Түлш, түлшний үнэ нэмэгдээгүй байхад зөвхөн тасалдал үүсэхэд л махны үнэ дагаад л бусад бараа, бүтээгдэхүүний үнэ дагаад л өсөж байгаа шүү дээ. Тэгэхээр энэнээс урьдчилан сэргийлэх, энэ эрсдэлээс хамгаалахад чиглэсэн, нөөц бүрдүүлэхэд чиглэсэн ямар асуудлуудыг ирэх жилд хийх юм бэ гэсэн?

Мөн ингээд ирэх жилүүдэд хөрөнгө оруулалтын ажлууд нэлээн хийх шаардлагатай тулгарсан асуудлууд байгаа юм. Тэгээд хөрөнгө оруулалтын орон зай байгаа юу? Намрын Төсвийн тухай хууль, 27 оны төсвийн хууль өргөн мэдүүлэхэд шинээр хөрөнгө оруулалт тавих тийм орон зай байгаа юу? Хуучин хөрөнгө оруулалтуудаа дуусгахад хэдий хэмжээний багцаагаар төсөв, хөрөнгө шаардлагатай байгаа юм бэ, дуусаагүй барилга, байгууламжуудаа дуусгахад хэдий хэмжээний хөрөнгийн шаардлага байгаа юм бэ гэсэн ийм асуудлууд байна.

С.Бямбацогт: Эдийн засгийн хөгжлийн сайд Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Урсгал зардал 27 оны төсөв дээр 6-аас 6 их наядын нэмэлт ийм ачаалал үүсгэнэ. Шинэ хөрөнгө оруулалтыг төлөвлөх бололцоо маш хязгаарлагдмал байгаа. 2,2 их наядын хөрөнгө оруулах төсвийн хөрөнгө оруулалтын орон зай байна. Үүнээсээ бид 3,6 их наядын үргэлжилж байгаа хөрөнгө оруулалтаасаа энэ 2,2-ыг чиглүүлнэ. Энэ хэрэгжиж байгаа төслүүдээ эрэмбэлэхээс өөр арга байхгүй. Урсгал зардлын хэт өсөлт үндсэндээ төсвийн дамжиж төсвөөр дамжиж хөрөнгө оруулалт хийх боломж маш хязгаарлагдаж байгаа.

Хил холболтын ажлууд идэвхтэй, санхүүжилт нь тасралтгүй өрнөж байна. 27 ондоо багтаж ашиглалтад оруулна. Нөгөө талдаа нүүрс маань өөрөө Монгол Улсын коксжих нүүрс энэ урд зах зээл дээр идэвхтэй өрсөлдөж байгаа. Нийт Бүгд Найрамдах Хятад Ард Улс /БНХАУ/ маань өөрөө 204 орчим сая тонн коксожсон нүүрс импортолж байгаа. Түүний бараг 50 хувийг нь Монгол Улс дангаараа бүрдүүлж байгаа. Тэгэхээр их томоохон орон зай эзэлж байна. Тэгээд нөгөө талаас

энэ чинь зах зээл нь хязгаартай байгаа, бусад орнууд байгаа. Тухайн орны бас бодлого байгаа. Иймд бид ер нь 100 сая тонн дээр л нүүрсээ ер нь барих бодлогыг цаашид хэрэгжүүлнэ. Хамгийн гол нь нүүрсээ баяжуулах, биржээр арилжих, үнэд хүргэх энэ бодлогыг хэрэгжүүлнэ гэсэн ийм бодолтой. Тэрнээс тоон хэмжээгээ нэмээд өгөөд байвал бидэнд бол чадавх байна. Тоон хэмжээгээ өгснөөр бас үнэ өсөх буюу зах зээлд тийм өрсөлдөөн бодитой байх боломж тийм хязгаартай. Тэгэхээр бид зохистой хэмжээнд, сайн үнээр, найдвартай нийлүүлэх ийм бодлогыг барина гэж.

Нөөцтэй холбоотой бодлогууд ЗГ дээр авагдаад, шаардлагатай эх үүсвэр нь гарагдаад явж байна. Ялангуяа түлш, түлшний нөөцийг бүхий л салбарт бүрдүүлэх. Үүн дотор экспортыг бүрдүүлж байгаа гол, гол уурхайн ордуудын дэргэд, ААН-үүдийн дэргэд нөөцийн савнуудыг барих ажлыг эхлүүлсэн. Мөн одоо улсын нөөц болон бусад нөөцийг нэмэгдүүлэх нь онцгой чухал. Дор хаяж 3 сарын нөөцийг барьж байж гэнэтийн ийм шокт бол эдийн засгаа савлахгүй аваад гарах ийм боломж бүрдэж байгаа. Энэ бол бодлого бол хэрэгжиж байгаа. Бусад бараа буюу хүнсний бараа, ялангуяа улаан буудайн хаврын тариалалтыг эрчимжүүлэх, үнийг инфляцад их өртүүлэхгүйн тулд хямдралтай үнээр шатахууныг нийлүүлсэн, бордоог нийлүүлсэн, ургамал хамгааллын бодисыг нийлүүлсэн. Тэгэхээр энэ жилийн улаан буудайн тариалалт эд өрнөж байна. Үр дүн эерэг гарах байх гэсэн ийм хүлээлттэй байгаа. Орлого, зарлага дээр яриадхаач.../минут дуусав/

С.Бямбацогт: Сангийн яам Тулга, ажлын хэсгийн ахлагч хариулах гэж байна уу? Ажлын хэсэг, хэн хариулах вэ? Анар Сангийн яамны ТНБД, 4 дүгээр микрофон, ажлын хэсэг хариулъя.

Б.Анар: Төсвийн хөрөнгө оруулалтын үргэлжлэх дүнг асуусан. Энэ оны 26 оноос үргэлжлэх хөрөнгө оруулалтын дүн бол 3,6 их наяд байна. Тэгээд энэ жилийн батлагдсан төсөв нөгөө Хэмнэлтийн хуулиараа энэ оны 5 сарын 31-нээр дуусах ёстой. Тэгээд тэр хүртэлх байгуулагдах гэрээний дүн ямар байхаас хамаараад ирэх жилийн үргэлжлэх хөрөнгө оруулалтуудын дүн бол тодорхой болох ёстой байгаа. Одоо байгаа байгуулсан гэрээнийхээ хүрээнд бол үргэлжлэх хөрөнгө оруулалтын шаардлагатай дүн бол 3,6 их наяд байгаа.

С.Бямбацогт: Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуултаа асууя.

Б.Мөнхсоёл: Олон асуулт байгаа боловч өмнө нь бас гишүүд асуусан учраас зарим нэг асуултыг цөөлье. Юуны өмнө энэ чухал учраас давтаж асууя. Бодит өсөлт 2027 онд 5,8 хувь, 28 онд 6 хувь, 29 онд 6,3 хувь гэж тооцсон байна. Энэ нь одоо Дэлхийн банк, Олон улсын банк, Валютын сан, ADB буюу АХБ зэргийн таамаглалаас нэлээн ахиу таамагласан байна. Тэгээд уул уурхайн экспортын нөхцөл байдал, дэлхийн зах зээлийн эрсдэлийг хэр тусгаж чадсан таамаглал вэ? Орлого бүрдэхгүй бол бид ямар хэцүү байдалд ордгийг бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд 25 оны нийт экспортын орлогын 78,3 хувийг зэс, нүүрс эзэлж байгаа шүү дээ. Тухайлбал зэс 37,7 хувь, нүүрс 40,6 хувь. Тэгэхээр уул уурхайн энэ экспортолж байгаа бүтээгдэхүүнүүдийн маань үнэ унавал тэр чигээрээ энэ таамаглал, экспортын орлогоос хэт хамааралтай орлогын сууриас шалтгаалаад 2027 оны бүх параметр нурах ийм өндөр эрсдэл байна гэж харж байгаа юм.

Дараа нь тэнцвэржүүлсэн тэнцэл. Энэ хүрээний мэдэгдэл учраас л гол хэдэн параметр асуучихъя. 2027 онд 1,7 их наядаар хасах, тэрбум төгрөгөөр 1,7 их наяд

төгрөг байхаар буюу ДНБ-ий 1,5 хувьтай тэнцэхүйцээр ингээд төлөвлөж байгаа байна. Алдагдал буурч байгаа нь эерэг мэт боловч одоо зөрөөг яаж санхүүжүүлэх вэ гэсэн тооцоолол байна уу?

Өрийн тухайд ЗГ-ын өр 27 онд 57,11 их наяд төгрөг буюу ДНБ-ий 50 хувьтай тэнцэхээр, 28-аас 29 онд мөн 50 хувь болон 45 хувьд хадгалагдахаар ингээд тус тус тооцож байгаа юм байна. Өрийн дарамт өндөр бөгөөд тогтвортой байдалд асуудал үүсэх үү гэж асуумаар байна?

Тэгээд одоо бүгдээрээ мэдэж байгаа, сая Анар бас хэлж байна. Орлого санхүүжилтийн тасалдлын улмаас хэрэгжиж буй хөрөнгө оруулалт зогсох, он дамжих хөрөнгө оруулалт, барилгын объектын тоо нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар үүсэхээр байна. Өчигдөрхөн бид Пунсалмаа гишүүнтэй хамтран санаачилсан тогтоолын төслөө бол өргөн барьсан. Түүн дээр бол дуусаагүй барилгуудаа хэрхэн бид шийдвэрлэж болох вэ, төсвийн дарамтыг хэрхэн бууруулж болох вэ гэдэг ийм саналуудаа тусгаад өргөн барьсан байгаа. Тэгэхээр энэ дүгнэлтийг ч гэсэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гаргачихсан байна. Энэ нөлөөллийг төсвийн хүрээний мэдэгдэлд хэрхэн тусгасан бэ гэж асуумаар байгаа юм?

Бидний байнгын ярьдаг бас нэг том асуудал нийгмийн халамж байдаг. 2,8 их наяд төгрөгөөр тусгасан байна. Тэгээд бид янз бүрийн нийгмийн халамж ч бай, үнэ тогтворжуулах ч бай, ер нь энэ нэг талдаа зорилтот группээ дэмжээд, нөгөө талдаа зах зээлүүдийг дэмжээд, иргэдийн худалдан авалтыг дэмжээд, хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг. ХАА-н салбарт ялангуяа маш их ийм дэмжлэгийн чанартай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байдаг. Гэтэл үр дүн тодорхойгүй байгаад байна. Өмнөх хөтөлбөрүүд хэрхэн хэрэгжсэн юм бэ, ямар үр дүнтэй байсан юм бэ, яагаад үргэлжлүүлэх болов гэдгээ сайн тооцоолж байгаад төсвийн хүрээний мэдэгдэл болон тухай тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгадаг баймаар байгаа юм.

Тэгээд нэмээд энэ үлдсэн секундээ ашиглаад хэлэхэд Гадаад зээлийн хуулийн төсөл уначихлаа гэж байгаа юм. Сөрөг, эсрэг санал өгсөн гишүүдийг буруутгах боломжгүй. Төсвийн байнгын хороон дээр ярилцсан. 3 төслийн газрын тос, Эрдэнэбүрэнгийн УЦС чухлыг мэдэж байгаа. Хэдийгээр анхнаасаа төлөвлөлт, тооцоолол алдаатай ч энийг дэмжихээс өөр аргагүй ийм байдалтай түр зуурын төсөл гээд дэмжиж байгаа. Гэтэл 3 дахь байдлаар орж ирсэн тэр Сэлбийн дэд төвийн түшиглэсэн орон сууцжуулах хөтөлбөрийг хасья гэсэн зарчмын зөрүүтэй саналыг Төсвийн байнгын хороо дэмжсэн байхад энд орж ирээд босгочихсон шүү дээ. Дэмжээгүй байхад тэрийг хасахыг дэмжсэн байхад.../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнхсоёл гишүүн асуултаа дуусгая. Энд яах вэ нөгөө нийгэмд буруу ойлголт өгөх гээд байгаа гишүүн болгон өөрийн өнцгөөс хараад, дутуу дулимаг яриад байгаа учраас тодруулмаар санагдсан шүү. Төсвийн байнгын хороон дээр хэд, хэд ярилцсан, ажлын хэсэг саналаа өгсөн, ажлын хэсэг дэмжсэн, хассан, чуулган дээр боссон шүү тэр 3 дахь төсөл. Тийм учраас энд зарчмаа бариад, зарим гишүүд эсрэг санал өгсөн. ЗГ болон бусад гишүүд дэмжиж байгаа бол ирцээ бүрдүүлээд дэмжих боломж байсан шүү. 64-ийн 3-хан хүн дутаад ингээд унасан шүү. Зориуд протоколд үлдээе. Баярлалаа.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Ер нь мэдээж онолын хувьд эдийн засгийн идэвхжил сул үед бид эрэлтээ нэмэгдүүлээд эдийн засгаа дэмжих ёстой, нэг ёсондоо зардлаар дамжуулж гэсэн үг. Тийм учраас гишүүд энэ Гадаад зээлийн ашиглалтын хуулийг баталъя, гадаад зээлийн эх үүсвэр нь тодорхой байхад энийг хэрэгжүүлбэ л гэж яриад байгаа. Энэ маш зөв. Үүнтэйгээ хавсаргаад бол ЗГ гүйцэтгэх засаглал бол ерөөсөө л энэ ажлын байраа хадгалах бодлогыг авч хэрэгжүүлэхгүй бол цаашаа ажлын байруудаа алдвал маш их эрсдэлтэй.

Эдийн засгийн өсөлтийг тооцохдоо ер нь ОУВС ч тэр, Дэлхийн банк, ADB ер нь эдийн засгийн өсөлтийг 5,3-аас 5,8 хувьтай янз бүрээр л тооцсон юм байна лээ. Тэгээд яах вэ энэ дунджаас нь хараад, дээрээс нь манай нөхцөл байдалд ямар байгаа вэ гэдэг дээрээ бид үнэлэлт дүгнэлт хийсэн. Экспорт өмнөх жилийн мөн оны энэ үеэс бараг 60 хувь өсчхөөд байгаа нь сайн хэрэг. Цаашдаа ч гэсэн биет хэмжээ нэмэгдүүлэх бололцоо байна. Үнэ ч гэсэн зах зээл дээр ер нь өсөлттэй байх бололцоо байна. Муу зүйлийн хажуугаар сайн зүйл давхар байдаг. Дэлхийн эдийн засгийг тодорхойлж байгаа том гүрний дэргэд байгаа манай улсын хувьд үүнийг зөв ашиглах ёстой. Тийм учраас экспортоо нэмэгдүүлэхийн төлөө бүх хүч чармайлтаа дайчилж ажиллаж байна.

Тэгэхээр экспортын хэмжээ өсөхөөр байгаа. Энэ жил ч гэсэн гүйцэтгэл өндөр гарна. Бид чинь үнийг, нүүрсний үнийг ч гэсэн 70 доллароор бодсон шүү дээ өмнө жил бол. Энэ бол давах байх гэсэн ийм хүлээлттэй байна. ОТ бол цэвэр зэсийн агууламж нэмэгдэнэ. ХАА-н салбарт энэ боловсруулах салбарын өсөлт өндөр байна. Энэ орон сууцны барилга байгууламжийг дэмнэх энэ маш олон бүтээгдэхүүнүүдийг бид бэлдэж байна ЗГ. Тэр Shared Mortgage, хамтын өмчлөл, ипотек, тэр түрээслээд өмчлөх гээд маш олон төрлийн бүтээгдэхүүнийг дэмжиж, хувийн хэвшлийнхээ бизнесийг тэтгэх ийм ажлуудыг хийж байна.

Дээрээс нь татварын хууль гарснаараа яг бага орлоготой жижиг, дунд эрхлэгчид, бага орлоготой иргэд гээд олон бүлгүүдэд томоохон дэмжлэгүүд үзүүлнэ.

Боловсруулах үйлдвэрүүд дээр энэ гангийн цогцолбор, зэсийн боловсруулах үйлдвэр, тэр нүүрс, пиролиз, хөнгөн цагаан гээд олон боловсруулах үйлдвэрүүд бараг нийтдээ 9800 ажлын байрыг нэмэгдүүлэх, түүний цаана маш олон компани, ААН-үүд гүйцэтгэх ажилд оролцож, идэвхжил нэмэгдэнэ гээд эдийн засгийн өсөлтийн энэ тоог бол.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгая Ерөнхий сайд.

Н.Учрал: Энэ бодитой тоо. Ер нь дунд хугацаандаа 6 хувь байна л гэж тооцож байгаа. Мэдээж энэ бол дээд, доод хязгаарыг баталдаг ийм хүрээ. Тэгэхээр үүндээ тохируулж бид төсвийнхөө, ирэх оныхоо төсвийг оруулж ирэхдээ төсвийнхөө гол бодлогуудыгаа буюу энэ тоонд хүрэхийн тулд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх юм, төсвөөр дамжуулж ямар реформ шинэчлэл хийх юм бэ гэдгээ хамтатгаж оруулж ирнэ. Тэгснээр бид энэ эдийн засгийн өсөлт 5,8-д байна гэдэг энэ тоондоо хүрэхийн төлөө ажиллана гэдгийг хэлье. Тийм учраас энэ төсвийн хүрээ өөрөө алдагдал ч тодорхой үүссэн, зээлээ ч ашиглах бололцоотой. Ер нь байгаа нөхцөл байдалдаа бүрэн нийцсэн ийм л төсвийн хүрээ болсон. Өр бол мэдээж хуулийнхаа тусгай шаардлагыг хангасан, 60 хувьд хүрээгүй, 50 хувь GDP-н.

С.Бямбацогт: Эдийн засгийн хөгжлийн сайд Энхбаяр сайд нэмж хариулъя. Болчихсон уу? 13 цаг болсон байна. Үдээс өмнөх чуулганы хуралдааныг завсарлуулъя. Үдээс хойш 14 цагаас энэ нэр өгсөн гишүүдээрээ асуулт, хариулт үргэлжилж явна. Үүний дараа бид 27 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө хэлэлцэх ёстой. Өнөөдөртөө хэлэлцэх асуудлаа багтааж дуусгана шүү гэдгийг гишүүддээ урьдчилж мэдээлье. 14 цагаас чуулганы хуралдаан үргэлжилнэ.

13.02 цаг

*2026 оны 05 дугаар сарын 08, Баасан гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 05 минут.*

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 14 цаг 05 минутаас хуралдааныг даргалав.

Б.Пүрэвдорж: 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн үдээс хойших чуулганы хуралдаан эхэлж байна. Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Ажлын хэсгийг чуулганы танхимд орохыг урьж байна. Ажлын хэсэг үдээс өмнө чуулганы хуралдаанд оролцсон албан хаагч, албан тушаалтнууд хэвээрээ байгаа. Сайд нарыг урьж байна. Улсын Их Хурлын гишүүд болон сайд нарыг чуулганы танхимд урьж байна. Ганхүлэг гишүүн асуулт асууж эхэлнэ. Ганхүлэг сайд Монгол Улсын Ерөнхий сайдаас болон Хүнс, хөдөө аж ахуй /ХХАА/-н сайдаас асуулт асуух юм байна. Шадар сайдаас бас асуулт асууна гэж байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууна.

М.Ганхүлэг: Өдрийн мэнд хүргэе. Төсвийн тухай, төсвийн төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдолтой 3 асуулт асууя. Энэ гадаад зээллэгтэй холбогдолтой асуудал чухал байсан. Тэгээд ингээд орхиж болохгүй байх гэж бодож байна. Тэгээд Ерөнхий сайдаас тодруулъя. Яах вэ гишүүд өргөн бариад явахаар асуудлууд үүсээд байгаа байж магадгүй. Тэгэхээр шуурхай горимоор байдаг юм уу, богино хугацаанд ЗГ-аас санал оруулж ирээд, тодорхой саяын гишүүдийн дэмжихгүй байгаа асуудлуудыг нь хасдаг юм уу ингээд оруулж ирээд явах энэ хувилбар байж болох уу энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ гэдгээ эхлээд тодруулъя?

2 дахь нь Энхбаяр сайд болон ХАА-н сайдаас асуух гээд байгаа юм. ДНБ-ийхээ өсөлтийг бид 2027 онд 5,8 хувь, 2028 онд 6 хувь, 2029 онд 6,3 хувиар тооцсон байгаа. Энэ жилийн ДНБ-ий өсөлтөд ХАА-н салбарын оруулсан хувь нэмэр нэлээдгүй байсан. Гэхдээ энэ нь бидний бүтээмж, үйл ажиллагаа гэхээсээ илүүтэй уур амьсгалын өөрчлөлтөөс хамаарсан ийм савлагаа л үндсэндээ энэ салбарт яваад байна л даа. 2021 онд ХАА-н салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд үзүүлсэн хэмжээ -5,5 байж байгаад 22 онд 12, 23 онд -8,9, 24 онд -28,7, 25 онд болохоор 33,2 болж ингэж өссөн байгаа юм. Тэгэхээр сүүлийн 5 жилд гээд ингээд харахад жилийн дотор л гэхэд ингээд -5,5-аас бараг 30 хэдэн хувь руу ингээд савлаж байгаа юм энэ салбарын үндсэндээ өсөлт. Гол шалтгаан зудын эрсдэл мөн газар тариалангийн салбар дахь ургацын хэмжээтэй хамааралтай байгаад байна.

Тэгэхээр энэ ДНБ-ий өсөлтөд энэ салбаруудын оруулж байгаа энэ хувь нэмэр, тогтвортой байдал, үүнтэй холбогдолтой судалгаанууд дээр ямар байр суурьтай байгаа вэ? Ирэх жилүүдэд ХАА-н салбарын энэ өсөлтийг тогтвортойгоор хадгалж явах гэдэг дээр ямар тооцооллууд хийсэн бэ? Өргөн агуулгаараа бид бүхэн нэг хүнд ноогдох ДНБ-ээ 15 мянган долларт хүргэвэл Монгол Улс нэлээн боломжийн эдийн засагтай ийм улс болно гэдэг зорилт тавиад явж байгаа. Тэгэхээр энэ хэзээ энэ 10 мянга, 15 мянган долларт хүрэх зорилт хангагдах вэ? Энэ зорилтдоо чиглэсэн энэ зүйлүүд явах ёстой.

2 дахь нь цалин хөлс, тэтгэврийн асуудал орон нутгаар явахад хамгийн их яригдаж байгаа ийм сэдэв байгаа. Шинэ ЗГ үүн дээр тодорхой шийдлүүд гаргаад, байгаа боломждоо тааруулаад ажиллаж байгаад талархалтай байна. Ирэх 3 жилд цалин хөлс болон тэтгэвэртэй холбогдолтой ямар өөрчлөлтүүдийг төсөвлөсөн байгаа вэ? Ялангуяа үндсэндээ хэрэглээний үнийн өсөлтийг 27 онд 7 хувь, 28 онд 6 хувь, 29 онд 5 хувь байна гэж инфляцыг үндсэндээ тодорхойлсон байна. Тэгэхээр хуулиараа инфляцтай уялдуулж нэмэгдүүлэх тухай агуулгууд байгаа. Тэгэхээр энэ өсөлтийг хадгалах чиглэл дээр нэг талдаа урсгал зардал нэмэгдэх эрсдэл, нөгөө талдаа бидний хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай энэ үнийн өсөлтийг дагасан ийм боломжуудыг нэмэгдүүлээд явах шаардлагууд байна гэдгийг нэмээд асууя?

ХАА-н салбар дээр бид бүхэн энэ бүтээмжийн тухай, тогтвортой байдлын тухай ярихгүй бол болохгүй байна. Эхлүүлсэн хөтөлбөрүүд ингээд дөнгөж эхлүүлчхээд орхиод байна. Зудын эрсдэлийг даван туулах зорилготой шинэ хоршоо хөдөлгөөн 5 их наядыг малчдад гаргая гэдэг ийм зорилт тавьсан. Өнөөдөр 1 их наяддаа хүрээгүй байгаа. Тэгэхээр мэдээжийн хэрэг энэ чинь тодорхой судалгаа, тооцооллууд, нарийн юмнууд хийж байж, энэ эдийн засгийн өсөлтөд энэ салбарын хэмжээг нэмэгдүүлэх ийм зорилго хангагдахгүй байх эрсдэлүүд үүсэх гээд байна. Тэгээд ингээд зудаас хамаарсан, ургацын байдал тухайн жилийнхээ хур бороо нөхцөл байдлаас ингээд хамаарсан ийм байдалтай ингээд явахаар цаад агуулгаараа энэ салбарт нэлээн хохиролтой байгаад байна. Тэгээд энийг яаж тооцсон бэ?

Б.Пүрэвдорж: Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал хариулна.

Н.Учрал: Гадаад зээлийн ашиглалттай холбогдуулаад Их Хурлын гишүүд цаг үеэ мэдэрсэн, энэ зээлийнхээ эх үүсвэрийг ашиглая гэдэг зорилгоор Гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх тухай хуулийг өргөн барьж, хэлэлцүүлсэн. Тэгээд үнэхээр цаг үеэ мэдэрсэн хууль байсан. Гэсэн хэдий ч сая эцсийн хэлэлцүүлэг дээр дэмжигдсэнгүй. Тэгэхээр зарим төслүүд байна эх үүсвэр нь тодорхой, ирэх 2 жилийн хугацаанд дуусах бололцоотой ийм төслүүд. Тэгээд бид энэ дээр дахиж ажиллаад, Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллая. Үүн дээр нэг заалтыг зайлшгүй оруулах ёстой юм байна лээ. Энэ цаашдаа ер нь гадаад зээл, тусламжийг энэ Хөгжлийн банкаар дамжуулах энэ нөхцөлийг бүрдүүлэх ёстой. Тийм учраас энэ зохицуулалтыг хийж чадвал цаашаа Хөгжлийн банк өөрөө гадаад зээлийг хариуцаад ингээд ажиллах бололцоо бүрэн бүрдэх болов уу гэж харж байгаа.

Таны сая хэлсэн эдийн засгийн өсөлт бид хамгийн боломжит хэмжээнд эдийн засгийн өсөлтийг таамаглаж байна. 6,8 хувь гарсан энэ жилийнх, үүнээс ХАА салбар 2,9 нэгж хувийг бүрдүүлсэн юм байна лээ. Тэгээд мэдээж яах вэ бусад салбартай харьцуулахад ХАА-н салбар өөрөө эрсдэлтэй салбар, хэлбэлзэж байдаг. Энэ цаг ууртай мэдээж холбоотойгоор ингээд хэлбэлзэж байдаг учраас энэ их эрсдэлтэй

салбар. Гэхдээ өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлуудаа мэдээж өргөжүүлнэ. Сая тариалангийн цаг хугацаатай холбогдуулаад шатахууны хангамжийг ч гэсэн нэмэгдүүлээд, шийдвэрлээд асуудлуудыг шийдээд явж байгаа гэдгийг танд хэлье. Үүн дээр Энхбаяр сайд нэмж хариулах байх.

Тэтгэвэр тэтгэмжтэй болон цалин хөлстэй холбоотой асуудал дээр бараг 30 гаруй хууль байна энэ цалин хөлсийг тогтоож байгаа. Их Хурлаар хууль гаргаад цалин хөлс тогтоочихдог. Их Хурлын Тамгын газар нэг өөр цалинтай, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /ЗГХЭГ/ нэг өөр цалинтай, төрийн албан хаагч ийм ялгаатай цалинтай ийм байдалтайгаас болоод Их Хурлаар төсөв нэмлээ гээд сая багш, эмч нарын асуудал шиг юм болно. Юутай ч богино хугацаанд багш, эмч нарынхаа асуудлыг шийдвэрлэсэн хэдий ч төсөв дээр их ачаалал ирж байгаа. Тэгэхээр бид энэ гадаад зээл, тусламжийн хуулиас гадна энэ цалин хөлсийг нь шийдвэрлээд байгаа 30 гаруй хуулийг өөрчлөх шаардлага байна гэж харж байна. Хэрвээ төсөв тодотгосон тохиолдолд энэ цалин хөлсний асуудлыг дагалдуулаад өргөн барина. Тэтгэвэр тэтгэмжийг индексжүүлж нэмэх, инфляцтай уялдуулж нэмэх энэ хууль, эрх зүйн орчноо тодорхой болгоно. Тэгж байж энэ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмэлт асуултад Сандаг-Очир сайд нэмж хариулъя. Энхбаяр сайд, Шадар сайд Энхбаяр, Жадамбын Энхбаяр гишүүн сайд хариулна.

Ж.Энхбаяр: Дэлхийн улс орнууд эрчим хүч, хүнс 2 дээрээ л төвлөрөн анхаарч байна. Хамгийн их инфляцад мэдрэг, нийгмийн амьдралд нөлөөлж байгаа 2 том салбар. Манай ХАА Монгол Улсын ДНБ-ий 11 хувь буюу 8 их наядын үйлдвэрлэл явуулж байгаа, хамгийн их ажлын байр бий болгож байгаа, хамгийн баялгийн хуваарилалтыг олонд хүргэж чадаж байгаа ийм салбар. Өнгөрсөн хугацаанд ЗГ-аас явуулсан бодлогууд амжилттай хэрэгжсэн. Сүүлийн 15 жилийн хугацааны хамгийн өндөр өсөлт буюу ХАА-н салбар өсөлт 37 хувийн өндөр өсөлтийг үзүүлсэн. Энэ нь УИХ-аас баталсан энэ зорилт хөтөлбөрүүдийн үр дүн. Олон арван шинэ үйлдвэрүүд, шинэ бүтээгдэхүүнүүд бий болсон. Энийгээ улам баталгаажуулах үүднээс Евроазийн зах зээл рүү гарах чөлөөт худалдааны хэлэлцээрийг баталсан. Энэ бол энэ салбарыг бодоод цаашид шинэ зах зээлд гарах.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ Евроазийн зах зээл манай ХАА, хөнгөн үйлдвэрийн салбарт их томоохон бодлогын дэмжлэг болно буюу шинэ зах зээл тэлнэ. Нөгөө талаараа хөдөө орон нутагт ажиллаж амьдарч байгаа хөдөөгийн иргэдийн орлогыг энэ хөтөлбөрүүд бодитой дэмжсэн байна. Хөдөөгийн өрхүүдийн орлого 10-аас дээш хувиар өссөн. Сүүлийн 2 жил мал бүхий иргэдийн орлого хамгийн өндөр өсөж, мал, махны үнэ, ноос ноолуурын үнэ өссөн. Хөдөө орон нутагт амьдарч байгаа иргэдийн албан хаагчдын цалин 20-оос 40 хувийн нэмэгдэл авч байгаа. Энэтэй холбоотойгоор орон нутгийн амьдрал нэлээн эерэг өөрчлөлтүүд гарч байна. Цаашдаа энэ хүнсний хувьсгал, атрын 4 дүгээр аянаа улам үргэлжлүүлэх, үүн дотроо малын эрүүл мэндийн асуудлыг онцгой анхаарах чухал болж байна. Ингээд чөлөөт хэлэлцээрүүд гадаад зах зээлийг дэмжих, урамшуулах, тэрийг гадаад худалдаанд учирч байгаад саад тотгорыг арилгах ийм бодлогын арга хэмжээнүүдийг үе шаттай энэ чөлөөлье гэсэн ЗГ-ын бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж байгаа.

Б.Пүрэвдорж: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Хэзээ 10, 15 мянга гэдэг зорилтдоо хүрэх вэ гэдэг дээр ерөнхий төсөөллийг сонсьё. ХАА-н салбарын хувьд хэт их ийм савлагаатай байгаад байна. Уур амьсгалын өөрчлөлтийг бид яаж ч чадахгүй, зудын эрсдэлийг яаж ч чадахгүй гэж байж болохгүй байх гэж бодож байна. Тэгэхээр энэ эрсдэлийг ер нь цаашдын төсөөлөлдөө яаж тусгаж байна вэ гэдэг ийм тодорхой асуулт асуугаад байгаа? Тэгээд ерөнхий хариулаад байна. Жилдээ л бид 8, 9 саяар нь ингээд малаа алдаад байхаар яах вэ малчны тэр чинь мал хоргодож байгаа асуудал биш байгаад байна шүү дээ, энэ чинь бүх л дүнгээрээ ДНБ-д үзүүлж байгаа асар их хэмжээний бид тодорхой энэ боломжийг эрсдэлийн улмаас ингээд алдаад байна. Тэгэхээр энэ эрсдэлийг хамгаалах тодорхой хөтөлбөрүүдээ бүтэн явуулж чадахгүй байна. Тэгээд энийг ингээд цаашдаа ерөнхийдөө ингээд тусгасан тодорхой тоо баримт, мэдээллүүд байвал тэрийгээ яг тодорхой хэлж өгөөч л гэдэг ийм асуулт байгаад байна л даа.

Б.Пүрэвдорж: Зочин танилцуулъя. Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн 1 дүгээр курсийн багш, оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаатай болон Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Шадар сайд Жадамбын Энхбаяр хариулъя.

Ж.Энхбаяр: 25 оны гүйцэтгэлээр ДНБ 1 хүнд ноогдох орлого 7380 ам.долларт хүрсэн. Бид 300 доллар дээрээс гараанаас эхэлж байсан бол өнөөдөр 7380 ам.долларт хүрсэн, дундаж хөгжилтэй орон болсон. Энэ чамлахааргүй их том өндөр амжилт. 29 онд гэхэд бид нэг хүнд ноогдох орлогыг 10 мянган долларт хүрэх ийм зорилттой ажиллаж байна. Энэ бүрэн биелэх бололцоотой гэж үзэж байгаа. Нэг хүнд ноогдох ДНБ 10 мянгад хүрснээр амьдралын чанарт эрс өөрчлөлт гарна. Монгол Улсын зээлжих зэрэглэл дахин 2 түвшнээр ахих, үүнтэй холбоотой зээлийн хүү буурах, цалингийн өсөлт багаар бодоход өнөөгийн түвшнээс 60 хувиар өсөх, өрхийн орлого нэмэгдэх, гадаадын шууд хөрөнгө оруулалт 3 дахин өсөх, дэд бүтэц сайжирна гэсэн ийм тооцоонууд хийгдэж байгаа.

Эрсдэлтэй холбоотойгоор ХАА-н салбарт хэрэгжүүлсэн бодлогын хүрээнд бид тэжээлийн аж ахуй.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Тэжээлийн үйлдвэрлэл, тэжээлийн таримлыг нэлээн нэвтрүүлсэн, туршсан, үр дүн их сайн гарсан. Нэг үеэ бодвол тэжээл тарьдаг, зөвхөн байгалийн бэлчээрт найдахаа больсон, таримал бэлчээрийн ургамлууд олон газар таригдаж байна. Нөөц сайн бүрдэж байна. Сүүлийн 2 жилийн байдлаар гэхэд үндсэндээ малын зүй бус малын хорогдол эрс багасчихлаа шүү дээ. Өмнө нь сая саяар гардаг байсан бол одоо тэжээдэг болчихсон, тэжээгээд аваад гардаг болчихсон. Нөгөө тал экспортыг дэмжсэнтэй холбоотойгоор мал, махан бүтээгдэхүүний экспорт сүүлийн 3 жил 300 сая доллароос дээш гарлаа. Энэ нь хөдөөгийн иргэдийн орлого, мал бүхий иргэдийн амьдралыг тэтгэсэн их том бодлого байлаа. Мөн түүхий эдийн боловсруулалтын түвшнийг сайжруулсан. Ялангуяа ноолуур дээр хийсэн бодлого үр дүнд хүрч, ноолуурын үнэ дотооддоо үнэ өндөр тогтдог, эцсийн бүтээгдэхүүнээ дотооддоо боловсруулдаг ийм чадавх нэмэгдсэн гэх мэтийн үр дүнгүүд байна.

Б.Пүрэвдорж: Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн алга байна. Жадамбаагийн Баясгалан гишүүн алга байна. Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн алга байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн алга байна. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн алга байна. Буланы Бейсен гишүүн асуулт асууя.

Б.Бейсен: Монгол Улсын нэгдсэн төсвийн 27 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 28, 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй танилцлаа. Энэтэй холбогдуулан 2 асуулт асууя гэж бодож байна. Ялангуяа эрүүл мэндийн салбарын санхүүжилт Эрүүл мэндийн даатгал /ЭМД/-ын сан гэж даатгалын салбарын өр зээлийн асуудлыг энэ 27 оны нэгдсэн төсвийн төсөлд яаж тусгасан бэ? Он дамжсан өр зээлүүд чинь байгаад байх юм. Зарим эмнэлгүүд дээр чинь 17, 20 тэрбум хүртэл, улсын 2 дугаар эмнэлэг 17 тэрбум, Эх, хүүхдийн эрүүл мэндийн байгууллага 7-гоос 9 тэрбум, аймгууд 3-аас 4 тэрбумын өртэй. Энийг яагаад ил болгохгүй байна вэ? Жил болгон дамжаад явж байдаг эрүүл мэндийн салбар чинь элгээрээ хэвтчихлээ. Хэвтэж байгаа өвчтөнүүд бүгд гаднаас эм авчирч байна.

Цалин нэмлээ гэсэн. Гэтэл 30 хувь нэмлээ гэсэн чинь илүү цагийн эмнэлгийн салбарын ажилчдын илүү цагийн хөлсийг хуучин цалингаар нь тооцоод, татварыг авахдаа нэмэгдсэн цалингаар нь аваад байх юм. Мөн 33 хувийн эмнэлэг байгаа, яг улсын эмнэлэгтэй адилхан ЭМД-ын сангаас санхүүждэг. 3 саяас 30 сая хүртэл төлбөр авдаг мөртөө тэгээд нөгөө эмнэлгийн салбарын ажилчид нь тийшээгээ явчхаад байна цалин өндөр гээд. Энийг болиулж байж улсын 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, хотын 9 дүүргийн эмнэлэг, хотын клиник эмнэлгүүдийг босгож ирэхгүй бол ер нь хүнд байдалд орчихлоо. Энэ талаар ямар бодлого барьж байна вэ, энэ төсвийн төсөөлөлдөө хэдийг нэмж, өр зээлийг хаах талаар ямар бодлого барьж байна вэ?

2 дахь асуудал Ерөнхий сайд та Евразийн холбооны хуралд яасан, худалдааны асуудал тэр баруун аймгуудын чиглэлээр Улаанхус, Сагсай-Улаанхус-Цэнгэл-Даянгийн чиглэлийн зам өнгөрсөн жил Аубакир гишүүн бид хэд хамтраад 19 тэрбумыг Аубакир гишүүн санаачлаад тавиулсан. Гэтэл энийг төсөв хүрэлцэхгүй байна гэж байгаад 16 тэрбумыг хасаад, 3 тэрбум болчихсон байх юм. Баталчихсан төсвийг ингээд Төсвийн хууль зөрчөөд яагаад ингээд хасчихдаг байна энэ талаар мэдээлэл авъя? Дараа тодруулъя.

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд Учрал хариулна.

Н.Учрал: Энэ асуудлын дараа улсын жилийн төлөвлөгөө мэдээж хэлэлцэнэ. Тэр үеэр яг хийгдэх ажлуудын талаар салбар болгоноор дэлгэрэнгүй ярих бололцоо үүснэ гэдгийг хэлье. Энэ цалин хөлсний асуудлаар миний ойлгосноор Их Хурал төсвөө нэмэгдүүлээд баталсан, ЗГ-ын тогтоолоор болохоор эмч нарын цалинг 2 янзаар тогтоосон байсан. Нөгөө цалин хөлс нэмэгдлүүдийг нь хуучин цалин дээр нь бодоод, хуучин цалин дээр нь нөгөө нэмэгдлийг нь тооцоод, шинэ цалин дээр нэмэгдлийг нь бодоод, нөгөө хуучин цалин дээр нь болохоор нөгөө 30 хувь нэмэгдүүлэхийг нь бодоод ингээд эхлэхээрээ эмч, эрүүл мэндийн салбарынхан 2 цалинтай болсон гээд байдаг нь ийм учиртай юм байна лээ. Миний хуучин цалин дээр Их Хурлаас миний нэмсэн цалинг бодсон. Нөгөө нэмэгдлүүдийг болохоор шинэ цалин дээр бодсон. Ингээд 2 цалинтай болсон. Ингээд Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам ЗГ-т энэ тогтоолынхоо төсөлд өөрчлөлт оруулахаар оруулж ирсэн. Ингээд ЗГ-ын тогтоол гараад, эмч, багш нарыг нэг цалинтай, тухайн цалин дээрээ

нэмэгдсэн цалин дээрээ цалин хөлс бусад нэмэгдлүүдийг нь тооцдог болгосон. 5 дугаар сарын 13-наас яг эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдын цалин хөлс нэмэгдээд явна.

Тэгэхдээ энийг зөвхөн төсвөөс шийтгэх бололцоо байхгүй, тавьсан төсөв нь хангалттай хүрэлцээтэй биш. Тийм учраас бид энэ эрүүл мэндийн салбарт тодорхой шинэчлэлүүдийг хийх ёстой гэж үзээд, би өөрөө эрүүл мэндийн салбар дээр очиж ажилласан. ЭМД-ын үндэсний зөвлөлийн гишүүдтэй саналуудыг нь солилцоод, ЭМЯ хурлаа хийсэн гэж надад мэдээлэл өгсөн байна. Тэгэхээр даатгалын санхүүжилтийн тогтолцоог бүрэн эргэж харж байгаа. Жишээ нь тэр фитнес төвд даатгалаас мөнгө өгдөг, яг нэн шаардлагатай байгаа санхүүжилтийг өгч чаддаггүй эдгээр асуудлууд байна. Тийм учраас бид ЭМД-ын санхүүжилтийн тогтолцоог илүү нүдээ олсон болгоё гэдэг зорилгоор ер нь 150 орчим төгрөг төсөвт ачаалаад ингээд цалинг нэмэх бололцоо бүрдэж байгаа юм.

Мөн эмийн жагсаалтыг шинэчлэх ажил хийгдэж байна. Бараг 260 гаруй эмийг жагсаалтаас хасаж байгаа. Яг ард түмний хэрэглэдэг эмийг л жагсаалтад бичнэ. Тэрнээс биш хүн дандаа хэрэглэдэггүй юу гэдэг юм Урсофальк (Ursofalk) гэдэг эм дээр 10 тэрбум төгрөг тавьчхаад, өвчин болгонд аваад шахаад байж болохгүй юм байна лээ. Түүнээс ард түмний хэрэглэдэг эмүүдийг бичье, тэгж байж нэг өвчтөнд нь ноогдох.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж хариулъя.

Н.Учрал: Тэгээд гол нь энэ эрүүл мэндийн салбарын онцлог юу вэ гэхээр боловсролын салбараас илүү ялгаатай нь өөрөө шимтгэл төлж байгаа, иргэний оролцоо өндөртэй. Тэгэхээр даатгалын санхүүжилтээ зөв болгож чадвал, эмийн жагсаалтаа шинэчилж чадвал зөвхөн төсвөөс гээд байхгүйгээр нүдээ олсон шийдвэрүүд байж болох юм байна лээ. Жишээ нь нэг өвчтөнд оногдох зардлыг нэмэгдүүлснээрээ энэ анхан шатлалын эмнэлгүүд дээр, ялангуяа энэ өрхийн эмнэлгүүд дээр нөгөө ачаалалгүйгээр хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх бололцоо одоо бүрдэж байгаа юм. Нэг өвчтөнд ноогдох санхүүжилтийг нэмэгдүүлэх шийдвэрийг гаргаад ингээд явж байна. Ингэснээрээ өрхийн эмнэлгүүд анхан шатын эмнэлгүүд дээр хүртээмж өмнөхөөсөө хамаагүй их нэмэгдэнэ. Тэгээд ингэснээр үүний үр дүнд эрүүл мэндийн салбар хүртээмжтэй ажиллах бололцоо бүрдэнэ. Үүнийг зөвхөн энэ санхүүжилтээр нь шийдвэрлэх бололцоотой юм байна лээ.

Б.Пүрэвдорж: Буланы Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Дарга, Их Хурлын дарга энэ илүү цагийн хөлсийг эмч нар өдөр шөнөгүй ажиллаад хөдөлмөрлөж байгаа юмыг чинь хуучин цалингаар нь бодоод, татварыг авахдаа нэмэгдсэн цалингаар нь авахаар чинь ямар ч нэмэгдсэн юм болохгүй энэ дээр анхаарч үзнэ үү 1 дүгээрт.

2 дугаарт Сангийн яамныхнаас асуух асуулт байна. Эмнэлгийн урсгал зардал эмийн төсөв хассан байх юм. Энэ чинь хөдөөгийн хувьд алсын дуудлагын төсөв, эмийн төсөв хаслаа гэдэг чинь маш хүнд асуудал байгаа. Энийг яагаад хассан бэ? Одоо энэ 27-ны төсвийн төсөлд нэмж оруулсан уу?

Б.Пүрэвдорж: Хэн хариулах юм бэ? Загджавын Мэндсайхан сайд хариулъя.

З.Мэндсайхан: Бейсен гишүүний асуултад хариулъя. Тэр Баян-Өлгий Сагсай-Улаанхус-Цэнгэл гээд Алтай таван богд руу чиглэсэн нийтдээ 89км замын асуудал та асууж байх шиг байна. 2 үе шаттай хэрэгжиж байгаа. Эхнийх нь Өлгий-Сагсай, Улаанхус-Цэнгэл сумын хатуу хучилттай авто замын дуусгал 66км, энэ дээр энэ жил 16 тэрбум төгрөг санхүүжих дүнгээр тавьсан. Энэ замын нийт өртөг 193 тэрбум. Өлгий, Сагсай, Улаанхус, Цэнгэлийнх нь үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь 21 тэрбум тус тус суусан байгаа. Энэ дээр ямар нэгэн төсөв батлагдсанаас хойш хассан асуудал байхгүй. Тэр эмнэлгийн асуудлаар манай Төрийн нарийн нэмээд хариулчих уу?

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон, нэрээ хэлээд, албан тушаалаа хэлээд хариулаарай.

Б.Анар: Сангийн яамны ТНБД Анар. Бейсен гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн салбар, эмнэлгийн төсвийг ерөөсөө хассан асуудал байхгүй. Өнгөрсөн оны зарим нэг санхүүжээгүй зардлуудыг энэ он гараад 55 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг хэвийн олгосон байгаа. Ямар нэг өөр байдлаар төсвөөс хассан, сүүлийн жилүүдэд ерөөсөө эрүүл мэндийн салбарын төсвөөс хассан, эмнэлгийн санхүүжилтийг хасаж бууруулсан тийм асуудал байхгүй байгаа.

Б.Пүрэвдорж: Буланы Бейсен гишүүн нэмж тодруулъя.

Б.Бейсен: Үгүй ээ энэ буруу мэдээлэл өгөөд байгаа юм уу, би ЭМЯ-наас очоод асуусан. Эмийн төсөв урсгал зардал гэдэг дотор алсын дуудлагын бензин шатахууны юу байдаг байхгүй юу. Тэрийг хассан, та нар яагаад мэдэхгүй байдаг юм. Сангийн яам хассан гээд хэлсэн. Эрүүл мэнд яамныхан байна уу? Би санхүүгийн албанаасаа очоод асуусан. Одоо хүрэлцэхгүй улсууд чинь гаднаас эм авчирч байна 1 дүгээрт. Бензин шатахуун алсын дуудлагад ар гэрийнхэн нь бензин хийгээд явж байна шүү дээ. Та нар харж үзээч энийг.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн 9Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Тогтмолын Мөнхсайхан гишүүн алга байна. Батжаргалын Заяабал гишүүн алга байна. Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу. 3 асуудал тодруулах гэсэн юм. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн асуудлаар гэсэн үг. Эрүүл мэндийн өвчний хяналт сэргэлтийн төв гээд манайх тушаал гаргаад саяхан байгуулагдахаар болж байгаа гэсэн. Үүний хүрээнд орон нутагт хэд хэдэн төвийг дахин юм уу, эсвэл шинээр зохион байгуулах ажлууд яригдаж байгаа. Нөгөө талд аймаг, дүүрэг болгонд эрүүл мэндийн төв эмнэлэг, нэгдсэн эмнэлэг энэ тэр гэж байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр ямар төсвийн зохицуулалт, яаж тусгагдсан юм бэ гэдэг талаар? Тэгээд энэ нь хуучин төвтэйгөө ямар уялдаатай байж ажиллах юм, эсвэл нийлэх юм уу, тусдаа байх юм уу гэдэг дээр тодруулж мэдээлэл авъя?

2 дугаарт нь махны үнэ бүүр үнэхээр бүүр тэнгэрт хадаж байна л даа. Зарим айл мах худалдаж авах боломжгүй болж байх шиг байна. Тэгэхээр энэ дээр ер нь ямар бодлого барих юм бэ? Цаашдаа яах юм бэ, ямар арга хэмжээг төлөвлөж байгаа гэдэг асуудал байна? Тэгээд энийг нэлээн ойлгомжтой мэдээллийг иргэдэд өгөх хэрэгтэй.

3 дугаарт нь хөгжлийн, энэ ажилгүйдлийг бууруулахтай холбоотой ямар ажил хийгдэж байгаа юм бэ? Тэгээд тэр дотор нь нөгөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон асран хамгаалагчдыг ажилтай болгох, хөдөлмөрийн уян хатан нөхцөлтэй ажлын байр бий болгоно энэ тэр гэсэн зохицуулалтууд ярьж байсан өнгөрсөн жил, тэр маань юу болж таарсан бэ? Тэр мэдээллүүд нэгдсэн мэдээлэл дээр алга байна л даа. Тийм болохоор би тодруулах гээд байгаа юм. Энэ 3 асуудлыг тодруулаад, тэгээд дахиад асууна шүү.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. 2026 оныг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зүгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгож зарласан. Ингээд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дээрээ 106,6 тэрбум төгрөгийн төсвийг үндэсний зөвлөлөөрөө батлуулаад ажиллаад явж байгаа. Энэ маань хөгжлийн бэрхшээлтэй иргэд төдийгүй нийт нийтээрээ манай Монгол Улсын ахмадууд, эмэгтэйчүүд, залуучууд ерөөсөө хөдөлмөр эрхэлье л дээ л гэж байгаа юм. Тийм учраас таныг хөдөлмөр эрхлэхэд бид дадлагажуулах, ажлын байран дээрээ дахин мэргэшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй айлын эцэг эхийг хөдөлмөр эрхлэх чадвартай бол хөдөлмөр эрхлүүлье. Харин асаргаанд байгаа хүүхдийг нь бид төрийн зүгээс орон байр, тэр сургалт, хөтөлбөр юмаар нь хангаж өгөөд, эцэг эхийг нь хөдөлмөр эрхлэх боломжийг хангах үүднээс бид өнөөдөр 2 ч дүүрэг дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нөхөн сэргээх төв бариад эхэлсэн, 2027 онд ашиглалтад орно. Хэдий хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асраад гэртээ байж байгаа ч гэсэн эцэг эх нь нийгэмд гараад, хамт олон дунд ороод, хөдөлмөр эрхлэх хүсэл зорилго нь илүү байдаг. Энийг хүүхдийн асаргааг нь төр хариуцаад, хувийн хэвшил, төр, хувийн хэвшлийн түншийн хүрээнд, төрийн бус байгууллагууд хамжиж хариуцаад, нөгөө эцэг, эх 2-ыг нь хөдөлмөр эрхлүүлье л гэдэг ийм бодлого бариад явж байгаа.

Тийм учраас бид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дээр 106,6 тэрбум төгрөгийг нийтээрээ хөдөлмөр эрхлэхэд зориулаад бүхий л залуучууд, эмэгтэйчүүд, ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дахин сургах, мэргэшүүлэх, хөдөлмөрийн ажлын байранд гараад мэргэжилтэй болгож очихын тулд өнөөдөр 2 ч мэргэжил сургалтын үндэсний үйлдвэрлэлийн төв ажиллаж байна. Энэ хүрээнд маш олон төрийн бус байгууллагууд хамтарч ажилладаг. Харин одоо нэг гацааг гаргах ёстой зүйл маань тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн агентлагуудаар явдаг энэ тендерийн асуудлыг бид нэг жил яваад л хаядаг биш, нэг жил тендер аваад, нөгөө айлын 10, 20 хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүмүүжүүлээд, нөхөн сэргээгээд явж байгаа төрийн бус байгууллага /ТББ/ маань дараа жил би энэ тендерээ авч чадах болов уу, би энэ түрээсэлчихсэн байраа, энэ цалин өгөөд авч байгаа багш нараа би цалинжуулаад явж чадах болов уу гэсэн ийм сэтгэл зүйн дарамтгүйгээр болгоод бид магадлаад, тогтвортой 4-өөс 5 жил тэр айлын хүүхдүүдийг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хүмүүжүүлээд, нөхөн сэргээх үйл ажиллагааг нь явуулдаг энэ үйл ажиллагааг тогтвортой, чадвартай болгохын тулд бид зөвхөн нэг жил биш 4-өөс 5 жил магадлаад ажиллуулах ийм зорилт бариад ажиллаж байгаа.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон, хэн хариулах вэ? Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Махны үнэ энэ инфляцад нөлөөлж байгаа. Гэхдээ аймаг, орон нутаг махаа нөөцөлдөг, тэгээд орон нутгийн түвшинд энэ нөөцөлсөн махаа хуваарилах энэ асуудлаа шийдвэрлэх хэрэгтэй. Мэдээж бид биржээ дэмжинэ шүү дээ, ХАА-н биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх бүх талын арга хэмжээнүүдийг авна. Махан дээр ер нь орон нутгууд өөр өөрсдөө махаа нөөцөлж байгаа учраас орон нутгийн түвшинд шийдвэрлэх бололцоотой. ЗГ-ын зүгээс бид энэ ХАА-н бирж дэмжих, бусад асуудлуудыгаа анхаарч явах болно. Махан дээр үнэ өсөөд байгаа нь мэдээж тэр 24 оны тэр ган, зудтай холбоотой үнэ өсчихсөн юмнууд байгаа. Гэхдээ энэ дээр би захиргааны арга хэмжээ авч, махны үнийг хүчээр барина гэдэг буруу арга хэрэгсэл гэж үзэж байгаа. Тийм учраас энийг орон нутаг нөөцөөрөө шийдэх ёстой.

Б.Пүрэвдорж: Саранчулуун гишүүн нэмж тодруулъя.

О.Саранчулуун: Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн асуудал 3 дахь асуултынхаа хариуг авсангүй.

Б.Пүрэвдорж: Түрүүн би Бейсен гишүүний асуултад хариулсан даа. Индрийн 4 дүгээр микрофон. Сангийн яамны ТНБД Анар.

Б.Анар: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Сангийн яамнаас хуваарилалтыг эрүүл мэнд, хуваарилалтыг бол Эрүүл мэндийн яам /ЭМЯ/ өөрөө хийж байгаа. Сангийн яамнаас бөөн дүнгээр санхүүжилтийг тухайн төсвийн ерөнхийлөн захирагч руу шилжүүлдэг. Эмчийн нэмэгдлийг, цалингийн нэмэгдлийг залруулсантай холбоотойгоор нөгөө үндсэн цалингаас тооцож байгаа нэмэгдэл нэмэгдэж байгаа. Тэгэхээр харин ч уул нь эмнэлгүүдэд очиж байгаа энэ зардлын хуваарилалт нэмэгдэж очиж байх ёстой. Доторх хуваарилалтын асуудлыг ЭМЯ төсвийн ерөнхийлөн захирагч өөрөө хариуцдаг гэдгийг хэлье. Одоо бол нөгөө төсвийн хүрээ хэлэлцэж байгаа учраас энэ нарийн зардлуудыг одоо ярихгүй. Өр төлбөрийн асуудлуудыг 27 оны төсөв хэлэлцэх үедээ нарийн дэлгэрэнгүй ярих боломжтой байгаа.

Б.Пүрэвдорж: Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Хүний хөгжлийн чиглэлээр эрүүл мэнд, боловсролын салбарт өнгөрсөн хугацаанд хамгийн их түлхүү хөрөнгө оруулалт, гадаад зээл, бодлогын арга хэмжээ авагдсан. Багш, эмч нарын цалин, нийгмийн асуудлыг иж бүрэн шийдвэрлэж дууссан. Бусад бүхий л салбараас онцгойлон анхаараад л ингэж дэмжиж байгаа. Эрүүл мэндийн салбарт гэхэд одоо 1,6 их наяд төгрөгийн гадаадын зээл, хөтөлбөрүүд амлагдаад байж байна. Одоо ашиглаж чадаагүй эх үүсвэр нь 1,5 их наяд байж байна. Энэ дотор эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1, 2 дугаар үе шатыг идэвхжүүлэх шаардлага байна. Гэтэл саяын энэ Гадаад зээлийн ашиглалтын хууль унасантай холбоотойгоор ийм мэтчилний бүхий л бусад салбарыг хамарсан гадаад зээлийн ашиглалтын хугацаа хойшлоод, бид энэ эх үүсвэрийг нь түгжсэний төлөө.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Тодруулчихсан шүү дээ. Саранчулуун гишүүн нэмж тодруулъя.

О.Саранчулуун: Баярлалаа. Яах вэ хөдөлмөр эрхлэлтийн асуудал болон ажилгүйдлийг бууруулахтай холбоотой улсын төсөв тооцооллыг хийхдээ хөгжлийн

бэрхшээлтэй юм уу, эсвэл хүүхэдтэй эцэг эхчүүдийн оролцооны жинг ер нь тооцож боддоггүй юм шиг ийм төсөв харагдаад байдаг байхгүй юу. Тэр ямар нэгэн бэрхшээлтэй байсан ч гэсэн хүн бол нөгөө ажил олгогч байж болно, бүтээгч байж болно. Тэр талаас нь дэмжиж, энэ улсын төсөв тооцоолол дээр жижигхэн ч гэсэн энэ чинь нэг ийм индекс тооцоолол тэдэн хүн ажлын байртай болно, ажилд орно гэдэг тооцоололтой юмыг уул нь би сонсмоор байгаа юм.

2-т гэвэл энэ эрүүл мэндийн, бид ингээд улсын төсөв дээр ярихдаа том, том мөнгөнүүдийг багц багцаар нь ярьдаг. Тэгэхдээ бид дотоод нөгөө менежментийг аягүй бага хөнддөг юм шиг санагдаад байгаа юм. Жишээлбэл эрүүл мэндийн салбар дээр харахлаар эмнэлэг барихдаа бид 300 тэрбумыг улсын төсвөөс төлөвлөж болж байгаа, эрүүл мэндийн боловсрол болохоор 3 тэрбум төгрөг байгаа байхгүй юу.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Тийм, 2027 онд нийт 21 аймгийн, 21 аймаг, 9 дүүрэгт хэрэгжих хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээнд нийтдээ 2963 иргэнийг хамруулахаар төлөвлөсөн 2027 онд шүү дээ. Тэгээд бусад үйл ажиллагаанд хамруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. Энэхүү арга хэмжээнд бид 2027 оны улсын төсвийн төсөлд шаардлагатай 11,4 тэрбум төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжих сангаас санхүүжүүлнэ гээд бид нөгөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ хөдөлмөр эрхлэх энэ бололцоог нь зөвхөн Улаанбаатарт биш, 21 аймагт, 9 дүүрэгт ний нуугүй хэлэхэд хөдөө орон нутаг, алслагдсан сумууд дээр байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань хаягдаад байдаг. Улаанбаатар хотыг бодвол илүү хүртээмж муутай, янз бүрийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдаж чаддаггүй. Тийм учраас бид 27 онд 21 аймаг, 9 дүүрэгт ингээд ажиллахаар төсөвт саналаа өгсөн байгаа.

Б.Пүрэвдорж: Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууна.

Ж.Баясгалан: Бүгдээрэнд нь энэ өдрийн мэнд хүргэе. 2 асуулт байна. 1 дүгээрт нь ер нь нийгмийн халамж гэдэг аливаа улс оронд зайлшгүй байдаг. Тэгээд өнөөдөр манайд хэрэгжиж байгаа Нийгмийн халамжийн тухай хууль хүн амын өсөлтийг дэмжих, гэр бүлийн хөгжлийг дэмжих агуулгууд бүгд байгаа. Гэтэл яг Халамжийнхаа хуулиар олгогдож байгаа ер нь нийт төсвийн 70 хувь нь өөрөө яг энэ халамжийн биш, хүн амын бодлогод чиглэгдсэн байдаг тийм ээ. Хүүхдийн мөнгө, тэгээд дээр нь жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 нас хүртэлх хүүхэд асарсны тэтгэмж, эх, хүүхдэд чиглэсэн үйлчилгээнүүд нь 70 гаруй хувь нь болчхож байгаа юм. Үлдсэн 30 хувь нь халамж руугаа явж байдаг. Тэгэхлээр энэ халамж хүн рүү чиглэсэн энэ 2 үйлчилгээгээ хэзээ салгах вэ? Энэ салгаагүйгээс болоод нийт төсөв маань ерөөсөө Монгол Улсын нөгөө халамж хавтгайрсан гэдэг гол ярианы сэдэв энэ болдог. Халамж хавтгайрсныг нь хүртээд байгаа хүмүүс нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэгээд дээр нь ахмад настан юм шиг санагдаад байдаг. Ингээд нөгөө хүмүүс маань л Монгол Улсын төсвийн хамаг мөнгийг хэрэглээд байгаа юм шиг ийм нийгэмд ойлголт төрөөд байгаа юм. Тэгэхлээр хүн амын бодлогод зориулж байгаа энэ төсвөө хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон тусгай тэр нөгөө яг зорилтот бүлэгт зориулж байгаа энэ хоёрыгоо хэзээ салгах вэ нэг?

2 дугаарт нь энэ Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 28-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилагдах зардлын дээд хэмжээг 27 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 2 тэрбум 823 сая төгрөг, 28, 29 оны төсвийн төсөөлөлд 2 тэрбум 998, 3 тэрбум 170 сая төгрөг гэж тусгахаар заасан байна. Тэгэхлээр энэ нь яг салгаад яг энэ нөгөө зорилтот бүлэг рүүгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүүгээ зориулсан яг энэ дэмжлэг нь мөн үү, эсвэл ерөөсөө хүн амдаа чиглэсэн нь юм уу? Энийг яг тодорхой хэлээдхээрэй.

2 дугаарт төрийн өмчийн компани үйлдвэрийн газруудаас 2025 онд аудитын тайлангаар нийт 8,4 их наяд, тэгээд 648 зөрчил илэрсэн байгаа. Тэгэхлээр энэ дээр 323 зөрчилд нь 5,9 их наядын акт тавьсан байгаа. Тэгээд албан шаардлага, албан шаардлага нь 5,9 их наядад, 619 сая төгрөгийн төлбөрийн акт тавьсан, 152,6 тэрбум төгрөгт хариуцлага тооцуулах ийм шаардлагууд хүргэгдсэн байна. Тэгээд бидний хамгийн сайн мэдэж байгаа нөгөө хамгийн ашигтай ажилладаг ЭТТ компани дээр маань хүртэл энэ 5,3 их наядын асуудал байгаа шүү дээ. Тэгэхлээр энэ дээр гарсан энэ зөрчлүүдэд ямар арга хэмжээ авсан бэ, энийг засаж залруулах талаар ямар арга хэмжээ авах гэж байгаа вэ гэдэг энэ талаар асуулт хариулт авъя гэж бодож байна?

Б.Пүрэвдорж: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Баясгалан гишүүний асуултад хариулъя. Тийм, одоо яг төсөв дээр суугаад явж байгаа зардлын ангилал гэх юм уу даа 2,8 их наяд төгрөг үндсэндээ ирэх жил Монгол Улс маань халамжид зарцуулахаар харагдаж байгаа. Тийм учраас бодлогын яамнаас хүн ам зүйн бодлого руу чиглэсэн, гэр бүлийн хөгжил рүү чиглэсэн зардлуудаа бид Гэр бүлийн хөгжлийн тухай хууль руугаа аваад, жишээлбэл хүүхдийн 1,5 их наяд төгрөг байна тийм ээ, мөн 0-ээс 3 насны хүүхэд эхийн мөнгө гэх зэрэг гэр бүлийн хөгжил рүү, хүн ам зүйн бодлого руугаа чиглэсэн зардлуудаа бид Гэр бүлийн хөгжлийн хууль руугаа авчихаар, яг халамж дээр манай Монгол Улс маань жилдээ 600 орчим тэрбум төгрөг л зарцуулж байгаа. 600 орчим тэрбум төгрөг.

Нөгөө талдаа гаднын экспертүүд хэлэхдээ танай энэ халамжийн зардал чинь өндөр харагдаад байна гээд байдаг. Нөгөө талдаа дэлхийн аль ч улс халамж шаардлагатай байгаа иргэддээ халамжаа өгсөөр л байдаг. Өгөх ч ёстой. Ирэх жилийн 2027 оны улсын төсөв дээр асаргааны тэтгэмж, хөгжлийн бэрхшээлтэй хүний авдаг сар тутмын тэтгэмж энэ тэрийг бид нэмэгдүүлж оруулж ирж санал өгч байгаа. Энэ маань нөгөө талдаа инфляцтай уялдуулж бид нэмэгдүүлэх ёстой. Халамжийн тэтгэвэр авдаг иргэд байдаг ч юм уу тийм ээ. Тийм учраас энэ 2,8 их наяд төгрөг бол ерөөсөө тэр чигтээ халамжийн зүйл биш шүү энэ бол. Гэхдээ одоо яг хуулийн зохицуулалтаар тэгж ойлгогдохоор байгаа. Тийм учраас бодлогын яамнаас 2 хуулиараа сая бид хамгийн сүүлд Халамжийн тухай хуулийн нээлттэй хэлэлцүүлгээ хийлээ. Одоо яг нээлттэй хэлэлцүүлэг явж байгаа учраас иргэд маань, Улсын Их Хурлын гишүүд маань энэ дээр санал өгөх асуудал нээлттэй.

Гэр бүлийн хөгжлийн тухай хууль бүх яамнуудаас саналаа аваад, олон нийтийн хэлэлцүүлгээ хийгээд, одоо ЗГ-аар хэлэлцүүлэхэд бэлэн болчихсон. Энэ бол хүн ам зүйн бодлого, гэр бүлийн хөгжлийн тухай бодлого. Монголын төр одоо байж байгаа 900 гаруй мянган Монголын энэ гэр бүлийг яаж яг бодитоор дэмжих гээд байгаа юм, энэ хүн ам зүйн өсөлт дээр Монголын төр яг яаж анхаарах гээд

байгаа юм, дэлхийн маш олон улсууд маань өнөөдөр ажиллах хүчний эрэлд гарчихсан байна шүү дээ. Өнгөрсөн нэг дэх өдөр би Чехийн Элчин сайдтай уулзлаа. Танайхаас 10 мянган ажиллах хүч авъя. Японыг хар, Европ тэр чигтээ. Тийм учраас бид өнөөдөр энэ төрөлтийг дэмжсэн Гэр бүлийн хөгжлийн бодлогын энэ хуультайгаа уялдуулж өгч явахгүй бол 20 жилийн дараа бид ямар байдалд хүрэх вэ. 2025 онд Франц улс анх удаа нас барсан иргэд нь төрсөн хүүхдийнхээ тооноос илүү гарч л байна шүү дээ. Өнөөдөр бид энэ арга хэмжээг авах ёстой л доо. Тийм учраас бид Гэр бүлийн хөгжлийн тухай хууль дэмжигдээд явсан, бид ЗГ дээр хэлэлцүүлээд оруулж ирнэ. Халамжийн тухай хууль маань одоо олон нийтийн хэлэлцүүлэг явж байгаа. Тийм учраас таны хэлсэн саналыг дэмжиж байна. Ийм ч байх ёстой юм. Халамж нь яг аль юм, нөгөө төрийн хүн ам зүйн бодлого нь аль юм бэ гэдгийг энэ хуулиудаар салгаж өгөхөөр ажиллаж байгаа.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууна. Уучлаарай. Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Баярлалаа. Үнэхээр манай засаглалын хамгийн гол асуудал энэ төрийн өмчийн компанийн засаглалын асуудал болж хувирсан. Энэ өр авлага гинжин урвал, энэ олон жил авлига хулгай, гол асуудал бол ерөөсөө төрийн өмчийн компанид байна. УИХ буюу ард түмний төлөөллийн байгууллагын хараа хяналтаас их хол байна. Төсөв нь орж ирдэггүй, тайлан орж ирдэггүй. Зөвхөн юу орж ирж байна вэ гэхээр та яг аудитын тайлангаас сая хэлж байна. 2025 оны гүйцэтгэлээр төрийн өмчийн компаниуд дээр 5,9 их наяд төгрөгийн өр авлагын асуудал ингэж орж ирж байгаа. Энэ бол Хэрэг эрхлэхийн сайд дээр бичигддэг юм байна төрийн өмчийн хувьцаа эзэмшигч гэдгээрээ. Тэгэхээр одоо төсвийн гүйцэтгэл яригдах үед, аудитын тайлан яригдах үед энэ асуудал илүү тодорхой яригдана.

Б.Пүрэвдорж: Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн 12Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууна.

Ж.Галбадрах: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Ерөнхий сайд маань өмнөх жилүүдийн төсвийг олсны хэрээр үрсэн, их үрэлгэн төсөв байсан гэж ингэж дүгнэж байна. Тэгэхээр энэ 2027 оны хөгжлийн хүрээний мэдэгдэл маань энэ үрэлгэн бус болж чадсан уу, энэ алдаануудыг хэрхэн зассан бэ? Тодорхой жишээ хэлнэ үү гэж хүсэж байна.

Мөн Монгол Улсын хөгжлийн 5 жилийн хөгжлийн төлөвлөгөөг бид саяхан баталсан хагас жилийн өмнө 26-аас 30 оны. Бид салбар салбартаа КPI буюу шалгуур үзүүлэлтүүдийг гаргасан. Би боловсролын салбараа гаргаж байсан. Энд ингээд ДНБ-ий өсөлт хэд байх вэ, инфляц хэд байх вэ, үнийн өсөлт хэд байх вэ гээд энд 9 том тоо маань байж байгаа. Тэгээд энэ тоон дээрээ ингээд тэрэнтэйгээ харьцуулаад харахад ингээд зөрөөтэй, дандаа багассан, буурсан ийм үзүүлэлтүүд байна. Ингэвэл бид 5 жилийн төлөвлөгөө гаргаад байх хэрэг байгаа юу? Энэ 5 жилийн төлөвлөгөөтэйгөө уялдуулах энэ зорилго, зорилт барьж, энийгээ хийж болохгүй юу гэдэг талаас асууя?

Дараагийн нэг асуулт энэ төсвийн хүрээний төслөөс ингээд харахад үнэхээр өмнөх жилүүдээс ийм чанга, нэлээн хатуу энэ төсөв болох нь гэдэг нь ингэж харагдаж байгаа. Тэгээд салбар бүрд хөрөнгө оруулалт багасах юм байна гэж

ойлгож байна. Гэхдээ бид хүнээ хөгжүүлж байж л Монгол Улс хөгжинө. Тийм учраас боловсрол, эрүүл мэнд, хүмүүсийн орон сууцын асуудалд бид энэ оруулах хөрөнгө оруулалтыг энд багасгах уу? Ер нь энэ хэр, мэдээж 27 оны төлөвлөгөөг харж байгаа. Энийг дараагийн асуулт дээр асууна. Энэ багасгах уу, багасгахгүй байх талаар ямар бодлого барьж байгаа вэ гэдгийг асууя?

Дараагийн нэг асуулт сая энэ Баясгалан гишүүн асуучихлаа. Аудитын дүгнэлтүүдийг хэрхэн тусгаж байгаа вэ? Энд ингээд гарч ирж байгаа энэ зөрчлүүд, маш их хэмжээний энэ зөрчлүүдийг бид хэрхэн орлого болгож буцааж авах уу, орлого болгож авахаас илүү энд бол хулгай явагдаад байдаг, тэр хулгай нь энэ аудитын дүгнэлтүүдээр ингээд гараад ирчихсэн байж байдаг. Тэгэхээр энэ зөрчил байсаар байтал тэр нь тэгээд дараа жилүүддээ тийм зүйл нь ингээд үргэлжлээд яваад байдаг төсөл хөтөлбөрүүд нь. Зөрчил гардаг, зөрчлөө арилгаагүй байж дараагийнх руугаа ингээд ороод яваад байгаа зүйлүүд энэ өмнөх, өмнөх төслүүдийг харж байхад ингээд давтагдаад байдаг юм байна. Тэгэхээр энэ дээр бид чинь хяналт шалгалтаа хэрхэн хийх юм бэ? Төсөв гэдэг орлогоо хэр олж чадах вэ, хэр нэмэгдүүлэх вэ, зарлагаа хэр багасгах вэ гэдгээс л бидний төсөв маань үр дүнтэй, ашигтай байх ёстой. Тэгэхээр энэ талаар асуулт асууя нэмэлт. Орлого нэмэгдүүлэх талаар бас л саяын асуулттай холбоотой төрийн өмчийн компаниудаас бүүр тодорхой орох орлогыг хэдэн хувиар нэмэгдүүлж тооцсон бэ энэ төсөвт гэдэг ийм асуултуудыг асууя?

Б.Пүрэвдорж: Жадамбаагийн Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ төсвийн хүрээ үндсэндээ макро эдийн засгийн 9 гол тоог баталж байгаа. Энэ 5 тоо нь таван жилийн үндсэн чиглэлд байгаа. Тэгээд энэ тоонууд үндсэн чиглэлээс төсвийн хүрээ өөрчлөлт орсон байна гэж хөндөж байна. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө хуулиараа 5 жилийг үндэслэж хийгдэж байгаа. Иймд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр гол тоонууд таван жил дээрх энэ зорилтыг хангахад чиглэнэ. Төсвийн хүрээний мэдэгдэл бол дараа жилийн төсвийн орлого, зарлагын тоо, хязгаарыг тодорхойлж байгаа тул өнөөдрийн өнөөдөр байгаа энэ олон төрлийн эрсдэлүүдийн нөлөөллийг нарийвчлан тусгадаг. Иймээс таван жилийн төлөвлөгөө дээр туссан тоон зорилтуудаас зарим үзүүлэлтүүд нь бага, их гардаг. Тухайлбал эдийн засгийн өсөлт 27 онд 5,8 хувь байна гэж бид оруулж ирж байна төсөөлж байгаа. Таван жилийн зорилт маань 6,3 хувь гэж зорилт дээр байгаа. Тэгэхээр энэ чинь жил жилийн онцлог нөхцөл байдал, гадаад, дотоод нөлөөллөөс болоод ингээд 1, 2 функтийн дээр доор орох юм гарна.

Таван жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх том зорилт бол хэвээрээ мэдээж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл бол бид төсвийн орлогын доод хэмжээг тооцоход ашигласан ийм хуульчлах тоо, төсөв бол энэнээс доошоо орж болохгүй орлого ингэж бүрдүүлнэ, энэ дээр сууриалаад зардлыг нь гаргаад өгөөд, өөрөөр хэлбэл төсвийн хүрээний мэдэгдэл бол эрсдэлүүдийн нөлөөг маш сайн тооцож тухайлан ингэж оруулж өгдөг ийм учиртай. Тэгээд энэ тоо зөрснөөр нэг асуудал үүсэх зүйл ердөө биш. Үндсэндээ 5 жилийнхээ том зорилтдоо үндсэн чиглэлдээ багтаад тэр хүрээндээ л явж байна гэсэн үг. Ажлын хэсэг хариулаарай, бусад салбартай холбоотой асуудлууд.

Б.Пүрэвдорж: Боловсролын сайд яасан юм бэ? Нөхөж хариулуулна. Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 28, 29 оны төсөөлөл орж ирж байгаа юм. Эдийн засаг, нийгмийн үндсэн 9 үзүүлэлтийн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тавигдсан тусгай шаардлага хязгаарлалтын хүрээнд харилцан уялдааг нь зохистой байлгах түвшинд орж ирдэг л дээ. Тийм учраас би тооцооллыг холбогдох байгууллагууд нэлээн нарийн хийж, таамаглал төсөөллүүдээ сайн гаргасан байх гэж ойлгож байгаа.

Эдийн засгийн өсөлтийг бид 5,8-аар төсөөлж байгаа юм байна лээ. Гэхдээ эргээд аваад үзэхээр зэрэг Монголын эдийн засгийн өсөлтийг хангадаг ерөөсөө 2, 3-хан салбар л байгаад байгаа шүү дээ. ХАА, уул уурхай, боловсруулах гэсэн энэ 3 чиглэл дээр гол юм нь явдаг. Тэгэхээр өсөлттэй байсан он жилүүдтэйгээ энэ 24 он, 25, 26 оныг харьцуулахаар бууралттай байхгүй юу. Тийм учраас үнээ бид жоохон дэлхийн зах зээл дээрх үнэ өндийх юм байна, тэгээд биет хэмжээгээ өмнөх жилээсээ 5 орчим сая тонноор жишээ нь гол гаргаж байгаа бүтээгдэхүүнээ нэмэгдүүлнэ гээд тооцчихож байгаа учраас энэ салбараас орж ирэх эдийн засгийн өсөлт чинь жоохон дээшлэх ёстой юм биш үү. ХАА-н салбар тал дээр чинь 3 жил дараалсан зудын ард дээр энэ жил нэг жоохон 26 оны төгсгөл дээр нэг жоохон өсөлт гарч ирэх байх. Ер нь жинхэнэ өсөлт нь 27 он дээр л гарч ирнэ. Дам дамаа МАА-н салбарын өсөлт чинь. Газар тариалангийн салбар чинь 25 онд нэлээн сайн уналт авсан. 2 үндсэн шалтгаантай. Нэг нь ган, нэг нь бидний төрийн алдаатай бодлого нөлөөлсөн. Эргээд сэргэлтийнх нь үйл явц бас энэ онтой чинь давхцаад байгаа. Энүүгээр өсөлтийн чинь төсөөлөл ер нь яаж харагдаад байгаа юм бэ гэдэг асуудал байгаа юм.

3 дахь зүйл. Монголын эдийн засгийн их том өсөлт чинь 2011, 2012 онд 17 хувь руу хүрсэн шүү дээ. Тэнд юуны өсөлт байсан гэхээр зэрэг ОТ-н хөрөнгө оруулалт байсан. Тэр 3,5 орчим тэрбум долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байх гэж би ойлгодог. Тэгвэл одоо бид гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлье, үр ашгийг нь дээшлүүлье гээд 200 хэдэн тэрбумаар хязгаарлахаад байгаа юмаа 1,8 их наяд руу хүргэе гээд нэг төсөл дээр гэхэд бодоод явж байгаа. Тэгвэл энэ том бүтээн байгуулалтуудыг чинь дагасан эдийн засгийн өсөлт ямар нөлөө үзүүлэх юм бэ? Тэр тооцоолол ямар юм гарч ирээд байна гээд энэ талаас нь нэг жоохон мэдээлэл юмнууд авмаар байна гэж?

2 дахь зүйл. Хүрээний нэг үндсэн үзүүлэлт бол төсвийн зарлагын дээд хэмжээ байдаг. Тэгвэл бид 26-аас 27 оноо харьцуулаад үзэхээр 3,5 их наядын өсөлт авсан юм билээ. Урсгал зардал талдаа хэдийн төсөөлөл явна вэ, хөрөнгийн зардал талдаа хэдийн төсөөлөл яваад байгаа юм бэ энэ өсөлтийн? Үүнийг нэг тодруулж тайлбар юмнуудыг нь авмаар байна.

3 дахь миний нэг хэлмээр байгаа санаа энэ гадаадын зээл ашиглалтыг улсынхаа хэмжээнд нэлээн энэ хууль, эрх зүйн орчныг нь боловсронгуй болгож, анхааралдаа авч, томоохон үнэлэлт дүгнэлт өгч явахгүй бол болохоо байчихсан юм байна. Одоо Монгол Улсад хэрэгжиж байгаа 78 төсөл, арга хэмжээнд авч байгаа зээлүүдээ аваад үзсэн чинь жилдээ 113 тэрбум төгрөг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэгмөсөн авчих уу? Батжаргал гишүүн нэмж нэг минутаар тодруулъя.

Ж.Батжаргал: Хугацаандаа авч чадаагүй үлдэгдэл зээлийнхээ эх үүсвэрт шимтгэл төлөөд явж байгаа юм байна. Энэ чинь бараг үндсэндээ 640 хүүхдийн 8 сургуулийн мөнгийг бид өөрөө өөрсдийнхөө үйл ажиллагаанд хязгаар тавьчхаад, тэгээд авах ёстой эх үүсвэрээ авч чадаагүйнхээ төлөө хий шимтгэл төлөөд явж байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг хууль яриад гэдэг юм уу, онол яриад тус тусдаа суугаад хэрэггүй. Нэг эх оронд бүгдээрээ амьдарцгааж байна. Эдийн засгийн хөгжлийн яам нь ч тэр, Сангийн яам нь ч тэр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь ч тэр бүгдээрээ нэгдэж, энэ гадаадын зээлийг яаж үр ашигтай ашиглах юм, үнэхээрийн өөрөө өөрийнхөө үйл ажиллагаагаар авсан анхны хөрөнгөө нөхчихдөг төслүүдээ яаж үнэлээд, тэрийгээ төсвийн зардал талдаа гарч байгаа зардлыг нь оруулалгүйгээр авч явах юм тэр Хөгжлийн банкаараа энэ тэр гэдэг юмаа тусгайлсан хуульчилж өгөхгүй бол энэ улс орон чинь хөгжихгүй нь. Энэ Төсвийн тогтвортой байдлын.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд Учрал хариулна.

Н.Учрал: Би энэ Төсвийн тогтвортой байдлын хуулийг маш цаг үеэ олсон, зөв хууль гэж үздэг. Тийм учраас энэ тусгай шаардлагуудыг бариад, төсвөө оруулж ирэх нь цаашаа төсвийн сахилга бат, хариуцлагыг нь нэмэгдүүлэхэд чухал. Гэхдээ зайлшгүй эргэж харах шаардлагатай хэд хэдэн заалт энэ хуульд байна гэвэл байна. Ялангуяа тэр нэг суурь тэнцэл 2 хувийн ашигтай байх, тэр нэг юу байгаа шүү дээ, 3 сарын заалт, тэгээд хэд хэдэн эргэж харах асуудлууд байна. Бусдаар бол Төсвийн тогтвортой байдлын хууль төсвийн сахилга батыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж байгаа. Энэ маш зөв. Тийм учраас ЗГ санхүүгийн сахилга бат, хариуцлагаа барина. Өнөөдөр эдийн засаг дахь харьцаа төсөв, төрийн өмчийн компани 2 чинь нийлээд бараг 60 хувь хүрчихсэн. Ерөөсөө л хувийн хэвшил төргүйгээр амьдарч болохооргүй ийм эдийн засгийн харьцаатай болчихсон.

Тийм учраас бид зайлшгүй энэ Батжаргал гишүүний хэлсэн энэ уул уурхай, ХАА, боловсруулах үйлдвэрүүдийг барьж байгуулах энэ ажлыг зэрэгцүүлж явуулахаас гадна, давхар энэ ЗГ-ын дэвшүүлээд байгаа энэ чөлөөлөлтийн бодлогыг амилуулах ёстой юм. Би энэ Зөвшөөрлийн хуулийг их Хуралд өөрийнхөө нэрээр өргөн бариад энэ хэдэн сар ч болчхов. Ингээд ажлын хэсэг ажиллаад анхааралтай ажиглаад байхаар ерөөсөө амьдрал ингээд бидийг хүлээхгүй байна. Ирэх долоо хоногийн 3 дахид стратегийн ордуудын эзэмшлийг тогтоож, баялгийн санд хуваарилах хуулийг нэн яаралтайгаар өргөн барина. Татварын хуулийг ирэх долоо хоногоос хэлэлцэж эхэлнэ. Ингээд олон хүлээгдэж байсан асуудлуудыг Их Хурал руу оруулж ирэхэд бүгдээрээ хурдан шуурхай батлахыг нь батлаад, буцаавал буцаагаад, засах сайжруулах асуудлыг шийдээд явах нь би зөв гэж үзэж байгаа.

Дээрээс нь мега төсөл гэдэг нэрийн цаана энэ мега төсөл гээд гоё сонсогдож байж магадгүй, том, том төсөл хэрэгжүүлдэг их гоё моодны сонсогдож байж магадгүй. Тэгэхдээ энэ шалгах ёстой юм байна лээ шүү энэ зарим төслүүдийг. Тэгж байж явахгүй бол энэ цаашаа хүнд юм байна лээ. Тийм учраас би асуудал дээр хууль хяналтын байгууллага ч тэр, ЗГ ч тэр шалгаад, асуудлыг мухарлаж байж урагшилж явна. Тэрнээс биш Учралыг мега төслийг том төслүүдийг та нар, чи зогсоогоод байна, энэ их гоё төсөл шүү гэж худлаа тэгж сошиалаар сэвээд нэмэргүй. Би ер нь асуудлыг шинжлэх ухаанчаар ингэж прагматикаар харж ирсэн. Тийм учраас том төсөл гэдэг нэрийн доор ямар нэгэн хулгай дээрэм, тендер юмыг хаацайлна гэж байхгүй. Харин манай ЗГ сая уржигдрын уулзалт дээр явуулах төслүүдээ зарласан,

явж эхэлсэн ажлуудыг ч үргэлжлүүлнэ, сайныг нь үргэлжлүүлнэ, шаардлагагүйг нь зогсооно.

Б.Пүрэвдорж: 2 дахь асуултад Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Монгол Улсын эдийн засгийг авч яваа уул уурхайн салбар өсөлт ямар байх вэ гэж. Өсөлт ер нь дунд хугацаандаа боломжийн байна. Нүүрсний олборлолт тогтвортой үргэлжилнэ. ОТ-н гүний уурхайн олборлолт нэмэгдэнэ. Алтны агуулга жоохон багасаж байна, гэхдээ нийлүүлэлт тогтвортой байна. Уул уурхайн бүтээгдэхүүн бирж энэ арилжаагаар биржийн арилжаа идэвхжээд, тогтмолжоод овоо байр сууриа олоод эхэллээ. Ер нь нэг гол эрсдэл бол энэ Ойрх Дорнодын нөхцөл байдалтай холбоотой шатахууны үнийн өсөлт аж ахуйн нэгжүүдийн зардалд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа нөлөөлөл байна. Эсрэгээр нь зах зээлийн идэвхжил, хил гааль, боомтын үйл ажиллагаа, ер нь гадаад худалдан авалт, төлөв тун эвтэйхэн. Ноднингийн мөн үеэс бид 2,2 тэрбум долларын илүү экспорт хийчхээд, биет хэмжээ, экспортын хэмжээ 60 хувь нэмэгдчихээд явж байна. Нэг онцгой анхаарах зүйл бол энэ геологи, эрэл хайгуулын ажлыг яаралтай шинэ хөрөнгө оруулалтыг татах. Өнөөдөр ашиглалтын тусгай зөвшөөрөл, хайгуулын тусгай зөвшөөрөл.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн 12В ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Нэмж нэг минутаар хариулъя Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Иймд геологи хайгуулын, эрэл хайгуулын салбарт хөрөнгө оруулалт татах энэ бодлогын арга хэмжээ яаралтай авах хэрэгтэй. Ашигт малтмалын хуулийг яаралтай хэлэлцэхээр өргөн барьж байгаа. АМНАТ-н хууль үүнд орж байгаа. Зөвхөн Монгол Улсад 21 зэсийн нөөц тогтоогдсон орд байна. Энэ АМНАТ-тай холбоотойгоор Эрдэнэтээс өөр хөрөнгө оруулалтууд хөдлөхгүй байна. Энийг нээснээр манай уул уурхайн салбар идэвхжих том бололцоо байна. Мөн уул уурхай дээр зэс, нүүрс гэсэн 5 тэрбумаас дээш доллар экспортолж байгаа 2 тулгуур бүтээгдэхүүн байна. Одоо алтныхаа экспорт, алтны батлагдсан нөөцүүдээ ашиглах асуудлууд байна. Бид өөрөө өөрсдийнхөө ингээд гар хөлийг л янз бүрийн эрх зүйн зохицуулалтаар хүлчихсэн зүйлүүд байдаг. Зуу зуун тонн бэлэн нөөц тогтоогдсон алт бэлэн байгаад байдаг, олборлолт, ашиглалт хийж чаддаггүй, янз бүрийн гацаатай. Иргэний нийгмийн байгууллага нэртэй төрөл бүрийн хөрөнгө оруулалтыг шантаажилдаг, гацаадаг байдал орон нутагт нэлээн хавтгайрч байна. Энэний эсрэг зохицуулалтын яаралтай хатуу арга хэмжээнүүдийг авч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ийм бодлогын арга хэмжээ авах хэрэгтэй болж байна гэж.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 15 цаг 09 минутаас хуралдааныг даргалав.

С.Бямбацогт: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хуулийн төсөлтэй холбоотой 3 асуулт байгаа. Ер нь Их Хурлын гишүүд бид сонгуульд орохдоо ямар сайхан амлалтыг ард түмэндээ өгч энд орж ирдэг билээ. Тэгээд орж ирсэн хойноо нөгөө гоё ярьсан амлалтууд бүүр байхгүй. Дандаа болохгүй, бүтэхгүй, байхгүй гэдэг үгнүүдийг энэ танхимд маш их сонсдог. Үнэхээр ард иргэдийнхээ, иргэдийн нүүрийг харахаас

бараг ичиж байна, 28 онд бид юу ярьж очих вэ? 2026 оны нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээ 33 их наяд 479 тэрбум байсан байна 26 онд, 27 онд 36 их наяд 493 тэрбум болоод үндсэндээ 3 их наяд гаруй төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ 3 их наяд төгрөгийн нэмэгдсэн мөнгийг яг юунд зарцуулахаар төлөвлөж байгаа вэ гэдгийг Учрал сайдаас асууя?

2 дугаар асуулт Төсвийн зарлага 26 оноос 3 их наядаар нэмэгдэж байгаагийн яг хэдийг улс эх орны тэргүүлэх салбар боловсрол, эрүүл мэндийн салбарт зарцуулах вэ?

3 дугаарт нь энэ хүн бүрийн амьдралтай холбоотой нэг асуудал байна. Өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлт бүр зах замбараагүй болж байна. Махны үнэ гэхэд л 30 мянга, 40 мянга бараг болчихсон байна. 2027 онд инфляц 7 хувь байхаар тооцож байгаа гэсэн ийм мэдээг уншсан. Тэрийг дагаад энэ өндөр настны тэтгэврийг нэмнэ, 7-хон хувиар л нэмэх байх л даа. Гэтэл нөгөө бүрэн тэтгэврийн доод хэмжээг 1,5 сая болго гээд ахмадууд бүтэн жил гаруй жагсаж байна. Энэ дээр манай ЗГ ямар бодлого барьж ажиллаж байгаа вэ?

Тэгээд би минутдаа багтаагаад Боловсролын ерөнхий хууль өргөн бариад нэг жил болж байна шүү дээ бараг. Тэгээд энийг хэлэлцэх эсэхийг нь шийдэхгүй жил тойрлоо. Энэ багш нар асуугаад байна. Энэ дээр Бямбацогт сайд дарга нэг хариу өгөөрэй. Би 3 даргын нүүр үзлээ. Амарбаясгалан даргын үед өгсөн, тэгээд Учрал сайд болсон, тэгээд дараа нь Бямбацогт дарга болсон. Тэгээд энэ хуулийг бараг хэлэлцэхгүй, хэлэлцэх шаардлагагүй гэсэн бараг тийм хариулт надад өгсөн, яг тэгж надад санагдсан шүү Бямбацогт даргаа. Тэгэхээр би одоо багш нарт хэлээд, өөр тэмцлийн акц зохион байгуулах юм уу, яах юм бэ? Өчнөөн олон мянган багш нар чинь энийг хүлээгээд жил гаран хүлээгээд сууж байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр та хариулт өгөөрэй надад.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Нийт зарлагын өсөлт 3,5 их наяд, суурь зарлагын өсөлт 2,6 их наяд байгаа. Тэгэхээр та бол зарлага өндөр болоод юунд зарцуулах вэ гээд байна. Жишээ нь багш, эмч нарын энэ жилийн цалин нэмэх амлалтыг ирэх жил хэрэгжүүлнэ, үргэлжлүүлээд хэрэгжүүлнэ гэвэл 2 их наяд төгрөгийн хэрэгцээ байгаа. Нэмээд бид тэтгэврийг 10 хувь нэмэхэд шүү дээ одоо 7 сарын 1-нээс, 6 сарын 1-нээс энэ оныг дуустал нэмэхэд 10 хувь тэтгэвэр нэмэхэд 300 тэрбум, ирэх жил бүтэн нэмэхэд 600 тэрбум, 2,6 их наяд байхгүй юу. Тэгэхээр суурь зарлагын өсөлт чинь 2,6 их наяд төгрөг гэвэл зөвхөн багш, эмчийн цалинг яг энэ хэвээр нь үргэлжлүүлж ирэх жил нэмээд л, тэтгэврийг 10 хувь нэмэхэд л энэ зарлага ийм байдалтай байгаа юм. Тэгэхээр ер нь ирэх жил хөрөнгө оруулалтуудыгаа хойшлуулах, танах байдлаа шийдэх ёстой.

Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс, нэг төсөвтэй. Тийм учраас байгаа зүйл маань ерөөсөө л энэ, төсөв маань нэг ийм нөхцөл байдалтай. Тэгэхээр үүнийг бодит үнэнийг хэлэх ёстой байх гэж бодож байна. Тийм учраас шаардлагагүй хөрөнгө оруулалтыг хойшлуулах арга хэмжээнүүдийг үе шаттайгаар аваад явж байгаа, 31-нд хуулиараа хаагдана. Ингээд шаардлагатай бол төсвийн тодотголыг бариад энэ зардлыг бууруулах, хэмнэлт хийх, энэ агентлагуудыг нэгтгэх, нийлүүлэх ийм дорвитой өөрчлөлтүүдийг хийнэ. Тэрнээс энэнээс өөрөөр цаашаа энэ алдагдал 2 хувь байгаад ч энийг цаашаа бол дийлэхээргүй ийм хэмжээнд

байгаа шүү. Тэгээд ер нь мэдээж энэ поп амлалтууд өнгөрсөн хугацаанд л энэ байдалд хүргэчихсэн юм байна лээ. Тэрнээс биш 10 жилийн өмнөхтэй харьцуулахад манайх чинь бараг ДНБ чинь 4, 5 дахин өсчихсэн шүү дээ. Бид чинь 15, 6 онд 20, 30 хүрэхгүй л их наяд GDP ярьдаг байсан, өнөөдөр чинь 90 лүү хүрчихлээ, 89,9. Энэ чинь 100 их наяд, энэ жилийн төсвийн хүрээнд чинь 115 их наядын GDP нийт үйлдвэрлэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ гээд тооцсон. Маш томорч байгаа шүү дээ ер нь.

Тэгэхдээ төсвийн сахилга бат, хариуцлага гэдэг зүйлийг алдсан. Тийм учраас би Мөнхтуяа гишүүний энэ гаргаж байгаа санал, энэ санаа зовж байгаа зүйлийг бүрэн дүүрэн ойлгож байна. Тийм учраас манай ЗГ-ын бодлого бол сайн ажлуудыг урагшлуулна, үрэлгэн зарсан шаардлагагүй хөрөнгө оруулалт төслүүдийг гоё нэрний цаана нуугдчихсан байгаа зүйлүүдийг зогсооно. Түүнд танил тал, элдэв юм байхгүй дээ. Тэгээд ажлаа хийе дээ л гэж бодож байна.

С.Бямбацогт: Энхбаяр сайд нэмж хариулья.

Ж.Энхбаяр: Хүний хөгжил ЗГ-ын тэргүүлэх чиглэл. Үүн дотроо боловсрол онцгой анхааралд байгаа. 91499 багш, ажилтан 5 сарын 1-нээс цалингийнхаа нэгдсэн сүлжээтэй болж, нэмэгдсэн цалингаасаа нэмэгдлээ авахаар болж байгаа. Жирэмсний амралт, хүүхэд асрах, эрүүл мэндийн чөлөө авах, тэтгэвэр тогтоолгох, зээл, тусламжид хамрагдах, виз мэдүүлэхэд учирдаг эдгээр саад тотгорууд нь цэгцэрч байна. Бодлогын хүрээнд 37 цэцэрлэг, 57 сургууль, аймаг, нийслэлийн бүсүүдэд олон улсын хөтөлбөртэй төрөлжсөн ахлах сургуулиуд, Google-ийн нэрэмжит сургуультай болох, chromebook угсрах үйлдвэр байгуулах зэрэг төслүүд эхэлнэ. Нэг багшид нэг хиймэл оюун туслах ийм томоохон бодлогын арга хэмжээ явагдана. Боловсролын хөгжлийн сан, Боловсролын зээлийн санг Боловсролын хөгжлийн сан болгон өөрчлөх бодлого хэрэгжүүлнэ. Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч ажиллангаа сурах, суралцангаа ажиллах боломжийг бүрдүүлэх зэрэг ийм бодлогын арга хэмжээнүүд төлөвлөгдөж байгаа. Гадаад зээл, тусламж эрүүл мэнд, боловсролын салбарт хамгийн тэргүүлэх хамгийн олон.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, болчихсон уу? Мөнхтуяа гишүүнээ таны асуултад хариулья. Та Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн бариад жил гаруй болж байгаа юм байна лээ. Би Улсын Их Хурлын даргаар томилогдоод нэг сар гаруй хугацаа өнгөрч байна. Таны хуулийг судалж үзсэн. Улсын төсвийн ачааллыг, зардлын ачааллыг 2 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэх, улсын төсвийн зарлагын 20-оос доошгүй хувийг боловсролын системд зарцуулах, ДНБ-ний 7-гоос доошгүй хувийг боловсролын системд зарцуулах ёстой гэсэн ийм агуулгатай хууль юм байна лээ. Тэгээд өнөөдөр нөгөө төсөв, эдийн засгийн нөхцөл байдал маань ямархуу байгаа билээ. Төсвийн нийт зардлын 90 орчим хувь нь урсгал зардал болчихсон. Урсгал зардал дотроо, урсгал зардлынх нь 70 хувь нь цалин хөлс, урамшуулал болчихсон ийм байгаа үед нэлээн том төсвийн бодлогын томоохон шинэчлэлт хийхгүй бол хөрөнгө оруулалт хийж байж, бүтээн байгуулалт хийж байж эдийн засаг тэлнэ, ажлын байр нэмэгдэнэ, ард иргэдийн орлого сайжирна, ААН бизнес маань орлоготой болно. Энд нэлээн тийм сөрөг нөлөө үзүүлэхээр хууль байна гэж харагдаж байгаа.

Гэхдээ одоо төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байгаа юм чинь энэ үед энэ асуудлаа хамтдаа хэлэлцээд болох, болохгүй, шийдэх ёстой, шийдэх ёсгүй

гэдгээ энэ төсвийн хүрээний мэдэгдлийн хувьд хамтдаа хэлэлцээд, нэг тодорхой шийдэл гаргах нь зөв байх. Улсын Их Хурлын гишүүд нийт иргэн, улсын эрх ашгийг эрхэмлэнэ гэж тангараг өргөдөг. Тийм болохоор бид улсын эрх ашиг, энэ том бодлого, том зорилго, улс орныхоо эдийн засаг, төсөв даах ачаа гэдэг юмаа сайн бодохгүй бол хөнжлийнхөө хэрээр хөлөө жийхгүй бол юу гэдэг юм сайхан амлаад байдаг, шийднэ гээд байдаг, эцэст нь бидэнд өгөх орлого, түүнийг санхүүжүүлэх зардал, зардлыг санхүүжүүлэх тийм орлого байхгүй ийм үед бүгдээрээ нэг тал талаас нь зөвхөн юу гэдэг юм амлах биш, ачаа үүрч хийх нөхцөл бололцоо, та бас нөгөө талд нь төсвийн орлогыг ингэж нэмэгдүүлээд, энэ нэмэгдүүлсэн орлогоосоо ингэж энэ зардлыг шийдье ийм асуудлыг тийм үү өөр боловсролын салбараас үр ашиггүй зардлуудыг ингэж бууруулаад, үүнээсээ боловсролын салбарын ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлье гэх мэтээр нэг тодорхой шийдэлтэй орж ирвэл ярьж болох байх.

Гэхдээ энийг Их Хурлын гишүүд хэлэлцэх үедээ шийдэх боломжтой байх. Хэлэлцэх үедээ анхаарах ёстой байх. Иймэрхүү байдлаар л ярилцаад явах ёстой болов уу гэж бодож байна. Тийм болохоор төсвийн хүрээнд мэдэгдэл хэлэлцэж байгаа үед таны хуулийн төслийг ер нь хэлэлцэх асуудалд оруулаад хамтдаа яриад явчихъя гэсэн ийм саналтай байна. Мөнхтуяа гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхтуяа: Энэ багш нарын Боловсролын ерөнхий хууль ер нь Инчоны тунхаглал бид олон улсын өмнө үүрэг хүлээсэн байгаа шүү дээ ДНБ-ий 20, төсвийн зардлын 7 хувь гээд. Тэрийгээ 2015 онд ЗГ нь өөрөө үүрэг хүлээчхээд, өнөөдөр ингээд хийхгүй байгаа нь өөрөө болохгүй шүү дээ. Тэгэхээр би энэнтэй холбож энийг оруулсан шүү. Тэрнээс өөрөө ингээд санаанаасаа тоо зохиогоод гаргасан юм байхгүй.

3 дугаар асуудлыг маань хэн хариулах вэ? Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт, инфляц 7 хувиар өсөх юм байна. Ахмадуудынхаа тэтгэврийг бүрэн тэтгэврийг сая 500 мянгад хүргэх үү, үгүй юү? Энэ ахмадууд чинь бүтэн жил гаран энэ гадаа зогсож байна, бодож байгаа юм байна уу, үгүй юү гэдгийг л асуугаад байгаа юм?

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Тэтгэврийн доод хэмжээг төдөд хүргэнэ гэвэл тогтолцоо нь буруу ийм үед шууд тэгж хавтгай нэмээд шударга бус байдал л бий болно. Насаараа хөдөлмөрлөсөн, шимтгэлээсээ цалингаасаа шимтгэл төлсөн хүмүүс, зарим нь халамжийн тэтгэвэртэй, тэгээд бүгдийг нь ижил тэгш нэмнэ гэдэг энэ шударга бус тогтолцоо. Эхлээд итгэлцүүрээ шийдэх ёстой гэж би ойлгож байгаа юм. Олон тулгууртай болох ёстой. Хувийн нэмэлт тэтгэврийн хууль Их Хуралд барьчихсан байгаа, батлах ёстой. Итгэлцүүрээ тэр 900 гаруй тэрбум төгрөгийн итгэлцүүрийг шийдэж байж, тэр нэмэх, нэмэхгүй асуудал явахгүй бол одоо ингээд гаргаж ирээд нэмчихдэг, дахиад энэ чинь бодлогогүй алхам болно л доо. Тэгээд хэзээ ч эцэс төгсгөлгүй юм болох гээд байгаа байхгүй юу. Тэгээд би түрүүн хэлсэн шүү дээ 10 хувь нэмэхэд бүтэн жилээ даахад 600 тэрбум байгаа байхгүй юу. Тэгээд манай суурь зарлага чинь энэ 2,6 болчихоод байна шүү дээ. Тэгэхээр яг.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Ерөнхий сайд.

Н.Учрал: Байгаа нөхцөл нь л ийм байгаа юм. Тэгэхдээ тэтгэврийг бид индексжүүлж л нэмэх үүрэгтэй. Цаашаа хуулийн хувьд ч тодорхой болгох ёстой,

ингэж индексжүүлж л нэмж явна. Тэгэхээр ахмадуудынхаа тэтгэвэр тэтгэмжийг нэмэх бол манай ЗГ-ын гол бодлого байна. Гэхдээ би худлаа яриад яах вэ сая таван зуун мянга болгоно энэ тэр гэж, ид шидтэн гарч ирээд ч тэгж болгож чадахгүй байх. Эсвэл зөвхөн төсвөө батлаад, зөвхөн тэтгэвэр тавивал 1 болох байх. Төсвийн тогтвортой байдлын хууль хамаагүй байх ёстой байх, ажлын байр нэмэгдүүлэх төслүүдээ явуулахад анхаарах ёстой.

Би нэмэлт мэдээлэл хэлэхэд энэ саяын Гадаад зээлийн ашиглалтын хууль өмнө жил төсвийн хүрээндээ багтаагаад шийдсэн төслүүд шүү. Одоо бүр сүүлдээ даварсаар, даварсаар гэдэг шиг нэг хууль оруулж ирээд баталж чадахгүй болохоор зээл гацаалаа энэ тэр гээд. Наад хуультай чинь, хуульгүй энэ зээлүүд явна. Тийм.../минут дуусав/

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Тувааны урилгаар Төв аймгийн Лүн сумын ЕБС-ийн 12А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Удахгүй сургуулиа төгсөөд, хүссэн мэргэжлээрээ, хүссэн сургуульдаа элсэн орж, сайн мэдлэг боловсрол эзэмшин, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулсан, хариуцлагатай, хуулиа дээдэлдэг иргэн болоорой. Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг асуултаа асууя.

Н.Алтанхуяг: Би Ерөнхий сайд байгаа учраас асуултаа би болилоо. Ер нь хэдэн санал хэлье. Учрал Ерөнхий сайдын хэлж байгаа үгэн дотор энэ алдаа дутагдлыг, гарч байгаа алдаа завхрал, алдаа дутагдлыг хүлээн зөвшөөрч байгаа явдал маш их зөв зүйтэй зүйл байна. Ялангуяа энэ төсвийн асуудлаар маш их алдаа завхрал гарсан. Гадагшаа гарч байгаа нэг жоохон түүхий эд, тэр дотроо нүүрснийх нь биет хэмжээ жоохон нэмэгдээд л, экспортынх нь үнэ нэмэгдэнгүүт нэлээн хэдэн төгрөг орж ирэхээр юм шиг ингээд хардаг. Ингээд тэрэндээ дагуулаад баахан зарлага төлөвлөдөг, дараа нь даахгүй нохой булуу хураадаг яг ийм схемээр явж ирсэн.

Дээр нь энэ өмнөх, өмнөх Сангийн сайд нарт би хэлээд, сүүлдээ бараг өөрөө хэрэгтэн болоод дууссан. Энэ Жавхлан, энэ Хүрэлбаатар энэ тэр маш буруу бодлого явуулсан. Одоо энэ Мэндсайхан гэдэг хүн сайд болсон байна лээ. Та нарыг бодлогоо зөв болгооч гэж би хүсэж байгаа юм. Энэ та нарын явуулж байгаа буруу бодлогын үр дүнд Монгол Улс сүйрээд байгаа учраас би энийг засах гэж дандаа хэлдэг юм. Тэгэхээр та энэ алдаа дутагдлыг зөвшөөрч байгаа нь үнэхээр би их баярлаж байна. Тийм учраас би баярласандаа нэг хэдэн үг хэлье гэж бодлоо.

1 дүгээрт байна шүү дээ энэ ЗГ байгуулагдаад нэг хэсэг хугацаа өнгөрчихлөө. Хамгийн гол юм бол 1 дүгээрт юу хийгээд өгөөч энэ юмныхаа үнийн өсөлттэй ер нь яаж тэмцэх гээд байгаа юм, Монголбанк чинь үндсэндээ инфляцыг онилж ажиллах ёстой. Эднийхтэй хамтраад гэдэг юм уу, ЗГ яг юу хийх гээд байгаа юм, одоо гялалзсан, гялтайсан гоё, гоё тоонууд яриад байх юм. Энэ бол буруу. Энэ чинь айл гэрийн тэр алхавч гэдэг босго гэдэг юмаар яаж давж орж байгаа юм, хэдэн төгрөг нэмэгдэж байгаа юм уу, үгүй юм уу энэ дээр л илүү яримаар байгаа юм. Инфляц бууруулах дээрээ анхаараад өгөөч. Би хугацаа байгаа учраас би товчлоод хэлчихье.

2 дугаарт та бүтцийн өөрчлөлт хийхдээ байна шүү дээ энэ Америкууд нэг хийсэн, бид нэг дуурайгаад нэг юм хиймээр байна. Department of Government Efficiency гэдэг шиг ЗГ-ын бүх байгууллагуудын үр ашгийг, үр өгөөжийг дээшлүүлж чадахуйц ийм түр шинжтэй яамыг байгуулмаар байна. Та нар энэ Барон мянгуужингийн үлгэр байдаг шүү дээ, ингээд шаварт шигдчихээд өөрийнхөө үснээс өөрийгөө татаад гаргадаг. Ямар ч мундаг хүн тэр салбар дээр очоод тэр яамыг бол салбарыг өөрчлөх боломжгүй. Тийм учраас ийм дундын юм байгуулах ёстой ЗГ дээр. Байшин сав чинь болж байгаа юм уу, метр квадрат ингээд болж байгаа юм уу, эмнэлэг болж байгаа юм уу, нэг өрөөнд 1 хүн байх нь зөв юм уу, 4 хүн байлгачихвал яадаг юм, тэгээд их олон янзын юмнууд байна, энэ дээр жаахан ажиллаад өгөөч гэж би хүсэж байна.

Дараачийнх нь Учрал Ерөнхий сайд та хөрөнгө оруулалтыг нь нэг бүрчлэн үзмээр байна. Нэг бүрчлэн. Ямар ч үр ашиггүй, эсвэл үр ашиг нь тодорхойгүй, эсвэл зураг төсөлгүй, эсвэл 10 жил үргэлжилдэг ийм юм байна гэдэг чинь бид дампуурна л гэсэн үг. Тэгэхээр та энэ дээр үзээч. Би 2 жил ажиллахдаа нэг удаа бүх объект дээр нь үзсэн, хэрэггүйг нь хасах гэж их оролдсон. Энэ дээр нэг ажиллаад өгөөч.

4 дэх нь төсвийн хөрөнгөөр барьсан юм чинь дахиад төсвийн хөрөнгө иддэг ийм уул уурхайн сав болчихоод байгаа байхгүй юу. Үгүй ээ энэ нэг муу жижигхэн улсад хэчнээн хэмжээний төсвийн театр ч гэнэ үү, юу ч гэнэ вэ ямар үр ашиг байгаа юм бэ, үр ашиг нь юу юм бэ? Тэгэхээр энийгээ маш сайн тооцоолдог иймэрхүү юмнууд жаахан хийчихвэл би хэд 3 төгрөг болох болов уу гэж бодож байна. Одоо та.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд нэг минут Алтанхуяг гишүүнд.

Н.Алтанхуяг: Их Хурлын гишүүдийн буруу биш л дээ. Энэ салбарын цалинг нэммээр байна, тэр салбарын цалинг. Тал талдаа салбарын цалин нэмнэ гэдэг юмаа бүгдээрээ толгойноосоо авч хая. Бид нэг л улс байхгүй. Энэ Учрал гэдэг Ерөнхий сайдын мэдэлд байгаа мөнгө чинь өөрөө лимитэд хязгаарлагдмал тоотой, тоолчихмоор эд л байхгүй юу. Энийг ингээд л Аубакир сайд гарч ирээд би салбарынхаа цалинг нэмнэ, Батлут гарч ирээд бид, тийм юм байхгүй шүү дээ та нар одоо болиоч. Нэг л Монгол Улсад нэг л ЗГ байдаг. Тэгэхээр энэ хязгаарлагдмал нөөцөө зөв хуваарилах юман дээрээ manage зохион байгуулалтаа Учрал сайдыг зөв хийгээч гэж хүсэж байгаа юм. Ингэж нэг гэр бүл шиг ажиллаач. Энэ ЗГ-ын сайд нарыг харахаар нэг л ийм 20 гаруй Ерөнхий сайд юм шиг юм ярих юм. Ийм юм байдаггүй, ингэвэл энэ дампуурч дуусна. Би энэ товчхон хэдэн санал хэлчихье. Их олон санал байгаа. Салбарын сайдуудтай уулзаж дахиж хэлнэ.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү? Мөнхтуяа гишүүнээр тасаллаа. Эрдэнэбүрэн гишүүн. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя, үгээ хэлье.

Б.Батбаатар: Иргэний Зориг ногоон намын зүгээс 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 29 оны төсвийн тухай хуулийн төслийн асуудлаар анхаарч, дараах байр сууриудыг илэрхийлж байгаа. Энэ бол зүгээр энгийн нэг ийм өнөөдөр баталж байгаа төсвийн техникийн бичиг баримт биш гэж үзэж байгаа. Монгол Улс ойрын 3 жилд ямар эдийн засгийн философи, ямар хөгжлийн зарчим, ямар эрсдэлийн удирдлагатай явахыгаа тодорхойлж байгаа бодлогын суурь баримт бичиг болж байна гэж харж байна.

Тэгээд ирэх жилийн төсөв ямар байхыг, бас ирэх жилүүдэд Монгол Улс ямар зарчмаар амьдрахыг шийдэх асуудал өнөөдөр хэлэлцэгдэж байна. Манай төсөв хэт эмзэг хэвээрээ л байгаа. Нүүрсний үнийн өсөлт, бууралт, худалдан авалт төсвийн хүндрэл буюу төсвийн ашгийг бий болгож байгаа. Тэгээд өнөөдөр энэ төсөөлөл маань бодит байдалдаа суурилж чадсан юм уу, эсвэл ийм өөдрөг хүлээлт дээр төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хүрээгээ зохиож оруулж ирж байна уу гэдэг дээр анхаарах ёстой. Төр нь томроод байдаг, иргэн нь хүчирхэгжиж чадаж байгаа юм уу, үгүй юм уу гэдэг дээр анхаарах ёстой. Энэ бол өнөөдрийн гол асуудал. 27-гоос 28 он бол сонгуулийн цикл үе болж байгаа. 2027 он Монгол Улсын төрийн тэргүүн Ерөнхийлөгчийн сонгууль болно, 2028 он Улсын Их Хурлын сонгууль болно.

Өнөөдөр оруулж ирж байгаа энэ ЗГ-аас өргөн барьж байгаа төсвийн хүрээ, төсвийн төсөөлөл дээр энэ циклд зориулсан байх магадлал их өндөр байна гэж харагдаж байна. Сонгуулийн мөчлөгт зориулж та бүхэн энэ эдийн засгийн суурь бодит чадавх, ирээдүй үеэ өрөнд оруулахгүй байх эрсдэлээ тооцсон, хариуцлагатай төлөвлөлтөө оруулж ирж чадахгүй байна гэж ингэж харагдаж байна. Бид экспортын тасалдал, гадаад орчны хүндрэл үүсвэл энэ төсвийн тогтвортой байдал ямар байх юм бэ гэдгээ тооцож чадаагүй байна. Ирэх жилүүдэд ирж байгаа өрийн дарамт, өрийн дарамтаа бууруулах, шинэчлэл хийх чиглэл рүү анхаарсан бодлого гүйцэд харагдаж өгөхгүй байна. Уур амьсгал, агаарын бохирдол, ногоон шилжилтийн асуудал, төсвийн асуудал бодитоор туссан уу, үгүй юу гэдэг нь бас орж ирж байгаа бичиг баримт дээр гарч ирэхгүй байна. Тэгэхээр түүхий эдийн цикл дамжиж ингэж савладаг ийм төсвийнхөө уламжлалт энэ оруулж ирдэг байдлаасаа салах болоогүй юм уу гэж хэлмээр байна.

Иргэний Зориг ногоон нам аливаа асуудлыг чөдөрлөж гацаадаг зүйл биш. Бид тогтвортой, хариуцлагатай, эрсдэл тооцсон бодлогын түвшний асуудлыг бол байнга дэмжинэ. Эрсдэлээ тооцоогүй, хариуцлага хүлээх эзэн байхгүй, бодит тооцоон дээр суурилаагүй, байгальд ээлгүй, шударга ёсыг алдагдуулсан, магадгүй энэ орж ирж байгаа төсвийн төсөөлөл нь эргээд шинээр авлигын шинэ хаалгыг нээх вий гэдэг ийм болгоомжлол бас төрж байна. Маш олон сайхан заалтууд байгаа боловч тэрийг хэрэгжих хүрээ хязгаар хэн хариуцах вэ, ямар үр дүн, ямар тооцоо нэгжээр хэмжиж, хариуцлага тооцох вэ гэдэг өнөөдрийн орж ирж байгаа бичиг баримтад бүрэн гүйцэд тусаагүй байна. Иргэний амьдрал яаж ч сайжрахыг.../минут дуусав/

С.Бямбацогт: Отгоншарын Батнайрамдал гишүүн үгээ хэлье.

О.Батнайрамдал: 29 он хүртэл бид эдийн засгийн 5 өсөлтөө 5,8-аас 6,3 хувь хүртлээ барихын тулд ер нь макро түвшиндээ ч гэсэн бид энэ ОТ-н хэлэлцээрийг заавал хийх ёстой болно. Зээлийн хүү, ер нь Монгол Улсад зээлийн хүү сүүлийн 10 жил бид зээлийн хүү гэж энэ чуулганд ямар их ярьсан бэ, бууж өгдөггүй. Гэхдээ энийг бүүр фундаментаар нь уул нь анализ хийх ёстой юм л даа. Тэгэхээр яг энэ дээр зөвхөн ЗГ-ын зээл ч юм уу, том зургаар нь аваад үзвэл энэ ОТ-н нийт зээлийн 50 хувийг заавал ярихаас өөр аргагүй болж байгаа юм л даа. Тэгэхээр энэ хэлэлцээрээ энэ зүйлүүдээ заавал эзлэх ёстой. Тэр дунд, Пүрэвдорж гишүүнээ би үгээ хэлж байна. Та миний минутаас битгий ав тэгэх үү, би үгээ хэлье. Би үгээ хэлээдэхье л дээ, би минутаа гүйцээж авъя. Пүрэвдорж даргаа та хүмүүс үг хэлж байхад дундуур нь ингэж орилж болохгүй шүү дээ. Яагаад ийм хүндэтгэлгүй хандаж байгаа юм бэ? Одоо миний бодож байсан бодлыг ингээд та бүр ингээд тэр чигээр нь алга болгочихлоо шүү дээ. Би хугацаагаа эхнээс нь авъя. Болохгүй шүү дээ. ОТ

ярихаар яагаад ингээд байгаа юм бэ? Би минутаа гүйцээж авна, шинээр авъя. Их Хурлын даргаа шинээр минутаа авъя, ингэж болохгүй шүү дээ. Энэ чинь Үндсэн хуулиар олгогдсон миний үг хэлэх мандат шүү.

С.Бямбацогт: Үгээ хэлье, нэг минут сунгачихъя.

О.Батнайрамдал: Ерөнхий сайд байгаа дээр хэлж байна л даа. Тэгэхээр ОТ-н хэлэлцээрийг та заавал амжилттай хийгээрэй. Энэ дээр баахан сайд нараар ахлуулсан ажлын хэсэг байгаа л даа. Гэхдээ үндсэн ажлын ачааны хүндийг Эрдэнэс Монгол, тэр дундаа яг 34 хувийг эзэмшиж байгаа Эрдэнэс ОТ хариуцах ёстой. Яг энэ цаг мөчид Эрдэнэс ОТ компанийн гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалт нээлттэй зарлагдсан байна. Тэгэхээр erdenesmongol.mn рүү ороод залуучуудыг энэ Эрдэнэс ОТ компанийн гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтад оролцоосой гэж энэ завшааныг ашиглаад уриалмаар байгаа юм. Энэ ОТ-н хэлэлцээр явж байгаа энэ цаг мөчид боловсролтой, мэдлэгтэй, туршлагатай яг Монгол залуучуудынхаа тэр туршлагыг ашиглах цаг нь яг мөн гэж харж байгаа.

Мөн ОТ-н Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн 3 гишүүнийг дахин томилох ЗГ-ын тэмдэглэл гарсан гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ дээр ч гэсэн ямар нэгэн улс төрийн томилгоо дахиад битгий хийгээч. Ийм хариуцлагатай хэлэлцээр явж байгаа үед мэдлэг, туршлагатай хүмүүс нь ажлаа хийх бид боломжийг нь заавал олгох ёстой.

3 дугаарт ОТ дээр Рио Тинто гээд үндэстэн дамнасан томоохон корпорацтай бид хэлэлцээр хийж байхад яг л тэдний дүрмээр нь тоглох ёстой. Юу гэсэн үг вэ гэхээрээ олон улсын томоохон банк, консалтинг компани, хуулийн компани эд нарыг нь бүгдийг нь авах ёстой. Тэд нарыг албан ёсоор, ямар нэгэн хамгийн гол нь ашиг сонирхлын зөрчилгүй тэр гадаадын том банк, хуулийн компани авч байж энэ том хэлэлцээр хэдэн тэрбумын долларын үр дагавар яригдах хэлэлцээр өөрөө амжилттай болдог байгаа. Тэгэхээрээ энэ зүйлүүдээ зоригтой хийгээд, энэ хэлэлцээр дээр заавал бид үр дүн гаргах ёстой. Энэ үр дүн эргээд бидний энэ өнөөдөр ярьж байгаа эдийн засгийн өсөлтийг 5,8 хувьд хүргэж чадах уу, үгүй юу гэдгийг тодорхойлно шүү.

Өнөөдөр валютын нөөц олон гишүүд ярьж байна л даа. Өнөөдөр Монгол Улс 7,2 тэрбум долларын валютын нөөцтэй гээд түүхэн хэмжээндээ. Гэхдээ тэн дотор чинь Баялгийн сангийн 2 тэрбум доллароо бид нэмж тооцчихоод байгаа шүү дээ. Тэр валютын мөнгөний урсгалыг нэмж олох боломж нь ОТ-н борлуулалтын орлогыг бид 100 хувь Монголын банк болон арилжааны банкаар дамжуулахад нэмэлт 2-оос 3 тэрбум долларын урсгал шүү дээ. 2025 оноос хойш, 2026, 27 гээд ОТ-н борлуулалтын орлого дандаа 5 тэрбум давахаар байгаа юм. Тэгэхээр энэ боломжуудаа ашиглаарай, энэ боломжоо ашиглахгүй бол энэ чинь өөрөө алдагдсан боломж болж хэзээ нэгэн цагт яригдах учраас энэ дээр өндөр хариуцлагатай ажиллах ёстой. Ард түмний маш том хүлээлт байгаа, энэ хүлээлтэд заавал хүрэх ёстой гэж хэлмээр байгаа юм.

С.Бямбацогт: Баярлалаа. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Очирбатын Амгаланбаатарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын Эрдмийн өргөө сургуулийн 12А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн

сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Удахгүй сургуулиа төгсөөд, хүссэн мэргэжлээрээ, хүссэн сургуульдаа элсэн орж, сайн мэдлэг боловсрол эзэмшин, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулсан, хариуцлагатай, хуулиа дээдэлдэг иргэн болоорой. Гишүүд, аав ээжийнхээ үгэнд орж, ажлаа сайн, багш нарынхаа үгэнд сайн ороорой. Тэгээд манай гишүүд энэ хааяа нэг маргадаг юм, зүгээр, зүгээр. Санаа зоволтгүй. Цэндийн Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Монгол Улс ойрын 2, 3 жилдээ эдийн засгийн бодлого ямар байх вэ, энэ бодлогын үр шим өрх болгон, айл болгонд хэрхэн очих вэ гэдэг чухал хэлэлцүүлгийг УИХ дээр хэлэлцүүлж байна. Тэгээд би энэ сайдуудыг их сахилга батгүй байна гэж хэлмээр байна. Өмнөх үе үеийн Засгийн газрууд төсвийн төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсөв хэлэлцэж байхад бүгдээрээ суугаад хариулдаг. Өнөөдөр ингээд Дамдинням сайд, Идэрбат, Сангийн сайд, Хэрэг эрхлэхийн сайд гээд хэдхэн сайд харагдаж байна. Тийм учраас би одоо хэлэх үгээ татаж байна л даа.

Их Хурлын гишүүдийн хэлж байгаа санал бол энэ нийслэлчүүдийн, өөрсдийнх нь аймаг, орон нутгийн саналууд байдаг. Тэгээд манай Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүргийнхэн нэг зүйлийг хэлээд байгаа юм. Энэ нийслэлийн ерөнхий төлөвлөгөөг УИХ батлах бол нэг мөсөн батлаад өгөөч. 20 40 чинь ойлгомжгүй байгаа учраас айлууд дахин төлөвлөлтдөө орох юм уу, орон сууцынх нь бодлого хэрэгжих юм уу, үгүй юм уу гэдэг маш ойлгомжгүй байдал бий болсон. Нийслэл хотын төлөвлөгөөг нь баталж өгөхгүй болохоор нийслэл өөрөө дур мэдэж ямар ч төлөвлөгөөгүй ингээд ажил хийгээд байдаг. Тэгээд Их Хурал энэ ажлаа хиймээр байдаг, хариуцсан энэ сайдууд нь энэ төлөвлөгөөгөө оруулж ирмээр байх юм. Энэ хотуудын төлөвлөлтийг.

Тэгээд ингээд чуулгандаа суудаггүй, ямар айхтар тийм замбараагүй, хариуцлагагүй сайдууд байна. Ерөнхий сайд нь суугаад байдаг. Монгол Улсын хөгжил дэвшил энэ зүйлтэй бол энэ сайдууд нэг тийм ач холбогдол өгөхгүй, хувийнхаа ажлыг амжуулаад яваад байдаг юм уу, ямар учир байдаг юм. Улсын Их Хурлын дарга цаашид энэ дээр анхаараасай гэж бодож байна. Бүх чуулган дээр та бүхнийг суу гэж хэлэхгүй, зөвхөн төсөв болон төсвийн хүрээний мэдэгдэл, хөгжлийн төлөвлөгөө гэсэн чухал чуулганууддаа нэг 3Г бүрэн бүрэлдэхүүнээрээ суумаар байна гэдгийг хэлье. Тэгээд энэ ерөнхий төлөвлөгөөг анхаарч, УИХ авч хэлэлцэх нь зөв байх. Энэ бол нийслэлчүүд буюу нийт хүн амын 50 хувь нь энэ асуудалтай холбоотой байгаа гэж хэлмээр байна. Өөр зүйлээ, саналуудаа татъя.

С.Бямбацогт: Баатархүү гишүүний тавьж байгаа шаардлага зөв. Улс орны төсөв санхүүтэй холбоотой, эдийн засагтай холбоотой Монгол Улсын Их Хурлын гол баталдаг хуулийн хугацаатай төрийн бодлогын бичиг баримтыг бид хэлэлцэж байгаа. Ялангуяа үүний дараа, нэг гишүүн үг хэлсний дараа Монгол Улсыг 2027 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө, хөгжлийн төлөвлөгөө бид хэлэлцэнэ. Энэ бол улс орны нийгэм, эдийн засгийн амьдралыг ирэх онд хэрхэн, яаж төсөөлж байгаа, ямар, ямар салбарт, ямар бодитой хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтууд хийх юм, ямар төслүүд хөдлөх юм, ямар салбарууддаа илүү онцгой анхаарах юм гэдэг асуудлууд яригдана. Энэ үед салбарын сайдууд бүгд байх ёстой шүү. Одоогоор Энхбаяр сайд, Ж.Энхбаяр, Б.Энхбаяр сайд, Мэндсайхан сайд, Идэрбат сайд, Дамдинням сайд, Доржханд сайд, Номтойбаяр сайд нар танхимд байна. Бусад сайдууд жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр бүрэн суугаарай гэдгийг хэлье. Найдалаа сайд бас байна. Бусад сайд нарыг дараагийн асуудал дээр бүрэн бүрэлдэхүүнээрээ суухыг хүсэж байна. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн үгээ хэлье.

Р.Эрдэнэбүрэн: Энэ өдрийн мэнд хүргэе. Их Хурлын даргад хандаад нэг ийм зүгээр нэг санал хэлчих гэсэн юм. Энэ Дэгийн тухай хууль дээр энэ хууль хэлэлцэх хэлэлцүүлэг явуулах дээр нам, эвслийн бүлгээс нэрсийн дагуу асуулт, хариулт зохион байгуулдаг, санал гаргадаг энэ тэр гээд энэ Германы гайхамшигтай санал гээд Дэгийн хуульдаа хийчихсэн. Тэгээд энэ бол чуулганы үйл ажиллагааг бидэнд тохирох болоогүй юм шиг байна. Энийгээ буцааж засаж, хуучин юугаар нь, тэр бүх хуулиуд дээр юу нэрсээ өгөөд, саналаа хэлдэг, асуултаа асуудаг ийм нэг амьд юу руу оруулахгүй бол бүлэг бүлгээс 2, 2-хон хүн оруулж ирнэ гэж хэлээд ингээд бусад нь өрөө өрөөндөө суучихдаг ийм байдалтай энэ хурал чинь 2 жил яваад, тэгээд энэ Дэгийнхээ хуулийг өөрчилж жоохон явахгүй бол сүүлдээ хуралдаа суу гэдэг хуулийн төсөл хүртэл Ерөнхийлөгчөөс орж ирж байна шүү дээ.

2-т нь энэ хуулийн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хэлэхэд энэ урсгал зардлыг бид бууруулж чадахгүй. Ялангуяа ингээд 27 он, 28 он гээд сонгуультай жил болох гэж байгаа. Урсгал зардал бууруулах гэж байна, мөнгө хэмнэнэ гэж хэдэн төрийн албан хаагч халдаг юм шиг байгаа юм. Тэгээд сүүлдээ нийгмийн даатгалын сангаас гэнэт ажлаас халагдсаны мөнгө гэж хэдэн төгрөг авч жоохон явж байгаад, буцаад ажилдаа орцгоогоод ингээд явдаг ийм л байдалтай байгаа шүү дээ. Одоо тэн дээр чинь 7,8 тэрбумын зөвхөн тэр ажлаас халагдсаны юуны өр гээд гарчихсан нийгмийн даатгалын сан дээр байж байна. Ингээд өөрсдийгөө хуураад, тэгээд л ингээд ярихлаараа хэмнэлт гаргана гээд ингээд яваад байдаг байдлаасаа гарах хэрэгтэй.

Тэгэхлээр нэг санал байгаа. Ерөнхий сайд гараад явчихлаа. Тэгэхдээ сонсох юм уу, үгүй юм уу мэдэхгүй. Энэ намын дарга нар энэ хуулийг хэлэлцэж байх үед энэ парламентад суудалтай намын дарга нар маш том зөвшилцлийн гэрээ байгуулж, гарын үсэг зурах хэрэгтэй. Бид энэ урсгал зардлаа энэнээс цаашаа нэмэхгүйгээр цаашаа 2 жил явъя ч гэдэг юм уу тийм юм зөвшилцөл хийх гэж үзвэл яадаг юм бол гэж ингэж бодож байгаа. Тэгээд орж ирсэн орлогоо хөрөнгө оруулалт руугаа хийх гэж оролдьё гэдэг ийм нэг зам байх магадлал байна. Хэрэвзээ тохирч чадвал.

Хэлэлцэж чадахгүй бол өнөөдрийн тэр юуны зээлийн гэрээтэй холбоотой хууль шиг л юм болно шүү дээ. Олонх нь ч хариуцлага байхгүй ингээд, ЗГ нь ч хариуцлага байхгүй байж байгаад унагаж байна шүү дээ. Тэгээд гарахлаараа цөөнхийнхөн энэ гэрээг унагачихлаа, 2 том төсөл явахаа болилоо гээд ингээд л зарлацгаагаад. Ийм байдлаар явбал юу ч явахгүй. Тийм учраас энэ намуудын дарга нар энэ хуулийг хэлэлцэж байхад энэ төсөв орж ирэхээс өмнө энэ урсгал зардлаа энэнээс цаашаа нэмэхгүй гэдэг дээрээ зөвшилцөж, гарын үсэг зурж, тэгээд энэ гадаа жагсаж байгаа улсуудад хугацаа хэлэх хэрэгтэй. Бид 1 жилдээ чадахгүй, нэмж чадахгүй, 2 жилдээ нэмж чадахгүй гээд ингээд хүлээлт үүсэхгүй байгаад байх юм руу орохгүй бол нэг нэмэх гээд ч байгаа юм шиг ийм байдалтай байлгаад байхлаар ингээд хүнд байдалтай байх нь.

2 дугаарт нь сая Энхбаяр сайд хэлж байна. Энэ ялангуяа уул уурхайн бүтээгдэхүүн жоохон гайгүй байна, дээр нь алтны үнэ нэмэгдэж байгаатай холбоотой ордууд дээр боловсруулах үйлдвэрүүд орж ирэх магадлал их байна. Тэгэхдээ бид маш их өөрсдийгөө хааж боосон ийм хуулиудаас болоод.../минут дуусав/

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Бас үг хэлж дууссан. Сая Эрдэнэбүрэн гишүүний ярьж байгаа асуудал дээр сая Даргын зөвлөл хуралдсан. Ер нь сүүлийн 2 сар УИХ өөрийнхөө үйл ажиллагааг сайжруулах, хуралдаан, Байнгын хороо, чуулган, ажлын хэсэг, бүлгийн хуралдаануудаа илүү чанартай, цаг хугацаатай, тодорхой төлөвлөж, товлож, товлосон хугацаанд асуудлаа хэлэлцэж дуусгах, Улсын Их Хурлын гишүүдийн хариуцлага, ёс зүй, ирцийг сайжруулах, парламентын нэр хүндийг дээшлүүлэх, парламентаа бэхжүүлэх, парламентын засаглалаа энэ чиглэлээр Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулахаар манай Сандаг-Очир гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга байхдаа ажлын хэсэг ахлаад, 3 сараас эхлээд ажилласан юм байна лээ. Тэр төслүүдийг өнгөрсөн 2 сарын хугацаанд нэлээн сайн ажиллаж, ярилцаад, Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар эцэслээд ирэх долоо хоногоос Их Хуралд өргөн барина. Энэ дээр Эрдэнэбүрэн гишүүний ярьж байгаа асуудлуудыг ярилцаад явах бололцоотой.

Юу гэдэг юм Германы парламент бол Бундестаг зөвхөн бүлгийн дарга нар нь бүлгээ төлөөлж үг хэлдэг, гишүүд үг хэлдэггүй. Урьд нь манайх ямар байсан хэлэлцэх асуудалтай холбогдуулж баахан үг хэлдэг, хэлэлцэх асуудалдаа орохгүй бөөн асуудал болдог, дараад нь хэлэлцэх асуудал дээр бие биеийнхээ үгнээс санаа аваад гишүүд тухайн үедээ баахан асуудал ярьдаг хамаатай, хамааралгүй гээд нэг иймэрхүү байсныг жоохон дэгтэй, жаягтай, товлосон хугацаатай, төлөвлөсөн ажилтай болгоё гээд тодорхой өөрчлөлтүүд орсон. Сайн өөрчлөлтүүдээ үлдээгээд, засах сайжруулах өөрчлөлтүүдээ хийгээд явах ийм боломж байгаа. Энэ дээр гишүүд маань анхааралтай хандаж, тэр хуулиуд дээр анхаараасай гэж хүсэж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл дээр би хэдэн үг хэлчихье гэж бодож байна. Өнөөдөр улс орны эдийн засаг, нийгмийн байдал амаргүй байгаа. Зөвхөн Монгол Улс ч биш, дэлхий даяараа дэлхийн дэг журам өөрчлөгдөж байна, олон улсад өнөөдөр геополитикийн нөхцөл байдал улам хурцадмал байгаа. Ялангуяа Ойрх Дорнодын нөхцөл байдлаас болж. Тийм болохоор нөхцөл байдлыг урьдчилан төлөвлөх, төсөөлөхөд хүндрэлтэй байгаа энэ цаг үед гишүүд маань төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөлд ач холбогдол өгч, тал талаас нь хэлэлцэж ярилцаж, анхны хэлэлцүүлэг хийж байна. Энэ сард 1 сарын хугацаанд батлах ёстой.

Ингэхдээ бид эдийн засгийн өсөлтийг 2027 онд 5,8 хувь, 2028 онд 6 хувь, 2029 онд 6,3 хувь байхаар нэлээн өөдрөг төсөөлөл орж ирж байгаа. Сүүлийн жилүүдэд эдийн засаг маань тогтмол өсөлттэй байгаа. Гэвч эдийн засгийн өсөлтийн үр өгөөж айл өрхийн хаалгаар орохгүй байгаа. 2022 онтой харьцуулахад нийт өрхийн 30 хувийнх нь бодит орлого 20 орчим хувиар буурчхаад байна. Энэ орлого багатай өрхүүдээ, орлого багатай иргэдээ, энэ дундаа энэ ахмадуудынхаа асуудлыг хэрхэн, яаж анхаарах вэ, эдийн засгийн өсөлтийг иргэддээ бодитой хүргэсэн, эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг айл өрхийн хаалгаар, энэ эмзэг бүлгийнхэндээ хүргэсэн ийм өгөөжтэй бодлого төрийн мөнгөний бодлого, төсвийн бодлого хэрэгтэй байна. Энэ тал дээр бүгдээрээ илүү анхаарч ажиллах ёстой байх.

Энэ хавтгайрсан халамжаа цэгцлэх, халамжаас хөдөлмөрт шилжих цаг нь болсон. Иргэдийн бодит орлого буурч, инфляцад идэгдэж байгаа энэ цаг үед хамгийн ихээр өртөж байгаа энэ зорилтот бүлгүүдээ, бага орлоготой өрхүүд, бага

орлоготой иргэд, нийгмийн эмзэг бүлгийнхэндээ илүү анхаарсан ямар бодлого байх юм. Ажлын байр бий болгож байгаа, баялаг бүтээж байгаа, татвар төлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээ хэрхэн яаж дэмжих юм. Эдийн засгаа яаж төрөлжүүлж, эдийн засгаа яаж солонгоруулж, эдийн засгаа яаж өргөжүүлэх юм энэ талаар анхаарах ёстой.

Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, төгрөгийн ханшийг тогтвортой байлгах, инфляцыг хязгаарлах энэ талд илүү анхаарсан бодлого бидэнд хэрэгтэй байгаа. Тийм болохоор энэ дээр манай гишүүд нэлээн хариуцлагатай хандаад, хуулийн хугацаанд нь батлах ёстой. Яаралтай ирэх долоо хоногт ажлын хэсэг байгуулж, төсвийн хэлэлцүүлгүүд, 2026 оны улсын төсвийн, 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцье. Төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороонд шилжүүлээ.

15.52 цаг

***Дөрөв. “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр
өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/***

Дараагийн асуудалдаа орьё. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төслийг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Жадамбын Энхбаяр танилцуулна. Таныг индэрт урьж байна. Ажлын хэсэг.

Ж.Энхбаяр: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт ЗГ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 5 дугаар сарын 1-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлж, УИХ 6 дугаар сарын 1-ний дотор батална гэж заасны дагуу монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төслийг боловсруулж, ЗГ-аас 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар нэг дэх хэлэлцүүлгийг хийж байна.

Уг төлөвлөгөөний төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь заалтад заасан тусгай шаардлагад нийцүүлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028, 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, Монгол Улсыг 26-аас 30 онд, 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй тус тус уялдуулан боловсрууллаа. Мөн түүнчлэн бид үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллага /НҮБ/-ын Тогтвортой хөгжлийн зорилтын 76 шалгуур үзүүлэлттэй уялдуулан тодорхойлсон нь Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

Монгол Улсын хөгжлийн 2027 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь ЗГ-ын чөлөөлье санаачилгыг дэмжиж, Эдийн засгийн чөлөөлөлт, Эрх зүй, дүрэм

журмын чөлөөлөлт, Ногоон хөгжлийн чөлөөлөлт, Авлигын эсрэг чөлөөлөлт гэсэн 4 чөлөөлөлтийн бодлого байх болно.

1.Эдийн засгийн чөлөөлөлтийн хүрээнд. Бизнесийн орчныг тогтвортой, эрх чөлөөтэй болгож, татвар ба төсвийн шинэчлэл хийж, ажил эрхлэлт, үйлдвэрлэл, бүс нутгийн хөгжлийг дэмжиж, зээлийн хүүг бууруулж, санхүүгийн зах зээлийг өрсөлдөөнтэй болгож, төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг дэмжинэ. Энэ хүрээнд дараах үр дүнгийн нөлөөлөл өндөртэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Эрчим хүчний салбарт Тавантолгой 450мвт-ын хүчин чадалтай дулааны станц, Дулааны 5 дугаар цахилгаан станц, Эрдэнэбүрэнгийн 90мвт-ын хүчин чадалтай УЦС-ыг барина. Боловсруулах үйлдвэрийн салбарт газрын тос боловсруулах үйлдвэр байгуулж, Зөөвч-Овоо төслийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, зэс, ган үйлдвэрлэлийн цогцолборын талбайн бэлтгэл ажлыг эхлүүлнэ. Тээвэр логистикийн салбарт экспорт болон аялал жуулчлалын чиглэлийн авто замууд болон Гашуунсухайт-Ганц мод, Ханги Мандал-Шивээхүрэн хил холболтын төмөр зам барьж, хилийн боомтуудын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хөгжүүлнэ.

ХАА-н салбарт Евразийн эдийн засгийн холбоотой байгуулсан худалдааны түр хэлэлцээр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтарсан зураглалыг хэрэгжүүлж, экспортыг нэмэгдүүлнэ. Атар 4 аяны хүрээнд газар тариалангийн үйлдвэр эрхлэгчид болон Цагаан алт хөдөлгөөний хүрээнд арьс шир, ноос ноолуурын үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ. Соёл, аялал жуулчлалын салбарт зам дагуух аялал жуулчлалын үйлчилгээний цогцолборуудыг байгуулж, Гурвансайхан 4D, Ховд, Мөрөн, Чойбалсан 4С нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжинэ. Эдийн засгийн чөлөөлөлтийн хүрээнд дээрх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг 2027 онд 5,8 хувьд хадгалж, үндэсний өрсөлдөх чадварын индексийг 65 дугаар байрт эрэмбэлэгдэж байгааг 7 байраар ахиулна.

2.Эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлтийн хүрээнд. Суралцагчийг мэдлэг, ур чадварын хоцрогдлоос чөлөөлж, эрүүл мэндийн тогтолцоог шинэчилж, ил тод болгоно. Хүнд суртлыг бууруулж, зөвшөөрлийн тогтолцоог хялбарчилж, төрийн үйлчилгээг цахимжуулж, үр ашигтай болгоно. Энэ хүрээнд дараах үр дүнгийн нөлөөлөл өндөртэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Боловсролын салбарт цөөн хүүхэдтэй анги бодлого баримталж, багийн болон хотхоны бага сургуулиудыг байгуулж, нэг багшид нэг IA туслах нэвтрүүлж, chromebook угсрах үйлдвэр байгуулах төслийг эхлүүлнэ. Эрүүл мэндийн салбарт Зүрх судасны үндэсний төв, Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төв 2 зэрэг эрүүл мэндийн салбарт шаардлагатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, 17 аймгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх төслүүдийг хэрэгжүүлж, нийгмийн ЭМТ дэд төвийг байгуулна.

Ажил эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. Өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээг нэмэгдүүлж, иргэдийн орлогын түвшинд нийцсэн ипотекийн зээлийн төрөлжилтийг бий болгож, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр гадаад улс орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж, орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны чадавхыг бэхжүүлж, гамшгаас урьдчилан сэргийлэх, мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлнэ. Эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлтийн хүрээнд

дээрх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүний хөгжлийн индекс 2025 онд 0,756 байгааг 2027 онд 0,781-д хүргэж, дундаж давхаргын эзлэх хувийг одоогийн түвшнээс 5 хувиар нэмэгдүүлнэ. Мөн үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн индекс 49 хувь байгааг 52 хувьд хүргэж, нийгмийн сайн сайхны байдлын үзүүлэлтийг одоогийн түвшнээс 5 хувиар нэмэгдүүлнэ.

3.Ногоон хөгжлийн чөлөөлөлтийн хүрээнд. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж Ногоон дата төв байгуулж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлж, эрчим хүчний хараат байдлыг бууруулна. Ногоон дэд бүтэц хөгжүүлэх хүрээнд айл өрхийн нарны хавтан, бага оврын нарны эх үүсвэрүүдийг нэмэгдүүлнэ. Энэ хүрээнд дараах үр дүнгийн нөлөөлөл өндөртэй төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Сэргээгдэх эрчим хүчний салбарт нүүрстөрөгчийн кредит тооцох, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлж, айл өрхийн нарны хавтан, бага оврын нарны эх үүсвэрийг нэмэгдүүлж, сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийн төслийг хэрэгжүүлнэ. Мандалговьд 100мвт-ын салхин цахилгаан станцын төслийг өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлнэ. Анхдагч эко системийг хамгаалах чиглэлээр усны нөөцийг хуримтлуулж, ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх Хэрлэн-Тооно, Онги-Цагаан бургастай төслийн бэлэн байдлыг хангана.

Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний тодорхойлсон хувь нэмрийн шинэчилсэн зорилтын хэрэгжилтийг хангаж, олон талын оролцоотой хамгааллын менежментийг хэрэгжүүлэх болно. Байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн чиглэлээр Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд 10 мянган га талбайг ойжуулж, нөхөн сэргээж, цөлжилт, газрын доройтлыг бууруулах, суурин судалгааны төвийг байгуулж, ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны тархац нөөцийг тогтооно. Ногоон хөгжлийн чөлөөлөлтийн хүрээнд дээрх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр байгаль орчны гүйцэтгэлийн индекс 2025 онд 37,2 оноотой байгааг 2027 онд 40 оноонд хүргэж, орон нутгийн хөгжлийн индексийг 0,553-д хүргэнэ.

4.Авлигын эсрэг чөлөөлөлтийн хүрээнд. Авлигын индексийн үзүүлэлтийг сайжруулж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг нэвтрүүлж, цахим засаглал, ил тод байдлыг бодитой нэмэгдүүлж, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжиж, үндэсний хиймэл оюуныг хөгжүүлнэ. Хариуцлагын тогтолцоог чангатгаж, төрийн албаны бүтцийг шинэчилж, шийдвэр гаргалтыг идэвхжүүлнэ. Энэ хүрээнд дараах үр дүнгийн нөлөөлөл өндөртэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Авлига, хүнд суртлыг бууруулах чиглэлээр авлигатай тэмцэх иргэний нийгэм, сайн дурын хөдөлгөөнийг дэмжиж, шүгэл үлээгчийг дэмжих мэдээллийн суваг, хамгаалалтыг сурталчлах, авлигын эсрэг соён гэгээрүүлэлт, хууль хэрэгжилтийн үнэлгээг хэрэгжүүлнэ.

Төрийн бүтээмж, засаглалын чиглэлээр. Төрийн байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгаж, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг нэмэгдүүлэн, төрийн худалдан авалтад хиймэл оюун нэвтрүүлж, ТӨК-удын засаглал, ил тод байдлыг сайжруулна.

Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр. Шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөрийг өрсөлдөөнт хэлбэрээр нээлттэй хэрэгжүүлж, Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг ашиглалтад оруулж, технологи дамжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлнэ. Дээрх үр дүнгийн нөлөөлөл өндөртэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр засаглалын үзүүлэлт 2025 онд 114 дүгээр байрт эрэмбэлэгдэж байгааг 2027 онд 7 байраар ахиулж, дэлхийн мэдлэгийн индекс 39,2 оноог 50 оноонд хүргэнэ.

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд нийт 15,3 их наяд төгрөгийн 124 төсөл, 186 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгалаа. Үүнээс 2,2 их наяд төгрөгийг улсын төсвөөр, 0,2 их наяд төгрөгийг орон нутгийн төсвөөр, 5 их наяд төгрөгийг гадаад зээл, тусламжаар, 4,5 их наяд төгрөгийг дотоодын хөрөнгө оруулалтаар, 1,6 их наяд төгрөгийг гадаадын хөрөнгө оруулалтаар, 1,5 их наяд төгрөгийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр, 0,3 их наяд төгрөгийг бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн болно.

Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Илтгэлээ зүгээр унших биш, сайхан слайд тавиад, гишүүдэд ч ойлгомжтой, ард иргэд телевизээр үзэж байгаа хүмүүс ч бас тодорхой мэдээлэлтэй ийм байдлаар, шинэлэг байдлаар танилцуулсан Энхбаяр сайдад баярлалаа. Цаашдаа манай хууль санаачлагчид, Их Хурлын гишүүд, ажлын хэсгийнхэн иймэрхүү байдлаар тодорхой танилцуулга ард иргэдэд энгийн ойлгомжтой, товч тодорхой хэлбэрээр слайдтай танилцуулга хийж байвал их зүгээр байна, энийг хэрэгжүүлье. Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын Эм Ай Ю сургуулийн 9А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Эрдэм номдоо шамдан суралцаад, удахгүй эхлэх анги дэвших шалгалтаа амжилттай өгөөрэй. Аав ээждээ тустай, үеийн найзууддаа эвтэй, нэгнээ дээрэлхдэггүй, хуулиа дээдэлдэг, шударга иргэн болоорой. Тэгээд амьдралд нь аз жаргал, амжилт ололтыг хүсье. Баяр хөөрөөр дүүрэн, аз жаргалтай амьдрахыг хүсье.

Төрийн аудитын дээд байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Үндэсний аудитын газар Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8.1-д заасан чиг үүргийнхээ хүрээнд жил бүр улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, хөгжлийн төлөвлөгөөг хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулах талаар дүгнэлт зөвлөмж хүргүүлж, ажиллаж ирсэн.

Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд 8 чиглэлийг тодорхойлж, үндэсний 10, салбарын 35, төсвийн ерөнхийлөн захирагчийн 85, хөтөлбөрийн 200 үр дүн, нийт 310 төсөл, арга хэмжээг 15,3 их наяд төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусгасан байх бөгөөд төлөвлөгөөний төслийг боловсруулах явцад дараах саналыг өгсөн. Үүнд:

1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасан зарчмыг бүрэн баримталж, төлөвлөлтийг судалгаа шинжилгээнд үндэслэн боловсруулах.

2.Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө хэрэгжилт, үр дүнг хангахад чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэр, шаардлагатай хөрөнгийг бодитой тооцоолох, үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийг хийхэд чиглүүлэх.

3.Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг тусгахдаа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн шаардлагыг баримтлах.

4.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа мэдээ, мэдээлэл, өгөгдөлд дүн шинжилгээ хийж, төлөвлөгөөний гүйцэтгэлд нөлөөлөх шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлж, үнэлэн, эрсдэлийн суурь судалгааг боловсруулан төлөвлөх талаар санал өгсөн.

ЗГ хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй зорилгын түвшинд уялдуулах, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн зарчим, шаардлагыг хангах, төлөвлөлтийг нөхцөл байдал, үр дүнгийн шинжилгээнд суурилан боловсруулах зарчим баримталж боловсруулсан байна. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай нийцүүлэн түүвэрлэн үзэхэд анхаарах зарим асуудлууд байна.

Тухайлбал, хөгжлийн жилийн төлөвлөгөөнд төлөвлөсөн бодлогын чиглэл, Үндэсний, салбарын, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт, эрэмбэ индексийг тодорхойлсон боловч үндэсний статистик болон ОУБ-ын гаргадаг үзүүлэлт, тайлангийн гарах болон тархаах хугацаанаас шалтгаалж зарим арга хэмжээний үр дүнг үнэлэх боломжгүй байдалд хүрэх эрсдэлтэй байгааг анхаарах.

2.Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд тусгасан Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн дагуу салбарын, үндэсний, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүн, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц бус, ижил агуулгаар тусгагдсан байгааг анхаарах.

3-д нь төсөл, арга хэмжээний төлөвлөлт болон төсөвлөлтийн уялдааг сайжруулж, санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын тооцооллыг бодитой болгож, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн урьдчилсан судалгаа, үнэлгээг хийж, эрэмбэлэн, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхой тусгах.

4.Хөгжлийн томоохон төслүүдийн шалгуур үзүүлэлт, санхүүжилт, хэрэгжилтийн нөхцөл, үр өгөөжийг нарийвчлан үнэлж, хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх стратегийг боловсруулж, судалгаагүй төсөл, хөтөлбөрийг төлөвлөгөөнд тусгахгүй байхад анхаарах шаардлагатай байна.

Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг төлөвлөх, тайлагнах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхээр баталсан холбогдох хууль, журмын цаглаварт хугацаанд дүн шинжилгээ хийж, Үндэсний аудитын газраас өмнөх жилүүдэд хүргүүлсэн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн, хэлэлцүүлгийн явцад төлөвлөгөөний төслийн шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин,

санхүүжилтийн эх үүсвэр, түүний тооцоололд анхаарахыг Улсын Их Хурлын эрхэм гишүүдэд толилуулж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Магнайсүрэн даргад баярлалаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг зөвлөлийн дарга Жамсрандоржийн Дэлгэрсайхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ж.Дэлгэрсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

ЗГ-аас Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2025 оны 5 дугаар сарын 1-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Монгол Улсын 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй танилцаж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16^{5.2} дахь заалтын дагуу дүгнэлт зөвлөмжөө танилцуулж байна. Юуны өмнө ЗГ-аас боловсруулсан 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд Алсын хараа 20 50, Монгол Улсыг 2026-аас 30 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаатай байдал, хуулийн шаардлага, хөгжлийн бодлогын зарчмыг баримтлах чиглэлд сайжирсан, төлөвлөлт, арга зүйн хувьд тодорхой ахиц гарсныг тэмдэглэж байна.

Мөн эдийн засгийн бодлогын хувьд чөлөөлөлтийн бодлогыг дэвшүүлж, эдийн засгийн эрх чөлөө, авлигын эсрэг чиглэсэн тэргүүлэх зорилтуудыг тодорхойлж, хүний хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл, эдийн засаг, дэд бүтцийн хөгжил, засаглалын шинэчлэлийн хүрээнд хувийн хэвшлийг дэмжих, төрийн оролцоог бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын чиглэлүүдийг тодорхойлсон нь бодлогын хувьд дэвшил гарсан төлөвлөлт гэж зөвлөлийн зүгээс үзэж байна.

Гэхдээ хөгжлийн төлөвлөгөөнд байгаа зарим анхаарах зүйлс, цаашид сайжруулах шаардлага байгаагийн үүднээс дараах асуудлуудад анхаарал хандуулах хэмээн үзэж, холбогдох дүгнэлт зөвлөмжийг өгч байна.

1.Макро эдийн засгийн нөхцөл байдлыг бодитой үнэлэх шаардлага хэвээр байна. 2025 оны эдийн засгийн өсөлтийн бүтэц, гадаад, дотоод эрсдэл өндөр байгаа нөхцөл байдлаас харахад 2026-аас 27 онд эдийн засгийн өсөлт 5,8, 6 хувийн өсөлттэй байх нөхцөл хэр бодитой байхыг магадлах шаардлагатай байна. Учир нь 2025 оны эдийн засгийн өсөлтийн гол нь ХАА-н салбарын сэргэлтээс хамаарсан нь суурь оны нөлөөлөлтэй байсан. 2027 оны төлөвлөгөөнд үйлчилгээ, худалдааны салбар эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл болох, төсөл, хөтөлбөрийн нөлөөлөл өндөр байхаар тооцсон нь бодит нөхцөл байдалд хэрэгжих эсэх, үндэслэл тооцоо хангалттай бус байна.

2.Хөгжлийн тэргүүлэх зорилт, үндэсний үр дүнг тодорхой болох шаардлагатай байна. Хөгжлийн бодлогод үндэсний үр дүнг тодорхойлсон боловч тэдгээрийн хэмжүүр бодит байдал, тэргүүлэх зорилттой уялдах байдал, эдийн засгийн тодорхой зорилтыг шийдэхэд чиглэсэн байдалд анхаарах асуудал байсаар байна. Үүнийг сайжруулахын тулд үндэсний үр дүнд хувийн хэвшлийн оролцоо, ядуурал, дундаж давхарга, боловсрол, эрүүл мэнд зэрэг суурь салбарын үр дүнг илүү тодорхой, нарийн шалгуур үзүүлэлтээр оруулах нь үндэсний үр дүнг нэмэгдүүлэх нөлөөтэй гэж үзэж байна.

3.Хөгжлийн бодлогын залгамж чанар хангалтгүй байна. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд 15 их наяд төгрөгийн 125 төсөл, 186 арга хэмжээг тусгасан. Гэвч өмнөх жилүүдийн төлөвлөгөөний гүйцэтгэл 40-өөс 60 хувьтай байсан болон эдийн засгийн суурь нөхцөлийг үнэлж, 2027 оны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлд арга хэмжээ авах шаардлагатай.

4.Хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд смарт байх шаардлагыг бүрэн хангаагүй байна. Жилийн төлөвлөгөөнд туссан 334 шалгуур үзүүлэлтийн зарим нь зорилго, зорилтот түвшингүй, хэт ерөнхий, хэмжих боломжгүй байдлаар тодорхойлогдсон нь үр дүнд суурилсан үнэлгээ хийх боломжийг сулруулж байна. Иймээс шалгуур үзүүлэлтийг илүү тодорхой, хэмжигдэхүйц, бодитой байдлаар боловсруулах шаардлагатай байна.

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө нь эдийн засгийн чөлөөлөлт, төрийн бүтээмж, бүсчилсэн хөгжил, ногоон хөгжлийг дэмжих чиглэлд зорилтуудыг дэвшүүлсэн нь зөв чиглэл бөгөөд зорилтыг бодит үр дүнд хүргэхийн тулд төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналтын уялдааг илүү бодитой, хариуцлагатай, үр дүнд суурилсан хэлбэрт шилжүүлэх шаардлагатай байна. Энэ хүрээнд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дараах зөвлөмжийг өгч байна.

1.Хөгжлийн төлөвлөгөөний үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг илүү тодорхой, тогтвортой, хариуцлагатай болгох. 2.хөгжлийн бодлогын уялдаа холбоог сайжруулах, төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн тодорхой болгох. 3.төлөвлөлт, төсөвлөлтийн уялдаа холбоог сайжруулж, сахилга бат, өрийн тогтвортой байдлыг хангахад онцгой анхаарах шаардлагатай. 4.Томоохон төслүүдийн санхүүжилт, хэрэгжилтийн нөхцөл, эдийн засгийн үр өгөөжийг бодитой үнэлж, хэрэгжих боломжтой төслүүдийг үе шаттайгаар эрэмбэлэн, харин судалгаа, үндэслэл нь тодорхойгүй төслүүдийг төлөвлөгөөнд тусгахгүй байх шаардлагатай байна. 5.УИХ-аас өмнө нь ЗГ-т өгсөн чиглэлүүдийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, тайлагнах механизмыг боловсронгуй болгон, хэрэгжилт болон нийцлийн үнэлгээг хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан хийж байх.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн эрх зүйн орчин, төлөвлөлтийн чанар харьцангуй сайжирч байгаа, 2027 оны хөгжлийн төлөвлөлтийн хувьд тодорхой ахиц гарсан боловч хөгжлийн төлөвлөлтийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь төлөвлөлтийн чанарыг сайжруулах, хэрэгжилтийг хангах үндэслэл юм гэж Төсвийн тогтвортой байдлын зүгээс үзэж байна, зөвлөлийн зүгээс үзэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Дэлгэрсайхан даргад баярлалаа. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд танилцуулна. Таныг индэрт урьж байна. Сайд нарыг чуулганы танхимд урьж байна. Ажлын хэсгийн гишүүд. Үүний дараа гишүүд асуулт асууж, хариулт авна. Тэр үед бүх салбарын сайд нар байх ёстой шүү, ЗГ-ын гишүүд байх ёстой шүү.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Монгол Улсын ЗГ Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1, 6.10.2 дахь заалтад заасан шаардлагад нийцүүлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулж, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын 76 шалгуур үзүүлэлттэй уялдуулан тодорхойлсон байна.

Монгол Улсын хөгжлийн 2027 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь Монгол Улсын ЗГ-ын чөлөөлье санаачилгыг дэмжиж, 1 дүгээрт эдийн засгийн чөлөөлөлт хүрээнд зээлийн хүүг бууруулж, санхүүгийн зах зээлийн, зах зээлийг өрсөлдөөнтэй болгон, төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг дэмжих, бизнесийн орчныг тогтвортой, эрх чөлөөтэй болгож, татвар, төсвийн шинэчлэлийг хийж, ажил эрхлэлт, үйлдвэрлэлийг дэмжин болзошгүй эрсдэлийг хохирол багатай даван туулах, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх бүхий эдийн засгийн чөлөөлөлт.

2.Эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлтийн хүрээнд, зөвшөөрлийн тогтолцоог хялбарчлан, төрийн үйлчилгээг цахимжуулж, төрийн албаны бүтцийг шинэчилж, шийдвэр гаргалтыг оновчлон, хүнд суртлыг бууруулж, суралцагчийг мэдлэг, ур чадварын хоцрогдлоос чөлөөлж, эрүүл мэндийн тогтолцоог шинэчилж, ил тод болгон, эрх зүй, дүрэм журмыг чөлөөлөх.

3.Ногоон хөгжлийн чөлөөлөлтийн хүрээнд, эрчим хүчний хараат байдлыг бууруулан, сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр, айл өрхийн нарны хавтан, зайн хураагуур, бага оврын нарны эх үүсвэрийг нэмэгдүүлж, ногоон дэд бүтцийг хөгжүүлэн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх шинэ боломжийг бий болгох. Ногоон дата төв байгуулах, ногоон хөгжлийн чөлөөлөлт.

4.Авлигын эсрэг чөлөөлөлтийн хүрээнд, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжиж, үндэсний хиймэл оюуныг хөгжүүлж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг нэвтрүүлж, цахим засаглал, ил тод байдлыг бодитоор нэмэгдүүлж, хариуцлагын механизмыг сайжруулан, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэн, хуульд авсан журмуудыг үе шаттайгаар бууруулахаар тус тус тусгасан байна.

Үндэсний аудитын газраас Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд хийсэн санал, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитын орлогч Цэдэнжав танилцуулсан бөгөөд санал, дүгнэлтдээ хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг төлөвлөх, тайлагнах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд дүн шинжилгээ хийж, бүх талуудын оролцоог жигд хангах, төслийн хэлэлцүүлгийн явцад төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, санхүүжилтийн эх үүсвэр, түүний тооцоололд анхаарах нь зүйтэй талаар дурджээ.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд хийсэн дүгнэлт зөвлөмжийг тус зөвлөлийн дарга Дэлгэрсайхан танилцуулсан бөгөөд улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хөгжлийн бодлогын суурь болсон эдийн засгийн өсөлтийн таамаглалыг илүү бодитой, эрсдэлийг тооцсон байдлаар боловсруулах. Хувийн хэвшлийн оролцоо, ядуурал, дундаж давхарга, боловсрол, эрүүл мэнд зэрэг суурь салбарын үр дүнг илүү тодорхой, нарийн шалгуур үзүүлэлтээр хэмжих, төлөвлөгөөнд туссан зарим төсөл, арга хэмжээнд ямар тэргүүлэх чиглэл, зорилттой холбоотойг илүү тодорхой болгох, хяналт шинжилгээ, үнэлгээний зарим шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой, хэмжигдэхүйц бодитой байдлаар боловсруулах. Мега төслүүдийн хувьд төслийн нийт өртөг, санхүүжилтийн эх үүсвэр, үр өгөөж тодорхой бус, зарим нь олон жил дараалан хөгжлийн төлөвлөгөөнд багтсан боловч хэрэгжилт хангалтгүй, томоохон төсөл, хөтөлбөрүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв, хариуцах эзэн, байгууллага тодорхой бус байгаа тул хөрөнгө оруулалтын ач холбогдол, үр өгөөжийн тооцооллыг сайжруулах шаардлагатай талаар тус тус дүгнэсэн байна.

Тогтоолын төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан боловч 2027 оны жилийн төлөвлөгөөнд тусаагүй шалгуур үзүүлэлтүүд хэд байгаа, төсвийн ерөнхийлөн захирагчид шалгуур үзүүлэлтийн талаар саналаа өгсөн эсэх, Монгол Улсын ЗГ-аас 2027 оныг Эрүүл мэндийг дэмжих жил болгож зарласантай холбоотойгоор тус салбарт төсөвлөсөн төсөв болон ЭМД-ын сангийн хөрөнгийн хүрэлцээгүй асуудлыг хэрхэн шийдвэрлэх, Цахим хөгжил, харилцаа холбооны яам сэндбокс бүс, Боловсролын яам chromebook, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Цөлжилттэй тэмцэх судалгааны төвийг хаана барихаар тус тус төлөвлөж байгаа, эдийн засгийн үр өгөөж талаасаа Алтанбулаг-Замын-Үүд чиглэлийн замыг 4 эгнээ болгон өргөтгөж, нийлүүлэлтээс хамааралтай инфляцыг бууруулах боломж байхад ямар үндэслэл, шаардлагаар Улаанбаатар-Лүнгийн чиглэлийн замыг өргөтгөх ажлыг 2027 оны төлөвлөгөөний төсөлд тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд 15,3 их наяд төгрөгийн 124 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасныг хэрхэн эрэмбэлж, ямар шалгуураар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх, Улаанбаатар хот орчимд үйл ажиллагаа явуулж буй арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг аж үйлдвэржилтийн парк руу үе шаттай нүүлгэн шилжүүлэх бодлого болон арьс шир боловсруулахад олгохоор төлөвлөж буй дэмжлэгт хэдэн ААН хамрагдаж, ямар хугацаанд, ямар үр дүн гарах тооцооллын талаар, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат хөдөө орон нутагт ажиллах хүний нөөцийн тогтвор суурьшлыг нэмэгдүүлэх хүрээнд цалин хөлс нэмэгдүүлэх, орон сууц барих, зээлийн хүүг бууруулах, ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар болон 2027 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой илүү нарийвчилсан төлөвлөгөө яамдад байгаа эсэх, төрөөс худалдан авч буй ажил, үйлчилгээ, төсөл, арга хэмжээнүүдийн хувьд эдийн засагт үзүүлж буй бодит нөлөө, Монгол Улсад үлдэж буй өгөөж, бий болгож буй ажлын байр зэрэг бодит үнэлгээ, дүн шинжилгээ хийх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар Монголбанкны үнэт цаасны үлдэгдэл, зээлийн хүүг бууруулах бодлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал 2027 оны хөгжлийн төлөвлөгөөний хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, Төсвийн тогтвортой байдлын дүгнэлтийн талаар болон төслийн Хүний хөгжлийн бүлэгт

тусгагдсан төсөв бодит хэрэгцээнд нийцсэн эсэх, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн бүрдүүлсэн орлогыг улсын төсөвт төвлөрүүлдэг шалтгаан, Боловсролын зээлийн сангийн эргэн төлөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг өмнөх онуудын төлөвлөгөөнд тусгагдсан олон төсөл, арга хэмжээ 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй талаар, тухайлбал Байдрагийн УЦС, Эгийн голын УЦС, төвийн бүсэд 100мвт хуримтлуурын УЦС, Багануурын цахилгаан станц, Архангай, Өвөрхангай, Өвөрхангайд 10мвт нар, 20мвт цагийн батарей хуримтлуур зэрэг эрчим хүчний томоохон төсөл, арга хэмжээнүүд, айл өрхүүд сэргээгдэх эрчим хүч ашиглан эрчим хүчний хэрэглээгээ бууруулах, илүүдэл цахилгаанаа сүлжээнд нийлүүлж, орлого олох боломжийг нэмэгдүүлэх, 5 аймгийн 100мвт тархмал эх үүсвэр барих, ногоон зээлийн хүүг бууруулах зэрэг олон төсөл, арга хэмжээ энэ оны хөгжлийн төлөвлөгөөнд тодорхой тусгагдаагүй талаар болон ногоон зээлийн хүүг хэрхэн бууруулахаар төлөвлөсөн талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар цаашид бодлогын хүүг бууруулж, эдийн засгаа дэмжих арга хэмжээ авах талаар, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлдэггүй, шалгуур үзүүлэлтүүдтэй холбоотой тодорхой үүрэг чиглэлийг хангалтгүй боловсруулж байгаа эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцдог байх асуудлыг цаашид анхаарах талаар саналаа хэлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Соронзонболд гишүүнд баярлалаа. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшиний урилгаар Их Засаг олон улсын их сургуулийн багш, оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Оюутан залуучууд та бүхэн Монгол Улсынхаа шийдвэр гаргах түвшинд дуу хоолойгоо хүргэж, нийгмийг өөрчлөх хамгийн хүчтэй хөдөлгүүр гэдгээ санаж, шүүмжлэгч байхаасаа илүү шинийг эрэлхийлэгч, идэвхгүй ажиглагч байхаасаа илүү идэвхтэй оролцогч байгаарай гэж Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулна. ЗГ-ын гишүүд бүгд суух ёстой, ЗГ-ын гишүүд хаана байна вэ? Ажлын хэсэг Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Нямтайширийн Номтойбаяр Монгол Улсын Шадар сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын Шадар сайд, Баттөмөрийн Энхбаяр Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Энхбаяр сайдыг дуудаарай. Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Батцэцэг сайд хаана байна вэ? Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Сайнбуянгийн Амарсайхан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Амарсайхан сайд хаана байна вэ? Гонгорын Дамдинням Аж үйлдвэрийн сайд, Дамбын Батлут Батлан хамгаалахын сайд, Цэндийн Сандаг-Очир Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, алга байна, дуудаарай. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Боловсролын сайд, алга байна, дуудаарай. Тилеуханы Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Борхүүгийн

Дэлгэрсайхан сайд гадаад томилолттой байгаа, Жуковын Алдаржавхлан сайд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд энэ чинь гадаад томилолттой байгаа билүү, үгүй билүү? Тийм. Энхтайвангийн Бат-Амгалан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Цагаанхүүгийн Идэрбат Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Чинбатын Номин Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Номин сайд хаана байна вэ? Бадрахын Найдалаа Эрчим хүчний сайд, Энхбаярын Батшугар Эрүүл мэндийн сайд.

Хотоос Хишгээгийн Нямбаатар гадаад томилолттой, орлогч дарга нь ирсэн үү, хотоос хэн байна вэ? Хотоос хүмүүс ирүүлээрэй. Содномдаржаагийн Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Санжаагийн Наранцогт Монголбанкны Ерөнхийлөгч, Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Буяндэлгэрийн Баттуяа Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, Түндэвийн Жамбаажамц СЗХ-ны дарга, Батмөнхийн Батдаваа Үндэсний статистикийн хороо /ҮСХ/-ны дарга, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Бат-Ирээдүйн Анар Сангийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Шүрэнчулууны Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД, Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын яамны ТНБД, Намсрайн Баярмагнай Зам, тээврийн яам /ЗТЯ/-ны ТНБД, Мянгаагийн Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төмөр-Уяагийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ТНБД, Бавуужавын Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ТНБД-ын албыг түр орлон гүйцэтгэгч, Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яам /ЭХЯ/-ны ТНБД, Намжилын Эрдэнэбаяр ЭМЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Шаравын Мөнхцэрэн ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар /ТӨБЗГ/-ын дарга, Вандансүрэнгийн Жавзан Төрийн албаны зөвлөл /ТАЗ/-ийн Ажлын албаны дарга, Намдангийн Ганбаатар Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга, Батсуурийн Даваадалай Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирал, Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засгийн хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Даринчулууны Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засаг, хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Төмөрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батсуурийн Мөнхбаяр Гадаад харилцааны яамны Бодлогын газрын дэд захирал, Мэлсчойгийн Мэндбаяр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга, Эрхэмбаярын Гансүх Батлан хамгаалах яам /БХЯ/-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Батчулууны Бат-Өлзий Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлогын газрын дарга, энэ яамны газрын дарга алга байна шүү бас. Цэндийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа ГБХНХ яамны Хөдөлмөрийн харилцаа,

хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга, Ванчингийн Рэнцэнханд ГБХНХ яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Юрагийн Отгонбилэг ГБХНХ яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, Баяраагийн Урьболд ССАЖЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Доржийн Энхтөр ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Батмөнхийн Хишигтогтох ХЗДХЯ-ны Хяналт шалгалт, дотоод аудитын газрын дарга, Бямбасүрэнгийн Туяа ЭМЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, алга байна шүү. Зияханы Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга, Бадраагийн Оюунгэрэл БХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга. Ажлын хэсгийг танилцууллаа та бүхэндээ.

Ажлын хэсгийн гишүүддээ хууль сануулъя. Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ЗГ-ын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй. Их Хурлын тухай хуулийн 21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, УИХ-д худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. Чуулганы нэгдсэн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байдгийг ажлын хэсгийн бүрэлдэхүүндээ сануулъя. Тэгээд УИХ-д хүндэтгэлтэй хандацгаая, Улсын Их Хурлын гишүүдийн асуусан асуултад үнэн зөв, бодитой мэдээлэл өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөл, Төрийн аудитын байгууллагын болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Төгсгөл нь хэн бэ? 31 гишүүн асуулт асуухаар нэрсээ өгсөн байна. Булгантуяа гишүүнээр тасаллаа. Саранчулуун гишүүнийг оруулъя. Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Энэ улсын хөгжлийн төлөвлөгөөний нэг жилийн төлөвлөгөө, гүйцэтгэл ч тэр, төлөвлөгөө нь ч тэр орж ирэхэд би нэг л юмыг хэлдэг юм. Энэ нь болохлоор нэг жилийн ийм төлөвлөгөө гаргахаа хэдүүлээ больцгооё. 5 жилийн төлөвлөлт гэж байгаад, тэгээд түүнийхээ дагуу тухайн жил бүрийнхээ төсвөө тухайн жил жилийнх нь төлөвлөгөө гэж үзээд явъя гэсэн ийм саналыг гаргаад байдаг. Ер нь улс орнууд, манай улс ч гэсэн Төлөвлөгөөний комисс 5 жилийн төлөвлөгөө гаргаад л, бусад улс орнууд чинь 5 жилийн төлөвлөгөөгөө дагаад л явдаг шүү дээ. Жил болгон төлөвлөгөөгөө өөрчлөөд байдаг, тэгээд тэр нь ердөөсөө төсөвтэйгөө ч уялддаггүй ийм сонин орчинтой бид ингээд л дандаа цагаа дэмий үрсэн, дандаа ингээд нэг хий ердөөсөө ингээд нэг л болж бүтэхгүй байгаад байгаа байхгүй юу.

25 оны жилийн төлөвлөгөөний биелэлтийг манай Аудитын газар гаргахад 4 тэргүүлэх чиглэлийн 6 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 20,9 хувь гэж байгаа байхгүй юу. Тэгээд аргагүй шүү дээ. 1 дүгээрт ЗГ-аас оруулж ирсэн төсвийн энэ төлөвлөгөөг нь бүүр танигдахгүй болтол нь гишүүд зарчмын зөрүүтэй санал гаргаад, баахан төсөл, хөтөлбөр оруулчихдаг. Яагаад гэхлээр төсөвтэйгөө андуураад байдаг байхгүй юу. Тэгээд хавар нь нэг төлөвлөгөө гаргаад л, намар нь болохлоор төсөв гэж шал тусдаа ондоо юм гаргаад л. Төлөвлөгөөнд нь орсон үзүүлэлтүүдийн 60 хувийн санхүүжилтийг нь ердөөсөө тавьж өгдөггүй, тэгээд л байнгын өөрчлөгдөөд байдаг энэ чинь утгагүй байгаа байхгүй юу даа. Тэгээд 5 жилийн төлөвлөгөөндөө нийцүүлээд л жил жилийнхээ төсөв батлаад л явах нь өөрөө зүйн хэрэг баймаар юм.

Одоо энэ төлөвлөгөөг нь та бүхэнд бүүр ингээд уншихлаар хөөрхөн инээдтэй, ёстой уучлаарай. Агаарын тээврийн зорчигчийн дагалдах ачаанд тавих гаалийн хяналтыг сайжруулна гэж байгаа байхгүй юу. Яах гэж байгаа юм бэ, гар тээш шалгах гэж байгаа юм уу дахиад? Баянхошуу дэд төв орон сууцжуулах төслийг хэрэгжүүлнэ гэж байгаа юм. Сая бид чинь Сэлбэ дэд төвөө унагаачихлаа шүү дээ. Тэгээд дахиад л ийм асуудал өрнөх нь үү дээ. Төрийн албан хаагчдад статистикийн сургалт зохион байгуулна гэж байгаа юм, манай статистикийн байгууллагынхан, манайхан ч оруулсан юм биш л дээ. Энэ хэрэглэгчийн чанартай, хүртээмжтэй мэдээлэл гээд ийм асуудал орж ирж байна. Гадаадын иргэний визгүй, ер нь иймэрхүү энэ мэтчилэн ийм зүйл, заалтууд яах үгүй жилийн төлөвлөгөө оруул гэсэн учраас иймэрхүү л жагсаалт орж ирж байгаа юм. Тэгээд энэ эцэслэн батлагдахдаа дахиад л бүүр шал өөр юм гарч ирнэ. Тэгэхээр энийг нэг больчихож болдоггүй юм уу гэсэн асуудлыг л дэвшүүлээд байгаа юм.

Надад нэг асуулт байгаа. Энэ төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн зөрөөг арилгах, цалин хөлсний бүтцийг оновчтой болгох, төрийн албаны бүтцийг шинэчлэх гэсэн ийм үг, өгүүлбэрийн ард яг юу нуугдаж байна вэ гэдгийг нэг хэлээд өгөөч гэсэн ийм л? Асуулт нь тэр, санал нь нэг жилийн төлөвлөгөө гэж өөрсдийгөө хуурахаа больж, ийм олон төрийн албан хаагчдын цаг завьг нь үрэхээ больж, жинхэнэ хийх ёстой ажлыг нь хийлгэмээр байгаа байхгүй юу. Бямбацогт даргаа та яг энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг санаачилж батлуулж байсан шүү дээ. Үгүй ээ яалт ч үгүй бид ингээд нөгөө дороо хий эргээд байгаа байхгүй юу. 5 жилийн төлөвлөгөө, тэгээд түүнийгээ дагасан жилийн төсөвлөлт. Тэгэхгүй бол ингээд нэг жилийн төлөвлөгөө нь ч юу юм, жилийн төсөв нь ч юу юм өөрсдөө ч ойлгохгүй, байнга өөрчлөгдөөд байдаг ийм асуудал байгаад байна. Төрийн албатай холбоотой асуултад хариултаа авъя.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүний ярьж байгаа асуудал дээр нэг тайлбар өгчихье гэж бодож байна. Ер нь хаана байгаагаа мэдээд, хаана хүрэхээ олж хараад, түүндээ хэрхэн, яаж хүрэхээ томъёолохгүй бол хэзээ ч хүрэх зорилгодоо хүрэхгүй. Дэлхийн бүх улс орнууд төлөвлөдөг, төлөвлөснийхөө дагуу төсөвлөдөг, төлөвлөгөөтэйгөө уялдуулж төсвөө хийдэг. Бид 90 он хүртэл нь төлөвлөж явдаг байсныг сая та хэлж байна, 5, 5 жилээр нь төлөвлөөд, жил жилээр нь тодотгоод. 90 оноос хойш 2020 он хүртэл үндсэндээ 30 жил ямар нэгэн төлөвлөгөөгүй явж ирсэн. Төлөвлөгөө байхгүй болохоороо бодлогогүй, төлөвлөлтгүй болохоороо төсвийг дураараа зарцуулдаг ийм замбараагүй болчихсон.

Гарч ирсэн нам болгон, томилогдсон Ерөнхий сайд болгон өөр өөрсдийн бодлогоо хэрэгжүүлнэ гээд тал тал руугаа ингээд татаж чангаадаг ийм болчихсон байсныг 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын хөгжлийн бодлого урт, дунд, богино хугацааных байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна. Тогтвортой байхын тулд урт, дунд, богино хугацааны бодлогууд нь харилцан уялдаатай байх энэ юмнуудыг шийдэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг Их Хурал 2020 онд баталсан. Ингээд үндсэндээ бид 30 жилийн урт хугацааны бодлого буюу Алсын хараа 2050, 10 жилийн дунд хугацааны 8 зорилт, хөтөлбөр батлах ёстой. Үүнээс нэгийг нь баталсан, бусад нь батлагдаагүй байгаа. 5 жилийн үндсэн чиглэл буюу таны ярьж байгаа 5 жилийн төлөвлөгөө, дээрээс нь ЗГ-ын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөр, үүнийгээ хэрэгжүүлэхэд жил болгон төлөвлөгөө батлаад, төлөвлөгөөндөө суурилсан төсвийг баталдаг ийм тогтолцоотой болсон.

Энэ дөнгөж хэрэгжиж эхэлж байгаа болохоор 30 жил ямар ч төлөвлөгөөгүй, замбараагүй, задгай явж ирсэн болохоор одоо нэг цэгцтэй явах гэхээр төлөвлөлт чухал уу, төсөвлөлт чухал уу. Аливаа нөөцөө дахиж тодорхойлоод төсвийн хүрээний мэдэгдлээрээ, энэ нөөцөө хэрхэн, яаж, юунд зарцуулах вэ гэдгээ төлөвлөөд, төлөвлөснийгөө буцаагаад төсвөөрөө хуваарилаад ингээд явбал бүх асуудал чинь цэгцтэй, төрийн бодлого чинь тогтвортой, тодорхой, харилцан уялдаатай холбоотой явах юм. Ийм л агуулгаар хийсэн уул нь. Төлөвлөөд сурчихвал, төлөвлөгөө дээрээ суурилоод төсвөө баталж чаддаг болчихвол энэ хамгийн зөв алхам. Нөгөө хянаж чадахгүй бол, хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй гэж төлөвлөлт ерөөсөө хянах, хэмжих, удирдахын хамгийн суурь нь. Тийм учраас ийм болсон гэдгийг хэлье. Эдийн засгийн хөгжлийн сайд Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ Үндсэн хуулийн зарчим, Үндсэн хуульд орсон өөрчлөлт. Үндсэн хуулийг бид биелүүлж, хэрэгжүүлэх учиртай. Тэгээд бид сая 25 оны жилийн эцсээр 26-аас 30 онд Монгол Улс нийгэм, эдийн засаг хөгжүүлэх 5 жилийн хөтөлбөрөө баталсан. Энэ хөтөлбөрийг энэ 5 жил улс төрийн бүх намууд хэрэгжүүлэхийн төлөө ажиллана. Улсын Их Хурлын сонгууль болон Ерөнхийлөгчийн сонгуульд дэвшиж байгаа аливаа нэр дэвшигч, улс төрийн нам энэ Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн төлөө ухаан санаагаа, арга ухаанаа уралдуулна. Тэрнээс энэ хөтөлбөрт тусаагүй, өөр хөтөлбөрийг хэрэгжүүлэх санал болгосон улс төрийн нам, нэр дэвшигчийг сонгуулиас хасдаг ийм хатуу зохицуулалттай болсон.

Энэ нь юу вэ гэвэл төрийн бодлого урт хугацаанд тогтвортой, улс төрөөс ангид, улс төржихгүйгээр хэрэгжих ийм гол суурийг хангаж байгаа ийм төрийн бодлого. Үндсэндээ өнгөрсөн 30 жилийн парламентын гашуун туршлага дээр ийм бодлого дээр улс төрийн намууд нийлж, Үндсэн хуулийн өөрчлөлт хийж ингэж шийдсэн зүйл шүү. Тэгэхээрээ гишүүд энэ дээр үг хэлэн дээр анхаармаар байна гэдгийг нэг хэлэхийг хүсэж байна.

Байнгын хороо, салбарын яамнууд шууд өөр өөрийнхөө асуудлаа гаргаад салбарууд ярина. Төсвийн хүрээгээс ялгаатай бол, төсвийн хүрээ бол бодлогын асуудлууд, макро эдийн засгийн 9 гол үзүүлэлтээр. Хөгжлийн бодлого бол салбарууд. Салбар, салбар хийх асуудлаа босож ярина. Тэгэхээр асуултуудаа асуухдаа гишүүд тэр яамнаас, тэр яамнаас, тэр салбараас гэж тодруулж асуувал их сайн байна, тодорхой.

С.Бямбацогт: Аубакир сайд. Аубакир сайд нэг арга хэмжээтэй гээд сая чөлөө авсан, Ерөнхий сайдтай хамт нэг арга хэмжээнд орох гээд явсан, чөлөө авсан. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас төлөөлөөд хариулчихъя, 4 номерын микрофон. Ажлын хэсэг Алимаа дарга уу?

Б.Алимаа: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны газрын дарга Алимаа хариулж байна. 27 оны тухайд төрийн албан хаагчдын цалин хөлсний бүтэц, тогтолцоотой холбоотой зарчмын өөрчлөлтүүд оруулах ийм зорилго тавьж ажиллаж байгаа. Одоогийн байдлаар салбарын 35 хуулиар төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлыг харилцан адилгүй, ялгаатай байдлаар зохицуулдаг ийм нөхцөл байдал байгаа гэдгийг Ариунзаяа сайд мэдэж байгаа. Энэнтэй холбоотойгоор адил албан тушаалд ижил цалин хөлс олгох энэ үндсэн цалин хөлсний тогтолцоо алдагдах, салбар хоорондын ажиллах хүчний шилжих хөдөлгөөн нэмэгдэх, зарим салбарт цалин багатай байж байгаа салбарт ажиллах хүчний дутагдалд орох ийм сөрөг үр дагаврууд гараад байгаа юм. Энэнтэй холбоотойгоор цалин хөлснийхөө тогтолцоогоо сайжруулах хууль, эрх зүйн орчныг нь нэгдсэн цалингийн бодлогын түвшинд хүргэх, тэгээд цалин хөлс, ангилал, зэрэглэлийнхээ асуудлыг нэгтгэж авч үзье гэсэн ийм агуулгаар.../минут дуусав/

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн тодруулж асууя. Намайг зөв ойлгоорой. Би юу гэж хэлээд байна вэ гэхлээр нэг жилийн төлөвлөгөө бол нэг жилийн төсөвтэйгөө огт уялддаггүй, нэг жилийн төлөвлөгөө нь 5 жилийн төлөвлөгөө, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялддаггүй, нэг жилийн төлөвлөгөө нь дараагийн жилийн төлөвлөгөөтэйгөө уялддаггүй ийм асуудлыг хэдүүлээ засах хэрэгтэй байна гэдэг асуудлыг хэлж байгаа.

Энхбаяр сайдын хэлсэнчлэн улс төрийн намууд мөрийн хөтөлбөрөө дэвшүүлэхдээ хөгжлийн төлөвлөгөөнөөс бусад энэ бодлогоос өөр бодлого дэвшүүлж болохгүй гэж заадаг, үнэн. Улсын Их Хурлын гишүүнээр орж ирчхээд, төсөв хэлэлцэхэд, энэ хөгжлийн төлөвлөгөөг батлахад хаа хамаагүй зүйл, заалтуудыг горимын санал гаргаад оруулдаг л байхгүй юу даа. Тэгэхээр энийг хэдүүлээ одоо цэгцлэх хэрэгтэй байгаад байна. Цаг бүр үнэтэй байгаад байна. Бодлогын төлөвлөгөө маань хорьхон хувийн биелэлттэй байгаа бол энэ чинь буруу шүү дээ, тийм биз дээ? Тэгэхээр энийг л засах хэрэгтэй байна гэж хэлээд байгаа байхгүй юу даа. Намайг зөв ойлгоорой би.

С.Бямбацогт: Тийм, үндсэндээ хуулиа хэрэгжүүлье, зарчмаа барья л гэсэн асуудал хэлж байна шүү дээ. Тэгэхгүй гишүүд маань төлөвлөгөөгөө уялдаагүй болгодог, гишүүд маань өөрсдөө хийчхээд байна гэдгээ анхаарах ёстой гэсэн санал хэлж байна гэж ойлголоо. Гишүүд анхааралдаа авъя. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Би хэдэн зарчмын юм хэлье. Дээрээс нь асууж байгаа шүү. 1 дүгээрт энэ төрийн ажил бол үйл хэрэг. Энэ алба барьж байгаа, аргацааж байгаа зүйл биш. Энэ үйл хэрэг байхгүй юу. Эх орны төлөө тангараг өргөсөн хүмүүс сайн, муу хэлүүлэх нь хамаа байхгүй, урагшаагаа шийдэл гаргаж явах ёстой бөгөөд тэдгээр шийдэл иргэдийн, олон нийтийн итгэл үнэмшилд суурилсан, сонгуулийн мөрийн хөтөлбөрт үндэслэсэн, ил тод, нээлттэй, иргэдээ оролцуулдаг, судалгаа тооцоололтой, нотолгоотой байх ёстой.

Гэтэл сүүлийн үед дарга нар бол ингээд ийм хүмүүсээс асуухгүй, хүч хэрэглэдэг, тулгадаг, иргэдийн санаа бодлыг үл хэрэгсдэг, тэгээд түүнийгээ ямар нэгэн байдлаар ноцож доромжилж тайлбарладаг болсон. Ялангуяа хот дээр энэ асуудал удаа дараа давтагдаж байна. Тэгээд даварсаар, даварсаар Дагвын оронд гэгчээр иргэдээсээ том, Их Хурлаасаа том дунд шатны албан тушаалтнууд бий болсон. Тийм учраас энэ алба барих үйл хэрэг биш. Яагаад гэхээр энд Монгол төрийн ихэнх яамнуудын сайд болон голлох шийдвэр гаргаж, бодлого боловсруулахад боловсруулалт хийж байгаа хүмүүс энд сууж байгаа.

Өнгөрсөн нэг жилийн өмнө яг 365 хоногийн өмнө 25 оны 5 сарын 8-ны өдөр Магнайсүрэн дарга томилогдсон. Таны нэг жилийн ойн өдөр өнөөдөр болж байна. Хоёулаа 1 асуудлыг 3, 4 удаа ярилаа. Танд би бичиг явууллаа. Танд зовлон байх шиг байна. Таны сая дүгнэлт дээрээ харагдаж байгаа хэмжигдэхүйц бус байна энэ төлөвлөгөө. 2 дугаарт хөрөнгө оруулалтыг бодит болгох үе шаттай стратегитай байхгүй байна. 3 дугаарт шалгуур үзүүлэлт, зорилгууд тодорхой бус байна гээд та хэлээд байгаа. Энэ бүх зүйлийн нууц юунд байна вэ гэхлээр, шалтгаан юунд байна гэхлээр өмнө нь Бямбацогт даргыг томилогдоход хэлж байсан. Энэ төсөв бөгөөд төсвийн хүрээ энэ төлөвлөгөөнүүд чинь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа хэмжүүр нэгж нь тодорхой болоод, энэ бүх зүйл чинь түүнд нийцэж байгаа эсэх талаар хяналт тавих ёстой. Тэгэхгүй болохлоор төсөв болохлоор тойрог, тойрог руугаа, салбар, салбар луугаа мөнгө татах уралдаан болдог. Зарим нь тэгээд популизмд өртдөг ингээд хяргуулчихдаг. Яг мөнгө очих ёстой, бодлого очих, ёстой шийдэл очих ёстой газрууд нь хохироод үлддэг. Тэгээд улсын хөгжил гацдаг. Тэгэхээр энэ асуудал дээр Магнайсүрэн дарга яг ямар нөхцөл байдалд байгаа юм бэ, та ямар үйлдэл нэг жилийн дотор хийв? Энэ дээр эргээд би яг нэг жилийн дараа асууна гэж танаас асууж байснаараа одоо асууж байна.

Дараа нь 24 онд ЗГ 4 жилийн хөтөлбөрөө батлахдаа 578 зүйл, заалттай 11 хэмжих нэгжээр баталсан. Тэгэхээр одоо ингээд Их Хурал бүрэн эрх талдаа орчихсон байхад ядаж 50 хувь энэ чинь хэрэгжчихсэн байх ёстой шүү дээ. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн сайд Энхбаяр сайдаас асууж байгаа нь, тухайн мэргэжлийн хүмүүс нь хариулмаар байна. Яг 24 оны 7 сарын 5, ингээд 26 оны 5 сарын 8-ны хооронд эдийн засгийн чинь метриксүүд 11 тутмаараа яг ямар, ямар байгаа юм бэ? Хүний хөгжлийн индекс яг зорилтынхоо хэдэн хувьд нь оччихоод байгаа юм бэ? Авлигын индекс бид мэдэж байгаа 10 байраар ухарчихсан. Өрсөлдөх чадварын индекс гээд бусад индексүүд дээр яг хэлмээр байна. Энийг яг ингээд товчлоод хэлээч?

Дараагийн нэг асуудал, энэ Бүтээмэл Оюун буюу хиймэл оюун гэж хэлээд байгаа энэ зүйл үр ашгийг 70 хүртэлх хувьд хүргэнэ гэж үзээд байгаа. Гэтэл Бүтээмэл Оюун чинь 3 сар тутам буюу улирал тутам нэг generation буюу нэг үе ахиад яваад байна. Өөрөөр хэлбэл 24 онд ЗГ байгуулагдсанаас хойш 8 үе хиймэл оюуны үе өнгөрчихлөө. Тухайн үед төлөвлөж байсан зүйл одоо ингээд энэ чинь технологийн хувьд маш том инновацийн боломж бий болчихлоо. Энийг төлөвлөгөөндөө хэр зэрэг ашиглаж байгаа юм бэ, төлөвлөгөөгөө гаргахад жишээлбэл симуляцыг энэ хиймэл оюун дээр хийж байна уу? Expectation буюу төсөөллийг, үр дүнг тооцож гаргаж байна уу? Энэний яг ашиглалт ямар байгааг хариулаач? 1 минутаа авчихъя дарга, 1 минутаа.

С.Бямбацогт: Хариулчхаад авах юм уу?

С.Эрдэнэболд: Үгүй ээ үгүй, шууд авчихъя.

С.Бямбацогт: Одоо. Эрдэнэболд гишүүнийг сунгаад өгчихье нэг минут. Асуултаа гүйцээж асууя.

С.Эрдэнэболд: Тэгэхээр хэдэн жилийн урьд бол бид цар тахал гээд хамаг шалтгийг тийшээ тавьчихдаг байсан. Түүний дараа Орос Украины асуудал гээд тийшээ тавьчихдаг байсан. Одоо ярьж байгаа зүйл нь геополитикийн нөхцөл байдлаас болоод гэж ярьж байгаа. Нөгөө алтны үнэ ч гэдэг юм уу ингээд олон юм ярьж байгаа. Тэгэхээр яг одоо энэ олон улсад өрнөөд байгаа нөхцөл байдлыг эдийн засгийн хэмжих нэгжүүдээр үзвэл хэчнээн хувь яг өнөөдрийн нөхцөл байдалд нөлөөлөөд байгаа юм бэ? Өөрөөр хэлбэл энэ геополитикийн асуудал ба эдийн засагтайгаа ийм versus буюу уялдааг нь та нар яг тодорхойлж өгөөч? Ингэхдээ энэ үндэсний сөрөн тэсвэрлэх чадвар, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх гэсэн энэ зорилт чинь эдийн засагтайгаа яаж уялдаж байгаа юм бэ, энийг төлөвлөгөөндөө юу гэж тусгасан юм бэ? Ард иргэд бол одоо махны үнэ л ярьж байна шүү дээ. Бодитойгоороо нөхцөл байдал хүнд байна. Хариултаа аваад, дахиад нэг тодруулгын эрхээ эдэлье.

С.Бямбацогт: Магнайсүрэн дарга эхлээд хариулъя, Үндэсний аудитын газрын дарга, ажлын хэсэг 3 дугаар микрофон.

С.Магнайсүрэн: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Манай Үндэсний аудитын газраас 1 дүгээрт төслийг боловсруулах явцад саналаа өгсөн. 2 дугаарт өнгөрсөн жилийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд нийслэлийн аудит хийж, шийдлээ гаргаж, зөвлөмжөө өгсөн байж байгаа. Энэ хүрээндээ авч үзээд энэ жилийн төлөвлөгөө дээр харьцангуй боловсруулахад ахиц дэвшил байна. Гэхдээ 4 зүйл дээр онцгой анхаарах шаардлагатай гэж ингэж юу гаргаж шийдэл гаргасан. 1 дүгээрт зарим арга хэмжээний үр дүнг үнэлэх боломжгүй байдалд хүрэх эрсдэл байж болзошгүй байна гэдгийг нь тодорхой хэлсэн. 2 дугаарт зорилтот түвшин хэмжигдэхүйц бус, ижил агуулгаар тусгагдсан 30 төсөл, арга хэмжээ байна гэж ийм жагсаалт гаргасан. Тухайлбал юу гэдэг юм хүний эрх, эрх чөлөөний хамгаалалтыг сайжруулна гээд суурь түвшин 84, зорилтот түвшин бас 84 гээд ингээд, ижил агуулгаар ингээд 30 арга хэмжээ тавьчихаад байна. Энийгээ хэлэлцүүлгийн шатдаа анхаарч үзээч. Хэмжигдэхүйц болгоё гэсэн ийм юу хэлсэн.

Дээр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдээ судалгаа тооцоотой эрэмбэлж оруулах нь зүйтэй. Энэ хуульд заасан шалгуур үзүүлэлтээ сайтар баримталъя, зарчмаа баримталъя гэдгийг хэлсэн. Мөн төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилтийн нөхцөл, үр өгөөжийг нарийвчилж, энэ хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх стратегиа эрэмбэлж ингэж авч үзэх нь зүйтэй гэсэн ийм байдлаар хэлсэн байж байгаа.

Таны ярьдаг нөгөө нэг том шалгуур үзүүлэлт бол Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хэрхэн нийцсэн юм бэ гэдэг энэ асуудал байж байгаа. Миний хувьд өнөөдөр жилийн хугацаанд Аюулгүй байдлын ажлын албатай би хэд хэдэн удаа холбогдсон, бичиг цаасаа нэлээн солилцож, мэдээллээ солилцсон. Одоогоор яг ажиллаж байгаа учраас би 6 сарын 10-нд ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл орж ирэх үед энэ асуудал тодорхой болоод, юмнууд энэ

чиглэлээр хийгдээд ороод ирэх болов уу гэсэн ийм урьдчилсан хариултыг танд өгөхийг, өгье. Баярлалаа.

С.Бямбацогт: Ер нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэх ёстой. Гэхдээ Үндэсний аудитын газар нийцлийн аудит хийнэ гэдэг маань төрийн бодлогын бичиг баримтуудтай нийцэж байна уу, үгүй юү гэдгийг үзэх үүрэгтэй шүү дээ. Санхүүгийн аудит, гүйцэтгэлийн аудитаас гадна. Тэгээд тэр боломжтой л баймаар юм. Боломжгүй бол тэгээд хууль санаачилъя л даа хэдүүлээ Эрдэнэболд гишүүн. Зохицуулалт нь байгаа бол хийх ёстой л доо. Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: 5 жилийн үндсэн чиглэлд нийт 516 индекс үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг ашиглаж тооцоолол гаргаж байгаа. 24 онд эдийн засаг 5 хувь өслөө, 25 онд 6,8 хувь өссөн тогтвортой байна. Инфляц 25 оны эцэст 7,5 хувь буюу зорилтот интервалд байсан, өнөөдөр 7,4 хувь 1 дүгээр улирлын байдалтай байна. Ажиллах хүчний оролцооны индекс сүүлийн жилүүдэд тогтвортой өссөөр 63 хувьд бид ажиллах хүчний оролцоогоо хангаж байна. Үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн индекс 40 хувь байгааг 52 хувь, байгаль орчны гүйцэтгэлийн индекс 25 онд 37,2 оноотой байгааг бид 27 онд 40 оноонд хүргэх ийм зорилттой ажиллаж байна. Хүний хөгжлийн индекс 25 онд 0,756 байгааг 27 онд 0,781-д хүргэнэ. Засаглалын үзүүлэлт 25 онд 114 дүгээр байрт эрэмбэлэгдэж байгаа бол 27 онд 7 байраар ахиулна, эдийн засгийн үзүүлэлтүүд сүүлийн 2 жил дажгүй тогтвортой гарч байна. Мэдээж эрсдэл байгаа, энд хариу арга хэмжээнүүдийг бид.../минут дуусав/

С.Бямбацогт: Энхбаяр сайд асуултаа дуусгая хариултаа.

Ж.Энхбаяр: Багтахгүй байна минутад. Дээрээс нь энэ сая эрсдэлийг яаж тооцож байна гэж. Гол эрсдэл нефть бүтээгдэхүүн байгаа. Энэ Ормузын хоолой, Орос Украйны дайнтай холбоотойгоор 100 хувь манайх импортоор хангаж байгаа нефть бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотойгоор эдийн засгийн суурь үнэ инфляцад нөлөөллүүд үүсэж байна. Дагаад хүнс, эм, бордоо, тэсрэх бодис гээд манай гол суурь үнэ тогтдог нөлөөлдөг бүтээгдэхүүнүүд импортын хамаарал их өндөр байна. Ингээд энэ чинь нэг баррель нефть яаж өсөхтэй холбоотойгоор бид дандаа нөлөөллүүдийг нь тооцож байгаа. Өнөөдрийн түвшинд 1 баррель нефть 110-аас 120 түвшинд байхад инфляц 2 оронтой тоонд хүрэх ийм эрсдэл бодитой байна. Энэний эсрэг бид хариу арга хэмжээнүүдийг үе шаттай авч хэрэгжүүлж байна. Нефтийн нийлүүлэлтийг тогтвортой байх, үнийг жилийн гэрээ хийх, мөн инфляцад нөлөөлж байгаа хүнсний бүтээгдэхүүний энэ жилийн хаврын тариалалтыг хямд үнийн.../минут дуусав/

С.Бямбацогт: Эрдэнэболд гишүүн нэмэлт асуулт нэг минут.

С.Эрдэнэболд: Их Хурлын даргаа ерөөсөө энэ ҮАБЗ-өөс тэр Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд төсөв нийцэж байгаа эсэх талаар шалгуур үзүүлэлт гаргачих боломжтой байгаад байгаа юм эрх зүйн хувьд. Тэгэхээр та энэ дээр манлайлаад, аюулгүйн зөвлөлдөө энийг оруулаад гарчихвал энэ аудитад хяналт тавихад амар. Би уг нь Магнайсүрэн даргад тусалж хэлээд байгаа юм шүү дээ энийг. Тэгээд жилийн өмнө хэлсэн, одоо жилийн дараа яг хэвээрээ байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр нэг ахиц гаргаж байж энэ бол яг бодитой төсвийн үр ашигтай байдал, төлөвлөгөө рүү орчих гээд байна нэг.

2 дугаарт яах вэ Энхбаяр сайдаа нөгөө юу л юм л даа яг энэ нөгөө 4 жилийн бидний төлөвлөгөөнийхөө хэдэн хувь нь биелчихсэн байгаа юм бэ гэж? Мөнгөнсүх дарга нэмээд хариулчихвал тэр хиймэл оюуны яг энэ ашиглалт ямар хувьтай байгаа юм бэ гэдгийг хариулчихмаар байна?

Дээрээс нь би энэ хэнд Батшугар сайдад баяр хүргэмээр байна. Яагаад гэхлээр эхэндээ энэ салбарын бус гэж байсан, богино хугацаанд салбараа том зургаар нь харуулж чадаж байна шүү дээ. Том зургаар нь хүмүүст ойлгуулж чадаж байна. Тийм учраас яг иймэрхүү бодлогыг ил тод.../минут дуусав/

С.Бямбацогт: Магнайсүрэн дарга тэр Эрдэнэболд гишүүний ярьж байгаа тэр шийдэл Их Хуралд танилцуулаарай. Бид дараад нь тэгээд албан журмаар албан бичгээр танилцчихъя. Номин сайд хаачсан бэ? Тэр цахимтай, хиймэл оюун ухааны хэрэгжилт, гүйцэтгэл гээд асуудал ярьж байна. Одоогоор эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа шүү дээ. Номин сайдыг дуудаарай. Эрдэнэболд гишүүний асуултад хариулах ёстой.

Өнөөдөртөө гишүүдээ цагаа сунгаж байгаад хэлэлцэх асуудлаа дуусгая. Тэгэхгүй бол хуулийн хугацаатай учраас энийг ирэх долоо хоногт шилжвэл нэг том 7 хоног алдаад, энэ Монгол Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө гэдэг энэ том асуудлыг богинохон хугацаанд чанаргүй хэлэлцэх тийм эрсдэл үүсэх учраас энэ 7 хоногтоо өнөөдөртөө багтаагаад санал хураалттай. Санал хураалттай учраас гишүүд маань тэгээд яаж ийгээд ордондоо 7, 8 цаг хүртэл байж байгаад, тэгээд санал хураалтдаа идэвхтэй оролцоорой. Хуралдаан зохион байгуулах газар Улсын Их Хурлын нам, бүлгийн ажлын алба, Улсын Их Хурлын гишүүдийн зөвлөх, туслахуудад дамжуулж хэлээрэй. Ингээд жоохон ажил хэрэгч байцгаая. Нэг өдөр нэг жоохон сунаад хуралдчихъя. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Манай Монгол Улс уул уурхайн гол эдийн засаг уул уурхай дээр байдаг. Тийм учраас энэний экспортын асуудал, ялангуяа хилээр экспортлох асуудал маш их чухал. Хилээ хаавал хохирол үүснэ, хохирол учирна, түгжрэл үүснэ. Ер нь хилээ хөгжүүлж байж, нээлттэй байлгаж байж Энхбаяр сайдаа, хилээ хөгжүүлж байж ер нь нэлээн амжилтад хүрнэ. Хил хамгаалалт гэдэг зөвхөн улсын үндэсний аюулгүй байдлын асуудал биш. Ер нь тэр тухайн тухайн хил нь улс орны болон тухайн бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн асуудал байж байдаг. Тэгэхээр саяхан яасан бэ гэхээр 2 ЗГ хоорондоо солигдох үед нэг ЗГ-ынх нь хилийн боомттой холбоотой авч байсан арга хэмжээг үгүйсгээд, мэдээж асуудал байсан байх, ялангуяа тэр Гашуун Сухайт энэ тэртэй холбоотой асуудлууд байсан байх, тэрийгээ ярина биз. Гэтэл бусад Хилийн боомтын боомтын хөгжлийн корпорац ч билүү нэг тийм корпорац дээр тодорхой хэмжээний газруудыг аваад, тэр нь төрийн өмчийн компани, тэгээд тэр нь буцаагаад тэр яг тухайн орон нутгийн боомтын хөгжилд хэрэгтэй тэр газруудыг хурдан шуурхай шийдээд, боомтоо хурдан нэвтрэх, боомтоор нэг хурдан нэвтрэх тэр арга хэмжээг авах тийм зүйлийг хийж байсан юм байна лээ. Тэгээд ер нь энэ жоохон улс төр болоод ингээд явсан байх.

Зарим нэгэн тэр хилийн боомтын хөгжлийн корпорацтай холбоотой асуудал байсан байгаа байх. Түүнийгээ нэг талд нь гаргаад, урьд нь ЗГ-ын явуулж байсан тэр боомтын хөгжилтэй холбоотой зарим нэгэн зүйлүүдийг илүү урагшаа хараад явуулахгүй бол болохгүй нь. Зарим нэгэн хүмүүс газар зарж, газар зарна гээд тэр албан тушаалтнууд яваад байсан сураг байгаад байх юм. Түүнийг нь нэг талд нь гаргачхаад, тэгээд ер нь асуудалгүй байгаа тэр хилийн боомтуудыг хурдан шуурхай

асуудлыг нь шийдээд, тухайн бүс нутгийн экспортод нөлөө үзүүлсний үр дүнд илүү сайн хөгжих ийм боломж нь бүрдэж байгаа. Жишээ нь манай Ховд аймаг гэхэд Хөшөөтийн уурхай дээр 2 том уурхай МоЭнко, Зүүн Хөшөөт гээд 2 уурхайтай. Гэтэл яг Ярантын боомтоор болохлоор дөнгөж хоёр зуугаадхан машин нүүрс гаргах ийм дээд тал нь боломжтой. Гэтэл одоо Байтагийн боомт, Ярантын боомтын урд талаар голын урд талаар гарц нээгээд бараг мянгаад машин нүүрс гаргах ийм боломж нь байгаад байгаа байхгүй юу. Тэгвэл орон нутагт орж байгаа орлого, дээрээс нь ААН компани, иргэдийн тэр нүүрс тээврийн үйл ажиллагаанд нэлээн орлого орох ийм боломжууд хангалттай нээгдэх юм.

Тийм учраас явж байсан газруудын тэр үйл ажиллагааг нь илүү үргэлжлүүлээд, хурдан шуурхай явуулах талаар яг энэ боомтын асуудлаар тухай үед яг энэ асуудлыг гаргаж ирж тавьж байсан хүний хувьд Энхбаяр дарга ЗГХЭГ-ын дарга, сайд Энхбаяр ямар асуудлыг цаашдаа шийдэж, энэ боомтын хөгжлийг илүү хурдасгах, бүс нутгийн хөгжлийг сайжруулах талаар арга хэмжээ ирэх жилд авах вэ гэдгийг нь энэ жил болон ирэх жилд авах вэ гэдгийг нь асууя?

С.Бямбацогт: Баттөмөрийн Энхбаяр сайд хариулья.

Б.Энхбаяр: Боомтыг хөгжүүлэх асуудал бие даасан эрхэлсэн сайдтайгаар ч явж үзлээ. Одоогоор хилийн боомтын захиргааны асуудал Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгаа. Уржигдрын ЗГ-ын хуралдаан дээр Хилийн боомтын захиргааны даргаар өмнө нь ажиллаж байсан хүнийг чөлөөлж, томилогдсон. Хил хамгаалалттай холбоотой асуудал нь ХЗДХ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгаа. Хилийн зурвас газруудад 54 ашигт малтмалын хайгуулын болон бүр ашиглалтын тусгай зөвшөөрөл өгсөн асуудал ЗГ-ын хуралдаанд танилцуулагдаж байсан. Энэ асуудлыг миний бие танилцуулсан. Энэ асуудлаар хууль хяналтын байгууллага хууль тогтоомж зөрчсөн эсэх асуудлыг шалгасан нэг асуудал байгаа.

Таны асууж байгаа асуудал бол хилийн боомтууд дээр Боомтын хөгжлийн захиргаа гэдэг корпорац байгуулаад төрийн өмчийн, тэр корпорацын нэр дээр ЗГ-ын шийдвэрээр газар олгосон асуудлуудыг та хөндөж асууж байна. Энэ асуудлыг мөн хууль хяналтын байгууллагад тухайн үед шилжүүлсэн. Энэ дээр газрын давхцал байгаа. Тухайлбал Цагаандэлийн боомт дээр 2 хилийг холбосон төв маршрутын зам концессоор хийгдэж байгаа. Тэгсэн чинь тэр концессоор хийгдэж байгаа замын яг маршрутыг хаагаад, яг хилийнх нь гарц дээр нь давхцуулаад газар олгочихсон байгаа жишээлбэл. Өөрөөр хэлбэл тэр асуудлыг жишээлбэл тодруулах шаардлагатай, тэр хэмжээ, зааг, координатыг тодруулах шаардлагатай. Ер нь тухайн үеийн ажлын хэсэг бол юу гэж үзсэн бэ гэхээр энэ боомтуудын захиргаан дээр 1 дүгээрт ТЭЗҮ байхгүй байгаа. ТЭЗҮ нь одоо хийгдэж байгаа зарим Гашуунсүхайт Ханги 2 дээр.

Тэрэн дээр жишээлбэл би тодорхой хэлсэн шүү дээ. Энэ Соёлын дэд сайд байсан Батбаяр гэдэг хүний хамааралтай компани орчихсон байна. Тэр ТЭЗҮ-г нь хийж байгаа, төрийн өөрийн албан тушаалтнууд нь өөрсдөө оролцоод, өөрсдөө хийгээд байгаа юм. Энэ хууль хяналтын байгууллага шалгах ёстой асуудал шүү дээ. Ер нь тэр хилийн боомт, юу боомтын хөгжлийн захиргаа гэдэг тэр компанийн удирдлагаар ажиллаж байсан бүсгүй гадаад улсын хүмүүстэй газар наймаалах асуудал яриад яваад байсан байхгүй юу. ТЭЗҮ нь гараагүй. Тийм компанийн нэр дээр газрын зөвшөөрөл авчхаад, тэр газрынхаа зөвшөөрлийг ингээд бариад хүмүүстэй уулзаад яваад байсан байхгүй юу. Тийм учраас энэ асуудал анх

шалгагдсан юм ЗГ-ын ажлын хэсэг. Энэ юун учиртай хүн гадаад улсын хүмүүстэй хилийн газар зураг үзүүлээд үнэ яриад яваад байгаа юм бэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Пүрэвдорж гишүүн тодруулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ер нь Эдийн засгийн хөгжлийн яамнаас Ховдын Ярантын боомтын нэмэлт гарцын асуудлыг ТЭЗҮ болон зураг, төслийн мөнгийг нь тавиад хийж байгаа. Байтагийн боомтын байнгын ажиллагаатай болгох түүний зураг, төсөл бүх ажлыг нь бас Эдийн засгийн хөгжлийн яамнаас санхүүжүүлээд хийгдэж байгаа, бараг дуусаж байгаа байх. Тэгэхээр би эндээс 2 газрыг асуугаад байна л даа Энхбаяр сайдаа. Дөнгөж сая Батсуурь гишүүн бас асуугаадаг гэж байна. Яг энэ Бичигтийн боомт дээр асуудал байгаа юу, янз янзын тийм гэмт хэргийн шинжтэй тэр асуудал тэр Боомтын хөгжлийн корпорац дээр чинь байгаа юу? Ховдын тэр Ярант, Байтагийн боомт дээр асуудал байгаа юу? Байхгүй бол маш хурдтайгаар энэ урьд нь явж байсан тэр төсөл.../минут дуусав/

С.Бямбацогт: Асуудал байхгүй бол хурдан явуулмаар байна, асуудал байгаа юу гэж асууж байна. Саяын дурдсан 3 боомт. Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Энэ асуудлыг би яг шалгаад, ЗГ-т танилцуулаад 5 сар өнгөрч байна. Хууль хяналтын байгууллагад шилжүүлээд 4 сар өнгөрч байна. ХЗДХ-ийн сайдын ажлаа өгөөд 45 хонож байна.

С.Бямбацогт: ХЗДХ-ийн сайд Сайнбуянгийн Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: Пүрэвдорж гишүүнд хариулахад хилийн боомтын хөгжлийн асуудал төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх асуудал ХЗДХЯ хийхгүй. Та энийг маш сайн мэдэж байгаа. Таны яриад байгаа тэр ажлын хэсэгтэй холбоотой асуудал, ажлын хэсэг байгуулагдаад хуралдаагүй байгаа юм байна лээ. Би хуралдуулахаар товыг нь зарлачихсан байгаа. Хууль хяналтын байгууллага тэр 54 хилийн бүсэд ашигт малтмалын зөвшөөрөл олгосон гэх асуудалтай холбоотой хяналт шалгалтын ажлууд хийгдээд явж байгаа зүйлүүд бий. Тэр хилийн боомтын газрыг зарсан гэдэг асуудал шалгагдаад явж байгаа. Гэхдээ энэ зарчихсан, үгүй хийчихсэн асуудал байхгүй гэдгийг та бүхэн өөрсдөө мэдэж байгаа. Энэ Хилийн боомтын захиргаа гэж ковидын үед байгуулагдаж байсан энэ байгууллагын үйл ажиллагааг цааш нь ер нь нэг бол тэр Сангийн яам хуучин байсан Боомтын зөвлөл гэдгээ, эсвэл Хил хамгаалах.../минут дуусав/

С.Бямбацогт: Пүрэвдорж гишүүн тодруулъя.

Б.Пүрэвдорж: Би тэгэхээр ер нь яг хүмүүстэй адилхан, иргэдтэй адилхан л мэдээлэлтэй байгаа шүү дээ. Гэтэл хуучин сайд хийж байсан нөхөр нь би бүгдийг нь шалгаад нэлээн юм явуулчихсан. Одоо тэгээд ерөөсөө тэр хилийн боомт дээр газар зарсан асуудал чинь ерөөсөө шинэ сайдын үед алга болчихлоо ухааны юм ярьж байна шүү дээ. Та 2 наадхаа нэг хоорондоо ямар, ямар нөхцөл байдалтай хүлээлгэж өгсөн юм, одоо ямар нөхцөл байдалтай байгаа юм түүнийгээ олон нийтэд гарч мэдээл хоёулаа зогсож байгаад.

С.Бямбацогт: Амарсайхан сайд нэмж хариулъя.

С.Амарсайхан: Ерөөсөө хөл жийлцээд байгаа юм байхгүй Пүрэвдорж дарга. Энийг бид нээлттэй мэдээлнэ тэртээ тэргүй. Хууль хяналтын байгууллагууд нь яг хуулийн дагуу хяналт шалгалтаа хийгээд, хууль зөрчсөн юм бол тэрийг нь хуулийн дагуу арга хэмжээгээ авна. Хууль зөрчөөгүй бол тэрийг мэдээлнэ. Энэ хооронд хариуцсан, хариуцсан яамнууд чиг үүргийнхээ хүрээнд төрийн байгууллагууд ажлаа хийгээд, хэрвээ тэр хууль зөрчсөн, хуулиар хориглоогүй бол үйл ажиллагаа явуулах нь нээлттэй шүү дээ.

С.Бямбацогт: Ер нь энэ асуудал бас тэгээд л хэн нь үнэн ярьж байгаа, хэн нь худлаа ярьж байгаа нь мэдэгдэхгүй, ялангуяа Их Хурлын гишүүд, сайд нар дунд явсан шүү дээ. Тулга Боомтын сайд байхдаа ийм асуудал байхгүй гээд гарч ирээд мэдэгдсэн. Тийм болохоор нэг талд нь гаргаад шийдмээр байгаа юм. Тэгээд Их Хурал дээрээ гишүүд нь бие биеийгээ гэмт хэрэгт холбож гүтгэдэг. Сайд нар нь бие биеийнхээ хийсэн ажлыг үгүйсгэж ярьдаг. Аль нь үнэн яриад байгаа юм, аль нь худлаа яриад байгаа юм тийм үү энэ чинь төрийн өндөр албан тушаалтнууд. Төрийн өндөр албан тушаалтнууд хариуцлагатай үгээ хэлж байх ёстой, хариуцлагатай мэдэгдэл хийдэг байх ёстой. Тэгээд дээрээсээ авхуулаад бие биеэ гүтгээд, гэмт хэрэгт холбоод, үнэн, худлаа нь мэдэгдэхгүй мэдээлэл тараагаад байгаа чинь энэ төрд итгэх ард түмний итгэлийг алдруулаад байгаа. Энэ дээр тэгэхээр маш тодорхой хугацаанд, тодорхой үр дүн гаргая. ЗГ гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй, Үндсэн хуулиараа энэ ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Энэ үүрэгтэй үнэн бол үнэн, худлаа бол худлаа гэдгийг тодорхой хугацаанд, хэзээ байх вэ, тэгээд сураггүй алга болчихдог, ингээд алга болчихдог биш, хугацаатай чиглэл өгч байна энийг. Ямархуу хугацаатай байхыг нь ажлын шугамаар ярилцаад, шийдэх ёстой. Энийг Тамгын газар анхааралдаа аваарай. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Хуралдаан даргалагч сануулсан асуултад үнэн зөв, бүрэн гүйцэт гэж. Тэгээд 27 оны төлөвлөгөөтэй холбоотойгоор 6 бүлэг дотроос хэдэн асуулт асууя. Санхүүжилт төсвийн чиглэлээр 124 төсөл, 186 арга хэмжээний нийт санхүүжилт яг хэдэн төгрөгөөр хэмжигдэж байгаа вэ? Санхүүжүүлэлтийнхээ хэдэн хувийг улсын төсөв, гадаад зээл, бонд, уул уурхайн орлогоос бүрдүүлэх вэ гэж? Нүүрсний үнэ унах, Хятадын эрэлт буурах үед энэ төлөвлөгөөний хэдэн хувь нь санхүүжилтгүй болох эрсдэл байгаа вэ? Төсвийн алдагдал, улсын өрийн дарамт 2027 он гэхэд ямар түвшинд хүрэх тооцоотой байна вэ, эдийн засгийн өсөлтийн төсөөлөл ямар нүүрсний үнэ дээр, хэд дээр суурилсан юм бэ? Экспортын өсөлтийн тооцоондоо Хятадын эдийн засгийн саарлыг тооцсон уу? Хэрэгжилт хариуцлагын чиглэлээр 186 арга хэмжээ тус бүр дээр хэн хариуцах юм бэ, ямар хугацаанд, ямар KPI-аар дүгнэх нь тодорхой болсон юм уу? Хэрэгжихгүй бол ямар сайд, ямар байгууллага улс төрийн болон хууль зүйн хариуцлага хүлээх юм бэ?

Өмнөх тэр Алсын хараа, Шинэ сэргэлт бусад хөгжлийн төлөвлөгөөний хэдэн хувь нь бүрэн хэрэгжсэн бэ? Өмнөх төлөвлөгөөнүүд нь хэрэгжээгүй байхад энэ удаа юугаараа өөр болж байгаа юм бэ гэдэг? Тэгээд Монголын төрийн ЗГ-ын өнөөгийн тендер, худалдан авалт, төслийн менежмент, хяналтын чадавх чинь энэ 186 арга хэмжээгээ хэрэгжүүлэх хэмжээнд хүрсэн юм уу?

З-д нь авлига хяналтын чиглэлээр, төсөл бүрийн тендер, гүйцэтгэл, зарцуулалт хэрэгжилтийнх нь явц нь иргэдэд нээлттэй байгаа юу, нээлттэй байж чадах уу? Иргэд бодит цаг хугацаанд хяналт тавих тийм нээлттэй цахим систем бий болгох юм уу?

С.Бямбацогт: Амарсайхан сайд сууж байгаарай, танаас асууж байна шүү.

Б.Батбаатар: Том төсөл бүр дээрээ хараат бус аудит хийх үү? Авлигын эрсдэлийн урьдчилсан үнэлгээ хийсэн үү? Улс төрийн нөлөөтэй компаниуд мега төслүүд дээр давуу байдал авахгүй гэдгийг юугаар баталгаажуулж байгаа вэ? Авлига гарвал ямар түвшний албан тушаалтан хариуцлага хүлээх вэ?

4-д нь иргэдийн амьдралын асуудлаар. Энэ төлөвлөгөө хэрэгжсэний дараа жирийн өрхийн амьдрал яг юугаараа өөрчлөгдөх вэ? Иргэдийн бодит орлого инфляцаас давж өсөх баталгаа нь хаана байгаа юм бэ? Залуучууд байр авч чадах юм уу, шударга өрсөлдөөнд итгэж чадах юм уу? Монголдоо үлдэх тэр хүсэл сонирхол, шаардлага нь нэмэгдэх юм уу? Орон сууцны хүртээмжийн зорилтууд нь бодит орлоготойгоо нийцэж байгаа юу? Ядуурал статистикаар буурах уу, эсвэл иргэдийн бодит амьдрал дээр буурах уу? Статистик гээд нэг тоо байгаад байдаг. Бодит амьдрал дээр хөргөгч, хадгаламж, харилцах данс, өр зээл, хуримтлал, эдэлж хэрэглэж байгаа зүйлийнх нь насжилт болоод, тоо хэмжээ, чанарын үзүүлэлт, амьдралын чанар нь унаад байдаг.

Эрчим хүч, ногоон хөгжлийн чиглэлээр. Эрчим хүчний реформын зардал нь инфляцад ямар нөлөө үзүүлэх тооцоотой байгаа юм бэ? 27 он гэхэд бодитоор бууруулах боломжтой юу? Ногоон хөгжил ярьж байгаа мөртөө нүүрсний эдийн засгаас хэт хамааралтай хэвээр байгаа нь бодлогын зөрчилтэй асуудал болж байгаа юм биш үү? Сэргээгдэх эрчим хүчний бодит эзлэх хувь эрчим хүчинд хэдэн хувь болох юм бэ? Ус, агаар, хөрсний хамгаалалтын хэмжүүрүүдийг тоогоор тогтоож чадсан уу?

6-д нь төр ба оролцооны чиглэлээр. Энэ төлөвлөгөө төр төвтэй хэвээрээ байгаад байна. Иргэн, орон нутаг, хувийн хэвшлийн бодит оролцоо хаана байгаа юм бэ? Орон нутаг шийдвэр гаргах эрх мэдэлтэй болох уу, эсвэл зөвхөн хэрэгжүүлэгч хэвээр үлдэх юм уу? Монголд дахиад том төр байгуулах гэж байна уу, эсвэл хүчтэй иргэн, хүчтэй орон нутаг бий болгох гэж байна уу? 124 төсөл, 186 арга хэмжээний мөнгө яг хаанаас гарах юм бэ, хэрэгжихгүй бол хэн хариуцлага хүлээх.../минут дуусав/

С.Бямбацогт: Нэлээн олон асуулт асуусан. Тэргүүн шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд хариулаад, яг өөр өөрсдийн салбартай холбоотой асуудлууд дээр манай ажлын хэсэг болон сайд нар 1, 1 минутад багтаагаад хариулъя. Энхбаяр сайд, Ж.Энхбаяр сайд, Жадамбаагийн Энхбаяр.

Ж.Энхбаяр: Гишүүдээсээ хүсэхэд асуух асуултаа яг тэр салбар, тэр яам гэж асуувал их тодорхой бэлдээд хариулахад их, хариулт их үр дүнтэй оновчтой болох болов уу гэж. 15,3 их наяд төгрөгийн 124 төсөл, 186 арга хэмжээг 2027 оны хөгжлийн бодлого төлөвлөж байгаа. Санхүүжилт яаж шийдэгдэх юм бэ гэж. Улсын төсөв 2,2 их наяд, улсын төсвийн дээд потенциал энэ. Бид 3,6 их наядын үргэлжилж байгаа төсөлтэй байгаа 25, 26 онд хэрэгжиж байгаа. Ийм төслийг үүнээс 2,2-ыг нь бид улсын төсвөөс бид санхүүжүүлнэ. Шинээр нэг ч хөрөнгө оруулалт эхлэх боломж байхгүй. Тэгэхээр яах вэ бид гадаад зээлийн ашиглалт гэж байгаа. Гадаад зээлийн ашиглалт дээр 4,7 их наяд. Энд 4,7 их наяддаа багтаж энэ хүлээгдэж байгаа амлагдсан 18 их наядын гадаад зээлээ бид хамгийн эрэмбээр нь хэрэгжүүлж эхэлнэ гэсэн үг.

Гадаадын энд гол энэ Монгол Улсын хэмжээний энэ чинь зөвхөн төсвийн асуудал, төсвийн хүрээний асуудал биш шүү дээ. Улсын хөгжлийн бодлогын асуудал болохоор бүхий л Монгол Улсад ажиллаж байгаа, хөрөнгө оруулж байгаа, дотоодын, гадаадын хувийн, төрийн бүх байгууллагуудын хийгдэх бодлогын арга хэмжээнүүдийг гол, гол ажлын буюу Монгол Улсын эдийн засагт нөлөөлөхүйц, нөлөө үзүүлэхүйц гол салбаруудыг нь нэгтгэж хийж байгаа юм. Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулалтаар 1,6 их наяд төгрөгийн ажлууд хийгдэнэ. Энэ бол яг хийгдэж байгаа, ялангуяа голлон уул уурхайн салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт, геологи хайгуул, уурхайн бүтээн байгуулалт, барилгын ажлуудыг оруулж байна.

Төр, хувийн түншлэлийн гэрээгээр 1,5 их наяд. Бөөрөлжүүтийн цахилгаан станцаас авхуулаад, Баянгийн цахилгаан станц, ТЭЦ 5 бүгдийг нь төр, хувийн хэвшлээр хийнэ. Чойр, Замын-Үүдийн замын асуудлыг мөн төр, хувийн хэвшлийн түншлэлээр, Дархан-Алтанбулаг чиглэлийн авто замыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр, боллоцоотой бол Лүнгийн чиглэлийн замыг хүртэл төр, хувийн хэвшлийн түншлэлээр л явуулна.

Эдийн төсвийн өөрийн чадавх, хөгжлийн хөтөлбөрт хөрөнгө оруулах чадавх бид хязгаарлагдмал болсон. Нэгэнт ийм байгаа үед төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын шууд хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн төслүүд манай энэ санхүүжилтийн гол хувийг үндсэндээ 80 хувь нь энэ хэлбэр л цаашдаа авч байгаа юм. Орон нутгийн төсөв 0,2 их наяд, гадаадын тусламж 0,3 их наяд, улсын төсөв 2,2 их наяд, дотоодын хөрөнгө оруулалт 4,5 их наяд. Харьцангуй дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулах чадвар сайжирч байгаа. Энэ хийгдэж байгаа олон төсөл, хөтөлбөрүүд чинь энэ барилга угсралтууд чинь дотоодын хөрөнгө оруулалтаар хийгдээд байгаа. Энэ болгоныг оруулж тооцож бүх салбаруудын дүнг нэгтгэж байгаа.

С.Бямбацогт: Гараа өргөөд манайтай холбоотой ийм асуудал дээр хариулт өгье гэх ажлын хэсгийн гишүүд, сайд нар байна уу? Алга бол юу яая, Доржханд сайд, дараад нь байгаль орчныхон. Тэгээд дутуу асуултуудад бичгээр л дараад нь хариулт өгүүлье.

Т.Доржханд: Би товчхон хариулчихъя. Батбаатар гишүүнтэй санал нэг байгаа. Тэгээд бид нөгөө хүрэн нүүрснээс хамаарсан ийм эрчим хүчний салбартай. Тэгээд байгаль орчны чиглэлээр ногоон хөгжлийн бодлого алдагдчихсан байсан. Тэгээд 2030 он гэхэд бид ногоон эх үүсвэрээр тухайлбал 30 хувийг хүргэнэ эрчим хүчний салбарт, тэгээд ногоон шилжилтийг хийнэ гээд явж байгаа. Тэгээд энэ Учрал Ерөнхий сайдын ЗГ-ын тавьж байгаа 4 бодлогыг нь чөлөөлье гэж байгаа нэг нь ногоон чөлөөлөлтийг хийе гээд. Тэгээд 30 хоногийн дотор шийдвэрээ гаргаад, ЗГ зарлаад, тэгээд сэргээгдэх эрчим хүчин дээр дуудлага худалдааг нээлттэй, ил тодоор зарлаад явж байгаа. Тэгээд энэтэй холбоотой нарийн мэдээллийг Эрчим хүчний сайд өгөх байх. Ер нь энэ дээр ЗГ хав хатуу байр суурьтай байгаа. Тэгээд цаашаа зөвхөн.../минут дуусав/

С.Бямбацогт: Энхбаяр сайд нэмж хариулъя, Ж.Энхбаяр.

Ж.Энхбаяр: Эх үүсвэрүүдээ та нар боломж ямар байна нөхцөл байдал гээд. Ер нь экспорт их сайн байгаа. Өмнөх оны яг мөн үеэс экспорт 63 хувиар өсөөд байгаа. Манай нүүрс бид ганцхан нүүрснээс хамааралтай эдийн засаг тун эмзэг байсан, одоо зэс ороод ирлээ. Зэс анх удаа нүүрснээс давсан 25 хоногийн

гүйцэтгэл. Одоо бидэнд дараагийн ашигт малтмал буюу алтыг эргэлтэд оруулах гэж байгаа буюу нэг салбараас хамааралтай байдлаа багасгана бидний зорилго. Нөгөө талаар зэсээ цэвэршүүлье, зэс дээр ноогдоод байгаа АМНАТ-н хувь хэмжээг өөрчлөх хуулийг Ашигт малтмалын хуулиар оруулж ирнэ. Ингэснээр нөөц тогтоогдсон 21 ордод хөрөнгө оруулалт хийх таатай нөхцөлийг бүрдүүлнэ. Нүүрсээ бид баяжуулах хүчин чадлыг байнга нэмнэ. Баяжуулсан нүүрс буюу биржийн арилжаа гэдэг маань манай өрсөлдөх чадварыг байнга нэмж байгаа нэг ийм зүйл болоод байна.

С.Бямбацогт: Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд Сандаг-Очир асуултад хариулъя.

Ц.Сандаг-Очир: Ганцхан минутад Батбаатар гишүүн ус, агаар, хөрсний хамгааллын хэмжүүрүүдийг тоогоор тогтоосон уу гэсэн. Тийм тоогоор тогтоож байгаа ус, агаар, хөрсний хамгаалалтын бодлогыг бүгдийг нь бодит тоон шалгууртайгаар төлөвлөсөн. Тодорхой төсөв тавьсан байгаа. Тухайлбал агаарын чанарын хувьд РМ 2,5 тоосонцрын хэмжээг 53-аас 50, РМ 10-ыг 107-гоос 96, азотын давхар ислийг 47-гоос 45, хүхэрлэг хийг 68-аас 66 гээд ингээд бүгд тоон үзүүлэлтээр ингээд тавьсан байгаа. Нөгөө талаар усны чанарын хувьд маш бохир ангилалд багтах цэгийн тоог 6-аас 5 болгож бууруулна. Хөрсний чанарын хувьд хүнд металлын бохирдол, стандарт давсан цэгийн эзлэх хувийг 17,2-оос 13,2 хувь болгон бууруулах зэрэг ийм тодорхой хөгжлийн төлөвлөгөөнд тоон зорилтууд маань тодорхой туссан байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Батбаатар гишүүн асуулт тодруулж асууя.

Б.Батбаатар: Ерөнхийдөө яах вэ, санхүүжилт, төсөв гэдгийг нь Ж.Энхбаяраар бүлэглээд хэдэн асуулт асуусан юм. Хэрэгжилт хариуцлагын асуудлаар Б.Энхбаяр сайдаас асуусан юм. Авлига, хяналтын асуудлыг Хууль зүйн сайд Амарсайханаас асуусан. Иргэдийн амьдралын асуудлыг Ж.Энхбаяр сайд Шадар сайд. Эрчим хүч, ногоон хөгжил мэдээж Байгаль орчин болон Шадар сайд Доржханд нараас асуусан. Төрийн оролцооны асуудлыг Б.Энхбаяр сайдаас асуусан. Тэгээд зарим сайд нар маань хариулсангүй, хуралдаан даргалагч хурал эхлэхэд хэлж байгаа юм асуултад үнэн зөв бөгөөд бүрэн гүйцэд хариулна гээд. Тэгээд энэ Их Хурлын гишүүд нь асуулт асуухаар 3 асуултын нэгийг нь хариулаад бусдыг нь хаячихдаг. Энэ чинь ер нь яах ёстой юм бэ? Хариулахгүй байгаа чинь үнэн зөв битгий хэл, бүрэн гүйцэд алиндаа ч хамаарахгүй шүү дээ.

С.Бямбацогт: Тийм болохоор Их Хуралд хүндэтгэлтэй хандах ёстой гэдэг чинь хуралд ирэх ёстой бол ирж асуултад хариулах үүрэгтэй. Тийм учраас л би сая Амарсайхан сайдыг хуралдаа суу, асуултад хариул, танаас асууж байна шүү гэж хэлж байхад гараад явчихлаа, дуудаарай. Б.Энхбаяр сайд. Одоо асуултад бүрэн гүйцэд хариулахгүй бол Энхбаяр сайд юу яачихъя, Ж.Энхбаяр сайд Эдийн засаг, хөгжлийн яам дутуу асууж байгаа асуултуудад бичгээр гишүүдэд гүйцээж хариулт өгье. Тэгээд 1 минутад бүрэн хариулж амжихгүй байж болно. Тийм болохоор дутуу хариулагдаж байгаа, хариулагдахгүй байгаа асуултуудад Батбаатар гишүүний асуусан асуултуудад ирэх долоо хоногт бичгээр хариулт өгөөрэй. Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд үдшийн мэнд хүргэе. Ерөнхий сайд маань дахиад л гараад явчихлаа. Уялдаа холбоо байхгүй байгаагийн илэрхийлэл энэ байж

магадгүй. Дахиад л нөгөө 6, 7 сайд маань л байна. Төлөвлөгөөг нь ярих гээд байгаа юм. Тэгээд асууя даа, 2 жилийн өмнө нэг мега, мега төсөл яриад эхэлсэн. 2 жилийн дараа мега, мега хулгай яриад сууж байгаа шүү гэдгийг холбогдох сайд нар анхаараарай. Би яг тодорхой асууна. Энхбаяр сайд маш сайн захиж хэлсэн учраас. Ерөнхий сайдаас асуух гэж байсан юм.

Авлига яг яаж буурах юм бэ, авлигын индекс хэдэн байраар сайжирч, хэдэд хүрэх юм бэ? Төрд орж, цүнх барьж, МАН-д элсэж төрөл садангаараа төрөөс тэрбумтан төрдөг энэ схемийг яаж буулгах юм бэ гэж Ерөнхий сайдаас асуух гэсэн, бас алга байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаас Алт 3 хөтөлбөр ямар шатандаа явж байгаа вэ, хэрэгжих юм уу? Хайгуулын ч юм уу, олборлолтын ч юм уу, ашиглалтын ч юм уу лиценз олгогддог. Лицензтэй компаниуд нь ажлаа хийх гээд яваад очихоор нутгийн иргэд сүүлдээ урдаас нь буу барьдаг боллоо шүү дээ. Ажил хийх юм уу, хийхгүй юм уу? Энэ дээр та нар ямархуу шийдэл гаргаж байгаа юм бэ?

Тэгээд Хэрэг эрхлэх газрын дарга эсвэл ТӨБЗГ-ын даргаас асууж байна. Эмх замбараагүй үрэлгэн төрийн өмчүүдээ хэзээ цэгцэлж, үр дүнд хүрэх юм бэ? Төрийн банкиг энэ цагаан байрны нэг даргын үеэл нь төрөөс төрдөг тэрбумтны жишээ болоод сууж байгаа. Хурлын дарга Бямбацогт дарга тэнчээ сууж байхдаа хэлж байсан бид салгана гэсэн, одоо хэдэн хувьтай, ямар явж байгаа юм бэ одоо Энхбаяр сайд хариулах юм уу, ТӨБЗГ хариулах юм уу?

Эрчим хүчний сайдаас асууя. Өнгөрсөн өвөл Улаанбаатар бараг л тоггүй цахилгаангүй өвөлжихөө алдсан. Цахилгаанаа яаж нэмэгдүүлэх юм бэ, дулааны эх үүсвэрийг яаж нэмэгдүүлэх юм бэ? Баянхонгор аймагт баригдах Байдрагийн УЦС-ыг хэзээ барих юм бэ?

Монголбанкны Ерөнхийлөгч нь ороод ирчихсэн сууж байна. Монгол төгрөгийн үнэ хэзээ нэмэгдэх вэ буюу Монгол төгрөг бусад валютын эсрэг хэзээ чангарч эхлэх вэ? Та нар тэнчээ ажил хийх гэж сууж байгаа болохоос зовлон бэрхшээл тоочих гэж суугаагүй. Ипотекийн зээлийн хүртээмж хэзээ сайжрах юм бэ, байргүй иргэд хэзээ очерггүйгээр ипотекийн зээл авч, байрандаа ордог болох бодлого хэрэгжих вэ гэсэн яг ийм тодорхой асуудлууд дээр хариулт авмаар байна Их хурлын даргаа.

С.Бямбацогт: Эхний асуулт авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй хэрхэн яаж тэмцсэн, ямар үр дүн гарч байна. Амарсайхан ХЗДХ-ийн сайд хариулах ёстой. Энхбаяр ЗГХЭГ-ын дарга энэ сайд нараа дуудъя. Дараагийн асуудал Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд хариулна. Дараад нь Эрчим хүчний сайд, тэгээд Бат-Амгалан сайд, Монголбанк, ЗГХЭГ уу, эсхүл ТӨБЗГ уу гэсэн дарааллаар хариултаа өгөөд бэлдэж байгаарай. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Дамдинням сайд.

Г.Дамдинням: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Алт 3 аяны бэлтгэл ажил хангагдаад, УИХ-ын тогтоол гарсан, ЗГ-ын тогтоол саяхан гарсан. Энэ хамгийн сүүлийн ЗГ-ын хуралдаанаар ажлын явцыг танилцуулсан байгаа. Бид ямар арга хэмжээ авч байгаа вэ гэхээр байгаа одоо хууль тогтоомжийн хүрээнд төрөл бүрийн хориглолт, хязгаарлалтад орчихсон байгаа талбайнуудад Байгаль орчны сайдтай хамтарсан ажлын хэсэг байгуулж, Байгаль орчны яам, манай яам 2 хамтарч нэмэлт талбайнуудын хүрээ хязгаарыг нарийвчлах, дахин тогтоох ажлуудыг хийсэн. Нийтдээ 72 талбайд, 51 ААН-ийн 72 талбайд хамтарсан ажлын хэсэг яваад, ойрын 3 жилдээ алт олборлолтын хэмжээг 13 тонноор нэмэгдүүлэх ийм боломжийг гаргаж ирсэн. Ирэх долоо хоногийн 3 дахь өдөр ЗГ-ын хуралдаанаар энэ талбайнуудтай

холбоотой тогтоол гарна. Ингээд ААН-үүдийн үйл ажиллагааг эрчимтэй явуулна. Манай яамнаас уулын ажлын төлөвлөгөөг түргэвчилсэн горимоор шийдэж байгаа. Гарсан тогтоолын дагуу, ЗГ-ын тогтоолын дагуу энэ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас энэ байгаль орчны үнэлгээнүүдийг богино хугацаанд гаргах ийм үүрэг даалгаврыг өгүүлчихсэн. Ингээд бид эрчимтэй ажиллаж байна. Хүсэлтээ гаргасан ААН болгоны талбай дээр очиж үзэж, үнэлгээ хийж, шийдвэр гаргаад ингээд явж байгаа.

Хууль ёсоор ажлаа хийгээд явж байгаа уул уурхайн компаниудад саад учруулдаг энэ бэрхшээл маш их байгаад байгаа. Тэгээд хуулийн ямарваа нэгэн санкц байхгүй ийм нөхцөл байдалтай байна. Тэгээд ЗГ-аас сая Ашигт малтмалын хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өргөн барихаар шийдчихсэн. Тэгээд Зөрчлийн хуульд өөрчлөлт оруулахаар тогтсон байгаа. Зөрчлийн хуулиар удаа дараа ингээд асуудал үүсгэвэл Зөрчлийн хуулийн дагуу шийтгэдэг болох ийм өөрчлөлтийг оруулсан. Энэ Зөрчлийн хуульд өөрчлөлт оруулахын тулд Улсын ерөнхий прокурор /УЕП/, Хүний эрхийн Комисс, Улсын дээд шүүхээс зөвшөөрөл авдаг юм байна, болсон байна. Одоо УЕП болон Хүний эрхийн комиссоос зөвшөөрлүүд нь ирчихсэн, Улсын Дээд шүүхээс хүлээгдэж байна. Улсын дээд шүүхээс энэ Зөрчлийн хуультай холбоотой дүгнэлтийг ЗГ-т ирүүлбэл Ашигт малтмалын хуулийг өргөн бариад, хэлэлцүүлээд явна. Тэгэхгүй бол нээрээ энэ хариуцлагатай уул уурхайг явуулахгүй хааж боох, хязгаарлах ийм асуудлууд явагдаж байгаа.

Нөгөө талдаа ард иргэддээ энэ Амнат-н хуваарилалтыг зөв болгож байгаа. Ухуулаад байдаг, тухайн сумд нь сургууль байхгүй, цэцэрлэг байхгүй байхаар ард иргэдээ буруутгаад байх буруу. Тэгэхээр энийг зөв менежментээр зохицуулах ийм Амнат-н хуваарилалтыг зөв болгох ийм хууль орж ирж байгаа.

С.Бямбацогт: Эрчим хүчний сайд Найдалаа хариулъя.

Б.Найдалаа: Гишүүний асуултад хариулъя. Энэ жил яах аргагүй нэмэгдэж орох цахилгаан эрчим шинэ эх үүсвэрүүдийг тооцоод, тооцоод, импортыг тооцоод, тооцоод чадлын дутагдал гарахаар байгаа нь үнэн. Энийг гаргахгүйн төлөө, энэ эрсдэлийг үүсгэхгүйн төлөө ажиллаж байна. Тухайлбал сая ЗГ-аас тогтоол гараад, 5 газарт мэдээлэл нь Эрчим хүчний вебсайтад орсон байгаа. 5 аймагт нийт 220мвт-ын чадалтай нарны станц, батарей хураагууртай барина. Мөн системийн хэмжээнд чадлын батарей хураагуур барих төлөвлөгөөтэй ажиллаж байна. Мөн айл өрхүүд өөрсдөдөө зориулсан нарны панел тавиад, илүү гарсан цахилгаанаа сүлжээнд нийлүүлэх гээд тэр төсөл ч гэсэндээ эрчим хүчний дутагдлыг нөхөх, өвөлжилтийг амжилттай давах нэг ажил юм. Дулааны хувьд үнэхээр ноцтой байгаа үнэн. Одоо дулааны байгаа хүчин чадлаасаа 47 хувиар илүү хэрэглээтэй байгаа.../минут дуусав/

С.Бямбацогт: Дэг боломжгүй. Найдалаа сайд хариултаа дуусгачихъя.

Б.Найдалаа: Маш товчхон дуусгачихъя. Дулааны хувьд бид дулааны хувьд нэг бодлогоо шинэчлэх шаардлага байгаа юм. Тэгээд 1 дүгээрт энэ шинээр нөхцөл өгөх ямар ч боломжгүй болсон. Тэгэхээр бие даасан жижиг тархмал эх үүсвэрийг дэмжихээс өөр аргагүй Нийслэлд ч гэсэндээ. Мөн тоолуур, дулаан хэмнэх асуудлыг онцгой тавиад ажиллана. Байдрагийн УЦС-ын хувьд санал нэг байна. Энэ бол ЭХЯ-ны хувьд, миний хувьд эн тэргүүний нэг төсөл байх ёстой юм. 53 аравны сая

долларын санхүүжилт хэрэгтэй байгаа. Тэгээд тойргийн гишүүдтэй хамтраад ажиллахаар ярилцсан зүйл байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Шадар сайд Энхбаяр хариулья.

Ж.Энхбаяр: Хөгжлийн гол том томоохон төслүүдийг төр, хувийн хэвшлээр явуулна. Тэрний нэг нь Байдрагийн 30мвт-ын УЦС-ын төсөл ирэх долоо хоногт ЗГ-ын хуралдаанаар оруулахаар бэлэн болгосон. Эндээс ингээд ЗГ хэлэлцэж шийдвэрлээд нийтэд санал болгоно гэсэн үг. Мөн нөгөө энэ Бөөрөлжүүт, Баян, энэ Шивээ, Тавантолгой, 5 дугаар станцыг зарлаж байгаа маягаар хувийн хэвшлийг урина гэсэн үг. Ингэж эрчим хүчний асуудал хэрэгжүүлнэ гэж.

Тэр авлигатай холбоотой асуудал. Ерөөсөө л нэг жишээ уул уурхайн бирж бол маш сайн кейс болсон, ил тод болсон, дуудлага худалдаа үнэ хаядаг болсон, экспорт эрс нэмэгдсэн, үнэ өссөн. Ноднингийн мөн үеэс 63 хувиар өндөр болоод эхэлж байна орлого. Дээрээс нь хил гааль, боомт, тээвэр зохион байгуулалт асуудлыг яг Эдийн засаг, хөгжлийн яам хариуцаад зохион байгуулалтаа хийгээд явж байна. Экспорт нэмэгдэж байна, тэгэхээр бидэнд нөөц байна.

С.Бямбацогт: Бат-Амгалан сайд тэр ипотекийн зээлийн хүртээмжийг яаж нэмэгдүүлэх ямар бодлого барих вэ ирэх онд гэсэн. Дараа нь Монголбанк бэлдэж байгаарай.

Э.Бат-Амгалан: Ер нь 26 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар банкнуудад 47,4 мянган зээлдэгчийн 6,7 их наяд төгрөгийн зээлийн хүсэлт хүлээгдэж байгаа. Ийм мэдээлэлтэй байна. Ер нь зүгээр ипотекийн зээлийн гол асуудал энэ эх үүсвэрийг шийдэх энэ асуудал байгаа. Тэгээд Ерөнхий сайд ч энэ ярьж байгаа. Ямар асуудал ярьж байна гэхлээр бид энэ хөрөнгө оруулалтыг татахын тулд банкны зээлийн хүү багатай гаднын банк оруулж ирээд, энэ банкаараа дамжуулж олон улсын зах зээлээс эх үүсвэр татах энэ асуудлаа л ярьж шийдэх энэ асуудлыг л хамгийн нэн тэргүүнд шийдэх асуудал байгаа юм. Тэгэхгүйгээр бид зөвхөн зах зээл дээр эрэлт, нийлүүлэлтийнхээ харьцааг харахгүйгээр ипотекийн зээлийг гаргаснаар метр.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя, Бат-Амгалан сайдын микрофон.

Ж.Бат-Амгалан: Үндэсний баялгийн сангийн эх үүсвэрээр гээд ингээд явахлаар хязгаарлагдмал дутагдалтай ийм байдал үүсчхээд байгаа юм. Тийм учраас энэ эрэлт, нийлүүлэлтийг аль аль талаас нь харж явуулахын тулд өнгөрсөн ЗГ дээр Орон сууцжуулалтын банк, мөн Орон сууцжуулалтын тухай хуулийг бид УИХ-д өргөн барихаар бэлдээд ингээд л явж байгаа асуудал. Тэгэхгүйгээр бид зөвхөн нэг талд нь ипотекийн зээлийн асуудлыг л яриад байдаг, нөгөө талд нь нийлүүлэлт талыг нь орхигдуулж явснаас энэ орон сууцын метр квадратын үнэлгээ их өндөр болоод ингээд явж байгаа асуудал байгаа.

С.Бямбацогт: Монголбанк Наранцогт Ерөнхийлөгч хариулья, индрийн 3 дугаар микрофон.

С.Наранцогт: Цогтбаатар гишүүний асуултад хариулья. Тэгэхээр төгрөг хэзээ чангарах вэ гэж. Монгол Улсын эдийн засгийн өнөөдрийн суурь бүтэц бидний нөхцөл байдал төлбөрийн тэнцэл маань жилд дунджаар урсгал тэнцэл маань 2,3

тэрбум долларын алдагдалтай. Энийгээ бид санхүүгийн дансаараа нөхөж ирсэн энийг та сайн мэдэж байгаа. Энэ нөхцөл ингээд байнга үргэлжлээд, сүүлийн энэ жилээс эхлээд энэ санхүүгийн дансаар нөхдөг асуудал маань хязгаарлагдмал болж ирж байна. Тэгэхээр энэ юу гэсэн үг вэ гэхээр бид ер нь эдийн засгийн суурь бүтцээ сайжруулж, төлбөрийн тэнцлээ сайжруулах нь бидний зайлшгүй асуудал байгаа. 2 дугаар суурь асуудал бол инфляц тогтвортой нам доор түвшинд очих ёстой. Энэ бол Монголбанкны үндсэн мандат.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя 3 дугаар микрофон индэр.

С.Наранцогт: Тийм учраас Монголбанк энэ инфляцыг нам доор түвшинд, тогтвортой хадгалах энэ цогц стратеги боловсруулаад хэрэгжүүлж ажиллаж байна. Ханшийн хувьд ер нь ханш Монгол Улсад маш их нөлөөтэй учраас бид ханшийг савлуулахгүй, тогтвортой байлгах өнөөдөр үүсэж байгаа гаднын энэ шокийн үед ч гэсэн энийг тогтвортой барих энэ бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд оны эхнээс ханшийн сулрал 05 хувьтай байгаа. Үндсэндээ бид тогтвортой ханшийн бодлогыг барьж хэрэгжүүлж байна. Цаашдаа ер нь яах вэ гэхээр энэ эдийн засгийн суурь бүтцээс гадна Монголбанк энэ валютын захыг хөгжүүлэх, Монголбанк өөрөө энэ market maker байхаас үе шаттай гарах ийм чиглэлээр энэ стратеги төлөвлөгөөндөө оруулаад ажиллаж байгаа. Ипотекийн хувьд та мэдэж байгаа энэ өөрөө татаастай яг зах зээлийн журмаараа бус явж байгаа учраас өнөөдөр энэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Товчхон, тодорхой хариулмаар байдаг, нэг минутад багтаж хариулах ёстой, би танд 2 минут өглөө. Тэгээд байхаар ингээд хариултаа дуусгахгүй бол минут өгөх боломжгүй байна. Асуултаа бичгээр Цогтбаатар гишүүний асуултад бичгээр хариулт өгөөрэй Монголбанк. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя. Хариулт дутуу байна. Энхбаяр сайд хариулъя Хэрэг эрхлэх газрын.

Б.Энхбаяр: Төрийн өмч 30 их наяд байсан 60 их наяд гэж байгаа боловч яг бид өмчөө зөв бүртгэсэн үү гэдэг нь ч эргэлзээтэй. Тухайлбал бид газрын үнэлгээг ерөөсөө үнэлэхгүй байгаа. Зөвхөн төрийн өмчүүдийг нягтлан бодох бүртгэлийн балансын үнээр ЗГ-аас баталсан аргачлалын дагуу үнэлж байгаа. Зах зээлийн үнэлгээгээр нь тооцож үзвэл энэ бүүр том хөрөнгийн асуудал гарна. Тэр утгаараа Нийтийн өмчийн хуулийг л Их Хурал хурдан баталчихмаар санагдаад байх юм. Энэ хууль дээр яг нийтийн өмч гэж юу үзэх вэ, аль тавилга эд хогшлыг нь яг ямар балансын үнээр шийдэх вэ. УИХ дээр байгалийн баялаг ард түмний өмч гэж байгаа яг энэ нийтийн өмчүүдийг.../минут дуусав/

С.Бямбацогт: Бичгээр гүйцээж хариулъя, товч, тодорхой хариулж чадахгүй бол дутуу асуултаа бүгдийг нь бичгээр хариулна. УИХ-ын гишүүдийн асуултад бүрэн гүйцэд, үнэн зөв хариулт өгөх ёстой. Цогтбаатар гишүүн тодруулж асууя.

Да.Цогтбаатар: Монголбанк ч хэлээд байна, та ч хэлээд байна. Би мэдэх гээд байгаа юм биш, одоо энэ асуулт асууж байгааг чинь, эсвэл хариулж байгааг чинь та нарын ярьдаг ард түмэн чинь үзээд сууж байгаа байхгүй юу. Тэд нарт үнэн зөв мэдээллийг нь цаг алдалгүй өгмөөр байгаа юм. Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө 2027-г хэлэлцэхдээ юу асуусан юм, юу хариулсан юм гэдгийг нь асуух гэхээр асуултыг нь гүйцэд асуулгахгүй юм, хариултыг нь гүйцэд хариулуулахгүй юм, бичгээр өгчих гэх юм. Бичгээр хэзээ ирээд, хэзээ тэгээд буцаад нөгөө ард иргэдэд чинь мэдээлэл хүрэх юм бэ? Хэлэлцэж байгаа дээрээ нэг цаг сунгаж байгаад ярилцаад, ярилцаад явчихвал яасан юм бэ даргаа? Бичгээр ирдэггүй шүү дээ, бичиг

бичээд байхад урдаас нууц гэдэг тайлбартайгаар хариулт ирдэггүй байхгүй юу. Тэгээд бид хэзээ, хаана ил тод нээлттэй ярих юм. Ерөнхий сайд алга байна, авлигал, та тэгээд цааш нь буруу орчуулаад байх юм. Авлигал яаж буурах юм бэ, хэдэн байр урагшлах юм бэ л гэсэн шүү дээ. Гэмт хэрэг гээгүй.

С.Бямбацогт: Дэгийн хуулиа л барина даа. Дэгийн хуулиараа асуултыг 4 минут, тодруулж асуувал нэг, шаардлагатай дахиад нэг, хариулт 3 минут, нэмэлт хариулт нэг минут гэсэн Дэгийн хуультай. Би харин илүү боломж олгоод, хариулт нь дуусахгүй байна гээд сая Монголбанк, ЭХЯ гээд нэмээд асуултаа хариултаа дуусгачих гээд өгөөд байна шүү дээ. Чадлаараа л би оролдож байгаа. Тэгээд хариулж чадахгүй, хариулт нь хангалттай гарахгүй болохоор би тэгээд бичгээр хариултаа гүйцээж өгөх дэгтэй. Энэ дэгээ л барьж ярьж байгаа дэгээ. Тэгэхээр Дэгийн дагуу бичгээр хариултаа гүйцээж өгөх ёстой, гүйцээгээд л өгчихье. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн.

Би юу яасан байгаа шүү, та бүхэнд энд байна уу, энэ харагдах нь уу, үгүй юу. Бичгээр хариулт өг гээд хариултын биелэлтийг танилцуулъя. Надад ирүүлээдэх. Би бичгээр хариулт өг гээд хариултууд ирсэн байгаа. Одоо зүгээр юу гэдэг юм ингээд хариултыг нь бичгээр өгөөрэй гээд орхихгүй, араас нь хөөцөлдөж байгаа Тамгын газар. Хариултыг нь авч байгаа, одоо мэдээлэл танд өгье. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асуучихъя.

О.Номинчимэг: Эрхэм сайд нараа төлөвлөгөө гэдэг хүсэл мөрөөдлийн жагсаалт биш, хариуцлагын гэрээ байх ёстой гэдгийг юуны өмнө тодотгоод хэлчихье. Төсөлтэй танилцсан. 2027 онд 15,3 их наяд төгрөг зарцуулна гэжээ. Та бүхний 2025 оны төлөвлөгөөний биелэлт чинь тал хувьдаа ч хүрч чадахгүй байгаа шүү дээ, дахиад 15 их наядын төлөвлөгөө оруулж ирж байна. 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан дээр тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны чинь гүйцэтгэл 48,5 хувьтай байсан, бүх хөтөлбөрийн үр дүн чинь 57,1 хувьтай байсан. Тэгээд гол шалтгааныг нь судалгаа тооцоололгүй төлөвлөлт гэж та бүхэн өөрсдөө дүгнээд, энэ тайландаа оруулсан байгаа шүү дээ. Тэгээд шалгалт дээрээ F дүн авчхаад, тэгсэн хэр нь хичээхгүй, одоо яг онц авна гэж байгаа юм шиг байж таарахгүй шүү дээ. Өнөөдөр яг л энэ алдаагаа давтаад орж ирж байна. Өмнөх алдаанаасаа ерөөсөө суралцаагүй байна. Даалгавраа 50 хувь хийсэн хүүхдэд ямар дүн багш нь тавьдгийг та бүхэн гэртээ хариад хүүхдүүдээсээ асуугаарай. F буюу муу дүн багш тавьдаг. Тэгээд ийм л дүн тавихаар байна гэж би харж байна.

Салбарын сайд нараас нь асууя. 1 дүгээрт Эдийн засаг, хөгжлийн сайдаа 2025 оны төлөвлөгөөний биелэлт чинь 50 хувьтай байхад 2027 оны төлөвлөгөөний үр дүн чинь ямар үндэслэлээр 100 хувь биелнэ гэж та ер нь бодож төлөвлөж байгаа вэ?

2 дугаарт ЗГХЭГ-ын сайдаас асууя. Манай улсын хувьд энэ Дэлхийн банкны засаглалын индексийг нэлээн энэ тоон шалгуур үзүүлэлтэд ашигласан байна л даа. Хууль, авлига, энэ засаглалтай холбоотой асуудлаар. Тэгээд энэ 6 ийм индекс байдаг. Энэ индекс дотроос тогтмол буурч байгаа нь, ерөөсөө өсөлт үзэхгүй тогтмол буураад байгаа нь government efficiency буюу төрийн ЗГ-ын үр дүнгүй байдал. Энэ үзүүлэлт ерөөсөө ахихгүй байгаа. Тэгээд ингэж буурсаар байгаад сэхээний тасагт орохоос нь өмнө бид суурь өвчнийг нь анагаах реформ шийдлээ хийхгүй бол зүгээр нэг барилга байгууламж бариад, арга хэмжээ зохион байгуулаад байвал болохгүй. Ингэж аргацаасаар байгаад сэхээний тасагт оров гэж хэлмээр байна. Тэгээд энийг

би энэ бүтээмжтэй холбоотой төрийн албаны асуудал. Энэ чинь мэдээж авлига, хээл хахууль, хууль, эрх зүйн орчинтой холбоотой индикаторуудыг харууллаа л даа. Ерөөсөө надад реформын шинж чанартай юм харагдахгүй байна.

Тэгээд энэ дээр уг нь УИХ түрүү жил нэлээн ахиц гаргах хууль тогтоомжийн хуулийг дагуулаад ЗГ-т энэ оны 5 сарын 1 гэхэд хууль давсан журмуудаа бүгдийг нь цэгцэл, хүчингүй болго, энэ чинь төрийн албанд давхраа нугалаа гаргаж байна, хууль ойлгомжгүй болгож байна, хүнд суртал бий болгож байна, авлига бий болж байна, хуулийн хулгай хийх, бүүр хуулиар биш журмаар зохицуулаад байгаа юм байна, энийгээ цэгцлээд 5 сарын 1 гэхэд дуусга гэсэн. Өнөөдөр 5 сарын 8-ны өдөр, энэ ажил юу болж байна вэ, ямар үр дүнтэй байна гэдгийг хариулаад өгөөч? 3 дугаар асуулт Хууль зүйн сайдад, Хууль зүйн сайд байхгүй юу.

Эрүүл мэндийн сайдаас асууя. Эрүүл мэндийн тэргүүлэх чиглэл гээд ингээд орж ирж байгаа. Гэхдээ нэг сэтгэл эмзэглүүлэм зүйл 2025 оны төлөвлөгөө дээр эх нялхсын эндэгдэл өссөн байсан. Тэгэхээр эх нялхсын эндэгдлийг та энэ жил 27 онд бууруулахын тулд яг ямар дорвитой арга хэмжээ авч байна гэдгийг асуумаар байна? Тэгээд энийг яагаад асуугаад байгаа юм гэхээр би 25 оны төлөвлөгөөний гүйцэтгэл дээр нэлээн гайхсан юм энэ Монгол хүний энэ дундаж наслалт буурчигсан гэдэг юм ЗГ-ын Хэрэг эрхлэх биш, Эдийн засаг, хөгжлийн яамны доор байдаг Хяналт хэрэгжүүлэх газрын тайланд бүүр өөрт нь дурдаад ирчихсэн байгаа байхгүй юу. Үгүй ээ энэ чинь дайн дажинтай улс байгаа биш дээ, цар тахалтай улс байгаа биз дээ, яахаараа ингэдэг юм гээд харсан чинь ерөөсөө тоо индексүүдээ буруу авчихсан, маш болхи алдаа, өөр улсын тоо.../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа гүйцээгээд асуучихъя, 1 минут Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Тэгээд уг нь Монгол хүний дундаж наслалт өсөж байгаа юм байна лээ шүү дээ. Тэгээд энийгээ та нар бүүр ингээд тоог нь хольж, Сент-Люси ч гэнэ үү, сонин улстай холиод оруулаад ирчихсэн. Тэгээд ийм хэмжээний тоог зөрүүлж орж байна гэхээр би бодлого, төлөвлөлт дээр тооны мэдрэмж байхгүй хүмүүс байна гэхээр жоохон санаа зовоод байгаа юм. Тэгээд энэ дээр та минь, та хэд маань юу гэж харж, ЭМЯ оруулж ирэв?

3 дугаар, 4 дүгээрт Хууль зүйн сайдаас асуумаар байна л даа. Энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг маш сайжруулна гээд тоон үзүүлэлтээр ороод ирж байгаа юм. Гэхдээ хийх арга хэмжээнд нь ямар нэгэн юм байхгүй, тэгээд энийг яагаад шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг ийм гэнэт сайн болчихно гэж төсөөлөөд байгаа юм бэ? Одоо иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл үнэхээр шалдаа бууж байна шүү дээ. Энэ хууль, эрх зүйн реформ нь Хууль зүйн яаман дээр байгаа энэ хуулиа хурдан оруулж ирмээр байна. Иргэд шударга шүүхэд итгэхгүй байгаагийн нэг асуудал чинь яг энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь ажиллахгүй байгаатай холбоотой байхгүй юу. Тэгээд үнэхээр шүүхэд итгэх итгэлээ сайжруулъя, шүүхийн шийдвэр гүйцэтгэлээ сайжруулъя гэвэл энэ хууль, эрх зүйн орчныг нь бий болгох хуулийн шинэчлэлийн энэ юмнуудаа түргэн оруулж ирмээр байна.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Энхбаяр сайд, Шадар сайд Энхбаяр хариулъя, дараад нь Батшугар сайд, Амарсайхан сайд бэлдэж байгаарай.

Ж.Энхбаяр: Энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль маш чухал хууль болсон цаг үеэ олсон. 5 жилээ төлөвлөдөг болсон. 5 жил дотор Монгол Улсын

нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх бүх хөтөлбөр, төсөл, салбар хоорондын бүх уялдааг хангаад, шаардлагатай тэр зорилтот түвшин хэмжигдэхүйц, бодитой, хамааралтай, хугацаатай, эдийн засгийн ач холбогдолтойгоор нь эрэмбэлээд гаргаад, шинжлэх ухааны Их, бага чуулганаар академийн Бага чуулганаар хэлэлцүүлээд бүхий л нийгмийн хүрээнд хэлэлцүүлэг болж их томоохон ажил болж баталсан. Тэгэхээр энийгээ л бид хэрэгжүүлнэ. Одоо бидэнд юм тодорхой. Энийгээ хэрэгжүүлэхийн тулд жилийн төсвийн хүрээг нь хатуу гаргаж байгаа. Орлого чинь ийм байна, зардал чинь энэ түвшинд байна, энэ түвшинд Сангийн яам төсвөө зохио. Ингэж байж бодлого нь, төсөв нь, одоо ингээд хэрэгжилт нь ингээд гараад эхэлж байгаа.

Энэ жилийн хэрэгжилт дээр зарим үзүүлэлтүүд бага байгаа асуудал яг түрүүн гишүүд хөндөөд байсан, манай энэ Их Хурлын гишүүд хуулийнхаа зарчмыг жоохон дутуу ойлгож, санал гаргаж, маш их хэмжээний санал гаргасан. Зарим нь бүүр хуулийн зөрчилтэй хүртэл санал гаргаж хэлэлцүүлэг дээр буцаагдсан зүйлүүд их бий. Одоо бол тэгэхгүй. Энэ чинь бодлого тогтвортой, сахилга баттай цаашдаа хэрэгжинэ. Бүгдээрээ ингээд нэг эндээ дасаад суралцаад, энэ чинь нэг шилжилтийн ийм ажил хийгдэж байна шүү дээ их сайн. Тэгэхээр энийг аль болох бүгдээрээ дэмжээд ингээд цаашдаа явна. Энэ нь өөрөө улс орны хөгжлийн бодлого улс төрийн ангид, улс төржихгүй, тогтвортой, их урт хугацаанд бодлого болж хэрэгждэг ийм тал руугаа л орцгооё гэж бид улс төрийн энд 5 нам хамтарч байж энэ Үндсэн хуулиа өөрчилж шийдсэн ажил шүү дээ. Тэгэхээр энийгээ бүгдээрээ хэрэгжүүлээд л ингээд явна.

Үр дүнгүүд тасралтгүй гарна, үр дүнгүүд байнга шийдэгдэнэ. Хамгийн гол нь энд хариуцлагын асуудлууд байгаа. Цаашид энэ хариуцлагын асуудлыг дүгнэдэг, шалгадаг энэ ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх гэж нэг том систем ажиллаж байгаа. Ажлаа хийхгүй байгаа, дутуу хийгдээд байгаа энэ төрийн албанд авах арга хэмжээний асуудлууд их тодорхой болсон шүү дээ ингээд. Одоо энийгээ хэрэгжилтээ хангаад л, 2 талаасаа шаардаад ингээд л явцгаая.

С.Бямбацогт: Батшугар сайд хариулъя.

Э.Батшугар: Баярлалаа. Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ нярайн эндэгдэл бол өссөн тийм харамсалтай статистик гарсан байна лээ. Үүнтэй холбоотойгоор Эх, нялхсыг засаад сайжруулаад, ахиад эмнэлэг бариад ингээд асуудал шийдэгдэхгүй. Энэ нь нэг ёсондоо шууд 1 дүгээрт хяналтад байх асуудал гарч байгаа юм. Хяналтын талаар бид анхан шатны эмнэлэгтээ дийлэнх ачааллыг нь үүрүүлэх нь зөв анхнаас нь. Энэ ёсондоо сая ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоол энэ онд батлагдсан. Анхан шатны өрхийн эмнэлгүүдийг санхүүжилтийг нь 30 хувиар нэмэгдүүлж байгаа. Яг үүнтэй холбоотойгоор танд хэлэхэд манай дундаж насжилт 71,8 байгаа юм. Үүнийг задлаад үзвэл эрэгтэй хүн 67,9, эмэгтэй хүн 77. Нэг ёсондоо.../минут дуусав/

С.Бямбацогт: Өөр хэнээс вэ? Б.Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Журмууд цэгцлэх тогтоолын биелэлт асуугаад байна л даа. Яах вэ би хариулчихна л даа. Ерөнхий сайдын захирамжаар энэ ажлын хэсгийг нь Хууль зүйн сайд ахалж байгаа байхгүй юу. Тэгээд би өөр сайдын өмнөөс ингээд хариулаад байх чинь зохимжгүй байгаад байна шүү дээ Номинчимэг гишүүнээ. Би хариулчихна. Шинэ сайд маань юу хийж байгааг би мэдэхгүй, өмнөөс нь

хариулмааргүй байгаад байна шүү дээ. Аягүй бол гомдчих ч юм билүү. Би 2 сайдын ажил хавсарч хийгээгүй шүү дээ.

С.Бямбацогт: Номинчимэг гишүүн тодруулж асууя, нэмэлт асуулт нэг минут.

О.Номинчимэг: Энхбаяр сайд яагаад ингэж хариулж байгааг би ерөөсөө ойлгохгүй байна л даа, уг нь хүний хэлээр л асууж байгаа юм сан. Өөрөө ч гэсэн та энэ асуудлыг маш их нийгэмд ойлгуулж, өөрөө энийг манлайлж явсан хүн шүү дээ. Тэгээд энийг асуухаар би биш, би сайд нь биш гээд байх юм. Танай ЗГ дээр л энэ чинь олон салбарын юм нэгтгэгдээд энэ чинь явж байх ёстой шүү дээ. Би Байнгын хороон дээр ч гэсэн асуусан. Та тэгвэл ЗГ дээрээ энэнийхээ асуудлыг тавиад, тэгээд мэдээллээ өгчхөөч дээ. Ийм маягаар юм хариулна гэж юу байдаг юм.

Ер нь цөмөөрөө энэ смарт буюу тэр хэмжигдэхүйц, тодорхой зорилт тавихгүйгээр төсөв ерөөсөө баталж болохгүй. Тэгээд үр ашиггүй зардлаа хасаж, салбарын сайд нарт нь үр дүнгээр нь хариуцлага тооцдог систем рүү орохгүй бол хөгжил гэж ер нь ярихад их хэцүү боллоо шүү дээ. Тэгээд хөгжил гэж ямар сургалтад суугаад, барилга байшин бариад байхыг хэлэхгүй. Хүндээ хөрөнгө оруулаад, системээ эрүүлжүүлээд, иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэх л асуудал шүү дээ. Тэгээд ингээд хариуцлагагүй төлөвлөлтийн уршгаар ард түмэн л, иргэдийн амьдрал дордож, иргэд нь л хохироод байна шүү дээ. Энэ дээр анхаармаар байна.

С.Бямбацогт: Номинчимэг гишүүний ярьж байгаа зөв шүү. ЗГ-ын гишүүн УИХ-ын гишүүдийн асуултад үнэн зөв, бодитой хариулт өгөх ёстой, УИХ-д хүндэтгэлтэй хандаж, чуулганы хуралдаанд ирэх үүрэгтэй. Энэ хууль зөрчвөл төрийн албаны болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно гээд заачихсан. Энийг би хуралдааны эхэнд сануулсан. Тэгээд Хууль зүйн сайдаа дуудаж ирүүл л дээ энэ таны үүрэг Энхбаяр сайд ЗГХЭГ-ын дарга. Хууль зүйн сайдаа ирэхгүй бол та өмнөөс нь хариулах үүрэгтэй ЗГХЭГ-ын дарга. Ингээд хариулаач гэхээр хариулдаггүй.

Би түрүүн нөгөө Цогтбаатар гишүүн хөндөж байсан хариулт хангалтгүй бол бичгээр гүйцээж өгөөрэй гэж. 4 сарын 7-ны өдрөөс би 5 сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд яг энэ асуудлаар УИХ-ын 21 дүгээр зүйлийн 21.24 дэх хэсэгт заасны дагуу 4 сарын 3-наас 5 сарын 1-ний хооронд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн асуудлууд дээр 8 удаагийн нэгдсэн чуулган дээр 9 асуудал дээр нэмэлт, 6 асуудал дээр ЗГ-ын сайд нарыг мэдээлэл өг гэсэн. 3 асуудал дээр УИХ-ын Тамгын газар тодорхой гишүүд бас мэдээлэл өг гэсэн хариултыг нь гүйцээж. Үүнээс 9 асуудлаас 8 нь биелсэн байна. 8 нь, 1 нь биелээгүй байна.

Тухайлбал 4 сарын 10-ны өдөр ААНОАТ-ын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр Саранчулуунаас, Саранчулуун гишүүний асуултад өгсөн хариулт хангалтгүй гэж үзэж, хууль зүйн үндэслэл, тайлбар холбогдох мэдээлэл бичгээр гүйцээж ирүүл гэсэн. Үүний дагуу Соёл, спорт, аялал жуулчлалын яамны ТНБД Бат-Эрдэнээс 4 сарын 17-ны өдөр, Татварын ерөнхий газрын Татвар төлөгчдөд үйлчлэх газрын дарга Буяннэмэхээс 4 сарын 30-ны өдөр бичгээр хариултыг өгсөн байна. Мөн Саранчулуун гишүүнээс хаягжилтын хүртээмж, ОУБ-тай хамтарсан ажлын үр дүн болон аймгуудад илэрсэн зөрчлийн талаар тодруулсан асуултад хариулт гүйцэт өгөөгүй тул хариулт өг гэсэн. Геодези, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Энхманлай 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр 1/1135 албан бичгээр хариултыг өгсөн байна.

ҮХЦ-ийн дүгнэлтийг хэлэлцэж байх үед УИХ-ын гишүүн Сайнзоригийн хөндсөн улс төрийн нам болон хуулийн этгээдийн бүртгэлийн зохицуулалттай асуудлаар Тамгын газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсээс судалгаа хийж танилцуул гэсэн. Энэ дээр 4 сарын 20-ны өдөр УИХ-ын Тамгын газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах ажилтан Амаржаргал Сайнзориг гишүүнтэй биечлэн уулзаж, танилцуулга мэдээлэл өгсөн байна гэх мэтчилэн. Ариунзаяа гишүүний асуусан асуултад Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Баярбаатарыг хариулт өг гэсэн. Баярбаатар гишүүн томилолттой байгаа учраас одоогоор өгч амжаагүй байна. Алтаншагай гишүүний хөндсөн асуудал, хууль дээр Энхтүвшин гишүүний тавьсан тендер шалгаруулалт, шалгарсан компанийн хамааралтай холбоотой асуудал дээр Нийслэлийн Засаг даргын орлогч Даваадалай 4 дүгээр сарын 21-ний өдөр, 29-ний өдөр албан бичгээр хариулт өгсөн гэх мэтчилэн хариултуудыг өгөөд явж байгаа.

Тийм болохоор энэ дутуу хариулагдаад байгаа хариултуудад сайд нар, ЗГ-ын гишүүд бичгээр гүйцэд хариултыг гүйцээж өгнө. Хангалттай хариулт гарахгүй байна гээд байгаа учраас. Тийм болохоор энийг ЗГХЭГ-ын дарга зохион байгуулаарай, УИХ-ын Тамгын газар бас зохион байгуулаарай гэдгийг чиглэл болгоё. Дуламын Бум-Очир гишүүн асуултаа асууя.

Д.Бум-Очир: Манай Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооноос эрдэм шинжилгээний байгууллагууд, их сургуулиуд, хүрээлэнгүүдтэй уулзсан юм. Энэ дотор бид нэг онцгой хүрээлэнтэй уулзсан. Энэ бол Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн байгаа юм. Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэд судлаачидтай уулзаж байхад тэд нар маань юу гэж хэлж байсан бэ гэхээр манай энэ 58 сая толгой мал эрүүл мэндийн хувьд маш их учир дутагдалтай байна. Тэр дундаа энэ гадаад, дотоод шимэгч паразит маш их байна. Магадгүй паразитгүй эв эрүүл мал гэдэг нь хэчнээн мал байгаа юм гэдэг асуудал хүнд байна гэдэг энэ асуудлыг эрдэмтэд судлаачид нь ярьж байсан юм. Энэ зөвхөн малын эрүүл мэндийн тухай асуудал биш л дээ, энэ хүний эрүүл мэндийн тухай асуудал. Бид чинь нөгөө малынхаа мах, махан бүтээгдэхүүн, сүү, элдэв зүйлийг хэрэглэж байгаа шүү дээ.

Ингээд энэ эрдэм шинжилгээний хүрээлэн энэ асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэх тухай асуудал ярьсан. Ялангуяа энэ малын эрүүл мэндтэй холбоотой эм бэлдмэл бүтээгдэхүүнүүд 80 хувь нь импортоор орж ирдэг юм байна. Дотооддоо энэ малын эм бэлдмэл үйлдвэрлэдэг улсын болоод хувийн ААН гэж байхгүй юм байна гэдэг мэдээлэл авсан. Энэ асуудлыг шийдвэрлэхээр Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс нэг шийдлийг санал болгоод байгаа юм. Энэ шийдлээ энэ 27 оны төлөвлөгөөнд оруулчихсан байсан. Тэр нь юу вэ гэхээр мал эмнэлгийн дэвшилт технологийн туршилт зүгшрүүлэлтийн үйлдвэрлэл явуулах байгууламж юм байгаа юм. Энэ яг масс үйлдвэрлэл биш шүү, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд масс үйлдвэрлэлээс өмнө энэ туршилт зүгшрүүлэлтийн үйлдвэрлэлийг хийдэг ийм үйлдвэрлэлийг хийх бүрэн боломжтой байна. Манай дотоодын эрдэмтдийн патент авчихсан эм бэлдмэл, вакцин, оношлуур маш олон бүтээгдэхүүнүүд байна. Энэ бүтээгдэхүүнүүд үндсэндээ импортыг орлох юм 1 дүгээрт. 2 дугаарт энэ малын эрүүл мэндийг сайжруулахад чухал хувь нэмэр оруулах ийм зүйл. Мэдээж 3 дугаарт Монголдоо энэ чиглэлийн шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэхэд чухал хөрөнгө оруулалт болох ийм зүйл юм гэж ярьж хэлж байсан юм.

Гэтэл харамсалтай нь энэ 27 оны төлөвлөгөөнөөс энэ маань хасагдчихсан байна. Эдийн засаг, хөгжлийн яамныхан яагаад, ямар шалтгаанаар хасагдчихсан

юм бол энэ дээр хариулт өгөх болов уу гэж бодож байна? Энэ эрдэм шинжилгээний хүрээлэнгийн удирдлага болоод эрдэмтэд судлаачдаас манай Байнгын хорооны гишүүдэд сүүлийн 1, 2 өдөр санал хүсэлт ирээд байна. Энэ асуудлыг та нар анхаарч өгөөч. Бидний энэ ажлыг дэмжиж өгөөч. Энэ Монголын малын эрүүл мэндийн асуудалд чухал хувь нэмэр үзүүлэх, Монголын шинжлэх ухааны салбарт чухал хөрөнгө оруулалт болох ийм зүйл юм, 7 орчим тэрбум төгрөгийн асуудал байгаа юм байна. Тэгэхээр 1 дүгээрт энэ байгууламж, үйлдвэрлэлийн туршилт зүгшрүүлэлтийн үйлдвэрлэлийн байгууламжийн төсөв яагаад хасагдсан юм бол?

Эрэмбэлээд, чухлаар нь эрэмбэлээд үзвэл малын эрүүл мэнд, хүний эрүүл мэндтэйгээ холбоотой, шинжлэх ухааныхаа хөгжилд чухал хувь нэмэр оруулах нэлээн чухал зүйл болох юм шиг байгаад байгаа юм. Энэ үйлдвэрлэл маань нэвтэрчихвэл малын эм, бэлдмэл, тэжээлийн нэмэлт, оношлуур, вакцин гээд маш олон зүйлийг үйлдвэрлэх үйлдвэрлэлд нэвтрүүлэх цаашдын замууд нь нээгдэх, улмаар импортоор авч байгаа оношлуурын 30 хувийг эм, бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн 80 хүртэлх хувийг дотоодоосоо хангах, вакциныг 100 хувь дотоодоосоо хангах ийм нөхцөл бололцоонууд цаашдаа бүрдэх юм байна. Тэгээд яг манай Байнгын хорооны гишүүд нэлээд олон гишүүд дээр яг энэ хүсэлт ирчихсэн байна. Бид дараа дараагийн хэлэлцүүлгээр холбогдох яамтай нь холбогдоод, санал солилцоод, саналын томъёолол боловсруулж нэмж оруулах уу гэсэн байр суурьтай байна.

С.Бямбацогт: ХХААХҮ-ийн сайд Идэрбат хариулъя.

Ц.Идэрбат: Монгол Улсын ХАА-н салбар, тэр дундаа МАА-н салбар дээр үүсээд байгаа нөхцөл байдал, эдийн засагт үзүүлж байгаа үр нөлөө харьцангуй тийм сайнгүй байгаагийн гол хүчин зүйл бол энэ малын эрүүл мэндийн асуудал. Улмаар энэ нь ганцхан малын биш, хүний эрүүл мэндийн асуудал болж байгаа. Тийм учраас бид бүхний хувьд энэ мал эмнэлгийн асуудал дээр онцгой анхаарч, ялангуяа таны хэлдэг дотоодынхоо эрдэмтдийн, Монголынхоо эрдэмтдийн боловсруулсан шинжлэх ухааны ололтуудыг хэрэглээнд нэвтрүүлэх тал дээр судалгаа гаргах, энэ эрдэмтэдтэйгээ уулзах ажлыг зохион байгуулж, ТНБД-аар ахлуулсан ажлын хэсэг гаргачихсан байгаа. Ер нь энэ мал эмнэлгийн үйлчилгээний асуудал дээр, вакцины чанарын асуудал дээр, технологийн асуудал дээр гээд олон өөрчлөх, шинэчлэх ийм зүйлүүд байгаа.

Нөгөө талдаа энэ мал эмнэлгийн хувьд малын эмийн асуудал өөрөө маш тийм задгай болчихсон ийм байна. Тэгээд та бид мэдэж байгаа. Малын битгий хэл хүний эм, вакцин чанартай, чанаргүй, хуурамч гэдэг асуудал хурцаар яригдаж байгаа ийм цаг үе. Тэгэхээр бид дотооддоо вакцинаа үйлдвэрлэчихдэг, дотоодоосоо энэ эрдэмтдийнхээ бүтээсэн бүтээлүүдийг хэн нэгэн даргын шургуулгад үлдээчихгүй юм сан гэдэг ийм зорилго тавьж байгаа.

Ер нь ийм юм билээ. Манай яаман дээр гэхэд энэ ХАА-н салбарын шинжлэх ухааны байгууллагууд, боловсролын байгууллага нь 2, 3 өөр газар луу хуваарилагдчихсан. Уул нь энэ чинь яам нь өөрөө бодлогоо гаргаад, боловсон хүчнээ сургуультайгаа нийлж бэлдээд, эрдэм шинжилгээнийхээ хүрээлэнгүүдэд нэг захиалгаа өгөөд, түүнийхээ үр шимийг үзэхийн тулд таны саяын ярьж байгаа 7 тэрбум төгрөгийн асуудлыг яам өөрөө оруулж ирээд, ингээд харилцан уялдаатай ийм тойрог бол их зөв тал руугаа явах юм байна гэж харж байгаа юм. Гадна, дотнын, гаднын энэ шинжлэх ухааны байгууллагынхан энэ ХАА-нхан ирээд манай энэ

тогтолцоог ойлгодоггүй гэж байна лээ. Яамнаасаа тусдаа ХАА-н сургуультай, тэнд нь оюутан бараг байхгүй болчихсон. Эрдэм шинжилгээний байгууллагууд нь тэс өөр яамнуудын харьяанд байгаад байдаг. Тэгэхээр чинь энэ салбарын юм ингээд эрдэмтдийн юм хаягдаад байгаа нь энэ тогтолцооны буруу юм билээ.

Тийм учраас гэхдээ энэ тогтолцоо гэхээсээ илүүтэйгээр яам энэ дээр идэвх санаачилга гаргаж ажиллана. 26, 27 онд ахиц гаргахын төлөө ажлын хэсэг гаргаад ингээд ажиллаж байгаа. Эхнээсээ энэ вакцины асуудал дээр ч гэсэн бид ер нь хэн нэгнээс биш, өөрсдөөсөө авах техникийн бололцоо бүрдэж байгаа юм байна. Ганц нэг зүйлийг засаж сайжруулах ёстой юм байна. Энэ гадуур зарагдаж байгаа баталгаагүй байгаа энэ малын эм Нарантуулын урдуур тэр зарагддаг тэр олон эмийг ч гэсэн бид дотоодоосоо хангадаг нэг дэгтэй, журамтай болгох.../минут дуусав/

С.Бямбацогт: Дуламын Бум-Очир гишүүн тодруулж асууя. Энхбаяр сайд хариулъя. Шадар сайд Энхбаяр, Жадамбаагийн Энхбаяр.

Ж.Энхбаяр: Энэ малын эмийн үйлдвэрийн асуудал ярьж байна. ТЭЗҮ байхгүй, хуулийн шаардлага хангадаггүй. Тэгэхээр юм бас их хатуурчихсан шүү дээ. Үндэслэлтэй, урьдчилсан үнэлгээтэй, үр ашигтай, хэрэгжихүйц гээд олон шалгуурууд гарчихсан. Энийгээ нэг хангаад аваад ирээч. Уул нь манай био комбинат эртний суурь шинжлэх ухааны суурьтай, хүний нөөцийн суурьтай. Био комбинатаа өөрчлөөд шинэчлээд явуулбал бүх бодлогоор л дэмжихэд бэлэн байгаад байдаг. Тэр бүрдүүлбэрийг нь зөв хангаад, яаралтай өгөхийг хүсье.

С.Бямбацогт: Бум-Очир гишүүн тодруулъя.

Д.Бум-Очир: Энэ байгууллага маань мэдээж төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага л даа. Тэгээд яг ТЭЗҮ энэ тэр хийнэ гэхээр 200, 300 сая төгрөг болох байх. Манай улсын төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагуудад ийм мөнгө байхгүй шүү дээ. Төсвөөс тавьж өгөхгүй бол. Тэгэхээр зүгээр бидний санал юу вэ гэхээр энэ үнэхээр хэрэгцээтэй гэдгийг бид нар бүгдээрээ ойлгож байгаа. Түүн дээр нэг их маргах хүн байхгүй болов уу гэж бодож байна. 27 оныхоо төлөвлөгөө дээр оруулаад ядаж ТЭЗҮ-г нь хийх мөнгө төгрөг боломжоор хангаад өгөх тийм боломж байдаг бол их сайн байна л гэж бодож байна.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя Шадар сайд.

Ж.Энхбаяр: Энэ төсөл өөрөө түншлэлийн жагсаалтад байсан юм. Төр, хувийн түншлэлээр хэрэгжүүлэх бүрэн бололцоотой. Хөрөнгө оруулагч нар их сонирхдог. Тэгэхээр тэр бодлогыг тодорхой болгох, тэр саналуудаа хурдан гаргаад ир. Та хэлэлцүүлгийн явцад зарчмын зөрүүтэй санал гаргаад энэ юундаа хөгжлийнхөө бодлогод оруулчих бололцоотой. Төр, хувийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл гээд оруулчих. Тэгэхээр энэ дээр тэр ТЭЗҮ дээр нь 27 оны төсөв дээр нь техникийн үндэслэл дээр энэ төслийг хэрэгжүүлнэ гэдгээрээ бүгдээрээ хамтраад ажиллах бүрэн бололцоотой ийм төсөл байгаа шүү. Жоохон санаачилга нь жоохон дутаад, зохион байгуулалт нь дутаад, Идэрбат сайдаа энэ дээр та нэг анхаараадахвал болохоор ажил байгаа шүү гэж.

С.Бямбацогт: Идэрбат сайд нэмээд хариулчихъя.

Ц.Идэрбат: Энэ хөгжлийн төлөвлөгөөний саналыг 1 сарын 15-ны өмнө шахаад авчихсан юм байна лээ. Миний хувьд сайдаар томилогдоод энэ чинь сар 10 хоног л хонож байна. Гэхдээ ЗГ-аас энэ Их Хуралд өргөн барихаас нь өмнө тодорхой саналуудаа оруулчихсан байгаа. Тэгэхээр 27 онд бид ТЭЗҮ-ийг боловсруулна гэхэд тэгээд 28 оноос наашгүй болох гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо төсвийн төсөөлөл, төсөв яригдах арай болоогүй байна. Тэгэхээр манай ТНБД-аар ахлуулсан энэ ажлын хэсэг тодорхой хэмжээнд урагшлуулаад, сайдын хувьд салбарынхаа нөөцөөс энэ эхний үндэслэлүүдийг нь гаргаад явчих бололцоо байгаа. Тэгэхээр энэ өнөөдрийн энэ хөгжлийн төлөвлөгөө дээр энийг оруулаад явчих нь би цаг хугацааны хувьд нааштай юм гэж бодож байгаа.

С.Бямбацогт: 18 цаг болсон байна. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө бол энэ чухал асуудал. Монгол Улсыг 2027 онд хэрхэн яаж хөгжүүлэх вэ, Монгол Улсын эдийн засаг, төсөв, орлого, зарлага ямархуу байх вэ, ямар том бүтээн байгуулалтууд яах вэ, хэдэн ажлын байр бий болох уу, гаднын хөрөнгө оруулалт юу байх бол, цалин тэтгэвэр маань яаж нэмэгдэх байх бол гэдэг энэ том бодлого ярьж байгаа учраас хуулийн хугацаатай асуудал учраас цагаа сунгаад өнөөдөр хэлэлцээд дуусъя.

Өнгөрсөн долоо хоногт энэ долоо хоногийн тов дарааллыг хэлэлцэх гэж байх үед АН-ын Үндэсний бодлогын хорооны хурал 5 сарын 8-ны өдөр хуралдана гэсэн тийм мэдээлэлтэй байсан учраас УИХ дахь сөрөг хүчин хамгийн том 42 гишүүнтэй бүлгийнхээ гишүүдийг энэ чухал асуудалд оролцох, асуултаа асуух, санал хэлэх бололцоо олгох үүднээс 4 дэх өдөр чуулганд асуудал энэ асуудлыг оруулаагүй, 5 дахийн чуулганд оруулсан. Тийм учраас өнөөдөр нэлээн ачаалалтай хуралдах нь байна. Их Хурлын гишүүд маань өнөөдөр санал хураалттай учраас хариуцлагатай байж, хэлэлцэж байгаа асуудалдаа чуулгандаа хариуцлагатай оролцоно уу гэдгийг дахин сануулъя. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Энэ төлөвлөлт дээр бид ерөөсөө үр дүн гаргаж чадахгүй байгаа харагдаад байна. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр саяхан 2 жилийн үр дүнг нь ярьсан. Тэгэхэд улсыг улс, нийгэм, эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол 5 үзүүлэлтийн 3-ыг нь ухраасан байсан, 60 гаран их наяд төгрөг зараад. Гэтэл өнөөдрийн бас яг энэ хөгжлийн төлөвлөгөө дотор хөгжлийн биш, доройтлын төлөвлөгөө маягтай зүгээр санамсаргүй ганц нэг жишээ хэлье л дээ. Хөгжүүлэх биш ухраах үзүүлэлтүүд байгаад байна л даа. Жишээлбэл эдийн засгийн эрх чөлөөний байдлын индекс 2027 онд 70-д хүргэнэ гэнэ, 70 дугаар байранд оруулна гэнэ. Өнөөдөр 69 дүгээр байранд байгаа байхгүй юу. Эдийн засгийн эрх чөлөөг чөлөөлье, хөгжүүлье гээд байгаа мөртөө нэг байр ухраана гэсэн ийм заалт орж ирсэн байна. ЗГ-ын нийт өрийн ДНБ-д эзлэх хувийг суурь түвшин 39-ийг 50 болгоно гэнэ. Тэгэхээр ерөө энэ буулгая гэсэн мөртөө ЗГ-ын өрийг 50 хувь болгож нэмэгдүүлнэ гэсэн ийм тоо байна. Гэр хорооллын айл өрхийн бага оврын нарны эх үүсвэрийг нэмэгдүүлэх гээд 1мвт хүргэнэ гэхихсэн байгаа. Одоо 1мвт давчихсан шүү дээ.

Тэгэхээр гэх мэтчилнээр ингээд сайжруулахгүй бол хариуцлага юу гэдэг юм энэ төсөв дээр хэрэглэдэггүй болоод ч тэр юм уу, эсвэл хэн хэнд нь хэрэггүй бичиг баримт болоод тэгдэг ч юм уу, ач холбогдол бага өгөөд байна. Хөгжүүлэх биш, ингээд ухраах үзүүлэлтүүд энэ дотор орчихсон яваад байх юм. Тэгээд мөнгө зарна гээд байдаг энийг анхаарна биз Эдийн засгийн хөгжлийн яам. Тэгээд нэг бүрчлэн харахгүй бол зүгээр энд тэндээс өгсөн тоонуудыг нийлүүлээд үзэхээр ийм асуудлууд харагдаад байна шүү. Та бүхэн нарийн юмнуудыг нь орж хараарай гээд.

Тэгээд хэдэн асуулт байна. 1 дүгээрт Авлигатай холбоотой авлигын индексийг, Авлигын төсөөллийн индексийг 31 байсныг 35 болгоно гэж. Тэгэхээр энэ 5 гол үзүүлэлт байдаг. Энэнээс холбоотой энэ Шүгэл үлээгчийг хамгаалах хуулийн талаар Хууль зүйн сайдаас асуумаар байна. Энэ хууль хэзээ орж ирэх юм бэ?

2 дугаарт нь энэ шүүхээр энэ авлигатай холбоотой хэрэг шийдэгдэж байгаа асуудал, шийдэгдэж байж энэ үзүүлэлт сайжрах бололцоотой. Тэгэхээр энэ Авлигатай тэмцэх газар /АТГ/-аас ч юм уу, энэ холбогдох байгууллага байвал энэ шүүхээр энэ авлигын хэрэг шийдэгдэх энэ процесс дээр ямар ахиц дэвшил гаргана гэж, энэ 31 оноогоо яаж 35 болгоно гэж төсөөлж байгаа юм гэдэг асуудал байна?

Дээр нь энэ ил тод байдал, иргэдийн нийтийн өмч хөрөнгийн ашиглалтыг ил тод мэдэх энэ зарчим бол алдагдаад байгаа. Нууцад оруулдаг, олон улсын гэрээ болгодог. Тэгээд жишээлбэл бараг төрийн яамнууд нь хүртэл нөгөө яамнаасаа мэдээлэл авахдаа өөр улсаас зөвшөөрөл авдаг иймэрхүү байдалтай байгаад байгаа. Тэгээд энэ дээр ямар нэгэн юм төлөвлөж байгаа юм байгаа юу?

2 дугаарт нь эрчим хүчний салбараас эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлнэ гэсэн байна. Тэгэхээр ер нь энэ хэзээ индексжиж хэдэн хувь нэмэгдэхээр энэ жилийн хувьд, юу 27 онд төлөвлөж байгаа вэ энэ талаар мэдээлэл өгөөч? Яг энэ индексжүүлэх нь зөв үү, эсвэл энэ боломжтой байна уу үгүй юү? Эрчим хүчний зохицуулах хороо маань яг бие даасан байдлаар энэ ажиллаж чадахгүй харагдаад байгаа юм. Дараа нь эрчим хүчний салбар дээр энэ Тавантолгой 450мвт-ын хүчин чадалтай ДЦС барих төслийг хэрэгжүүлнэ гээд энэ асар олон жил ярьж байгаа. Бид гадаадад IMPIC Хятадын компанид ОТ-гоос олон 100 сая долларын ингээд юм төлөөд л байгаа. Тэгээд маргаан үүсээд ингээд орхичихдог юм. Яг энэ асуудлыг шийдэж чадах юм уу, ямар төлөвлөгөөтэй байгаа юм бэ?

Дараа нь энэ Гадаад хэргийн яам юм уу, Эдийн засгийн хөгжлийн яамнаас юу асууя. Энэ Узбектэй хийж байгаа барааны хөнгөлөлтийн хэлэлцээр, Солонгостой хийж байгаа Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн талаар. Тэгээд дараа нь, минут дуусаж байгаа учраас энэ Зөвч-Овоотой холбоотой энэ төслийг эрчимжүүлээсэй. Энэ талаар мэдээлэл өгөөч урантай холбоотой? Ийм асуултууд байна, баярлалаа.

С.Бямбацогт: Хууль зүйн сайд дуудъя. Эрчим хүчний сайд Найдалаа хариулж байя. Гадаад харилцааны сайдаас асуусан, өөр? Уул уурхайн сайд. Найдалаа сайд хариулъя Эрчим хүчний сайд.

Б.Найдалаа: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Тэр эрчим хүчний үнийг үнэ тарифыг индексжүүлэх талаар асуусан байна. Яах вэ энэ дээр нэг тодруулга хийхгүй бол болохгүй. ЭХЯ эрчим хүчний үнэ тарифыг хариуцдаггүй, хараат бус, тусдаа институц байгаа Эрчим хүчний зохицуулах хороо гээд. Эрчим хүчний зохицуулах хороо үнэ тарифыг өсгөх, бууруулах, салбарын хөгжилтэй уялдуулаад, зах зээлийн хандлагатай уялдуулаад зохицуулах үүрэгтэй байгаа. Энд Эрчим хүчний зохицуулах хорооноос хүн байвал хариулбал их зохистой байна.

Зүгээр үнэ тарифын хувьд товчхондоо хэлбэл хамгийн түрүүнд нэмэх, хасах гэхээсээ өмнө өртгийг нь бууруулах, илүү зардлыг нь танах, цахимжуулах, нөгөө

ярьдаг элдэв хулгай зэлгий байдаг юм бол тэрийг нь үгүй хийх иймэрхүү байдлаар өртгийг нь эхлээд хамгийн бага түвшиндээ байлгах бодлого барьж байгаа. Түүний дараа мэдээж хэрэг өртгөөс нь хэт бага үнэтэй зарж байвал үнэтэй нь уялдуулах ёстой гэсэн бодлого барьдаг. Зүгээр яг эцсийн үнийг тохируулгыг тарифын тохируулгыг Эрчим хүчинд зохицуулах хороо хийдэг юм. Эрчим хүчинд зохицуулах хороо байвал хариулбал сайн юм байна.

Тавантолгойн ДЦС-ын хувьд үнэхээр үнэн. Олон жилийн турш бүтэх, бүтэхгүй ярьсаар байгаад ерөөсөө бүтсэн юм байхгүй, болсон юм байхгүй ингээд дууссан байгаа. Энэ дээр ямар ч байсан өмнийн говь ОТ-н хэрэгцээг хангахуйцаар эрчим хүчний шинэ эх үүсвэр зайлшгүй хэрэгтэй байгаа. Энэ дээр тодруулж нэг хэлбэл дулааны станцын хажуугаар тэр их сэргээгдэхийн эрчим хүчний нөөц байхад, эрчим хүчний, сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглах шийдлүүдийг судалж байгаа. Энэ дээр богино хугацаанд шийдэл гаргаад, хослуулаад явна гэсэн бодолтой байгаа.

С.Бямбацогт: Зөөвч-Овоо аж үйлдвэрийн, Эрдэс Монгол компани хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон, дараад нь Хууль зүйн сайд бэлдэж байгаарай.

Б.Даваадалай: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Зөөвч-Овоо төсөл хөрөнгө оруулалтын гэрээ нь хүчин төгөлдөр болсон 2 сарын дундуур. Тэгээд үйл ажиллагаа эхэлсэн гэж ойлгож болно. Хамгийн сүүлд байгаль орчны үнэлгээ нь хийгдэж дуусаад ингээд эхэлчихсэн. Энэ жилдээ 150 орчим сая долларын зарцуулалт хийгдэнэ гэж хүлээж байгаа юм. Тэгээд кемп, нөгөө дэд бүтцүүд, бусад зүйлүүд нь ингээд эхлээд явна. Тэгээд ажил хугацаандаа явж байгаа. Одоогийн төлөвлөгөөгөөр 28 оны 4 дүгээр улиралд ашиглалтад оруулна гээд хүлээж байгаа. Тэгэхээр хүчин төгөлдөр болчихсон, ажил эхэлчихсэн гэж ойлгож болно.

С.Бямбацогт: Амарсайхан сайд хариулъя. Авлигын индекс хэрхэн, яаж бууруулах, авлигатай яаж тэмцэх гэж байгаа талаар.

С.Амарсайхан: Авлигын асуудлыг анхаарч ажиллаж байгаа холбогдох хууль хяналтын байгууллагууд. Мэдээж авлигын индексийг ахиулах, энэ ухарсан энэ чинь бараг 10-аар ухарчхаад байгаа учраас холбогдох байгууллагуудын уялдаа холбоог хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига хээл хахууль, албан тушаалын асуудлуудыг урьдчилан сэргийлэх чиглэлийг 1 дүгээрт эрчимжүүлнэ. 2 дугаарт энэ чиглэлээр Ерөнхий сайдаас өгсөн үүрэг даалгавар, ЗГ-ын бодлогын хүрээнд бүх талын оролцоотой авлигыг бууруулах ажлуудыг эрчимжүүлэх ажлууд хийгдээд эхэлж байна, явж байна. 2 дугаарт энэ Шүгэл үлээх тухай хууль байгаа. Шүгэл үлээх тухай хуулийг ЗГ-аар хэлэлцээд, УИХ-д өргөн барихад бэлэн болсон байгаа боловч энэ хуулийн.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, Амарсайхан сайдын микрофон.

С.Амарсайхан: Шүгэл үлээгчийн тухай хуулийг өргөн барихтай холбоотой асуудал дээр бид нэлээн нухацтай хандах ёстой гэж үзэж байгаа. Шүгэл үлээгчийн тухай хууль өөрөө энэ авлига, албан тушаалын хэргийг илчлэхээс гадна, асуудлыг улс төрийн хэрэгсэл болгож болохгүй. Аливаа шүгэл үлээж байгаа шүгэл үлээгчийн эрх өөрөө бас хариуцлага хамтдаа явах ёстой гэж үзэж байгаа учраас энэ өргөн барих асуудлыг ойрын хугацаанд тодорхой болгож мэдээлэл өгнө гэж ойлгож болно.

С.Бямбацогт: Жадамбаагийн Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Авлигын индексээр манайх 24 онд 33 оноо аваад 114-д байсан юм, 25 онд ухраад 31 оноо аваад 182 улсаас 124 дүгээр эрэмбэлэгдсэн юм. Тэгэхээр энэ 10 хэдэн байрын ухралт үүсчихсэн. Тэгэхээрээ бид буцаад үсрээд энэнийхээ урд гарах мэдээж зорилготой байна. Гэхдээ бодит түвшин ингээд л урагшлаад л эхний ээлжид тэр 24 оныхоо 33 оноондоо хүрэх нь л их чухал байна. Транспэрэнси Интернэшнл манайд ингээд ийм 6 зөвлөмж өгчихсөн. Энэ төрийн үйлчилгээ, төсвийн хяналт ил тод байдлыг сайжруул, иргэний нийгэм болон шүгэл үлээгчийг хамгаал, авлигын хохирогчдыг шударга ёсонд хүрэх боломжоор хангах, улс төр дэх зүй бус нөлөөллийг зохицуулах, өндөр түвшний авлига болон хууль бус санхүүгийн урсгалаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариуцлага тооцох гэх мэтийн үнэлгээнүүдийг өгсөн. Тэгээд энийг хэрэгжүүлж байж манай авлигын индекс сайжирна. Авлигатай хийх тэмцэл.../минут дуусав/

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Найдалаа сайд дээр тэр би харин энэ Тавантолгойн цахилгаан станц дээр дулааны гээд биччихсэн. Саяын таны хариултаас сэргээгдэх байж магадгүй юм шиг үг үсэг, юу хариулт сонсогдлоо. Тэгэхээр энэ дээр дулааны гээд биччихээр дахиад энэ чинь явахгүй ийм асуудал болох юм биш үү гэдэг нэг ийм асуудал байна?

Тэгээд энэ нөгөө гадаад худалдааны хэлэлцээр Узбектэй хийж байгаа барааны хөнгөлөлттэй хэлэлцээр, Солонгостой хийж байгаа эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн талаар асуусан. Энэ дээр хариулт авъя.

Түрүүн Хууль зүйн сайдаас энэ авлигатай холбоотой индекс дээр энэ шүүхээр энэ авлигын хэргүүд шийдэгдэхгүй яваад байгаа. Яригдаад л байдаг, үнэн, худлаа нь мэдэгдэхгүй. Тэгээд энэ асуудлууд шийдэгддэг байдлаар ямаршуу ахиц дэвшил, өөрчлөлтүүд төлөвлөж байгаа вэ тэр талаар мэдээлэл өгөөч гэсэн ийм асуултууд байсныг нөхөж асууя?

С.Бямбацогт: 4 номерын микрофон ажлын хэсэг хариулъя.

Д.Эрдэнэтуяа: Гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Эрдэнэтуяа байна. Узбекистан улстай байгуулах хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээрийн хувьд айлын талаас худалдааны хэлэлцээрийн төсөл болон барааны жагсаалтыг ирүүлсэн байгаа. 94 барааны жагсаалт ирүүлсэн байна. Манай яамны хувьд болон холбогдох яамд болон агентлагуудыг оруулаад ажлын хэсэг байгуулсан байгаа. Манайхаас урьдчилсан байдлаар 102 барааны жагсаалт урьдчилсан байдлаар гаргасан байна. Ажлын хэсгийн хүрээнд бид судалгаагаа эцэслэхээр байгаа. Дээрээс нь нөгөө барааны жагсаалтаа, 2 талын барааны жагсаалтаа эцэслэхээр, эцэслэж хэлэлцээ хийх ийм ажлууд явж байгаа.

Солонгосын хэлэлцээрийн хувьд өнгөрсөн хугацаанд бид 4 удаагийн хэлэлцээг хийсэн байгаа. 5 дахь удаагийн, 5 дахь үе шатны хэлэлцээг ойрын хугацаанд 6 дугаар сарын дундуур хийхээр бэлтгэл ажлаа хангаад явж байна. Хэлэлцээрийн хувьд одоогийн байдлаар 17 бүлэг бүхий ийм хэлэлцээр байгаа. Урьдчилсан байдлаар бүлэг тус бүрээрээ ахиц дэвшлүүд гараад явж байна. Бид ажлын.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя 4 номер.

Д.Эрдэнэтуяа: Бид ажлын хэсгийнхээ хүрээнд буюу том ажлын хэсгийнхээ хүрээнд 2 улсын ЗГ-ыг төлөөлөөд явж байгаа төлөөллүүд хэлэлцээгээ 5 дахь үе шатны хүрээнд хийнэ. Дотооддоо бол бүлэг тус бүрээрээ бэлтгэл ажлаа хангаад, техникийн уулзалтуудыг ойрын хугацаанд хийхээр ингээд бэлтгэл ажлаа хангаад явж байна.

С.Бямбацогт: Болсон уу хариулт? Ганбатын Хосбаяр. Найдалаа сайд, Хууль зүйн сайд. Найдалаа сайд хариулъя.

Б.Найдалаа: Тэр зөв, зөв. Дулааны цахилгаан станц барина гээд олон жил явсан, болоогүй. Гэхдээ тэр төсөл төр, хувийн хэвшлийнх юм уу, ингээд хувилбараар явж л байг. Тэрний хажуугаар нэгэнт энэ нүүрсэнд тулгуурласан ДЦС барих нь төвөгтэй байгаа бол төр өөрөө барих нь төвөгтэй байгаа бол хөрөнгө оруулагчдын хандлагыг ажиглавал ер нь сэргээгдэхийн яагаад эх үүсвэр байж болохгүй билээ гэсэн судалгааг бид хийж байгаа юм. Сэргээгдэхийн эх үүсвэр бол хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэх учраас энэ төлөвлөгөөнд орох шаардлагагүй, хэзээд нээлттэй. Тэгэхээр энийг ингээд хосолсон байдлаар хэрэгжүүлээд, аль илүү боломжтой, аль илүү хурдан, үр дүнтэй байхыг бид хэрэгжүүлэхийг зорино. Тэгсний ачаар ОТ өмнөд хөршөөс авч байгаа тэр импортыг хязгаарлах, гарч байгаа валютын урсгалыг зогсоох тийм зорилготой, хувилбартай ажиллаж байгаа гэсэн үг.

С.Бямбацогт: Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Энхтүвшин гишүүнээс энэ авлигын асуудал хууль шүүхийн байгууллага дээр хэрхэн шалгагдаж байна гэж. АТГ дээр авлига, албан тушаалын асуудлаар 145 хэрэг шалгагдаж, 45 нь шүүх хуулийн, прокурорын байгууллага руу шилжсэн байдаг. Өнгөрсөн хугацаанд нэг ийм өндөр, төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой хэрэг шийдэгдэхгүй байна, эсвэл замхарч байна гэсэн асуудал байдаг. Тэгвэл энэ 16 төрийн өндөр албан тушаалтнуудын асуудал хууль, шүүхийн байгууллагаар шийдэгдсэн байдаг. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын гишүүд гээд. Тэгээд өнөөдөр энэ хянан шалгах үйл ажиллагаанууд хууль хяналтын байгууллагуудаар шалгагдаж байгаа хэргүүдийн явцын талаар та бүхэн байнга мэдээлэл авч байгаа учраас энэ чиглэл.../минут дуусав/

С.Бямбацогт: Ганбатын Хосбаяр гишүүн асуултаа асууя.

Г.Хосбаяр: Бүсчилсэн хөгжлийн бодлогын талаар асууя. Тэгэхээр нөгөө бүсийн хөгжлийн бодлого маань ер нь Номтойбаяр сайдын Шадар сайд дээр харьяалагдаж байна уу, хаана байна аа? Бүсчилсэн хөгжлийн газраас хүмүүс байгаа юу? Ер нь бид нөгөө сонгуулиа бүсчилсэн байдлаар явуулсан. Мөн ноднин чинь бүс, бүс дээр очиж чуулган хийсэн. Ер нь нэлээн л ажил хэрэгч зүйлүүд явж байсан чинь сүүлийн үед яригдахаа больчихлоо. Тэгэхээр ер нь бүсээрээ хөгжих маань хэвээрээ юу, больчихсон уу тэрийгээ нэг хариулаад өгөөч? Уг нь бүсийн хэмжээний бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт бүсийн хэмжээнд асуудлуудаа шийдээд явдаг байвал хэрэгтэй байх юм. Гэтэл энэ төсөв, төлөвлөгөө энэ юмтай холбоотой асуудлыг харахад энэ бүсийн хэмжээний асуудлыг ерөөсөө ярихгүй байна. Зөвхөн нэг аймгийн хэмжээний, эсвэл нэг өмнө нь эхэлсэн ийм асуудлуудаа яриад байна. Тэгэхээр энэ бүсчилсэн хөгжил, бүсчилсэн хөгжих хэвээрээ юу,

бүсчилсэн хөгжлийн бодлого дээрээ ер нь яаж анхаарч байгаа вэ? Энэ дээр энэ бүсчилсэн хөгжлийн газрынхан бүүр тодорхой мэдээлэл өгмөөр байна.

Дараагийн асуулт Боловсролын яамнаас. Бид чинь энэ 2026 оныг боловсролын жил болгоод зарлачихсан байгаа. Тэгээд энэ жил ер нь яг боловсролын салбарт ямар ахиц дэвшил гарах вэ? Боловсролын сайд маань нэг цалин хөлсний асуудал яриад яваад байгаа. Гэтэл энэнээс цаана боловсролын салбарын барилга байшин, хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, мөн сургалтын орчин, бүүр сүүлийн үед 1 дүгээр ангид орж байгаа хүүхдүүдийн насыг ахиулах тухай хүртэл ярьдаг боллоо. Тэгэхээр энэ дээр ер нь яг нэгдсэн бодлого байгаа юу? Ер нь тэгээд судалгаагаар 108 сургууль, 95 цэцэрлэг улсын хэмжээнд 2030 он хүртэл хэрэгтэй гэж байгаа. Энэ барилга байшинг барьчихвал ямар ч байсан 3 ээлжээр хичээллэхгүй, хүүхдүүд маань сургуультай болох юм байна лээ. Мөн цаана нь хөдөө орон нутагт олон сургуулиудын засвар шинэчлэлт, мөн тоног төхөөрөмжийн дутагдалтай байдал маш их байгаа. Тэгэхээр энэ дээр ер нь ямар байр суурьтай, ямар бодлоготой байгаа юм бэ?

Дээр нь энэ бүсчилсэн, энэ 26 оны хөгжлийн төлөвлөгөө дээр боловсролын салбарт хийгдэх ажил гэхээр зэрэг энэ ерөнхий боловсролын сургуулиудын бүтцийн дахин төлөвлөлт хийж, сумдад бага, дунд, сум дундын ахлах сургууль, нийслэлийн 3 мянгаас дээш хүүхэдтэй сургуулиудын бүтцийг өөрчлөх гэсэн байх юм. Тэгэхээр энэ чинь нөгөө 90 оноос өмнөх шигээ зарим сумд нь бага сургуультай болоод сум дундын 10 жил, 12 жилийн сургуулиуд бий болоод, энэ хотын 3 мянгаас дээш хүүхэдтэй сургуулиуд нь бас ямар болох гээд байгаа юм бэ энэ дээр ер нь өмнө нь сонсогдоод байсан яг ямар бодлого барьж байгаа юм бэ? Ийм асуудлууд дээр энэ Боловсролын яам, Боловсролын сайдаас хариулт авмаар байна.

3 дугаар асуудал нь болохоор энэ тээвэр логистик ЗТЯ-наас, энэ төлөвлөгөө дээр харж байхад нэг өмнө нь эхэлсэн баахан замуудыг дуусгах юм байна. Мөн тэр нисэх буудлууд, хилийн боомтууд гээд үргэлжлэх ажлууд байна. Яг өнөөдөр хөдөө орон нутагт бараа, бүтээгдэхүүний үнэ ханш чинь энэ тээвэр логистикийн салбартай маш их хамааралтай байгаа шүү дээ. Монгол Улс тээвэр логистикийн салбар муу хөгжсөн учраас, логистикийн салбараа сайжруулж чадаагүй учраас энэ бараа, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт гээд үнэ өртөгтэй холбоотой олон асуудлууд байдаг. Тэгэхээр энэ ЗТЯ энэ ирэх жилүүдэд энэ төр, хувийн хэвшлийн түншлэлээр ч байна уу, эсвэл энэ бодлогоор ер нь яг энэ логистикийн салбарт, тээврийн салбарт ямар өөрчлөлт, ахиц дэвшил авчрах зүйл хийх гээд байгаа юм бэ? Энэ дээр ЗТЯ тодорхой хариулт өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Бүсчилсэн хөгжил Номтойбаяр сайд хариулъя, дуудаарай. Боловсролын сайд асуултад хариулж байя. Дараад нь Зам, тээврийн сайд гадаад томилолттой байгаа учраас ЗТЯ-наас Төрийн нарийн бичгийн дарга хариулна. Энх-Амгалан сайдын микрофон өгье.

Л.Энх-Амгалан: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Хосбаяр гишүүнээ сая шинэ ЗГ байгуулагдаад Монгол хүүхдийг мэдлэгийн хоцрогдол, ур чадварын хоцрогдлоос чөлөөлье гэдэг бодлогоо дэвшүүлж байгаа. Тэгэхдээ энэ бол цоо шинэ бодлого биш. Юун дээр тулгуурлаж хийсэн юм гэхээр урт болон дунд хугацааны хөтөлбөр, ЗГ-ын мөрийн хөтөлбөр дээрээ тулгуурлаад, одоо үлдэж байгаа 2 жилдээ нэг боловсролын хүртээмжийн хувьд яг ямар дэвшил гаргах юм, боловсролын чанарын хувьд яг ямар дэвшил гаргах юм бэ гэдэг нэг ийм бодлогоо бид

дэвшүүлээд, тэгээд ЗГ-аар батлуулчихсан. Ирэх долоо хоногт би танай бүлэг дээр энэ бодлогыг танилцуулна гэж бодож байна. Өнгөрсөн долоо хоногт МАН-ын бүлэг дээр танилцуулсан. Тэгээд нэг минутад хариулахад хэцүү.

Ерөнхийдөө хийсэн их өгөгдлийн тооцоогоор Монгол Улсад шинээр 100 орчим цэцэрлэг, 100 орчим сургууль бариад, тэгээд хуучирсан сургуулиуд байгаад байгаа шүү дээ насжилсан, газар хөдлөлтөд тэсвэргүй болсон 100 орчим сургууль байгаа юм байна лээ. Тэгээд энийгээ нэг шийдье. Тэгэхдээ энэ чинь бүгдийг нь ингээд төсвийн эх үүсвэрээс шийдэж чадахгүй учраас бид энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бид тооцоо хийж байна. 100 гаруй сургуулиудыг олон жилийн санхүүгийн түрээс, бариад-ашиглаад-шилжүүлэх хэлбэрээр хийх ийм тооцоонууд хийгдэж байна. Энэ дээр нэлээн том дэвшил гарах болов гэж бодож байна.

Тэгээд ер нь яах вэ бид энэ өнгөрсөн 30 жил төлөвлөгөөгүй явж ирсний л гай уршиг өнөөдөр бас гарч байгаа л даа. Тэгээд одоо яг 89 он хүртэл энэ сургуулийн бүтцүүд их зөв явсан юм байна лээ Хосбаяр гишүүнээ. Нийт сургуулийн үндсэндээ 19 хувь нь бага сургуулийн тогтолцоотой, нийт сургуулийн 50 хэдэн хувь, 50 гаруй хувь нь дунд сургуулийн тогтолцоотой, тэгээд нийт сургуулийн 30 гаруй хувь нь ахлах сургуулийн тогтолцоотой явж байсан. Энэ бол ингээд үндсэндээ 89 оноос хойш эвдэгдсэн байгаа юм. Одоо бол үндсэндээ 330 сум бүгдээрээ 12 жилийн тогтолцоотой болчихсон ийм болж байна. Тэгээд 10 дугаар ангид 5 хүүхэдтэй, 11 дүгээр ангид 7 хүүхэдтэй, 12 дугаар ангид 12 хүүхэдтэй 200 гаруй сургууль байна. 200-аас доош хүүхэдтэй 200 гаруй сургууль.

Тийм учраас энэнээс үүсээд багшийн хомсдолууд үүсэж байгаа. Тэгэхээр боловсролын чанар ярьж байгаа тохиолдолд бид сум дундын ахлах сургууль яг гаргаж ирнэ. Та зөв ойлгосон байна. Нийслэл дээр бид цэцэрлэгийн асуудлыг шийдсэн. Ингээд сүүлийн 5 жил энэ хүн амын төрөлт буурсан байна. Энэнээс болж цэцэрлэгүүд дээр хүүхдийн тоо багасаж байгаа. Энэ дээр бид үндэслэж энэ цэцэрлэгүүдийг бид хотхоны бага сургууль болж, хүүхэд яг хотхон дотроо сургуульд явах ийм боломжоор бид хангана. Тэгээд ингээд 3 ээлжийн эрсдэлд орох гэж байгаа 3 мянгаас дээш хүүхэдтэй байгаа 38 сургуулиудыг бид дунд, бага, дунд, ахлах сургуулийн тогтолцоогоор задалъя гэсэн ийм төлөвлөлттэй байна. Та энийг маш зөв ойлгосон байна. Тэгээд би танай бүлгийн хурал дээр нэлээн дэлгэрэнгүй энэ танилцуулгуудыг хийе гэж бодож байна. Ингээд бүх юм бид аймаг аймгаар нь, дүүрэг дүүргээр нь энэ тооцооллуудыг хийсэн байгаа.

С.Бямбацогт: Амарсайхан сайд хариулъя, биш, Амарсайхан сайд биш шүү. Зам, тээврийн яамны ТНБД уу, 4 дүгээр микрофон. Бүсчилсэн хөгжил дээр хэн хариулах юм бэ? ЗГХЭГ-ын дарга сайдуудаа дуудаарай.

Н.Баярмагнай: Их Хурлын дарга, эрхэм гишүүдэд энэ оройны мэндийг хүргэе. Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Зам, тээврийн салбар түрүүн төсвийн хүрээний мэдэгдэл болон Монгол Улсын эдийн засгийн өсөлттэй холбоотой мэдээлэл Их Хурлаар орсон. Үүнтэй холбоотой бүх өсөлтийн суурь мэдээж зам, тээвэр үнэ төлбөрийн үнэтэй холбоотой асуудал холбоотой. Тийм учраас ЗТЯ-ны хувьд логистикийг, зам, тээвэр логистикийг хөгжүүлэх чиглэлээр бүсийн тээвэр логистикийн төвүүдийг Чойр, Алтанбулаг, Замын-Үүд зэрэг логистикийн төвүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулахаар төлөвлөж байгаа. Мөн Дэлхийн банкны санхүүжилтээр Хөшигийн хөндийн логистикийн төв ТЭЗҮ боловсруулах ажлыг 26 оны 2 дугаар сард багтаан эхлүүлэхээр ажиллаж байна. Одоогоор Монгол

Улсын хэмжээнд тээвэр логистикийн зардал тээврийн нийт зардлын 30 хувийг эзэлж байгаа. Тийм учраас ийм бодлогын арга хэмжээнүүдийг зайлшгүй авч явах шаардлагатай. Төмөр замтай холбоотой та бүхэн мэдэж байгаа Багахангай, Хөшигийн хөндий, Эмээлтийн.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, 4 дүгээр микрофон.

Н.Баярмагнай: Төмөр замын ачаа эргэлтийг нэмэгдүүлэх эдийн засгийн ийм ач холбогдолтой ийм Багахангай Эмээлтийн хөндийг ийм төмөр замын холболт байгаа. Ингэснээр мөн логистик 1, 2 төвүүдийг байгуулна. Тэгснээр хотын нийслэлийн, нийслэл хүртэл төмөр замын бараа эргэлтийг тэр ХАБ дээрээ цуглуулж, нийслэл рүү оруулж ингэж төлөвлөх ийм том төмөр замын төлөвлөлт, бодлого явж байгаа. Ингэснээр нийслэлээр дамжих аюултай бараа ачаа нийслэлийг тойрох, нөгөө талаас урд, хойдоос орж ирэх бараа бүтээгдэхүүн Хөшигийн хөндийн бараа логистикийн төв дээр буюгаад, хот руу орох ийм том төлөвлөлт явж байгаа юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Бүсчилсэн хөгжил, Номтойбаяр сайд иртэл нь хэн, дараагийн гишүүн асуултаа асууж болох уу? Тодруулъя Хосбаяр гишүүн. Хосбаяр гишүүний микрофон өгөөрэй. Бүсчилсэн хөгжлийн газраас хүн байхгүй байгаа гэж ойлгох уу тийм ээ, уг нь баймаар юм. Тэр саяын тээвэр логистик дээр маш их судалгаанууд байдаг. Тэгээд сая энэ хөгжлийн төлөвлөгөө дээр яах вэ зөвхөн Дархан-Уул, Чойр гэсэн юмнууд байх шиг байна. Жишээлбэл манай Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод гэхэд томоохон тээвэр логистикийн төв байгуулахаар төлөвлөлт нь хийгдчихсэн. Орон нутгийнхан төр, хувийн хэвшлийн түншлэл гээд явж байна. Тэгээд нөгөө манай төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн л алдаанаас болоод цаг алдчихсан л даа. Тэгээд сая Төсвийн хуулийг дагаж орж ирсэн өөрчлөлтөөр арай цаг хугацаа хэмнээд, энэ төсөл маань нэг урагшлах байх гэж ингэж найдаж байгаа. Түүнээс биш одоо төр, хувийн хэвшлийн түншлэлээр ганцхан зам л хийгдсэн. Өөр ямар ч амжилттай хэрэгжсэн төсөл байхгүй байгаа. Тэгэхээр Эдийн засгийн хөгжлийн сайд Төр, хувийн хэвшлийн түншлэлийнхээ хууль дээр онцгой анхаарч, сайн ажиллаарай. Орон нутгуудаас.../минут дуусав/

С.Бямбацогт: Энхбаяр сайд, Жадамбаагийн Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бүх түвшинд дэмжиж байгаа. ТЭЦ 5, Баян, Бөөрөлжүүт, Сэлэнгэ, Замын-Үүдийн зам, хил боомтын замууд бүгд энүүгээр явж байгаа. Тэгэхээр хаана санаачилгатай хөгжлийн бодлогоо тодорхойлж байгаа тэр орон нутаг юмаа тодорхойлоод л аваад ир. Зарлаад, үнэлгээ дээр нь тус дэм болоод, хамтарч ажиллаад, манай Төр, хувийн түншлэлийн газартай хамтраад ЗГ-т оруулаад, хэлэлцүүлээд л гаргаад бай. Бид ирэх долоо хоногт гэхэд Байдрагийн 30мвт-ын станцыг оруулах гэж байна. Хурал болгоноор л нэг нэгээр ороод л урагшлаад байгаа шүү. Тэгэхээр энийг бүрэн ашиглаарай. Үнэхээр улсын төсвөөр дамжих боломж, санхүүжүүлэх боломж хязгаартай болж байгаа үед дандаа энэ чиглэл рүү. Энд л хувийн хэвшилдээ бид ажлын байр гаргая, боломж гаргая, бодлогын бүх дэмжлэг үзүүлье гэдэг нь энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн энэ бодлогоор хэрэгжинэ. Санаачилгатай ажиллацгаагаарай гэж.

С.Бямбацогт: Төр, хувийн хэвшлийн түншлэл ч хурдацтай яваад, хууль нь их сайн болчихсон ч юу л бол. Би Зам, тээврийн сайд байхдаа төр, хувийн хэвшлийн түншлэлээр энэ Туулын хурдны замыг явуулах гээд 5, 6 компани өөрийнхөө

хөрөнгөөр бариад, замын төлбөр аваад явчихъя гээд явж байсан. Наад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиас чинь болж гацсан. Монгол Улсын баруун бүсэд, зүүн бүсэд Ховдын, Дорнодын, Өмнөговийн, Хөвсгөлийн нисэх буудлыг хувийн хэвшлийнхэн гаднын хөрөнгө оруулалтаар барья гэж байхад наад хуулиас чинь болж гацсан.

Дараа нь энэ Улаанбаатараас Замын-Үүдийн чиглэлд 4 эгнээ зам барья гэдэг асуудал явуулах гээд явж байхад наад хуулиас чинь болж гацсан. Наад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиа өөрчилж байж, хөрөнгө оруулалт орж ирнэ. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр явна шүү. Тэр хууль өөрчлөгдөөгүй байхад нэг их төр, хувийн хэвшлийн түншлэлээр асуудал яваад байх нь юу л бол. Тийм болохоор яаралтай тэр төр, хувийн хэвшлийн түншлэлээ өөрчлөх асуудал оруулж ир Энхбаяр сайд. Одоо бол яваад байгаа юм байхгүй шүү наад хуулиар чинь. Харин ч хуучин хуулиар явж байсан юмнуудыг шинэ хуулиар гацаасан шүү. Хүнд сурталтай, хэтэрхий төрд данхар эрх мэдэл өгчихсөн. Бүсчилсэн хөгжил гээд асуугаад байна. Энхбаяр сайдаа ЗГХЭГ-ын даргаа сайд нараа дууд. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя. Ирэхээр нь хариулуулъя Хосбаяр гишүүнээ.

Л.Соронзонболд: Энэ төсвийн урсгал зардал маш өндөр болсон. Тэгээд зөвхөн боловсрол, эрүүл мэндийн салбарын цалинг нэмчихсэн, бусад салбарын цалинг нэмэх шаардлага байна, тэтгэврийн хэмжээг нэмэх шаардлага байна гээд ингээд яригдаад байдаг. Тэгэхээр нөгөө талдаа энэ чинь юу гэсэн үг вэ гэхээр урсгал зардал маань ингэж төсөвтөө хамгийн их хувь эзлээд эхэлбэл бид ер нь цаашдаа улс маань хөрөнгө оруулалтын асуудлаа яаж шийдэх вэ гэдэг ийм асуудалд орж байгаа. Тэгэхээр энэ төрийн албыг цомхон, бүтээмжтэй өндөр бүтээмжтэй болгоно гээд ингээд зорилт тавьсан мөртөө яг ингээд дотоод төлөвлөгөөг нь хараад уншаад үзэхээр тэнд ерөөсөө тийм цомхон болох талаар ямар ч үг, үсэг байхгүй. Зүгээр л сайхан сургалт хийнэ, сайхан системтэй болно л гэсэн байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр яг энэ төрийн албан дээр цомхон, энэ бүтээмжтэй болох талаар яг тодорхой ямар өөрчлөлт, шинэчлэлт хийх юм бэ гээд? Миний хувьд хараад үзэхээр татвар, гааль, нийгмийн даатгал, эрүүл мэндийн гээд ийм 4 байцаагч төсөвт орлого төвлөрүүлэхээр ажиллаж байгаа байхгүй юу. Бусад улсуудын жишиг бол ингээд хараад үзэхээр энэ нэгдсэн ийм орлогын газар байж болохоор санагдаад байгаа юм. Иймэрхүү өөрчлөлтүүд бид хийнэ гэж бодож байна уу, яг юу хийе гэж бодож байна вэ гээд 1 дүгээр асуулт байна?

Дараагаар нь болохоор энэ төрийн өмчийн компаниуд. Төрийн өмчийн компаниудын өр бол төсөвт ЗГ-ын өрөнд орохгүй байгаа. Төрийн өмчийн компаниуд бүх асуудал нь төсвийн гадуур явж байгаа. Тэгэхээр төрийн өмчийн компаниудаар яг ямар тодорхой бүтцийн өөрчлөлт хийх гээд байгаа юм бэ? Өөрөөр хэлбэл ноогдол ашиг нэмэгдүүлэх хүрээнд хувьчлал болон бүтцийн өөрчлөлт хийгээд 2027 онд төсөвт хэдэн төгрөгийн орлого оруулж ирэх гээд байгаа юм бэ?

Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтээр бол ноогдол ашгийг хэд болгож байгаа талаар ямар ч мэдээлэл алга байна. Бүтцийн өөрчлөлтөөс дамжуулаад, хувьчлалаас дамжуулаад төрийн өмчийн компаниудын өөрчлөлтөөс хамаараад хэдэн төгрөг орж ирэх гэж байгаа нь бас тодорхойгүй байгаад байна. Энэ талаар ЗГХЭГ-аас ингээд хариулаач?

Эдийн засгийн хөгжлийн яамнаас зөвхөн уул уурхай, эрчим хүчний салбараас бусад салбарт яг тодорхой хэмжээнд ямар том ажлыг 2027 онд төлөвлөж байна вэ? Эрчим хүч, уул уурхай дээр ойлгож байна. Бусад салбарт яг ямар тодорхой эдийн засгийг солонгоруулах үүднээс ямар ажлууд хийх гэж байна вэ гэж асуух гэж байна?

Боловсролын яамнаас асуух асуулт юу байна гэхээр энэ сумын төв, аймгийн төв болон нийслэлийн сургуулиудын хүүхдүүдийн мэдлэгийн гүйцэтгэлийн үнэлгээ харилцан адилгүй байна гээд ийм судалгаа гараад ирчихсэн байгаа. Тэгээд энэ дээр болохоор математик, унших, байгалийн ухаан гэсэн 3 хичээлээр суралцагчдын гүйцэтгэлийн ялгааг гаргаад ирчихсэн юм байна лээ. Тэгээд би энэ талаараа тодорхой ажлууд хийх гэж байгаа юм байна гээд хараад үзэхээр 2027 оны энэ төлөвлөгөөнийхөө хяналт шинжилгээ, үнэлгээнийхээ шалгуур үзүүлэлтээр болохоор зөвхөн 6-аас 14 насны математик, Монгол хэлний чиглэлээр тодорхой ийм зорилтууд тавьсан байгаа. Тэгэхээр яагаад бусад насан дээр болон нөгөө байгалийн ухааны хичээл дээрээ ингээд тодорхой зорилгууд, зорилтууд тавихгүй байна вэ гэсэн ийм асуулт байна?

С.Бямбацогт: Тэргүүн шадар сайд Энхбаяр хариулъя.

Ж.Энхбаяр: Соронзонболд гишүүнтэй санал нэг байгаа. Ер нь энэ төрийн алба, төрийн өмчит ААН тойрсон асуудал бүүр нийгмийн бухимдал, нийгмийн гол шаардлага хүсэмжлэл болчихоод байгаа. Эрс өөрчлөлт хэрэгтэй байгаа. ЗГ дээр Хяналт хэрэгжүүлэх газар дээр ажил үүрэг өгөгдөөд, төрийн албаны чиг үүрэг, салбарын чиг үүргийн уялдаа, чиг үүргийн давхцал гээд энэ иж бүрэн шинжилгээнүүд зураг авалтууд хийгдээд үндсэндээ дөхөж байна. 9 сарын 1 гэхэд төрийн өмчийн бодлого, зохицуулалттай холбоотой төрийн өмчийн компаниудыг хувьчлах, татан буулгах, нэгтгэх зохион байгуулалтын арга хэмжээг, төрийн албатай хамтарсан энэ бодлогын арга хэмжээг 9 сарын 1 гэхэд төсөвтэй дагуулан өргөн барихаар ингээд шийдвэрлэхээр орж ирнэ.

Гишүүддээ хэлэхэд түрүүн бид төрийн өмчийн хувьчлалын том багц оруулсан. Тэгээд Их Хурал дээр унасан шүү дээ, хувьчлах цаг болоогүй гээд буцаасан. Дахиад оруулна. Ер нь яаралтай хувьчлах хэрэгтэй. Аль болох эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах хэрэгтэй. Эдийн засаг дахь төрийн оролцоо төсөв болон ТӨК-аараа дамжуулаад эдийн засгийн 61 орчим хувь нь төрийн оролцоо болчихоод байдаг. Орон зайд, хувийн орон зайд нэлээн хязгаарлалт үүсээд байдаг. Энийг яаралтай бид чөлөөлөх ёстой. ЗГ-ын чөлөөлөх бодлогын хүрээнд тэргүүн ээлжид энэ бодлогууд явж байгаа. Тэгээд намар гэхэд нэлээн бодлогын арга хэмжээтэй, санал санаачилгатай орж ирнэ.

С.Бямбацогт: Баярлалаа. Энэ чухал асуудал, тэгээд чөлөөлье энэ бодлогын хүрээнд бид нэн тэргүүний шийдэх ёстой хуулиуд Эдийн засгийн эрх чөлөөний хуулиа хурдан оруулж ирмээр байна ЗГ-аас. 2 дугаарт нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийнхаа хүнд суртлыг, чөдөр тушааг тасалж хаямаар байна. Хуучин гайгүй байсан, дордуулчихсан. 3 дугаарт нь тэр Хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийг дэмжих тухай хууль. Их Хурал дээр бид Зөвшөөрлийн тухай хуулиа хурдан явуулах гээд оролдож байгаа. Энэ бол нэлээн эдийн засагт чинь нэлээн том дэм болох байх. Тийм болохоор ЗГ энэ Хөрөнгө оруулалтыг дэмжих, дээрээс нь Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн энэ хуулиудаа илүү либерал, илүү төр, хувийн

хэвшлээ, хувийн хэвшлээ дэмжсэн ийм хууль чиглэлээр оруулж ирэхдээ илүү анхаараарай гэдгийг хэлье. Хэрэг эрхлэх газар Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Ер нь төр томроод байгаа гол шалтгаан төрийн өмчийн компаниуд дээр л байгаа. Тэгэхээр Нийтийн өмчийн хуулийг болон Төрийн өмчийн компанийн засаглалтай холбоотой 2 хуулийн төслийг УИХ-д ЗГ өргөн барьчихсан байгаа, хэлэлцүүлгийн шатад байгаа. Гэхдээ эрх зүйн орчноо их оновчтой болгох ёстой эхлээд. Энэний дараа УИХ-д өргөн барьчихсан байгаа Төрийн өмчийн компаниудыг хувьчлах асуудлыг энэний дараа ярих ёстой. Хуулиасаа түрүүлээд Их Хурал тогтоол гарах боломжгүй байгаад байгаа. Төрийн өмчийн компаниудын талаар баримтлах стратеги. ЗГ, Ерөнхий сайдын бодлого ер нь энэ төрийн өмчийн стратегийн орд газруудтай холбоотой хувь хувьцаа эзэмшиж байна гээд тэнд дахиад авлига.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, Энхбаяр сайд Б.

Б.Энхбаяр: Авлига, хулгай ингээд нүүрлээд, энэ бол яг эсрэг ийм байдалтай байна. Компаниуддаа ч гэсэн ер нь энэ дарамттай, хувийн эдийн засгаа ерөөсөө тэлэх ийм чөлөөлөх боломж олгохгүй байна гэдэг утгаар, ер нь татвараа авдаг энэ зарчим руугаа орвол яасан юм бэ гэдэг бодлого барьж байгаа. Энэ чиглэлээр хуулийн төсөл боловсруулах үүрэг, чиглэл өгөгдчихсөн ажиллаж байна. Нэн яаралтай горимоор оруулж ирэх болов уу гэж төсөөлж байгаа. Мөн томоохон, ялангуяа ЭТТ, Эрдэнэт, ОТ-той холбоотой ажлын хэсгүүд бүгд шинэчилж байгуулагдсан, хэлэлцээрийн шатад орсон. Ер нь бодит утгаараа зүгээр данс дээр байдаг биш, ард иргэддээ зарж, үрж, хоорондоо шилжүүлж, өвлүүлэх боломжтой ийм хувьцаа эзэмшүүлэх асуудлыг.../минут дуусав/

С.Бямбацогт: Боловсролын сайд Энх-Амгалан хариулъя. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан.

Л.Энх-Амгалан: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Соронзонболд гишүүнээ бид PISA үнэлгээнд олон улсын дэлхийн чанарын үнэлгээнд 22 онд хамрагдаад, нэлээн хуучин дүнгийн үнэлгээгээр -3 гэдэг дүн авчихсан. Одоо ингээд 25 онд PISA-н 2 дахь үнэлгээндээ хамрагдсан байна. Энэ 10, 11 сард зарлагдана. Тэгэхдээ сүүлийн 2 жил энэ боловсролын чанарын үнэлгээг хийгдээгүй орхигдчихсон юм байна лээ. Зүгээр ямар учир шалтгаантайг би сайн ойлгохгүй байгаа. Ингээд үндсэндээ нөгөө Монгол хүүхдийг мэдлэгийн хоцрогдол, ур чадварын хоцрогдлоос чөлөөлье гэдэг энэ хүрээнд бид гэрт ойрхон сургууль бол хамгийн сайн сургууль байна гэдэг бодлогоо тодорхойлж байгаа. Тэгээд хамгийн сайн сургууль гэдэг юуг хэлэх вэ гэхээр сайн хөтөлбөртэй, сайн багштай, хуурамч дүнгийн тогтолцоогүй, хүүхэд бүр төсөвтэй, хамтын удирдлагатай, цахим шилжилт хийсэн, үдийн хоолтой, үе тэнгийн.../минут дуусав/

С.Бямбацогт: Энх-Амгалан сайд гүйцээгээд хариулчихъя.

Л.Энх-Амгалан: Их Хурлын даргаа энэ УИХ-ын гишүүд чинь улсын төлөвлөгөө ярьж байгаа. Үнэхээр суурь, суурь асуултууд асууж байна шүү дээ. Тэгээд хариулт дээр нэг минутад бид яг үнэхээр хариулах ямар ч боломжгүй юм байна шүү дээ. Тэгээд энэ хариултыг 3 минутын горимд шилжүүлж өгөөч. Их Хурлын гишүүд ч гэсэн асуусан асуултдаа бүрэн хариулт авах болов уу гэж бодоод байна. Тэгээд энэ Соронзонболд гишүүний асуулт их суурь асуултууд асуугаад байна л

даа. Тэгээд бидний энэ УИХ-д өргөн танилцуулж байгаа бол Монгол Улсын хөгжлийн 27 оныхоо төлөвлөгөөг нэг танилцуулаад, ард талд нь төлөвлөгөөний үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд гээд өмнөхөөсөө нөгөө хүсэж, бүх гишүүдийн хүсээд байдаг нөгөө суурь үзүүлэлтүүд, хүрэх түвшнээ яаж тодорхойлж байгаа юм бэ, ямар бодлогын арга хэмжээнүүд авч, яг энэнд хүрэх гээд байгаа юм бэ гээд тоо бүхний ард чинь нэг том хөтөлбөр тайлбарлах хэрэг гарч ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр яагаад ч нэг минутад ямар ч супер сайд хариулж амжихгүй болов уу л гэж бодоод байна шүү дээ.

С.Бямбацогт: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Би харин Эдийн засгийн хөгжлийн сайдаас, Тэргүүн шадар сайдаас асуугаад байгаа нь энэ уул уурхай, эрчим хүчний салбараас өөр бусад салбарт 2027 онд ямар томоохон ажил хийхээр төлөвлөж байна вэ? Ялангуяа зорилго нь эдийн засгийг солонгоруулах гэдэг талаасаа гэж асуусан шүү дээ. Тэрэнд хариулаач.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя, Шадар сайд Энхбаяр, Жадамбаагийн Энхбаяр.

Ж.Энхбаяр: Эрчим хүч нэг номер. Эрчим хүчээ хангаж байж цаашаа явна. Тийм болохоор гол хүч эрчим хүчин дээр очно. Мэдээж уул уурхайн экспортоо бүрэн дэмжиж, идэвхжүүлнэ. Экспортоо идэвхжүүлэхийн тулд бид үнэтэй экспортлох ёстой. Ингэхийн тулд боловсруулах үйлдвэрүүд рүү онцгой анхаарна. Энэ дотор зэс, ган боловсруулах том ажлуудаа эхлүүлнэ. Газрын тос боловсруулах үйлдвэрийнхээ ажлыг яаралтай хурдан гүйцэтгэлийг нь шахаж гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлнэ. Аялал жуулчлалын салбар их том найдлага төрүүлж, ажлын байр олгож байгаа том салбар болж гарч ирж байгаа. Иймд аялал жуулчлалын дэд бүтцүүдийг, ялангуяа голлох 4 бүсийн 4 аймгийн нисэх буудал Ховд, Хөвсгөл, Өмнөговь, Дорнод энэ 4 аймгийн нисэх буудлыг олон улсын шууд онгоц хүлээж авдаг, Улаанбаатарт буугаад дамждаггүйгээр шууд аяллын бүсдээ ирдэг тэр бололцоог бүрдүүлэх төслүүдийг эхлүүлнэ. Энэ жил эхний гэрээнүүд хийгдсэн. Хөвсгөлд Солонгосоос шууд дунд оврын онгоцнууд бууж эхэлнэ.

С.Бямбацогт: Соронзонболд гишүүн тодруулж асууя. Маш чухал, сайхан мэдээ сонсогдож байна шүү.

Л.Соронзонболд: Төрийн албаны бүтцийг цомхон, бүтээмжтэй болгоно гэдэг дээр би нөгөө түрүүн асуусан шүү дээ. Гааль, татвар, гааль, нийгмийн даатгал, ЭМД-ын орлого цуглуулж байгаа байцаагч нар чинь нэг төрлийн ажил хийгээд байна гээд байгаа байхгүй юу. Эдгээрийг нэгтгээд, нэг ийм бүтцийн өөрчлөлт хийх боломж байна гэж би хараад байгаа юм. Тэгэхээр энэ талаар тодорхой ажил төлөвлөж байгаа юм байна уу, энэ талаар саналаа хэлээч?

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя Шадар сайд.

Ж.Энхбаяр: Төрийн албаны бүх түвшний байгууллагууд дээр үнэлгээ хийгдэж байгаа, чиг үүргийн шинжилгээ хийгдэж байгаа. Таны санал бас нэг яригдсан том асуудал. Ер нь маш олон зүйлүүд байгаа. Зарим салбарыг төрийн албанаас төрийн үйлчилгээ рүү гаргана, нийтийн алба болгож хувиргана. Мөн нэгдсэн зохион байгуулалтад оруулчихаар, нэгтгэгдчихээр, татан буулгачихаар чиг

үүрэг нь давхцаж байгаа олон байгууллагууд байна. Тэгэхээр ЗГ бүхий л түвшиндээ хэмнэлтийн бодлого зарлаад эхэлчихсэн. Энийгээ бодитой хэрэгжүүлэх үүднээс дотоод энэ зохион байгуулалт бүтцийг боловсронгуй болгох ажлуудыг сайн хийнэ. Намар гэхэд энэ шинэ өргөн барих 27 оны төсөв, энэ зохион байгуулалт дагасан хуулиуд дээр нэлээн том ахиц гарна. Хавар энэ чуулгандаа багтаад бид Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Гадаад худалдааны тухай хууль, Төр, иргэний хяналт шалгалтын тухай хууль гээд бизнес, хувийн хэвшлээ дэмжсэн, хөрөнгө оруулалтын орчныг нэмэгдүүлсэн.../минут дуусав/

С.Бямбацогт: Номтойбаяр сайд бүсчилсэн хөгжлийн асуултад, Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Асуултаа дахиж асуух уу, хэрэггүй юү? Хосбаяр гишүүн асуултаа асуучихъя нэг минут.

Г.Хосбаяр: Бүсчилсэн хөгжлийн бодлого маань хэвээрээ юү? Нөгөө сонгуулиа бид чинь бүсчилж хийсэн, тэгээд бүсийн чуулганууд хийсэн. Сүүлийн үеийн энэ хөрөнгө оруулалт, төсөв, төлөвлөгөөг харахаар бүсчилсэн бодлогын юмнууд ер нь бага харагдаад байна. Тийм учраас энэ асуудал асуулт, энэ бодлого дээр ер нь ямар байр суурьтай байгаа вэ?

С.Бямбацогт: Шадар сайд Нямтайширын Номтойбаяр хариулъя.

Н.Номтойбаяр: Бүсчилсэн хөгжлийн бодлого сонгууль угтуулж гарч ирээгүй, эртнийх, эртний түүхэн эдийн засгийнхаа бодлогыг харвал 1924 он хүртэл манайх босоо тэнхлэгтэй бүсчилсэн хөгжлийн эдийн засгийн бодлого л явдаг байсан. Мэдээж тэр үед уул уурхай гэхээсээ илүүтэй ХХАА-н суурь бодлого дээр тулгуурлаж манай газар зүйн дотоод зохион байгуулалт ч хүртэл тэгж явж байсан. Тэгээд сонгууль угтаж ердөөсөө гарч ирээгүй. Яах аргагүй бүсчилсэн хөгжлөөр бид явснаар дэд бүтцийн нэг бодлоготой, ХАА-н нэг бодлоготой, уул уурхайн нэг бодлоготой, аялал жуулчлалын нэг бодлоготой буюу нөгөө эко системийн зарчмаар л энэ эдийн засгийн платформыг бид харж байгаа. Энэ ажлыг авснаар ямар ахиц дэвшил гаргах гэж байна вэ гэж гол нь асуух гээд байх шиг байна. Тэгээд мэдээж энэ дээр бид өнөөдрийг хүртэл нэг зүйл дээр бид санаа зовниж явах хэрэгтэй байгаа юм Их.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя.

Н.Номтойбаяр: Аж үйлдвэрийн газрын зураг өнөөдрийг хүртэл нэгдсэн байдлаар Монголын төрд байхгүй яваад байгаа юм. Энийг бид бий болгож байж бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг зөв оновчтой гаргана. 2003 оны Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохион байгуулалтын хууль маань өнөөдөр үйлчлэлээ хангахаа больсон. Тэгээд ажлын хэсэг нь гарсан. Тун удахгүй үзэл баримтлал хуулиа Их Хуралд өргөн барина.

С.Бямбацогт: Нанзадын Наранбаатар гишүүн асуултаа асууя.

Н.Наранбаатар: Говийн бүсийн усан хангамжийн талаар л. Хөгжлийн төлөвлөгөөнд ийм л 2 өгүүлбэр байгаа. Усны нөөцийг хуримтлуулж, ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх Хэрлэн Тооно төслийн бэлэн байдлыг хангах гээд, бэлэн байдлыг хангах. Дараа нь усны нөөцийг хуримтлуулж, ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх Орхон-Онги экологийн төслийн Онги Цагаан бургастай усан сан, ус

дамжуулах хоолой барих төслийн бэлэн байдлыг хангах гээд 2 заалт л байгаа юм л даа. Энэ 2 том төсөл дээр төсөл дээр. Тэгээд санхүүжилт гээд ард нь ерөөсөө хоёулан дээр нь 0, 0 гээд төсвийн хөрөнгө тавиагүй. Тэгээд эх үүсвэрийг нь улсын төсөв гээд ингээд тавьсан байгаа юм. Тэгэхээр энэ 2 чухал ач холбогдолтой төсөл гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа. Өнгөрсөн 25 оны яг өдийд шүү дээ 5 сарын 6-нд Цагаан бургастай төслийн нээлтийг энэ Төрийн ордонд хийсэн. 25 оны 5 сарын 7-нд буюу ноднин яг өдийд ЗГ-ын тогтоолоор говийг усжуулах судалгааны нэгжийг байгуулсан. Ингээд ажлууд ер нь эхэлсэн, галт тэрэг хөдөлсөн гэж л ойлгоод байгаа.

Тэгэхээр өнгөрсөн яг бүтэн нэг жилийн хугацаанд ямар ажлуудыг нь төслийн нэгж маань хийчхэв? Төслийн нэгж маань ямар бүтэц, бүрэлдэхүүнтэй, төсөвтэй ингээд ажиллаж байгаа юм бэ? Тэгээд энэ талаар тодорхой мэдээлэл өгөөч. Хэрлэн Тооно төслийн ТЭЗҮ-г нь ОТ компани хийж байх ёстой, тэр дууссан уу? Ямар шатдаа дуусаагүй бол ямар шатдаа явж байгаа юм бэ, хэзээ энэ ТЭЗҮ нь дуусах юм бэ гэсэн ийм асуултад эхлээд хариулт авчихъя? Өнгөрсөн 25 оны төсөвт, 25 онд энэ жилийн төсөв батлахад Цагаан бургастай төсөл дээр 44 их юу тэрбум төгрөг нийт төсөвт өртөг нь, тэгээд тухайн онд санхүүжих нь буюу энэ онд санхүүжих нь 9 тэрбум төгрөг тавьсан юм. Энэ санхүүжилтээр ямар ажлууд энэ жил хийгдэж байгаа юм бэ, үр дүн юу байна гэсэн ийм асуулт байна? Тэгээд тодруулъя.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 18 цаг 50 минутад хуралдааныг даргалав.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Байгаль орчны яамнаас, индрийн 4 дүгээр микрофон, нэрээ хэлээд, албан тушаалаа хэлээд хариулаарай.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам ТНБД Батбаяр. Гишүүний асуултад хариулъя. Төслийн нэгж маань 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байгаа. Цалингийн нэмэгдэл болон урсгал зардлыг 50 сая төгрөгөөр нэмэгдүүлж өгсөн байгаа энэ жил өмнөх жилийнхээс, ажиллах орчин нөхцөлийг хангах чиглэлээр яамны зүгээс дэмжлэг үйлдүүлэн ажиллаж байна. Энэ жилийн хувьд ТЭЗҮ боловсруулах тендер маань зарлагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны газар дээр худалдан авах ажиллагаа явагдаж байна. Энэ 5 дугаар сардаа багтаагаад сонгон шалгаруулалтаа хийчихнэ гэж бодож байгаа. Одоогийн явцын хувьд Хэрлэн Тооно төслийн ТЭЗҮ-ийн зураг, төсөл хийх ажилд шаардлагатай 3 сая долларын санхүүжилт хийх асуудлыг ОТ компаниас эхний ээлжид шийдвэрлэж, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Монхидроконстракшн хязгаарлагдмал компанийг сонгон шалгаруулсан. Уг ажлын тайланг 1 дүгээр улиралдаа нөөцийн зөвлөлөөр оруулж тайланг нь тавих ёстой байгаа. Үүний дараа танд яг тодорхой мэдээллийг өгье.

Одоогоор яг гүйцэтгэлээ компани маань өгөөгүй байгаа. Ирэх онд 2027 онд Хэрлэн Тооно төслийн ажлын зураг төсөл, төсөв хийгч, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ажлын тайланг боловсруулах ажлыг хэрэгжүүлж, батлагдсан зураг төсөлд үндэслэн барилга, угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа. Мөн төслийн санхүү, хөрөнгө оруулалтын шийдвэрлэх болон барилга, угсралтын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хүлээж авахаар төлөвлөсөн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахаар ажиллаж байна. Эдийн засгийн хөгжлийн яамтай энэ талаар хамтран ажиллаж байгаа.

Б.Пүрэвдорж: Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Тэгээд энэ жил COP 17 цөлжилтийг бууруулах чиглэлээр талуудын оролцоотой бага хурал Монгол Улсад болох гээд байгаа. Тэгэхээр энийг л үр дүнтэй, энэ усныхаа төсөл, цөлжилтийг бууруулах чиглэлээр тэр хөв цөөрөм байгуулах барих эдгээр дээр хөрөнгө төсөв татах дээр л онцгой анхаарч ажилламаар байна. Тэгээд COP 17-гоос ер нь юу хүлээж байгаа юм бэ? Усны ийм төслүүддээ хөрөнгө төсөв татах ийм боломж байгаа юу, үгүй юү?

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон.

Ш.Батбаяр: Гишүүний асуултад тодруулж хариулъя. Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурлын бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсаас 3 үндсэн санаачилгыг боловсруулан бэлтгэл ажлыг хангаж байна. Өнөөдрийн байдлаар усны санаачилга маань төслийн хэмжээнд бүрэн бэлэн болсон байгаа, тэгээд холбогдох байгууллагуудаас саналаа аваад явж байгаа. Энэ нь өнгөрсөн 16 конвенцод усны талаар нэг ч асуудал яригдаж байгаагүй энүүгээрээ онцлогтой Монгол Улс. Тэгэхээр энэ дээр олон улсын хэмжээнд анхаарлыг их татаж байгаа. Тэгэхээр бид тодорхой хэмжээний мөнгөн санхүүжилт төсөл, хөтөлбөрөө дэмжүүлж чадна гэсэн итгэлтэй байгаа. Тэгээд энэ дээр ОУБ болон Конвенцын газрын нарийн бичгийн дарга нар маань өндөр ач холбогдол өгч байгаад бид хүлээлт өндөр байгаа.

Б.Пүрэвдорж: Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууна.

Б.Мөнхсоёл: Оройн мэнд хүргэе. Хэд хэдэн асуулт байна, бас дор нь хамраад саналуудаа хэлчихье гэж бодож байна. Өмнөх жилийн гүйцэтгэл ерөнхийдөө хангалтгүй гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа. 25 оны жишээлбэл төлөвлөгөөний хэрэгжилтийн гүйцэтгэл дунджаар 61 хувьтай байна. Тэргүүлэх чиглэлийн үр дүн 48,5 хувь, хөтөлбөрийн үр дүн 57,1 хувь биелсэн гэж байгаа юм. Хяналт шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан 326 төсөл, арга хэмжээний тал нь буюу 161 нь 85 хувиас доош гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна. 27 оны төлөвлөгөөнд энэхүү гүйцэтгэлийн сул байдлын шалтгааныг тодорхой арга хэмжээгээр засах механизм бол хангалтгүй тусгагдсан байна гэж үзэж байна. Тэгэхээр яагаад гүйцэтгэл доогуур гарсныг тус бүрд нь шалгаад, бодитой залруулга хийх арга хэмжээг 2027 оны төлөвлөгөөнд тусгах хэрэгтэй. Энэ талаар юу бодож байна гэж 1 дүгээрт асуумаар байна?

2 дугаарт 25 онд 326 төсөл, арга хэмжээнээс 107 төсөл, арга хэмжээний санхүүжилт нь улсын төсөвт тусгагдаагүй, 39 төсөл, арга хэмжээний эх үүсвэр тодорхойгүй байсан. 9,2 их наяд төгрөгийн санхүүжилтийн бодит гүйцэтгэл зөвхөн 5,4 их наяд буюу 58,8 хувьтай байсан. 27 оны төлөвлөгөөнд болохоор 15,3 их наяд төгрөгийн 310 төсөл, арга хэмжээ тусгасан нь нэлээн том дүн байна. Тэгээд бодит санхүүгийн чадавх улсын төсөвтэй уялдаа дутмаг байх эрсдэлтэй гэж харж байна. Энэ талаар асуулт асууя.

Санал гэвэл тус бүр төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг батлагдсан, баталгаажсан байдлаар нь тусгах эх үүсвэр нь тодорхойгүй гэсэн статустай төслийг хасах ийм саналтай байгаа гол санал маань. Мөн ажиллах хүчний оролцооны түвшин сүүлийн 5 жилд бараг өөрчлөгдөөгүй 54,4 хувь байна эмэгтэйчүүдийн хувьд шүү, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо.

Эрэгтэйчүүдийнх болохоор 70,8 хувьтай байгаа байхгүй юу. Тэгэхээр нийт ажилгүйдлийн түвшин буурч байгаа боловч тогтворгүй байгааг хэрхэн шийдэх ийм төлөвлөгөө энэ онд, ирэх онд тусаж байгаа вэ? 24 онтой харьцуулахад ажилгүйдэл буурч байгаа юм шиг боловч 23 оноосоо өсчихсөн ийм дүнтэй харагдаж байгаа шүү.

ЭМД-ын сан, Эрүүл мэндийн сайд байна уу? Сангийн талаар асуулт байгаа юм. Бид бүгдээрээ мэдэж байгаа 24 онд төр хариуцах даатгалын сангийн орлогын 16,8 хувийг бүрдүүлж байгаа мөртөө зардлын 41,9 хувийг хэрэгжүүлж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувьд л эрүүл мэнд зарцуулагдаж байгаа. Харин Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/-ын зөвлөгөө нь болохоор энэ зарцуулалтыг ДНБ-ий 5 хувьд хүргэвэл их үр өгөөжтэй гэсэн ийм дүгнэлт санал байна. Тэгэхээр энэ талаар Эрүүл мэндийн сайдаас асуулт асуумаар байна. Эрүүл мэндийн сан, даатгалын сангийн санхүүжилтийг бодлогын эрс шийдлээр өөрчлөх реформ хийх хэрэгтэй гэж үзэж байгаа. Их Хурал дээр ажлын хэсэг гарч байсан. Энэ байдлын талаар асуулт асууя, юу болж байна вэ?

Засаглал, авлигатай холбоотой асуултуудыг өмнөх гишүүд нэлээд асуучихсан учраас энийг алгасъя. Статистик мэдээлэл нэлээн хоцрогдолтой гарч байна. Тэгэхээр бүгдээрээ нөгөө өмнөх төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнг дүгнэхэд жоохон хэцүү, цаг хугацааны хувьд хоцрогдолтой байгаад байна. Тэгэхээр бодлогын зорилтот үзүүлбэрийг жил бүр хэмжих боломжтой, шуурхай статистик тогтолцоог бий болгох арга хэмжээ авах шаардлагатай байна гэсэн ийм саналыг оруулмаар байна. Асуулт биш.

Б.Пүрэвдорж: Шадар сайд Энхбаяр хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ олон гишүүн дээр энэ гүйцэтгэл дутуу гарсан тухай ярилаа. Тэгээд бид өнгөрсөн хугацаанд юу хийсэн бэ гэдгээ нэг эргээд санавал тодотголууд хийчихсэн. Тодотголтой холбоотойгоор бид төсөв, хөрөнгө оруулалтыг нь л хасаад нааш нь, цааш нь болгоод байсан болохоос биш, энэ төлөвлөгөөгөө ерөөсөө тодотгоогүй орхиод яваад байсан. Энэнтэй холбоотой төлөвлөгөөний хэрэгжилт чинь тэгж унаж гараад байгаа юм 1 дүгээр том суурь шалтгаан.

2 дугаарт Байнгын хороон дээр гишүүд янз бүрийн санал гардаг. ТЭЗҮ-гүй, үр ашгийн тооцоололгүй, судалгаагүй баахан төслүүд нэмсэн. Энэ болгон чинь хэрэгжээгүй, хасагдсан. Ер нь хууль нэлээн чангарчихсан, цаашдаа энэ бодлого, төлөвлөлт дандаа ТЭЗҮ-тэй, хэрэгжигдэхүйц, энэ хэмжигдэх нь гол нь, шалгуур үзүүлэлт хангаж байгаа ийм төсөл, хөтөлбөрүүд л явна. 5 жилийн хөтөлбөрөөр нэлээн чангатгаад бид хөтөлбөрүүдээ баталчихсан, энэ хүрээндээ л ажиллана. Одоо нэмж ямар нэгэн уран сайхан хийх бололцоо байхгүй болчихоод байгаа. Энэ маань өөрөө сая энэ бодлогыг ийм дутуу гүйцэтгэлтэй, уялдаа муутай харуулаад байгаа зүйл энэ шүү. Энэ болгон ингээд засагдаад, эрх зүйн орчин чангараад, ингээд яваад байна.

Ажиллах хүчний асуудал дээр. Нийт хүн ам маань 3,5 сая хүн ам байгаа. Үүнээс ажиллах хүчний оролцоо манайд нийт хүн амын 66 буюу 2,4 сая хүнийг хөдөлмөрийн насных гэж үзэж байгаа. Хөдөлмөрийн насны 100 хүн тутмын 59 нь ажил хийж байна, 3 нь ажил хайж байна, 38 нь ажил хийх боломжгүй, боломж, сонирхолгүй буюу ахмад настнууд, тэгээд төрөл бүрийн оюутан, гадаадад оршин сууж байгаа олон үзүүлэлтүүд байна. Тэгээд манайх хөдөлмөрийн ажиллах хүчний оролцоо энэ 63 хувь руу хүрээд байгаа нь энэ бас их муу үзүүлэлт биш шүү. Ер нь

байгаа хүн, бид хүнийхээ ажиллах хүчээ бүхий л салбарт үндсэндээ дайчлаад дуусаж байна. Бүхий л салбарт мэргэжилтэй, мэргэшсэн ажиллах хүчний дутагдалд орж эхэлж байна. Иймд бид гадаад ажиллах хүчний асуудлыг хөндөх цаг болсон. Нэгэнт дотоодоосоо бид хангах бололцоо хязгаарлагдмал байна. Эдийн засаг маань тэлээд байна шүү дээ. 2001 онд 1 тэрбум долларын эдийн засаг чинь өндөр 25 тэрбум долларын эдийн засаг болчихоод байна. Энэ хэмжээнд хүн ам чинь өсөж чадаагүй, хүн, ажиллах хүчний хүрэлцээ бүхий л салбарыг хамарсан ийм асуудал үүсэж байна.

Тэгэхээр энд бид энэ зорилтын хүрээнд бид 40 гаруй мянган ажлын байраар нэмэгдүүлэхэд л ажиллах хүчний оролцоо 65 хувь хүрээд, дэлхийн дундаж руу гараад л ирэх юм. Тэгэхээр бид байгаа нөөцийг сайн дайчилж байгаа. Монголд ажилгүйдэл тун бага байгаа шүү. Сайн дурын залхуурал харин нэлээн өндөр байгаа. Ажил хийх хүсэл, дур сонирхолгүй улсуудын хандлага нэлээн байгаа ийм тооцоо гардаг.

Б.Пүрэвдорж: Нэмж Мөнхсоёл гишүүн тодруулъя.

Б.Мөнхсоёл: Батшугар сайд байгаа юм байна. Би Энхбаяр сайд дээр тодруулаад хэлэхэд статистик тоо хэрэггүй шүү дээ. Би өөрөө хэлчхээд байхад, өөдөөс өөр статистик тоо хэлээд байна 1 дүгээрт.

2 дугаарт нь болохоор зөрчилтэй хариулчихлаа өөрөө. Ажиллах хүчин ханачихсан, хөдөлмөрийн зах зээл ханачихсан, гаднаас авч байна гээд байдаг. Гэтэл цаанаа ажилгүй байгаа, ядуурал, ажилгүйдэл энэ тэр нэмэгдээд байгаа юм биш үү? Тэгэхээр хоорондоо уялдаа холбоогүй, шал авцалдаагүй тоонууд гэсэн үг үү? Эдийн засгийн утга нь хааччихав гэж асуумаар байна? Хөдөлмөрийн зах зээл дээр реформ энэ тэр хэрэггүй юм уу гэдэг ямар арга хэмжээ авах вэ гэж асуусан, хариултаа эргээд сонсвол нэлээн зөрчилтэй юм ярьчихлаа шүү. Батшугар сайдын хариултыг сонсьё.

Б.Пүрэвдорж: Батшугар сайд хариулъя.

Э.Батшугар: Баярлалаа. ЭМД-ын санг тодорхой хэмжээнд шинэчлэх нь зөв. Гэхдээ Монгол Улсын тогтолцоо нь өөрөө нэг худалдан авагчид DRG тогтолцоо бол маш сайн сайндаа дэлхийд ордог юм билээ. Хамгийн гол нь 2 зүйл хэлмээр байна. Зарцуулалт нь бүрэн оновчтой болж чадахгүй байна. 2-т нь яг шимтгэлийн орлого нь дөнгөж 20 хувь байгаа шүү ЭМД-ын сангийн, бусад нь улсын төсвөөс орж байгаа. Улсын төсөв гэхээр төрөөс даах ёстой эмийн жагсаалтаас авхуулаад л, эмнэлгүүдийн санхүүжилт.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж Энхбаяр гишүүн, Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Ажиллах хүчний оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн асуудал байгаа юм. Үнэхээр нийтлэгээрээ ажиллах хүч дутаж байгаа. Мөн яг зорилтот ийм өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх энэ хөтөлбөрүүд хангалттай хэрэгжиж байгаа. Энэ хүрээнд яг зорилтот бүлэг, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон энэ залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих энэ арга хэмжээнүүд ингээд энэ төлөвлөгөөнд суусан. 27 онд санхүүгийн дэмжлэг жижиг зээл олгох арга хэмжээ гэхэд 5903 иргэн, ААН-ийг хамруулахаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 73 тэрбум төгрөгийг зарцуулахаар суусан байгаа. 21 аймаг, 9

дүүрэгт хэрэгжих энэ бизнес үйл ажиллагааны гарааны болон хөгжлийн шатны санхүүгийн дэмжлэг, жижиг зээл олгохоор ингэж тооцоологдсон ийм арга хэмжээнүүд явж байна. Яг үнэндээ ажиллах хүчний оролцоо өндөр болж байгаа, сайн дайчилж байгаа, бүх салбарт хүн дутаж байгаа. ХАА, хөнгөн үйлдвэрлэл, уул уурхай, ер нь газар тариалан, энэ боловсруулах салбарт ажиллах хүч, үйлчилгээний салбарт хүн дутаад байна.

Б.Пүрэвдорж: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Чуулганы завсарлагаагаар нэлээн тойрогт ажиллаад байгаа. Тэгээд тойргоос ирсэн иргэдийн асуултыг ерөнхийдөө энд асуух нь зөв байх гэж бодож байна. 18 сум, тосгоны төрийн албан хаагч, сонирхлын бүлэг гээд 27 удаагийн уулзалтаар 140 орчим багц саналыг үндсэндээ авсан. Тэгээд яах вэ багцлаад дараах асуултуудыг сайдуудаас асууя.

Саяын үндсэндээ тойролтын хамгийн гол сэдэв энэ багш, эмч нарын цалинтай холбогдолтой асуудал байсан. Энх-Амгалан сайд ажлаа аваад, тодорхой шийдлүүд гаргасан гэж байгаа юм. Тэгэхээр байхгүй байсан асуудлыг хаанаас, ямар эх үүсвэр гаргаж ирж шийдэх боломжийг бий болгов гэдэг дээр тодорхой мэдээлэл өгөх нь зөв байх. Мөн улсын төсвийн тодотгол хэрвээ орж ирэхгүй бол энэ асуудлыг ингээд шийдсэн байдал нь хэвээр үргэлжлэх үү гэдгийг нарийвчлаад асууя? 2027 онд нөгөө нөхцөл байдал ямар байх вэ гэдгийг танаас тодруулж асууя?

Ахмадын тэтгэвэртэй холбогдолтой асуудал иргэдийн уулзалтын хамгийн гол асуудал байдаг. Гэхдээ нэмэгдүүлэх гэхээсээ гадна тооцоолол итгэлцүүр гээд олон суурь асуудлууд байгаа. Үүнтэй холбоотой 2027 онд ямар асуудлуудыг шийдэх вэ гэдгийг Аубакир сайдаас асууя?

Нийгмийн шударга ёсны төлөө хүсэмжлэл, үүнтэй холбогдолтой иргэдийн маш их бухимдлууд уулзалт дээр гардаг. Хэд хэдэн хуулиудын тухай онцолж үндсэндээ асуугаад байгаа юм. Шүгэл үлээгчдийн эрх зүйн байдлын тухай хууль, мөн дээрээс нь тэр хөрөнгө хураахтай холбогдолтой хууль бас энэ 2027 он, ирэх намар орж ирэх үү, энэ чиглэлийн төсөв төлөвлөгөө байна уу гэдгийг Амарсайхан сайдаас асууя?

Стратегийн орд газруудтай холбогдолтой, баялгийн хуваарилалттай холбогдолтой бүлэг саналуудыг үндсэндээ илэрхийлж байгаа, хэлээд байгаа юм. Тэгэхээр 2027 онд стратегийн энэ орд газруудыг ашиглахтай холбогдолтой, баялгийн хуваарилалтыг явуулахтай холбогдолтой ямар асуудлууд байна вэ гэдгийг Дамдинням сайдаас асууя?

Номин сайдаас явж, явж үүрэн телефоны асуудал багийн түвшинд, сумын түвшинд хамгийн чухал асуудал болж байна. Орчин үед бид цахим Монгол болно гээд ингээд зориод явж байгаа. Гэтэл Монголын олон багууд сүлжээнд холбогдож чадахгүй, үйлчилгээгээ авч чадахгүй байдалтай байна. Миний уулзсан уулзалтаас 20 багийн санал гарсан байгаа. Ингээд цаашаа нэмээд гаргавал зөндөө ийм багууд байна. Энийг ер нь цогцоор нь шийдэх, сууриар нь шийдэх төлөвлөгөө байна уу, 2027 онд хэчнээн багийг нэмж үүрэн телефоны сүлжээнд холбох вэ?

Эрүүл мэндийн салбар, анхан шатны эмнэлгүүдтэй холбогдолтой олон асуудал байна Батшугар сайдаа. 9 хувийн цомхотгол нүдээ ололгүйгээр,

судалгаагүйгээр халсан тухай олон гомдлууд ирсэн. Энэ асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж байгаа вэ? 2027 онд анхан шатны эрүүл мэндийн энэ байгууллагуудаа дэмжих, тэр хуучин байсан бүх ажлуудыг нь төв рүүгээ татчихсан тэгээд, сарын тал хагаст нь ажиллаад, тал хагаст нь квот байхгүй гээд үндсэндээ сууж байгаа.

Дээрээс нь ХАА-н чиглэлийн асуултууд байгаа, манай сайд байна уу? Арьс шир, түүхий эдүүд үнэгүйдэж байгаатай холбогдолтой асуудлууд.

Номтойбаяр сайдын маань хувьд тэр зүүн бүс дээр аялал жуулчлалын бүс болон нэлээн олон боомтууд байгаа. Тэгэхээр энэ боомтуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ялангуяа Ульхан боомтыг энэ Евразийн хэлэлцээртэй холбогдолтой сайжруулах энэ саналууд Хэнтий, Дорнодын энэ хойд талын сумдаас хамгийн их гарч ирж байгаа. Зам тавигдаж байгаа, дэд бүтэц хийгдэх гэж байгаа. Үүнтэй холбогдолтой 2027 онд хийгдэх гол ажлууд байна уу?

Бат-Амгалан сайд дээр орон нутагт тэр түрээсийн орон сууц, төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны асуудал маш их хөндөгдөж байна. Тэгээд энийг та нэг тодруулж, 27 онд юу тусгав гэдгийг хэлж өгөөч?

Б.Пүрэвдорж: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Манай ЗГ байгуулагдаад нэг сар 3, 4 хонож байна. Ерөнхий сайдын хамгийн түрүүн барьж авч суусан ажил энэ боловсрол, эрүүл мэндийн салбарт үүссэн байсан энэ 2 цалингийн тогтолцоо үүсчихсэн, шинэ цалин, хуучин цалин гээд нэг ойлголт гараад ирчихсэн. Тэгээд нэмэгдлүүдээ хуучин цалингаас нь нэмэгдлүүдийг нь олгодог болж, нөгөө УИХ дээр бид 618 тэрбум төгрөг батлуулсан шүү дээ. Энэ маш их том мөнгө. Тэгээд энэ 618 төгрөгөөр багш нарынхаа цалинг 50 хувь нэмэх уг нь ийм үүрэг хүлээсэн байснаа Үйлдвэрчний эвлэлтэй хийсэн гэрээн дээр би нэлээн тийм алдаа дутагдал гарсан юм байна л гэж харж байгаа. Манай яам би өмнөх сайдыгаа би буруутгахыг хүсэхгүй байна, манай яамны ТНБД энэ 3 талт хэлэлцээрийг ахалсан юм байна лээ. Тэгээд энэ дээр аль, аль нь хариуцлагагүй хандаж ийм ойлгомжгүй нөхцөл байдал үүсгэсэн. Хөдөлмөрийн хуулийн заалтууд зөрчигдсэн. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 2 ЗГ-ын тогтоолыг зөрччихсэн ийм асуудлууд гарсан. Тэгээд би энэ нөхөрт бол хариуцлага тооцсон.

Ингээд үндсэндээ 5 сарын 1-нээс нэг цалингийн тогтолцоотой болж байгаа. 2 цалингийн тогтолцоотой болсноор нийгмийн даатгалын санд 70 орчим тэрбум төгрөгийн өр үүссэн байна. Өнөөдөр гэхэд 33 мянган багш, ажилтнууд нөгөө цэцэрлэг, сургууль нь НДШ-ээ төлж чадаагүй учраас үүсэж, 1600 орчим багш нар маань жирэмсний амралтынхаа даатгалыг авч чадахгүй, эмнэлэгт хэвтсэн эмч нар маань, эмнэлэгт хэвтсэн багш нар маань листийн мөнгөө авч чадахгүй, тэгээд гадагшаа явах гэж байгаа виз мэдүүлэх гэж байгаа багш нар маань визээ мэдүүлж чадахгүй, арилжааны банкнаас цалингийн зээл авах гэж байгаа багш нар маань, боловсролын салбарын ажилтнууд маань ингээд цалингийн зээлээ авч чадахгүй. Хамгийн харамсалтай нь энэ жил тэтгэвэрт гарах гэж байгаа багш нар маань аль цалингаасаа тэтгэврээ тогтоолгох вэ гэдэг нь ойлгомжгүй ийм нөхцөл байдлууд үүсчихсэн байсан.

Ингээд энэ нөхцөл байдлууд дээр бид шийдвэр гаргаж, энэ 5 сарын 1-нээс нэг цалингийн тогтолцоотой болсон. Эхний цалин бол мөнгө буусан. Гэхдээ ихэнх

нэмэгдлүүд нөгөө бөгс мөнгө гэж ярьдаг энэ дээр нэмэгдлээ тооцдог учраас 5 сарын 20 хэднээр энэ бүх нэмэгдлүүд нь нэмэгдсэн цалингаасаа нэмэгдээд явах ийм асуудлыг бид шийдэж байгаа. Мэдээж эх үүсвэрийн хувьд хүндрэл байгаа. Гэлээ гэхдээ төсөв дотроо зохицуулалт хийж энэ жилийн хөрөнгө оруулалтуудаас тодорхой гүйцэтгэл муутай байгаа хөрөнгө оруулалтуудаас 100 орчим тэрбум төгрөг хэмнэгдэж байна. Сургуулийн хоол, цэцэрлэгийн хоолноос, цэцэрлэгийн хоолны хүүхдийн мөнгийг эцэг эхчүүдтэй нь мянган төгрөг хуваалцаж эхэлснээс хойш гучаад тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан, тодорхой хяналт бий болж байна гэсэн үг. Гэх мэтчилнээр л тодорхой зардлууд дээрээ төсвийн тодотгол хүртэл энэ зохицуулалтуудыг хийгээд явахаас ийм өөр сонголтгүй л болж байна.

Б.Пүрэвдорж: Эхлээд Номин сайд хариулъя.

Ч.Номин: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 21 аймаг, 330 суманд 1600 гаруй баг байгаа. Энэ багаас бид яг төсөвт суугаагүй үлдэж байгаа нь нийтдээ 104 баг л өнөөдрийн байдлаар ямар нэгэн байдлаар сүлжээнд холбогдоогүй үлдэж байгаа. Үүнээс гадна бид яг 2026 оны хөрөнгө оруулалтаар 75 багт сүлжээ оруулна. Энэ 75 баг орсны дараа 104 баг үлдэнэ. Зүүн бүсэд яах вэ яг өнөөдрийн байдлаар ойролцоогоор 21 баг үлдэх юм байна лээ. Тэгэхээр бид энийг цааш нь анхаараад явна. Ер нь бид 2028 он гэхэд бүрэн засаг захиргааны нэгжүүдээ буюу багуудаа бүгдийг нь сүлжээнд хамруулна гэж үзэж байгаа. Сүлжээг хамруулахдаа бид дан ганц улсын төсвөөр хийдэггүй, бидэнд бас үүргийн сан гэж байдаг. Үүнээс гадна бид Дэлхийн банк болон бусад хөгжлийн.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Батшугар сайд хариулъя.

Э.Батшугар: Баярлалаа. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагууд бол хамгийн том чухал үүрэгтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг тогтолцоо байгаад байгаа юм. Үүнд тодорхой хэмжээний дэмжлэг олгож байгаа юм. Нэг ёсны нэг хүнд оногдох норматив зардлыг нь 30 хувиар нэмчихсэн байгаа. Цаашлаад та бүхэн мэдэж байгаа байх 5 сарын 1-нээс эхлээд нэг цалинтай болгосон эмч нарыг, сувилагч нарыг, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг. Мөн насны бүлгээр нь зардлыг нь нэмсэн. Нэг ёсондоо 30-аас 60 насны эрэгтэй хүн бол эмэгтэй хүнтэй харьцуулахад 4 дахин нас барах магадлал өндөртэй байхаар нь тэр насны бүлгийн эрэгтэйчүүдийг үзэж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлбэл 111 хувиар тариф нэмсэн. Ингэснээр манай анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд аль болох иргэндээ ойрхон, хүртээмжтэй хүрч, иргэд илүү чанартай эрүүл мэндийн үйлчилгээ авах тийм боломжийг нь нээж өгч байгаа. Яг олон улсын жишгээр явж байгаа шүү.

Б.Пүрэвдорж: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. 2027 оны улсын төсвийн төсөлд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас саналаа өгч байгаа. Энэ дээр би 2 зүйлийг баталгаатай, итгэлтэй хэлж болохоор байгаа. 1 дүгээрт бид итгэлцүүрээ шинэчлэх шаардлагатай байгаа. Ганхүлэг гишүүнээ итгэлцүүрээ шинэчлэхэд 353,3 тэрбум төгрөг шаардлагатай. Нөгөө талдаа бид 2024 онд баталсан хуулийн хүрээнд энэ жилийн инфляцын гүйцэтгэлтэй уялдуулж 2027 оны тэтгэврийг инфляцтай нь уялдуулж нэмнэ гэсэн 2 саналыг улсын төсвийн төсөлд

өгөхөөр ажиллаж байна. Бид хүрээнд тооцооллоо өгсөн байгаа. Тэтгэвэр нэмэгдэнэ гэсэн үг.

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Стратегийн орд газруудыг эргэлтэд оруулах тухай асуудал ингээд хэлэлцээр хийнэ гэдэг байдалтайгаар ингээд хүлээгдээд байгаа юм. Тэгээд ер нь энэ 2007 оны 27 дугаар тогтоолоор 1 дүгээр хавсралтад үндсэн 16 орд, 15 орд ороод, 2015 онд 1 нэмэгдээд, нийтдээ одоо 16 орд байгаа. 2 дугаар хавсралтад нь 39 орд, нийтдээ 55 орд. Орд газар болгоныг Их Хурал дээр яриад явна гэвэл энэ Монголын парламент үндсэндээ 55 жил ярина гэсэн үг. Тэгэхлээр ер нь Ерөнхий сайдын зүгээс болон ЗГ-ын зүгээс бүгдэд нь тэгш хандах нэг удаагийн хууль бэлдэж байна үндсэндээ. Өөрөөр хэлбэл энэ орд газруудын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоогоод, 2 дугаарт АМНАТ-өөр орлуулдаг нөгөө Ораногийн загвараар хийхээр ийм нэг удаагийн хууль ирэх долоо хоногийн ЗГ-ын хуралдаанаар оруулж ирж, Их уралд өргөн барья гээд бэлдээд явж байна.

Б.Пүрэвдорж: Сандаг-Очир сайд хариулъя. Уучлаарай, Идэрбат сайд, уучлаарай.

Ц.Идэрбат: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Монгол Улс ер нь жилдээ 20-оод сая арьс хэрэглээнд гаргаад, түүнийхээ 7, 8 саяыг нь боловсруулаад, 12 сая арьсаа ер нь хаяад арваад жил болж байгаа. Тийм учраас энэ арьс ширийг, түүхий эдийг эргэлтэд оруулах талаар онцгой анхаарч байгаа. 2 арга зам байна. 1 дүгээрт Эмээлтийн боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулахад өнгөрсөн ЗГ-ын хуралдаанаас оруулж, тодорхой шийдвэр гаргуулсан. Баруун бүсэд Ховд аймагт маш сайн аж үйлдвэрийн парк баригдаж дуусаж байгаа. Энэ их сайн зүйл. Нөгөө талдаа түүхий эдийн зах зээл бол чанартай түүхий эдээр, чанартай бүтээгдэхүүн гэдэг ийм дэлхийн зах зээлийн хандлага нь ноёлчихсон юм байна. Тийм учраас бид түүхий эдийг анхан шатанд нь боловсруулах ажлыг Монгол Улсын 10 суманд энэ 7 сарын 1-нээс туршиж, түүхий эдийг хаяхгүй байх, тэр мал эмнэлгийн үйлчилгээ, дээрээс нь механик гэмтэлгүй байх.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Буланы Бейсен гишүүн асуулт асууна.

Б.Бейсен: Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөтэй танилцлаа. ХАА-н салбарт энэ газар тариалангийн асуудал байгаа. Бид энэ гаднаас малын тэжээл ч их авч байна. Тийм учраас Увсын Баруунтурууны гурил тэжээлийн үйлдвэр, Баян-Өлгий Ногоон нуур сумын Ачит нуурт түшиглэсэн тэжээлийн аж ахуй, Ховдын Эрдэнэбүрэнгийн усалгаатай газар тариалангийн сэргээх тал дээр энэ юундаа тусгаагүй байх юм. Энийг ХАА-н сайдаа ирэх жил өвөл хэцүү болбол тэгээд яах вэ 1 дүгээрт?

2 дугаарт энэ хүлэмжийн аж ахуйн талаар Ерөнхийлөгчийн хүнсний хувьсгалын хүрээнд дотооддоо хүнсний ногоогоор хангах боломж байна. Энэ талаар тодорхой хэмжээний төлөвлөгөө байна уу?

Дараагийн асуудал Цагааннуурын чөлөөт бүсийн асуудал байна. Баруун 5 аймагт тээвэр логистикийн хувьд ч гэсэн, худалдааны хувьд ч гэсэн хамгийн чухал юу байгаа, энэ талаар бас тусгаагүй зүгээр орхигдсон байх юм. Уг нь зураг төсөв нь гарсан гээд тэгж байсан. Сая Ерөнхийлөгч очихдоо Өлгий-Кимовск, Каменск-н шууд

нислэгийн асуудлыг ярьсан. Энэ онгоцны буудлын асуудал хуучин төлөвлөгөөнд онгоцны буудлын төсөв тавигдаад, тендерийн асуудалтай холбоотой хойшлогдсон, энд тусгаагүй байх юм.

3 дахь асуудал эрүүл мэндийн салбартай холбоотой асуудал байна. Эрүүл мэндийн салбарын хөгжлийн асуудлыг ярихад өр зээлийг шийдэхгүйгээр энэ асуудал шийдэгдэхгүй ерөөсөө. Би түрүүн бас хэлсэн. Та ажлаа авангуут энэ өр зээлээ ил болго, он дамжсан өглөг, авлагаа ил болгохгүй бол зарим нь 17 тэрбумын өглөг, авлага, 20-иод тэрбумын өглөг, авлага чинь юу гэсэн үг вэ энэ чинь. Бүсийн оношилгооны төв гэхгүйгээр аймаг болгонд нэгдсэн эмнэлгийн барилга нь бэлэн байж байгаа. Энэ дээр тоног төхөөрөмж тавьчихвал оношилгооны төвийг чадавхжуулаад, боловсон хүчнээ сургачихвал энэ болох асуудал байгаа. Хотын ачаалал багасна. Оношилгооны төв гэхээр шинээр барилга барих юм шиг ойлгодог, энэ талаар тоног төхөөрөмж тавих талаар ямар төлөвлөгөө барьж байна вэ?

Энэ 25, энэ дээр ингэж тусгасан байх юм. Нярайн эрт илрүүлэгд хамрагдах талаар ингээд энэ хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан байна. Нярайн асуудлыг эх нярайн асуудлыг аймгийн төрөх тасгийн нярайн эмч нар, өрхийн эмч нар шийдэж байгаа асуудлыг ингэж тавиад ямар хэрэг байна. Хөрөнгө зарж байгаа юм шиг. Нийт хүүхдийн 53,7 хувь нь л хамрагдсан гээд байх юм. Тэгсэн мөртөө нярайн эндэгдэл 6,7 хувиар өсчихдөг, 5 хүртэлх хүүхдийн эндэгдэл 4,2 хувиар өссөн байх юм, эхийн эндэгдэл 17 тохиолдол бүртгэгдсэн байна. Мянган амьд төрөлтөд 31,4 хувь байна. Өмнөх онтой харьцуулахад 4 тохиолдлоор өссөн байна. Мянган амьд төрөлтөд 8,9 хувиар нэмэгдсэн байна. Эхийн эндэгдлийн 70,6 хувь нь эмнэлэгт, 29,4 хувь нь гэртээ юм байна. Энэний шалтгаан нь юу вэ? Улсын хэмжээнд хоёр, нялхсын эндэгдлийн 738 тохиолдол бүртгэгдсэн байна. Амьд төрөлтөд 13,6 хувь, өмнөх оноос 1,4 хувиар өссөн байна. Нялхсын эндэгдэл 62,3 хувь болсон байна. Энийг тодруулъя? Дараа нь тодруулъя.

Б.Пүрэвдорж: Эхний асуултад хэн хариулах вэ? Идэрбат сайд хариулъя.

Ц.Идэрбат: Бейсен гишүүний асуултад хариулъя. Зуд болоход яах вэ гээд, зуд болоход бэлтгэлтэй байхгүй бол ямар айхтар юм болдгийг бид өнгөрсөн 23, 20 оны зудаар харсан. Тийм учраас энэ 100 1000 гэдэг энэ хөтөлбөрийг МАА-н салбарын ирээдүйн зудын олон хүндрэлүүдээс, үүсээд байгаа энэ олон асуудлуудыг цогцоор нь авч шийдэхийн тулд дэвшүүлэн тавьж байгаа. Удахгүй энэ 5 сарын 20-нд баруун бүсийн МАА-н салбарынхантай уулзаж, энэ концепцоо танилцуулна.

Хүнсний ногоон дээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар эхлүүлсэн Хүнсний хувьсгал маш их үр дүн гаргасан. Мөн ЗГ-ын зүгээс ч гэсэн маш том ач холбогдол өгч, тодорхой шийдвэрүүдийг гаргаж ажиллаж байгаа. Хамгийн сүүлийн шийдвэр бол энэ ногооны, хүнсний ногооны хангалтыг, ургалтыг сайжруулахын тулд 15 тэрбумын хөрөнгө оруулалтын болон эргэлтийн зээлүүдийг олгож эхэлсэн. Ер нь газар тариалангийн салбарт ирээдүйд гарах хүндрэл бол зөвхөн энэ гангийн асуудлууд, энэ байгалийн эрс тэс, энэ байгаль орчны энэ нөлөөллүүд их өндөр байгаа. Тэгэхээр бид цаашдаа усалгаатай газар тариалан гэдэг ийм зүйл рүүгээ явахгүй бол болохгүй гэж ингэж үзэж байгаа.

Хүнсний хувьсгалыг 2022-оос 2026 он гээд энэ оноор дуусаж байгаа. Манай яамны зүгээс цаашид энэ хүнсний хувьсгалыг үргэлжлүүлэх шаардлага байна гэж

харж байгаа. Тийм учраас удахгүй хүнсний хувьсгалын дараагийн үе шатыг боловсруулж дуусаж байгаа, удахгүй танилцуулна гэж товч хариулъя.

Хүлэмжийн аж ахуйн асуудал байна. Хүлэмжийг зуны болон өвлийн гэж ангилж байгаа. Ер нь цаашдаа өвлийн хүлэмжийг бид хөгжүүлэх нь зайлшгүй шаардлага байна. Өвлийн хүлэмжийг хөгжүүлэхэд дэд бүтцийн асуудлууд, ялангуяа эрчим хүчний хангалтын асуудлууд туйлын чухал байгаа. Тийм учраас ЗГ-аас өвлийн хүлэмжид зориулсан эрчим хүчний зарцуулалт дээр тодорхой хөнгөлөлтүүдийг үзүүлснээр жилд 400-гаад сая төгрөгийн хөнгөлөлтийг энэ хүлэмжийн аж ахуйд зориулж гаргах ийм бололцоо бүрдсэн байгаа. Нөгөө талдаа байгаль, цаг уурын бүсчлэлийг бид их зөв ашиглах ёстой юм байна. Ялангуяа говь чиглэл рүүгээ энэ хүлэмж хийх асуудал бол цаг хугацааны хувьд Улаанбаатар орчмоос бараг 2 сараар илүү байх ийм бололцоо байгаа гэж ингэж харж байгаа. Бид хөнгөлөлттэй үнээр, урт хугацаатай зээлээр хүлэмж олгоно. Энэ хүлэмжийг энэ газрын, хүлэмжийн хүнсний ногооны салбарт ажиллаад сурчихсан, борлуулах механизмаа бий болгочихсон ийм хүмүүст түлхүү олгоно гэсэн ийм чигтэй явж байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Цагааннуурын чөлөөт бүсийн талаар Номтойбаяр сайдаа асуусан. Цагааннуурын чөлөөт бүсийн талаар. Цагааннуурын чөлөөт бүс 2005 онд байгуулагдсан байна. Үүнээс хойш тэр их том хашаа татаад, өчнөөн олон хөрөнгө оруулалтууд, төсвийн хөрөнгө оруулалтууд тийшээ хийгдсэн. Гэвч өнөөдөр тэнд нэг ширхэг ч ААН үйлдвэр бариагүй байна. Нэг ширхэг ч ААН худалдааны нэг ТҮЦ ч барьсангүй. Тэгээд ингээд 21 жилийн туршид Ардчилсан нам, Ардын нам гээд өчнөөн олон ухаантай мэргэн хүмүүс, бизнес сэтгэлгээтэй өчнөөн олон хүмүүс сайд дарга нар хийсэн байх. Тэгээд ерөөсөө ажил явдаггүй ийм газруудыг татан буулгах ёстой биз дээ ер нь бол. Та энэ талаар ямар байр суурьтай байна вэ? Ер нь жилдээ Цагааннуурын чөлөөт бүсэд хэдэн төгрөгийн зардал гардаг юм, тэгээд тэнд байгаа хүмүүс яагаад тэр Цагааннуурынхаа чөлөөт бүсийг илүү идэвхтэй болгох талаар ажилладаггүй юм бэ, цалин аваад суугаад байдаг юм бэ гэдэг дээр нэг хариулт өгнө үү?

Н.Номтойбаяр: Цагааннуурын чөлөөт бүс дээр газар дээр нь очиж танилцаж хараахан амжаагүй байна. Өнгөрсөн хугацаанд Замын-Үүд, Алтанбулаг, Хөшигийн хөндий дээр очиж танилцлаа. Ер нь чөлөөт бүс дээр бид өнгөрсөн хугацаанд юу нь болохгүй болоод энд анх төлөвлөсөн шигээ үйлдвэрлэл, худалдаа хөгжиж чадаагүй юм бэ гэдэг дээр дүн шинжилгээ хийсэн. Тэгээд таны хэлж байгаа зөв, зөв, би санал нэг байна. Газар дээр нь очоод танилцсан, асар их бухимдалтай л эргэж ирсэн. Тэгээд тун удахгүй Чөлөөт бүсийн тухай хуулийг өргөн барина. Хамгийн гол нь ерөөсөө л таны хэлээд байгаа нь үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын асуудал байгаа юм л даа. Тэгээд тэрийг нь нээх талаар нэг цогц хуулиа өргөн барихдаа танилцуулга хийе. Газар дээр нь очиж үзнэ, тулна.

Б.Пүрэвдорж: Та яг нэг жилийн дотор Цагааннуурын чөлөөт бүсэд хэдэн төгрөгийн зардал гардгийг нь энэний дараагийн асуулт дээр хариулчхаарай, мэдээлэл аваад. Буланы Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Эрүүл мэндийн салбарын хариултыг авъя. Тэгээд Цагааннуурын чөлөөт бүс дээр ийм асуудал байгаа. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АЙЛ ӨРХИЙН ТҮВШИНД ЧӨЛӨӨТ БҮС АЖИЛЛАЖ БАЙГАА. Энэ удирдлага, зохион байгуулалттай холбоотой асуудал байхгүй юу. Хотод байхгүй хүнсний жимс, ногоо, барилгын материал

бүгдийг нь зарж байгаа. Энэ дээр Номтойбаяр сайд анхаарахгүй бол 30-аад хүн 21 жил цалин авч байна шүү дээ хоосон хашаанд, ямар ч юм хийхгүй.

Дараагийн асуудал энэ Байгаль орчны яам Аялал жуулчлалын яамтай хамтраад ажиллаж байна уу ер нь Таван богдын аялал жуулчлал, Хотон, Хурган нуурын асуудал дээр байгалийн цогцолбор газар бохирдуулж байгаа. Отоглох газар, ариун цэврийн байгууламж барина гээд ЗГ-ын мөрийн хөтөлбөрт орчихсон, жилдээ 40-өөд мянган хүн очдог, баригдсан нэг ч юм байхгүй. Гадаадын жуулчдыг татах боломж байхгүй. Энэ талаар хийж байгаа ажил байна уу?

Б.Пүрэвдорж: Батшугар сайд хариулъя.

Ж.Батшугар: Бейсен гишүүний асуултад хариулъя. Таны зөв, энэ яг би эмнэлгийн харьяа байгууллагуудын дарга нартай уулзсан. Нийт өр нь бараг 100 тэрбум хүрчихсэн байгаад байгаа юм 100 тэрбум. Яг харахад ямар эмнэлгүүд өртэй байна вэ гэхээр ердөө л хүний нөөц нь данхайчихсан, нийт хүний нөөцийн зардал нь нийт зардлынхаа 70 хувиа давчихсан. Нөгөө талдаа сайн эмнэлгүүд байгаад байна, сайн менежменттэй. Хүний нөөцийн, бусад зардал нь яг 40 хувьтай барьчихсан. Тэгэхээр эмнэлгийн дарга нарт яг хугацаатай даалгавар өгнө. Тэгээд тэрийгээ биелүүлэхгүй бол дараачийн арга хэмжээ авахаа илэрхийлчихсэн байгаа. Яагаад гэвэл энэ ЭМД сан болон улсын төсвөөс санхүүжилт авчхаад, тэгсэн мөртөө муу менежмент, зохион байгуулалт хийж чадахгүй, анхан шатныхаа суурь тусламж, үйлчилгээ үзүүлж чадахгүй СТ, scan, рентген нь эвдэрчихсэн мөртөө тэгээд янз янзын юм нэхээд, хүний нөөц нь данхайчихсан ийм эмнэлгүүд байж болохгүй гэж хэлж байгаа юм. Хамгийн гол нь эмнэлгүүд чанартай тусламж, үйлчилгээгээ л ард иргэддээ олгох ёстой.

Б.Пүрэвдорж: Номтойбаяр сайдад нэмж хариулъя.

Н.Номтойбаяр: Алтанбулагийн чөлөөт бүстэй зүйрлэж үзвэл жилийнх нь урсгал зардал 1,6-аас 8 тэрбум төгрөгийн урсгал зардал байгаа. Энийг би та хэддээ нэг хариуцлагатай хэлэхэд ирэх жилийн төсөв дээр цалин тавигдана. Гэхдээ бага орон тоотой. 28 оны улсын төсөв дээр нэг ч төгрөгийн зардал суухгүйгээр өөрөө бие даасан аж ахуйн тооцоотой явах эрх зүйн орчныг нь Чөлөөт бүсийн тухай хуульд оруулж өгч байгаа юм. Ийм байдлаараа явбал ер нь Пүрэвдорж даргын хэлээд байгаатай санал нэг байна. Чадварлаг улсуудыг нь авч ажиллуулна, битгий харин халаад солио хийхэд тэр ч манай хань, хамаатан садан гээд мессеж бичээд, утсаар яриарай, бүгдийг нь орвонгоор нь солихоос өөр аргагүй болсон юм. Уучлаарай.

Б.Пүрэвдорж: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууна.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу, энэ өдрийн мэндийг хүргэе. Ядуурал бүр нэлээн нэмэгдчихсэн юм байна. 914 мянган хүн өнөөдөр ядуурлын шугамаас доод түвшинд байна. 346 мянган хүн нэмэгдэхэд бэлэн байна гэхчихсэн байна. Ерөөсөө энэ бол Монгол хүний 3 хүн тутмын 1 нь л ядууралтай нүүр тулчихаад байна л гэсэн үг байхгүй юу. Тэгээд 880 мянга орчим ажилгүй хүмүүс байгаад байгаа юм. Энэ их ажилгүйдэлтэй холбогдолтой л доо. Тэгэхдээ яах вэ энэ дотор ахмад, хөгжлийн бэрхшээлтэй, хүүхдээ харж байгаа ээж нар энэ тэр ордог л доо. Тэгсэн ч гэсэн ажилгүйдлийн түвшин өндөр байгаад байгаа юм. Тэгэхлээр ядуурлыг, энэ ажилгүйдлийг бууруулахын тулд хүнсний хувьсгал, ногоон хувьсгал, цагаан алт

хөтөлбөрүүд хэрэгжээд байгаа юм. Гэхдээ үүн дээр нэмэгдүүлээд бид ийм цогц бодлого хэрэгжүүлэхгүй бол болохгүй байна.

Аж үйлдвэржилтийн паркуудаа, сая тэр ярьж байна, эдийн засгийн чөлөөт бүсүүдээ бид дэмжих хэрэгтэй байна. Тэгээд энэ аж үйлдвэржүүлэлтийн парк дээр ажиллаж байгаа энэ компани, ААН-үүдэд татварын хөнгөлөлт эхний 2, 3 жилд нь татварын бүрэн хөнгөлөлт үзүүлдэг. Дээрээс нь тэнд үйлдвэрлэгдэж байгаа бараа, бүтээгдэхүүний төрийн худалдан авалтаар квотоор дэмждэг. Тэнд үйлдвэрлэл эрхэлж байгаа ААН-үүдэд энэ хөнгөлөлттэй зээл, тусламж очдог ийм цогц бодлого хэрэгтэй байна шүү дээ. Тэгээд энэ аж үйлдвэржилтийн паркууд маань ямар удаан баригддаг юм бэ 6, 7 жил л баригдах юм. Үгүй ээ 1, 2 жил уул нь барьчихмаар л харагдах юм даа. Тэгээд нийслэлийн төсвийн хөрөнгөөр энэ Эмээлт аж үйлдвэржилтийн парк уул нь баригдаад байгаа юм. Гэхдээ түрүү жил улсын төсвөөс далангийн 30 орчим тэрбум төгрөг нэмэгдүүлж тавих гээд чадаагүй. Тэгэхлээр энэ мэтчилэн бид энэ улсын төсөв нь ч тэр, нийслэл нь ч тэр энэ тал талдаа анхаараад, энэ цогц бодлого гэдэг юмаа бид барьж ажиллах хэрэгтэй байна.

Тэгээд ер нь ажлын байрыг нэмэгдүүлэх, бизнесийг, нийгмийн, бизнесүүдийг дэмжих нь нийгмийн бусад бүх асуудлуудыг шийдээд чирээд аваад явчихдаг юм байна. Өнөөдөр энэ ААНОАТ-ыг 90 хувь хөнгөлөөд эхэлсэн чинь Монголын компаниуд өнөөдөр сургуулиа бариад эхэлсэн. Энэ багийн бага сургууль гээд энэ алслагдсан аймаг, сумдад сургууль бариад ингээд улсад хүлээлгэж өгөөд эхэлж байгаа байхгүй юу. Тэгэхлээр ерөөсөө ААН, бизнес энэ эдийн засгаа дэмжих чинь өөрөө хамгийн бүх асуудлын суурь байна. Энэ тэргүүлэх чиглэлийн бидний зорилт байна. Энэ талаар та бүгдийн санал бодлыг сонсьё.

Б.Пүрэвдорж: Идэрбат сайд хариулья.

Ц.Идэрбат: Пунсалмаа гишүүнтэй олон юман дээр санал нэгдэж байна. Энэ бизнесийг дэмжих талаар төрийн зүгээс ямар нэгэн хүнд сурталгүй, ил тод, шуурхай байх энэ зарчим ХААЯ-ан дээр хэрэгжиж байгаа. Тэр экспорт, импортын асуудал дээр ямар нэгэн хорио цээр байхгүй. Дээрээс нь ЗГ-ын хуралдаанаар оруулж энэ ЖДҮ-лэлийн зээлээс авхуулаад олон зүйлүүдийн нөхцөлийг нь, цаг хугацаа нэлээдгүй хөнгөлж байгаа. Ирэх долоо хоногос бид Сум хөгжүүлэх сангийн зээл гэж байсан, тэр зээлийн нөхцөлийг хоршоо хөгжүүлэх зээл рүүгээ оруулж ирж байгаа. Ингэснээр нэлээдгүй ажлын байрууд нэмэгдэнэ.

Би таныг Эмээлтийг онцолж ярьсанд тун талархалтай байна. Яагаад гэвэл Монгол Улсын эдийн засагт энэ МАА, тэр дундаа малын арьс ширтэй холбоотой энэ том зах зээлийг бид хэд хэрэгжүүлж чадвал өөрөө асар том орон зай байгаа. Тийм учраас энэ Эмээлтийн асуудал зөвхөн нийслэлийн асуудал биш, энэ Монголын МАА-н асуудал юм гэж харж байгаа учраас очиж газар дээр нь танилцсан. Өнгөрсөн 3 дахь өдөр Монгол Улсын ЗГ-ын хуралдаанд танилцуулж, тодорхой шийдвэрүүд гаргуулсан. Үүнийхээ хүрээнд бид 2027 онд нийслэл өөрсдийнхөө хийх юмаа хийнэ, ЗГ-ын зүгээс бас таны хэлдэг тэр асуудлуудыг тодорхой хэмжээнд шийдвэрлэж ажиллана.

Нөгөө талдаа энэ нийслэлийн Хан-Уул дүүргийн 20 дугаар хороонд байгаа энэ 20 гаруй арьс шир үйлдвэрлэх, арьс ширний үйлдвэрүүдийг Эмээлт рүү нүүлгэх, технологио шинэчлэх, эргэлтийн хөрөнгөө бий болгох 90 гаруй тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн татаасны 10-аад тэрбум төгрөгийг шийдчихвэл ингээд 28

оноос Эмээлтийн цогцолбор ашиглалтад орж, 8 сая арьс боловсруулах бололцоотой болно. Нөгөө талдаа манай яамны зүгээс нэг анхаарч байгаа юм бол энэ арьс ширэн дээр 2 нөхцөл байдал үүсээд байгаа юм байна. Дэлхийд арьс ширний үнэ тэгтлээ уначихсан зүйл бас байхгүй юм байна. Яагаад гэвэл чанартай түүхий эдээр чанартай бүтээгдэхүүн гэдэг ийм зарчим явчихсан. Манайд мал эмнэлгийн үйлчилгээ сулаас болоод хачиг хувалздаа баригдсанаас болоод шаардлага хангахаа больсон. Нөгөө талдаа үнэгүйдсэнээс болоод механик гэмтэл их болсон. Тийм учраас Монгол Улсын 8 аймгийн 9 суманд энэ арьс ширийг, түүхий эдийг анхан шатан дээр нь бэлтгэх ажлыг хамгийн цааддаа бид 7 сарын 1-нээс эхлүүлээд, энэ түүхий эдийг хаяхгүй байх бололцоо байдаг юм байна гэдгийг туршиж үзэж, харуулахыг зорьж байгаа. Ингэж чадаж гэмээ нь цаашлаад энэ Монгол Улсынхаа энэ хаягдаад байгаа 10 гаруй сая арьсыг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл бололцоо үйлдвэрлэлийн хувьд ч тэр, цааш нь боловсруулаад экспортлох ч тэр, бүтээгдэхүүн хийх ч тэр бүх бололцоо бүрдэнэ гэж төлөвлөөд ажилдаа орчихсон байгаа гэдгийг би танд хэлье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулья.

Г.Дамдинням: Пунсалмаа гишүүний асуултад хариулья. Ер нь одоо бол аж үйлдвэржилттэй холбоотой Хүнд үйлдвэрийн тухай хууль манай яаман дээр бэлтгэж байна. Үйлдвэр технологийн паркийн тухай хууль гэдэг хуулиар л ер нь явж байгаа, энэ хуулийн хүрээнд газрын төлбөр, ААНОАТ, импортын татвар зэрэг дээр тодорхой хөнгөлөлтүүд бий. Энэ үйлдвэр, технологийн паркууд, аж үйлдвэрийн парк хөгжиж өгөхгүй байгаа гол шалтгаан бол манай энэ байгаа хууль тогтоомжуудын маань хорио хязгаар байгаад байгаа юм. Хамгийн наад захын том гацаа болж байгаа зүйл ердөө энэ Биржийн тухай хууль. Уул уурхайн бараа, бүтээгдэхүүний биржийн тухай хууль гэдэг хууль. Энэ хуулийн хүрээнд ерөөсөө ухаад л, ачаад л, экспортолж байх ийм зориулалттай хууль болчихоод байгаа юм. Дотоодын борлуулалтыг зөвшөөрдөггүй. Тэгэхээр одоо шинээр өргөн барьж байгаа Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ гажгийг засаж байгаа. Тэгээд энэ дээр бүгдээрээ хамтраад ажиллавал тодорхой үр дүн гарна.

Б.Пүрэвдорж: Пунсалмаа гишүүн тодруулья.

Б.Пунсалмаа: Тэгэхлээр яах вэ татварын багц хууль орж ирж байгаа, тэнцээнээс нэлээн хүлээлттэй байгаа бид. Тэгээд нэлээн олон асуудлыг энд шийдэх байх. Гол нь ерөөсөө цогц бодлого гэдэг юмыг л яриад байгаа. Тэгэхлээр сая сайд хэллээ. Тэр хачиг хувалз, вакцинжуулалтын асуудлыг бид шийдэж байж цаашдын дараачийн алхмууд нь зөв болж ирнэ гээд. Энэ тал дээр Монгол эрдэмтдийн хийчихсэн бүтээлүүд байна. Монгол эрдэмтдийн гаргачихсан энэ үйлдвэрлэж болох энэ зүйлүүд дээр яамны зүгээс ямар дэмжлэг үзүүлэх юм бэ?

Б.Пүрэвдорж: Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууна.

О.Саранчулуун: Сайн байцаана уу? Би Эрүүл мэндийн сайд, Гэр бүлийн сайд болон ЗГХЭГ, Сангийн яамдтай холбоотой хэд хэдэн зүйл тодруулья. Ийм нэг бид дээр ирж байгаа энэ төлөвлөгөөг харахаар энэ чинь яг Монгол Улсад 27 онд ингэж хийхээр төлөвлөж байгаа гээд оруулаад байгаа. Тэгээд форматын хувьд төлөвлөгөө гэдэг ийм баримт бичиг дотор төлөвлөгөөг хэрэгжүүлнэ гэдэг ийм ажил орж ирээд байх юм. Тэгээд агуулгыг нь харахаар Төлөвлөгөө гэдэг гарчиг дотор чинь энэ ажлыг хийнэ гэдэг ажлын даалгавар нь байх ёстой байхад баахан төлөвлөгөө

хийнэ, төлөвлөгөө хийнэ, арга хэмжээ хийнэ гээд байх юм. Ямар хүн боловсруулж, энийг эд нарыгаа ингэж нэгтгэж шалгадаг юм бэ?

2-т гэвэл яам, ер нь энэ яамнууд бодлогын ажил, өөрчлөлтүүдийг хийх ёстой, баахан сургалт хийх юм, баахан аян хийх юм, баахан л ийм юмнууд хийх юм. Тэгээд үр дүнг нь хамрагдсан иргэдийн тоо гэдэг ийм юмнууд их харагдаад байгаа. Тэгэхээр би энийг бүгдийг нь шүүж үзээд, нэг бүрчлэн энэ дээр санал өгөх ёстой юм байна гэж бодож байна. Нэг тийм үг, үсгийн алдаа засдаг хүн шиг л болоод байх юм даа.

3-д болохлоор нэг ийм юм бас ингээд ажиглагдаад байна. Би 1 сарын өмнө билүү, 2, 3 долоо хоногийн өмнө Сангийн сайдаас ийм албан бичиг авсан юм. Тэр нь юу байсан гэхээр бүх төсвийн захирагч нар үйл ажиллагаандаа хүртээмжийн талаар 4 ангиллаар тооцоолол гаргаж ингэж тусгаж байгаа, төсөв төлөвлөгөөндөө хүртээмжийг задалж байгаа. Би одоо энэ баримт бичиг дээр яг түүнтэй уялдаатай зүйлүүд харсангүй. Тэгэхээр тийм задаргаануудыг ер нь хаанаас, яаж харах юм бэ гэдэг нэг ийм асуудал байна? Тэгэхээр форматтай холбоотой түгээмэл харагдаад байна.

Тэгээд манайхан нэг ийм юм бас харагдаад байгаа юм. Эрүүл мэндийн талын зардлыг харахаар эмнэлэг барьчихвал хүмүүс өвдөхөө больчих юм шиг, спорт цогцолбор бариад өгөхөөр хүмүүс эрүүл болчих юм шиг ийм төсөвлөлт нь аягүй их харагдаад байгаа байхгүй юу. Эрүүл Монгол хүн эрүүл мэндийн хөтөлбөр дээр болохоороо аягүй бага мөнгө тавьчихдаг, хүн амын эрүүл мэндийн боловсрол болохоор 3 тэрбум ч юм уу, тэгээд эмнэлэг бариад л тэр нь хэдэн 100 тэрбум төгрөгийн төсөвтэй зохицуулалтын хувьд. Тэгэхээр энэ дээр ингээд харъя л даа. Жишээлбэл энд ямар ч төсөвт тусгаагүй аягүй олон ажлууд байна л даа. Анхан шатанд сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлж, ахмад настанд хүргэнэ гэж байгаа юм. 5 мянган хүнийг сургалтад хамруулна гэсэн юм байгаа байхгүй юу. Энэ ямар ч төсөвгүй юм байна. Хэн заах юм, ямар хөтөлбөр байх юм гэдэг ийм ажил жишээлбэл байгаад байгаа байхгүй юу 1.2.6 дээр жишээлбэл. Төсөв байхгүй, ахмадуудыг сурах болохоор төсөв байхгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ эрт оношилъя гэж өнгөрсөн жил ч ингээд ярьсан. Баахан ICF гэдэг юм ярьсан, тэр төсөв байхгүй, ямар ч төсөв тусгагдаагүй. Хүмүүсийг хөдөлмөрийн, ажилд оруулах нэг ийм хөдөлмөрийг дэмжих сангийн нэг төлөвлөгөө байгаа юм л даа 11,5 тэрбум хавьцаа төсөв гарах юм байна. Өнгөрсөн жил ер нь хэчнээн хүн ажилд орсон юм бэ? Ажилд орсон хүн дунджаар хэдэн сар юм уу, хэдэн жил ажилладаг гэдэг тоог асуугаад, хариултаа аваагүй их удаж байгаа. Бас нэг ийм санхүүжилт байхгүй.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтыг багасгана гэж байгаа юм, зөрөөг нь арилгана гээд байгаа байхгүй юу. Яаж арилгах юм бол? Ямар ч төсөв байхгүй. Гэр бүлийн болон хүүхдийн хүчирхийллийн урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэл олгох сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна гэнэ. Мянган хүнийг хамруулах юм гэнэ, төсөв байхгүй. Нийгэмшихүйн арга хэмжээ гээд гэмт хэрэг, зөрчилд хамрагдсан, хохирсон хүүхдүүдэд чиглэсэн арга хэмжээ байгаа, төсөв байхгүй. Иргэдийн орлогын түвшинд нийцсэн ипотекийн зээлийн төрөлжилтийг бий болгож, хүртээмжийг нэмэгдүүлнэ гэж байгаа юм, 25 мянган хүн гэж байх шиг байна, өрх гэж байх шиг байна, төсөв байхгүй. Тэгээд яг энэ нийгмийн

зорилтот бүлэгт чиглэсэн иймэрхүү юмнууд яагаад төсөвгүй байгаад байдаг юм бэ? Энийг яаж.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Аубакир сайд хариулъя. Индрийн 4 номер, албан тушаал, нэрээ хэлээд хариулаарай.

Б.Мөнгөнсүх: Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мөнгөнсүх. Гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд байгаа зарчмын шаардлагуудыг хангуулж, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын баталсан Монгол Улсын богино хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах аргачлалын дагуу боловсруулдаг. Энэ тодорхой цогц арга хэмжээ гэдэг юм уу, хөтөлбөрүүд гэдэг энэ зүйл бол олон түвшний санхүү, түвшинд хэрэгжих ийм цогц арга хэмжээнүүд байгаа. Зарим арга хэмжээнүүд бол урсгал зардлаар хэрэгжих ийм арга хэмжээнүүд байгаа. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд үр нөлөөний, үр дүнгийн нөлөөлөл өндөртэй арга хэмжээнүүд учраас зайлшгүй төлөвлөгдөж орж ирж байгаа. Энэ арга хэмжээнүүд нь цаашлаад төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд аймгуудын жилийн төлөвлөгөөнүүдэд, яамдын төлөвлөгөөнүүдэд нэг бүрчлэн задарч ингэж уялдаж, олон түвшинд зохион байгуулагдах арга хэмжээнүүд аргачлалын дагуу төлөвлөгддөг байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Саранчулуун гишүүн тодруулъя. Эхлээд Батшугар сайд хариулчихъя, тэрний дараа тодруулчихъя.

Э.Батшугар: Саранчулуун гишүүн маш зөв юм хэллээ л дээ. Бид эмнэлэг бариад, бариад тэгэхэд эрүүл мэндийн салбар, ялангуяа дундаж насжилт эд нар харьцангуй сайжирна гэсэн үг зүйл биш байхгүй юу. Тогтолцооны асуудал байхгүй юу. Яаж эхлээд эрүүл байх вэ гээд. Тэгээд үүнтэй холбоотойгоор энэ жил удахгүй CDC байгуулагдаж байгаа. Одоогоор бид яг нийгэм, эрүүл мэнд дээр вакцинжуулалт, эрт илрүүлье гэх мэтчилэн зүйлүүд байгаа. Яг дорвитой арга хэмжээ бол яг харагдахгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр CDC-ээ байгуулж байгаа байгаад яаж хүнийг өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх вэ гэдэг дээр нь илүү тулж ажиллах нь зөв. Яагаад гэвэл нэгэнт өвдчихсэн хүнийг чинь эмчлэхэд маш их хэмжээний зардал гардаг. Нөгөө талдаа нөгөө хүндээ хүнд гэж ойлгож болно. Ялангуяа хавдар дээр манайд ирж байгаа нийт хавдрын тохиолдол нь 3, 4 дүгээр шатанд нь ирчхээд, тэгээд эндэлт их өндөр байгаад байгаа байхгүй юу. Эрт илрүүлэг хийсэн бол нөгөө хүн чинь анхны шатдаа эмчлэх бүрэн бололцоотой байгаад байгаа юм.

Б.Пүрэвдорж: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Баярлалаа. CDC-ээ сайжруулах дээр урт замын зураг, дэлгэрэнгүй байх хэрэгтэй байна гээд бид яаман дээр ажиллаад, тайланг нь дахиж шинэчлээд, ингээд дахиад нэг төлөвлөгөө явуулаарай гэсэн байгаа. Ирэх долоо хоногт уулзаад задалж ярих хэрэгтэй байх. Яагаад гэвэл нийгмийн эрүүл мэндийн төсөв өнгөрсөн жил танагдсантай холбоотой шинээр гаргаж байгаа төлөвлөгөө нь ямаршуу сайжирсан уу, үгүйг нь би энэ бичиг баримтаас харсангүй. Тэгэхээр дахиж нягталж харж байх ёстой байх гэж бодож байна.

Энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ийм амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр байгаа, 11 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шаардаж байгаа, 11,6 тэрбум. Тухайн жилд шаардагдах нь 5,8 тэрбум гэж байгаа. Ер нь энэ тэрбум төгрөг чинь зөндөө мөнгө шүү дээ. Тэгэхээр энүүгээр бид яг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс яг ажилд ордог юм болов уу? Би одоо ингээд л яг ажилд ороод л, тэгээд л тэр ажил дээрээ 5 жил болчихсон, яг энэ сангаас энэ мөнгөөр ажилд орчихсон хүмүүсийг би ерөөсөө нэг л дутуу л.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хариулах юм байна, нэр, албан тушаалаа хэлээрэй.

Ю.Отгонбилэг: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Отгонбилэг байна. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх энэ хөтөлбөр шинэ хөтөлбөр байгаа, 2025 оноос анх ингэж шинээр Халамжаас хөдөлмөрт бодлогын хүрээнд хэрэгжүүлж эхэлсэн ЗГ-ын шинэ хөтөлбөр. Энэ хөтөлбөрийн хүрээнд яг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг Японы Жайка байгууллагын дагалдан ажиллуулж хөдөлмөрт бэлтгэх гэсэн энэ хөтөлбөрийн хүрээнд туршлага дээр үндэслэн үйлчилгээг үзүүлэх юм. Мөн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай байгаа ядуурлын шугамаас бага орлоготой өрхүүдэд чиглэсэн өрхийн мэдээллийн нэгдсэн сангаас өрхүүдээ сонгоод, үйлчилгээг үзүүлэхээр энэ хөтөлбөрт тусгагдсан. Тэгээд тодорхой тоног төхөөрөмжийн дэмжлэгээс гадна, тухайн өрхүүдийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвар.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Баярлалаа. Цаг бага байгаа учраас шууд, шууд асуугаад явъя. Ер нь хүнээ хөгжүүлж байж л энэ тодорхой суурь зүйлүүдийг шийдэхээс өөр арга, үйлдвэр яриад байдаг боловсон хүчин алга. Наад захын гагнуурчин алга, наад захын энэ слесарь ч гэдэг юм уу, энэ холболтын мэргэжилтнүүд алга сантехникийн, дутагдалтай байна. Тэгэхээр ер нь энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, ЖДҮ-лэлийг дэмжих сан гээд ийм ижил төстэй жижиг өрхийн, жижиг, дунд бизнесийг дэмжих ийм зориулалттай сангууд байна. Зарим давхцалууд нь ч байна. Тэгэхээр би ер нь зүгээр юу хэлэх гээд байна гэхээр энэ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг зүгээр залуучуудыг дэмжих сан болгоё. Бусад орон яг ийм чиглэлээр явдаг. Жишээ нь Австрали. Яг залуучууд гэсэн энэ категоритой орж байгаа хүмүүсээ дэмжиж, өнөөдөр Монголын 150 мянга орчим иргэд гадаадад амьдарч байна шүү дээ. Дандаа ажиллах бололцоотой буюу хамгийн идэвхтэй хөдөлмөр эрхлэх бололцоотой хүмүүс. Энэ хүмүүсийг эх орондоо авчирч хөдөлмөрлөх нэг хөшүүрэг өөрөө эргээд бид хэд ирэхэд нь энэ бизнес эрхлэх бололцоог нь бүрдүүлэх.

Жишээ нь Европын Герман энэ тэрд байдаг шүү дээ МСҮТ. МСҮТ-ийг төгсөөд 2 жил заавал дагалдан ажилтан байх ёстой. Дагалдан ажилтан хийчхээд, дээрээс нь энэ ЖДҮ-лэлийн ийм Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаасаа ингээд зээл авах бололцоотой байдаг. Ийм хөтөлбөрүүдийг уялдуулаад, энэ зөвхөн залуучуудыг дэмжих энэ бололцоогоор ашиглавал яадаг юм бэ, энэ дээр бодлогын өөрчлөлтүүд юу байна вэ? Ер нь залуучуудын хөдөлмөр эрхлэх, эх орондоо буцаж ирэх ийм бодлогын хүрээнд ямар бодлого байгаа вэ? Энийг нэг хариулж өгөөч.

Уул уурхайн салбарыг дэмжиж, жоохон орлогоо нэмэгдүүлэхгүй бол энэ зардлууд нэмэгдэхгүй. Тэтгэвэр нэмж чадахгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ дэмжиж чадахгүй, боловсролдоо хөрөнгө оруулах асуудлууд хумигдана. Тэгэхээр энэ уул уурхайн салбар дээр энэ АМНАТ-ын бодлогын асуудлыг, ялангуяа зэс дээр ямар бодлого барих юм бэ? Эрдэнэт гээд 20 хувийн АМНАТ-н төлөөд л ганцаараа зүтгээд байдаг. Эрдэнэт шиг ядаж 3 үйлдвэртэй болчихмоор байна. Яг бэлэн судалгаатай ямар, хэчнээн зэсийн орд, үйлдвэрүүд байна вэ? Энийг нийтээрээ нэг зөвшилцөхгүй, улс төр болгохгүйгээр, нэг хөдөлгөчихвөл яасан юм бэ? Энэ нөхцөл байдал биднийг ер нь хүлээхгүй л байна л даа энэ гадаад нөхцөл байдал чинь. Тэгээд ирэх жилүүдээс энэ төсвийн урсгал зардалдаа бүр дийлдээд унах вий дээ. Бөөнөөрөө цалингаа тавьж чадахгүй, тэтгэврээ тавьж чадахгүй, багш, эмч нар нь ажиллах нөхцөлгүй болчих вий дээ.

Тэгээд хөрөнгө оруулалтыг хамгаалах асуудал дээр анхаараач. Би Ховдын ард түмэндээ хэлмээр байгаа юм. Хэдүүлээ газар нутагтаа хайртай байлгүй яах вэ, тэгэхдээ ингэж гаднын ч бай, дотоодын хөрөнгө оруулагчдын эд зүйлийг эвдэж, ингэж бид тэмцдэг ард түмэн биш, бид хэд уужуу ярих ёстой. Ямар шаардлагууд тавиад байна, тэр шинжлэх ухаан баримтуудтай нь сайн танилцаач. Ийм байдлаар явахгүй бол хөрөнгө оруулалтыг татах гээд байдаг, нөгөө талдаа ард иргэд нь ч гэдэг юм уу, хэн нэгний турхирах байдаг юм уу, цаана нь ямар эрх ашиг байдаг юм мэдэхгүй. Ингээд тэр контейнеруудыг бүүр ингээд хэвтүүлж байна лээ шүү дээ. Монголын ард түмнээс ийм балмад юм гардаг тохиолдол ховор доо. Энэ дээр хэдүүлээ хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах асуудал дээр нэг жоохон дорвитой алхмууд хиймээр байна. Энэ дээр ямар ажлууд байна вэ?

2 дугаарт энэ ХАА-н салбар бол эдийн засгийн томоохон салбар. Өсөлт ч гэсэн гайгүй байна. Тэгэхдээ ирэх жилүүдэд энэ дэлхийн гадаад нөхцөл байдалтай уялдуулаад манай энэ тэсрэх бодис гэдэг юм уу, бордооны нийлүүлэлтийг хариуцдаг ОХУ энэ дээрээ квот тогтоогоод хязгаарлаад эхэлж байна. Энэ дээр бид хэд ер нь ирэх жилүүдэд ямар тактик, бодлоготой байх юм бэ, алсдаа ер нь бид хэд хэзээ энэ бордооны үйлдвэртэй болох юм бэ? Ер нь аж үйлдвэр манайд хөгжих үү, үгүй юу, энэний төлөвлөлт ямархуу байгаа юм бэ, ирэх жил ямар ажлууд хийгдэх юм бэ?

Улаанбаатарт буучхаад, 21 аймаг руугаа аялдаг баймааргүй байна. Манай Энхбаяр сайд нэг хэлж байсан, 3 аймаг дээр олон улсын онгоцны буудал барьж байгаа гэсэн. Энэ 3 аймгийн яг эхний тэргүүлэх чиглэл нь аль аймагт байгаа юм бэ, ирэх жил хэчнээн хувийн ажил нь хийгдэх юм бэ? Энэ дээр нэг хариулт аваад, тэгээд нэг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Шадар сайд Энхбаяр хариулъя.

Ж.Энхбаяр: Сайнзориг гишүүн их ажил хэрэгч саналууд гаргалаа. Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн бий болсон чадавх үндсэндээ ингээд дээд түвшиндээ тулсан. Ажиллах хүчээ үндсэндээ бүрэн дайчилж байна. Бид эдийн засгаа тэлэхгүй бол энэ хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэглээ, улс орны хөгжлийн санхүүжилтийг шийдэж чадахгүй. 27 оны төсөв бол урсгал зардал, цалин хөлс, тэтгэврээ тавиад л дуусна, нэг ч шинэ хөрөнгө оруулалт хийх боломж байхгүй. Одоо байгаа үргэлжилж байгаа хөрөнгө оруулалтаасаа 2,2 их наядын хэмжээнд хөрөнгө оруулалтыг нь үргэлжлүүлэх хэмжээнд. Энд их том дүгнэлт хийх ёстой.

Яагаад вэ гэж. Бидэнд шинэ ОТ, шинэ Тавантолгой, шинэ төмөр зам, шинэ цахилгаан станц, шинэ зах зээл эдийн засгийг томруулах, саваа томруулах хэрэгтэй.

Бидний эхний нийгэм, эдийн засгийн шилжилтийн 35 жил муугүй амжилттай, эдийн засаг маань 90 их наядад очиж нэг хүнд ноогдох орлого 7300 долларт хүрч, дундаж хөгжилтэй орон боллоо. Одоо яг энэ дундаж хөгжлийн гацаа саад гэдэг нэг юм руу ороод байгаа юм зогсдог. Энэ бол нэлээн олон орон ийм оронд очсоноор зогссон, хөгжил ингээд зогсчихдог. Одоо бид дараагийн түвшиндээ үсрэн гарахын тулд бидэнд үйлдвэржилт, боловсруулалт, байгаа нөөцөө бүрэн ашиглах, одоо экспортолж байгаа бүхий л түүхий эдийнхээ боловсруулалтыг нэмэх, цэвэршүүлэх, баяжуулах, уранаа боловсруулах, нефтиэ боловсруулах, газрын ховор элементээ боловсруулах, та бордоо хөндлөө. Манай Монгол Улс дэлхийд байхгүй бордооны нөөцтэй шүү дээ фосфорит ордтой. Мөн нөгөө л учир шалтгаанаар зогсчихсон. Юун ОТ, Тавантолгойгоос илүү зөвхөн энэ фосфорын ордыг ашиглалтад оруулбал Монгол Улсын эдийн засаг өнөөгийн байгаагаас дахин нэг дахин нугарах бололцоо байгаа байхгүй юу даа. Дэлхийд юу дутаж байна вэ гэвэл дэлхийд бордоо дутаж байна. Хүнс, эрчим хүч нэг номерын асуудал байгаа. Энэ үед эрчим хүчний нөөц баялаг нөөц байдаг, ашиглаж чаддаггүй.

Одоо бид хар даа, 70 жилийн түүхтэй Монголын геологийн эрж хайж, бий болгосон ордыг бид одоо ашиглаж, идэж байна. Шинээр бид олигтой шинэ орд гаргасангүй ОТ-гоос өөр, хуучин дээрээ л байна. Гэтэл ашигт малтмалын орд маань хайгуулын талбайн ашиглалтаасаа цөөрчихсөн. Энэ чинь байж боломгүй буруу урвуу хамааралд орж байгаа байхгүй юу. Хайгуул нь нэмэгдэж, урд нь гарч, шинэ нөөц, шинэ баялаг бүтээж байдаг, ирээдүй хойшдоо үлдээж байдаг энэ ажил нь ингээд хаягдчихсан. Одоо байгаагаа ашиглаж чаддаггүй зогсчихсон. Гаднын хөрөнгө оруулалтыг хөөгөөд гаргачихсан.

Эдийн засгаа тэлэхгүйгээр энэ олон хүсээд байгаа цалин, тэтгэвэр, нийгмийн энэ хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн асуудлыг шийдэх боломжгүй болж байгаа юм. Тэгээд энэ дээрээ л зогсоно гэсэн үг. Төсөв маань цалин, тэтгэврээ тавьчихаад л сууж байдаг. Тэгэхээр бид бодлогоо, сэтгэлгээгээ энэ танхимаасаа авхуулаад бид өөрчлөлтийг хийх хэрэгтэй. Эрс өөрчлөлт хийж байж, бид эдийн засгаа хөгжлийн шинэ түвшинд гаргах болно.

Б.Пүрэвдорж: Эхлээд Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Үнэхээр хэрэгтэй л асуултауд. Зэсийн АМНАТ манай улс дэлхийд байхгүй өндөр АМНАТ зэсээс 21,6 хувийг авч байгаа юм. Хоёрхон төсөлтэй, энэ ганц уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр төлдөг. Нөгөө төсөл нь ОТ тогтворжуулалтын 5 хувьтай. Бид олон улсын түвшинд хүргэж, зэсийн АМНАТ-ыг буулгаж байж, цаана нь 20 гаруй жижиг том төслүүд бэлэн болоод ингээд хөдлөхөд бэлэн болчихсон, хайгуулаа явуулах гээд байж байна. Хамгийн эхний үр дүн бол Цагаан суваргын ордоос бий болно. Жилдээ 300 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр 80 гаруй хувийн гүйцэтгэлтэй болчихсон. Ингээд энэ АМНАТ-аас шалтгаалаад хөдөлж чадахгүй ингээд байж байгаа. Ашигт малтмалын хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энийг олон улсад өрсөлдөх хэмжээнд бууруулж оруулж ирж байж нүүрстэй зэрэгцээд зэс гэдэг эдийн засгийн суурь том баганатай болох ийм бодлогыг бид хэрэгжүүлж ажиллана.

Б.Пүрэвдорж: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан гэж сан байдаг ЗГ-ын тусгай сан. Одоо гаднын ажиллах хүчний төлбөр 1 дүгээрт, 2 дугаарт хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй ААН-үүдийн төлдөг ийм шимтгэлээс бүрддэг сан байдаг. Сангийн зориулалт ахмадууд, залуучууд, эмэгтэйчүүд эдгээр иргэдээ ажлын байраа хадгалах, шинээр ажлын байр бий болгоход зориулж, жижиг зээл, зарим санхүүгийн дэмжлэг. Энэ жижиг, дундын зээлээс арай өөр. Манай энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл аваад, тодорхой хэмжээний ажлын байр бий болгоод, дараагийн шат нь ЖДҮ-лэлээс арай өргөжүүлээд явах ийм зориулалттай. Бид ажлын байраа хадгалах, ажлын байран дээрээ дахин дадлагажуулах, дадлагажуулж байгаа багшид нь тодорхой хэмжээний урамшуулал, мөн тухайн шинээр орсон тэр залуучуудыг хөдөлмөрийн дадалтай болгоход зориулагдсан ийм сан. Таны хэлж байгаа зөв. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт төдийлөн сайн биш байгаа. Тийм учраас бид залуучууд руугаа чиглэсэн ахмад, эмэгтэйчүүд рүүгээ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Аубакир сайд нэг тодруулаад хариулаад өгөөч. Одоо жилд 106 тэрбум төгрөг цугларч байна. Тэгээд ингээд яг босож ирсэн бизнес их ховор. Тэгэхээр ер нь би яг ингээд бүр зорилтод фокус болгоод яг дотоодын юу гэдэг юм дагалдан хийгээд, дараагийн нэг иж бүрнээр нь сантехникийн төхөөрөмжийг нь ч юм уу, гагнуурын төхөөрөмжийг нь өгөөд ингээд ажлын байран дээр гардаг, энийгээ ингээд хийгээд явдаг мэргэшсэн ийм боловсон ажилтнуудыг баазыг бэлдмээр байгаа юм. Эсвэл ингээд олон улсын томоохон байгууллагуудын интерншип /Internship/ болоод ирвэл бид эндээс санхүүжүүлээд, ОУБ руу зам жимтэй болмоор байгаа байхгүй юу. Залуучууд л гарч ирж. Солонгос ийм хөтөлбөрөөр явж байж маш олон олон улсын байгууллагуудын удирдах зөвлөлд гарч чадсан. Ингээд буцаагаад ноу-хау /know-how/ мэдлэг ур чадварыг эх орондоо авчирч байгаа. Энэ дээр яг энэ санг бүтэн ажиллуулмаар байна. Би яг холбогдох хуулийн төсөл дээр ажиллаж байгаа юм. Тэгээд танай яамтай хамтраад ажилламаар байна, яг чиглүүлээд нэг ингээд зориод үзвэл яадаг юм.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жилийн орлогыг нь бид 30-аас 40 тэрбум төгрөгөөр тооцдог. Гэхдээ төвлөрүүлэлт давуулан биелүүлдэг л дээ. Энэ жилийн хувьд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дээр 106,6 тэрбум төгрөгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжиж байгаа. Яг энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөнгөлөлттэй зээл, дэмжлэг аваад төдийлөн сайжрахгүй байна гэвэл бас үгүй дээ. Саяхан Монгол Улсын Ерөнхийлөгч яг энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг аваад ажиллаж байгаа өрх, өрхийн аж ахуй, иргэдийн үйл ажиллагаатай очиж танилцсан. Том үзэсгэлэн гарсан, маш олон хүмүүс бий. Миний хувьд яах вэ өмнөх ажлаа дуугүй хийгээд явах ёстой гэж боддог л доо, айхтар мэдээлэл цацаад л попроод байх гэхээсээ илүү, бид жилдээ нийтдээ 5 мянга орчим орлогын түвшин доогуур иргэдийг бид орлоготой болно гээд зорилго тавьчихсан ажиллаж байгаа байхгүй юу энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хүрээнд 5 мянган өрхийг. Өнгөрсөн жил бид 3200 өрхийг тодорхой хэмжээний орлогын түвшнийг дээшлүүлсэн гэхээр.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: 2027 оны хөгжлийн, эхлэх үү? 2027 оны хөгжлийн хөтөлбөр хэлэлцэж, өнөөдөр УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэж байна. Маш чухал асуудал хэлэлцэж байгаа энэ цаг үед Ерөнхий сайд маань алга байна. Аубакир сайдаас асууна Гэр бүл, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны сайд. Та ер нь сайдын ажлыг аваад багагүй хугацаа өнгөрлөө. Яг үнэндээ өнөөдрийн энэ орж ирж байгаа 2027 оны хөгжлийн хөтөлбөр дээр таны оруулсан энэ Хүний хөгжил гэдэг бүлгийг би харж үзлээ. Энд тодруулах, тайлбар авах зүйлүүд хэд хэд байна. Энэ хүний хөгжлийн бүлэгт дундаж давхаргыг нэмэгдүүлнэ гэхчхэн байгаа юм. Та сая ярихдаа бас л Сайнзориг гишүүний асуултад худлаа л хариулчих шиг боллоо тоогоор.

Яагаад гэхээр энэ дундаж давхаргыг нэмэгдүүлнэ гээд заачхаад, амьдрал дээр яг энэ дундаж давхаргыг бодитоор нэмэгдүүлж байгаа юм ерөөсөө огтхон ч харагдахгүй байна л даа. 2025 онд энэ суурь түвшин нь 5363, 2027 онд 5903, зөрөө нь бод доо, 540 ажлын байр, нэг хүн нэмэгдсэн байгаа юм иргэнээр. Тэгэхэд энийг 46 тэрбумыг энэ 5903-д хуваагаад үзэхээр ер нь нэг хүнд оногдох зээлд бичил бизнес эрхэлж байгаа энэ зээл эрхэлж байгаа хүмүүс чинь ерөөсөө 8 орчим сая төгрөгийн л зээл оногдох юм байна шүү дээ. Ийм жижигхэн юм тавьсан байх жишээтэй. Тэгээд энэ 540 зөрөө энэ ажлын байр энийгээ та ер нь залуучууд, эмэгтэйчүүд, дээр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, энэ бичил бизнес, үйлдвэрлэл эрхэлж байгаа, ЖДҮ-лэл эрхэлж байгаа иргэдэд ингээд харуулахаар энэ бүүр аягүй инээдэмтэй тоо харагдаж байна шүү. Та энд ерөөсөө ямар нэгэн бодлого барьж ажилласангүй.

Өнөөдөр Монголын нийгэмд дундаж давхаргын асуудал, иргэдийг ёстой ганц бухимдуулж байгаа энэ сегмент бол дундаж давхарга шүү дээ. Яг үнэнийг хэлэхэд миний хажууд байж байгаа туслах, зөвлөхүүд хүртэл дундаж давхаргад амьдарч байгаа юм. Зээлээс ч зээлд амьдарч байгаа юм, бүгд зээлтэй. Олсон цалингийнхаа орлогыг бүгд зээлд өгчхөж байгаа. Энэ Монголын нийгмийн энэ дундаж давхарга өнөөдөр та ядуурал руу шилжээд одоо хэдэн жил болж байна вэ? Ядуу нь доошоо нэн ядуу руу шилжчихсэн. Энд та сайд хүний хувьд дорвитой яг энэ хөгжлийн хөтөлбөр дээр бодлого бүр боловсруулж оруулж ирэх ёстой байсан шүү. Одоо та яг надад хариулаарай.

Энэ хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа, дээр нь эмэгтэйчүүд гэж байгаа, залуучууд гэж байна, хөдөлмөрийн юу, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг энэ 46 тэрбум тавьчихсан байгаа. Эмэгтэйчүүд дээр 5,7 тэрбум, залуучууд дээр 9,3 тэрбум, дараа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд дээр 11,4 тэрбум гээд төсвийг хангалттай тавьж зоож өгсөн. Тэгвэл яг энэ чинь яг тэр сегмент, зорилтот түвшиндээ очоод үйлчлэх ямар шалгуураар, яаж ангилаад, ямар хэмжээний зээлийг, хэзээ, яаж олгох энэ талаар тодруулга авъя нэг?

Дараа нь энэ ажилгүй, орлогогүй залуучуудын нийгмийн асуудал, тэр дундаа оюутан залуусын асуудал. Өнөөдөр гэр орноосоо хол хотод сургуульд сурчхаад, хагас цагийн хөдөлмөрөөр энэ СУ энэ тэр шиг ийм компани юунд үйлчилгээний газруудад ажиллачхаад, нөгөө хөдөлмөрийн хөлснөөсөө ЭМДШ, НДШ-ийг тооцуулж аваад байгаа юм. Энийг та энэ дээр ер нь анхаарч ажиллаж, ямар арга хэмжээ авах гэж байгаа вэ? Тооцуулахгүй байх тийм бодлого боловсруулж ажиллах уу?

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Эхлээд Энх-Амгалан сайд хариулъя, 4 минутаар хариулна шүү дээ, та чинь нэг минутаар бага байна гээд байсан билүү.

Л.Энх-Амгалан: Хурлын даргадаа баярлалаа, хурлын дэд даргадаа, 2 Ховдынх учраас андуураад яагаад байх юм. Батчимэг гишүүнийхээ асуултад хариулъя. Маш чухал асуудал хөндөж тавьж байна. Бизнесийн салбарт байсан хүн учраас энэ жаргал, зовлонг мэдэж байгаа байх. Дундаж давхаргын тухайд асуултыг манай Энхбаяр сайд илүү хариулах болов уу гэж бодож байна.

Гэхдээ яг таны саяын хөндсөн энэ залуучуудыг хөдөлмөрт бэлдэх, энэ хөдөлмөрийн зах зээл дээр өнөөдөр үүсчихсэн байж байгаа ур чадварын ялгааг яаж арилах, ямар, тогтолцооны ямар шинэчлэлүүд хийгээд байна вэ гэдэг нэг зүйлийг та асуугаад байна. Тэгэхээр өчигдөр та анзаарсан байх. Өчигдөр манай төрийн өмчийн 300, төрийн өмчийн 30 мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв /МСҮТ/ буюу одоо коллеж болсон, 30 коллежийг бид Монголын хамгийн том баялаг бүтээгч 30 компанид менежментийг бүрэн шилжүүлж байгаа. Өчигдөр давхар ямар гэрээнүүд хийгдсэн бэ гэхээр яг энэ МСҮТ төгсөж байгаа хүүхдүүдэд ЖДҮ-ийн сангаас яг гарааны бизнесийн санхүүжилтүүдийг нь, өөрөө ажлын байр бий болгож байгаа залуучууд гарааны бизнесийн санхүүжилт олгох зээлүүдээ манай ЖДҮ-ийн сангийнхан зарласан.

Манай хөдөлмөр эрхлэлтийн сангийнхан бас адилхан. Яг өөрөө төгсөөд, ажлын байраа бий болгож байгаа улсуудад гарааны буюу start-up-н энэ зээлийн бүтээгдэхүүнийг зарлаж байгаа. Энэ дээр нь мэдээж шинээр ажилд гарч байгаа, ажлын байр бий болгож байгаа улсууд чинь зээл авъя гэхээр мэдээж үл хөдлөх хөрөнгө байхгүй шүү дээ, баталгаа хөрөнгө байхгүй. Тэгэхээр Зээлийн батлан даалтын сан бол энэ дээр ажиллаж, тодорхой нийт авах гэж байгаа зээлийнх нь 70 хүртэл хувь дээр Зээлийн батлан даалтын сан гаргах. Тэгээд мэдээж манай тэргүүлэх ААН-үүд MCS, АПУ өчигдөр чинь Очжаргал захирал, Батсайхан захирал, Баатарсайхан захирал, манай Түмэнгэрэл захирал, Цэлмүүн захирал гээд л МАК гээд бүгдээрээ л тэргүүлэх захирлууд ирж нэг, нэг коллежуудыг хөл дээр нь босгох ийм том үүрэг хүлээж, нийгмийн өмнө үүрэг хүлээж. Нөгөө талаасаа өөрсдөө яг өөрсдийнхөө хүсэж байгаа ур чадвартай мэргэжилтнүүдийг бэлдэж авах энэ тогтолцоо руу өөрсдөө ажил олгогч нар орж ирж байгаа. Энэ бол нөгөө Германы хосмог тогтолцоо буюу ажил олгогч, төгсөгч хоёр хоорондоо ийм итгэлцлийн гэрээ хийж, ажиллангаа суралцах, суралцангаа ажиллах ийм тогтолцоо руу шилжиж байна.

Би ганцхан жишээ дурдъя гэж бодож байна. Газар тариалангийн компанид мэргэжилтэн бэлдэж байгаа сургуулиуд яг газар тариалангийнхаа үеэр л тэр хүмүүс дадлагаа хийх ёстой. Гэтэл манайд тэр танхимаас нь явдаггүй, тэр яг ид газар тариалан дээр ур чадвараа сургах ёстой тэр сургалтынх нь үеэр ингээд хичээллээд сууж байдаг нэг ийм амьдралаас гажчихсан ийм тогтолцоонууд байгаад байна шүү дээ. Тэгэхээр энэ тогтолцооны гажуудлыг бид арилгаж, яг энэ мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол дээр Монгол хүүхэд бүрийн ур чадварын ялгаа арилж, хөдөлмөрийн зах зээл дээр байгаа энэ ур чадварын ялгааг арилгах ийм тогтолцооны шинэчлэлүүдийг ингээд эхлүүлж байна гэдгийг би танд хэлье.

Б.Пүрэвдорж: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог санхүүгийн дэмжлэг зээл маш бага Батчимэг гишүүнээ 8 сая төгрөг, 15 сая төгрөг. Танд бол яах вэ бага мөнгө байх л даа. Малжуулах хөтөлбөр гээд тогтвортой олон жил явуулж байгаа ийм хөтөлбөр байдаг. Тухайн нэг иргэнд, нэг өрхөд 8 сая төгрөг өгөөд, нөгөө малчин айлаасаа мал худалдаж аваад, ингээд нөгөө айлыг тодорхой хэмжээнд орлоготой болгоод, өөрөө тодорхой хэмжээнд хэдэн толгой малтай болж байгаа. Ийм хөтөлбөрүүд энэ манай Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан чинь өөрөө start-up буюу эхний л тэр санхүүгийн хэрэгслийг олгож байна шүү дээ.

Цаашлаад өргөжөөд явъя гэвэл ЖДҮ-лэл, өөр том зээлүүд рүү явах ёстой. Манай хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан бол ерөөсөө ийм жижгээр эхэлдэг. Жишээлбэл өнгөрсөн жил бид 5535 ажлын байрыг ирэх жил болгохоор зориод ажиллаж байна. Өнгөрсөн жил бид 727 ажлын байрыг хадгалаад, 69 ажлын байрыг шинээр бий болгосон. Ажлын байрыг өөрөө.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Батчимэг гишүүн тодруулъя. Өөрөө асна.

П.Батчимэг: Аубакир сайд та Их Хурлын танхимд Их Хурлын гишүүнийг тэгж доромжлохгүй шүү. Танд бага мөнгө байх энэ тэр гэж та ярихгүй шүү. Би таныг энд хариуцлага, би танд хариуцлага юу яана тооцуулна. Та ер нь нийгмийн хамгаалал, Гэр бүл, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд болчихоод Монголын нийгмийн дундаж давхарга, хамгийн хүнд сегментийг өнөөдөр босгох, аврах, хамгаалах ямар ч бодлого барьж ажиллаагүй. Цаашдаа би танаас таныг яг энэ сайдын сэнтийд байх хугацаанд, байх туршид чинь би танаас нийгмийн яг энэ дундаж давхаргын талаар асуулга асууж, араас нь хөөцөлдөж, таны энэ тавьсан 100 тэрбум, энэ 46 тэрбум, 9,3 тэрбум, энэ 5,3 тэрбум төгрөгийн зарцуулалт энэ бүх гүйцэтгэлийг би танаас байнга нэхэж ажиллана гэдгээ өнөөдөр хэлье.

Б.Пүрэвдорж: Үг хэлсэн сая. Нэмж тодруулъя.

П.Батчимэг: Гэр бүл, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам бол өнөөдөр Монголын яг энэ иргэдийн гол асуудал хөдөлмөр олголт, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл энэ бүгдийг шийдэх гол гогцоо бодлогыг барьж суух ёстой байтал та газрын дарга нараараа хэдэн тоо тавиулчихаад, орж ирж аархаад байх шаардлага байхгүй. Жишээ нь энэ хөгжлийн хөтөлбөр энэ ном дээр ядуурлын түвшнийг 2022 оны байдлаар 27,1 хувь байгаа гэж дүгнэж оруулж ирсэн. Үндэсний статистикийн газар 2 жил тутамд тооцоолол гаргаж өгдөг. Яагаад 2024 оны энд статистик судалгаа мэдээлэл байхгүй байгаа юм бэ? 26-гаага байа гэхэд, 25-аа байа, энэ 24 оны судалгаа байхгүй юу, 22 оны байдлаар бид энэ ядууралд ойртчихсон 346,4, одоо 914,2 мянга ядуурлын доогуур шугамд байна гэж байна. Тэгвэл Монголд.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хариулъя товчхон, Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Тийм, тийм, ер нь хөдөлмөр эрхлэлт, ядуурлын түвшин дорвитой буурахгүй байгаа нь үнэн Батчимэг гишүүнээ. Яах вэ энэ зөвхөн энэ салбарын гэхээсээ илүү жишээлбэл өнөөдөр Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн 50 хувь нь эзэмшсэн дипломоосоо өөр хөдөлмөр эрхлээд байгаа юм. Энэ маань нөгөө талдаа боловсролын систем маань хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй байгаа боловсон хүчнээ эрэлтэд нийлүүлж бэлтгэхгүй байна л гэсэн нэг дүгнэлт гарна жишээлбэл. Энэ маань эргээд цалин хөлсний юутай асуудалтай холбогдоод

л явна. Би яах вэ танд хэрвээ эмзэглэсэн бол уучлаарай. 8-хан сая төгрөг гэхээр чинь би тэгээд хэлчихлээ л дээ. Түүнээс энд 8 сая төгрөг, 10 сая төгрөг, 15 сая төгрөг аваад, тодорхой хэмжээнд 1-ээс 2 иргэнийг жилийн туршид ажилтай байлгаад, ажлын байраа хадгалаад, дахиад өргөжүүлээд явж байгаа маш олон өрх бий. Би энэ дэлгэрэнгүй мэдээллүүдийг ер нь ингээд яриад явж байхгүй бол болохгүй юм байна л даа. Өнгөрсөн жил бид тодорхой хэмжээнд Энх-Амгалан сайдыг байх үеэс хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнг энэ жил бид тооцож харлаа л даа. Тодорхой хэмжээнд үр.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Оройн мэнд хүргэе. Энэ Монгол Улсын 2026-аас 30 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл гэдгийг бид Эдийн засаг, хөгжлийн яам, ЭМЯ, Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, тэгээд ажлын албатай хэдэн өдөр, хэдэн шөнө сууж боловсруулаад гаргасан. Түүн дээр жишээлбэл тэр 1.2.1.3 дээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлнэ гээд, тэрийг хүрэх арга замтай нь, жишээлбэл эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн төвтэй нэгдмэл загварт шилжүүлж, чанар, үр дүнг сайжруулна гэж батлаад, яг тэрүүнтэй логик холбоотой олон улсын нэршлээр нь тусгайлсан KPI-тай нь хавсралт 3-аар баталсан.

Гэвч, гэвч юу байх вэ дээ ЗГ-ын оруулж ирж байгаа 27 оны төлөвлөгөө дээр яах аргагүй энэ хавсралт 3 нь тэр хавсралт 3 тэр чигээрээ яг логик дэс дарааллаараа зөв ороод ирчихсэн, их сайшаалтай, сайхан байна, баярлаж байна. Нуруу нь босчихвол ерөнхийдөө цаг хугацааны хувьд бид ерөнхийдөө юмаа янзлаад явчхаж болно. Гэхдээ хавсралт 2 нь энэнээсээ логик дэс дарааллын хувьд жишээлбэл яг адилхан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлнэ гэдэг үг, үсэггүй яг адилхан юм биччихээд, шалгуур үзүүлэлт, хийх арга нь дандаа барилга, байшин тавьчихсан байх юм. Энэ дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барина Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх гээд оруулаад ирчихээр яаж энүүгээрээ эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулаад, үр ашиг нь яаж нэмэгдээд байгаа юм бэ? Энэ нь тэр хавсралт 3-ынхаа логиктойгоо яаж холбогдох юм бэ барилгын гүйцэтгэлээр үзвэл? Энийг нэг зүгээр логикийн хувьд нэг ойлгогдох түвшинд энгийн хэлээр нэг тайлбарлаад хэлээд өгөөч.

Энэ барилга, байшин баригдсанаараа эмнэлгийн тусламж, үйлчилгээ сайжирчихна гэдэг хаана, хэн, юу гэж хэлээд, ямар эшлэл дээр үндэслэж энийг байнга оруулж ирээд, сүүлийн 2 жил яриад байгаа вэ гэдэг асуудал байна. Энэ үнэхээр тэр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ чанар сайжирчихсан уу барьсан барилгынхаа тоогоор жишээлбэл?

2 дугаарт энэнтэй бас нэг хамааралтай өвчлөл, нас баралтын бүтцийн тухай нэг асуудал байгаад байгаа юм. Бид бүгд мэдэж байгаа. Зүрх судасны өвчин, хавдар бол тэргүүлэх шалтгаан. Тэр дотроо эрэгтэйчүүдийн өвчлөл, тэр нь гол эрсдэлт хүчин зүйл нь архидалт, осол, амиа хорлолт, таргалалт гээд ингээд явж байгаа. Тэгэнгүүт бид хэд эрэгтэйчүүдийн дундаж наслалт, эмэгтэйчүүдийнхээсээ бараг 10 орчим бага байгаад, гол эрсдэлт хүчин зүйлийг нь тогтоогоод, гол өвчлөл, нас баралтын шалтгаанаа гаргачихсан юм бол яг тодорхойлон бодлогодоо эдгээр эрсдэлт хүчин зүйлийг бууруулах эрэгтэйчүүдэд чиглэсэн гол бодлого нь юу вэ гэдэг нэг асуулт байгаа?

Энэнээсээ яг бас нярайн эндэгдлийг ярихгүй өнгөрч чадахгүй нь маш эмзэг сэдэв. Олон улс биднийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хаана байгааг дундаж наслалт, нярайн эндэгдлээр үздэг. Ингээд харахаар зэрэг нярайн эндэгдэл, ерөөсөө нярайн эндэгдэл нь ч нэмэгдчихсэн, нялхсын эндэгдэл нь ч нэмэгдчихсэн, 5-аас доош насны хүүхдийн эндэгдэл нь ч нэмэгдчихсэн 50 дугаар хуудас дээр ил тод байна. Хүүхдийн хавдар 5 жил өссөн гэхийсэн байна. Тэгэхлээр энэ хүүхдийн өвчлөлийн өсөлтөд яг онцгойлсон бодлого юу гаргаж байгаа вэ? Бодлогоо мэддэг, чаддаг нярай, эх үрсийн эрүүл мэндийг гол нэг ганц, хоёрхон л төв байдаг. Энэ дээр ажиллаж байгаа, зангидаж байгаа мэдээ мэдээлэл, ажил хийж байгаа хүмүүс чинь чадаж байгаа юм уу юмаа? Чадахгүй байгаа бол яагаад энэ дээр тусгайлсан бодлого гаргаж, энэ дээр маш яаралтай арга хэмжээ авахгүй, нэг жил өнгөрөөгөөд л, 2 жил өнгөрөөгөөд л, одоо дахиад хэдэн жил харж суух вэ, хэдэн хүүхдээ алдъя гэж бодож байгаа юм бэ бид?

Тэгээд дээрээс нь энэтэй холбоотой эрдэм шинжилгээнийхээ бүх судалгааны төвүүдийг дэд захирлуудыг нь татаад буулгачихсан. Энийг бид хаанаас, яаж харж хянах вэ гэдэг дээр эхлээд асуултаа авчихъя, хариултаа.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Батшугар сайд хариулъя.

Э.Батшугар: Ганмаа гишүүний асуултад хариулъя. Эрэгтэйчүүдийн дундад наслалт 67,9 байгаа, эмэгтэйчүүдийнх 77 байгаа, 9,2 жилээр зөрөөтэй байгаад байгаа юм. Шалтгааныг нь судалж үзэхэд 30-аас 60 насны яг хөдөлмөр эрхлэлтийн насанд байгаа эрэгтэй хүн эмэгтэй хүнтэй харьцуулахад адилхан насны бүлгийн нас барах магадлал нь 4 дахин өндөр, магадал ч гэж дээ 4 дахин илүү нас бараад байгаа юм. Суурь шалтгаан нь та түрүүн хэллээ маш сайн мэдээлэлтэй мэдэж байгаа. Тэгэхээр яг энийг ямар байдлаар, бид яаж нэг ёсны засах вэ, яаж эрэгтэй хүмүүст илүү урт удаан амьдруулах вэ гэдэг дээр нэг том өөрчлөлт хийсэн. Тэр нь анхан шатны эмнэлгүүд дээр тулгуурлаад эрэгтэй хүний үзлэгийнх нь суурь зардлыг нь 111 хувиар нэмчихсэн. Нэг ёсондоо өрхийн эмнэлгүүд эрэгтэй хүнд тусламж, үйлчилгээ үзүүлээд, нөгөө хүнээ хяналтад байлгавал 30-аас 60 насны эрэгтэй хүнийг тэгвэл гүйцэтгэлийн санхүүжилт нь 111 хувиар нэмүүлчихсэн.

Тэгэхээр өрхийн эмнэлгүүддээ бид тулгуурлаж, энэ 550-иад өрхийн эмнэлгүүд байгаа. Бид улс орон даяар сүлжээд гэж ойлгож болно шүү дээ. Тэгэхээр улс орон даяар байгаа өрхийн эмнэлгүүд дээрээ эрэгтэй хүмүүсээ илүү хяналтад оруулаад, тэгээд магадгүй зүрх судасны өвчтэй байж магадгүй, даралттай байж магадгүй, тэрийгээ мэдэхгүй яваад байгааг үгүйсгэхгүй байна. Тэгвэл тэрийг нь тодорхойлоод, тодорхой хэмжээний эмийг нь өгөөд, эмчлээд явах нь хамгийн зөв гэж харж байгаа юм.

Нярай хүүхдүүдийн өвчлөл болон эндэгдэл бол өндөр байна. Ялангуяа өвчилчихсэн. Тэгэхээр бид ямар зүйл яригдаж төлөвлөж байгаа вэ гэхээр өнөөдөр Эх, нялхсын л төв байна, нэг яг дийлэнх ээжүүд, аавууд хүүхэд нь өвдөхөөр очдог. Тэгвэл бусад амаржих төвүүдээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болгомоор байгаа юм. Тийм бодлого явагдаж байгаа, тэгж байж төвлөрлийг сааруулна, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ илүү хүртээмжтэй болох бодлого явж байгаа шүү гэж танд хэлье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон, албан тушаал, нэрээ хэлээд хариулаарай.

Н.Эрдэнэбаяр: Ганмаа гишүүний асуултад хариулъя. ЭМЯ ТНБД Эрдэнэбаяр. Энэ юунууд дээр та бүхэнд тараагдсан материалууд дээр байгаа юмнууд дээр энэ яах вэ 2019 оноос хойш энэ эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах гээд төсөл хэрэгжиж байгаа юм байна лээ. Тэгээд энэ хүрээн дээрээ нөгөө орсон яг энэ бүтээн байгуулалттай холбоотой зүйлүүдээ илүү тусгаад өгчихсөн байгаа. Ер нь уг нь энэ дотор нэлээн олон ажил, хөтөлбөрүүд ингээд тусгачихсан боловч хасагдаад ингээд яг өнөөдрийн байдлаар энэ 21 арга хэмжээ гэдгээр ингээд явчихсан. Тэгэхээр бүхэлд нь харахаараа бас нэг ийм ганцхан барилга, байгууламж гэдэг юм шиг ийм ойлголт төрөөд байгаа. Энийгээ бид эрүүл мэндийг дэмжих жилийн төлөвлөгөө гэж 2027 он эрүүл мэндийг дэмжих жил болж байгаа. Тэгэхээр энэ жилийн хүрээнд бид төлөвлөлтийн ажлуудыг оруулж ирээд, саяын яг таны асуугаад байгаа энэ чиглэлийн ажлуудыг тусгаад ингээд явж байгаа. Энийг удахгүй энэ 5 сард багтаагаад, ЗГ-ын хурлаар хэлэлцүүлэх.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ганмаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: Өөрчлөх юм байна гэж ойлголоо. Энэ 2 дугаар хавсралт дээр жишээлбэл аягүй тэр логикийг нь ерөөсөө би ойлгохгүй байгаа гээд байгаа нь уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг өргөжүүлнэ гэж оруулж ирснээ, ард талд нь болохоор чинь зэрэг энд яаж байгаа вэ гэхээр хорт хавдрын эрт илрүүлэг, нярайн илрүүлгийн үзлэг энэ тэр гэж орж ирээд бүүр ерөөсөө хоорондоо учир холбоог нь ойлгохын аргагүй юм орж ирчхээд байгаа юм. Алдаа гарчихсан юм уу, яасан юм, засчих байх.

Сая тэр хүүхдийн нас баралт дээр, би нэг дундаж наслалтыг асуухгүй бол ерөөсөө болохгүй байна. Бас л манай дэлхий нийт ерөөсөө дундаж наслалтыг асуугаад байдаг. Дундаж наслалтаа харахаар зэрэг ийм 4 өөр тоо гарч ирээд байгаа юм л даа. 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд болохоор төрөлтөөс тооцсон дундаж наслалтаа 24 онд 71,8 гэгчихсэн, 25 оных нь хэд юм бэ? Эрүүл мэндийн хөгжлийн төв болохоор 72,07 гэж өгөөд, Монгол Улсын ЗГ болохоор дундаж наслалтаа 71,7 гэж өгөөд. Тэгэхээр ингээд яг зөв тооцоо нь яг аль вэ? Ялангуяа.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон.

Н.Эрдэнэбаяр: Ганмаа гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Тийм, энэ одоо яах вэ 25 оны тоон мэдээ албан ёсоор хэвлэгдээгүй байгаа юм гишүүнээ. Тэгэхээр энийг бид яг албан ёсны хэвлэгдчихсэн мэдээ мэдээллээр нөгөө Их Хурлын гишүүдийг хангах ёстой учраас 24 оны мэдээллээр яваад байгаа. Удахгүй яг ингээд хэвлэгдэж гарна. Энэ маань Статистикийн хорооноос бүх мэдээллүүд нь авагдаад, ингээд өрөлтөд орно гэдэг ийм мэдээлэл бидэнд ирсэн байгаа. Тэгээд бид яг энэ дээр жоохон өөрчлөөд орно гэж хэлж болно.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн алга байна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн алга байна. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн алга байна. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууна.

Р.Эрдэнэбүрэн: Оройн мэнд хүргэе.

Б.Пүрэвдорж: Энхцэцэг.

Р.Эрдэнэбүрэн: Минутаас яваад байна. Энхбаяр сайд жоохон хэлэлцэх эсэх явж байгаа учраас ерөнхийдөө юм асууя. 1 дүгээрт нь энэ он дамжаад хэрэгжих 128 төсөл 15 их наядын гэдэг чинь одоо худалдан авах чинь 5 сарын 10 дунд орж байхад 30 хүрэхгүй хувьтай явж байна. Тэгэхлээр 6 сарын 1 гээд Хэмнэлтийн хууль гээд зогсоно. Тэгээд энэ бол хэцүү байдалд руу орчхож байгаа. Тэгээд бидэнд олимпын найдвар хувийн хэвшил болж байна. Бүгдээрээ хувийн хэвшилдээ их аягүй итгэл найдвар хүлээлгээд дэмжье барья гэж эхэлж байна.

Хувийн хэвшлийг дэмжих хамгийн эхний ажил бол төрийн оролцоо тэр зөвшөөрөл өгдөг юмаа байхгүй болгох хэрэгтэй байгаа. Тийм ч учраас Ерөнхий сайд чөлөөлье гэдэг юу ярьж байх шиг байна. Тэгэхлээр энэ гарын үсэг зурдаг энэ журам чинь хүчингүй болохоос наана энэ явахгүй. Яагаад гэхлээр бүх, одоо энэ хэвээрээ хүчинтэй байгаа үед энэний эсрэг явбал тэр зурдаг хүмүүс чинь бүгд шоронд орно. Тийм учраас миний эхний асуулт юу гэж хэлэх гээд байна вэ гэхлээр яг энэ боловсруулах үйлдвэр ялангуяа, тэгээд энэ уул уурхай, аялал жуулчлал гээд энэ юм хийх гээд байгаа улсуудад өгдөг төрөөс өгдөг тэр зөвшөөрөл, гарын үсэг, энэ журам, хэчнээн журам байна вэ, хэчнээн хууль байна вэ? Ажлын хэсэг байгуулсан гэж байна. Тэгэхлээр энэ гаргачихсан байгаа байх гэж бодож байна.

2 дугаарт ийм юм хийж болохгүй юу? Энэ асуудал хэлэлцэгдэж батлагдахаас өмнө энэ 2005 онд Элбэгдорж Ерөнхий сайд байхдаа нэг бүх энэ гарын үсэг зурдаг журмуудыг нэг урж бариад л энэ тэр нэг хүчингүй болгож явж байсан юм. Тийм зүйл хийж болохгүй юу, бүгдийг нь хүчингүй болгочоод. Бүгдийг нь болохгүй байж болох байх, ялангуяа эрүүл мэндийн салбартай холбоотой юмнууд дотор бол байх. Ихэнхийг нь хүчингүй болгочоод ингээд явах, цаашаа энэ юугаа хэлэлцээд явах боломж байна уу гэж 2 дахь асуулт? Тэгэхгүй бол энэ хэрэгжих худлаа болно.

Ялангуяа ингээд боловсрол, юу боловсруулах үйлдвэр гээд овоо хүмүүс ярьж эхэлж байна. Яаж байна вэ гэхлээр бүх үйлдвэрүүд дээр, бүх юун дээр ихэнх нь гаднаас технологи, техник юм хум орж ирж байна. Тэгээд яаж байна вэ гэхлээр энийг бүгдийг нь орчуулж ир гэдэг Монгол хэл дээр, тэрний дараа батална, тэгж байж ажил эхлүүлэх зөвшөөрөл өгнө гэж байгаа юм. Тэгээд энэ чинь өөрөө хэдэн сар болдог юм. Тийм учраас бид энэ хувийн хэвшилдээ туслах хамгийн экстремист юм чинь хамгийн том тус бол энэ зөвшөөрлүүдийг өгдөг энэ маш олон журмуудыг хүчингүй болгох хэрэгтэй байна. Энэ юун дээр үе шаттай эд нар гэж байна. Тэгээд үе шаттай эд на гээд худлаа болно, бөөнөөр нь л бүгдийг нь байхгүй болгох.

Ер нь бид дэлхийн нөхцөл байдал чинь маш хүнд, сүүлийн 70, 80 жил болоогүй хүнд нөхцөлд байна гэж байна. Тэгээд энэ үед нь бид бүүр нэг өөр арга замаар явмаар байна. Бид чинь баахан 20, 30 жил гадагшаа яваад, өндөр хөгжилтэй орнуудад туршлага судалж ирээд, баахан нарийвчилсан хууль, журам хийчихсэн. Тэгээд өөрсдийгөө чөдөрлөчхөөд, одоо ингээд чөдөртэй морин дээрээ суучаад ташуурдаад байна шүү дээ гол проблем чинь.

Б.Пүрэвдорж: Эрдэнэбүрэн гишүүн нэг минут нэмж тодруулъя.

Р.Эрдэнэбүрэн: Зоригтой ийм алхам хиймээр байна. Тэгээд бид чинь гаднын ч байна уу, дотнын ч байна уу хөрөнгө оруулагчдыг ажил хийхээс нь өмнө баахан стандарт гаргаж тавьчихаад, баахан гарын үсэг зурах зөвшөөрөл хийчихээд, ерөөсөө

хийлгэхгүй байгаа байхгүй юу. Тэгэхлээр одоо яаж өөрчлөх хэрэгтэй байна вэ гэхлээр хэн хийж чадах нь хий, хамаагүй, тэгчхээд тодорхой хугацааны дараа 5 жилийн дараа нөхцөл байдал өөрчлөгдөөд ирэхлээр стандартчилал юм хумаа ингээд яриад явдаг тийм юм руу шилжиж болохгүй юм уу? Орж ирээгүй байхад нь, хийгээгүй байхад нь баахан дөнгө саад тавьчихаад, чөдөрлөхөөд ингээд суугаад байна. Тэгээд энэ талаар та юу гэж бодож байна вэ? Аялал жуулчлал гэж байна. Голын эрэг дээр кемп барьж болохгүй, дархан цаазтай газар кемп барьж болохгүй. Тэгээд хэзээ бид энэ дархан цаазтай газрыг чинь тэнд хөрөнгө оруулсан хүмүүс хамгаална гэдгийг ойлгох юм бэ?

Б.Пүрэвдорж: Шадар сайд Энхбаяр хариулъя.

Ж.Энхбаяр: Эрдэнэбүрэн гишүүний саналтай 100 хувь санал нийлж байгаа. ЗГ-ын бодлого чөлөөлөлт. Учралын ЗГ юу вэ гэвэл чөлөөлөлт. Энэ чөлөөлөлтийн нэг гол чиглэл энэ эдийн засгийн чөлөөлөлт, энэ хөрөнгө оруулалтын орчны чөлөөлөлт, энэ хувийн хэвшилд саад тотгор болж байгаа, худалдаанд саад тотгор болж байгаа, хөрөнгө оруулалтад саад тотгор болж байгаа энэ бүгдээс чөлөөлөлтийг хийнэ гэсэн зорилго. Чөлөөлөлт гэдэг үгэн дотор их юм багтаж байгаа. Үнэхээр энэ журам, зохицуулалт, зөвшөөрөл, баталгаажуулалт гэх нэрийн доор байгаа хууль давсан олон тийм хязгаарлалтууд олон байгаа. Бүх салбарт үүрэг өгөгдсөн, салбар болгонд чөлөөлөлтүүдийг эхэлж байгаа. Салбар болгон үйл ажиллагаагаа, хүнд суртлаа чөлөөлөлт. Хэн, хаана шинэчлэл хийж чадна, хэн гол нь чөлөөлөлт хийж чадна тэр сайдын ажлыг сайн гэж дүгнэж байгаа.

Сая энэ өнгөрсөн, одоо энэ өнгөрч байгаа энэ өвлийн хугацаанд бид хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах төв гэж байгуулаад, энэ бүхий л салбарыг хамарсан 13 долоо хоногийн ийм арга хэмжээг зохион байгууллаа. Үнэхээр бүхий л салбарт улс улсаар нь хөрөнгө оруулагчдаар нь гаргасан. Уулзалтыг зохион байгуулсан. Үнэхээр санаа зовмоор нөхцөл байдлууд үүссэн. Үнэхээр яаралтай хөрөнгө оруулалт, бизнесийн орчинд бид эрс өөрчлөлт хийхгүй бол бид яг энэ дээрээ гацаж байна. Эдийн засгаа өсгөө гэвэл бид энэ чөлөөлөлтийг л хийж байж урагшилна. Би нэг мэдээлэл болгоод 2 тоо хэлээдэхье. Нийт 4 мянган гадаадын хөрөнгө оруулалттай компани Монголд байнгын үйл ажиллагаа явуулж байна. Монголд 230, 13 мянган ААН бүртгэлтэй байгаа юм. 4 мянга нь гаднын үйл ажиллагаа. Гэтэл энэ 4 мянган ААН манай ААН-ийн орлогын албан албан татварын дүнгийн 24 хувийг $\frac{1}{4}$ -ийг бүрдүүлж байна. Цалингийн сангийн 15 хувийг өгч байна, НДШ төлөлтийн дүнгийн 18 хувийг гадаадын хөрөнгө оруулалттай компани төлж байгаа байхгүй юу. Ийм том боломж өгөөжийг бид дандаа хаасан боосон, хяхан боогдуулсан.

Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулалт гэдэг чинь ямар их том нөлөөлөл вэ гэдэг эндээс их тод харагдаж байгаа. Тэгэхээр энэ ГХО-дын эрх ашгийг хамгаалах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүрэг даалгаврууд өгөгдсөн. Энэ хаврын чуулганд бид Бизнесийн эрх чөлөөний тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Худалдаа зохицуулалтын хууль, Төрийн хяналт шалгалтын хуулийг Төр, иргэний хяналтын тухай хууль гэх мэтээр дандаа ийм либерал эдийн засгийн чиглэлийн хөрөнгө оруулалтыг дэмжсэн орчин бүрдүүлэх ийм хуулиудыг бид хурдан, хурдан оруулна. Сая бид Гадаадын зээл ашиглалтын гишүүдийн хууль сая уналаа. Сая бид өнөөдөр ажиллаад, сая өргөн бариад, маргааш Их Хуралд ЗГ-ын хуулийг өргөн барихаар сая бэлдээд дууслаа, оруулна. Ингээд хурдтай, шуурхай ажиллах хэрэгтэй. Тэгж байж бид энэ тулаад байгаа энэ

сорилтыг, хүндрэлийг амжилттай давна. Цаг нь болсон одоо. Бид бүгдээрээ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Наранцэцэгийн Алтаншагай, өөр хэн хариулах юм бэ? Тодруулчихсан. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуулт асууя.

Н.Алтаншагай: 2027 оны Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөг ярьж байгаа юм. 2027 онд Монгол гэдэг улс, Монгол гэдэг их айл яаж аж төрж, амьдран суух вэ гээд салбар салбартаа ингээд яригдаад эхэлж байгаа юм. Хэдэн асуух, тодруулах зүйлүүд байна. Энэ 5.1.4 дээр байна л даа. Энэ гадаад аялал, гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлэх гээд хоёрхон заалт байгаа юм. Би уншаад өгчихье. Нэг ийм юм байгаа юм. Орон нутагт болон нийслэлд цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх дэд бүтцийг үе шаттайгаар хөгжүүлэх, авто зам дагуух аялал жуулчлалын үйлчилгээний цогцолбор байгуулах. 2-т нь болохоор соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих гэж байгаа юм. Тэгээд төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр улсын төсвөөр ингээд 5 тэрбум төгрөг тавьчихсан. Иймэрхүү дүр зурагтай энэ яаж аялал жуулчлалыг хөгжүүлэх юм бэ? 27 онд гээд иймхэн юм хийчхээд, гадаадын хэдэн мянган жуулчид авна гээд байж байдаг 1 дүгээрт.

2 дугаарт ажлын байрыг яг бодитоор яг нэмэгдүүлэх тийм боломж, тооцоолол гарсан уу? Төр бол ажил олгогч биш шүү. Явж, явж яг хувийн хэвшил л ажил олгогч байгаа юм. ЗГ-аас өргөн барьсан энэ татварын багц хуулийг шинэчлэгдэж, энэ хүлээлт үүсгээд байгаа ААН, байгууллагууд, хувь иргэд рүү яг бодитоор орж чадах нь уу? Цаг хугацааны хувьд амжих уу? Өнөөдөр Гадаад зээллэгийн ашиглалтыг нэмэгдүүлэх тухай хууль Их Хурал дээр уналаа. Сэлбэ дэд төв маань цаашаага ямар нөхцөл байдалтай үргэлжлэх вэ? Барилга, хот байгуулалтын сайдаас энийг тодруулж байгаа.

Боловсролын сайдаас тодруулъя. Энэ боловсролын салбарт үүссэн энэ хүндрэлтэй нөхцөл байдал чинь илаарьших нь уу? Аливаа юм чинь хөгждөг дэвждэг, цаг хугацаагаараа энэ чинь бүгд сайжрах л ёстой гэсэн хүлээлттэй байгаа шүү дээ иргэд ч тэр, ААН ч тэр. Гэтэл тэгээд л өдрөөс өдөрт доошоо орж, хойшоо малтсан ийм л шийдвэрүүд байна, ийм л бодлогууд явж байна.

Эрчим хүчний сайдаас тодруулъя. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын явц байдал нь ямар байгаа юм бэ? 2026-аас 27 онд энэ Монгол Улсын эрчим хүчний одоо байгаа нөхцөл байдал дээрдэх юм уу, хэр хэмжээтэй төсөв, санхүү зарцуулагдаж байгаа юм бэ?

ХХАА-н сайдаас тодруулах зүйл байна. Энэ мах магнаг боллоо гээд 34 мянга, 30 мянга, 39 мянга гээд ийм маргаантай зүйлүүд байгаа. Энэ жил энэ мах бэлтгэл дээрээ, нөөц дээрээ яаж анхаарах юм бэ? ААН-үүд чинь бас тодорхой хэмжээний татаасуудыг авдаг шүү дээ. Банкны зээл, хөнгөлөлттэй зээл авч байгаа, килограмм тутамдаа хөнгөлөлт авч байгаа. Гэсэн мөртөө энэ махных нь нийлүүлэлт муу байна гээд гомдол гараад байдаг. Дараа нь тодруулъя.

Б.Пүрэвдорж: Боловсролын сайд Энх-Амгалан хариулъя.

Л.Энх-Амгалан: Манай Алтаншагай гишүүн чухал асуудал, хөгжлийн суурь асуудал хөндөж ярьж байна л даа. Үнэхээр үнэн л дээ. Өнөөдрийн энэ нийгэмд үүсээд байгаа ядуурал, ажилгүйдэл, энэ нийгмийн сэтгэлгээний доройтол ингээд

өнгөрсөн 30 жилийн манай боловсролын салбарын системийн хямрал болсны л үр өгөөж, /үг өгөөч/ гэдгийг би хаалт дотор хэлж байгаа юм шүү, нөхцөл байдал үүссэн гэдгийг бид их зөв оношлох ёстой юм байгаа юм. Тэгээд ганцхан сургууль, цэцэрлэгийн хүртээмжийн асуудлууд яриад, энэ асуудлыг шийдэж болохгүй. Тийм учраас энэ Монгол Улсын ЗГ-аас зарлаж байгаа энэ Монгол хүүхэд бүрийн мэдлэгийн хоцрогдол, Монгол хүүхэд бүрийн ур чадварын хоцрогдлоос чөлөөлье гэдэг энэ бодлогыг л бид зөв хэрэгжүүлэх ёстой юм байгаа юм. Тэгэхээр энэ бодлого чинь гэнэт тэнгэрээс буугаад ирчихсэн бодлого биш. Өмнөх ЗГ-ын мөрийн хөтөлбөр дээр урт болон дунд хугацааны хөтөлбөр дээр суурилж, ирэх 2 жилд бодитойгоор яг ард иргэдийн хүсэж байгаа энэ сургууль, цэцэрлэгийн хүртээмжийн асуудлууд, ингээд боловсролын чанарын асуудлыг л илүү анхаарах асуудал болчихоод байна шүү дээ.

Чанарын асуудал дотроо багш нарын асуудлуудыг, чанартай багш нарын асуудлуудыг бид үнэхээр нэг өөр түвшинд гаргахаас өөр бидэнд сонголт байхгүй гэж харж байгаа юм. Тэгээд Германы Ерөнхийлөгч Ангела Меркель /Angela Dorothea Merkel/-н хэлсэн үг бол өнөөдөр та боловсролдоо мөнгө зарвал маргааш шоронд бага мөнгө зарна шүү л гэж хэлсэн шүү дээ. Яг тэр л нөхцөл байдал өнөөдөр болчихоод байна. Тэгэхээр өнөөдөр хэдийгээр боловсролын салбарын хөрөнгө оруулалт 5,3 их наяд хүрээд, ингээд мэдээж гадаадын компани, гадаадын улс орнуудын адил ДНБ-ий 5 хувьд хүрчихсэн. Төсвийн урсгал зардлын 19, 20 хувьд хүрчихсэн. Яг энэ үзүүлэлтээрээ бид муугүй. Гэтэл өөрөө манай GDP өөрөө бага учраас нөгөө GDP-с авч байгаа тоонууд учраас бага байгаад байдаг. Ингээд дан ганц 5,3 их наядаар бид ингээд боловсролынхоо чанарын асуудлуудыг нэг дор өргөс авсан юм шиг шийднэ гэж байхгүй л дээ. Тийм учраас төсвийн эх үүсвэр биш, ганц төсвийн эх үүсвэртээ найдах биш, энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр санхүүжилтийн хэлбэр босгох.

Ер нь би Эдийн засгийн хөгжлийн сайдад ч гэсэн хэлж байгаа, Ерөнхий сайдад ч гэсэн хэлж байгаа. Боловсролын бондын асуудлуудыг бид босгох, энэ ирээдүйд хадгалж байгаа Ирээдүйн өв сангийн мөнгө 8 их наяд байна уу Энхбаяр сайдаа, 8 их наядын мөнгө. Ингээд энэ чинь Үндсэн хуулиар юугаараа бол энэ чинь 33, 33, одоо ба ирээдүйд энэ хүмүүс чинь байгалийнхаа баялгийг ижил тэгш хүртэх ийм зарчимтай шүү дээ. Тийм учраас энэ боловсролын салбарын санхүүжилтийн юуг олон эх үүсвэртэй болгох энэ чиглэл рүү бид ажиллах ёстой. Өнөөдөр би боловсролын салбарынхаа донорын уулзалтуудыг хийлээ бүх доноруудаа урьж. Тэгээд 2 жилд хийх гэж байгаа ажлуудаа танилцууллаа. Дахиад шаардлагатай байгаа 5 их наядын эх үүсвэрийг яаж босгох вэ гэдэг асуудлыг л.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Минийх чинь нэг минутаар явчихлаа шүү. Эрдэнэбүрэнгийн станц 2030 онд дуусах төлөвлөгөөтэй. Нийт, 27 онд 134 тэрбум төгрөгийг ашиглахаар гарсан. Нийтдээ 860 тэрбум төгрөгийн төсөвтэй ийм ажил. Энэ Эрдэнэбүрэнг явуулах гэж бид хэдэн жил алдав. Жил болгон бид ОХУ-д баруун аймгуудын төлбөрт 90 сая доллар төлж байгаа шүү дээ. Гэтэл энэ явуулахгүй гээд арваад жил маргаан, арай гэж хөдөлгөж байгаа. Үнэхээр харамсалтай. Тэгээд ийм мэтчилэн том төслүүд явах тусам цаана нь Монгол Улсын эдийн засагт үлдэх мөнгө, нөлөөлөл өндөр гарч байгаа юм шүү. Ийм учраас энэ төсөл, энэ ямар ч байсан гараасаа гарсан, асуудлыг нь шийдсэн, ажил нь цаашдаа ингээд явна.

Аялал жуулчлалын асуудлыг хөндлөө. Улсын хэмжээнд 800 мянган жуулчин авсан, энэ рекорд хийсэн. Бид чинь 40, 50 мянгаас хэтэрдэггүй байсан аялал жуулчлалтай байсан салбар шүү дээ. Цаг нь дуусчихлаа.

Б.Пүрэвдорж: Гишүүдээ дуудмаар байна, гишүүд ерөөсөө орж ирэхгүй байна. Ер нь энэ залуу гишүүдэд нэг зүйлийг хэлэхэд энэ асуулт асууж байгаа энэ олон Их Хурлын гишүүд тойрог, орон нутагтаа маш их ажиллаж, тэдний санал бодлыг маш их уламжилж ярьж байгаа. Тэнд нь сайдууд хариулж байгаа. Улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой маш чухал, чухал асуулт, хариултууд энд явагдаж байгаа. Үүнээсээ маш их олон мэдээллийг уул нь өөрсдөө авдаг юм л даа. Тэгсний үр дүнд сайн парламентач болдог л юм байгаа юм. Тэгээд би сая Батнайрамдал гишүүнийг энд хүлээж бай гэсэн чинь гараад явчих шиг боллоо.

Тэгэхээр би Батнайрамдал гишүүний нэг асуултад хариульа гэж бодож байна. Ер нь ОТ нийтдээ 11,2 хувийн хүүгээр зээл авч, маш их ашгийг тэр зээлийнхээ өөрөөр хэлбэл Рио Тинто гэж компани дэлхийн зах зээл дээрээс 4,5 хувийн хүүтэй зээл босгодог, бонд босгодог. Тэгээд наашаа ОТ-д өгөхдөө 11,2 болгож, хамаг ашгийг нь тэр зээлийн хүүгээр олдог гэдэг ийм ойлголт надад байгаа. Тийм учраас би энэнд нь жоохон дургүй хүрдэг. Тийм учраас ОТ-н Түр хорооны хурал дээр 11 сард би энэ ОТ-н авч байгаа зээлийг SOFR нэмэх нь 3 буюу 6,5-аас дээшгүй байх ёстой гэдэг ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан юм. Энэ нь юу гэж байна вэ гэвэл Рио Тинто компанийн 4,5 дээр нэмэх нь 2 буюу 6,5-аас дээш гарах ёсгүй гэдэг ийм л зарчмын зөрүүтэй ганц санал гаргаад, үүний үр дүнд зээлийн хүү буурна.

Өөрөөр хэлбэл ОТ-н Түр хорооны тогтоол тодорхой дүнтэй, тодорхой шаардлагатай байх ёстой байхгүй юу. Өнөөдрийн Батнайрамдалын яриад байгаа нэг ийм мөлгөр тогтоол гаргачхаад, түүнийгээ яриад байдаг шиг биш, яг дээд тал нь 6,5 байна гэдэг ийм л зарчмын зөрүүтэй саналыг би гаргасан. Гэвч харамсалтай нь Батнайрамдал унагаасан. Тэгээд яагаад миний саналыг унагаачхав гэхээр энэ арай хэтийднэ хатуудна гэж. Ер нь жоохон төр хатуу байж, парламент хатуу байж, энэ ЗГ-т тодорхой ташуур өгч, энэ зээлийн хүүг буулгах ёстой гэж би үздэг. Хэрвээ миний энэ зээлийн хүүгийн дээд хэмжээ 6,5 байсан бол жилд төлж байгаа ОТ-н 4,7 их наяд төгрөгийн 2,2 их наяд нь хэмнэгдэх байсан байхгүй юу даа. Тэгээд өнөөдөр ингээд нэг жижиг улс төр хийгээд ингээд яваад байгаа юмнаасаа болиорой гэж Батнайрамдал залуу гишүүнд хэлье. Аялал жуулчлалын асуудлаар Энхбаяр сайд хариульа.

Ж.Энхбаяр: Аялал жуулчлал маань салбар маань өсөлттэй байгаа 800 мянган жуулчин авсан. Бидний барьсан Чингис хаан нисэх буудал маань үндсэндээ хүчин чадал нь тулсан. Өнгөрсөн жил 2,4 сая зорчигч агаарын тээврээр авсан, хүчин чадлаасаа 3 дахин хэтэрсэн гэсэн үг. Одоо дараагийн дэд бүтцийг 8 ийм гарцтай нисэх буудлаа бид нэмээд, 11 гарц нэмж хийхээр ингэж 19 гарцтай болгохоор өргөтгөх ажлыг хийж байна. Түрүүний хэлсэн 4 аймгийн төвд том онгоц буух, олон улсын рейсийг шууд хүлээж авах ийм зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангаж, энийгээ төр, хувийн хэвшил хэрэгжүүлэх бололцоотой ийм төсөл болгож байгаа. Аялал жуулчлал дээр тэр юунууд байна, энэ цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх энэ дэд бүтцийг үе шаттай хөгжүүлэх, авто зам дагуух аялал жуулчлалын үйлчилгээний цогцолборуудыг байгуулах ажлыг түншлэлээр хэрэгжүүлэхээр

тусгасан. Одоо ингээд жуулчид явж байгаа бүх маршрут дагуу амрах, хооллох.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: БХБ-ын сайд Бат-Амгалан хариулъя.

Э.Бат-Амгалан: Сэлбэ төсөл өнөөдөр Их Хурал дээр уналаа. Харамсалтай байна. Би тантай санал нэг байгаа. Сэлбэ төсөл манай яаманд харьяалалгүй, нийслэл Улаанбаатар хот бонд босгож, тэнд 10 орчим мянган айлын орон сууц барихаар ингээд явагдаж байгаа. Ийм төслүүд ер нь цаашдаа Улаанбаатар хотод, Монгол Улсын аймгийн төвүүд, сумын төвүүдэд олон ашиглалтад орох хэрэгтэй гэж би бодож явдаг хүн. Цаашдаа тантай санал нэг байгаа зүйл нь төр өөрөө бизнес эрхлэгч биш, харин бизнес эрхэлж байгаа улсуудад бизнес эрхлэх боломжийг нь олгох энэ чиглэлээр хамтарч, төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллаж явах ёстой гэж бодож байгаа. Цаашдаа одоо манай салбарт гэхэд 100 гаран мянган ажилтан, албан хаагчид ажиллаж байна. Энэ 100 гаран мянган барилгын салбарынхныг энэ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ганзоригийн Лувсанжамц гишүүн асууя.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. Бид зөв төлөвлөж байж, зөв хөгжинө. 5 жилийн үндсэн чиглэлийг хагас жилийн өмнө баталсан. Үүний 4 дүгээр хавсралтаар нийтдээ 70 их наяд төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ гэж тусгасан. 2027 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний 2 дугаар хавсралтаар нийт 65 их наяд, тухайн жилдээ 15,3, улсын төсвөөр 2,2, гадаад зээлээр 4,7 их наядыг зарцуулахаар тусгасан байна. Төлөвлөж чадаж байна уу, 5 жилдээ 70 их наяд гэхээд нэг жил дээрээ 65 их наяд гэж ороод ирэхлээр эрэмбэлээд, эрэмбэлээд, үр дүнгүйнүүдийг нь хасаад, хасаад ийм л болж байна уу? Ямар аргачлалаар энэ төслүүдийг 2 дугаар хавсралтад тусгасан бэ гэдэг эхний асуулт?

2 дугаарт энийг байнга ярьж байгаа. Бид эрүүл мэнд, боловсрол, эрчим хүчний салбартаа анхаарах ёстой, ийшээгээ л төсөл, арга хэмжээгээ хэдэн жил гүрийгээд хөрөнгө оруулалтаа хийгээд явах ёстой. Улсын төсвөөр боловсролын салбарт 400 тэрбум, эрүүл мэнд 330, эрчим хүч 84-хөн, зам дээр 473 тэрбум. Гадаад зээлээ оруулбал боловсрол дээр байхгүй, эрүүл мэнд 154, эрчим хүч 682, зам дээр дахиад л 415 тэрбум төгрөгийг тусгасан байгаа. Замын хөрөнгө оруулалт нь боловсрол, эрүүл мэнд 2-ыг нийлүүлснээсээ их байна. Эрчим хүчний салбар үндсэндээ гадаад зээлээр л хэрэгжихээр байна. Энэ салбар гадаадаас зээл авч байж л хөгжих юм уу?

Алсын хараа, 5 жилийн үндсэн чиглэл дээр байгаа зорилго, зорилтдоо нийцүүлээд энэ салбаруудын хөрөнгө оруулалтын харьцааг тооцож чадаж байна уу? Яамнуудаас өгсөн санал нь ийм байна уу, эсвэл Эдийн засгийн хөгжлийн яаман дээр ийм болгож хуваарилж байна уу?

3-д хэмжиж чадахгүй бол удирдаж чадахгүй. 5 жилийн үндсэн чиглэлд туссан 361 зорилго зорилт, эдгээрийн 74 хувь нь шалгуур үзүүлэлтийн 516-аас 76 хувь нь жилийн төлөвлөгөөнд туссан. 123 зорилго зорилтыг хасчихсан байгаа юм, яагаад хассан бэ? 5 жил, жилийн төлөвлөгөө, төсөв эд нар бүгд адилхан байх ёстой. Тэгж байж бид үр дүнд суурилсан засаглалыг бий болгоно. Төлөвлөж чаддаг, төсөвлөж чаддаг, хяналт үнэлгээгээ ч энүүгээрээ ашиглаад хийх боломжтой болно.

Эдийн засгийн хөгжлийн яамнаас асууя. Өөрийн яамны 15 шалгуур үзүүлэлт 5 жилийн үндсэн чиглэл дээр байгаа, энэнээс 9-ийг нь хасчихсан байна. Эндээс хүнсний инфляцыг тогтвортой барих зорилт байсан. Махны үнэ өсөөд, иргэдийн амьжиргаа хэцүү байгаа энэ үед энэ үнийн огцом өсөлтийг тогтворжуулах бодлогоосоо ухрахаар харагдаж байна. Дээрээс нь хөгжлийн бодлого, төсвийн уялдааг сайжруулна гэсэн заалт байсан, бас хасагдсан байна. Бодлого хэрэгждэг, үр дүнд хүрдэг байх ёстой. Яагаад ийм шалгуур, чухал шалгуур үзүүлэлтүүдийг хассан бэ?

Эрүүл мэндийн сайдаас асууя. 1.2.1.4 таван жилийн үндсэн чиглэл дээр байгаа. Зах зээл дэх чанаргүй хууль бус эмийг бууруулах зорилтыг тусгасан. Энийг хассан байна.

Хот байгуулалтын сайдаас асууя. 6.2.3.1 дээр барилгын дулаалга, ногоон барилгуудын нийлүүлэлтийг ихэсгэх, барилгын гэрчилгээ авахад, үл хөдлөхийн гэрчилгээ авахад ногоон барилга байвал давуу тал үүсгэдэг гэсэн ийм чухал заалтуудыг мэргэжлийн хүний хувьд тусгасан. Дахиад л хасаад ороод ирсэн. Яагаад вэ?

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хамгийн сүүлд нь асууя. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд энэ жилийн төлөвлөгөө сайн нийцсэн байна гэж байна. Төлөвлөгөө таван жилийн үндсэн чиглэлийн зорилтот шалгуур үзүүлэлтүүдийн 27 оны түвшнийг хангах хүрээнд боловсруулсан байна гэж байна.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Шадар сайд Ж.Энхбаяр хариулъя.

Ж.Энхбаяр: Их чухал зүйл ярилаа. Үнэхээр энэ үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт манай энэ үндсэн удирдлагын бүрэлдэхүүн хэсэг болж байгаа. Энэ одоо өнгөрсөнд дүн шинжилгээ хийгээд, ирээдүйд төлөвлөх үйл явцыг л хийж байгаа. Энэ дээр манай Лувсандорж гишүүн маш үнэтэй хувь нэмэр орууллаа. Энэ нэгдмэл цогц, харилцан уялдаатай судалгаа шинжилгээтэй, баримтат нотолгоонд үндэслэсэн, үүрэг хариуцлага тодорхой байдаг буюу хэмжигдэхүйц, бодитой, хамааралтай, хугацаатай байх гээд ийм зарчмууд үндсэндээ мөрдөж эхэлж байна. Энэ манай парламентын их том дэвшил шүү дээ. Өмнө бид ерөнхийлөөд улс төрийн үр дүн тавиад явдаг байсан бол одоо илүү ажил хэрэгч, бодит салбарын үр ашигтай байдлыг 1 дүгээрт тавьдаг болсон, ТЭЗҮ шаарддаг болсон. Энэ манай энэ төсвийг болон төсвийн сахилга батыг бий болгоход үнэхээр томоохон үүрэг гүйцэтгэж байна.

Таны асуулттай холбоотой 5 жилийн үндсэн чиглэлд 362 үр дүн, 516 шалгуур үзүүлэлттэй батлагдсан. Тэгэхээр улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд бид 27 онд 268 үр дүн, 393 шалгуур үзүүлэлт туссан байгаа. Хугацаа болоогүй 8 үр дүн, 8 шалгуур үзүүлэлт байгаа. 94 үр дүн, 123 шалгуур үзүүлэлтийг тусгаагүй. Эдгээр нь яагаад гэвэл үр дүн, шалгуур үзүүлэлтийн зарим нь санхүүжилт шаардахгүй, зарим нь урсгал зардлаар санхүүжээд үр дүн гарах бололцоотой гэж үзсэн тул гол шалгууруудаа ингээд авсан.

4 дүгээр хавсралтын тухайд 88 төслийг бүрэн тусгаад явж байгаа. Энд 5 жилийн төсөл бол улсын хөрөнгө оруулалтын том төслүүд 88 төслийн санхүү нь олдчихсон, ТЭЗҮ хийгдчихсэн төслүүдийг баталсан. Босго их өндөр болсон гишүүдээ. ТЭЗҮ батлагдаж байж, эх үүсвэр нь шийдэгдэж байж, УИХ-ын ажлын

хэсэг дээр нь тухай танилцуулагдаж байж, энэ хөгжлийн бодлого дээр нэмэгдэх бололцоо бүрдэж байгаа. Тэгэхээр бас шинэ төслүүд гарна шүү дээ амьдрал баян болохоор хөрөнгө оруулалтууд шийдэгдээд ирвэл ийм агуулгаар дэмждэг ийм болсон. 27 оны жилийн, ер нь жилийн төлөвлөгөөний төслүүд тухайн жилдээ хамгийн тэргүүлэх чухал гэдэг төслүүдээ эрэмбэлээд байгаа төсвийнхөө эх үүсвэртээ тааруулж ингэж эрэмбэлж оруулж ирж байгаа.

Хэрвээ санхүү, ТЭЗҮ нь бэлэн болбол төслүүд дараа нь нэмэгдэх, ажлын хэсэг дээр нэмэгдэх бололцоотой. Зам дээр хэрэгжиж байгаа төслүүд нэлээн хасагдаж байгаа. Хэрэгжиж эхэлсэн замын төслүүдийг ч гэсэн хассан. Нийт хэрэгжиж байгаа 17 төслийг хассан. Энэ дээр нөгөө эрэмбэ. Одоо бидний хамгийн гол барих юм бол энэ төслийн тухайн салбарын төсөвт эзлэх хувь хэмжээ, зохистой хэмжээг. Тэргүүлэх чиглэл нь аль юм бэ гэж, ТЭЗҮ бэлэн болсон гэдгээрээ бид дэд бүтэц рүү хийгээд, хөрөнгөө зарцуулаад байвал эргэн төлөгдөх хугацаа, эргээд нөгөө төсөвт, эдийн засагт үзүүлэх ач холбогдол нь дутуу сул байдаг. Иймд илүү ач холбогдолтой, эдийн засгаа дэмжсэн ийм шаардлагатай тэргүүлэх төслүүд дээрээ онцгой анхаарч оруулсан байгаа.

Б.Пүрэвдорж: Бат-Амгалан сайд хариулъя.

Э.Бат-Амгалан: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн төсөлд байгаль орчин, ногоон эдийн засгийн бодлогын хүрээнд хэлэлцэгдэх салбарын хэмжээнд ногоон барилгын шалгуур буюу best гэрийг нэвтрүүлэх зорилтууд тусгагдсан байгаа. Гэвч жилийн гүйцэтгэлийн KPI-р тусаагүй шалтгаанууд нь журмын хэрэгжилт ба стандартын шинэчлэлийн хүрээнд ногоон барилгын үнэлгээний аргачлалыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам 24 оны 12 дугаар сард, харин хялбаршуулсан аудиторыг нь 2025 оны 6 дугаар сард баталгаажуулсан байгаа. Тиймээс суурь үзүүлэлтүүд бүрэн гараагүй байгаа. 2026-аас 2030 оны төлөвлөгөөнд тусгах судалгаа үргэлжилж байгаатай холбоотой гэж та ойлгож болно.

Б.Пүрэвдорж: Батшугар сайд хариулъя.

Э.Батшугар: Эмийн чанарын асуудал үнэхээрийн маш чухал асуудал, бараг үндэсний аюулгүй байдлын түвшинд яригдах асуудал байгаад байгаа юм. Тэгээд бид бодит үнэнтэй нүүр тулах ёстой л доо яг үнэндээ. Тэр нь юу вэ гэвэл өнөөдөр бид яг нарийвчлалтайгаар эмийн стандартаа шинжлэх тийм лаборатори Монголд байхгүй, байхгүй. Яг биохими, молекулын түвшинд, ямар түвшинд энэ эм хуурамч уу, үгүй юү, аль эсвэл үйлчлэл хуурамч биш, тэгэхдээ хүнд үйлчлэх үйлчилгээ нь сул уу гэдгийг нь тодорхойлж чадахгүй байгаад байгаа юм. Үүнтэй холбоотойгоор нэг сайн мэдээ байгаа. Тэр нь ДЭМБ-ын санхүүжилтээр 6 сард яг эмийн лаборатори ашиглалтад орж байгаа юм. Энэ лаборатори нь GMP, GLP, мөн ML-3 гэсэн олон улсын эмийн стандартын дагуу тийм лаборатори ашиглалтад орж байгаа. 4 мянган эмийг жилд шинжлэх чадалтай. Тэгэхээр бид яг нарийвчилсан биохими бүх.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Манай Лувсанжамц гишүүнд бид талархах ёстой. Сая Энхбаяр сайд ч гэсэн хэллээ. Ер нь энэ улсын төлөвлөгөө батлахад арай нэг тийм шинэ соёл бий болгож байгаа, нэвтрүүлж байна гэж хэлж болно. Энийг бид талархах

ёстой. Тэгээд Лувсанжамц гишүүн яг манай боловсролын салбар дээр ганцхан 506 тэрбум төгрөг бас биш, энэ жил санхүүжих дүн нь 506 тэрбум төгрөг, АХБ-аар санхүүжиж байгаа 130 сая буюу 588 тэрбум төгрөг, орон нутгийн хөрөнгөөр, орон нутгийн эх үүсвэрээр 257 тэрбум төгрөг гээд 1,3 их наядын бодитой хөрөнгө оруулалтууд энэ 26 онд хэрэгжих ийм бололцоонууд нь байгаа. Энэ дээр 156 сургууль, 114 цэцэрлэг, 35 дотуур байр, 20 спорт заал гэсэн ийм санхүүжилтийн эх үүсвэрүүд байгаа гэдгээ би хэлье. Тэгээд та нөгөө 506 гээд нэг тоо яачих шиг боллоо, энийг нэг залруулах ёстой.

Б.Пүрэвдорж: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс индрийн 3 дугаар микрофон дээр хариулъя.

Ж.Дэлгэрсайхан: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дунд хугацааны 5 жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй нийцтэй байна гэсэн дүгнэлтийг өгсөн. Энэ дүгнэлтийг өгсөн шалтгаан нь үндэсний 10 үр дүн, түүний шалгуур үзүүлэлтийн хүрээнд энэхүү 27 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдсан гэдэг энэ шалгуураар бид тавьсан. Гэхдээ зөвлөлийн дүгнэлт дээр бид нэмээд эдгээр үндэсний үр дүнгүүдийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Ядуурлын хамралтын хүрээ, дундаж давхаргыг эзлэх хувийг зорилтот түвшнийг тодорхойлоогүй, зарим үзүүлэлтийн хувьд суурь түвшнийг нь тооцох шаардлагатай гэсэн ийм сул талууд байгааг бас дурдаж өгсөн. Тэгэхээр яг үндэсний үр дүн болон түүний шалгуур үзүүлэлтийнхээ хувьд энэ 2 хөгжлийн баримт бичиг хоорондоо яг нийцэж байгаа гэдгийг бид нийцтэй байна гэдгээр дүгнэсэн. Анхаарах зүйлс байгаа гэдгийг бид дүгнэлтээ дурдсан. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя.

Г.Лувсанжамц: Тодорхой хариулсан сайд нартаа баярлалаа. Ингээд хэдүүлээ яг бодлогын мэтгэлцээн хийдэг, үр дүн дээрээ суурилж чадаж байна уу, үгүй юү, энэ дээр бичигдээгүй байгаа мэдээллүүдийг манай сайдууд маань тодорхой хэлж өгч байгаа болохлоор ийм л зорилготой УИХ байх ёстой, ийм л зүйлийг хэлэлцдэг байх ёстой. Хэрүүл уруул бид ярьж болохгүй. 5 жилийн үндсэн чиглэл, 4 жилийн хөтөлбөр, жилийн төлөвлөгөө, жилийн төсөв эднийхээ шалгуур үзүүлэлтийг бид яг нэг л болгох ёстой. Тэгэхлээр 27 оны хөгжлийн төлөвлөгөөний ажлын хэсэгт орохоор, орж ажиллахаар саналаа өгч байгаа. Эд нарыг бүгдийг нь ижилсүүлнэ.

Сангийн сайдад анхааруулж хэлмээр байна. Намар төсөв өргөн барихдаа дахиад энэ 5 жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтүүдийг хасдаг ч юм уу, өөрчилдөг ч юм уу оруулж ирж болохгүй. Тавьсан зорилго зорилтоосоо ерөөсөө ухарч болохгүй, эндээ хүрэхийн төлөө л бодлогоо боловсруулдаг байна, түүнийгээ хэрэгжүүлдэг байна. Үр дүнгээ хянадаг, үнэлдэг байх ёстой шүү.

Б.Пүрэвдорж: Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууя.

М.Энхцэцэг: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд ашгүй Эрчим хүчний сайд маань өнөөдөр байна. Эдийн засгийн байнгын хороон дээр байхгүй байсан. Тэгэхээр хэд хэдэн асуулт асууя. 1 дүгээрт болохоор өмнөх онуудын төлөвлөгөө дээр байсан нэлээн олон ажлууд энэ төлөвлөгөө дээр байхгүй болчихсон байна. Энэ яг ямар учиртай юм бэ? 1 дүгээрт нь Эгийн голын УЦС, Байдрагийн УЦС, тэгээд төвийн бүсэд 100мвт-ын ус хуримтлуурын УЦС барина гэж

байсан, мөн ДЦС 3-ыг өргөтгөнө гээд л бид бүхэн чинь зүгээр жигтэйхэн хууль УИХ оруулаад л байсан, тэр маань бүр ор тас байхгүй байна. Дээрээс нь бид чинь ДЦС 3-ын 50мвт-ын том станцыг бүр ингээд шатаагаад байхгүй болгочихсон. Тэрийг чухам энэ 27 ондоо хийх юм уу, хийхгүй юм уу? Та бүхний төлөвлөгөө дээр байхгүй байна. Тэгэхээр энэ ажлууд ямар үндэслэлээр энэ жилийн төлөвлөгөөнөөс хасагдсан юм бэ? Тэрийг нэг тодорхой хариулж өгөөч.

2 дугаарт нь Ерөнхий сайд 5 аймагт нарны том эх үүсвэр барина гэж зарласан. Та бүхэн ингээд дуудлага худалдааг нь өчигдөр ингээд зарлачихсан байх шиг байна лээ. Тэгэхээр энэ Ерөнхий сайдын 5 аймаг бол бас л энэ 27 оны төлөвлөгөө дээр 1 дүгээрт байхгүй байна. 2 дугаарт нь энэ 27 оны төлөвлөгөө дээр 6 аймаг дээр 115мвт-ын нарны станцын auction зарлана гээд биччихсэн байна. Тэгэхээр энэ Ерөнхий сайдын яриад байгаа төсөл, энэ төлөвлөгөө дээр байгаа төсөл 2 ялгаатай төсөл үү? Өөрөөр хэлбэл та бүхэн Ерөнхий сайдын яриад байгаа 5 аймаг, тэр эрчим хүчний энэ 27 оны чинь төлөвлөгөө дээр байгаа 6 буюу 115мвт гэхээр нийтдээ 11 төслийг, нарны төслийг зарлах гээд байгаа юм уу? Энийгээ нэг тодорхой болгож хэлээч.

Дараагийн асуулт нь болохоор мөн энэ төлөвлөгөө дээр айл өрхүүдийг нарны эх үүсвэртэй болгоно гэсэн байна. Тэгээд хэмжих нэгж дээр нь мянган квт гэсэн байна. Ерөнхий сайд хэд хоногийн өмнө 10 мянган айл гэж мэдэгдсэн. Тэгэхээр энэ дээр та бүхэн яг аль нь үнэн яриад байгаа юм бэ? Эсвэл тэр 10 мянган айл гээд Ерөнхий сайд л худлаа яриад байгаа юм уу, эсвэл та бүхний тэр 1000 квт гэдэг нь зөв юм уу? Энэ 2-ын тоо нь чухам аль нь зөв юм бэ? Энийг ингээд залруулж хэлээч.

Дараа нь мөн Ерөнхий сайд ирэх онд энэ айл өрхүүдийн нарны тархмал эх үүсвэрийг дэмжихийн тулд ногоон зээлийн хүүг бууруулна гэсэн. Тэгэхээр та бүхэн яг ямар механизм хэрэглэж одоо байгаа ногоон зээлийн хэд байгаа хүүг ирэх онд та бүхэн хэд болгож бууруулах юм бэ? Тэр төлөвлөгөөгөө та бүхэн танилцуулаач.

Дараагийн нэг асуулт нь болохоор ЭХЯ-ны Стратеги бодлого, төлөвлөлтийн хэлтэс гэж байдаг. Энэ төлөвлөлтийн хэлтсийн үндсэн том үүрэг функц юу вэ гэхээр мэдээж салбарын бодлогыг боловсруулах, салбарын хууль эрх зүйн орчин, дүрэм журмыг боловсруулах, стандартыг боловсруулах ийм үүрэгтэй. Өнөөдөр та бүхэнд би өмнөх хурал дээр хэлж байсан, цахилгаан байгууламжийн дүрэм, нэгдсэн сүлжээний дүрэм сүүлийн 10 жил шинэчлэгдээгүй. Өөрөөр хэлбэл энэ таны алба чинь ямар ч ажлаа хийхгүй байна. Эрчим хүчний тухай хууль чинь 2001 оноос хойш 25 жилийн хугацаанд шинэчлэгдээгүй. Арай ядан ингээд бүтэн жил ажиллаад Найдалаа сайд өөрөө оролцоод, бүтэн жил хамт суугаад боловсруулсан дулааныхаа хууль дээр санал өгөхгүй 2 сар дараад хэвтчихсэн. Тэгэхээр яаж ийм байдлаар чинь энэ салбар хөгжих юм бэ?

Тэгтэл энэ Дулааны хуулийн чинь гол цөм нь таны өчигдөрхөн яриад байсан тэр дулааныг тоолдог болно, тоолууртай болгоно, хувийн хэвшлийн оролцоог дэмжинэ, төрийн оролцоог багасгана гэсэн гол концепц чинь энэ Дулааны хууль дээр явж байгаа юм. Гэтэл ингээд өөрсдөө хуулиа боловсруулахгүй, УИХ-ын гишүүдийн боловсруулаад өгсөн хуульд санал өгөхгүй 2 сар ингээд дараад хэвтчихэж байгаа юм. Тэгэхээр ийм асуудлуудаар хариулт өгөөч. Хэзээ тэр та бүхэн цахилгаан байгууламжийн дүрмээ шинэчлэх юм бэ, хэзээ тэр сүлжээнийхээ дүрмийг шинэчлэх юм бэ? Бүүр та бүхний өмнөөс бараг нийгмийн өмнөөс ичиж байгаа байхгүй юу.

Б.Пүрэвдорж: Найдалаа сайд хариулъя.

Б.Найдалаа: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Тэр таны дурдаад байгаа энэ ирэх жилийн хөгжлийн төлөвлөгөөнд ороогүй гэгдээд байгаа зүйл нь Эдийн засгийн хөгжлийн яаман дээр ажлын хэсэг томилогдоод ажиллаад, санхүүжилт нь тодорхойгүй гэдэг үндэслэлээр хасагдсан байгаа. Тэр тархмал, 5 аймагт хэрэгжих нээлттэй дуудлага худалдаагаар хийж байгаа төслүүд болон хувийн хөрөнгө оруулалттай төслүүд бол энэ төлөвлөгөөнд орох шаардлага байхгүй. Төсөвгүй, хувийн хөрөнгө оруулалтаар хийх учраас шаардлага байхгүй юм. Тийм болохоор тэр төслүүд ямар ч саадгүйгээр энэ бичиг баримтад орох шаардлагагүйгээр хэрэгжээд явна.

Стратеги бодлого, төлөвлөлтийн юм асууж байна. Энэ дээр таны асуулт яг зөв байна. Эрчим хүчний салбар одоо салбараараа нэг тийшээ харах ёстой байгаа. Салбар нь нэг тийшээ хараагүй бол яаж энэ танхимд 126 гишүүн нэг тийшээ харах юм, яаж бодлого батлах юм, яаж төсөв батлах юм, яаж төлөвлөгөө батлах юм. Тэгэхээр бид ажиллаад, харин бүүр сайн ажилласан гэж үзэж байгаа манай яамны залуучууд. Эрчим хүчний, ногоон шилжилтийн стратегийн эхний төслийг нь гаргасан байгаа. Одоо үүнийг мэргэжилтнүүдээс саналыг нь аваад, мөн ЗТЯ, УУЯ, магадгүй ХХААЯ-тай хамтраад Монгол Улсын ногоон шилжилтийн стратегийг гаргах ёстой байгаа юм.

Магадгүй энэ бичиг баримт бид амжвал, хэлэлцэж дуусвал Монгол Улсын СОР 17 дээр гаргах бас нэгэн бодлогын чухал мессеж болно. Тэгээд энэ дээр маш тулгуу ажиллаж байгаа. Энэ төлөвлөгөө гарсны араас, нөгөө бидний ярьдаг хөрөнгө оруулалтууд, шугам сүлжээ, дэд бүтэц, эх үүсвэрүүд, хаана, юу барих юм гээд тов тодорхой болох учраас хөрөнгө оруулалт татахад маш чухал бичиг баримт юм. Тэгээд тантай энэ дээр санал нэг байна.

Ногоон зээлийн хувьд ногоон зээл бол бага хүүтэй гэж үзэж байгаа. Бага хүүтэй эх үүсвэрийг ер нь гаднаас босгож авчирдаг. Гаднаас босгож авчраад, тэр долларын гадаад валютын эх үүсвэрийг ханшийнх нь эрсдэлийг хүлээгээд Монголд оруулбал, яг тэр бодлого хэрэгжүүлж чадвал бид бага хүүтэй ногоон зээлийг өгөх боломж байгаа. Ногоон зээлийг 3 түвшинд хувааж байгаа юм л даа. 1 дүгээрт яг энэ том төслүүд дээр хөрөнгө оруулалт байдлаар, 2 дахь нь банкнуудаар дамжуулаад, Хөгжлийн банкаар дамжуулаад бизнесийнхэнд дотоодын бизнесийнхэнд, 3 дахь нь яг иргэдэд дулааны тоолуур, хашаандаа тавьж байгаа нарны панел, өөр юу байдаг юм, яг тэр эрчим хүч хэмнэж байгаа, шинэ эрчим хүчийг нэвтрүүлж байгаа тэр ажлуудад нь олгох ёстой юм.

Хуулийн хувьд Дулааны хуулийг бид дэмжиж байгаа Энхцэцэг гишүүнээ. Би өөрөө дотор ажлын хэсэгт нь ажиллаж байсан дэмжинэ. Гэхдээ хууль бол олон талаас нь хэлэлцэж, ул суурьтай гарах ёстой, ялангуяа анхдагч хуулиуд. Ялангуяа бодлогын чанартай том шинэчилсэн найруулгууд маш олон талаас нь ярих ёстой. Тийм болохоор энэ дээр саналаа өгөөд явж байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Энхцэцэг гишүүн нэмж тодруулъя.

М.Энхцэцэг: Тэгэхээр хариултаас тодруулга асууя гэж бодож байна л даа. Тэр нөгөө өмнөх ажлууд болохоор төсөвгүй учраас хасагдсан гэж ярьсан. Тэгэхээр

өөрөөр хэлбэл ДЦС 3-ын тэр 50мвт-ыг сэргээх ажил маань бас энэ 27 онд хийгдэхгүй юм байна. Тийм учраас энэ төлөвлөгөөнөөс хасагдсан юм байна гэж ойлгож байна, зөв үү, энийг тодруулаач?

Ерөнхий сайдын төлөвлөж байгаа 5 мвт болох, 5 аймгийнх болохоор хувийнхаар болохоор хийгдэхгүй юм байна. Гэтэл та бүхний энэ 6 аймаг чинь улсын төсвөөр хийх болохоор та бүхэн төлөвлөгөө дээр тавьчихсан юм уу? Уул нь миний энэ харж байгаагаар энэ төлөвлөгөө дээр улсын төсвөөр, хувийн хэвшлээр, төр, хувийн хэвшил хамтарсан гээд бүхий л ажлууд энэ төлөвлөгөө дээр ороод явдаг. Тэгэхээр ингээд энэ дээр нэг жоохон ойлгомжгүй хариулт өгчих шиг боллоо.

3 дугаарт нь тэр айл өрх дээр яг 1000квт гээд байгаа юм уу, эсвэл тэр Ерөнхий сайд 10 мянган айл гээд худлаа яриад байгаа юм уу, энийгээ та бүхэн тодорхой болгоод хэлээд өгөөч? Энэ дээр би тодруулж асуумаар байна.

Б.Пүрэвдорж: Найдалаа сайд нэмж хариулъя.

Б.Найдалаа: Энэ дээр би хариулаадахъя. Тэгээд яах вэ саяын 1000квт гэдэг дээр манай ТНБД тодруулаад хэлчхээрэй, яг тэр ямар, тооцоо юу байгаа билээ, төлөвлөгөө дээр яг ямар тоо тавьсныг нь. Тэр дурдсан төслүүдийг нээрээ хариулт орхисон байна. Эгийн голын УЦС, Байдраг, түрүүн Энхбаяр сайд хариулж хэллээ. Байдраг бол төр, хувийн хэвшлээр хэрэгжихээр явж байгаа. Бидний хувьд энэ бол онц чухал төсөл байгаа. Мөн Цэнхэр мандалын усан цэнэг станц, энэ бол бас чухал төсөл байгаа. Төсөл бол хэрэгжүүлэх хамгийн эхний ээлжид явж байгаа. Мэдээж хэрэг ТЭЦ 3-ын саяын таны ярьдаг ажил байна. Мөн хойд хөршийн хөрөнгө оруулагч компанитай хамтраад ТЭЦ 3-ын асуудал явж байгаа, тэр явж байгаа. Мөн ТЭЦ 4-н 9 дүгээр зуухыг барихыг Хөгжлийн банкаар санхүүжүүлнэ гэсэн шийдвэрийг ЗГ гаргасан байгаа. Тэгээд энийг нэн тэргүүнд маш яаралтай ажиллуулах ёстой байгаа юм. Ерэн-Өлзий дарга энэ дээр тэр 100квт дээр хариулна.

Б.Пүрэвдорж: Жигжидийн Батжаргал гишүүн алга байна. Батжаргалын Заяабал гишүүн алга байна. Тодруулга байгаа юм уу? Индрийн 3 дугаар микрофон, нэр, албан тушаалаа хэлээрэй.

Б.Ерэн-Өлзий: ЭХЯ-ны ТНБД Ерэн-Өлзий. Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Гэр хорооллын айл өрхийн бага оврын нарны эх үүсвэрийг нэмэгдүүлэх гэсэн ийм зорилтот ажил байгаа. Энэ төлөвлөгөөний суурь түвшин нь 2025 он. 25 оны үед ерөнхийдөө түгээх сүлжээнд цахилгаан нийлүүлж байгаа ийм жижиг оврын нарны панелтай айл өрхийн нийлбэр бол 100квт орчим байсан гэсэн үг. Энийг зорилтот түвшинд 1мвт буюу дор хаяж 300 айлын түвшинд хүргэнэ гэсэн ийм тоо байна. Тэгэхдээ бид энэ тоог бол, энэ тоогоор хязгаарлагдахгүй, цааш нь энэнээс дээшээ нэмж төлөвлөж ажиллаж байгаа.

Б.Пүрэвдорж: ЗГ-ын тэргүүн Учрал Ерөнхий сайд, Энхцэцэг гишүүн 2 энэ асуудлыг яриад байгаа. Тэгэхдээ ер нь яг мэргэжлийн хүмүүс энэ ард иргэдээс буцааж худалдан авах энэ зүйл ер нь алсдаа эрчим хүчний асуудлыг нэлээн тийм хүнд нөхцөл байдалд оруулна гэж ярьдаг юм байна лээ шүү гэдгийг хэлье. Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн алга байна. Ренчинбямба, байна уу? Ренчинбямбын Сэддорж гишүүн алга байна. Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууя.

Ж.Галбадрах: Оройн мэнд. Олон асуулт байгаа учраас шууд асуултдаа оръё. УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалд тогтоолын төсөл батлагдсанаар чанар, хүртээмжийг сайжруулах боломж бүрдэнэ гэсэн байгаа. Үнэхээр ийм үр дүн гаргах төсөл хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтууд тусгагдсан уу гэдэг өнцгөөс нь асууя.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хийсэн дүгнэлтийг би та бүхэнд уншиж өгье гэж бодож байна. Хөгжлийн тэргүүлэх чиглэлийг баримталсан, хөгжлийн бодлогын тогтвортой зорилтууд дэвшүүлж, эрэмбэлж ажиллах шаардлагатай байна. Тэргүүлэх зорилтууд урт хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн, бодитой тодорхойлох, шалгуур нь хэмжигдэхүйц байх ёстой гэж заасан байгаа. Тэгэхээр хөгжлийн тэргүүлэх зорилтуудыг хэрхэн эрэмбэлсэн бэ, хэмжүүр нь оновчтой болсон байгаа юу? Миний харж байгаагаар хөгжлийн бодлогын үр нөлөөг бодитой тодорхойлох тийм боломжууд нь хомс байна гэж ингэж харж байна. Чухамдаа хөгжлийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэмд, боловсролд ямар эерэг нөлөө авчрах нь тодорхойгүй байна гэж ингэж хараад, бид нээлттэй хэлэлцэж байгаа учраас хэдэн асуултууд, тодорхой асуултуудыг асууя.

Ялангуяа төлөвлөгөөнд тусгасан асуудлуудыг харахаар эрэмбэлсэн байдал, шалгуур үзүүлэлтүүд, тодорхойлсон байдал нь учир дутагдалтай байна гээд. Ингээд 4 асуулт байна. 1 дүгээрт нь ЗГ-ын хөтөлбөрт хот, суурин газрын сургууль, цэцэрлэгийн дүүргэлтийг стандарт түвшинд хүргэх гэж заасан байгаа. Тэгвэл төлөвлөгөөний 1.1.2.1-д цэцэрлэгийн, сургууль, сургуулийн 53 төсөл, арга хэмжээнд 241 тэрбум тусгажээ. Өнөөдөр 35-аас дээш дүүргэлттэй ангид 2 мянга гаруй, 200 мянга гаруй хүүхэд сурч байгаа. Тэд бол чанартай боловсрол авах эрх нь ноцтой зөрчигдөж байгаа. Энийг би байнга ярьж байгаа. Тэгвэл энэ 241 тэрбум төгрөгөөр 53 сургууль байгуулснаар энэ үр дүн нь, хүртээмж нь хэдэн хувиар дээшлэх вэ? Гэтэл энэ төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтэд юу гэж заасан байна гэвэл ашиглалтад орох сургуулийн тоо л гэсэн байна. Шийдэх асуудал маань сургуулийн хүртээмжийг нэмэх болохоос, байшин сургуулийн тоог нэмэх биш байгаа.

2 дугаар асуудал нь нэг компьютерт оногдох сурагчдын тоог бууруулна гэсэн. Өнөөдөр нэг компьютерт 9 хүүхэд оногдож байгаа бол үнийг 5 гэсэн түвшинд хүргэнэ. Өөрөөр хэлбэл 50 мянган ширхэг нэмнэ гэж байгаа. Үүнд зарцуулах хөрөнгийг дотоодын хөрөнгө оруулалтаар босгоно гэж байгаа нь маш сайшаалтай. Гэхдээ энд 640 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн байна. Сургууль барихаас 2,2 дахин их хөрөнгө оруулалт энд тусгагджээ. Нэг компьютерыг хэдэн төгрөгөөр тооцсон бэ? Ширээ, сандал нь хүрэлцэхгүй байгаа хүүхдүүдэд компьютер өгөх, компьютероор хангах гэдэг нь эхний ээлжид авах арга хэмжээ мөн үү? Энийг сонсмоор байна.

Дараагийн Мэдлээ цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангахад 10 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөжээ. Хамрагдах хүүхдийн тоо нь 17 мянга суурь түвшнээс 18 мянга буюу 1 мянгаар нэмэгдэхийн тулд 10 тэрбум төгрөг зарцуулах болжээ. Энэ шалгуур үзүүлэлт нь хамрагдах сурагчдын тоо гэсэн байгаа. Үнэхээр сурлагын түвшинд амжилт гарах уу, энэ шалгуур үзүүлэлтийг өөрчилж болох уу гэдгийг асуумаар байна?

Дараа нь хамгийн сүүлд chromebook угсрах үйлдвэрийг гадаадын хөрөнгө оруулалтаар, энэ хаанахын хөрөнгө оруулалтаар, ямар байх вэ? 150 тэрбум төгрөг гэж төсөвлөжээ. Суурь түвшин нэгийг харьцах 9 буюу 80 мянган хүүхэд л

компьютертой байгаа юм байна. Үүнийг 133 мянга болгох гэсэн би ийм тооцоо хийлээ. Өөрөөр хэлбэл 50 мянгаар chromebook үйлдвэрлэхэд 150 тэрбум зарах нь. Нэг chromebook өртөг хэд вэ гэсэн ийм асуултыг эхний ээлжид асууя?

Б.Пүрэвдорж: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Галбадрах гишүүнийхээ асуултад хариулъя. Галбадрах гишүүн маань боловсролыг төлөөлж Их Хуралд сууж байгаа. Тэгээд сүүлийн 2 жил энэ боловсролын хүртээмж, багшийн хүртээмжийн асуудлаар, багшийн хомсдолын асуудлаар нэлээн дорвитой судалгаанууд хийж, асуудалд ул суурьтай хандаж байгаа гишүүдийн нэг. Тэгээд энэ удаагийн 27 оны төлөвлөгөө дээр би өөрөө жаахан суусан Галбадрах гишүүнээ. Тийм учраас энэ тоог энэ тоон дээр би өөрөө нэлээн сууж, бодитой тоонуудыг тавьсан гэдгийг танд хэлье.

Өмнөх төлөвлөж байсан тоонуудыг нэлээн зассан. Одоо бид сумын түвшинд нэг ангид, нэг бүлэгт байгаа хүүхдийн тоог 25-аас хэтрүүлэхгүй, цаашдаа сумын түвшнийхээ сургуулиудыг бид бүтцийн өөрчлөлтүүд хийгдэнэ. 1 ээлжид сумын сургуулиудыг шилжүүлэх ийм бүрэн боломж байгаа гэж харж байгаа. 2 дугаарт аймгийн төвд 30 хүүхдээс нэг бүлэгт хэтрүүлэхгүй. Улаанбаатарт 35 хүүхдээс хэтрүүлэхгүй нэг ийм шийдлүүдийг хийе гэж харж байна. Тэгээд эхний ээлжид ямар ч байсан энэ Улаанбаатар хотод байгаа 3 мянгаас дээш хүүхэдтэй 38 сургууль байгаа юм байна лээ. Тэгээд энэ сургуулиудыг задална, хотхоны бага сургууль, дунд сургууль, төрөлжсөн ахлах сургууль болгож задална гэж байгаа. Энэ жил ямар ч байсан 9 сарын 1-нээс өмнө 20-оод сургуулиудыг бид ингээд 35 руу оруулчих ийм боломжууд нь байгаа гэж харж байна. Бид цэцэрлэгүүдийн сугалааны цэцэрлэгийг шийдсэн. Та бүхэн санаж байгаа. Тэгээд сүүлийн 5 жил энэ төрөлт багассан байна. Сүүлийн 3 жил маш нэлээн огцом багассан. Энэнтэй уялдаж цэцэрлэгүүд нэлээн хүүхэд нь багасаж байгаа ийм тооцоонууд гарч ирж байна. Тэгэхээр энийг бид хүүхэд багасаж байгаа цэцэрлэгүүд дээр хотхоны бага сургууль болгож зохион байгуулах энэ зохион байгуулалтуудыг хийх гэж байна.

Энэ жил энэ юун дээр тоон дээр нэг тоо алдсан байна. Өнөөдөр нэг компьютер дээр 11 хүүхэд байгаа, энэ дээр 9 гэж тавьсан байна. Энийг бид 2 жилийн дотор нэг компьютер дээр 2 хүүхдийн, нэг компьютер 2 хүүхэд гэсэн энэ харьцааг барьж явъя гэж нэлээн тийм aggressive төлөвлөгөө гаргаж байгаа. Нийт 300 мянган chromebook-н хэрэгцээ байна. Энийг хийхийн тулд гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, Гүүглийн chromebook үйлдвэрийг байгуулах энэ хэлэлцээрт бид орсон. Тэгээд энийг бид төсвийн эх үүсвэрээр хийхгүй. Хөгжлийн банк, Хөгжлийн банкны доор байдаг DB Лизинг гэж энэ компанитай бид хэлэлцээр хийж байна. 3 жилийн дотор 300 мянган компьютерыг авч, 1,5 сая төгрөг тооцож байгаа Галбадрах гишүүнээ нэг chromebook. Тэгээд харамсалтай нь сүүлийн үед энэ дэлхий дээр байгаа, дэлхий дээр үүсэж байгаа нөхцөл байдлаас шалтгаалж энэ нэлээн хардверын үнүүд, энэ чипийн үнүүд 30 хувь нэмэгдчихлээ. Энэ бидний хувьд маш том эрсдэл гэж харж байна.

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя, Галбадрах гишүүн.

Ж.Галбадрах: Харин тийм. Тэгэхээр төрөлжсөн ахлах сургууль, тэр багийн хотхоны бага сургууль ч гэдэг юм уу, энэ багийн бага сургууль энэ тэрд ингээд төлөвлөж байгаа юм нь ерөөсөө л 10 хэдэн тэрбум төгрөг болчихоод байдаг. Гэтэл энэ зүйлүүд дээр 640, хэрвээ дотоодын хөрөнгө оруулалт үнэхээр нөөц байвал энэ

сургуулиудыгаа эхний ээлжид тэр анхдагч суурь хэрэгцээгээ бүрдүүлэх. Би яриад байгаа тантай тоогоо нийлүүлье гээд ингээд уулзаад ярья гээд байгаа. Багшийн тоон хомсдол, чанарын хомсдолыг арилгахад, тэгээд мэргэжлийн хувьд нь бэлтгэхэд ийм боломжийг гаргаж ирж байгаа бол бид өмнө нь Эрдэнэт үйлдвэрээс 160 тэрбум төгрөгийн дотоодын хөрөнгө оруулалтыг гаргаад нүхэн жорлонгоосоо салах хөтөлбөр хэрэгжүүлж байсан шиг та бол менежер хүн. Дотоодын хөрөнгө оруулалтыг би бол босгох нь гэж харж байна. Зүгээр энэ талаар ийм мөнгө босгож чадвал энийг бид эрэмбэлээд, эхний ээлжид хааш нь чиглүүлэх вэ гэдэг дээрээ ярилцах хэрэгтэй юм байна гэж бодлоо. Та энэ талаар бодлоо хуваалцаач?

Б.Пүрэвдорж: Энх-Амгалан сайд хариулья.

Л.Энх-Амгалан: Галбадрах гишүүнээ та нэг их сайхан үг хэлсэн шүү дээ, юу гэхээр боловсрол мега төсөл гэж. Ер нь мега төсөл гэвэл боловсрол байна гэж. Тийм учраас энэ 2 жилд ер нь манай ЗГ-ын тэргүүлэх салбар боловсрол. Тийм учраас яг хэрэгжүүлэх төсөл бол боловсролын мега төслүүд гээд нэрлэхэд ер нь болох болов уу гэж бодож байна. Тэгээд энэ сургуулиудын хэв шинжүүдийг өөрчлөн байгуулалтуудын асуудлуудыг хийнэ. Энэ дээр бид энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилтүүдийг гаргаж ирэхээр ажиллаж байна. Сая Дэлхийн банктэй хэлэлцээр хийлээ, өнөөдөр салбарынхаа донорын уулзалтуудыг хийлээ. Эхний ээлжид ямар ч байсан 10-аас 15 сургуулийг 10-аас 15 жилийн хугацаанд санхүүгийн түрээсээр хувийн хэвшилтэйгээ барьж, түрээслэх хэлбэрээр явах энэ шийдлүүдийг бид судалж байна. Тэгээд цаашдаа энэ амжилттай болбол төр өөрөө сургууль барихгүйгээр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтуудыг оруулж ирээд, тэгээд бид сургуулиа, дотуур байраа түрээслэх ийм хэлбэрийн санхүүжилт нь зохимжтой болов уу л гэж ингэж харж байгаа.

Б.Пүрэвдорж: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууна.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Дан шүүмжилсэн хар бараан юм ярихгүй. Боловсролын салбар маань сүүлийн 2 жил нэлээн зогсонги байдалд орсон байгаа. Тэгээд Энх-Амгалан сайд ирээд 1 сарын дотор асуудлаа шийдье гэдэг ярилцлагыг өгч байсан. Манай Энх-Амгалан сайдын хувьд маш хурдтай, манлайлалтай ажиллаад бараг 14 хоногийн дотор энэ асуудлуудаа нэлээн цэгцлээд явж байгаад халуун баяр хүргэе. Хийж байгаа хүнээ дэмжинэ, хийхгүй байгааг нь шүүмжилнэ. Тийм учраас би Энх-Амгалан сайдад баяр хүргэмээр байна. Багш нар их талархалтай байгаа шүү таныг ирсэнд.

2025 оны 11 сарын 28-ны өдөр Монгол Улсыг 26-аас 30 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг баталсан. Энэ тогтоолд 26-аас 30 онуудад цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багшийн үндсэн цалинг яаж тогтоох аргачлалыг маш тодорхой оруулж өгсөн. Энэ 2026 онд багшийн цалин 2 сая 800 мянган төгрөг байхаар, 27 онд 26 оны улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр байхаар, мөн дараагийн жилүүдэд өмнөх жилийнхээ улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр байхаар тогтоох ийм бодлогыг бид ноднин өнгөрсөн 11 сард дэмжиж баталсан. Энэ бодлогыг санаачилж батлуулсан хүний хувьд 2024-өөс 28 оны 126 гишүүнтэй парламентын Монголын орчин цагийн боловсролын 100 гаруй жилийн түүхэнд алтан үсгээр бичигдэх шийдвэрийг дэмжиж батлалцсан 126 гишүүддээ халуун баяр хүргэе.

Энэ үндсэн чиглэлийн дагуу анхны жилийн хөгжлийн төлөвлөгөө орж ирж байна. Үүнтэй холбоотой 3 асуулт байна. 1 дүгээр асуулт нь 5 жилийн үндсэн чиглэлд зааснаар 26 онд багшийн цалин 2 сая 800 мянган төгрөгт хүрэх ёстой. Энэ чиглэлээр ямар ажлууд хийгдэж байгаа вэ Энх-Амгалан сайдаа?

2 дугаарт 27 онд 5 жилийн үндсэн чиглэл, мөн 27 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгаж оруулж ирснээс үзэхэд 26 оны улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно гэж заасан байгаа. Статистикийн үндэсний хорооны тайлангаас үзэхэд 26 оны 1 дүгээр улирлын дундаж 3 сая төгрөгийн босго давсан. Тэгэхээр 26 оны улсын дундаж нэрлэсэн цалин хэд байх тухай ерөнхий төсөөлөл гараад ирлээ гэсэн үг. Тэгэхээр 27 оны төсвийн тухай хууль орж ирэхэд багшийн цалин 26 оны улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооход нийт хэдэн төгрөгийн санхүүжилт оруулж ирэх вэ?

3 дугаар асуудал. 26 онд багшийн үндсэн цалин 2 сая 800 төгрөгт хүрснээр боловсролын салбарын төсөв улсын төсвийн нийт зардлын хэдэн хувийг, ДНБ-ий хэдэн хувийг тус тус эзлэх вэ гэдгийг асуумаар байна? Энх-Амгалан сайдаас 3 асуулт.

Б.Пүрэвдорж: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Мөнхтуяа гишүүнд баярлалаа. Бурмаар тэжээхээр урмаар тэжээ гэж сайхан үг байдаг. Цаашдаа бид энэ багшийн цалин гэдэг ярьдаг нэг энэ ойлголтоосоо жаахан салсан нь дээр болов уу гэж бодож байна. Юу гэхээр манайд үр дүнгийн гүйцэтгэлүүд буюу нэг хүүхдийг сургах хувьсах зардлын тогтолцоо руу бид шилжчихсэн шүү дээ. Тэгээд харамсалтай нь энийг жаахан засаж залруулах ийм нөхцөл байдал үүссэн. Бид ер нь цаашдаа ингээд нэг ийм багшийн цалинг энэ төрийн цалингийн сүлжээтэй уяад, ингээд нэг ийм бусад салбарууд нь барьцаад байдаг нэг ийм хуучинсаг цалингийн тогтолцоог бид өөрчлөх ёстой. Энэ хүрээндээ төрийн үйлчилгээний албаны том реформ манай салбараас эхлэх ёстой гэж би ойлгож байгаа. Ерөнхийдөө энэ хувьсах зардлын чинь хувьсах зардалд багшийн цалингийн эзэлдэг хувь 90, 10 гэсэн хувь байдаг. Энийгээ цаашаа бид энэ хувиа барьж аваад, цаашаа бид ер нь цалин гэж ярихгүйгээр хувьсах зардлынхаа нэмэгдлүүдийг аваад явъя. Хувьсах зардал л нэмэгдээд байвал багшийн цалин нэмэгдээд байх энэ тогтолцоо руу бид ингээд шилжиж байгаа.

Тийм учраас энэ үндсэн чиглэл дээр таны тавьсан, таны тодорхой оролцоотой энэ тогтоол батлагдсан гэдгийг Монголын ард түмэн, Монголын багш нар мэдэж байгаа болов уу гэж бодож байна. Галбадрах гишүүн ч гэсэн энэ дээр тодорхой үүрэг гүйцэтгэсэн. Ингээд цаашдаа бид энэ хувьсах зардлынхаа тогтолцоонуудыг аваад явна. Одоо бид чинь ер нь саяын энэ нэмэгдлээс үүсэж зөвхөн манай цалингийн сан чинь 3,2 их наяд байсан бол энэ оны төгсгөл рүү 4,2 их наяд болж байна шүү дээ. Зөвхөн энэ багш, ажилтнуудын цалингийн сан. Дахиад энэ дээр чинь мэдээж хөрөнгө оруулалтууд, хүүхдийн хоолны зардал гээд ингээд харвал манай багц ирэх жил 27 оны төсөв дээр бараг 6 их наяд руу хүрэх болов уу гэж бодож байна, 6,2 их наяд. Энэ бараг үндсэндээ дотоодын нийт бүтээгдэхүүний өнөөдөр хэлэлцэж байгаа энэ төсвийн төсөөллөөс харахад ДНБ-ий бараг 6 хувь руу, 7 хувь руу дөхөх асуудал болно. Төсвийн зардлын бараг үндсэндээ 21 хувь руу, 22 хувь руу очно.

Гэхдээ хамгийн гол нь ингээд очоод байгаа ч гэсэн нөгөө нэг хүүхдийн боловсролд зарж байгаа мөнгө чинь 500 доллар л болж байгаа шүү дээ. Даруй хөгжиж байгаа орнуудаас 7, 8 дахин бага байна. Тийм учраас бид энэ ганцхан төсвийн эх үүсвэрээр биш, боловсролын салбарын эх үүсвэрүүдийг энэ ЗГ-ын бонд, би хөгжлийн бонд, боловсролын бонд, ингээд мөн тэр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилтийн эх үүсвэрүүд, хуримтлалын сангийн тодорхой эх үүсвэрүүдийг ч гэсэн энэ боловсрол руу би оруулах ёстой гэж ойлгож байгаа. Хуримтлалын сан бол эрүүл мэнд, орон сууц, боловсрол гэсэн мөртөө өнөөдөр яг боловсролын салбарт нэг ч төгрөг ороогүй ингээд хуримтлал хэлбэрээр байж байгаа. Тэгээд энэ санхүүгийн нөөцүүдийг ашиглавал таны хүсэж байгаа, та бидний хамтдаа зорьж байгаа нэг багш нөгөө мянган доллар.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Бид ийм орой болтол суугаад, ЗГ-ын гишүүд нь Их Хурлынхаа гишүүддээ хариулаад, бага ард түмэндээ бас улсаараа тэгээд сонсох нэг нь сонсоод ингээд байж байдаг нь бидний давуу тал л даа парламентын засаглалын. Манай Пүрэвдорж дарга, Бямбацогт дарга та бүхэн ч юу яачихмаар байгаа юм тэр хуулиа эмхлээд, бид чинь нэг кнопоо дараад үгээ хэлчихдэг, тэр цагтаа багтаадаг тийм болчихмоор байгаа юм шүү тийм. Тэгэхгүй бол тэгээд л баахан хүнд суртал тэгээд л дамжаад явдаг, тэрийгээ больчихмоор байгаа юм.

Энэ төлөвлөгөөгөө батлаад бид тэгээд яах юм бэ 2027 онд баталчих юм байна. Тэгээд 27 онд батлаад, энэнийхээ дагуу хэрэгжээд явахаараа хэдэн хүн ядуурлаас гарах юм бэ? Бид чинь 3 хүний нэг нь ядуу байна л даа. Тэгээд салбар салбарын сайдууд яаж ядуурлаас гарах талаараа нэг хэлээд өгчихвөл зүгээр байна. Ингээд 27 он гээд төлөвлөөд байдаг, энэ 26, 27 онд чинь ер нь юм их тодорхойгүй байна шүү дээ. Бензин тосных нь үнэ нь ямар байх юм бэ түлшнийх нь үнэ? Бид нэг улс орноос хамааралтай. Ядаж 26 онд авах бензин чинь тогтмол үнэтэй байж чадах уу? ОХУ-аас та нар саяхан live хийгээд л хоорондоо яриад байх шиг байна лээ. Тэр үнээ түгжиж чадсан уу? Хэрэв тэр үнэ тодорхой гэвэл яаж төлүүлэх юм бэ?

Дараагийнх нь эрчим хүчний талаар яримаар байна. Эрчим хүчний үнийг баахан нэмчхээд 556 тэрбум төгрөг авсан гэсэн билүү ард түмнээсээ? Тэгээд авлигатай тэмцээд өөдөлсөн юм алга, баахан гэрэл цахилгаан тасарлаа. Тэрний аж ахуйн хэвшлүүд, хувь хүмүүс өчнөөн хохирсон байгаа, тэр цахилгаан тоног төхөөрөмжөөрөө. Ирэх онд ч энэ байдал үргэлжлэх нь. Энэний төлбөрийг хэн хийх юм бэ, энэ хохирлыг хэн барагдуулах юм бэ? Сүүлийн арваад жил, хориод жил энэ МАН-ынхан Жангийнхан л засаглалаа л даа. Тэгээд энэ хугацаанд өдөр өдрөөр бид ядуурлаа ард түмэн. Ард түмэн гэдэгт би ч орж байгаа юм, ийм л байгаа. Тэгээд эндээсээ нэг баахан дарга, сайд нар станцтай, тэгээд янз янзын юмтай болоод л гараад явчих юм, хувийн сургуультай болоод л. Ингэж явмааргүй байгаа юм. Уул нь иргэд нь ч гэсэн адилхан бас аятайхан амьдрал ахуй нь жоохон дээшилж баймаар байгаа юм.

Энэ инфляц гэдэг юм байна. Инфляц гэдэг зүйл чинь энэ онд ч, өнгөрсөн онд тэр юмаа биелүүлж чадсангүй. Тэр 6 дээр +2, -2 хувь ч билүү. Одоо 8 гээд байгаа, 8-аасаа илүү л байгаа шүү дээ. Би тэр 8-аас бага байна гэдэгт итгэхгүй байгаа. Энэ махны үнийг харахад л ойлгомжтой байгаа шүү дээ. Тэгээд 27 онд гуриллын үнэ ямар байх юм гээд нэг тодорхой, тодорхой нэг багцаа хэлчихмээр байх юм. Тэгээд авч

байгаа энэ хүмүүсийн цалин пүнлүү нь ямар байх юм гэх мэтчилний? Энэ хугацаа нь ямар байх билээ, дөхчихсэн юм уу.

Энэ боловсролын салбар яах вэ гадаа жагсаад байсан багш нар алга болчихсон. Багш нар ч юу юм, баахан хүмүүс орилоод л хашхичаад байх шиг байсан. Харин энэ сарын дараа гэхэд Энх-Амгалан сайд очоод арай гайгүй болгочихсон юм уу, үгүй юү. Гэхдээ тантай санал нийлэхгүй юм байна. Та бас одоо юу байна. Энэ хувийн сургуулиудыг Монгол хүүхдүүд адилхан сурч байгаа шүү дээ. Тэр эх эцэг нь үнэтэй машин авалгүй, хүүхдэдээ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Эхлээд Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Ер нь Ормузын хоолойн нөхцөл байдлаас болоод дэлхийн бүх л улс орон энэ дизель, бензиний хомсдолд орчхоод байна. Тэгээд бидний хувьд яах вэ сая энэ 5 дугаар сард гэхэд нэг литр дизель түлш 6 мянга хүрэхээр байсан Сингапурын биржийн үнээр бол. Тэгэхээр бид ОХУ руу Ерөнхий сайд тусгайлан захидал явуулж, утсаар холбогдож, араас нь би очиж уулзалт хийж ингэж ярьсны үр дүнд дизель түлш 2026 оныг дуустал ОХУ-ын Дотоодын биржийн үнээр авахаар болсон. Өөрөөр хэлбэл ОХУ-ын, энэ Энх-Амгалан, тэгээд Цогтбаатар гишүүн жоохон юм ярих боломж олгочих тэгэх үү? Дотоодын үнээр өгөхөөр тохиролцсон. Тэгээд энэний үр дүнд бид 5 дугаар сард 4 мянга, 6 мянга хүрэхээр байсан үнийг 4300-гаар болгож байна. 6 дугаар сард үнэ нэлээн доошоо бууна гэсэн хүлээлттэй байна.

Энэ оныг дуустал бид ер нь ОХУ-ын дотоодын биржийн үнээр явна. Дотоодын биржийн үнэ гэдэг Санкт Петербургийн биржийн үнэ дээр үйлдвэрүүддээ өгдөг татаасны төлбөрийг төлөөд авдаг. Энэ бол Сингапурын биржийн үнээс зөвхөн тонн тутамдаа бараг 400 гаруй доллароор хямдарч байгаа юм дизель түлш. АИ92 бол бид тогтмол 705 доллар буюу яг одоогийн байдлаар, та хэрвээ анзаарсан бол 92 бензин яг энэ хямралын үед ерөөсөө үнэ өсөөгүй, яг бариад байж байгаа. 2028 он болтол бид барихаар гэрээ хийсэн ийм байгаа. Тэгэхээр дотооддоо үйлдвэрлэдэггүй дэлхийн улс орнуудын хувьд харьцуулж үзвэл бид маш хямдаар, тэгээд нөөцтэйгөө ингээд явж байгаа.

Ташрамд хугацаа байгаа дээр нэмж хэлэхэд нөөц саваа бүрдүүлэх хуулийг та бүхэн маань баталж өгсөн. Энэний үр дүнд ААН-үүдийн барилгын ажил эхэлчихсэн байна. Энэ жилдээ багтаад 150 мянган м3-ийн савтай болно. Ирэх жилийн өдийд гэхэд дахиад 180 мянгынхыг хийчихсэн байна. Ингээд манай хадгалах чадвар нэг сараар нэмэгдэнэ. Тэгээд үндсэндээ 2 сараа хадгалж чаддаг болно гэсэн үг. Энэ бодлогоо ирэх жилдээ үргэлжлүүлээд явах ийм зорилт тавиад ажиллаж байгаа.

Б.Пүрэвдорж: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Ганбат гишүүний асуултад хариулъя. Яах вэ ядуурлыг бууруулна гэдэг зөвхөн дан ганц Гэр бүл, хөдөлмөрийн, нийгэм хамгааллын яам гэхээс илүү бүхий л яамнуудын төрийн бодлогын уялдаа холбоотой явж байдаг. Ядуурлыг зөвхөн орлогоор хэмжихээс илүү амьдрах орчин, боловсролын түвшин, эрүүл мэндийн түвшин гэх зэрэг маш олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Манай яамны хувьд тодорхой зорилт тавьж ажиллаж байгаа. 2027 онд 5 мянган өрхийн 20 мянган хүний амьжиргааг дэмжинэ гээд тодорхой хэмжээний төсөл хөтөлбөр юмнуудаа

боловсруулаад явж байгаа. Тийм учраас ядуурлын түвшнийг зөвхөн нэг яамны, эсвэл ганцхан орлогын түвшин гэхээсээ илүү саяын миний хэлсэн боловсролын түвшин, эрүүл мэндийн байдал, энэ хот, амьдарч байгаа сум, суурин газрын хүртээмжийн асуудал гэж маш олон зүйлс нийлж байж энэ ядуурлын түвшнийг тодорхойлдог л доо. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас маш тодорхой 5 мянган өрхийн 20 мянган иргэнийг тодорхой хэмжээнд амьжиргааны түвшин доогуур түвшнээс дээшээ гаргана л гэсэн зорилт тавиад.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Боловсролын сайд Энх-Амгалан.

Л.Энх-Амгалан: Ганбат гишүүнээ би хувийн хэвшлийгээ ингээд нэг араас нь төрсөн, урдаас нь төрсөн гэдэг шиг ингэж хандахгүй. Би өөрөө хувийн хэвшилд олон жил ажилласан ийм хүн. Ер нь хувийн хэвшилд сайн стандарт байдаг, сайн технологи байдаг. Тийм учраас энэ боловсролын салбарт байгаа хувийн хэвшил энэ хувийн сургуулиудыг дэмжиж ажиллана. Манай Ерөнхий сайд хэлж байгаа шүү дээ. Өглөө бүхэн битгий нэг босож ирээд гэнэт ийм сюрприз битгий бариад бай, гай болдоггүй юм гэхэд, гавьяа байгуулдаггүй юм гэхэд гай битгий болоод бай гэж хэлж байгаа. Тэгэхээр мэдээж энэ хувийн сургуулиуд дээр чинь нийт 80 гаруй мянган хүүхдүүд байна. Төрийн ачааллуудыг маш сайн хуваалцаж байгаа. Хувийн их сургууль, коллежууд дээр 40 гаруй мянган оюутнууд байна. Мөн энэ төрийн ачааллуудыг хуваалцаж байгаа. Тэгээд хамгийн гол зүйл бол нэг стандарт шаардана, тэр бол шаардана, төрийнх, хувийнх гэхгүйгээр шаардана. Тийм учраас энэ дээр ямар нэгэн байдлаар хувьд, хувийнхныг ингэж яасан.../минут дуусав/

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 21 цаг 29 минутаас хуралдааныг даргалав.

С.Бямбацогт: Энхбаяр сайд, Шадар сайд Энхбаяр асуултад хариулъя.

Ж.Энхбаяр: Инфляцтай холбоотой мэдээ өгье. 4 сарын мэдээлэл инфляц 10 хувь хүрээд байна, 2 орон тоо руу очиж байна гэсэн үг. Энэ юу вэ гэвэл нөгөө шатахууны үнийн өсөлттэй холбоотой манайд мэдрэгдэж эхэлж байна л гэж. Монголбанк 26 ондоо инфляцын зорилтыг 6 хувь гэж тогтоогоод, 4-өөс 8 хувийн интервал дотор байна. Бид 27 оныг 7 хувь гэж төсөөлж байгаа нь инфляцын тухайд Монголбанкны зорилтот интервалд байна. Инфляцыг ингээд 7 гэж зорьж байгаа нь энэ чинь бидний зорих, энд хүрэх энэний төлөө ЗГ, МонголБанк хамтран ажиллана гэсэн үг шүү дээ.

Ялангуяа шатахуунтай холбоотой нөлөөлөл өндөр байна инфляцад. Энийг бид сөрөх арга хэмжээнүүдийг сая Дамдинням сайд хийж, амжилттай ажиллаж ер нь нэлээн тогтворжуулалт, нийлүүлэлт дээр нэлээн асуудлыг нэлээн хөнгөлж байна. Мэдээж ЗГ мөн нөөц бүрдүүлэх ажлуудыг нэлээн хийж савны асуудал дээр.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя.

Ж.Энхбаяр: Нөөц бүрдүүлэх зорилгоор энэ савны асуудал дээр нэлээн санхүүжилт шийдэгдээд ингээд нөөцүүдийг, шатахууны нөөцийн сав барих ийм ажлуудыг хийгдэж байна. Нөгөө талаар мөчлөг сөрсөн энэ төсвийн бодлого баримтална. Хүнсний нийлүүлэлт дээр холбоотой хамгийн өндөр өсөлт хүнс дээр байгаа юм. Энэ хүнс дотроо манай дотоодын мах, хүнсний ногооны үнэ их өндөр

гарсан. Гэхдээ энийг бид энийг шийдэж чадах нөөц байгаа байхгүй юу. Бид мал, махны асуудал, энэ жилийн таримал тариалалт дээр нэлээн урамшуулалт бодлогууд хийсэн. Дотоодоосоо төмс, хүнсний ногоогоо хангаж чадаж байсан. Ноднингийн байгаль цаг уурын бэрхшээлтэй холбоотойгоор бид энэ инфляц их өндөр нөлөөллийг дотоодоосоо мах, ногоон дээрээ аваад байгаа юм. Энийг бид дотооддоо шийдэх бололцоотой байгаа тул бид энэ инфляцыг энэ жилийн эцэс гэхэд яг энэ зорилтот түвшиндээ хүрэхийн төлөө ажиллах бололцоотой. Мэдээж гадаад худалдааг идэвхжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх энэ ажлууд үе шаттай сайн ажиллаж байна. Нөгөө талаас Монголбанк бодлогын хүүгээрээ дамжуулаад бие даасан бодлого хэрэгжүүлж байгаа. Ер нь мөнгөний бодлого, төсвийн бодлого уялдаатай.../минут дуусав/

С.Бямбацогт: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуултаа асууя. Ганбат гишүүн тодруулъя, Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Тэр хувийн хэвшил дээр үргэлжлүүлээд хэлэхэд бүгдийг нь ялгалгүйгээр тэр нөгөө яах зардал билээ улсын сургуульд өгдөг нэг хүүхдэд өгдөг мөнгөө бүгдийг нь л адилхан өгмөөр байгаа юм. Тийм, түүн дээр анхаараарай.

Энэ авлига, албан тушаалын хэрэгтэйгээ яаж тэмцэх гээд байна вэ? Энэ танхимаас эхэлнэ гээд л хэлчихсэн. Авлигаас чөлөөлье гээд л Ерөнхий сайд ч хэлээд байгаа. Тэгээд энийг ард түмэн хүлээгээд байгаа шүү дээ. Харбины гэрээ байна. Харбины гэрээгээр хэлэлцээрээр тэр үнээ тогтчихсон л юм байна лээ шүү дээ. Тэр Чайналкогийн үнээр зарна гэхсэн. Тэр үед чинь нүүрсээ ч гаргадаг ч үгүй байлаа, Тавантолгой гэж байхгүй ч байлаа. Тэгэхээр чинь маш бага үнэ болчихоод байгаа шүү дээ. Энэ ямар учиртай юм бэ? Ер нь улсын төрийн болон албаны нууц гэж байна уу, байхгүй юу? Энэнд нь хамаарч байна уу, ямар байдаг юм бэ? Тэрийг Энхбаяр сайд нэг хэлчих үү.

С.Бямбацогт: Энхбаяр сайдаас асууж байх шиг байна, Хэрэг эрхлэхийн сайд Энхбаяр хариулъя.

Б.Энхбаяр: Харбины гээд гэрээ гээд байгаа Монгол Улсын ЗГ, хоёр улсын ЗГ хооронд байгуулсан хэлэлцээр болон тэр хүрээнд Монгол Улсын төрийн өмчийн компани БНХАУ-ын төрийн өмчийн компанийн хооронд байгуулсан гэрээ бол төрийн болон албаны нууцад хамаарахгүй байгаа. Энэ асуудлаар тагнуулын байгууллагаар дүгнэлт гаргуулсан. Тагнуулын байгууллага энэ асуудалд Монгол Улсын төрийн болон албаны нууцад хамаарахгүй гэсэн дүгнэлт гаргасан. 2 компанийн хооронд байгуулсан гэрээнд энийг гуравдагч этгээдэд задруулах тохиолдолд зөвшөөрөл авна гэсэн ийм заалт байгаа. Их Хурлын гишүүд хүсвэл бичгээр хандвал энэ гэрээ хэлэлцээрийг бичгээр хүргүүлэх асуудал нээлттэй байгаа.

С.Бямбацогт: Ганбат гишүүн дахиж тодруулъя.

Д.Ганбат: Энэ ажилгүйдэл энэ юм хум чинь ихсэх юм шиг байна лээ. Яагаад гэвэл хиймэл оюун ухаан нэвтрэх ёстой, тэрний өмнө технологи сайжирна энэ тэр гээд зөндөө асуудал байгаа. Эрүүл мэндийн салбар дээр Европын тэр стандартыг баталчихвал яадаг юм бэ тэр эм дээрээ? Тэгээд л болоо шүү дээ, тэрийг авчирч оруулж ирээд л. Ийм цөөхөн хүн амтай юм чинь бид чанартай л эм хэрэглэх хэрэгтэй. Тэр талаар юу бодож байна вэ Эрүүл мэндийн сайд?

Энэ хувьчлах асуудал юу болж байна вэ? Энэ олон төрийн өмчтэй компаниудаа хэзээ хувьчлах юм бэ? Энэ Эрдэнэс, Эрдэнэт, ОТ энэ компаниудынхаа хувьцааг хэзээ иргэддээ эзэмшүүлэх юм бэ? Энэ талаар хийж байгаа ажил байгаа юу, байхгүй юу? Тэр татвараа жоохон ойлгомжтой болговол яасан юм бэ? Яг манай АН шиг 4, 10-ын бодлого гэдэг.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд эхлээд хариулъя, дараад нь Эрүүл мэндийн сайд бэлдэж байгаарай.

Н.Учрал: ЭТТ компанийн 28 орчим хувийг иргэд эзэмшдэг. Энэ бараг, ингээд сая нас барсан иргэдэд хувьцааг нь өвлүүлэх асуудлыг шийдээд 63 тэрбум төгрөг шийдэж, 120 мянган хүнд шийдвэрлэсэн. Гэхдээ энэ ТӨК-ийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хууль, Нийтийн өмчийн хууль 2 Их Хурлаар батлагдсаны дараа ЗГ-аас ТӨК дээр баримтлах чиглэлээ оруулж ирэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Тийм учраас өмнө нь оруулж ирсэн байсан тэр ТӨК дээр баримтлах Их Хурлын нэг тогтоолын төсөл байсан, тэрийг татаж авъя гэж тийм шийдвэр гаргасан. Ирэх долоо хоногт энэ жагсаалтыг татаж авна. Яагаад гэхээр бэлэн байдлыг ерөөсөө хангаагүй хэдэн жагсаалт өгчихсөн юм байна лээ. Тийм учраас энэ дээр олон улсын аудит оруулах хэрэгтэй, зардал мөнгө нь шийдэгдэх хэрэгтэй. Тийм учраас татаж авна. Цаашаа нээлттэй болох ажлуудыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.

С.Бямбацогт: Эрүүл мэндийн сайд Батшугар сайд хариулъя. Энхбаярын Батшугар.

Э.Батшугар: Баярлалаа. Ганбат гишүүн маш зөв юм хэлж байна. Монгол Улс нийт 4 мянгад эм хэрэглэдэг, үүний зөвхөн 880 нь дотооддоо үйлдвэрлэдэг. Энэ 880-нх нь дийлэнх нь юу байгаа юм уламжлалт эм байгаа юм. Энэ эмүүдийг харахад ДЭМБ-ын хатуу зохицуулалттай эмийн улс орнууд гэж явдаг юм. Азид гуравхан улс орон байна. Солонгос, Япон, Сингапур. Европын холбооны улс орнууд байгаа, мөн Америкийн улс орон. Тэгэхээр яг манай ЭМЯ-ны бодлого бол энэ түргэвчилсэн байдлаар энэ хатуу зохицуулалттай улс орнуудын эмүүдийг бүртгэхээр тийм журмын өөрчлөлт явж байгаа. Тун удахгүй энэ сардаа багтаагаад баталчихна гэж танд хэлье.

С.Бямбацогт: Баярлалаа. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуултаа асууя.

Х.Булгантуяа: Жилийн төлөвлөгөөг нэлээн нарийн үзлээ. Нэг ийм хэдэн зүйл дээр асуух гэсэн юм. Төсвийн урсгал зардлыг зохистой түвшинд хязгаарлана гэсэн байна. Тэгсэн мөртөө үүн дээр ямар ч үзүүлэлт зоогоогүй байна, суурь үзүүлэлт ч алга, зорилтот түвшин ч алга. Тэгэхээр юунаас юунд хүрэх гэж байгаа гэдэг нь ерөөсөө тодорхойгүй байна.

Дээрээс нь нэмээд байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн бэлтгэл ажлыг хангана гээд энэ бол урсгал дансны алдагдлыг үе шаттай бууруулна гэдэгт орсон байна. Төслийг одоогоор бараг ямар ч хэрэгжилтгүй байгаа төслийг 100 хувь хэрэгжүүлээд, тэгээд энэ урсгал дансны алдагдлыг үе шаттай бууруулахад яаж нөлөөлөхийг би ерөөсөө ойлгохгүй байна.

Дээрээс нь нэмээд гадаад худалдааг хөнгөвчилнэ гээд би нэг ийм хэдэн саналуудыг хэлэх гэсэн юм. Зүгээр хэдүүлээ яаж хийх нь бидний ажил, үр дүн л ард

түмэнд хэрэгтэй. Тэгэхээр эсрэгээрээ гадаад худалдааны гэрээ байгуулах бол гайгүй амархан. Харин байгуулсан гэрээ маань үр дүнтэй болоход их хэцүү. Япон улстай бид эдийн засгийн түншлэлийн гэрээтэй, энэ дандаа манайд алдагдалтай. Яагаад гэвэл бид эдийн засгийн, Япон улсын зах зээлд зориулж бараг юу ч үйлдвэрлэж төдийлөн сайн чаддаггүй. Тэгэхээр эсрэгээрээ уг нь өмнө нь байгуулсан гэрээнүүдээ экспортынхоо хэмжээг нэмэгдүүлэх ч гэдэг юм уу ийм юман дээр анхаарахгүй юм уу? Тэгэхгүй бол одоо ахиад 2 улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулна гэж байна. Яах вэ нэг бодлын сайн. Гэхдээ бид ахиад тэдний зах зээлд хүртэл юм үйлдвэрлэж чадах уу?

Тэгээд Ерөнхий сайдаа бас нэг хүсэлт тавих гэсэн юм. ЗГ солигдох болгонд, өөрчлөгдөх болгонд яам болгон бүтцээ хийдгээ нэг жоохон болмоор байна, бид нэг нам л засаглаж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэж байхад намайг ажлаа өгснөөс хойш 2 удаа бүтэц хийлээ, 2 жилийн дотор нэг ч хууль УИХ-аар орж ирж өргөн баригдсангүй. Тэгээд энэ бол иргэдийн хувьд их чухал салбар байгаад байдаг. Тэгээд бүтэцтэйгээ ноцолдсоор байгаад энэ юу үүсдэг вэ гэхээр нөгөө төрийн албан хаагчдын хувьд, үгүй ээ тэгээд өргөн барьж хэлэлцэгдээгүй байна шүү дээ. Өргөн барьж хэлэлцэгдээгүй байна Энх-Амгалан сайдаа. Одоо 2 дахь, энэ 2 дахь жилийн чуулган өнөөдөр дуусах гэж байна. Өргөн баригдаагүй байна. Мэдэхгүй, хэлэлцэгдэж батлагдаагүй байна. Хэдүүлээ энд нэг бичиг цаас, ажлын хэсэг байгуулсан бол ард түмний амьдралд нэг их чухал биш. Эсрэгээрээ, би 6, 7 хууль батлуулсан Нийгмийн даатгалын багц хуулиас авхуулаад.

Тэгэхээр эсрэгээрээ бид өөрснөө яг ард түмний амьдралд туссан нь л чухал болохоос биш, бидний ажлын хэсэг байгуулсан уу, бэлтгэл хангаж байгаа юу гэдэг яг үнэнийг хэлэхэд зүгээр жирийн ард түмэнд нэг их чухал биш байгаад байгаа юм. Тэгээд бас нэг хүсэх хүсэлт нь Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2 бид энэ НДШ-ийн 2 хувийг мөнгөжүүлэхээр тусгаж өгсөн. Одоо манай шимтгэл төлж байгаа хүмүүс бидний мөнгө тэр чигээрээ буцаад тэтгэвэрт гарчихдаг. Тэгээд хүмүүс юу хүсээд байгаа вэ гэхээр өнөөдөр би шимтгэл төлөхөд, тэр мөнгө нь миний яг нэр дээр мөнгөжөөд байршиж баймаар байгаа байхгүй юу. Одоо бид бараг 30 их наядыг хоосон бичилт хийчихсэн байж байгаа. Тийм шүү дээ, бараг 4, 5 жилийн өмнө 27 их наяд байсан юмыг чинь. Энх-Амгалан сайдаа би таныг ярьж байхад юм яриагүй шүү дээ. Тэгэхээр, тэгвэл намайг Ёс зүйн дэд хороонд өгөх юм уу Энх-Амгалан сайдаа, тэг.

Тэгэхээр одоо бид энэ НДШ төлөгчдөө нийгмийн даатгалынхаа санд итгэл төрүүлэхийн тулд энэ төлж байгаа мөнгийг нь эхнээс нь бага багаар ч хамаагүй мөнгөжүүлээд өгөөч. Тэгвэл энэ жилдээ 600 орчим тэрбум төгрөг мөнгөжнө. Гэхдээ шимтгэл төлөгч хүн өөрөө бичээд ороход яг банкны хуримтлал шиг тэнд бодит мөнгөн дүн үүсэж эхэлнэ. Тэгэхгүй бол одоо ирээдүйд миний данс дээр миний нэр дээр мөнгө байх уу, үгүй юү, намайг тэтгэвэрт гарахад энэ яг бодитоор энэ байх уу, үгүй юү гэдэг дээр хүмүүс итгэл төрөхгүй байгаа учраас шимтгэл төлөх хүсэл сонирхол бага байгаад байна.

Дээрээс нь нэмээд Ерөнхий сайд их дэмжиж байгаа. Энэ хувийн тэтгэврийн сангийн хуулийг тун удахгүй өргөн барьж, нийгмийн даатгалынхаа тогтолцоог бас дараагийн шатад нэг.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Тэр урсгал зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2024 онд 27 хувь байсан, энийг 2027 онд 25,3 хувь болгож бууруулж байгаа. Сая багш, эмч нарын цалин Их Хурлаар төсөв батлагдахдаа яг тэр эндээс батлагдахдаа 50 хувь нэмэгдээд, 11 сард 26 хувь нэмэгдэх энэ нэмэгдэлдээ хүрэхгүй байсан. Ийм учраас эрүүл мэндийн салбар тэр ЭМД-ын санхүүжилт дээрээ тодорхой арга хэмжээ аваад, энэ ЭМД-ын зөвлөлөөрөө тодорхой хэдэн асуудлуудыг шийдвэрлээд, гэсэн хэдий ч үр дүнд нь нэг өвчтөний зардал бараг 20 орчим мянган төгрөгөөр нэмэгдчихэж байгаа байхгүй юу. Дээрээс нь эмийн жагсаалт шинэчлэгдсэнтэй холбогдуулаад шаардлагагүй эмүүдийн санхүүжилтийг татаад эхлэхээр энд хэмнэлт бий болж байгаа.

Боловсролын салбар өөр. Боловсролын салбар өөрөө нөгөө иргэн өөрөө шимтгэл төлдөг биш, өөрийгөө санхүүжүүлэх бололцоо байхгүй. Боловсролын салбарыг бид төсвөөс санхүүжилтийг нь тавиад ирсэн. Гэхдээ хувьсах зардлын тэр нормативыг нь шийдээд, хувьсах зардлаар нь дотоод үйл ажиллагааг нь зохион байгуулж болдог. Тийм учраас төсвийг захирч байгаа сургуулийн захирлууд өөрсдөө энэ хувьсах зардлаараа дамжуулаад тэр менежментээ зохион байгуулах бололцоотой. Тийм учраас зөв менежмент хийсний үр дүнд юутай ч 5 сарын 1-нд ингээд цалин хөлсний асуудал шийдэгдсэн. Тэгэхээр энэнээс болоод мэдээж нөгөө төсвийн урсгал зардлын хэрэгцээ их өндөр болж байгаа, урсгалын хэрэгцээ. Тэгэхээр урсгал чинь төсвийн бараг 75 хувийг эзлээд байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм өндөр болчихсон тохиолдолд урсгал зардал дотроо буцааж бууруулах боломжгүй зардал нь бараг 80 хувь болоод эхэлчихсэн. Тэгэхээр нэг ийм л нэг орон зай багатай л байна л даа яг үнэндээ.

Тэгэхээр хэмнэлт хийгээд байдаг, та нар урсгалаа багасга гээд байдаг, нөгөө талаасаа тэтгэвэр нэм гээд байдаг, инфляц өндөр байна гэхээр эрэлтийн гаралтай инфляц бууруулах гээд шатахуун түлш гээд үзээд байдаг, тэгэнгүүт нөгөө худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх гээд үзээд байдаг. Нэг болохоор бодлогын хүүгээ буцаагаад зөөллөөд өгөөч гэхээр нөгөө эрэлтийн гаралтай инфляцыг нь өдөөчих гээд байдаг гээд ийм нөхцөлд байгаа. Тийм учраас мэдээж хүн болгонд таалагдах биш, цаашдаа илүү сахилга баттайгаар явахаас өөр зам байхгүй. Тийм учраас үнэнээ яриад явна. Тэр утгаараа таны хэлсэн энэ нийгмийн даатгалын шинэчлэл хийх ажлыг би тэргүүн ээлжийнхээ ажил гэж үзэж байгаа. Тийм учраас Их Хурлын гишүүд та бүхнийг энэ Хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг батлаад өгөөсэй гэж хүсэж байна. Ингэж чадвал санхүүгийн зах руу нэг жилд багадаа 300 тэрбум төгрөг хийчихвэл энэ эдийн засаг чинь 2 тулгууртай болно. Арай ахиц дэвшил гарах юм уу гэсэн ийм л бодолтойгоор ажиллаж байгаа. Тэгээд гишүүд та бүхнээс хүсье энэ Хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг батлаад өгөөсэй гэж.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд гүйцээгээд хариулъя.

Н.Учрал: Дээрээс нь бид Төсвийн тогтвортой байдлын хууль тусгай шаардлагуудыг чанд барьж байгаа. Урсгал зардал нь Төсвийн тогтвортой байдлын хуулийн тэр тусгай шаардлагаар ДНБ-ий 30 хувь гэхээр яг эндээ ингээд баригдчихсан. Мэдээж тусгай шаардлагыг барих нь их чухал. Булгантуяа гишүүн түрүүн асуусан. Тэр бүтэцтэй холбоотой асуудал. Ер нь бүтэц дээр захиргааны хэв шинжтэй чиг үүрэг их байгаа. Тэр үнэн. Нэг ёсондоо үндсэн чиг үүргээсээ гадна тийм захиргааны шинж чанартай ажил хийдэг болчихсон байна шүү дээ. Яам, тамгын газрын ажилтнууд чинь гараад гудамж талбайгаар хагас, бүтэн сайнд өөр, шал өөр чиг үүргийн ажил хийж байж болохгүй биз дээ. Тэгэхээр бид энэ бүтцийг өөрчлөхийн

тулд ЗГ-ын зүгээр тогтоолоор яам болгоны бүтэц, чиг үүргийн шинжилгээг нь батлах гэж бэлдэж байгаа юм. Чиг үүргийн шинжилгээг. Тэрний дагуу л бүтэц хийгдэнэ. Тэрнээс биш сайд болгон тийм дур дураараа бүтэц хийх бололцоо байхгүй.

С.Бямбацогт: УИХ-ын чуулган өнөөдөр баасан гаргийн 5 дахь өдрийн 22 цаг хүртэл хуралдаж байна. Энэ долоо хоногт бид ирэх онд улс орны нийгэм, эдийн засгийн амьдрал ямархуу байх нь, ард иргэдийн амьдралд ямархуу, ЗГ, Их Хурал төр засгаас бодлого, шийдвэр хэрэгжүүлэх гэж байгаа талаараа төсвийн хүрээний мэдэгдэл 27 оны, 27 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө ярьж байгаа. Цаг сунгаад, ажил хэрэгчээр хуралдаад явж байгаа гишүүддээ баяр хүргэе. Ирэх долоо хоногт бид татварын багц хуулиуд ярина. ЗГ-аас ААНОАТ, Хүн амын орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар татварын багц хуулиудыг томоохон шинэчлэлт, өөрчлөлт, энэ эдийн засаг хүндрэлтэй үед ард иргэдийнхээ, ААН-ийнхээ нурууг яаж тэнийлгэх вэ гэсэн агуулгатай хуулиуд, Их Хурлын гишүүдийн өргөн барьсан хүлээгдэж байсан татварын хуулиуд, НӨАТ, ААНОАТ гээд үндсэндээ хамтад нь хэлэлцээд явах гэж байгаа.

Ирэх долоо хоногийн чуулган нэлээн ачаалалтай чуулган болно. Түүний дараа ЗГ-аас энэ нийгмийн даатгалын тогтолцоогоо шинэчлэх, өөрчлөх энэ томоохон бодлогын реформоо оруулж ирэх хэрэгтэй байгаа. Уул нь ЗГ дээр хуулийн төсөл нь боловсруулагдаад яваад л байгаа. Ер нь ороод ирэх дөхчихсөн байгаа гэж ойлгож байгаа. Тийм болохоор тэр үедээ Хамтын тэтгэврийн хууль, манай Түвшин нарын гишүүдийн санаачилсан Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулиуд гээд энэ хуулиудыг багцаар нь хэлэлцээд, үндсэндээ ингээд тус тусад нь цувуулах биш, бодлогын асуудлуудыг багцлаад, багцлаад тулгамдсан асуудлаа шийдвэрлэх ийм бизнес төлөвлөгөөтэй ажиллаж байгаа шүү. Тэгэхээр ЗГ, сая Ерөнхий сайд хэллээ. Аубакир сайд тэр хуулиудаа хэзээ оруулж ирэх юм бэ? Оруулж ирэхгүй байна гээд гишүүд нэхээд байгаа, шахаад байгаа. Энэ дээр та нэг хариулт өгье.

Дээрээс нь гишүүдэд болон иргэдэд үнэн зөв, бодитой мэдээлэл өгөх ёстой. Үнэхээр бид гишүүд өөрсдөө буруу мэдээлэл, буруу дохио өгвөл энэ чинь эргээд нийгэмд бухимдал, сөрөг мэдээлэл болж очно. Тийм болохоор Аубакир сайд бодитой хариултыг сая Булгантуяа гишүүний асуултад хариулахдаа нэмээд өгчихье.

Т.Аубакир: Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиа өргөн барьчихсан байж байгаа. Энэ сарын 18-наас эхлээд Байнгын хороодоор хэлэлцэгдээд эхэлнэ. Булгантуяа гишүүний хэлж байгаа үнэн. Энэ ЗГ ойр ойрхон солигдож байгаатай холбоотой, дахиад шинэ сайд ирэхээр нөгөө үзэл баримтлалаа батлуулах, ингээд бусад зөвшөөрлүүдээ авах гээд процесс орчихдог 1 дүгээрт.

2 дугаарт манай салбарын хууль өөрөө төсвийн эффекттэй байдаг учраас бид Нийгмийн даатгалынхаа багц хуулийг анхны ЗГ байгуулагдаж байхад Занданшатарын ЗГ байгуулагдах үед бид оруулсан. Төсвийн эффекттэй учраас буцаагдсан. Одоо ар араас нь Халамжийн тухай хууль, дахиад Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиа өргөн барьсан. Гэр бүлийн хөгжлийн тухай хууль, Дохионы хэлний тухай хууль гээд маш олон хуулийг Энх-Амгалан сайд байх үедээ манай яамны ажилчид харин харьцангуй тогтвортой байгаа. Тийм учраас хуулиудаа бид шат дараатайгаар хэлэлцүүлээд явж байгаа. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль 18-наас эхлээд хамгийн эхний хууль нь хэлэлцэгдээд эхэлчих юм байгаа юм.

Хуримтлалын хувьд та асуулаа, нийгмийн даатгалын сангийн 2 хувийг.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, Аубакир сайд.

Т.Аубакир: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд заагдсаны хүрээнд бид бүрэн болон хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах гээд даатгуулагч болон ажил олгогч, мөн сайн дурын даатгалаас 2 хувийг гээд үндсэндээ 300 гаруй тэрбум төгрөг, Булгантуяа гишүүнээ би таны нөгөө асуултад хариулаад байгаа юм. 300 гаруй тэрбум төгрөгийн хуримтлалыг үүсгээд, нэрийн данс дээр үүсгээд явж байгаа. Бид арилжааны банкнууд дээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийнхөө шийдвэрээр гаргаад, Монголбанкны бодлогын хүүгээс доош хүүгээр бид байршуулаад эхэлчихсэн. 2024 онд батлагдсан хуулийн хүрээнд тодорхой хэмжээний хуримтлал үүсээд явж байгаа гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Тэр 30 их наядын хоосон бичилт гээд ярьж байна, дээрээс нь ярилаа шүү дээ. Асуудлаа цогцоор нь, бүхэлд нь хамтад нь шийдэж явмаар байна. Тэгэхгүй ингээд юу гэдэг юм үхрийн баас ингээд цувуулаад, цувуулаад нэг асуудал шийдэхдээ нөгөөдхийнхөө асуудлыг хөндөөд, нөгөөдөө шийдэхдээ нөгөөдхөө нураагаад ингээд явахаар чинь болохгүй Аубакир сайдаа. Тийм учраас Их Хурал дээр бид төсвийн хүрээний мэдэгдэл ярьж байна, ирэх оны төсөв маань ямархуу байх нь, араас нь татварынхаа хууль багцаар нь ярих гэж байна. Яг үүнтэй зэрэгцээд наад нийгмийн даатгал чинь төсөвт ямар ачаалал өгөх юм, эдийн засагт яаж нөлөөлөх юм, эерэг үр дагавар, сөрөг үр дагавар хамтад нь яримаар байна. Тэгэхээр энэ хуулиудаа хурдан оруулж ирмээр байна. Тэгээд нэмээд хариулчихъя.

Т.Аубакир: Нийгмийн даатгалын багц хууль Бямбацогт даргаа бид энэ Түвшин нарын гишүүдийн өргөн барьсан хуулийг тодорхой хэмжээнд шинжилгээ үнэлгээг нь өгөөд явж байгаа. Эргээд даатгуулагчдаа хохиролтой ийм зүйл яваа шүү. Бямбацогт даргаа би таны зөвлөхөд, 2 зөвлөхөд сууж байгаад нэлээн дэлгэрэнгүй манай яамны зүгээс тайлбарласан Түвшин нарын гишүүдийн хуулийг. Бид ингээд заавал нэг байгаа зүйлийг өөрчлөх гэж байгаа нь тэр гээд бүр дордуулчихвал жишээлбэл яах вэ. Өнөөдөр манай Нийгмийн даатгалын сан айхтар тийм дампуурчихсан сан биш, тогтолцоо нь өөрөө тийм буруу тогтолцоо биш байхгүй юу даа. Ариунзаяа гишүүний хэлдэг, Булгантуяа гишүүний хэлдэг бид суурь тэтгэвэртэй болохын тулд тодорхой хэмжээний шилжилтийн зардлыг бий болгох хүрээнд бид хуримтлалаа үүсгээд явж байгаа. Заавал ингээд л өөрчлөх ёстой юм гээд л тэртээ тэргүй болж байгаа зүйлийг, жишээлбэл ажил олгогчийн НДШ-ийг бууруулъя гээд зардал жишээлбэл явж байгаа. Нэг талдаа ажил олгогчдоо сайн юм шиг мөртөө нөгөө талдаа нөгөө даатгуулагч маань тэтгэвэрт гарах үед тэтгэвэр тооцох тэр орлогын бүрэлдэхүүн хэсэг буураад.../минут дуусав/

С.Бямбацогт: Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: Тогтолцооны өөрчлөлт гэвэл маш том юм. Зүгээр аль нэг шимтгэлийг бууруулсан нь тогтолцооны өөрчлөлт биш. Тогтолцооны өөрчлөлтийг уг нь бид батлаад, хэд хэдэн зүйлийг хийсэн нь хуримтлалын тогтолцооноос хуваарилалтын тогтолцоо руу. Одоо 1979 оноос хойш төрсөн хүмүүс тэтгэвэрт гарахдаа яг өөрийнхөө нэрийн данс дээр банкны хуримтлал шиг хэдэн төгрөг шимтгэлээр төлсөн байна, түүнийг нь тухайн үед дундаж эмэгтэй хүн, эрэгтэй хүн

хэдэн жил амьдрахаар байна тэрүүнд нь хуваагаад тэтгэвэр болгож авна. Их төлбөл их авна, бага төлбөл бага авна. Энэ бол тогтолцооны өөрчлөлт. Бид 20 хувийг өвлүүлдэг болсон, гэр бүлийн хүн нь нэг нас барахад. Дээрээс нь нэмээд ахиад тэтгэврийг жил бүрдээ инфляцтай уялдуулж нэмдэг болсон. Энэ бол 24 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхлээд, 24 он, 25 он, 26 он, одоо 27 он дээр ч гэсэндээ ингээд оруулж ирж байна. Дээрээс нь нэмээд нөгөө хүмүүсийн бухимдаад байгаа нэг хэсэг нь бага төлж байгаад 5 жил өндөр төлөөд, өндөр тогтоолгоод байна гэдгийг бид өөрчлөлтүүдийг хийсэн. Одоо хүсэх ганц зүйл нь нөгөө 2 хувийг мөнгөжүүлэх, тэрийгээ чадах уу Аубакир.../минут дуусав/

С.Бямбацогт: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Бид энэ 2 хувийг мөнгөжүүлэх хүрээнд бид 2024 онд 1,3 сая даатгуулагчийн 214,8 тэрбум төгрөг, 2025 онд 1,3 сая даатгуулагчийн 301 тэрбум төгрөгийг мөнгөжүүлээд байршуулаад явж байгаа. Таны ойлгоод байгаа бид 30 их наядын хий бичилт гэж байх шиг байна. Манай яг нийгмийн даатгалын газраас хүн байна уу, тийм зүйл байхгүй. Бид нийгмийн даатгалын сан маань улсын төсвөөс буюу татвар төлөгчдийн мөнгөнөөс 1,7 их наяд төгрөгийн татаастай явж байгаа. Энэ маань ямар үр дүнгээр ийм татаас аваад яваад байгаа юм бэ гэдэг чинь нөгөө нэг попрлотой улс төрчдийн хийсэн хууль ний нуугүй шулуухан хэлэхэд. Зарим нийгмийн сегментийг НДШ-ээс чөлөөлдөг, заримыг нь бууруулж өгдөг. Энэ чинь орлого, зарлага хоёрыг тэнцвэртэй аваад явж байх ёстой шүү дээ. Нөгөө талдаа бид хөдөлмөр эрхлэлтийг яагаад дэмжье гээд байгаа маань нөгөө даатгуулагчийнхаа тоог нэмэх, 537 мянган иргэн 2026 онд тэтгэвэр авч байна. Нөгөө талдаа 1,3 сая иргэн маань хөдөлмөр эрхлээд НДШ төлж байна. Тийм учраас манай энэ тогтолцоо айхтар, бид мэдээж хэрэг тодорхой хэмжээний өөрчлөлтүүд хийх ёстой. Төлсөн мөнгөө эргээд тэтгэвэрт гарахдаа бүрэн авдаг энэ тогтолцоо руу шилжих гээд бид шилжилтийн зардал буюу саяын таны хэлж байгаа 2 хувийг хуримтлуулаад явж байгаа.

С.Бямбацогт: Дахиад тодруулчихъя Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Сангийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Ерөнхий сайдаас хүсэхэд энэ 2 хувийг бид бүрэн яг мөнгөжүүлж явмаар байгаа юм. Уг нь энэ тооцоолж үзэхэд 24 онд зөвхөн мөнгөжүүлэхэд бараг 600 тэрбум төгрөг болж байсан. Тэгэхээр 24, 25, 26 гэхэд өдийд бараг 2 их наяд төгрөг мөнгөжчихсэн байх ёстой байхгүй юу. Тэгэхээр үүнийг Сангийн яам ингээд бид мөнгөтэй, мөнгөгүй, боломжтой, боломжгүй гээд мөнгөжүүлж чадахгүй байгаа нь өнөөдрийн шимтгэл төлж байгаа хүмүүст яг энэ санд ирээдүйд итгэлтэйгээр мөнгө төлөх хүслийг нь бид бий болгох гээд байгаа юм. Тэрнээс энэ ингээд тэр мөнгөжүүлсэн мөнгөө хаана байршуулах нь Сангийн яамны, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтран эрхлэх асуудлын хүрээнд шийдэж болно шүү дээ. Гэхдээ шимтгэл төлөгч хүн өөрөө ороод, Болд гэдэг хүн ороод харахад миний нэр дээр бодит мөнгө л баймаар байна. Тэгж байж хүмүүс шимтгэл төлөх хүсэл төрнө. Тийм учраас үүнийг бүрэн мөнгөжүүлэхэд Ерөнхий сайд та анхаарч өгөөч гэж хүсэж байна.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Тэр 2 хувийгаа бүрэн мөнгөжүүлэх талдаа анхааръя. Гэхдээ 30 их наядын хоосон бичилт гэж байхгүй юм байна шүү, ингэж тийм худлаа мэдээлэл хэлж, ярьж болохгүй шүү гишүүд. УИХ-ын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх УИХ-ын гишүүд нэрээ өгнө үү? Батын

Батбаатар гишүүнээр, Отгоншарын Батнайрамдал гишүүнээр үг хэлэх хүмүүс тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя, үгээ хэлье.

А.Ариунзаяа: Өнөөдөр чинь юу юу ч болов доо, өглөөнөөс авхуулаад л хэд, хэд өөрчлөгдөөд л явлаа. Юуны өмнө ямар ч байсан энэ улаан лаазаа далд хийчихье, хүмүүс буруу дохио авчих вий. Ер нь дэмжиж байгаа шүү. Энхбаяр сайдын түрүүний хэлсэн мэдээлэл дээр нөгөө Гадаад зээллэгийн ашиглалтыг нэмэгдүүлэх хуулийн төсөл маань өнөө өглөө унасан шүү дээ. Тэгээд ЗГ сая өөрсдөө яг ЗГ-ынхаа түвшинд Эрдэнэбүрэний усан цахилгаан станц, мөн газрын тос боловсруулах үйлдвэрийн энэ гадаад зээллэгийг ашиглах хуулийн төслийг ЗГ яаралтай өргөн барихаар болсон байна. Баярлалаа, болж байна шүү дээ, ингээд, ингээд ажиллаад байвал хэн уурлаад байх вэ дээ.

Одоо болохоор байна шүү дээ өнөөдөр чинь баасан гараг ингээд ажлын цаг дуусчихсан байгаа. Дараагийн ЗГ-ын хуралдаан 3 дахь өдөр юм байна шүү дээ. Болж өгвөл уг нь наана нь ээлжит бусаар хуралдаад, өргөн барихаар шийдвэрлээд, УИХ-даа өгчихвөл 3 дахь өдрийн 12 цагаас манай ТББХ хуралдах юм. Түүгээрээ хэлэлцэх эсэхийг нь оруулаад, тэгээд 4 дэх өдрийн чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг зөвшөөрөх эсэх санал хураалтыг явуулбал бас энэ асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэх нь. Тэгэхээр манайд нэн ялангуяа гадаад түншүүд яг энэ төслүүд дээрээ, хөрөнгө оруулалт дээрээ санаа зовж байгаа бол ЗГ анхаарч, шуурхай ажиллахаар болсон байна гэдгийг энд дурдаж талархлаа илэрхийлье.

Сэлбэ төв харин орхигдох юм байна, нэлээд шүүмжлэлд өртөж байгаа гэдэг агуулгаараа. Мэдээж бид бондоо босгочихсон, мөнгө нь байгаад байдаг, гэхдээ улс төртэй байгаад байгаа учраас ЗГ энийг орхин, 2 төслийг оруулж ирэх юм байна. Тэгэхээр энэ үйл ажиллагааны энэ төлөвлөгөө дээрээ 8.1.2.7 дээр 8.1.2.7.1 Баянхошуу дэд төв орон сууцжуулах төслийг хэрэгжүүлэх гээд гадаад зээлээр бас ингээд ороод ирчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр дахиж энэ Сэлбэ төвтэй адилхан нөхцөл байдалд орохгүйн тулд магадгүй хэлэлцүүлгийн үед энийг чинь хасахаас өөр арга байхгүй болох нь байна шүү. Тэгэхээр бид аливаа ажлыг зөвшөөрлийг нь өгчхөөд, тэгээд хэзээ хойно араас нь ингээд улс төржиж болохгүй гэдгийг энэ ташрамд хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. 5 гишүүн үг хэлээд, санал хураалт явагдана. 22 цаг 20 минут орчимд санал хураалт явагдана, гишүүдийг өрөөндөө байгаа гишүүдээ танхимдаа цуглаж байхыг урьж байна, 22 цаг 20 минут. Их Хурлын гишүүдийн зөвлөх, туслахууд, бүлгийн ажлын алба, бүлгийн дарга, дэд дарга нар, Хуралдаан зохион байгуулах газар гишүүддээ зар хүргээрэй. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үгээ хэлье.

С.Эрдэнэболд: Эдийн засаг, хөгжлийн яамны энэ хүний нөөц залуучуудад талархал илэрхийлмээр байна. Хэд хэдэн сайд солигдсон ч гэсэн чадавхтай, нэлээн ийм хичээмтгий залуучууд ажиллаад байгаа. Тэгээд ямар ч байсан энэ нам харгалзахгүй энэ залуучуудаа үргэлжлүүлж байж ажиллаарай гэдгийг сайдад нь хэлмээр байна. Үлгэрлэвэл Монголд ингээд олон хүүхэдтэй айл байлаа гэхэд нэг хүүхэд нь арай илүү манлайлалтай байдаг л даа. Тэгээд ээж аав нь тэрэндээ хамаг ирээдүйгээ л найддаг гэдэг шиг манай улсыг ингээд нэг гэр бүл гэж аваад үзвэл тэр манлайлалтай хүмүүс нь бизнес эрхлэгчид. Бусад ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс бол тэгээд мэдээж ач холбогдолтой. Гэхдээ яг бизнес эрхлэгчид буюу entrepreneur-ууд бол яг гавьяа явуулж байгаа хүмүүс.

Гэтэл манай улсыг ингээд аваад үзэхлээр өөрийнхөө мөнгийг зарцуулаад, зээл аваад, амьдралаа дэнчин тавиад, эрсдэл хийгээд, бизнес хийгээд явж байгаа хүмүүс эргээд гэмт хэрэгтэн болж хувирах тохиолдол асар их байна. Өнөөдөр ял эдэлж байгаа хүмүүс ковидын үеэр зээлээ төлж чадаагүй, тэрэндээ болоод залилангийн зүйл анги авдаг. Ингээд ялтан болж хувирдаг. Дээр үед нөгөө социализмын үед Лоохууз гуайг ингээд санаачилгатай байсных нь төлөө шоронд хийгээд, нутаг заагаад цөлдөгтэй адилхан. Тийм учраас энэ бидэнд маш яаралтай ингээд төлөвлөгөө ярьж байгаа, төсвийн хүрээ ярьж байгаа үед эдийн засгийн харилцааг эрүүжүүлсэн энэ хуулиудыг хүчингүй болгох зайлшгүй шаардлагатай байгаа юм Ерөнхий сайдаа. Эдийн засгийн харилцааг эрүүжүүлсэн, бизнес хийснийхээ төлөө шорон оронгоор айлгадаг энэ тогтолцоог үгүй хийвэл Нобелийн шагналт Амартъя Сэний гол зарчим байгаа шүү дээ. Төр бүхнийг хийх гээд байхаас илүүтэйгээр хөгжлийн боломжийг нь олгоод байвал тэр улсын эдийн засаг, санхүү хөл дээрээ маш хурдтайгаар босдог. Тэгэхээр энэ тогтолцоог бид энэ эрх зүйн орчиндоо шинэчлэл хийх замаар авчрах ёстой.

Монголд байгаа судалгаагаар, иргэдээс авсан судалгаагаар хэрвээ танд боломж байвал бизнес хийх үү гэсэн асуулт асуухад нийт иргэдийн 80 хувь, залуучуудын 80 хувь нь бид боломж гарвал бизнес хиймээр байна гэсэн хариулт өгөөд байгаа байхгүй юу. Гэтэл бусад орнуудын энэ чиглэлийн судалгааг харахад 20 хувьтай байгаа юм хамгийн дээд тал нь. Бизнес хийх идэвхжилт буюу иргэдийн хүсэл сонирхол 20-оос дээш хувь хэтэрдэггүй байхад Монголчууд олон улсын тогтолцооноос 4 дахин их байгаа байхгүй юу. Гэтэл төр нь тэрэн дээр нь боолт хийдэг, саад хийдэг болчихоод байгаа юм. Өнөөдөр ингээд гадаадын хувийн хөрөнгө оруулалт гэдэг зүйл Монголд өдрийн од шиг болсон. Тийм учраас энэ хөрөнгө оруулалт, бизнес хийх орчныг илүү таатай болгох дээр ЗГ реформын шинж чанартай шинэчлэлийг хийх ёстой. Нөгөө чөлөөлье гээд байгаа бодлогуудаа ийшээгээ чиглүүлэх ёстой.

Тийм учраас энэ декриминализаци буюу эдийн засгийн эрх чөлөөгөө эдэлсний төлөө, үүнийг тууштай хамгаалж, идэвхтэй ажилласны төлөө гэмт хэрэгтэн болж байгаа энэ зохицуулалтыг нь бүүр root out мөргүй байхгүй болгох ёстой. Жишээ нь мөнгө угаах гэмт хэрэг гээд хүмүүсийг шоронд хийж байна. Гэтэл олон улсын томоохон санхүүгийн дүн шинжилгээ хийдэг байгууллагууд асуудалгүй гээд гаргачихаар, Монголд энийг нь нэг шинжээчид даалгавар өгөөд гэмт хэрэгтэн болгочихдог асуудлууд байгаа гэх мэт зүйлүүд байна. Тийм учраас энэ төлөвлөгөөний амин сүнс нь Ерөнхий сайдаа иргэддээ итгэл өгөх, бизнес эрхлэгчдэдээ эрмэлзэл өгөх энэ рүү чиглэсэн байх ёстой шүү. Тэгээд энийг хэлэлцүүлгийн явцад хэлээд явна.

С.Бямбацогт: Батын Батбаатар гишүүн үгээ хэлье.

Б.Батбаатар: Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төслийн нэг дэх хэлэлцүүлэг явагдаж байна. Тэгээд асуултууд асуусан, хариулт гүйцээж авч чадаагүй. Ирэх долоо хоногийн хэлэлцүүлэг, зарчмын зөрүүтэй санал эхлэх тэр дэгийн горимоос нь өмнө хариултуудыг ЗГ ирүүлээрэй гэж хүсэж байна. Бичгээр ирүүлбэ гэж ярьсан.

Иргэний Зориг ногоон нам хөгжлийн бодлогыг эсэргүүцэхгүй. Монгол Улсад төлөвлөгөө хэрэгтэй, иргэдэд хөгжил хэрэгтэй, залуучуудад ирээдүй хэрэгтэй, орон

нутагт боломж хэрэгтэй. Гэхдээ энд нэг зүйлийг маш тодорхой хэлэх ёстой. Монголд, Монгол Улсад ингээд дахин, дахин сайхан нэртэй, том тоотой, хэрэгжилтгүй төлөвлөгөөг хүсэхгүй байх гэж бодож байна. Энэ төсөлд 124 төсөл, 180-ын арга хэмжээ тусаж байна. Цаасан дээр сайхан харагдана, сайхан харагдана. Харин иргэн өнөөдөр, иргэд энгийн асуулт л асууж байгаа шүү дээ. Мөнгө нь хаанаас гарах юм, хэн хэрэгжүүлэх юм, хэн хянах вэ, бүтэхгүй бол, хэрэгжихгүй бол хэн хариуцлага хүлээх вэ л гэж байгаа юм. Энэ 4 асуултад энэ төлөвлөгөө энэ хөгжлийн бичиг баримт хариулт нь алга.

Сонгуулийн өмнөх ээлжит амлалтын жагсаалт шиг болж хувирч байна гэж ингэж харагдаж байна. Өнгөрсөн жилүүдэд бид, бид ч юу байх вэ дээ эрх баригч нам Монголын ард түмэнд Алсын хараа, Шинэ сэргэлт, мега төсөл, том бүтээн байгуулалт гэдэг үгийг хангалттай олон хэлсэн, сонсгосон. Гэхдээ өнөөдөр бодит амьдрал дээр утааг бууруулж байгаа боловч, маш их мөнгө зарж байгаа. Түгжрэл буураагүй, орлого хүрэлцэхгүй, авлига багасаагүй, залуус гадагшаагаа явсаар байна Монголоос. Тиймээс Иргэний Зориг ногоон нам энэ төлөвлөгөөндөө зарим зүйлийг шаардаж байгаа юм. Том үг биш, бодит хариуцлагыг зоох ёстой. Сүржин төлөвлөгөө биш, хэрэгжих боломжийг тодорхойлох ёстой, хяналтгүй зарцуулалт биш, иргэдийн нээлттэй хяналтыг тавих боломжийг нь энэ төлөвлөгөө дээрээ гаргах ёстой.

Энэ төлөвлөгөөний хамгийн анхаарал татаж байгаа эмзэг хэсэг нь 124 төсөл, 186 арга хэмжээ гэсэн тоо. Монголын төр өнөөдөр нэг эмнэлгийн ачааллыг бүрэн шийдэж чадахгүй, нэг сургуулийнхаа хүртээмжийг бүрэн хангаж чадахгүй, нэг хотын түгжрэлийг бууруулж чадахгүй байж байгаа байж энэ 180 арга хэмжээг хэрэгжүүлнэ гэдэгт иргэд хэр итгэж байгаа юм бэ гэдэг дээр анхаарах ёстой. Тийм болохоор 1 дүгээрт нь төсөл бүрийн санхүүжилтийн эх үүсвэрийг нь ил тод болго. Улсын төсөв үү, зээл үү, бонд уу, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт уу, зарцуулалт нь яаж явах юм бэ гэдгийг нь задалж гаргах хэрэгтэй. Том төсөл хөтөлбөр хэрэгжихэд иргэдийн эсэргүүцэл учрахгүй байх боломж нь өөрөө энэ.

2 дугаарт нь энэ 186 арга хэмжээ бүр дээрээ хариуцах эзэн, хугацаа, хэмжих шалгуур буюу KPI-г тодорхой бичих ёстой, тодорхой олон нийтэд танилцуулах хэрэгтэй.

3 дугаарт нь төсөл бүрийн тендер, гүйцэтгэх зарцуулалт, хэрэгжилтийн явцыг иргэд харах боломжтой нээлттэй цахим хяналтын системтэй болох ёстой.

4-д нь том төсөл бүр дээр авлигын эрсдэлээ, аудитаа хийх ёстой.

5 дугаарт нь ногоон хөгжил гэж ярьж байгаа бол ус, агаар, хөрс, нүүрсний хамаарал, сэргээгдэх эрчим хүчний бодит хэмжүүрүүдийг тоогоор тогтоох ёстой. Бид энэ зарчмын зөрүүтэй саналууд оруулна.

Эцэст нь залуучууд 2027 онд хэдэн төсөл хэрэгжих вэ гэж биш, эх орондоо үлдэх шалтгаантай болов уу гэж асууж байх хэмжээнд очих ёстой. Энэ төлөвлөгөөг сайхан мөрөөдөл биш, иргэдийн бодит.../минут дуусав/

С.Бямбацогт: Баярлалаа. Отгоны Саранчулуун гишүүн үгээ хэлье.

О.Саранчулуун: Богино хугацаанд ч гэсэндээ яг түүгээд харахаар Боловсролын яамны харьяа 5 төсөл, Гэр бүлийнх 7, Барилгын, хот байгуулалт, байрлах дээр 2 төсөл хөтөлбөр мэдээлэл нь жоохон бүрхэг ойлгомжгүй, зардал тооцоо, яаж хэрэгжих нь тусгагдаагүй байгаа. Тэгээд тэр ямар, ямар төслүүд нь ингээд төсөвгүй орхичихсон бэ гэхлээр яг тэр нөгөө нийгмийн эмзэг бүлгийн асуудлууд, эсвэл нийгмийн эрүүл мэндийн асуудлууд, эсвэл хүмүүсийг гэгээрүүлэх, сургах зан үйлтэй холбоотой төслүүдийг дандаа хоосон тавьчхаад байгаа юм. Тэгээд хоосон тавьчхаад байна гэдэг чинь энэ дээр тооцоолол хийгээгүй юм уу, гадаад зээл юм уу, гадаад гэхлээр үгүй, улсын төсөв гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр яг энэ 5, 7, 10 гэхээрээ одоо байгаа тоолж чадаж байгаагаар 14 төслийг ядаж сайжруулж, бид засаж, дэлгэрэнгүй болгож, ойлгомжтой болгох хэрэгтэй байгаад байгаа.

2-т гэвэл бид улсаараа нэг хүртээмжийн тухай ерөнхийдөө ярихгүй бол болохгүй байна. Баяр наадам болон олон нийт цугладаг бүх арга хэмжээ, олон хүмүүс үйлчлүүлдэг нийтийн болон олон нийтийн газрууд, соёлын газрууд бүх газрууд дээрээ үүд хаалгыг нь, доторх үйлчилгээг нь хүртээмжтэй болгох, хаягжилтыг нь хүртээмжтэй болгох талаар нийтээрээ бүр аян өрнүүлж ингэж ажилламаар байна. Тойрог дээр ажиллаж, иргэдтэйгээ уулздаг гишүүд минь та нар ч гэсэндээ аймаг, орон нутгийнхаа төсөв төлөвлөгөө дээр анхаарч байхдаа энэ талаар ажиллаж, энийг сайжруулаач. Тэнд чинь цөөхөн ч гэсэндээ хүмүүс байгаа.

Нөгөө талдаа 10 жилийн дараа гэхэд ахмад хүмүүсийн тоо улам өсөж байгаа, хараа муутай хүмүүс олон болно, хөл, гар муутай хүмүүсийн тоо өсөж байгаа статистикийн хувьд. Тэгэхээр ирээдүйд одоо байгаа үйлчилгээ тэр хүмүүст ээлгүй болно. Бид өөрсдөө тэрийгээ бүтээсэн ийм буруутан болж хувирна. Тийм учраас хүртээмжийн асуудлыг нүдэнд харагдахуйцаар улсын төсөвтөө тусгаж оруулж харагдуулмаар байна. Одоо байгаа орж ирж байгаа төлөвлөгөө дээр яг түүгээд харахлаар яг харагдахгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр төсвийн захирагчид болон төсөв төлөвлөгөө дээр яг энэ, энэ чиглэлийн хүртээмж, орчны хүртээмж нь ийм байх юм, мэдээллийн хүртээмжээ ингэж сайжруулъя гээд ингээд явмаар байна.

Төрийн байгууллагууд руу орохлоор үүдэнд нь нөгөө манай сайчууд гээд дарга нарынх нь зураг, веб сайт руу нь орохоор дарга нарынх нь зураг байдаг болохоос яг нөгөө иргэнд зориулсан авах гээд байгаа үйлчилгээ нь нүүрний эгнээнд байдаггүй байхгүй юу. Гэтэл бид Мобиком ч юм уу, банк, гар утасны теллер компани руу орохоор ийм үйлчилгээ авах бол тэд дарна уу, тэр цонхон дээр очно уу гээд ойлгомжтой байгаад байгаа, хүн төөрөхөөргүй. Тэгэхээр энийг хүртээмж гэж хэлээд байгаа юм л даа. Тэгэхээр энд байгаа бүх сайд нар, ер нь төрийн үйлчилгээний байгууллагууд өөрсдийнхөө харьяа бүх байгууллагадаа энэ хаягжилт, энэ мэдээллээ цахимаар болон биетээр сайжруулах дээр онцгой анхаармаар байна. Тэгээд тэрийгээ төсөв дээрээ тусгаж, арга хэмжээ болгож төлөвлөх хэрэгтэй байгаа гэсэн үг.

Энэ дээр миний хамгийн харамсалтай жоохон санагдаад байгаа нэг зүйл бид хөгжлийн бэрхшээлтэй хүнээ тоолоод ялгана гээд ЗГ-ын төлөвлөгөөндөө оруулчихсан мөртөө хүүхдүүдээсээ эхэлье, ICF гэдэг олон улсын ангиллаар эхэлье гэсэн ажил нь энд төсөвгүй явж байна шүү дээ. Тэгээд Гэр бүлийн яам гээд биччихсэн. Тэгээд яам нь төсөв оруулаад, Эдийн засаг, хөгжлийн яам нь хасчихдаг юм уу, эсвэл яам нь анхнаасаа төсөвгүй ингээд оруулаад ирдэг юм уу яг яадаг юм. Тэгэхээр энэ хүүхдийн ICF-ийн төсвийг заавал тусгах хэрэгтэй. Нэг хөгжлийн

бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад нэлээн цаг гарна шүү. Энэ дээр чинь ажил процесс явагдана шүү дээ. Энийгээ заавал засаж сайжруулахгүй бол болохгүй нь.

Тэгээд хөдөлмөр эрхлэлтийн дэмжих үйлчилгээ байгаа. Хэдэн хүн ажилд оруулаад байгаа нь мэдэхгүй, хэдэн тэрбум төгрөг байдаг. Тэрнийхээ тайлан задаргааг авъя, мэдээллийг авъя, тэгж байж энэнийг дэмжиж баталмаар байна.

С.Бямбацогт: Дашдондогийн Ганбат гишүүн үгээ хэлье.

Д.Ганбат: Энэ чинь юу билээ, энэ чинь 3 ч ЗГ солигдов уу. Манай эрх барьж байгаа нам, жижиг намуудаас ер нь энэ сайд ЗГ-т ороогүй хүмүүс үлдээгүй байх, бараг үлдээгүй байх. Тэгээд энэ хийж байгаа ажил, байж байгаа юмыг ингээд харахаар Монголын ард түмэн хараад л яах гэж энэ хэдийг сонгов доо, яах гэж Ардын намыг олонх болгов доо гээд толгойгоо шаагаад сууж байгаа байх л даа. Амьдрал хүнд байна, олон ААН-үүд хаалгаа барьж байна. Гэтэл байдал ямар байгаа вэ гэхээр манай гадагшаа гаргадаг юмны үнэ бүгд сайн байгаа, зэс 13 мянган доллар гараад явчихлаа, алт бараг 4, 5 мянга дээр байна, нүүрс 140, та нарыг засаглаж байх хугацаанд бараг 300, 600 хүрлээ. Тэгээд арваад жил та нар засаглалаа. Тэгээд дэлхийн 2 дахь, удахгүй нэг дэх том эдийн засаг болох энэ улсыг тойроод байж байгаа 15, 6 орон бүгдээрээ 3, 4 дахин сайжирчихсан амьдрал ахуй нь. Манайхыг ардчиллын баян бүрд гэдэг байсан бол одоо тэгж ярихаа больсон. Одоо бараг Казакстан, Узбекстан энэ тэрээс бид очиж суралцах шаардлагатай болсон. Сүүлийн 2, 3-хан жил тэд маш сайжирч байна. Ийм л байгаа.

Энэ асуудалд хандаж байгаа, ажил хийж байгаа юм чинь яах вэ үеийн Засгийн газрууд арай дээрдээд байна л даа. Гэхдээ л яах вэ өнөөдөр валютын нөөц чинь 7,3 тэрбум байгаа юу, яах вэ дээрдээд л байгаа. Гэхдээ энэ маягаараа явбал ёстой яг яст мэлхий шиг явж байна шүү дээ. Бусад улс орон хамаагүй өөрчлөгдсөн, хамаагүй урагшаа явчихсан байгаа шүү дээ. Тэгэхээр та нарын хийх гэж байгаа ажил, хийж байгаа энэ юм чинь болохгүй байгаа байхгүй юу. Яг манай нэг хэсэг АН ажиллаж байсан даа. Батболдын ЗГ-ын үед чинь 11, 12 онд чинь эдийн засаг чинь 17 хувьтай өсдөг байлаа шүү дээ. Хятадын эдийн засаг чинь бараг хориод жил дандаа 7-гоос дээш хувь өсөж байлаа шүү дээ. Тэгээд гол, гол юмаа барьж авч шийдэж чадахгүй байна.

Энэ тээврийн асуудлаа шийдмээр байгаа юм дэд бүтцээ. Гол гоц замтай болмоор байна. Эрчим хүчнийхээ эх үүсвэрийг бид шийдчихмээр байна. Хангалттай эрчим хүчний нөөцтэй мөртөө гаднаас эрчим хүч импортлоод л байж байгаа шүү дээ. Энэ дээрээ дүгнэлт хийгээд, жоохон ажилламаар байна. Тэгээд хамгийн өндөр IQ-тай ийм 5 ард түмний нэг нь Монгол Улс шүү дээ. Тэгэхэд өнөөдөр боловсролын хувьд 2, 3 дугаар ангиар хоцорчихсон үеийнхнээсээ ийм нөхцөл байдалтай ингээд явж байна л даа. Өөрөө ч тэрийг Боловсролын сайд нь хэлээд байгаа. Тэр хамгийн сайн багш нартай больё гэж яриад байдаг нь зөв л дөө.

Эрүүл мэнд ч гэсэн, энд тавиад, онош хийгээд, тэр эмийг нь уугаад явж байгаа хүмүүс гадагшаа гараад үзүүлэхээрээ бүгдээрээ өөр, өөр оноштой гарч байна гэж байна лээ шүү дээ. Ийм л маягтай яваад байгаа юм л даа. Тэгээд төрөлт хар л даа. Сүүлийн арваад жилд 20 мянгаар буурчихсан байна шүү дээ. Та нарын тэр халамжийн бодлогын чинь үр дүнд, энэ чинь нэг л явахгүй байгаа байхгүй юу. Энэ та нарт тавьж байгаа дүн гэж ойлгох хэрэгтэй нөхдөө. Тэгээд одоо энэ дээр сайхан, сайхан юм ярина л даа, энэ төлөвлөгөө ингэж гоё болдог юм.../минут дуусав/

С.Бямбацогт: Ренчинбямбын Сэддорж гишүүн үгээ хэлье. Үүний дараа санал хураалттай шүү, гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Санал хураалтдаа бэлтгэцгээе бүгдээрээ.

Р.Сэддорж: Оройн мэнд хүргэе. Өнөөдөр бидний гол ярих ёстой зүйлүүд энэ протоколд тэмдэглэж үлдэх ёстой. Ерөнхий сайд байж байна. Ерөнхий сайдын үед энэ төсөв бол тийм чамлахааргүй байгаа. Бид саяхан 7 их наяд төсөвтэй байсан улс шүү дээ тийм ээ. Одоо 33 их наяд төсвийг яаж хуваарилах тухай яаж байна. Ер нь нэг мөнгөтэй болчихоороо аймаар цацаа цалгиатай байдаг нэг айл байдаг шүү дээ, тийм өрхийн тэргүүн, тэгээд л нэг хэдэн сарын дараа бүүр нэг чимээгүй болчихдог айл шиг ийм л битгий байгаасай. Байгаа энэ боломжоо яг чухал юмнуудаа л.

Манай энэ төрийн албан хаагчид төлөвлөөд л байгаа, яамнууд сайн л төлөвлөж байгаа. Тэгээд л энэ дундуур янз бүрийн нөлөөллүүд орж ирээд ингээд будилуулаад байгаа байх. Энийг нь энэ Их Хурлын гишүүд шүүмжлээд байгаа байх. Юмаа эрэмбэлж, яг журмаар нь эрэмбэлж, эрэмбэлээд ороод ирэхэд дундуур нь юмнууд нөлөөлөөд байгаа байх. Энэ эрэмбэ чинь 21 аймаг газар нутаг, үндэсний язгуур эрх ашиг, эдийн засгийн тэр нөөц бололцоо энэ бүх юмаар нь тооцож, эрэмбэлэх ажлаа энэ яамнууд маань яг нэг сайн хийгээрэй, хийхгүй бол ингээд л шүүмжлэл, энд хэлж байгаа юмнууд, гишүүдийн энэ хэлж байгаа зүйлүүд бүгдээрээ л сөрөг юмнууд их байна.

Тэгээд байгаа орлогоо чамлаж болохгүй шүү дээ. Тэгээд өөр орлого олох боломж одоогоор байхгүй. Тийм учраас энэ байгаа орлогоо маш чамбай зарцуулах хэрэгтэй байна. Энэ хамгийн ачаалалтай байгаа замаа яаралтай 4 эгнээ болгох талаар жишээ нь Улаанбаатар Замын-Үүдийн зам байгаа. Энд ямар олон хүний ачаа бараа мөргөлдөж, шатаж байна, хүний амь нас сүйдэж байна. Тэр Улаанбаатар Гашуунсухайт, Улаанбаатар Шивээхүрэнгийн чиглэлийн замуудыг яаралтай 4 эгнээ болгох талаар энэ дээрээ сайдууд, ЗГ сайн ажиллах байх гэж итгэж байна.

Онги Цагаанбургастай усны төсөл дээр Ерөнхий сайд энэ жил мөнгө тавихгүйгээр үлдчих вий дээ. Өнгөрсөн 2 жил мөнгө тавьж, энэ ажил гайгүй явж байна. Тэгээд энэ ТЭЗҮ-гээ дуусгаад авбал 5 жилийн дотор ТЭЗҮ хүчинтэй байх ёстой. Тэгээд энэ хугацаандаа ОХУ, БНХАУ-тай энэ 2 голоо хэрхэн хамтран ажиллах, хэрхэн цөлжилтийн эсрэг ажиллах нэрийн доор энэ төслөө амжилттай хэрэгжүүлэх талаар энэ ирэх жилийг алдаж болохгүй шүү гэдгийг онцгой сануулъя.

Бид энэ эрүүл мэнд, боловсролын асуудал дээрээ л их олон алдаа гаргасан орон. Манай улс бол боловсролын систем дээр, сая Боловсролын сайд эргэн тавигдлаа. Энэ дээрээ онцгой анхаарч байгаа байх. Танд бүрэн итгэж байгаа. Тэгээд хүүхдээ алагчлалгүй, сургуулийнхаа хүүхдийг үдийн хоолоор нь хангачихгүй байж том, том төсөл ярихад бид ичмээр байна. Тийм учраас энэ 27 оны 1 сарын 1-нээс хойш энэ 37 гишүүн энийг дэмжиж, гарын үсэг зурсан хүүхдүүдээ алагчлалгүй үдийн цай, 1 доллар хүрэхгүй байгаа энэ үдийн цайгаа өгөөд, амар жимэр ард аав ээжүүд нь ажил хийх энэ боломжийг нь олгоё. Монгол Улс тийм ядуу улс биш, тэгээд учраа олохгүй л байгаа улс гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Баярлалаа Сэддорж гишүүнд. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Танхимд 30 гаруй, 40-өөд гишүүн байна. Гишүүдийг танхимдаа

орж, санал хураалтдаа бэлдэхийг урьж байна. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө бол үндсэндээ ирэх жилийн Монгол Улсын эдийн засаг, Монгол гэдэг өрх айл ямархуу төсвийн орлоготой, ямархуу зардалтай, аав ээж нь ямар цалинтай, хүүхэд багачууддаа ямар боломж олгосон, ахмадуудаа яаж ачилсан, гэр орондоо ямар тавилга, эд хогшил хөрөнгө оруулалт хийсэн байх вэ гэдгийг шийддэг хамгийн бодлогын төрийн бодлогын хамгийн гол бичиг баримт богино хугацааны. Хэмжиж чадахгүй бол хянаж удирдаж чадахгүй. Тийм болохоор хөгжлийн бодлого, төлөвлөлт хүслийн жагсаалт биш, харин заавал хэрэгждэг байх ёстой.

Тиймээс хөгжлийн төлөвлөлт, төсөвлөлт 2 харилцан уялдаатай байх учиртай. Мөн тооцоо судалгаанд суурилсан, нөхцөл байдал дээрээ зөв дүгнэлт хийж, бодлогоо зөв тодорхойлсон байх ёстой. Хэдийгээр эдийн засгийн өсөлт 6,8 хувь байгаа ч хөрөнгө оруулалтын цэвэр урсгал 40 хувиар буурсан байгаа. Энэ бол ЗГ Хөрөнгө оруулалтын тухай хууль, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, мөн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиудыг яаралтай өргөн барья, энэ хуулиудыг хүнд суртлаас чөлөөлөх шаардлагатай байгааг илэрхийлж байгаа. Эндээ анхаарья.

УИХ дээр зөвшөөрлийг чөлөөлөх, зөвшөөрөлтэйгөөс бусад нь хориотой, хүнд сурталтай байгааг чөлөөлж, үнэхээр ард иргэдийн амьдралд, эрүүл мэндэд, амь насанд аюул занал учруулахгүй бол зөвшөөрөлтэйгөөс бусад нь чөлөөтэй байх, хориотой биш, чөлөөтэй байх энэ бодлогоо хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байгаа. Жил болгон хөгжлийн бодлого, төлөвлөлтийг татвар төлөгчдийн мөнгөөр хэрэгжүүлдэг. Тийм болохоор татвар төлөгчид маань, баялаг бүтээгчид маань хувийн хэвшил, ААН-үүд маань татвар төлөгч бидний мөнгийг яаж зөв зарцуулах нь вэ, яаж үрэн таран хийхгүй байна байх нь вэ гэдгийг нүд цавчилгүй харж байгаа. Тэгээд ард түмнээр ямар төсвөөр, ямар зургаар, ямар тооцоо судалгаан дээр үндэслэж, чухам юу хийх гэж байгааг ард түмэнд ил тод тайлагнаж, эхнээсээ хэрэгжилтийг нягт хянаж, зөв хэмжиж, үр дүнг нь зөв тооцож, үнэлж дүгнэж байж бүрэн биелнэ.

Түрүүн бид 2027 оны төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцсэн. Урсгал зардал 28,8 их наяд төгрөгийн төсвийн нийт зардлын 80 хувьд хүрэхээр ийм тооцоололтой орж ирсэн. Өөрөөр хэлбэл улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх хөрөнгө оруулалтын шинэ төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх боломж маш бага болсон. Энэ цаг үед бид гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангаж, мега төслүүдээ хэрэгжүүлэх, ажлын байр бий болгоход хувийн хэвшлээ дэмжих, энэ хувийн хэвшлээ том төслүүд хэрэгжүүлэх хувийн хэвшлүүдээ дэмжих ийм бодлогод илүү анхаарах ёстой.

Хөгжлийнхөө төлөвлөгөөг батлахдаа энэ гадаад зээлээ яаж ашиглах вэ, хувийн хэвшлээ яаж хөрөнгө оруулалт, мега төслийг хөдөлгөхөд оролцуулах вэ гэдэг дээр нэг зарчим барих ёстой. Хөгжлийн судас болсон авто зам, төмөр замын гарц коридоруудаа нэмэгдүүлэхэд анхаарах ёстой. Улс орон импортын хараат байдлаас салж, экспортын хэмжээ, нэр төрлөө нэмэгдүүлж байж үйлдвэрлэл хөгждөг. Зэсийн боловсруулах үйлдвэр, ган боловсруулах үйлдвэр, хүнд үйлдвэрүүдээ хурдан эхлүүлмээр байна. Түүхий эд бэлтгэн нийлүүлдэг биш, түүхий эдийг бүтээгдэхүүн болгодог, нэмүү өртөг шингээдэг ийм болмоор байна. Түүхий эдийг түүх болгомоор боловсруулж. Болчихсон уу? Эрчим хүчний асар их нөөцтэй мөртөө гаднаа түлэх түлээтэй айл гэр дотроо галгүй байгаатай адилхан асуудалтай байгаа. Тийм болохоор эрчим хүчнийг нэлээн анхаарах ёстой шүү.

Жилийн хөгжлийн төлөвлөгөөг ажлын хэсэг байгуулна. Ажлын хэсэг дээр гишүүд маань маш анхааралтай, маш ажил хэрэгч хандах ёстой. Хуулийн хугацаатай учраас яаралтай хэрэгжүүлэхэд анхаарах ёстой гэдгийг хэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 65.6-д заасны дагуу Жилийн хөгжлийн төсөл, жилийн төлөвлөгөөний төсөл Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10-д заасан шаардлага хангасан эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Харин тэр үед нөгөө АН-ын Үндэсний бодлогын хороо хуралдсан өчигдөр. Тийм болохоор түүнтэй холбоотойгоор өнгөрсөн долоо хоног тэгээд төлөвлөж байх үед, ирэх долоо хоногийн тов дараалал хэлэлцэж байх үед АН-ын Үндэсний бодлогын хороо 4 дэх өдөр хуралдахаар товтой байсан учраас энэ цөөнхийн бүлгээ хүндэтгээд, энэ чухал асуудалд үгээ хэлэх, санал бодлоо илэрхийлэх боломж олгох гээд өнөөдөр 2 асуудлыг хамтад нь тавьсан байгаа. Энийг гишүүд маань зөв ойлгоорой.

Санал хураалтад 53 гишүүн бэлэн болсон байна, 40 гишүүн бэлэн болоогүй байна. Ирцдээ ороод, хурууны хээгээ уншуулаад, санал хураалтдаа гишүүд бэлэн больё. Бүртгэлийн санал хураалт явуулчихъя. Татгалзсан гэж гарч байгаа гишүүд чуулганы танхимдаа хүрэлцэн ирэхийг урья. Санал хураалтдаа оролцоод, ажлаа хиймээр байна. Санал хураалт явуулъя.

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10-д заасан шаардлагыг хангасан байна гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 51 гишүүн буюу 54,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Монгол Улсын хөгжлийн 2027 онд төлөвлөгөө батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

22.25 цаг

Тав.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох

Дараагийн асуудалдаа оръё. Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-д УИХ энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль, тогтоолын эцсийн найруулгыг холбогдох Байнгын хороо бэлтгэж, УИХ-д танилцуулахад бэлэн болсон байн.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулга. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль, эцсийн найруулга сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хууль, алга байна, сонссонд тооцлоо.

22.26 цаг

Өнгөрсөн 4 сарын чуулганы ирцийн мэдээ гарсан байгаа. Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сарын нэгдсэн хуралдаан 9 удаа хуралдсан байна. 9 удаагийн хуралдааныг нэг ч таслаагүй, нэг ч минут хоцроогүй 14 гишүүн байна. Энэ 14 гишүүнийг цагаан толгойн үсгийн дарааллаар нэрсийн дарааллаар танилцуулъя. Аюушийн Ариунзаяа, Батын Батбаатар, Жигжидийн Батжаргал, Ренчиндоржийн Батболд, Дуламын Бум-Очир, Сандагийн Бямбацогт, Батжаргалын Заяабал, Сүрэнжавын Лүндэг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Бадрахын Найдалаа, Бөхчулууны Пүрэвдорж, Доржзовдын Энхтуяа, Дашцэрэнгийн Энхтүвшин, Сүхбаатарын Эрдэнэболд. Эдгээр 14 гишүүн 04 сарын нэгдсэн хуралдааныг нэг ч удаа таслаагүй, нэг ч минут хоцроогүй, бас гадаадад томиллолтоор ажиллаагүй, орон нутагт томиллолтоор ажиллаагүй, чөлөө аваагүй байна. Хуралдаандаа идэвхтэй оролцсон байна. 100 хувь ерөөсөө оролцсон энэ гишүүддээ баяр хүргэе. Цаашдаа гишүүдийнхээ ирцийн мэдээг долоо хоногоор, сараар, дэд хороо, Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд хэрхэн оролцсон бэ гэдгээр гаргаж, иргэд сонгогчдодоо байнга тайлагнаж, мэдээлж байх болно гэдгийг сануулъя, хэлье.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Чуулганы хуралдаандаа идэвхтэй оролцсон 53 гишүүндээ баярлалаа. Номин сайддаа их баярлалаа. Нэгдсэн чуулганы хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА